



SHIHIHUTUG UNIVERSITY

SHIHIHUTUG

JOURNAL OF LAW AND MANAGEMENT

Ulaanbaatar
2022

© ШИХИХУТУГ сэтгүүл нь бүхэлдээ зохиогчийн эрхээр баталгаажсан болно.

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн эрхлэгч:	Д.Лүндээжанцан
Зөвлөлийн гишүүд:	Ж.Бямбаа Н.Жалбажав Д.Оюунцэцэг А.Доржготов Р.Оюунбадам Г.Энхбаяр Т.Сүхбаатар Б.Одончимэг
Нарийн бичгийн дарга:	Б.Мөнх-Эрдэнэ
Дизайнер:	Г.Энхдэлгэр
Хэвлэлийн хуудас:	9.0 Х.Х
Хэвлэсэн газар:	“Өнгөт талст” ХХК

Хаяг:

СБД 5-р хороо Үндсэн хуулийн гудамж

Шихихутуг их сургууль.

Web site: www.shihihutug.edu.mn

Tel: 11+314977 Ulaanbaatar, Mongolia.

ГАРЧИГ

ИЛТГЭЛ НИЙТЛЭЛ, ӨГҮҮЛЭЛ	5
Даяаршил, үндэсний аюулгүй байдал, түүний оюуны дархлааны тухайд /Н.Жалбажав/	6
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хуульд захирагдах зарчмын хэрэгжилт, анхаарах зарим асуудал /Б.Нармандах/	15
Нэгдмэл Монгол Улс /А.Доржготов/	29
Нийтийн эрх зүйн талаарх эрдэмтдийн үзэл баримтлалын тухай /Ж.Мөнхболд/	32
Хуулийн хэлний прагматикийн тухайд /Англи хэл дээрх жишээн дээр/ /Л.Нарангэрэл/	42
"Монгол Улс дахь хүүхэд үрчлэлтийн хяналтын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал" /Ё.Болормаа/	48
Улс төр судлал ба хууль зүйн шинжлэх ухаан /Д.Отгончимэг/	57
Эрүүгийн хууль дахь хөөн хэлэлцэх хугацааны тулгамдаж буй асуудал /Б.Мөнх-Эрдэнэ/	63
Төрийн албан тушаалын ангилал зэрэглэлийн талаар эртний хууль цаазын сурвалж бичгүүдэд тусгагдсан байдал /Т.Сосорбарам/	76
Хүний үндсэн эрх ба хүний генетик мэдээллийн хууль зүйн шинэчлэл /Ц.Амарсанаа/	89
Эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах эрх зүйн зохицуулалтын зарим асуудал /Э.Анхбаяр/	104
Оюуны өмчийн эрхийн үнэлгээний эрх зүйн зохицуулалт /Ч.Жадамба, Э.Гэрэл/	116
Эрх зүйн этгээд байх ойлголт буюу эрх зүйн чадварын тухай /М.Хатанзориг/	126
Төр хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн зохицуулалтын тухайд /Г.Батнасан/	137
Даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр авах эрх түүнийг хамгаалахад анхаарах асуудал /Г.Хонгор/	148
Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь /Г.Төгөлдөр/	159

Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийн Үндсэн хуулийн үзэл баримтлал /З.Жаргалмаа/	170
Бизнесийн эрх зүйн орчныг сайжруулахад комплаенсын мэргэжилтнүүдийн үзүүлэх үр нөлөө /О.Анударь/	178
Эрх, түүний зохицуулалтыг боловсронгуй болгох асуудалд /С.Номынбаясгалан/	189
Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн хэрэгжилт, түүнд тулгамдаж буй зарим асуудлууд /М.Бүжинлхам/	208
Арбитрын хэлэлцээр ба хэргийн харьяаллын зарим асуудал /М.Цэдэнпунцаг/	224
Орон нутаг дахь эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийг сайжруулах хэрэгцээ, шаардлага /Ч.Саранмандах/	234
Бүх насаар хорих ялын зарим тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх нь /Д.Цэрэнпагам/	242
Гэрээний зарчмын онолын хандлагуудын хэрэглээний зарим асуудал /Г.Ариунболор/	250
ЯРИЛЦЛАГА	261
Шихихутуг их сургуулийн захирал, Монгол Улсын гавьяат багш, профессор Д.Оюунцэцэг	262
Шихихутуг их сургуулийн Клиник сургалтын төвийн эрхлэгч Т.Сүхбаатар	274
ХУУЛИЙН ТАЙЛБАР	276
Компанийн хуулийн тайлбар /А.Доржготов/	277

ИЛТГЭЛ
НИЙТЛЭЛ, ӨГҮҮЛЭЛ

ДАЯАРШИЛ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТҮҮНИЙ ОЮУНЫ ДАРХЛААНЫ ТУХАЙД



Шихихутуг их сургуулийн
Судалгааны хүрээлэнгийн
захирал, Шинжлэх ухааны гавьяат
зүтгэлтэн. Доктор(Ph.D), профессор
Н.Жалбажав

6 Даяаршлын эринд эрдэмтэн судлаачдын анхаарлыг татаж, улс үндэсний болон соёл иргэншлийн аюулгүй байдалд нөлөөлж буй глобал буюу нийтлэг шинжтэй олон асуудал, хувьслын шинэ хандлага шил шилээ даган гарсаар буй. Тухайлбал:

-Аливаа улс орны нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийн нөөц боломж дэлхийн эдийн засгийн зах зээлийн конъюнктур, чиг хандлага, тухайн улс орны олон улсын эдийн засгийн хамтын нийгэмлэгт эзлэх байр суурь нэр хүнд, экспортын чадавх зэргээс үлэмж хамааралтай болж байна. Товчоор хэлэхэд улс орны тусгаар тогтнол аюулгүй байдал эдийн засгийн хүчин зүйлээс улам бүр хамааралтай болж байна. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд дэлхийн болон бүс нутгийн банк, санхүүгийн

төв, байгууллагуудын нөлөө, үүрэг онцгой идэвхжиж байна. Эдийн засгийн нөөц боломжийг нано, био, IT технологи, хими, генийн инженерчлэл, үйлдвэрлэл, удирдлагын шинэ технологи, эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг хэрхэн нутагшуулж эзэмшиж байгаагаар тодорхойлох боллоо. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухаан, технологийн ололт, инновацад суурилсан хөгжлийн бодлого, үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх нэн чухал үндэс нь болж байна.

Монгол Улсын тухайд материал баялгийн үйлдвэрлэлийн салбарууд/эдийн засгийн салбаруудын/-ын зохист харьцаа буюу гармонийг хангах, шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг мэдэгдэхүйцээр, бодитой нэмэгдүүлэх, боловсруулах үйлдвэрлэлийг экспортын чиг хандлагаар хөгжүүлэх, эрчим хүч, шатахууны, химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйг эрчимжүүлэх, банк, санхүүгийн тогтолцоог шинэчлэх зэрэг нь улс орны эдийн засгийн тогтвортой хөгжил бие даасан хараат бус байдлыг бэхжүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой болж байна.

-Даяаршлын нөлөөн дор нийгэм улам бүр нээлттэй болж улс үндэстний хувьд иргэншил, соёл урлаг, шинжлэх ухаан, технологийн

ололтууд хил хязгааргүй нэвтэрч, үндэсний, локал, дэлхийн соёл иргэншлүүдийн ялгаа зааг, уялдаа холбооны үр дагавар нарийн төвөгтэй болж даяаршихуй болон дангааршлын диалектик болон дианетик (Л. Түдэв) нь үндэсний аюулгүй байдлыг хангах чухал асуудал болж байна.

Мэдээллийн технологийн ололт нь улс үндэстэн, бүс нутаг, олон улсын хил хязгаараас үл хамааран нийт хүмүүнлэгийн хүртээл болж хүний бүр анхдагч хэрэглээний зүйл болж байна. IT өргөн ашиглагдах болсон цаг үед хүмүүс хаана, ямар ч улс оронд байна ялгаагүй өөр хоорондоо чөлөөтэй харилцан төвөг саадгүйгээр шаардлагатай мэдээ, мэдээллээ олж ашиглах боломжтой болжээ. Даяаршлын эринд хүмүүнлэгийн харилцааны зах хязгааргүй тэлэлт, соёлын харилцан "уусалт, шингэлт", мэдээллийн хүчирхэг давлагаанд хөл алдлалгүй үндэснийхээ соёл иргэншлийн өвөрмөц, дахин давтагдашгүй онцлог, үнэт зүйлсээ хадгалан хамгаалах нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой болж байна.

-Эдүгээ хүнийг нийгэм эдийн засгийн хөгжлийн төвд тавихгүй, хүний хөгжилд хүрэлцэхүйц хөрөнгө оруулалт хийхгүй бол үндэсний соёл иргэншлийн үнэт зүйлсээ хадгалан хамгаалах, аюулгүй байдлаа бэхлэх боломжгүй болсон цаг үе юм. Ийм

учраас энэ цаг үед төрийн аюулгүй байдлыг хангах болон нийгэм- эдийн засгийн хөгжлийн бодлогын төвд "Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалттай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, зрүүл монгол хүнийг хөгжүүлэх" зорилт тавигдаж байна¹. Монгол хүн, монгол оюун ухаан, монголын түүх, монгол өв соёл, монгол урлаг, монгол ёс заншил, уламжлал бол улс эх орны бахархал, үнэт зүйл байх ёстой. Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаа болсон Монголоо гэсэн зүрх сэтгэлтэй Монгол хүнийг хүмүүжүүлэх их үйлсийг бид цалгардуулах учиргүй.

Энэ бол даяаршлын эринд Монгол Улс, монголын соёл иргэншлийн тусгаар байдал, өвөрмөцөөр оршин, үндэсний аюулгүй байдлаа бэхжүүлэх оюуны дархлааны тухай цаад утга бүхий бодол санааг шингээсэн үг юм.

-Нийгмийн тогтвортой хөгжлийн алхам , бүтээн байгуулалтын арга хэмжээ бүр байгаль эхээ хайрлан хамгаалах, эко тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн бодлого, хандлагатай ухаалгаар нийцүүлэх, уялдуулах нь улс орон бүрийн ирээдүйн хөгжлийн стратеги, аюулгүй байдлаа бэхжүүлэх арга зам болж байна.Монгол Улсын

¹ "Алсын хараа 2050", 61 дэх талд.

оршин тогтнох эко орчин нь болсон Төв азийн чулуурхаг хөрс нь эмзэг хэврэг, нөхөн сэргээгдэх чадавх дорой бөгөөд цаг уурын дулаарлын нөлөөнд хамгаас илүүтэй өртөж эвдэрч цөлжих нь газар авсаар байна. Олон олон нуур цөөрөм, гол горхи ширгэж шургаж ой мод шингэрч, олон төрөл ан амьтан устаж үгүй болох аюул нүүрлэх болж байна. Энэ бүхэнд байгалийн давагдашгүй хүчин зүйлийн зэрэгцээ хүний шунахайралдаа автсан үйлдэл, үйл ажиллагаа, уул уурхайн нөхөн сэргээлтгүй үйлдвэрлэл, эрдэс баялгийн хэтийн оновчтой бодлого төлөвлөлт, зохицуулалт үгүй олзворлолт нэрмээс болж байна. Иймд байгаль эхээ "амилуулан" хайрлан хамгаалах, халдах, хандах дэг жаяг, хорио цээрийг тогтоон мөрдүүлэх, байгалиа түшиж байгальтайгаа зохицон амьдрах арга ухааныг хойч үедээ "яс мах, ой ухаанд нь шингээн" өвлүүлдэг уламжлалаа, зан заншлаа сэргээн мөрдөх, хууль цаазаа тэгшлэх нь үндэсний аюулгүй байдлаа бэхжүүлэхэд амин чухал хэрэг болж байна.

-Нийгмийн дэвшлийн үндсэн нэг гол шалгуур нь улс үндэсний эв нэгдэл, нийгмийн (сошиал) тогтвортой байдал юм. Даяаршил нь хөгжил дэвшлийн хурдасгуур хүчин зүйлийн зэрэгцээ улс хоорондын хөгжлийн зөрүүг төдийгүй улс орны дотоодод "нийгмийн сошиал

ялгарал, баян ядуугийн туйлшрал, тэгш бус байдал, улмаар ашиг сонирхлын зөрчлийг өдөөгч болох эрсдэл дагуулдаг байна. Сайн сайхны зэрэгцээ ажилгүйдэл ядуурал, хар тамхи мансууруулах бусад бодисын тархалт, халдварт өвчин тахал, байгаль орчны доройтол, терроризмын аюул занал, хүний эрхийн элдэв нуугдмал зөрчил зэрэг муу муухай үзэгдлүүд даяарших хандлагатай болж байна. Эдгээр үзэгдлүүд улс орны нийгмийн тогтвортой байдал, үндэсний эв нэгдэл зэрэг аюулгүй байдлыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлүүдийг сулруулдаг, нэг ёсондоо "төвөөс зугтаагч", задлагч хүчний уршиг нөлөөтэй ажээ.

Учир иймд баялгийн хуваарилалтын шударга ёсыг хэлбэрэлтгүй баримтлах, ажилгүйдэл ядууралтай тууштай тэмцэх, хүн амын чинээлэг, дунд давхаргыг дэмжих зэрэг эдийн засаг, нийгмийн арга хэмжээний сацуугаар нийт иргэний эх оронч үндэсний ухамсар, үндэсний ой санамж, бахархлыг төлөвшүүлж хөгжүүлэх, улс, үндэсний үнэт зүйлсээ дэлгэрүүлж бэхжүүлэх нь үндэсний аюулгүй байдлаа бэхжүүлэхэд шийдвэрлэх хүчин зүйлийн нэгэн болж байна. Өөрөөр хэлбэл улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлын оюуны дархлааг бүрдүүлж бэхлэх нь хэзээ хэзээнээс илүү чухал болж байна.

-Даяаршлын эринд “Үндэсний аюулгүй байдал”, ба “Үндэсний соёл иргэншлийн аюулгүй байдал” гэсэн ойлголт, ухагдахууныг ялгаж зааглахад тун нарийн няхуур хандлага чухал юм. Үндэсний аюулгүй байдлыг үндэсний болон олон улсын түвшинд харьцангуй нарийн сайн судалсан, нэлээд олон улс орон аюулгүй байдлаа хангах өөр өөрийн хууль, үзэл баримтлалтай байна.

Монгол Улс “Үндэсний аюулгүй аюулгүй байдлын үзэл баримтлал” анх 1994 онд баталж 2010 шинэчлэн мөрдөж байгаа бол “Үндэсний аюулгүй байдлын тухай” хуулиа 2001 оноос хэрэгжүүлж байна. Эдгээрт үндэсний аюулгүй байдлыг “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ” гэж тодорхойлжээ.

Судлаачийн хувьд энэ тодорхойлолт нь аюулгүй байдлын мөн чанарыг бус харин ач холбогдол, үр дагаврыг баримталсан мөн улс, үндэсний аюулгүй байдлын гол зүйл болсон Монгол хүний аюулгүй байдлаас хөндий, “хүнийшсэн” тодорхойлолт гэж үзэж байгаа болно. Аюул эрсдэлээс сэргийлэгдсэн хамгаалагдсан байж чадсанаар л оршин тогтнох, хөгжих нөхцөл байдал бүрдэнэ гэж үзэж байна. Тиймээс ҮАБ –ын тодорхойлолтыг “ҮАБ гэж Монгол Улсын иргэн, монголын нийгэм, Монгол Улсын төрийн бүрэн эрхт байдал дотоод, гадаад аливаа

аюул, эрсдэлээс хамгаалагдсан байдлыг хэлнэ. ҮАБ найдвартай хангагдсанаар Монгол Улс, монголын ард түмний язгуур эрх ашиг хамгаалагдах нөхцөл бүрдэнэ” гэж өөрчлөн найруулах, монголын ард түмний язгуур эрх ашгийн эхэнд Монгол Улсын иргэн, түүний эрх, эрх чөлөөний баталгаажилт байхыг зааж өгөх саналтай байна.

Эдүгээ соёл, иргэншил, түүний аюулгүй байдал, үнэт зүйлсийн судалгаа харьцангуй шинэ, нэгдмэл ойлголтод хүрэх асуудал чамгүй ажээ.

Хүн төрөлхтөн өөрийн хөгжлийнхөө таван сая жилийн туршид сайндаа л дөч гаруйхан бие даасан соёл иргэншлийг үүсгэж бүрдүүлсэн бөгөөд тэдгээр нь дараах “амьдралын орчлыг”, тухайлбал үүслийн, хөгжлийн, нэгдлийн, түгээмэлчлэлийн, үеэ өнгөрөөсөн гэх мэт үеүдийг туулж өнгөрүүлсэн байдаг^{2,3,4}.

Энэ нь Монголын соёл иргэншилд ч мөн хамаатай юм. Тухайлбал: Монгол бол уламжлалт нүүдлийн соёл иргэншлийн өв сонгодог хэлбэрээрээ хадгалагдаж үлдсэн дэлхийн цөөхөн орны нэг юм. Энд нүүдлийн соёл иргэншил орчин үеийн суурин соёл иргэншлийн үндсэн хэв маягуудтай хослон хөгжиж байна.

² Comparing Nations and Cultures: Readings in a Cross-Disciplinary Perspective. Alex Inkles, Masamishi S Sasaki, Prentice Hall, 1996.

³ A Framework for Comparative study of Civilizations. Shintaro Ito, J. Comparative Civilizations Review, 36. 1997.

⁴ Ц. Доржсүрэн. Умард Хүннү (Северная Хунну). УБ., 1961.

Орчин үеийн Монголын соёл иргэншил нь дэлхийн соёл иргэншлийн идэвхтэй сүлжээний нөлөөн дор оршиж байна. Энэхүү асуудлыг авч үзэх үндсэн хэсэг нь соёл иргэншил дэх нийтлэг шилжилтүүдийг зөв ухаж ойлгох явдал юм^{5,6,7,8}.

Бидний ойлголтоор хүн төрөлхтөн түүхэндээ таван үндсэн соёл иргэншлийн хувьсгалыг туулжээ. Тухайлбал.

- антропологийн хувьсгал
- газар тариалан-газар эдэлбэрийн хувьсгал
- хотжилтын хувьсгал ба оюуны хувьсгал
- шинжлэх ухаан-технологийн хувьсгал

Соёлын бүх бүс нутгууд нь, тэнд оршин тогтнож байсан болон тогтнож байгаа нийгмийн тогтолцоонууд нь эрт орой хэзээ нэг цагт өөрийнхөө анхны буюу шинээр байгуулагдсан хэлбэрүүддээ эдгээр хувьсгалын шатыг дамжин өнгөрсөн аж.

Антропологийн хувьсгалын урдундхүнөөрийнбодгальшилжилтийн шатнаасаа гарч хөдөлмөрийн багаж зэвсэг хийж эхэлжээ. Түүнтэй хамт хүмүүсийн хоорондын харилцааны чухал хэрэгсэл-хэл үүсч хөгжсөн. Газар тариалангийн хувьсгал бол

⁵ Stephen K. Sanderson. Social Transformations: A General Theory of Historical Development. Blackwell Publishing Inc. , Cambridge. Mass. , 1995.

⁶ The development of sedentary and nomadic civilizations. 700 B. C. to A. D.

⁷ The third Wave: Democratization in the late twentieth century Samuel Huntington. University of Oklahoma Press. 1996.

⁸ Ц. Доржсүрэн. Умард Хүннү (Северная Хунну). УБ. , 1961.

өөрийн үндсэн шинж чанараараа аж ахуйн хувьсгал байсан бөгөөд түүний ачаар хүнсний үйлдвэрлэл хөгжилтэй болсон. Хөгжилтийн хувьсгалын тухайд гэвэл тэр нь нийгмийн тогтолцоон дахь хувьсгал байсан. Оюуны хувьсгал нь үзэл бодлын үүднээс шашны, философийн гэх янз бүрийн үзэл санаа үүсэх эхлэлийг тавьсан бөгөөд тэр нь дэлхий дахины хэмжээн дэх хүний оюун санааны цаашдын өсөлт хөгжлийн тохиол болж өгсөн.

XVII-XX зуунд хүн төрөлхтний соёл иргэншлийн хөгжилд шинэ хувьсгал гарсан бөгөөд түүний үр дүнд аж үйлдвэрийн нийгмийн үндэс тавигдаж, сансрыг эзэмших зам мөр засагдаж, цөмийн төдийгүй нано, био технологийн болон компьютерын үйлдвэрлэл, мэдээллийн /ИТ/ технологи хөгжиж, тэр бүхний ачаар хүн төрөлхтөн орон зай, цаг хугацааны хил хязгаарыг даван туулах оргон боломж бий болж, шинэ эрин зууны болон орчин үеийн мэдээллийн соёл иргэншлийн эхлэлийг тавьсан билээ.

Гараад буй XXI зуун дэлхийн соёл иргэншлийн хөгжилд үзүүлэх өөрийн нөлөөний хүчээрээ онцгой өвөрмөц онцлогтой юм. Чухамхүү энэ зуунд дэлхийн даяаршил, мэдээлэл зүй, шинжлэх ухаан, технологи, хүрээлэн буй орчин болон байгальд хандах шинэ чиг хандлагыг хөгжүүлэх нөхцөлүүд бүрдэх болно.

Дээр дурдсан хүчин зүйлүүд өнгөрөгч зуунуудын дэлхийн соёл иргэншилд нөлөөлж байсан дайн, аж

үйлдвэр, эдийн засгийн интеграци зэрэг тэр хүчин зүйлүүдээс агуулгаараа ч, нөлөөллөөрөө ч илүү давамгайл шинжтэй, ихээхэн баялаг юм. Шинэ нөхцөл дэх соёл иргэншлийн хөгжлийн эдгээр шинэ шинэ хандлага, зүй тогтлуудыг судлахын тулд соёл иргэншлийн онолын үзэл баримтлалыг боловсруулах явдал онцгой чухал болж буй нь мэдээж билээ.

Нийгмийн оюун санааны түүхэнд "соёл иргэншил" гэдэг ойлголтын үндсэн агуулгын талаар янз бүрийн үзэл бодлыг дэвшүүлж байсан. Үүнийг өөр өөр эрин зууны сэтгэгчид хийж байлаа. Тухайн асуудал эдүгээ ч шинжлэх ухааны судалгаанууд эрдэмтэн судлаачдын анхаарлын төвд байна. Жишээ нь ЮНЕСКО-гоос 1994 онд хэвлэн гаргасан "Culture and Civilization" ("Соёл ба иргэншил") гэсэн судалгааны бүтээлд "соёл иргэншил" гэдэг ойлголтыг энэ үгийн явцуу утгаар нь буюу "хотжилт" гэсэн яг махчилсан орчуулгаар ухаж болохгүй бөгөөд энэ ойлголт цаад утгаараа илүү өргөн агуулгыг илэрхийлж байна гэжээ. Соёл иргэншилд хамрах хүрээ нь нийгмийн (социальный) амьдрал бүхэлдээ, нийгэм, төрийн удирдлага, эрх зүй, соёл, бичиг үсэг, боловсрол, технологи, шинжлэх ухаан, урлаг энэ бүхний эв зохицолт цогц нь юм. Хар ухаанаар тунгаавал **соёл иргэншил** нь хүн, түүний олонлог болсон гэр бүл, угсаатан, улс үндэстний оршин аж төрөх орчин, хэв маягийг бүхэлд нь агуулсан ухагдахуун гэх үндэстэй

байна. Ийм хандлага, аргаар уг ухагдахууны үндсэн агуулга, ач холбогдлыг оновчтой тодорхойлж болно гэх үндэстэй байна.

Бид энэ тодорхойлолтыг орчин үеийн соёл иргэншлийн шинжлэх ухааны судалгаануудын үр дүнг нэгтгэж дүгнэсэн, мөн чанарыг нь тунгаасан зөв тодорхойлолт гэж үзэж байна.

Соёл иргэншлийг судлах шинж их ухааны гурван бие даасан үзэл хандлага байдаг⁹. Үүнд:

- формацийн үзэл хандлага
- Дэлхийн тогтолцооны үзэл хандлага
- Иргэншлийн үзэл хандлага эдгээр юм.

Сүүлийн үед эрдэмтдийн анхаарал соёл иргэншлийн ирээдүйн хувь заяаны асуудлуудад улам бүр төвлөрөх болов. Эрдэмтэн судлаачид даяаршил болон дангааршлын хүрээг хамарсан **зураглал (сценарийг)**-ыг санал болгож байна байна.

Бид дараах зургаан сценарийг харьцуулах үндсэн дээр энэ талаар өөрсдийн бодол санаа, байр сууриа илэрхийлэх оролдлогыг хийлээ¹⁰. Үүнд:

1. Нэгдэх сценарийн мөн чанар нь дэлхий нийтээрээ нэг л соёл иргэншилд тухайлбал, барууны соёл иргэншилд шилжих, бусдыг бүгдийг

⁹ Cultures and Civilizations, Integral Study of the Silk Roads. UNESCO Publishing, 1994.

¹⁰ B. Enkhuvshin, M. Tumorjav, G. Chuluunbaatar. Nomadic: Civilizations, cultures and development // International Symposium on Nomads and Use of pastures today, Collection of abstracts, Ulaanbaatar, 1999.

нь соёл иргэншлийн үеэ өнгөрөөсөн “үзмэр” болгон “музей”-д өгөх санал тавьж буйд оршиж байна. Бидний бодлоор энэхүү үзэл баримтлал нь өрөөсгөл, улс үндэстний соёл иргэншлүүдийн өвөрмөц онцлог, хөгжлийг үгүйсгэсэн шинжтэй бөгөөд тиймээс янз бүрийн хүн зоны олонлог/нэгдлүүд/-уудын хувь заяа, “авир араншин/чиг хандлага/ хангалттай тусгаж чадахгүй юм.

2. Уламжлал, шинэтгэлийг хосолсон соёл иргэншлийн хөгжлийн хосолмол сценарийг өөрөөр хэлбэл, алгуур аажим, жам ёсны зугуухан хувьслын хувилбарыг дэвшүүлж байна. Энэ сценари нь соёл иргэншлийн хөгжлийн логикийг илүү нарийн тусгаж байна гэх үндэстэй байна.

3. Гурав дахь сценари нь локал соёл иргэншлүүдийн хөгжил дэх алив өөрчлөлтийг зөвхөн гаднын нөлөөгөөр хийгдсэн хэмээн үзэхгүй байх, учир нь үндэстний болон голомтолсон/локаль/ соёл иргэншил нь өөрийгөө хамгаалах, өвөрмөц онцлогоо хадгалах, гаднын аливаа ноёрхол, давамгайллын эсрэг “өөрийн дархлаа”-тай байдаг гэж үздэг. Энэ сценариар соёл иргэншлүүд нь эдийн засгийн даяаршил болоод хөгжлийн “хөлийг тушдаггүй”, харин эсрэгээр нийтлэг дэвшил хөгжлийн хүчин зүйлүүдийг дэмждэг. Бидний үзэж буйгаар энэхүү сценарт сайн зүйл, хандлага байгаа ч төдийлөн явууртай биш юм. Учир нь энд энэ тэр соёл иргэншлийн онцлогийн “сайн болоод саар”-ын

харьцуулалтыг харааныхаа гадна үлдээж, бүх зүйлийг хийсвэрээр “соёлын дотоод дархлаан”-ны хүчин зүйлийн ач холбогдлыг хэтрүүлэн л хамаатуулдаг байна.

4. Дөрөв дэх сценари нь локал соёл иргэншилд засвар оруулах шаардлагагүй, “боловсронгүй болгож” бүр ч болохгүй, учир нь тэр нь өөрийнхөө байгаагаараа л оршин тогтнох чадвартай гэдэг үүднээс ханддаг. Ямар ч соёл иргэншил өөрөө өөрийнхөө хувьсал хөгжилтэй зөрчилддөггүй гэж үздэг байна.. Бидний үзэж буйгаар соёл иргэншлийн ирээдүйн талаарх энэхүү үзэл нь мөн л төдийлөн оновчтой биш юм. Учир нь энэ үзэл соёл иргэншлүүдийн хязгаарлагдмал, явцуу түгжигдмэл байдлыг номлодог.

5. Тав дахь сценари нь соёл иргэншлийн хөгжил болоод өөрчлөн хувиргах асуудлыг тусгайлан авч үзэх шаардлагагүй, харин биотехнологийн болон мэдээллийн хөгжилд л аль болох илүү анхаарал тавих хэрэгтэй хэмээн өгүүлдэг. Энэ үзэл баримтлалын зарим нотолгоо нь анхаарал татаж байна, бүр наанадаж хэлэхэд л энд соёл иргэншлийн хөгжилд хамгийн хүчтэй нөлөө үзүүлж буй тэр хоёр хүчин зүйлийг тэргүүн зэрэгт тавьж байна гэж бид үзэж болох талтай.

6. Эцэст нь, зургаадугаар сценари нь барууны соёл иргэншлийн ноёрхолд цаашид анхаараад байх шаардлагагүй, учир нь ийм хандлага ноёлж, давамгайлж, бас ч зарим

талын ач холбогдол өгч байсан цаг үе улирч өнгөрсөн, харин "соёлуудын нэгдэн нийлэх нийтлэг талбар"-ыг бий болгоход, тэгэхдээ дорнын соёл иргэншилд голлон анхаарч, түүгээр л дамжуулан бусад соёл иргэншилд нөлөө үзүүлж болно гэж тунхагладаг. Бидний бодлоор энэ хувилбар мөн л соёл иргэншлийн хөгжлийн ирээдүйг бүрэн хэмжээгээр төлөөлж чадахгүй, учир нь тэр нь соёлын эрт дээр үеийн уламжлалт хоёр хэв маягийг бие биеийнх нь эсрэг сэргүүлэн тавьж байна. Ийнхүү соёл иргэншлийн хөгжлийн ирээдүйн талаар дэвшүүлж буй төрөл бүрийн сценариуд ерөнхийдөө ийм байна.

Одоо дээр өгүүлсний дагуу монголчуудын соёл иргэншлийн хөгжлийн үндсэн зааг хязгааруудыг авч үзэхэд сонирхолтой байна. Монголчуудын аж ахуй эрхэлж байсан технологи болон аж амьдралын хэвшил нь манай эриний өмнөх хоёр дахь мянганаас эхэлсэн эртний түүхтэй билээ. Монголын соёл нь нүүдлийн соёл иргэншилтэй салшгүй амин холбоотой юм. Монголчууд хүн төрөлхтний түүхэнд нүүдэлчдийн дахин давтагдашгүй соёл иргэншлийг цогцлоосон ард түмэн.

Тухайлбал: Монголчууд нүүдлийн амьдрал, ахуйд туйлаас зохицсон, буулгаж барихад тун амархан гэр хэмээх өвөрмөц дугуй орон сууц болон хасаг тэрэг бүтээж мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах, үндэсний хувцас оёж шидэх технологийг бий болгосон.Эцэг

дээдэс маань тэмээ, адууг тээврийн хэрэгсэл болгон ашиглаж байсан бөгөөд Төв Азийн нүүдэлчдийн нэг түүхэн гавьяа бол Ази, Европыг холбосон алдарт Торгоны замыг тэд л гаргасан бөгөөд тэр нь Өрнө, Дорнын соёлын солилцоо болон түүний харилцан холбоотой хөгжилд өргөн боломжийг нээсэн явдал юм. Аж амьдралын нүүдлийн хэв маяг гарч ирсэн нь анхны хөдөлмөрийн том хуваарь үүсэх нөхцөлийг бүрдүүлж, цэргийн зэвсэг бүтээх болон түүнийг боловсронгуй болгох үйлст хувь нэмэр оруулсан билээ Тэд хэлний шинэ шинэ бүлийг үүсгэхэд маш чухал үүрэг гүйцэтгэсэн.

Бидний өвөг дээдэс орчин цагийн шуудан холбоо, бараа бүтээгдэхүүний солилцооны арга технологи, цаасан мөнгөн тэмдэгт бүтээн оюуны болон биет соёлыг цогцлоон хот (Хархорин) сүндэрлүүлсэн төдийгүй эрхшээсэн олон улс үндэстний соёл иргэншлийг бүтээсэн гавьяатай.

Окада Хидэхиро: "Чингис хаан Монгол хэмээх үндэстний эцэг болой. Тэгээд ч зогсохгүй Чингисийн үр хойчис Азиас Европ хүртэл тархан суурьшиж, олон төр улс байгуулж, өрнө дорнын ертөнцийг холбосноор дэлхийн түүхийн чиглэл өөрчлөгдсөн хүн төрөлхтөн XIII зуунаас эхлэн шинэ цаг үетэй золгосон юм. Энэхүү шинэ эриний үүдийг нээсэн хүн бол Чингис хаан. XIII зуунд Чингис хааны байгуулсан эзэнт гүрэн XIV зуунаас хойш олон шинэ улсыг төрүүлсэн нь өнөөгийн дэлхийн голлох улсууд

болжээ. Хятад, Солонгос, Энэтхэг, Турк, Орос, Төв Азийн Турк хэлээр ярилцагч Исламын улс орнууд цөм монголын эзэнт гүрнийг залгамжилсан төр улсууд билээ... Ийнхүү Чингис хааны Монголын эзэнт гүрэн зүүн талдаа Солонгосын хойг, Хятадаас баруун талдаа Газрын Дундад Тэнгис хүрсэн бараг бүх улс орныг бий болгожээ. Чингис хаан дэлхийг бүтээсэн ажгуу"¹¹. Даяаршил, шинжлэх ухаан, мэдээллийн технологийн эринд үндэсний соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангах, өвөрмөц дахин давтагдашгүй өнгө төрхийг хадгалан хамгаалах, хөгжүүлэх, нүүдлийн болон суурьшлын иргэншлийн зөрчлийг зохицуулах зэрэг нь Монголын соёл иргэншлийн нэн чухал.

¹¹ Чингис хаан, түүний үр сад. 2019.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ҮНДСЭН ХУУЛЬД ЗАХИРАГДАХ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ



Шихихутуг их сургуулийн
Судалгааны хүрээлэнгийн нарийн
бичгийн дарга. Доктор(Ph.D),
профессор Б.Нармандах

Түлхүүр үг:

Хуульд захирагдах, Үндсэн хуулийг дээдлэх, Үндсэн хуулийн хяналт, Үндсэн хуулийн цэц.

Оршил

Хараат бус, шударга шүүхийн хяналтаар дамжуулан иргэний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, эрх зүйт ёсны үзэл санааг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор энэхүү илтгэлийг толилуулж байна.

Үндсэн хууль хууль зүйн хүчин чадлын хувьд эцсийн бөгөөд дээд хүчинтэй байж, төр засгийн эрх мэдэл ард түмнээс үүдэлтэй, засгийн үйл ажиллагаа хуулиар хязгаарлагдсан, хууль нь хүний эрхэд үндэслэсэн, эрх зүйт ёсны үзэл санааны дээд илэрхийлэл байх нь улс төрийн эрх мэдлээс хараат бус, шударга шүүхийн оршин байх үндэс мөн.

Тиймээс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2

дугаар зүйлийн 2.1-д “Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн хуулийг дээдлэх... нь Цэцийн үйл ажиллагааны мөн үндсэн зарчим мөн” хэмээн хуульчилсан байдаг.

Цэц Үндсэн хуульд захирагдах зарчмын агуулга нь Цэцийн үйл ажиллагаа, шийдвэр бүхэлдээ Үндсэн хуулийн зүйл заалт төдийгүй түүний үзэл баримтлал, агуулга, зарчимд бүрнээ нийцсэн байх явдлаар илэрхийлэгдэнэ.

Үндсэн хуулийн хяналт бодитойгоор хэрэгжиж эхэлсэн 200 гаруй жилийн тэртээгээс эдүгээг хүртэл Үндсэн хуулийн хяналтын байгууллага улс орнуудад харилцан адилгүй цаг хугацаанд харилцан адилгүй эрх хэмжээтэйгээр үүсэж¹, тэдгээрийн бүрэн эрх, хяналтын агуулгад байнга хувьсал өөрчлөлт гарч хөгжиж ирсэн. Тухайлбал, 20 дугаар зууны сүүлчээр Польш, Унгар, Словак зэрэг Төв болон Зүүн Европын орнуудын Үндсэн хуулийн шүүх болон парламентын олонх хоорондын ардчилсан өөрчлөлтийн үйл явцын дараа шүүх хэт их эрх мэдэлавсан нь шүүхээс хууль тогтоох байгууллагуудын маневр хийх боломжийг хэтэрхий хязгаарласан,

¹ Үндсэн хуулийн тусгай шүүх нь Австрид 1919, Лихтенштөйд 1925, Грект 1927, Испанид 1931, Ирландад 1937, Францад 1958, Туркэд 1962, Польшид 1982, Унгарт 1989, Африкт 1993, Украинд 1996 онд гэх зэргээр өнөөдрийн байдлаар 64 улсад дагнасан хэлбэрээр ажиллаж байна.

улс төрийн талбарт орж ирсэн гэх сөргөлдөөн нь шүүх эрх мэдлийн болон хууль тогтоох байгууллагын харилцааны хязгаарыг хөндсөн олон улсын сонирхлыг ихээр татсан асуудал болсон.²

Энэ үйл явц шүүхийн улс төрийн ач холбогдол өсөн нэмэгдэж байгааг харуулсан, шүүх үйл ажиллагааны хүрээгээ тэлж, ердийн эрх зүйн хүрээнд хүн, хуулийн этгээд, төр хоорондын маргааныг хянан шийдвэрлэх хил хязгаарыг өргөтгөн, төрийн байгууллагууд хоорондын хяналт, тэнцвэрийн хил хязгаарыг шинэчлэн тогтоох замаар шүүхийн улс төрийн үйл явц дахь оролцоо, бодлого боловсруулалтын өнөөгийн "стандарт"-ыг бий болгох асуудал түгээмэл үзэгдэл болон өргөжиж байгааг харуулж байна. Гэхдээ энэ нь дэлхий даяар өргөн цар хүрээтэй болж чадаагүй байна.

Нөгөө талаас Үндсэн хуулийн шударга ёс, хууль дээдлэх зарчмын урьдчилсан нөхцөл болсон Үндсэн хуулийн шүүхийн хараат бус, хүчирхэг байдлыг гажуудуулах, сөргөөр нөлөөлөх зэргээр шүүхийн улс төржилт бий болох замаар улс үндэснүүдийн Үндсэн хуульд ёсны шаардлагыг гажуудуулах эрсдэлд хүргэдгийг дэлхийн цөөнгүй улс орнуудын үндсэн хуулийн практик харуулсан.³

² *Kölmön Pycza. Constitutional Politics and the Judiciary: Decision-making in Central and Eastern Europe.*, 2019

³ АНУ-ын 1860 оны иргэний дайн, ОХУ-ын 1993 оны Үндсэн хуулийн хямрал гэж нэрлэгдсэн улс төрийн сөргөлдөөн. Каталаны 2017 оны тусгаар тогтнолын хөдөлгөөн, Филиппин дэх 1999 оны Үндсэн хуулийн хямрал, Казакстаны ҮХЗ-ийн

Эндээс харахад ардчилсан улс орнуудад Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуульд ёсны зарчим болон төрийн эрх мэдэл хуваарилах онолын шаардлагын хүрээнд Үндсэн хуульд захирагдсан, судалгаанд үндэслэсэн, төвийг сахисан, бие даасан шийдвэрээрээ дамжуулан улс төрийг Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, хэм хэмжээний хүрээнд орших хязгаарыг тогтоох чадамжтай байж, улс төрийн дарамт шахалтыг хязгаарлах шаардлага үүснэ.

Нөгөө талаас улс төрийг шүүх ажиллагааны цар хүрээ, мөн чанар, шалтгаан, түүнчлэн шүүхийн статусыг тодорхойлох асуудал ч анхаарал хандуулахыг шаарддаг. Энэ бол Үндсэн хуульд захирагдах зарчмын онолын үндэс мөн.

Үндсэн хэсэг.

Монгол Улс анх 1992 оны Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1-д "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага мөн"⁴ хэмээн зааснаар Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх шүүх байгуулах эрх зүйн үндэс бүрдсэн бөгөөд Улсын Бага Хурлын 1992 оны хаврын V чуулганы 7 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар Үндсэн хуулийн

Ерөнхийлөгчийг эсэргүүцэх эрхийг хязгаарласан г.м

⁴ Монгол Улсын Үндсэн хууль, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

цэцийн анхны бүрэлдэхүүнийг баталж, Үндсэн хуулийн хяналтын механизмыг бий болгосон нь манай улсын хувьд Үндсэн хуулийн дархлааг бэхжүүлсэн нэн чухал ач холбогдолтой үйл явдал байсан.

Үндсэн хуулийн шүүхийн хянан шийдвэрлэх маргааны агуулга, маргагч талуудын ёс зүйгээс хамааралтайгаар Үндсэн хуулийн шүүх “улс төржих” эрсдэлийг бий болгож байдаг бөгөөд Үндсэн хуулийн хяналтыг улс төржүүлснээр ардчилсан зарчмыг зөрчиж, улс төрийн хүчнүүдийн хоорондын зөрчлийг хурцатгаж, нийгэмд бухимдал үүсгэж нийгмийн хөгжлийг саатуулах болон бусад сөрөг үр дагаврыг төрүүлэх аюултай.

Тиймээс ч Монгол Улсын Үндсэн хуулийн жаран дөрөвдүгээр зүйлийн 2-т “*Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна*”, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2 дугаар зүйлд “*Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах⁵, Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн хуулийг дээдлэх, судалгаанд үндэслэх, төвийг сахих, бие даасан, ил тод байх нь Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн*”, Монгол Улсын Үндсэн хуулийн

цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “*Гагцхүү Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, хараат бус байх, гишүүд эрх тэгш байх, цэцийн шийдвэр хууль ёсны, үндэслэлтэй байх... нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим мөн*” гэж тус тус заасан.

Монгол Улсад Үндсэн хуулийн шүүх үүсэж байгуулагдсанаас хойш эдүгээг хүртэлх 30 жилийн хугацаанд Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхийнхээ хүрээнд 297 шийдвэр гаргасан байна. Эдгээр шийдвэрүүд нь Монгол Улсын Үндсэн хуулийг чандлан сахиулах үйл хэргийн илэрхийлэл мөн.

Тиймээс Үндсэн хуулийн Цэцийн дээрх шийдвэрүүдийг эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд өргөнөөр оруулж, Үндсэн хуулийн эрх зүйн онол-арга зүйн хүрээнд судлах, нийтээр хэлэлцүүлэх замаар Монгол Улс дахь Үндсэн хуульд ёсны төлөвшлийг үнэлэх, хөгжүүлэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох зүйн хэрэг.

Учир нь ҮХЦ-ийн шийдвэр, түүний хянан хэлэлцвэл зохих маргааны талаар:

- Нэг асуудлаар өөр өөр агуулгатай шийдвэр гаргасан;
- УИХ-аас Цэцийн шийдвэрийг үл ойшоон хүчингүй болгосон хууль тогтоомжийг яг өмнөх агуулгаар

⁵ Оросын эрдэмтэн С.В.Боботов. “Дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмын шинжтэй нийгмийн нийтлэг үнэт зүйлс бий болж Үндсэн хуульд тусгалаа олсон. Үндсэн хууль нь хууль зүйн дээд хүчин чадалтай акт болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн, Үндсэн хуулиас гадуур нийгмийн харилцаа хэрэгжих боломжгүй.”

нь дахин баталдаг;

- Цэц зарим тохиолдолд өргөдөл, гомдол, мэдээллээр ирүүлсэн асуудлаар маргаан үүсгэн шалгах ажиллагаанд цаг хугацааны шалгуур баримталдаггүй;
- Цэцээс маргаан үүсгэж хянан хэлэлцээд гаргасан дүгнэлтийн талаар парламентаас тогтоол ирүүлдэггүй;
- ҮХЦ-ээс өргөдөл, гомдол, мэдээлэл, хүсэлтийн хүрээнд хянан шийдвэрлэсэн маргаантай холбоотой тухай хуулийн зохицуулалт л хүчингүй болдог нь, парламентаас түүнтэй адил үйлчилж буй Үндсэн хуулийн хэм хэмжээ зөрчсөн хууль тогтоомжийг хуульд нийцүүлэх боломж байдаггүй;
- Цэцийн шийдвэр зарим талаар ойлгомжгүй гардаг зэрэг Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн чанар чансаа, тэдний төвийг сахих чадвар, цэц мэргэн байдал, тэдний ёс суртахуун, ажил хэрэгч байдал зэрэгт итгэх итгэлд зарим талаараа эргэлзээ төрүүлж ирснийг Үндсэн хуулийн эрх зүй судлаачид тухай бүр байр сууриа илэрхийлж ирсэн байдаг.⁶

Энэ удаад миний бие ҮХЦ-ийн хянан хэлэлцсэн болон хянан шийдвэрлээгүйгээс нийгмийн хэлэлцүүлэгт өргөнөөр орсон, процессын явцдаа болон араасаа маргаан дагуулж ирсэн зарим үйл баримт, шийдвэрүүдийг түүвэрлэн

⁶ Ж.Амарсанаа, Үндсэн хуулийн маргаан, УБ., 2012

авч эдгээр асуудлыг Үндсэн хуулийн улс төр-эрх зүйн нэгдмэл шинж⁷ болон Үндсэн хуульд захирагдах зарчмын хэрэгжилт талаас үнэлэхийг зорьж, өөрийн дэвшүүлэн тавьж буй байр суурийг баталгаажуулах, дэмжлэг авах зорилгоор зарим эрдэмтэн, судлаачдын байр суурийг эх сурвалжийн хамт шигтгээ болгон толилуулж байна.

БАРИМТ-1.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд “Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжөөр шүүгчийг албан тушаалаас түдгэлзүүлэх” тухай нэмэлт оруулах тухай хуулийг 2019 оны гуравдугаар сарын 27-ны өдөр УИХ баталсан бөгөөд энэ нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Үндсэн хуулийн бус аргаар шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль болон шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, журмыг баримтлахгүйгээр дур зоргоороо шийдвэр гаргах эрх зүйн үндсийг бүрдүүлжээ.

Энэ асуудлаар УДШ-ээс энэ хууль Үндсэн хууль зөрчсөн эсэхийг тогтоолгохоор ҮХЦ-д хүсэлт гаргасны зэрэгцээ нэр бүхий 9 иргэн мэдээлэл ирүүлсэн байдаг.

Гэвч ҮХЦ тус маргааныг хянан хэлэлцээгүй бөгөөд энэ талаар нийгэм болоод улс төрийн хүрээнд

⁷ Л.Гарлицкий, Үндсэн хуулийн хяналтын улс төрийн аспектиг түүний Үндсэн хуулийн үндсэн дээр бусад хуулийг тайлбарлах явдал нь Үндсэн хуулийн шүүхийг улс төрийн байгууллага гэсэн ойлголтыг бүрэн төрүүлдэг.

нэлээд өргөн хэлэлцүүлэг өрнөсний эцэст 2021 оны 01 сарын 15-ны өдөр баталсан Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар дээрх алдаа засагдсан.

Ерөнхийлөгчийн санаачилснаар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд оруулсан дээрх нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн төрийн эрх мэдэл хуваарилах онолын буюу хяналт тэнцлийн зарчмыг гажуудуулсан, шүүхийн хараат бус байдалд нөлөөлсөн улс төрийн шинжтэй шийдэл байсан гэж үзэж байна

ШИГТГЭЭ 1.

<https://ikon.mn/n/1j6w>

УИХ-ын гишүүн С.Эрдэнэ: Энэ хуулийг Үндсэн хууль зөрчсөн байх магадлалтай гэж харж байна. УИХ өөрийн Үндсэн хуулиар олгогдсон ямар нэгэн байгууллагын зөвлөмжөөр шийдвэр гаргадаг болвол хууль тогтоох байгууллагын үндсэн үүрэг алдагдана. Өөр чиг үүрэг бүхий институцийн шийдвэрийг хүлээн авч, тусгадаг болох нь хууль тогтоох байгууллагын чиг үүрэг алдагдана гэж харж байна...

ШИГТГЭЭ 2.

<https://news.mn/r/2377726/> (2020-11-30)

Үндсэн хуулийн Цэц улс төрийн захиалга биелүүлдэг байгууллага болсон

Үндсэн хуулийн Цэцийн талаар хуульч Б.Баяраатай ярилцлаа.

-Сүүлийн үед ҮХЦ-ийн шийдвэр, үйл ажиллагааны талаар хуульчид нэлээд шүүмжлэлтэй хандах болсон шалтгаан юу вэ?

-Ерөнхийлөгчийн зүгээс 2018 онд Үндсэн хуульд заасан шаардлага хангахгүй иргэдийг Цэцийн гишүүнд нэр дэвшүүлж, улмаар УИХ томилсон нь хуульчид судлаачдын дунд хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан. ҮХЦ-ийн гишүүн бол хуульч хүний хувьд мэргэжлийн дээд карьер гэж үздэг. Тэр утгаараа хуульч мэргэжлээрээ ажиллаж байгаагүй, энэ салбарт хүлээн зөвшөөрөгдөөгүй, танигдаагүй иргэд Цэцийн гишүүнээр томилогдсоныг эсэргүүцэх нь зүйн хэрэг. ҮХЦ нэртэй боловч тогтсон ойлголт нь Үндсэн хуулийн шүүх юм...

-Үндсэн хуулийн Цэцэд улс төрийн захиалга биелүүлдэг гишүүд томилогдсон гэж үү?

-ҮХЦ хараат бус байж, гагцхүү Үндсэн хуульд захирагдахын зэрэгцээ Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж, түүнийг чандлан сахиулах баталгаа болдог. Энэ утгаараа УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгч болон төрийн өндөр албан тушаалтнуудын шийдвэр, үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянадаг шүүхийн байгууллага юм. Өөрөөр хэлбэл, өөрийг нь нэр дэвшүүлдэг, томилдог байгууллагыг ч эргээд хянах үүрэгтэй. Гэтэл хуульд заасан шаардлага хангахгүй, мэргэшсэн бус этгээд томилогдсон нь нэр дэвшүүлэгч даргынхаа захиас даалгаврыг биелүүлэх зорилгоор ам өчиг өгч албан тушаалд очсон гэх хардлагыг эрхгүй үүсгэсэн.

-Гэхдээ хувь хүний хувьд хардаж болно, хуульчийн хувьд үндэслэл хэлж болох уу?

-Цэцийн эдгээр гишүүн томилогдсоноос хойш хэн нь хэн бэ гэдгийг харах 2,6 жилийн хангалттай хугацаа өнгөрлөө. Харамсалтай нь хуульчдын хардаж байсанчлан нэр дэвшүүлсэн улстөрчийнхөө захиас даалгаврыг биелүүлж эхэлсэн баримтууд тодорхой болж байна. Тухайлбал, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд “Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжөөр шүүгчийг албан тушаалаас түдгэлзүүлэх” нэмэлт оруулах тухай Ерөнхийлөгчийн санаачилсан хуулийг УИХ 2019 оны гуравдугаар сарын 27-ны өдөр баталсан. Маргааш нь УДШ-ээс энэ хууль Үндсэн хууль зөрчсөн эсэхийг тогтоолгохоор ҮХЦ-д хүсэлт гаргасны зэрэгцээ мөн нэр бүхий 9 иргэн мэдээлэл ирүүлсэн байдаг. Гэтэл Ерөнхийлөгчийн санаачилсан хуулийг Үндсэн хууль зөрчсөнийг тогтоолгох хүсэлтийг Ерөнхийлөгчийн санаачилж нэр дэвшүүлсэн Цэцийн гишүүнд хуваарилаад өнөөдрийг хүртэл бүтэн 20 сар гаруй хугацаанд дунд суудлын хуралдаан зарлахгүй “хав дарж” байгааг сонирхлын зөрчилгүй гэж үзэх үү. Цэцийн гишүүн бүрэн эрхийнхээ дийлэнх хугацааг маргаан гацаасан байдалтай өнгөрүүлсэн байна. Үндсэн хуульд заасан “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, “Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана”, “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын гишүүн ... хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэснийг илэрхий зөрчсөн энэ хуулийг ҮХЦ шийдвэрлэхгүй байгаа нь ардаа маш их хор уршиг дагуулж байна. Тухайлбал ҮАБЗ бүх шатны шүүгчийн төлөөллийг оролцуулан 17 шүүгчийг “үзүүлэн” болгож албан тушаалаас түдгэлзүүлэн эрүүгийн хэрэгт шалгаж эхэлсэнээр шүүх эрх мэдэл бүхэлдээ улстөрчдийн гарт хуулийн дагуу орсон гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, шүүгч ажил, амьдралгүй болохгүйн тулд хуульд захирагдах зарчмаасаа ухран улс төрийн захиалгаар шийдвэр гаргах эхлэлийг энэ хууль тавьсан. ҮАБЗ-ийн хууль бус шийдвэрийн улмаас УДШ-ийн иргэний танхим бүрэлдэхүүнгүй болж бүтэн жил гаруй хугацаа алдаж хэрэг маргаан шийдвэрлэж байгаа нь муу үр дагаврын нэг жишээ юм. Гэтэл энэ хууль нь эрх зүйн ухралт болсоныг УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгчийн бүх түвшинд хүлээн зөвшөөрч алдаагаа засаж залруулах тухай ярьж байхад хүртэл ҮХЦ таг гацсан хэвээрээ байна. УИХ-ын дарга Шүүхийн багц хуулийн хүрээнд цаашид ҮАБЗ-өөс шүүхийг хянах шаардлагагүй болсон гэж чуулганы нээлтэд мэдэгдсэн бол Ерөнхийлөгч тухайн цаг үеийн шаардлагаар баталсан тул цаашид хэрэггүй гэж үзээд өөрийн өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр хасаж оруулсан гэсэнтэй Засгийн газрын хуулийн төслийн байр суурь ч мөн адил байна. Ер нь Үндсэн хуулийн суурь зарчмын нэг болох төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг илт алдагдуулсан муу хуулийн үр дагаварт улс төрийн хэрэгт олон иргэд хэлмэгдсэн тухай нийтээрээ ярьж байна. Хэрэв УИХ Үндсэн хууль зөрчсөн хуулийнхаа сөрөг үр дагаврыг амсаж, өөрөө алдаагаа хүлээн зөвшөөрч засах хүртэл хүлээх юм бол Цэцтэй байхын шаардлага юу байна. Энэ хуулийг буцаан хүчингүй болгох хуулийг УИХ-ын 17 гишүүн өргөн барьсан байгаа. Харин Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг даргалахын зэрэгцээ Шүүхийн ерөнхий зөвлөлийг томилдог, шүүгчийг түдгэлзүүлж, томилж, чөлөөлөх замаар шүүхэд нөлөөлөх онцгой давуу эрх эдэлдэг Ерөнхийлөгчид Цэцийн шийдвэр гарахгүй удах нь ашигтай нь тодорхой байна....

БАРИМТ-2.⁸

2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч хийх боломж олгосон. Энэ нь төрийн эрх мэдэл хуваарилах онолын эрх мэдэл тэнцвэртэй, хяналттай, хуваарилагдсан байх зарчмыг гажуудуулж, хууль тогтоох эрх мэдлийн байгууллагаас гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад тавих хяналтыг сулруулсан.

Үйл баримтын үндэс болсон Үндсэн хуулийн заалтын өөрчлөлт

1992 оны 01 дүгээр сарын 13-нд баталсан Монгол Улсын Үндсэн хууль	2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт	2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт
<p>Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг:</p> <p>"1.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй."</p>	<p>Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг:</p> <p>"1.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй."</p>	<p>Гучин есдүгээр зүйл:</p> <p>1. Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно...</p> <p>4. Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид т а н и л ц у у л с н а а р Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө."</p>

⁸ Хорин есдүгээр зүйл. 1.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй./Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан, 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Үндсэн Хуулийн Цэцийн 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон, 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан/

УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүний үүргийг хавсран эрхлэх явдал Үндсэн хууль зөрчсөн эсэхийг тогтоолгох асуудлаар Үндсэн хуулийн цэц

- 1996 оны 7 дугаар сарын 17-ны өдөр 06 дугаар дүгнэлт,⁹
- 1996 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр 03 дугаар тогтоол,
- 1998 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 9 дүгээр дүгнэлт,
- 1998 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр 02 дугаар тогтоол,
- 2000 оны 3 дугаар сарын 15-ны өдөр 3 дугаар дүгнэлт,
- 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр 2 дугаар тогтоол тус тус гаргаж байсан бөгөөд Цэцийн дээрх дүгнэлт, тогтоолууд бүгд “Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн байх нь эрх мэдлийг хуваарилсан Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй” гэсэн нэг л байр суурьтай байсан.

Тухайлбал, 1998 оны 11 сарын 24-ний өдрийн их суудлын хуралдаанаараа иргэн Д.Ламжавын өргөдөлд үндэслэн 1997 оны 2 сарын 6-нд батлагдсан «Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль»-ийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн тухай маргааныг хянан хэлэлцсэн байна. Уг хуралдаанаар Цэц УИХ-аас 1998 оны 1 сарын 15-нд баталсан «Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль»-иар УИХ-ын гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсран ажиллаж болохоор зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн ялгаа зааг, харилцан бие биедээ хяналт тавих Үндсэн хуулийн үзэл баримтлалын агуулгатай зөрчилдөж байна гээд «Монгол Улсын Их Хурлын гишүүний тухай хууль»-ийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалт «Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдвол хавсран ажиллах үүрэгтэй», мөн зүйлийн 3 дахь хэсгийн «Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж болно», 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн « Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдох” гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн «...Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэснийг зөрчсөн байна хэмээн эцэслэн шийдвэрлэж 2 дугаартай тогтоол гаргасан байдаг.

Цэцийн дээрх шийдвэрүүдийг шинжлэн үзэхэд, УИХ-ын нэг ч гишүүн Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж болохгүй бөгөөд хэрэв хавсран гүйцэтгэж буй тохиолдолд мөн л Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал болох төрийн эрх мэдэл хуваарилах зарчим алдагдаж байгаа хэрэг болно.

⁹ <https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=31&active=1&page=1&sort=enacteddate&page=1>

ШИГТГЭЭ 3.*Зууны мэдээ. 2012.7.09. №16. 4-р тал***Б.Чимид: Энэ бүгдийг хэлэх цаг нь болжээ**

...УИХ, Засгийн газрыг тойрсон бужигнаан бол өөрөө өөртэйгөө орооцолдсон нэг л юмны ялзрал, доройтлын илрэл, УИХ дотор л болж байгаа үзэгдэл. Яагаад гэвэл, Засгийн газар бараг бүхэлдээ УИХ-ын гишүүдээс, УИХ нь Засгийн газрын гишүүдээс бүрддэг болсон. Ингэж эрх мэдэл хуваарилах, хариуцлага, хяналтыг зааглах Үндсэн хуулийн зарчмыг үгүйсгэсэнд харамсавч барахгүй. Өмнөх Засгийн газрын арав гаруй, одоогийн 17 сайд бүгд УИХ-ын гишүүн байгаа. Нэг харвал Засгийн газрын гишүүн, нөгөө харвал парламентын гишүүн.

Төрийн эрх мэдлийг ингэж хутгаснаас болж парламентаас Засгийн газарт тавих хяналт зэрэглээ төдий болсон. Засгийн газрын гишүүдийн эрхэлсэн ажлын талаар ноцтой баримтууд хэвлэлээр гардаг, түүний мөрөөр хянаад шийдэж байгаа юм өнөөдөр парламентад алга. Жишээ нь, Засгийн газрын нэлээд гишүүн төсвийн мөнгийг тэрбум, тэрбумаар нь хэтрүүлсэн баримтыг аудит гаргаад ирсэн. Гэтэл түүнийг ултай судлаад ард түмэнд хариу өгсөнгүй. Бид сайд байхдаа ажилтнууддаа томилолтын найман төгрөг илүү өгчихөөд цалингаараа төлж, төсвийн сахилгыг "төмөр" мэт сахиж байлаа шүү дээ. Гэтэл өнөөдөр энэ их мөнгийг бие бие рүүгээ чихээд сууж байгаа нь тэвчишгүй. Энэ мэтийн жигшээ олныг хэлж болно. Ингээд үзэхээр шалтаг, шалтгаан бол асуудал бүр дээр байгаа. Гэхдээ л хямралын цаад эх нь Үндсэн хуульд хийсэн 2000 оны өөрчлөлт мөн шүү...

ШИГТГЭЭ 4.*Б.Чимид Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. УБ. 2006. 112-113 дах тал*

... «Үндсэн хууль өөрчлөх шаардлага байна уу гэсэн асуултад: Өөрчлөгдөхгүй хууль гэж үгүй. Харин төрийн байгууламжийн тогтолцоо, түүний зарчмын суурь асуудлын хувьд Үндсэн хуулиар оролдох нь төр, улсын амьдралд хор хохирол учруулж болзошгүй байдаг.

Учир нь Үндсэн хууль бол түр зуурын буюу хэсэг хугацааны хөтөлбөр биш, харин ард түмний нэгэнт сонгосон зам болох нийгмийн яс булчингийн тогтолцоог язгуураар нь зангидсан, зүйл бүр нь авцалдаатай суурь хууль бөгөөд түүнээс аль нэг судсыг тасалбал бусад сүлжээндээ шарх үүсгэдэг. Үүнийг дордуулсан долоон өөрчлөлт тод харуулав. Иймд юу юугүй өөрчлөхийн оронд хохирол багатай буюу хор хөнөөлгүй арга замыг олох хэрэгтэй байдаг. Үүний тул түүний үг бүрийн утга, үзэл баримтлалыг гүнзгий ойлгож хэрэгжүүлэх, нарийвчилсан зөв тодорхой, Үндсэн хуульчилсан (органик) хууль, ердийн хууль, дэгээр (стандарт) оролдох нь зөв байдаг. Энэ бол олон улс оронд нотлогдсон зүйл болох нь маргаангүй. Юм л бол Үндсэн хуулийг ямар нэг хэрэглээний заавар, дэг журамчлага (процедур) шиг ойлгож гоочилдогоо болих цаг болсон...

ШИГТГЭЭ 5.

"Иргэний оролцоо" сэтгүүл. УИХ-ын гишүүн Н.Батбаяр, Д.Лүндээжанцан, Д.Дэмбэрэл, Р.Гончигдорж, С.Баярцогт, С.Оюун, Н.Батцэрэг нарын гишүүдээс бүрэн эрхийнхээ дагуу санаачлан боловсруулсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

...УИХ-аас Монгол улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нийт иргэдээс санал авахад иргэд, судлаачдыг ихэнх нь УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүний үүрэгт ажлыг хавсран гүйцэтгэж байгаа нь Үндсэн хуулийн гол үзэл баримтлал болох төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг алдагдуулж Эрх мэдэл хуваарилах зарчмыг алдагдуулж, парламентыг гүйцэтгэх эрх мэдэл нь давамгайлж байсан хуучин тогтолцоог сэргээсэн гэж саналаа өгсөн байна.

Харьцангуй цөөн тооны гишүүнтэй манай улсын хувьд Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр давхар ажиллах нь парламентад Засгийн газрын нөлөөллийг бий болгох, Засгийн газарт тавих хяналтыг сулруулах сөрөг талтай юм. Жишээ нь, Н.Алтанхуягийн Засгийн газрын 19 гишүүний 17 нь Улсын Их Хурлын гишүүн байв...

БАРИМТ-3

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн Х.Баттулга Ерөнхийлөгчийг дахиж сонгуульд оруулахгүй байх өөрчлөлт болсон гэх маргаан бүхий үйл баримтын үндэс болсон Үндсэн хуулийн заалт, түүний өөрчлөлт

1992 оны 01 дүгээр сарын 13-нд баталсан Монгол Улсын Үндсэн хууль	2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт
<p>Гучдугаар зүйл</p> <p>2."Ерөнхийлөгчөөр дөчин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно."</p> <p>7. "Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно."</p>	<p>Гучдугаар зүйл.</p> <p>2.Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.</p>

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.4, 5.6, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай" 2021 оны 04 дүгээр сарын 16-ны Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 02 дугаар дүгнэлтээр "Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн

сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт «Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.», Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт «Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.», Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт «Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.» гэж заасныг зөрчсөн байна.» гэж дүгнэснийг УИХ хүлээн зөвшөөрсөн.

ШИГТГЭЭ 6. <https://dnn.mn> Ерөнхийлөгчийн зөвлөх Л.Болд. «УХЦ улс төржиж, улс төрийн хараа хяналтад орвол маш аюултай» гэв.

... өнгөрсөн онд бид аргагүйн эрхэнд Үндсэн хуулийн мухардалд орж шударга ёсны хувьсгал, томоохон хөдөлгөөн хийж байж дахиад Үндсэн хуулиа өөрчилсөн. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлт 30 жил гажуудаж байсан ардчилалд байгаа алдаа дутагдалыг засахад чиглэгдсэн. Гэтэл өнөөдөр үүнийг мушгиж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн Х.Баттулга Ерөнхийлөгчийг дахиж сонгуульд оруулахгүй байх өөрчлөлт болгосон аль нэг улс төрийн хүчний бодлого руу хальтарч байгаа нь өөрөө маш аюултай.

Үүнийг бид бүгдээрээ байж байгаад баталсан. Ингэхдээ хэн нэгэн хүний, Монгол Улсын нэг ч иргэний сонгох сонгогдох эрхийг нь хязгаарлах асуудал тавигдаагүй. Ард түмэн сонгуулиа хийж байг л дээ. Ард түмэн сонголтоо хийж байг.

Өнөөдөр хэн нэр дэвших нь тодорхойгүй байхад ийм зохицуулалт, тохируулга хийж байгаа нь Монголын нийгмийг 30, 20, 10 жилийн өмнө хөтөлж байсан Үндсэн хуулийн хямрал руу дахиад түлхэж байна. Үндсэн хуулийн цэц ийм хямрал руу ард түмнээ түлхэсний цаана монголын ард түмэн хохирч байдаг. Өнөөдөр нөхцөл байдал маш ноцтой болж байна. Монголын ард түмэн 30 жилийнхээ ололт амжилт, ардчилсан тогтолцооныхоо үндсийг уландаа гишгүүлэхийг хүсэхгүй...

БАРИМТ-4.

Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга Үндсэн хуулийн цэцэд хандан 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн Е/11 дүгээр албан бичгээр Монгол Улсын шүүхийн тухай хууль бүхэлдээ Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх асуудлаар хүсэлт гаргасан бөгөөд мөн оны 3 дугаар сарын 11-ний өдрийн Е/18 дугаар албан бичгээр хүсэлт гаргасныг Үндсэн хуулийн цэц 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Дунд суудлын хуралдаанаараа хянан хэлэлцэж, 03 дугаар дүгнэлт гаргасан.

Тус дүгнэлтээр Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтоох нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэгт зааснаар хууль тогтоогчийн

бүрэн эрхийн хүрээнд хамаарах хэдий ч ийнхүү хуульчлахдаа Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын хүрээнд тодорхойлогдсон Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус таван гишүүнийг бусад институцээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох талаарх чиглэлийг баримтлаагүй гэж үзэхээр байна. Ингэснээр шүүх эрх мэдлийн байгууллагын хараат бус байдал болон Үндсэн хуулиар баталгаажсан төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлж, Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3, 5, 6 дахь хэсгийг зөрчсөн гэж үзэж хуулийн холбогдох зохицуулалтыг 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн тус тус түдгэлзүүлсэн.

ШИГТГЭЭ 7.

<https://news.mn/r/2414794/> Т.Доржханд: Ерөнхийлөгчийн даалгаараар Цэц ажиллаж байна

...-Т.Д: Үндсэн хуулийн Цэцийн өнөөдөр эрх мэдэлтэй, албан тушаалтай хүний нөлөөнд автаж байна гэсэн дүгнэлтийг хийж байна. Ялангуяа Цэцийн зарим гишүүн нь маш тодорхой үйлдэл гаргаж байна. "Үндсэн хуулийн Цэцийн дээр Үндсэн хууль, түүний дээр хөх тэнгэр байна" гэж хэлдэг нь Үндсэн хуулийн дээр ямар нэгэн дарга байх ёсгүй гэсэн санаа. Гэтэл Цэц дээр Монгол Улсын Ерөнхийлөгч очсоны үр дүн нь одоо гарч байна.

Хоёрдугаарт, УИХ-ын гишүүн байхаас үл хамаарч жирийн иргэнийхээ хувиар Үндсэн хуулийн Цэцэд мэдээлэл гаргасан. Гэтэл иргэдийн гаргасан мэдээллийг нь улс төрийн нөлөөгөө ашиглаж бүр тодорхой хэлбэл, өөрийнх нь томилсон Цэцийн гишүүдээр дамжуулж бидний гаргасан мэдээллийг хүчингүй болгох ажлыг хийж байна. Ийм байдлаар цааш явах юм бол ҮХЦ-ийг татан буулгах ёстой гэсэн байр суурийг улстөрчийнхөө хувьд хатуу илэрхийлье.

Гуравдугаарт, Үндсэн хуулийн Цэцийн үйл ажиллагааг маш сайн хуульчлах шаардлага үүсчээ. Саяхан УИХ-аар Шүүхийн багц хуулийг шинэчилж, улс төрөөс хамааралгүй байлгах алхмыг нь хийсэн. Гэтэл Үндсэн хуулийн шүүх байгууллага нь улс төрөөс шууд хамааралтай үйл ажиллагаа явуулдаг нь нотлогдлоо. Ийм учраас энэ байгууллагыг өөрчлөх цаг нь болсон байна...

Гэтэл Монгол Улсын Ерөнхийлөгч 2021 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн Е/04 дүгээр албан бичгээр ирүүлсэн «Хүсэлтээс бүхэлд нь татгалзах тухай» хүсэлтийг ҮХЦ-д ирүүлсэн бөгөөд ҮХЦ хүсэлтийг хүлээн авах тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 9 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар тогтоол гаргасан.

Энэ үйл баримт болон ҮХЦ-ийн шийдвэртэй холбон үзэхэд хүсэлтээс бүхэлд нь татгалзах тухай хүсэлтийг хэлэлцэж тогтоол гаргасан процессын хувьд хуульд нийцсэн мэт боловч агуулгын хувьд улс төрийн шийдэлтэй үйл явц байсан.

Дүгнэлт, санал

ШИГТГЭЭ 8.

Ц.Сарантуяа. Үндсэн хуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны зарим асуудал «Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн үндсэн асуудлууд» олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс. 2021,

ҮХЦ-ийн дунд суудлын хуралдаанаас шийдвэр нэгэнт гарсан байхад маргалдагч өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн шаардлагаасаа татгалзах нь өөрөө хууль зүйн логикгүй. Үндсэн ухуулт зөрчсөн, зөрчөөгүй аль ч тохиолдолд. Маргагчийн шаардлагаасаа татгалзах эрхийг нэгэнт хуулиар хязгаарлаж өгөөгүй, хязгаарлах тохиолдлыг хуурьчлаагүй тул маргагч тал уг эрхийг эдлэх боломж хууль зүйн хувьд нээлттэй байна. Жишээ нь. Шүүхийн тухай хуульд ШЕЗ болон сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр УИХ дангаар томилохоор заасан. Энэ асуудлаар ҮХЦ-ийн 2021 оны 4 сарын 3 дугаар дүгнэлт Үндсэн хууль зөрчсөн гэж гарсан боловч, УИХ 2021 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 41 дүгээр тогтоолоороо дүгнэлтийг хүлээн авахаас татгалзсан байна.

ҮХЦ их суудлын хуралдаанд бэлтгэх явцад Монгол Улсын ерөнхийлөгч 2021 оны 9 сарын 6-ны өдрийн Е/4 дүгээр албан бичгээр хүсэлтийн шаардлагаас татгалзсан байна.

Шүүмжлэл:

Цэц УИХ-ын тогтоолыг хэлэлцэх ёстой байтал хүсэлтийг хэлэлцсэн Их суудлын тогтоол 2/3 саналаар гарах байтал 1/2 саналаар гарсан.

Бодит байдал: Улсын их хурлын тогтоолыг өмнөх хүсэлтээсээ татгалзах тухай Ерөнхийлөгчийн шинэ хүсэлтийг хэлэлцэхээс өмнө хэлэлцэх боломжгүй байсан бөгөөд хүсэлтийг хүлээгээд авбал УИХ-ын тогтоолыг хэлэлцэх шаардлагагүй.

Харин Цэц хүсэлтийг хуралдаан хийлгүйгээр хүлээгээд авсан бол өмнөх дүгнэлт нь Хүчинтэй хэвээр үлдэх байсан

Тухайн асуудлаар цэцэд хандаж өргөдөл мэдээлэл хүсэлт гаргах нь нээлттэй болохыг Цэц шийдвэртэй дурдсан. Иймд Цэц асуудлыг эцэслэн шийдвэрлэхээр дахин хянаагүй тул тогтоолыг гуравны хоёрын саналаар гаргахгүй.

Асуудлын гол нь:

Хүсэлтээр ирүүлсэн шаардлагаас татгалзсаныг маргааны зүйл үгүй болсон гэж үзэх үү.

Дээрх баримтууд болон түүнийг дагалдан нийгэмд үүссэн маргаан бүхий хэлэлцүүлгүүд нь Үндсэн хуулийн шүүх болон парламент, төрийн тэргүүн зэрэг Үндсэн хуулийн институтууд тухайн цаг үе дэх улс төрийн ашиг сонирхлын улмаас Үндсэн хуулийн үзэл баримтлалыг гажуудуулах асуудал цөөн биш удаа гаргаж ирснийг харуулж байна. Энэ нь Үндсэн хуулийн улс төр-эрх зүйн нэгдмэл шинжийн тэнцвэрийг хангаж чадаагүйтэй холбоотой.

Иймд ҮХЦ-ийн улс төрөөс хараат бус байх дотоод болон гадаад баталгааг улам бүр боловсронгуй болгох асуудал шаардагдаж байна.

Үндсэн хуулийн эрх зүйн шинжийг хадгалж, Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд захирагдах зарчмын шаардлагыг хангах хүрээнд:

1. Үндсэн хуулийн институт хоорондын үл ойлголцол, зөрчилдөөнд байдлыг процессын хуулийн хугацааг нарийн журамласан дэг, хугацаагаар шахах замаар арилгах боломжтой гэж үзэж байна. Тиймээс DUE PROCESS-ийн шаардлагын хүрээнд энэ талаарх зарим нэмэлт, өөрчлөлтийг Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд тусгах;
2. Үндсэн хуулийн субъектүүдийн Үндсэн хууль зөрчсөн, зөрчиж болзошгүй үйлдлүүдийг Үндсэн хуулийн зөрчил хэмээн хуульчлан тогтоох замаар улс төрийн хүсэл зоригоос эрх зүйг хамгаалах нөхцөл бүрдүүлэх;
3. Үндсэн хуулийн цэцийн гадаад эрх зүйн баталгааг бүрдүүлэх хүрээнд цэцийн гишүүнд тавих "мэргэшсэн байх" шалгуур хуулиар нэмж тогтоох шаардлагатай.

Нөгөө талаас, Үндсэн хуулийн улс төрийн шинжийг үгүйсгэж болохгүй. Энэ хүрээнд улс төрийн ашиг сонирхол, эрх чөлөөний хязгаарыг хүлээн зөвшөөрөх, түүнийгээ ёс зүйтэй хэрэгжүүлэх эрх зүйн ухамсрыг парламентчдад төлөвшүүлэх, нөлөөлөх нөлөөллийн болон зохион байгуулалтын арга хэмжээг идэвхжүүлэх, VOLUNTARY үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх нь үндсэн хуулийн эрх зүй судлаачдын нийгмийн хариуцлага мөн болохыг цохон тэмдэглэж байна.

Энэ хүрээнд Үндсэн хуулийн цэцийн хараат бус, төвийг сахисан байр сууринд итгэх ард түмний итгэлийг нэмэгдэх зэрэг талтай.

НЭГДМЭЛ МОНГОЛ УЛС



*Шихихутуг их сургуулийн Хувийн
эрх зүйн тэнхимийн багш
А.Доржготов*

Монгол Улсын Үндсэн хуулиар даяар олноо зарлан тунхагласан эрхэм зорилго, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын талаар Үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан өмнө ¹ товч өгүүлсэн билээ.

НЭГДМЭЛ МОНГОЛ УЛС гарчгийн дор төрийн байгууламж нэгдмэл, засгийн бүх эрх ард түмний мэдэлд, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын тухай хууль зүйн ойлголтод тулгуурлан өөрийн үзэл бодлоо илэрхийлэхийг эрмэлзэв.

Нэгдмэл монгол улс. Монгол Улсын үндсэн хуулийн Хоёрдугаар зүйл дор "Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна" хэмээн батлан заажээ. Мөн зүйлд "Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана" гэжээ. Үндсэн хуулийн эдгээр заалт, үзэл баримтлал өнөө цаг дор хэрхэн хэрэгжин биелж

байгаа талаар ажиглалт судалгаанд үндэслэн өгүүлэв. Сэдвийн дор:

Төрийн байгууламж бол улсын бүтцийн суурь ойлголт² байдаг. Энэ нь улсынхаа нутаг дэвсгэрийг засаг захиргааны хуваарилалт, түүнд харьяалуулсан хүн ам, удирдлагын болон орон нутгийг эрх барих байгууллагын тогтолцоог цогц байдлаар зохицуулахад оршино. Монгол нэгдмэл улсын тул нэг үндэстний нутаг дэвсгэртэй .Төр засгаас хуульчлан тогтоосон эрх зүйн байдалтай засаг захиргааны нэгжүүдэд хуваагдсан шинжээрээ нэгдмэл улс юм. Тиймээс улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана.

Хууль зүйн ном бүтээлд төрийн байгууламж нь тухайн улсын болон түүний бүрэлдэхүүнд багатах хэсгүүдийн эрх зүйн байдал, харилцааг тусгасан байдаг. Монгол Улсын үндсэн хуулийн заалт "Монгол Улсын хүн амын бүрэлдэхүүн нэг үндэстнийхээс гадна төрийн байгууллагын уламжлалт зохион байгуулалтад үндэслэсэн" болохыг тэмдэглэсэн³ байдаг. Монгол Улсын үндсэн хуулийн тайлбарт⁴ Монголын Үндсэн хуулиар төрийн байгууламжийн

¹ Шихихутуг их сургуулиас эрхлэн гаргасан тусгай дугаарт 2021 он.

² С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий тол бичиг УБ, 2021 он, X-407.

³ Ж.Амарсанаа, Г.Баясгалан, Т.Мөнхжаргал, С.Нарангэрэл, Г.Соёд, Г.Уранцэцэг, "Хууль зүйн тайлбар толь", УБ, 2003 он, X-248.

⁴ Г.Соёд, Н.Жанцан, Ж.Амарсанаа, С.Жанцан, Монгол Улсын үндсэн хуулийн тайлбар, УБ, 2000 он.

нэгдмэл улсын хэлбэрийг сонгон авч хуульчилсан явдал бол: а/. Монгол Улсын төрийн байгууламжийн уламжлалыг тусгасан, б/. Монгол Улсын хүн ам үндсэндээ нэг үндэстний бүтэцтэй, в/. Хэл, соёл, зан заншил, амьдралын уламжлалт нийтлэг хэвшилтэй зэрэг нь төрийн нэгдмэл бүтэцтэй байх нөхцөлийг бүрдүүлдэг талаар тодорхой тусгажээ.

Төрийн байгууламжийн нэгдмэл хэлбэрийн үндсэн шинж нь орон нутагт төрийн эрх барих байгууллагын үйл ажиллагаа ямар нэгэн дамжлагагүйгээр шууд хэрэгждэг. Улмаар засаг захиргааны нэгжид хуваагддаг оршино. Үндсэн хуулийн хоёр дугаар зүйлийн 2 хоёр дахь хэсэгт заасан Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хуваагдана гэсэн заалтыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай *Шинэчилсэн найруулга*/ Монгол Улсын хуулиар нарийвчлан зохицуулсан. Энэ хуулийн зорилт нь "Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах, иргэд орон нутгийн үйл хэрэгт шууд болон сонгож байгуулсан төлөөллийн байгууллагаараа уламжлан оролцох эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд оршино." гэж тодорхойлсон. Улмаар хуулийн аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо нь нийтийн эрх зүйн этгээд байхаар, аймаг, сум, нийслэл, дүүрэг эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно

хэмээн тодруулан заасан. Мөн Нийслэл, дүүрэг, хорооны эрх зүйн үндсэн шинжийг тогтоосон байна.

Хууль тогтоомжийн эдгээр заалт зохицуулалтаас үзвэл үндсэн хуулийн үзэл баримтлал бүрэн хэрэгжиж байгаа, төрийн байгууламжийн нэгдмэл байдал бүрэн хангагдсан байдал харагдана. Тийм боловч анхаарах асуудлууд ажиглагдана.

Нэгдүгээрт: Нэгдмэл Монгол Улсын талаар хууль тогтоох байгууллага, засгийн газрын хүрээнд бага ярьж байна. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2021 оны 11 сарын 16-нд хэлсэн үгэндээ "Үндсэн хуулиараа Монгол Улс бол нэгдмэл улс" гэдгийг онцлон сануулсан нь чухал ач холбогдолтой.

Хоёрдугаарт: Улсын нэгдмэл байдлыг анхаарахгүйгээр холбооны улс мэт үйл ажиллагаа явуулдаг засаг захиргааны нэгжийн удирдлага, УИХ-ын гишүүд хааяахан анзаарагдах болов. Боловсруулж байгаа хууль тогтоомж нэгдмэл улсад тохиромжтой биш зохицуулалт бас харагдана. Энэ асуудалд хамааруулан бодол санаагаа илэрхийлэхэд :

- Монгол Улсын төрт ёсны уламжлалыг огоорон ор тас орхиж болохгүй
- Монгол Улсын хүн ам үндсэндээ нэг үндэстний бүтэцтэй гэдгийг мартаж болохгүй
- Хэл, соёл, зан заншил, амьдралын уламжлалт нийтлэг

хэвшилтэй зэргийг бодитой хийгдсэн судалгаа тооцоонд үндэслэх хэрэгтэй. Судалгаа, түүний үр дүнг тооцохдоо зөвхөн барууны амьдралын жишээнд тулгуурлан хуулбарлах замаар тодорхойлдог, арга зүйн хувьд ч ихээхэн харьцаж байгааг анхаарах хэрэгтэй болжээ.

Гуравдугаарт: Монгол Улсад "Үндэсний цөөнх" гэх үзэл санаа цухалзах болсон байна. Тийм ойлголт яриа нэгдмэл улсын хувьд, манай орны хувьд байж болохгүй. Үндэстэн өөрийн оршин суух нутаг дэвсгэртэй өөр улсад дагаар орсон, эзлэгдсэн зэрэг шалтгаанаар үндэсний цөөнх гэх үзэл ойлголтыг тодорхойлж болно. Тиймээс ч тусгаар тогтнох, өөртөө засан тохинох эрхтэй болох зэрэг шаардлага тэмцэл өрнүүлэх үндэслэл болж болох юм. Өөр улсад цагаачлах, дүрвэх зэрэг шалтгааны улмаас суурьшсан цөөнх үндэстэн ийм үзэл санаа илэрхийлэх эрхгүй гэж үзэж болно. Эдгээр нь тухайн улсын иргэншилтэй болсон ч, тодорхой нутаг дэвсгэрт төвлөрөн суурьшсан ч "Үндэсний цөөнх" гэсэн үзэл санаанд тулгуурлан өөртөө засан тохинох эрх, тусгаар тогтнох зэрэг нэгдмэл улсад байж үл болох ажиллагаа явуулах эрхгүй гэж үзэж болно. Үүнээс гадна монголын үндэстэн ястан, аймаг орон нутгаараа талцах, нэгдмэл улсын хууль тогтоомжид үл нийцэх үйл ажиллагаа явуулах ёсгүй. Монгол Улсад "Увс хүн, Говь-Алтай, Дорнод, Сүхбаатар хүн, баруун зүүн монгол,

Төв халх гэсэн ялгаварлах үзэл санаа байж болохгүй. Бид бүгдээр Монгол Улсын иргэн- монгол хүн гэдгээрээ бахархах энэ үзэл санаанд нэгдэн нягтрах асуудал чухал болжээ.

Дөрөвдүгээрт: Монгол Улсын үндсэн хуулиар тодорхойлсон нутаг дэвсгэр засаг захиргааны нэгж, түүнийг бэхжүүлэхэд нэн анхааралтай хандах шаардлагатай болов. Өнөө цагт Үндсэн хуулийн өөрчлөх тухай асуудал яригдаж байх шиг байна. Манай орон цөөн хүн амтай өргөн уудам газар нутагтай билээ. Тиймээс орон нутаг засаг захиргааны нэгжийн эрхийг хүндэтгэн үзэх нэн ач холбогдолтой. Хүний тоонд үндэслэн төрийн тогтолцоог бий болгох нь орон нутаг газар шороогоо эзгүйдүүлэх аюултай. Иймээс төвлөрлийг сааруулах, орон нутагтаа тархан суурьших, орон нутгийн төлөөллийг бэхжүүлэн төрийн үйл хэрэгт орон нутаг засаг захиргааны оролцоог нэмэгдүүлэх хууль тогтоомжийн зохицуулалт нэн чухал болжээ.

Тавдугаарт: Нэгдмэл улсад үл нийцэх нийгмийн задрал бий нөхцөл байдал ажиглагдах болсон. Иймээс нийгмийн үр ашиггүй талцах үзэл санааны задралаас сэргийлэн зохицуулах хууль тогтоомжийн тогтолцоо бий болгоход нэн анхаарвал зохино. Энд янз бүрийн шашны олон урсгал, улсыг нэгдмэл байдлыг алдагдуулан задлах тодорхой зорилгод суурилсан төрөл бүрийн ургалч үзэл санаа зэргийг хамааруулж байгаа болно.

НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ТАЛААРХ ЭРДЭМТДИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТУХАЙ



Хууль зүйн ухааны доктор, (Ph.D)
дэд профессор, цагдаагийн
хурандаа Ж.Мөнхболд

Товчлол: Энэхүү өгүүллээр Оросын нийтийн эрх зүйн талаарх үүсэл, хөгжил, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд, нийтийн эрх зүйн нэгдмэл байдал, зөрчлийн шийтгэл, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд, төрийн албадлага, засаглалын эрх мэдлийн хуваарилалт, эрх мэдлийн төвлөрлийн тухай оросын эрх зүйн шинжлэх ухааны зарим төлөөлөгчдийн үзэл баримтлалыг авч үзсэн болно.

Түлхүүр үг: Зөрчлийн шийтгэл, Гүйцэтгэх эрх мэдэл, Төрийн албадлага, Засаглалын эрх мэдэл.

Үндсэн хэсэг:

**САНКТ-ПЕТЕРБУРГИЙН ИХ
СУРГУУЛИЙН РЕКТОР, ХУУЛИЙН
ТЭНХИМИЙН ПРОФЕССОР
И.Е.АНДРЕЕВСКИЙ (1831-1891)**

– *Нийтийн засаглалыг төвлөрүүлэх И.Е.Андреевскийн үзэл баримтлал.*

– *Албадлага нь засаглалын үйл ажиллагааны үндэс болох нь.*

Оросын нэрт эрх зүй судлаач, Санкт-Петербургийн Их сургуулийн ректор, Цагдаагийн хуулийн тэнхимийн профессор **И.Е.Андреевский (1831-1891)** нь үлэмж эрх мэдэл бүхий төвлөрсөн гүйцэтгэх засаглалын талыг баримтлагч хүн байв.

Захиргааны арга хэмжээнүүдийн төрлүүд нь тухайн үйлдлийн нийгмийн аюултай байдалд тохирсон байх ёстой бөгөөд урьдчилан сэргийлэх арга хэмжээнд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Тухайлбал, "...хяналтын зохих арга хэмжээнүүдийн тусламжтайгаар төрийн өмчид халдсан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломжтой. Хяналтын эрх мэдлийг албан тушаалтнуудын шатлан захирагдах ёсонд тулгуурласан дотоод хяналт, төрийн мэргэшсэн байгууллагуудын хэрэгжүүлдэг гадаад хяналт гэж хуваадаг..."¹ хэмээн тэмдэглэсэн байна.

Нийтийн хэв журам зөрчсөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цагдаагийн байгууллагуудын харьяалалд гүйцэтгэх үүрэгт хамааруулдаг байсан бөгөөд тэдгээр цагдаа нар бие махбодын шинжтэй албадлагын арга хэмжээ авах эрхтэй байжээ.

¹ Андреевский И.Е. Цагдаагийн эрх зүй. 1-р боть. Аюулгүй байдлын цагдаа. СПб., 1874, 283 дахь тал.

Зөвхөн орон нутгийн засаг захиргаа болон цагдаагийн байгууллагуудын уялдаа холбоотой хүчин чармайлтаар л харьяат ард иргэдийн хувийн өмчид халдсан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, илрүүлэх боломжтой юм.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний агуулга нь "... аюулаас урьдчилан сэргийлэх, аюул заналыг арилгах..." арга хэмжээнүүд гэдгээрээ ялгаатай байв. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний төрлүүд нь гэмт этгээдийн хүсэл зоригоос үл хамаарах субъектив ба объектив нөхцөл байдлаас хамаардаг.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь анхан шатны урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй адил бөгөөд хууль зөрчсөн үйлдлүүд гарах хүчин зүйлүүдийг илрүүлэн тодорхойлоход оршдог бол хоёрдогч арга хэмжээ болох «аюултай байдлыг арилгах» нь тааламжгүй хүчин зүйлийг арилгахад чиглэдэг. «Аюулаас урьдчилан сэргийлэх болон түүнийг арилгах» арга хэмжээг Андреевский органик нэгдмэл байдлаар нь авч үзсэн бөгөөд тэдгээрийн аль нэг нь нөгөөгөөсөө түрүүлэх нь гарцаагүй. Хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоох нь харьяат ардуудын эрхийг хязгаарласан бие махбодын болон ёс суртахууны нөлөөлөл хэрэглэхтэй холбоотой бөгөөд эдгээр арга хэмжээ нь бага зэргийн гэмт хэрэг, зөрчил гаргасан тохиолдолд ч гарцаагүй байдалтай байдаг.

Профессор И.Е.Андреевский гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй нийгмийн үндсэн хүчин зүйлүүд болох юу ч хийхгүй хоосон, зорилгогүй амьдрал, үрэлгэн байдал, бодлогогүй, хувиа хичээсэн зан үйл гэх мэтийг тодорхойлонгоо албадлагын арга хэмжээ, жишээ нь, засан хүмүүжүүлэх ажил зэргийг авч үзсэн байдаг. Тэрбээр бичихдээ «Хүн амынх нь хамгийн их хэсэг нь газар тариалан эрхэлдэг Орос улсад ажлын байруудыг өөр хэлбэрээр, хийх ажилгүй, хөдөлмөрийн чадвартай хүмүүсийг заавал хийх албадлагын хөдөлмөр эрхлүүлэх хэлбэрээр бүрдүүлж болно»² гэсэн байна. Тэгэхдээ эдгээр шийтгэлийг эвлэрүүлэн зуучлах шүүхээс ногдуулах ёстой байв.

Энэ тохиолдолд Европын аж үйлдвэржсэн орнуудаас ялгаатай нь зөвхөн Орос улсад байдаг засан хүмүүжүүлэх ажлын онцлогийг тодруулахыг хичээн бичсэн нь харагдаж байна. Үүний зэрэгцээ Андреевский эвлэрүүлэн зуучлах шүүхийн захиргааны харьяаллыг өргөжүүлэхийг санал болгож байв. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний агуулга дотор хууль ёсны үйл ажиллагааг үндэслэгч нийгэм - эдийн засаг, эрх зүйн хүчин зүйлсийг онцлон тэмдэглэж байв. Тухайлбал, аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн салбарт төрийн протекционист³ буюу хамгаалалтын

² Андреевский И.Е. Цагдаагийн эрх зүй. 1-р боть, Аюулгүй байдлын цагдаа. СПб., 1874, 283 дахь тал.

³ Үндэсний эдийн засгаа гадаад худалдаа, эдийн засгийн тэлэлтээс хамгаалж, гаалийн татвараар дамжуулан эдийн засаг худалдааг ивээх төрийн бодлого.

бодлого явуулах үндэслэлийг гаргасан бөгөөд тэдгээрийн дотор худалдаа-үйлдвэрлэл эрхлэгчдэд янз бүрийн хөнгөлөлт, давуу эрх олгох, хэрэглээний шинжлэх ухааны хөгжилд материаллаг туслалцаа үзүүлэх зэргийг дурдсан байна.

– “Ард түмнийг боловсруулах үйл ажиллагаа”-ны тухай.

Захиргааны эрх зүйн зөрчил судлалын чиглэлээрх урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдэд Андреевский хүн ардыг боловсруулах үйл ажиллагааг хамааруулжээ. Тэрбээр ард түмний боловсролын үйл ажиллагаа гэдгийг ойлгохдоо ёс суртахууны хөгжил, шашин шүтлэг, оюун санааны болон гоо зүйн боловсрол гэсэн дөрвөн бүрэлдэхүүн хэсгийг нэгдмэл байдлаар авч үзсэн байна. Шашны боловсрол, түүний дотор шашин мөргөлийн үйл ажиллагааг дэмжих, тэргүүлэх сүм хийдийн шатлан захирах ёс журмыг хангах үйл ажиллагаа нь шийдвэрлэх ач холбогдолтой байжээ. «Улс оронд ноёрхож байгаа нь хүлээн зөвшөөрөгдсөн шашны үндсэн зарчмуудыг түгээн дэлгэрүүлэх гарцаагүй байдалтай»⁴ гэж эрдэмтэн тэмдэглэж байв.

1870-аад оны Оросын эрх зүй судлал нь «гэмт хэрэг» гэсэн ойлголтоос ялгаатай «гэм буруугийн» ангиллын шинжлэх ухааны үндэслэлийг тавих анхны оролдлогуудыг хийсэн

⁴ Андреевский И.Е. Цагдаагийн эрх зүй. 2-р боть. Аюулгүй байдлын цагдаа. СПб., 1876, 64 дэх тал.

бөгөөд тухайлбал, эвлэрүүлэн зуучлах шүүгчдийн эрх мэдлийг өргөжүүлэн тэлэх саналуудыг дэвшүүлж байв. Бие хүнийхээ хувьд Андреевскийн байгуулсан гавьяа бол улс, нийгэм аюулгүй байдал, ард түмний сайн сайхны төлөө хууль зөрчсөн үйлдлүүдээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг таслан зогсоох ажиллагааны урьдач хүчин зүйлүүдийн талаар ухааран ойлгосонд оршиж байв.

КАЗАНИЙН ИХ СУРГУУЛИЙН ПРОФЕССОР В.В.ИВАНОВСКИЙ (1854-1926)

– *Нийтийн эрх зүйн судалгаануудын нийтлэг байдал.*

Оросын захиргааны эрх зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд Казанийн Их сургуулийн профессор **В.В.Ивановский** мэдэгдэхүйц хувь нэмэр оруулжээ. Тэрбээр «Оросын төрийн хууль» (Казань, 1898) хэмээх үндсэн бүтээлдээ захиргааны эрх зүй, төрийн эрх зүй, цагдаагийн эрх зүй, эрүүгийн эрх зүй, эрүүгийн гүйцэтгэх ажиллагааны болон хотын эрх зүй зэрэг нийтийн эрх зүйн салбаруудын нэгдмэл байдлыг нотлохыг оролдсон. Тийнхүү эрдэмтний шинжлэх ухааны судалгааны эрэл хайгуулын хүрээнд захиргааны хариуцлагын асуудлууд ч багтаж байв.

XIX зууны сүүл үеийн Оросын хууль тогтоомжид Захиргааны эрх зүйн зөрчил, гэмт хэргийн хооронд норматив тогтоосон зааг ялгаа

байхгүй байсан. Хууль зөрчсөн үйлдлүүдийг зааглан ялгах гол шалгуур нь гэмт хэрэг, зөрчлүүд (учирсан хохирлын хэмжээнээс хамаарч) орон нутгийн шүүх, эсхүл ерөнхий шүүхийн алинд нь харьяалагдах вэ гэдэг асуудалд оршиж байв. Хулгай, залилан болон бусад гэмт хэргийг Сенатын Эрүүгийн хэргийн давж заалдах хэлтсийн шийдвэрийн дагуу «бага зэргийн зөрчил» болгон ангилж байв. Хэрэв зөрчлийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол 30 рублиас хэтрээгүй бол уг зөрчлийг орно нутгийн шүүх авч үздэг байжээ.

Зөрчлийн гэмт хэрэгт ноцтой үр дагавар, гэмтэл учруулаагүй бол хувийн халдашгүй байдалд халдсан, түүнчлэн захиргааны тогтоосон дэг журамд халдсан гэмт хэрэг, тэдгээрийн дотор цагдаад, мөн орон нутгийн болон хөдөөгийн удирдлагууд албан үүргээ гүйцэтгэх үеэр «дуулгаваргүй байдал» гаргасан (өөрөөр хэлбэл, захирагдаагүй); энэ мэт нөхцөл байдалд эдгээр хүмүүсийг доромжилсон, шашны зан үйлийн үеэр зохисгүй байдал гаргасан (нийтийн хэв журам зөрчсөн) гэх мэт үйлдэл багтаж байв. Хууль зөрчсөн бусад олон үйлдлийг бага зэргийн зөрчил гэж үзэж байв, жишээлбэл, хүчтэй согтууруулах ундаа худалдах дүрэм журам зөрчих; ёс суртахуун, нийтийн сайн сайхны эсрэг гэмт хэрэг; оршин суух зөвшөөрлийн төрөл зүйл, барилга байгууламж, харилцаа холбооны тухай хууль

тогтоомж зөрчих; галын аюулгүй байдлын дүрэм зөрчих; хүн амын эрүүл мэнд, хувийн аюулгүй байдалд халдах; хүний нэр төрийг гутаан доромжлох; хүчирхийлэл үзүүлэхээр заналхийлэл (ноцтой хохирол, шарх, гэмтэл учруулахгүйгээр хүн зодох) болон дур зоргоороо авирлах; гэр бүлийн эрх зөрчих, түүнчлэн бусдын эд хөрөнгөнд халдах (түүний дотор бусдын эд хөрөнгийг зөвшөөрөлгүй ашиглах, түүнийг эвдэж гэмтээх, олдсон зүйлийг өөрийн болгон завших, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэх мэт) зөрчлийг дурдаж болно. Бага зэргийн зөрчлийн тоонд мөн иргэдийн хөдөлмөрлөх эрхэд зарим талаар халдах (цалин хөлсний гэрээг зөрчих), түүнчлэн нийтийн хэв журмын зөрчил гаргах («эдийн засгийн эмх замбараагүй байдалд хүргэх» үрэлгэн байдал, архидан согтууралд, өөрөөр хэлбэл, энэ үйлдлээр эд хөрөнгөнд хохирол учирсан бол) зэрэг зөрчил багтаж байв.

XIX зууны сүүлээр Орос улсад эдгээр гэмт хэргийг зөвхөн орон нутгийн шүүхээр авч үздэг байжээ. Эдгээр шүүхээс бага зэргийн зөрчил гаргасан хүмүүст оногдуулдаг байсан шийтгэл нь эрүүгийн гэмт хэрэг үйлдэхэд оногдуулдаг шийтгэлтэй харьцуулшгүй, ихээхэн хүмүүнлэг байсан байна. Орон нутгийн шүүх зөрчил гаргасан хүмүүсийн эд хөрөнгийн болон материаллаг бус эрхийг хязгаарласан таван төрлийн шийтгэл ногдуулах эрхтэй байв.

Үүнд:

- олон нийтийн өмнө зэмлэл хүлээлгэх (энэ тохиолдолд шүүхийн оролцоотойгоор);
- 25 копейкоос 3 рубль хүртэлх мөнгөн торгууль ногдуулах;
- 6 хоног хүртэлх хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх;
- 15 хүртэлх хоногийн хугацаагаар баривчлах, энгийн эсвэл хүнд дэглэм (сүүлийн тохиолдолд гэмт этгээдийг талх, устай байлгах). Илүү ноцтой зөрчил (хулгайлах, залилан мэхлэх, бусдын эд хөрөнгийг завших) гаргасан бол баривчлах хугацааг 30 хоног хүртэл сунгах боломжтой;

20 хүртэл удаа саваадаж занчих. Бие махбодын шийтгэл ногдуулсан орон нутгийн шүүхийн шийдвэрүүд Нутгийн өөрөө удирдах байгууллагын дарга баталсны дараа хүчин төгөлдөр болдог байсан бөгөөд тэрхүү дарга бие махбодын шийтгэлийг мөнгөн торгууль юм уу баривчлах шийтгэлээр солих эрхтэй байжээ.

- *"Шүүхийн удирдах байгууллага" болон дотоод хэргийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг.*

Профессор В.В.Ивановский нь захиргааны албадлагын байгууллагуудын салбар, салбарын эрх мэдлийн тухай онолыг үндэслэсэн хүн юм. Орос улсад XIX-XX зууны зааг дээр шүүх, хуулийн байгууллагуудын хоорондох эрх мэдлийн илэрхий харагдах хуваарилалт байгаагүй. Хууль зүйн

сайд өөрийн шийдвэрээр улс төрийн гэмт хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох эрхтэй байсан бөгөөд тэрбээр гэм буруутай ноёд, түшмэдэд эрүүгийн зарим шийтгэлийг нь хөнгөвчлөх юм уу өршөөл үзүүлэх тухай Сенатын өргөдлийг мөн авч үздэг байжээ. В.В.Ивановский хууль зүйн байгууллагуудад («шүүхийн удирдлагын байгууллагуудад») засаглалын тусгай эрх олгохыг онцолж байсан бөгөөд түүний үзэл баримтлалаар Эрх баригч Сенатын авч үзэж буй захиргааны ихэнх асуудлын хувьд хууль зүйн сайдад ерөнхий прокурорын эрх ногдож байгаа нь түүнийг зөвхөн «бусад сайд нараас дээгүүр төдийгүй Сенатаас өөрөөс нь дээгүүр тавьж байгаа аж»⁵. Европын ихэнх орнуудын Хууль зүйн яам ч ийм статустай байсан байна.

Дотоод хэргийн яамны бүрэн эрхийн хүрээнд В.В.Ивановский хоёр бүлэг эрх мэдлийг онцлон тэмдэглэж байв. Аюулгүй байдлын цагдаагийн газрын харьяалалд төрийн болон нийгмийн аюулгүй байдлыг хангах жинхэнэ цагдаагийн үйл ажиллагаа (жандармын корпус, Цагдаагийн хэлтэс), мөн Хэвлэлийн асуудал эрхэлсэн ерөнхий газраас хэрэгжүүлдэг цензурийн хүрээн дэх хяналт хамаарч байв. Тийнхүү цагдаагийн байгууллагуудыг Дотоод хэргийн яам тэргүүлдэг «дотоод

⁵ Ивановский В.В. Оросын төрийн эрх. 1-р боть: Дээд засаглал ба түүний байгууллагууд. 2 дахь хэвлэл.

Төвийн удирдлагын байгууллагууд. Казань, 1896, 427 дахь тал.

удирдах байгууллагууд"-ын нэг хэсэг гэж үздэг байв.

Хүн амын эрүүл мэндийн чиглэлээр Дотоод хэргийн яамны бүрэн эрхэд Эрүүл мэндийн хэлтэс, Эмнэлгийн зөвлөлийн ажлыг хамааруулж байв. Эмнэлгийн хэлтэс нь «эмнэлэг - ариун цэврийн удирдлага"-ын тогтолцоог удирдаж байсан; Эмнэлгийн зөвлөлийн бүрэлдэхүүнд бусад яамдын албан тушаалтнууд, тухайлбал, Цэргийн эмнэлгийн удирдах газрын дарга, флотын эмнэлгийн ахлах байцаагч болон бусад хүмүүс багтаж байв.

Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудыг (орчин үеийн ойлголтоор) захиргааны байгууллагуудтай адилтгаж байжээ. В.В.Ивановский холбогдох яамдаар толгойлуулсан салбарын захиргааны байгууллагуудыг онцолж байв. Тухайлбал, «санхүүгийн захиргааны байгууллагууд Сангийн яамны тогтолцоонд хамаарч, «Хөдөө аж ахуй, төрийн өмчийн захиргааны байгууллагууд"-ыг Газар тариалан, төрийн өмчийн яам удирддаг байжээ. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд «төвийн удирдлагын байгууллагууд» болон орон нутгийн захиргааны албан тушаалтнуудын, тухайлбал, тойргийн, хилийн, хошууны дарга нар, шуудан, телеграф, гаалийн тойргуудын дарга нарын гүйцэтгэх болон захиргааны үйл ажиллагааг ойлгож байв.

Эдгээр даргын эрх мэдэлд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа багтаж байсан бөгөөд тэд басөөрсдөө төрийн байгууллагуудын үйл ажиллагааны эсрэг харьяат ардын өргөдөл, гомдлыг хүлээн авдаг байжээ. Сахилгын болон захиргааны хариуцлагын хооронд нарийн тодорхой ялгаа байгаагүй, тухайлбал, өөрийнх нь удирддаг гаалийн удирдах байгууллагын ажилтнуудын (гаалийн удирдлага гэх мэт) гомдлыг авч үзэх, торгууль ногдуулах гаалийн тойргийн дарга нарын үйл ажиллагааг захиргааны шийтгэл ногдуулахтай адилтган үзэж байжээ⁶.

Хошууны дарга нарын захиргааны эрх мэдэлд хошууны цагдаа, мужийн харуулуудыг удирдах эрхийг (Польшийн Вант улс болон зарим мужид) хуваарилж, холбогдох сахилгын хэргийг хянан шийдвэрлэх асуудлыг тэдэнд даалгаж байв.

⁶ Ивановский В.В. Оросын төрийн эрх. 1-р боть: Дээд засаглал ба түүний байгууллагууд. 2 дахь хэвлэл:

Төвийн удирдлагын байгууллагууд. Казань, 1896, 294 дэх тал.

**МОСКВАГИЙН ИХ СУРГУУЛИЙН
ХУУЛИЙН ТЭНХИМИЙН
ПРОФЕССОР В.Н.ЛЕШКОВ (1810-
1881)**

Оросын цагдаагийн эрх зүйн онолыг хөгжүүлсэн нь. Оросын ард түмний эдийн засгийн хэт тусгаарлалтын хаалттай бодлогын тухай үзэл баримтлал.

Оросын цагдаагийн эрх зүйг хөгжүүлэхэд Москвагийн Их сургуулийн Төрийн боловсронгуй ба зохист байдлын хуулийн тэнхимийн гавьяат профессор, Хууль зүйн факультетийн декан В.Н.Лешков (1810-1881) онцгой хувь нэмэр оруулсан юм. Оросын нэрт хуульчдын нэг, профессор В.М.Нечаев энэхүү эрдэмтнийг «Москвагийн их сургуулийг алдаршуулсан өв уламжлалыг тээгч, Москвагийн уламжлалт профессорын үлгэр жишээ» хэмээн тодорхойлсон байна.

«Оросын ард түмэн ба төр» (1858) хэмээх үндсэн бүтээлдээ В.Н.Лешков төрийн засаглалын эрх мэдлийг Оросын ард түмний нийтийн автарк буюу эдийн засгийн хэт тусгаарлалтын хаалттай бодлогод эсрэгцүүлэн тавьжээ. Түүний бодлоор ард түмний оюун санааны болон эдийн засгийн тусгаар тогтнол нь түүний үндэс суурь, өдөр тутмын ахуй амьдралаас хол хөндий I Петр хааны шинэчлэлээс болж суларсан байна.

В.Н.Лешков нийтийн сайн сайхныг давамгайлж байдаг хувь хүний эрхийг хамгаалахын төлөө тэмцэгч байв. Түүний бодлоор төрийн засаглалын эрх мэдэл чухамхүү энэ зорилгыг хангах ёстой аж. Тэрээр өөрийн бүтээлдээ "... Бид төрийн чиглүүлэн жолоодох чиг бодлогоор нийтийн ашиг тус эсвэл нийтийн сайн сайхныг чухалчлан тавьдаг онолыг онцгой эсэргүүцэн тэмцдэг. Олон нийтийн эрх зүйн хуулиудын албадлагын хүчин чадал нь зөвхөн эрх зүйн үүднээс л тайлбарлагддаг... Албадлагын хүчин чадлын үндэс суурь нь олон нийтийн хуулийн шударга ёс юм. Энэхүү албадлагын туйлын хязгаар нь хувийн болон нийтийн гэдэг ойлголт хоорондын тэмцлийн шийдэл юм..."⁷ хэмээн тэмдэглэсэн байна.

Олон нийтийн (нийтийн) эрх зүйн үзэл баримтлалыг дэмжигч В.Н.Лешков ард түмний төлөөлөгчдийн бие даасан бүтээлч хүчийг дарангуйлдаг эртний улс орнуудын дотоод бодлогын нийгмийн давхаргыг тусгасан үндэс суурьт шүүмжлэлтэй ханддаг байв. Дундад зууны үеийн нийтийн эрх зүйн институтийн хөгжил нь хувийн аюулгүй байдлыг хангаж чаддаггүй байсан гэж тэрбээр үзэж байв. Түүнчлэн Лешков шинэ үеийн Баруун Европын төрийн захиргааны төвлөрсөн байгууллагуудын нөлөөг хүлээн зөвшөөрдөггүй нэгэн байв. Эрдэмтний үзэж байгаагаар төрийн

⁷ Лешков В.Н. Оросын ард түмэн ба төр. XVIII зуун хүртэлх Оросын олон нийтийн эрх зүйн түүх. М., 1858. 22 дахь тал.

албадлагын хэт их илрэл нь олон түмэн үндэслэлтэйгээр эсэргүүцэн босоход түлхэц үзүүлдэг аж.

Бүтээл туурвилын эхэн үед Лешков Роберт Мол, Лоренц Штейн нарын Германы цагдаагийн эрх зүйн онолыг баримталдаг байсан боловч хожим нь тэрээр олон нийтийн албадлага дахь хувь хүнээс нийтийг эн тэргүүнд тавих онолыг үндэслэдэг герман школын суурь үзэл санааг хүлээн зөвшөөрдөггүй байжээ.

Лешковын шинжлэх ухааны судалгаа нь харьцуулсан-түүхийн аргад тулгуурлаж байсан бөгөөд олон тооны түүхэн болон түүх-эрх зүйн эх сурвалжаар дамжин өвлөгдсөн байдаг. Тухайн цаг үеийн төлөөллийн нэг И.Е.Андреевскийгээс ялгаатай нь В.Н.Лешков өрнөдийн шинжлэх ухааны туршлагыг шүүмжлэлтэйгээр хүлээн авах талыг баримтлагч байсан бөгөөд хожим энэ нь түүнийг цагдаагийн болон нийтийн эрх зүйг баримтлагчдын хоорондох шинжлэх ухааны маргаан мэтгэлцээнд хөтөлсөн байна.

ЯРОСЛАВЛЬ ДАХЬ ДЕМИДОВЫН НЭРЭМЖИТ ХУУЛИЙН ЛИЦЕЙ СУРГУУЛИЙН ПРОФЕССОР Э.Н.БЕРЕНДТС (1850-1925)

*Германы цагдаагийн
эрх зүйн онолын хямралын
үндэслэл. Бүх давхаргыг хамарсан
цагдаагийн төр улсын тухай үзэл
баримтлал.*

Захиргааны эрх зүйн франц номлолыг анхны дэмжигчдийн нэг бол Ярославль дахь Демидовын нэрэмжит хуулийн лицей сургуулийн профессор, захирал Э.Н.Берендтс (1850-1925) юм. Энэхүү эрдэмтэн XIX зууны сүүл үеийн Германы цагдаагийн эрх зүйн онолын хямралын тодорхойлолтыг анх удаа үндэслэгчдийн нэг байв.

“Полизейвиссеншафт” буюу «Цагдаагийн шинжлэх ухаан»-ны эх нутаг Герман нь Францын эрх зүйн улмажлалыг авч, хөгжүүлсэн байна. Цагдаагийн шинжлэх ухааны сурах бичиг бараг бичигддэггүй байсан учир нь тухайн шинжлэх ухаан байх нь зохистой эсэх талаарх хэлэлцүүлэг нэг шийдэлд хүрээгүй талаар нэг сэдэвт бүтээлүүдэд тусгагдсан байдагтай холбоотой байж болох юм.⁸ Э.Н.Берендтсийн эрхэм дээд тэмүүлэл нь зөвхөн засаглалын эрх мэдлээр хангагдсан төдийгүй иргэдийнхээ эрх чөлөөг хангасан нийгмийн чиг баримжаа бүхий бүх

⁸ Берендтс Э.Н. Захиргааны эрх зүйн тогтолцооны туршлага. Ярославль, 1898, 1-р боть, 13, 14 дэх тал.

давхаргыг хамарсан цагдаагийн төр улс байв. Э.Н.Берендтс XIX зууны дунд үеийн Орос орон дахь төрийн удирдлагын үр дүнтэй байдлын онолыг үндэслэнгээ «Олон нийтийн сайн дурын аливаа үйл ажиллагааг устгасан хамжлагат ёсонд суурилсан цэрэг-цагдаагийн төр нь улсынхаа аюулгүй байдал, сайн сайхан байдлыг хангаж амжаагүй, ард түмний сайн сайхан байдлыг болон дэг журам тогтоогоогүй болохыг Крымын хянан шалгах ажил нотолсон»⁹ хэмээн тэмдэглэж байв.

Тухайн эрдэмтний үзэл санаагаар I Николайн хаанчлалын үед улс орны бүрэн бүтэн байдал, аюулгүй байдал нь зөвхөн залхаан цээрлүүлэх аргаар хангагддаг байсан төрийн цэрэг-цагдаагийн бүтэц тархсан оргил үе байв. Шинэчлэлийн өмнөх Орос орон дахь цагдаагийн засаглал нь зөвхөн эрх дархтнуудын төдийгүй олон нийтийн хяналтанд байх ёстой, түүнчлэн бүх давхаргын ашиг сонирхолд нийцүүлэн ажиллах ёстой гэж тэрээр үзэж байв. 1861 оны тариачны шинэчлэл нь Оросын гүйцэтгэх засаглалыг «цэрэг-цагдаагийн дэглэмээс эрх зүйн дэглэмд шилжих» эхлэл тавигдахад түлхэц үзүүлжээ. II Александрын хаанчлалын үеийн төрийн удирдлагын шинэчлэл, цэрэг, тариачны асуудлаарх тусгай «шүүх-захиргааны байгууллагууд», мужийн болон бусад байгууллагууд үүсэн

байгуулагдаж эхэлсэн нь «хөгжиж буй захиргааны эрх зүйн загвар» болж, тэдгээрийн бүрэлдэхүүнд дээд түвшний албан тушаалтнууд ч, өөрөө удирдах ёсны байгууллагын болон бүхий л давхаргын төлөөлөгчид орж байв.

Цагдаагийн байгууллагын 1860 оны системийн өөрчлөлтийн дараа тухайн байгууллагын эрх мэдлийг хязгаарлаж, эрх мэдлийн нэг хэсгийг шүүхийн мөрдөн байцаагчид шилжүүлэн, эвлэрүүлэн зуучлах¹⁰ институт нэвтрүүлсэн нь ач холбогдол багатай байсан. Үүнийг «... цагдаагийн байгууллагуудын хууль бус, нэг талыг барьсан үйл ажиллагааны талаарх гомдол мужийн захиргаа болон захирагчид ирсэн хэвээр байна. Эрх мэдлээ хэтрүүлэн болон урвуулан ашигласан цагдаагийн албан тушаалтнуудад хүлээлгэх шүүхийн хариуцлагын аугаа их зарчим хэрэгжээгүй...» гэдгээр тайлбарладаг¹¹.

Э.Н.Берендтс Төрийн залхаан цээрлүүлэх чиг үүргийг үнэлэхдээ: «...хууль сахиулах байгууллагуудад либерал-ардчилсан шинэчлэл хийх зайлшгүй хэрэгтэй...» гэдэг санааг дэвшүүлсэн бөгөөд түүний бодлоор ялангуяа Францын туршлагыг хүлээн авах, тухайлбал, 1884 оны 4-р сарын 8-ны өдрийн хуулийн дагуу зарим хэсгийг нь орон нутгийн байгууллагуудад шилжүүлэх замаар засаглалын эрх мэдлийг дахин

⁹ Берендтс Э.Н. Захиргааны эрх зүйн тогтолцооны туршлага. Ярославль, 1898, 1-р боть, 191 дэх тал.

¹⁰ Зуучлах гэдэг нэр томъёо хир оновчтой болохыг цаашид судлах шаардлагатай...

¹¹ Мөн тэнд, 200 дахь тал.

хуваарилах нь онцгой тохиромжтой байжээ. Эрх мэдлийн төвлөрлийг сааруулах талыг баримталдаг хүний хувьд Э.Н.Берендтс энэ мэт шинэчлэл нь төрийн бүрэн бүтэн байдалд заналхийлж байна гэж тэмдэглэсэн байдаг.

Ашигласан материал:

1. Андреевский И.Е. Цагдаагийн эрх зүй. 1-р боть, Аюулгүй байдлын цагдаа. СПб., 1874, 283 дахь тал.
2. Андреевский И.Е. Цагдаагийн эрх зүй. 2-р боть, Аюулгүй байдлын цагдаа. СПб., 1876, 64 дэх тал.
3. Ивановский В.В. Оросын төрийн эрх. 1-р боть: Дээд засаглал ба түүний байгууллагууд. 2 дахь хэвлэл.
4. Ивановский В.В. Төвийн удирдлагын байгууллагууд. Казань, 1896, 427 дахь тал.
5. Лешков В.Н. Оросын ард түмэн ба төр. ХҮИИ зуун хүртэлх Оросын олон нийтийн эрх зүйн түүх. М., 1858, 22 дахь тал.
7. Берендтс Э.Н. Захиргааны эрх зүйн тогтолцооны туршлага. Ярославль, 1898, 1-р боть, 13, 14 дэх тал.

ХУУЛИЙН ХЭЛНИЙ ПРАГМАТИКИЙН ТУХАЙД

/Англи хэл дээрх жишээн дээр/



Шихихутуг их сургуулийн
Ерөнхий эрдмийн тэнхимийн
эрхлэгч. Хэл шинжлэлийн ухааны
доктор.(Ph.D) Л.Нарангэрэл

Abstract: *This paper is considered the relations between language and the law, the importance and some features of the language in the law and its origin. Language is crucial role in law. Speech act is a part of pragmatics that there are specific purposes beyond the words when a speaker says anything. The linguists consider that speech act is to explain speaker's meaning. Laws regulate people's actions, that are expressed through language. Law is directed to public. Laws themselves might be seen as speech acts as types of commands or authorizations. Law and language studies are concerned and researched from many perspectives. Speech act has illocutionary act in the law and illocutionary act refers to the use of a sentence to express an attitude with force, called an illocutionary force. In English, modals function as implicit performatives or indicators. Modal*

verbs are preferred than performatives in the current research. Therefore, modal verbs are predominate as indicators of speech acts in English.

Keywords: *illocutionary act, law language, speech act, performative*

David Mellinkoff 'The law is a profession of words'

Орчин үед хэлшинжлэлийн ухаанд хэлний системийн судалгаа нь хэлний мөн чанарыг тэр бүр тайлбарлаж чадахгүйд хүрсэн учраас антропологи буюу хүн төвт хэлэх үйл ажиллагааны зорилгоос буюу үүргийн талаас голлон судалж тодорхойлох хандлага эрчимтэй гарч ирж байгаа бөгөөд хэлшинжлэлд олон шинэ салбар үүссэний нэг болох прагматик хэлшинжлэл нь прагматизм философийн үзэл санаанаас урган гарч 1970-аад оноос Америк, Англи, Герман, Орос гэх зэрэг олон улсын эрдэмтэн судлаачид судлах болсноор прагматикийн дэг сургуулиуд үүсэн бий болж нийгэм хэлшинжлэл, сэтгэл судлал, хэлний философи гэх мэт хэлний үүрэгтэй холбоотой хэлшинжлэлийн бусад салбарыг хамарсан шинжлэх ухаан хоорондын судлагдахуун болон хөгжиж байна. Прагматик нь тухайн үгийн өөрийн утгын цаана нэмэлт утгыг тодорхой хам сэдвийн хүрээнд судалдаг. Орчин үеийн прагматик хэлшинжлэлийн үндсэн онолын нэг

болох хэлэхүйн үйлдэл нь бөгөөд энэ нь харилцаанд үйлдэл гүйцэтгэж байдаг өгүүлэмж /мэдэгдэл/ юм. Бид өдөр тутмын амьдралдаа уучлалт гуйх, мэндчилгээ дэвшүүлэх, урих, магтаал, амлах, татгалзах үедээ хэлэхүйн үйлдлийг гүйцэтгэж байдаг. Өөрөөр хэлбэл, яригч ямар нэг зүйлийг хэлэх үед тухайн үг, өгүүлбэрийн цаана тодорхой зорилго агуулагдаж байгааг судлах юм.

Нийгмийн өдөр тутмын амьдралд хэрэгжиж нийгмийн амьдралыг зохион байгуулах, хүмүүс болон байгууллага хоорондын харилцааг зохицуулах үүрэг бүхий хуулийн хэл нь хийсвэр шинжтэй учраас хэрэг маргааныг шийдэхэд хүссэн зорилгодоо үйлчилж болох ч хаа нэгтээ ямар нэг тохиолдолд тодорхойгүй, эргэлзээтэй болсон үед хуулийг тайлбарлах зайлшгүй шаардлага гарч ирдэг учраас үүний утга санааг хэлэхүйн үйлдлийн онолын талаас харгалзан үзэж тайлбарлах шаардлагатай. Хуулийн хэлийг хэлний талаас нь хуулийн практикт хэрэглэгдэж буй харилцааны үйлдэл гэж тодорхойлдог. Хэл шинжээч Д.Мелинкофф 1963 онд гаргасан "Хуулийн хэл" (The Language of Law)" хэмээх бүтээлдээ хуулийг өөрийн гэсэн онцлогтой үгс, үг хэллэг бүхий өгүүлэмжийн бүтэцтэй хуульчдын хэрэглэдэг уламжлалт хэл хэмээн тодорхойлжээ. (Мелинкофф, 1963:3) Б.Данет хуулийг шинжлэх ухааны салбар хоорондын судлагдахуун

бөгөөд хууль нь хэлгүйгээр оршин тогтнох аргагүй юм" гэж тэмдэглэжээ. (Danet B. Language in the legal process. 1980)

Бодит амьдрал дээр хэлэхүйн үйлдэл буюу бусдад нөлөөлөх хүчний (хэлэхүйн үйлдлийн) тусламжтайгаар хууль нь амьдрал дээр хэрэгжих нөхцөл бүрддэг гэж хэл шинжлэлийн судлаач эрдэмтэд үздэг байна. Хуулийг хэл шинжлэлийн эрдэмтэд Хэлэхүйн үйлдэлд иллокуц буюу бусдад нөлөөлөх хүч бүхий индикаторууд байдаг (Illocutionary Force Indicating Devices- IFIDs) нь өгүүлэмжийн хүчийг тодорхойлоход сонсогчид тусалдаг учраас хууль нь заавал биелэгдэх шинжийг агуулсан байдаг байна. Эдгээр иллокуц хүч бүхий индикаторт одоо цагт, эзэн бие нь нэгдүгээр биеийн ганц тоонд, үйл үгийн идэвхтэй хэвд байх перформатив үйл үгс, үгсийн дараалал, хоолойны өнгө, дайвар үг, дохио зангаа, бичгийн хэлэнд цэг тэмдэглэл, мөн өгүүлэмжийн нөхцөл байдал зэрэг ордог ба эдгээр хэлний хэрэгслүүдээр тодорхой иллокуц хүч бий болж үйлдлийн гүйцэтгэл биелж байна. Жишээ нь: "Open the door", "Could you open the door" гэсэн өгүүлэмжүүдэд "хаалга нээх" гэсэн ижил утга агуулгатай боловч нэгд тушаах, хоёрт хүсэлтийг илэрхийлснээрээ өөр өөр иллокуц үйлдлийг буюу хүчийг илэрхийлж байна. Өдөр тутмын хэлэхүйн үйлдэлд: I promise гэдэг бол хуулийн хэлэхүйн үйлдэлд: We hereby enact that гэх

байдлаар илэрнэ. Иймээс утга санааг илэрхийлэхэд хэрэглэгдэж байгаа хэлний хэрэглүүрүүдийг судлах нь чухал байна.

Иллокуц үйлдэл нь яригчийн санаа зорилготой нийцэж байдаг бол зорилго (illocutionary point) нь өгүүлэмжийн хүчийн (illocutionary force) хамгийн гол онцлог бөгөөд хоёр ижил зорилго бүхий өгүүлэмж нь хүчээсээ хамаарч өөр байж болох төдийгүй хэлэхүйн үйлдлийн зорилго, учир шалтгаан, оновчтой нөхцөлийг заадаг төдийгүй яригчийн өгүүлэмжийг ухамсарлаж, ойлгох сонсогчид үзүүлж буй нөлөө гэж үзэж болох талтай. Хуулинд иллокуц хүч нь императив хэл буюу ямар нэг үйлдэл хийх үүргийг оногдуулдаг, факултатив хэл буюу эрх олгодог, хориглох хэл буюу ямар нэгэн үйлдэл хийхийг түдгэлзүүлдэг гэж гурван категорит хувааж үзэж, дээрх иллокуц хүчийг дамжуулахын тулд 'may', 'shall', 'may not', 'shall not' зэрэг баймж үгсийг англи хэлэнд ихэвчлэн хэрэглэдэг бөгөөд эдгээр баймж үгс нь хуулинд перформатив индикаторын үүргийг гүйцэтгэж байна. Прагматик хэл шинжлэлд перформатив гэх ойлголт нь англи хэлний үйлдэл, үйл хэрэг (action) гэсэн үгтэй гол төлөв хамт хэрэглэгддэг гүйцэтгэх, биелүүлэх гэсэн утга бүхий "perform" гэсэн үйл үгнээс гаралтай бөгөөд ямар нэг зүйлийг хэлж байхын зэрэгцээ давхар үйлдлийг гүйцэтгэж байгаагийн илэрхийлэл юм¹. Өөрөөр хэлбэл

хэлж байгаа зүйл, үйлдэл хоёр давхцаж байхыг хэлнэ. Практикт, хуульчдад перформатив үйл үгс болон хэлэхүйн үйлдлийн харилцан хамааралтай байдал ихээхэн тохиолддог оос гадна перформатив үйл үгсийг нь хэлэх үед үйлдэл нь хамт гүйцэтгэгдэж байдаг. Жишээ нь: "I hereby sentence you to five years in prison." Шүүгчийг энэхүү таван жил шоронд хорих тухай шийдвэрээ танилцуулах үед үйлдэл зэрэг хийгдэж байна. Бичиг баримтын перформатив онцлог нь 1) "hereby" дайвар үг хэрэглэгдсэнээр, 2) "do" туслах үйл үг хэрэглэгдсэнээр, 3) "these presents" үгсийг хэрэглэсэнээр илэрхийлэгддэг². Түүнчлэн 'may', 'shall', 'may not', 'shall not' зэрэг баймж үйл үгсийг англи хэлэнд хуулийн перформатив индикаторууд ч гэж нэрлэдэг хэмээн өмнө дурдсан. Судлаач Сулливаны (Sullivan 2002) үзсэнээр 'may' нь эрх мэдлийг өгөх, эрх олгоход хэрэглэгддэг бол 'shall' нь үүрэг оногдуулахад, 'may not', 'shall not' – г аливаа үйлдлийг хориглоход хэрэглэдэг боловч сүүлийн жилүүдэд 'must' баймж үг нь 'shall' үгийн оронд зарим үед хэрэглэгдэх болжээ.³ Товчхондоо хуулиар олон нийтийн зан үйлийг залж, чиглүүлэхэд англи хэлэнд shall, must баймж үйл үгс нь маш өндөр үүргийг уншигчид оногдуулахад, can /could, will/ would may зэрэг баймж үйл үгс нь зөвшөөрөл өгөхөд, shall not баймж үг нь хориглоход тус тус хэрэглэгддэг. Жишээ нь:

² Heikki Mattila 'Comparative Legal Linguistics', USA, 2006, p.33.

³ D.Cao 'Illocutionary acts of Chinese legislative language', journal of Pragmatics., 2009., p.1331.

¹ J.L.Austin. How to Do Things with Words. Harvard University Press. 1975. p.6.

*The right of the people to be secure in their persons, houses, papers, and effects, against unreasonable searches and seizures, **SHALL NOT BE VIOLATED**, and no Warrants shall issue, but upon probable cause, supported by Oath or affirmation, and particularly describing the place to be searched, and the persons or things to be seized. Хувь хүн, орон байр, бичиг баримт, эд хөрөнгө халдашгүй байхаар ард түмний эрхийг үндэслэлгүй нэгжлэг хийх буюу баривчлан зөрчиж болохгүй бөгөөд зөвшөөрлийн бичгийг тангараг буюу албан ёсны мэдэгдлээр баталгаажуулахгүйгээр нэгжлэг хийх газар, баривчлах хүн, хураах эд зүйлийг тодорхой заасан хангалттай үндэслэлгүйгээр олгож болохгүй. /CUS amendment 2/*

Эндээс үзэхэд бусдад нөлөөлөх зорилготой хүч бүхий хэлэхүйн үйлдэл нь перформатив үйл үгсээр илэрдэг байна. Хуулийн хэл нь албадлагын хүчээр хамгаалагдаж, нийтээр заавал мөрдөгдөж байдгийн хувьд иллокуц хүчийг агуулж байдаг гэж үзэж болохоор байна.

Эрх зүйн хэлэнд янз бүрийн хүрээнд хэлэхүйн үйлдэл нь илэрхий ялгаатай байгаа нь хамгийн түрүүнд яригч/бичигч болон сонсогч/уншигчийн хоорондын ялгаа юм. Хуулийн хэлэхүйн үйлдэлд, яригч/бичигч нь хууль тогтоох байгууллага буюу парламент, сонсогч/уншигч нь олон нийт байдаг бол гэрээний хэлэхүйн үйлдэлд гэрээний талууд байна. Хуулийг бичгийн хэлбэрээр

илэрхийлдэг байхад шүүхэд аман нотолгоог шаарддаг байдлаараа хуулийн болон шүүхийн хэлэхүйн үйлдэл нь харилцааны арга техникээрээ өөр байна. Шүүхийн мэдүүлэг нь өмгөөлөгч болон гэрчийн хооронд түүнчлэн шүүгч, тангарагтны шүүхийн хооронд ч байж болохоос гадна бүх өгүүлэмж нь тодорхой горим журмыг (procedure) дагах ёстой төдийгүй гэрээ, гэрээслэл, хууль нь өөр өөрийн гэсэн тодорхой хэв маяг, хэлбэртэй байна. Хуулийн хэлэхүйн үйлдэлд бичигч гэдэгт хуулийг тогтоогч болох хуулийг батлан гаргах эрх бүхий парламентын гишүүд байдаг бол уншигч буюу сонсогч гэдэгт олон нийт байдаг бөгөөд хууль тэдэнд зориулагдан гардаг. Хуулийн гол уншигч нь олон нийт байх ба энэ нь тэдгээрийн зан үйлийг удирдахад чиглэгдэхээс гадна өөр нэг уншигч нь гүйцэтгэх байгууллага байж болох хэдий ч гүйцэтгэх байгууллагын санаа зорилго нь хуулинд тусгагдсан байдаг гэдэг утгаараа бичигч байж болох талтай хэмээн Д.Курзон тэмдэглэсэн. Бичигч болон уншигч хооронд хуулийн хэлэхүйн үйлдэл хэрхэн гүйцэтгэгдэж, харилцан ойлголцолд хүрч байгаа нь чухал бөгөөд яригчийн санаа зорилгыг уншигч таньж мэдсэнээрээ харилцаа нь амжилтад хүрдэг гэж хэлний судлаачид үзсэн байна. Хуулийн дискурс нийгэмд хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулах, нийгэмд дэг журмыг тогтоох болон хэлний тусламжтайгаар шударга

ёсонд хүрэх гурван үндсэн үүргийг гүйцэтгэдэг ба олон нийтийн зан үйлийг удирдахад чиглэгдэж, энэ нь хувь хүний дан ганц илэрхийллийн шинжтэй бус нийт ард түмэнд хүртээлтэй төрөөс ард түмэнтэй харьцаж байгаа албан ёсны хэл учраас аливаа хууль бол хэн нэгэн хүнд зориулагддаггүй, нийт олныг хамардаг⁴. Нөгөө талаасаа, хуулийн дискурс нь уран зохиолтой адил олон нийтэд зориулагддаг боловч уншигчдын мэргэжил, нас, сэтгэхүйн онцлогийг харгалзаж үздэггүйгээрээ болон зорилго сэдвээрээ ялгарч захиран тушаасан, хөдөлбөргүй байдаг ч жирийн хүмүүст зориулагддаг тул хууль тогтоогч хуулийн ухагдахууныг цэгцтэй бөгөөд оновчтой илэрхийлэхийн хамт энгийн хүртээмжтэй, илэрхий байлгах нь чухал хэмээн үздэг байна.

Дүгнэлт

Хэлэхүйн үйлдлийг судалдаг прагматик хэлшинжлэлийн онолын ухагдахуун болох хэлэхүйн үйлдлийн онол нь хэлний үндсэн үүрэг болох хэлэх, харилцах зорилгын талаас судлах нь орчин цагийн хэл судлалын онцлог гэж үзэж болох юм. Хуулийн бичвэр нь хэлний нэгжийн утгын агуулгыг гаргах бол хуулийн прагматик нь харилцааны нөхцөл байдал, учир холбогдлыг судлан үгээр илэрхийлэгдэхгүй байгаа далд санаа, шилжсэн утга, үнэлэмжийг гарган харуулах

«амьд бичвэр» болох нь харагдаж байна. Хуулийн хэлэхүйн үйлдэл биелэгдэж, зорилгодоо хүрэхэд хуулийг тогтоогчийн эрх мэдэлтэй байдал, батлагдах орчин зэрэг бэлтгэл нөхцөл нөлөөлөхөөс гадна тааламжгүй үр дагавраар айлгах, сүрдүүлэх зэрэг үр дүнг хамгаалсан хариуцлага шийтгэл болон хүмүүсийн ухамсар гэх зэрэг хүч нэмэгдүүлсэн хэлний бус нийгмийн хүчин зүйлүүд ихээхэн нөлөөлж байна. Хуулийн хэлэхүйн үйлдэлд англи хэлэнд бусдад нөлөөлөх хүч бүхий перформатив үйл үгс чухал үүрэг гүйцэтгэхээс гадна баймж үйл үгс чухал үүрэг гүйцэтгэдэг болох нь харагдаж байна. Түүнчлэн харилцаанд оролцогчдоосоо шалтгаалан хэлэхүйн үйлдлийн хүч нь харилцан адилгүй байх бөгөөд үүнд хэлний хэрэглүүрээс гадна нийгмийн хүчин зүйлс нөлөөлж байна. Цаашид төрөл бус хэлүүдийг прагматик хэлшинжлэлийн үндсэн ойлголт болох хэлэхүйн үйлдлийн онолын үүднээс судлах нь түгээмэл зүй тогтол, прагматик утга санаа, мөн чанар, өвөрмөц онцлогийг нээн илрүүлэхэд ихээхэн чухал учраас орчин цагийн хэлшинжлэлийн ололт амжилтыг хуулийн хэлэнд нарийвчлан гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна. Түүнчлэн хуулийн хэлийг семантикийн үүднээс төдийгүй прагматик хэл шинжлэлийн үүднээс судалж, тайлбарлах шаардлагатай. Энэ удаад бид өнгөц авч үзсэн болно.

⁴ "Хууль сахиулахуйн инноваци", олон улсын эрдэм шинжилгээний хурал, эмхтгэл-1, УБ., 2014. т.18

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр

1. Алексеев.С.С, "Төр ба Эрх зүй", УБ., 2004.т.108.
2. Амарсанаа.Ж, "Эрх зүй-нийгмийн харилцааг зохицуулагч", УБ., 1988.т.64.
3. Зэгиймаа, Ч. Прагматик хэлшинжлэл, УБ., 2010.
4. Хонгорзул, Д. Дискурсийн үндсэн ойлголтууд ХИС, УБ., 2012.
5. "Хууль сахиулахуйн инноваци", олон улсын эрдэм шинжилгээний хурал., эмхэтгэл- 1, УБ., 2014.т.18

Англи хэлээр

1. Austin,J.L."How to do with words", Oxford University Press
2. Anna Trosborg, "Statutes and contracts: An analysis of legal speech acts in the English language of the law", Elsevier journal of Pragmatics, 1995.p.32.
3. Anna Wagner, Wouter Werner, Deborah Cao., "Interpretation, Law and the Construction of Meaning", Springer, 2007
4. Andrew Mckinlay and Chris mcVittie, "Social Psychology and Discourse", Blackwell Publishing., 2008
5. Anna Trosborg, "The Performance of Legal Discourse", 1999
6. Bhatia, V. K. Language of the Law. Language Teaching 4 1987, 227-234.

7. D. Cao 'Illocutionary acts of Chinese legislative language', journal of Pragmatics., 2009.,
8. Kurzon, Dennis. Linguistics and Legal Discourse: An Introduction. International Journal for the Semiotics of Law Vol. VII no. 19 (1994)
9. Gibbons, J "language and law", Annual Review of Applied Linguistics., 1999.p.4.
10. Heikki E.S.Mattila. Comparative Legal Linguistics, University of Lapland, Finland, 2006.
11. Laura Alba-Juez, "Perspectives on Discourse Analysis: Theory and Practice", Cambridge Scholars Publishing., 2009
12. Maurizio Gotti, Christopher Williams, "Legal Discourse across Languages and Cultures", Linguistic Insights: Studies in Language and Communication., 1997
13. Tiersma.P Some Myths about Legal Language Legal Studies paper No 2005

“МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮҮХЭД ҮРЧЛЭЛТИЙН ХЯНАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ”



Шихихутуг их сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш.

Докторант.
Ё.Болормаа

Хамтарсан судлаач
О.Цэнд-Аюуш

ӨМНӨТГӨЛ

Сэдвийн зорилго

Хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтыг онолын болон практик талаас нь судалж, хяналтыг сайжруулахтай холбоотой асуудлыг авч үзэхэд оршино.

Судалгааны арга зүй

Харьцуулалт, бичиг баримт шинжлэн судлах болон судалгааны ерөнхий арга зүйг голчлон ашиглав.

Сэдэв сонгосон үндэслэл

Монгол Улсад хүүхэд үрчлэлттэй холбоотойгоор холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгож, үрчлэлттэй холбоотой материаллаг болон процессын асуудал зохицуулагддаг ч хүүхэд үрчлэгдсэний дараах хяналтын асуудал төдийлөн, нарийвчлан

судлагдаагүйг хөндсөн болно.

Сэдвийн судлагдсан байдал

Судлаач, эрдэмтэд Хүүхэд үрчлэлтийн асуудлыг эрх зүйн зохицуулалт болон боловсронгуй болгох талаас нь нэлээдгүй судалжээ.¹

Нэгдүгээр асуудлын хүрээнд, ХҮҮХЭД ҮРЧЛЭЛТИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН ПРАКТИК ШИНЖИЛГЭЭ, ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ /Монгол улс/

Монгол хэлний их тайлбар тольд² тайлбарлажээ. Эрх зүйн баримт бичигт тодорхойлсноор³ үрчлэлтийг дотоодын буюу Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үрчлэлт, гадаадын буюу гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах гэсэн 2 төрөлд авч үзэх ба дотоод үрчлэлтэд дараах хэлбэр түгээмэл байна. Тухайлбал,

- Өвөө, эмээгийн үрчлэлт
- Хойд эцгийн үрчлэлт

¹ Хүүхдийн төлөө үндэсний газар, НҮБ-ын Хүүхдийн сангаас “Хүүхэд үрчлэлтийн харилцаа-хүүхэд хамгааллын бодлогын зарим асуудал” түргэвчилсэн үнэлгээний тайлан, А.Батбаатар Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал (2021) бүтээлийг, мөн 2013 онд ХАХНХЯ-ны захиалгаар судлаач Б.Мөнхжаргал, А.Батбаатар нар “Гадаад болон дотоод үрчлэлтийн асуудалд дүн шинжилгээ хийх, бодлогын зөвлөмж” тус тус гаргажээ. Мөн холбогдох мэргэжлийн сэтгүүлүүдэд нийтлүүлсэн бүтээл болон их, дээд сургуулиудад хамгаалагдсан магистрын бүтээлүүд, холбогдох ном сурах бичиг... цөөнгүй байна.

² “Үрчлүүлэх” гэсэн үгийг бусдад үр болгон өгөх (хүүхдээ үр болгон өгөх)

³ НҮБ-ын Хүүхдийн сан “Хүүхэд үрчлэлтийн харилцаа-хүүхэд хамгааллын бодлогын зарим асуудал” түргэвчилсэн үнэлгээний тайлан. УБ, 2014 он /Эрх зүйн холбогдох хэсэг/

- Төрөл садан, хамаатны үрчлэлт
- Найз нөхөд, танил хүмүүсийн үрчлэлт
- Төрөх газраас хүүхэд үрчлэх
- Баг, хорооны ажилтны тусламжтайгаар хүүхэд үрчлэх
- Асрамж, халамжийн газраас үрчлэх
- Тээгч эх гэх мэт шинэ хэлбэрийн үрчлэлтүүд байна.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй хууль тогтоомж, бодлогын баримт бичиг⁴, үрчлэлтийг хүчингүйд тооцуулах тухай нэхэмжлэлтэй шүүхийн шийдвэр⁵

⁴ НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенцийн 20, 21 дүгээр зүйл, 1989 он, Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай гаагийн конвенц /Бүх заалт/, 1993 он, ГБТХ 7 дугаар бүлэг, 1999 он, УБТХ 6.1.6 дугаар зүйл, 2018 он, ИХШХШТХ 145.3 дах заалт, 2002 он, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5.3.4 дэх заалт, 2012 он, Эрүүгийн хууль 16.6 дах заалт, 2015 он, ХТХ-ийн 138.1 дэх заалт 2021 он, Харьяатын тухай хуулийн 13 дугаар зүйл, 1995 он, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3.1.2 дах заалт, 2016 он, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.2, 5.3 дах заалт, 2013 он, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.5.2, 40.1.6 дах заалт, 2010 он, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 11, 26 дугаар зүйл, 2018 он, Иргэний хуулийн 520.1 дэх заалт, 2002 он, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 8.4 дэх заалт, 1993 он, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4.2, 12.1 дэх заалт, Нийгмийн халамжийн тухай хууль 13.1.2 дах заалт, 2012 он, Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хууль 1.1.1, 1.1.2 дах заалт 2019 он, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.5 дах заалт, 2019 он, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 3.1.1, 3.2 дах заалт, 2010 он, Хууль зүй дотоод хэргийн сайд, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал 100/32., 2001 он, БГД-ийн засаг дарга, хүүхдийн төв сувиллын захирлын хамтарсан захирамж А/559-А23., 2016 он

⁵ Хүүхэд үрчлэлттэй холбоотой анхан шатны шүүхийн шийдвэрийн түүвэр /2016-2021 он/-ийг холбогдох онд хамаарал бүхий 72 шүүхийн шийдвэрийг авч үзэхэд, Хуулийн үндэслэл нь Гэр бүлийн тухай хуулийн 61.2 бөгөөд хэргийн товч утгын агуулгыг багцлахад хүүхдээ аав, ээждээ

зэрэг баримт бичигт дүн шинжилгээ хийхэд хүүхэд үрчлэлтийн ерөнхий нөхцөл, ямар шаардлага хангасан Монгол Улсын харьяат иргэн болон гадаадын иргэн, харьяапалгүй хүнд, ямар бичиг баримт бүрдүүлсний үндсэн дээр, ямар субъект хүүхэд үрчлүүлэх шийдвэр гаргах, үрчлэлтийг бүртгэлийн байгууллагад хэрхэн бүртгүүлэх, ямар тохиолдолд хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцох зэрэг асуудлыг тус тус зохицуулжээ. Үрчлэлтийн асуудлыг зохицуулж буй хууль тогтоомжид үрчлэлтийн үйл явц нь:


1. Үрчлэх хүүхдээ сонгох
2. Бичиг баримтаа бүрдүүлэн хүлээлгэн өгөх
3. Бичиг баримтыг хянах
4. Шийдвэр гаргах
5. Бүртгэх гэсэн үе шаттайгаар явагдаж байна гэж тодорхойлж болно.

Эндээс хяналтын үе шат байхгүйг харж болох юм. Гэр бүлийн тухай хуулийн 54.1-т зааснаар хүүхдийг тэдний ашиг сонирхлын үүднээс

үрчлүүлсэн, хууль бус үрчлэлт хийгдсэн, шинээр гэрлэсэн хүний нэр дээр үрчлэлт хийгдсэн, эцэг, эх нь нас барсан учраас үрчлүүлсэн, танил хүнд хүүхдээ үрчлүүлсэн, үрчлэгдсэн болохыг тогтоох, хадам аав, ээждээ үрчлүүлсэн, хойд эцэгтээ үрчлүүлсэн, хүүхдээ төрөхөд өөрөө насанд хүрээгүй байсан тул ээж, аавдаа үрчлүүлсэн, гадаадад амьдрах зорилгоор дүүдээ үрчлүүлсэн, танилдаа үрчлүүлсэн зэрэг байна. Үрчлүүлсэн, үрчлэлтийг хүчингүйд тооцсон шалтгааныг авч үзэхэд, аав нь настай болсон, өөрийн ач охиныг ээжид нь мэдэгдэхгүй үрчлэлтийг бүртгүүлсэн, гадаад явах болсон, хотруу шилжих болсон, гэр бүл салсан тул хүүхдээ өөрийн нэр дээр болгох, өөрөө хүссэн, сургуульд орох болсон, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авахад, хүүхдийг хайхрахгүй байсан, оюутан байсан, гэр бүл салсан тул хүүхдээ өөрийн нэр дээр болгох, гэр бүл салах болсон, гадаадруу явж аав, ээжтэй нь уулзуулах, амьдарлын бололцоогүй, насанд хүрээгүй байхдаа төрүүлсэн, үрчлэгдсэн хүн одоог хүртэл улсын бүртгэлд бүртгэлгүй байгаа зэрэг.

үрчлүүлнэ гэж заасан хэдий ч бодит байдал дээр тэтгэвэрт эрт гарах, халамжийн мөнгө авах, гэр бүл салалтын улмаас, хүсээгүй жирэмслэлт, гадаад улсад амьдрахаар явахдаа гэх мэт хүүхдийн бус бусдын эрх ашгийн үүднээс үрчлүүлэх тохиолдол нэлээд хувийг эзэлж байна.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн хугацаанд 18907 хүүхэд дотооддоо үрчлэгджээ.⁶



Мөн 2000 оноос хойш нийт 272 монгол хүүхэд гадаадын 17 улс оронд, тухайлбал АНУ, ХБНГУ, БНСУ, БНФУ, Нидерланд, Канад, Итали, Австрали, Англи, Бельги, Япон, Дани, Испани, Финлянд, Швед, ОХУ, Шинэ Зеланд зэрэг улсад үрчлэгдсэн байна.⁷

Гадаад улс оронд хүүхэд үрчлүүлэхэд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989)⁸, Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенц (1993)⁹, Харьяатын тухай хуулийг тус тус мөрдлөг болгож мөн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2001 оны 100/32 дугаар тушаалаар батлагдсан "Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам, түүнчлэн Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2010 оны А/396 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх журам"-ыг баримталдаг. Гадаадын иргэнд хүүхэд үрчлэгдсэний дараах хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор "Хүүхдийн эрхийн тухай" НҮБ-ын конвенцод

⁶ Эх сурвалж www.1212.mn

⁷ Үрчлэлтэд үрчлэн авагч нь хүүхэд үрчлэн авсан тухайгаа иргэний гэр бүлийн асуудал эрхэлсэн тухайн шатны албанд бүртгүүлж, гэрчилгээ авсан тохиолдлыг ойлгоно. Үндэсний статистикийн хороо.

⁸ 1989 оны 11 сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1990 оны 01 сарын 26-нд гарын үсэг зурж, 1990 оны 07 сарын 05-ны өдөр соёрхон баталсан.

⁹ Монгол Улс 1998 онд нэгдэн орсон.

заасны дагуу хоёр буюу гурван талт гэрээг үрчлэгч эцэг, эх, зуучлагч байгууллагатай байгуулдаг. Гэрээгээр үрчлэгч эцэг, эх хүүхдийг хэвийн өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, эрхээ хамгаалуулах бүх нөхцөлөөр хангах, хувцас, хоол хүнс, орон байр, ахуйн хэрэгслээр гачигдуулахгүй, хүүхэдтэй хэрцгий харьцахгүй байх, уугуул эх орон, ёс заншил, түүх соёлын уламжлалыг танин мэдэх боломжоор хангах талаар гэрээнд тусгадаг нь чухал юм.

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан дахь үрчлэлттэй холбоотой анхан шатны шүүхийн шийдвэрээс харахад 2016-2021 оны байдлаар нийт 72 хэрэг, маргаан шийдвэрлэгдсэний гурав нь үрчлэгдсэн болохыг тогтоолгох, хоёр нь үрчлэлтийн бүртгэлтэй холбоотой, үлдсэн нь буюу 67 нь үрчлэлтийг хүчингүйд тооцуулах нэхэмжлэлийн дагуу хянан шийдвэрлэгджээ.¹⁰ Холбогдох шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийхэд төрлийн буюу өвөө, эмээдээ үрчлүүлэх нь 41, дахин гэр бүл зохиож хүүхдээ хойд эцэгт нь үрчлүүлсэн тохиолдол 6, садангийн хүн буюу эгч, ахдаа үрчлүүлсэн 12, бусад хүнд үрчлүүлсэн 8 тохиолдлыг шүүх хянан шийдвэрлэжээ.

Шалтгаан нөхцөлийн дийлэнх хувийг эцэг, эх нь гадаад улс оронд ажиллаж, амьдрахаар явахдаа өвөө, эмээ, ах, эгч дүү наргаа үрчлүүлж, хэсэг хугацааны дараа үрчлэлтийг хүчингүйд тооцуулах замаар төрсөн эцэг эх нь эрхээ сэргээлгэсэн байна. Цөөн тохиолдолд насанд хүрээгүй, оюутан байсан зэрэг

шалтгаан үрчлэлтэд нөлөөлсөн бол зарим тохиолдолд ээж нь дахин гэр бүл зохиож хүүхдээ хойд эцэгт нь үрчлүүлдэг ч 50 орчим хувьд нь дахин гэр бүл салалт бий болж үрчлэлтийг хүчингүйд тооцуулжээ.

Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан Үрчлэлтийг хүчингүйд тооцох үндэслэлийн дагуу шийдвэрлэгдсэн дээрх тохиолдлуудаас харахад "Үрчлэгч нь эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэй хэрцгий харьцсан тохиолдолд төрүүлсэн эцэг, эх, сонирхогч бусад этгээд, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага, 14 нас хүрсэн хүүхдийн өөрийн нэхэмжлэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцно гэсэн үндэслэлээр" үрчлэлтийг хүчингүйд тооцуулсан нэг ч тохиолдол гараагүй байгаа нь үрчлэгдсэн хүүхдийн эрх ашиг зөрчигдөхгүй байна уу эсвэл үүнийг хянах механизм байхгүйн улмаас бүртгэгдэхгүй өнгөрч байна уу гэдэг асуудал анхаарал татаж байна.

Дээрхээс нэгтгэн авч үзэхэд хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй асуудлыг дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

1. Үрчлэлтийн дараах хяналтын үе шат, эрх зүйн орчин бүрхэг
2. Хүүхдийн эрх ашгийн үүднээс бус бусад этгээдийн эрх ашгийн үүднээс үрчлүүлж буй тохиолдол харьцангуй их, үрчлэлтийн зорилгыг тодорхойлох, хянах асуудал зохицуулалтгүй.
3. Хүүхэд үрчлүүлэх харилцаанд төр хяналт тавихдаа зөвхөн бичиг баримтаар хязгаарлаж,

¹⁰ Хавсралт №...

хүүхдийн язгуур эрх ашиг хоёрдугаарт тавигддаг.

4. Хүүхэд үрчлэгдсэнээс хойш насанд хүртэл нь үрчлэгдсэн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж буй эсэхэд хэн, ямар хяналтыг хэрхэн, яаж, хяналт тавих, үүрэг бүхий субъект хяналтаа зохих ёсоор хэрэгжүүлээгүй тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх талаарх зохицуулалтгүй.
5. Үрчлэх хүүхдээ хэрхэн олох тухай асуудал тодорхойгүй, мэдээлэлгүй.
6. Хүүхэд үрчлэгдсэнээс хойш төрийн болон бусад байгууллагууд ямар нэгэн үйлчилгээ, дэмжлэг үзүүлдэггүй.
7. Удмын сангийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө.¹¹ Өөрөөр хэлбэл¹², Үрчлэгч үрчилсэн хүүхдийг төрсөн эцэг эх, ах дүү нар, гэр бүлийнхэнтэй нь танилцуулдаггүй, уулзуулдаггүйгээс насанд хүрсэн хойноо төрсөн ах дүү, хамаатан садантайгаа гэр бүл болох эрсдэл гарах магадлалтай.
8. Үрчлэлт хүчингүй болоод хүүхэд төрсөн гэртээ болон асрамжийн байгууллагад буцах тохиолдолд буруутай этгээд хууль зүйн хариуцлага хүлээх тухай эрх зүйн зохицуулалт тусгагдаагүй зэрэг.

Хоёрдугаар асуудлын хүрээнд, ХҮҮХЭД ҮРЧЛЭЛТИЙН ХЯНАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ АСУУДЛЫГ АВЧ ҮЗЭХ НЬ /Монгол улс/

¹¹ Сугармаа илтгэл.

¹² ХЭҮК-ийн 7-р зүйл: хүүхэд эцэг эхээ мэдэх эрхтэй.

Үрчлэлт нь нэг талаас үрчлэгдэж буй хүүхэд гэр бүлийн хайр халамж, хамгаалалд өсөж хүмүүжих боломж, нөгөө талаас үрчлэгч нь эцэг эхийн үүрэг хариуцлагаа биелүүлэх, гэр бүл бүрэн бүтэн болох зэрэг ач холбогдолтой харилцаа юм. Гэвч энэхүү харилцааг дагаад үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдөх, үл хайхрах, хүчирхийлэл, бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгт өртөх, хүний наймааны золиос болох зэрэг эрсдэл гарах магадлалтай тул үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтад үрчлэгдсэний дараах хяналтын механизмыг нарийвчлан тусгах нь чухал юм. Монгол Улс 0-18 насны 100000 хүүхэд тутамд дунджаар 187 хүүхэд үрчлэгддэг гэсэн статистик үзүүлэлтээрээ дэлхийд 2 дугаарт эрэмбэлэгдэж¹³ байгаа нь эдгээр хүүхдүүдийн эрх хэрхэн хамгаалагддаг нь тодорхойгүй төдийгүй хяналтын эрх зүйн зохицуулалтыг нарийвчлах хэрэгтэйг илэрхийлж буй хэрэг мөн.

Дотоод үрчлэлтийн хувьд, Цахим орчинд холбогдох нас, хүйс бүхий хүүхдийг өргүүлнэ гэсэн зарлал тавигдаж байгаа нь хүүхдээ үрчлүүлэх хүсэлтэй эцэг эх хаана хандахаа мэдэхгүй байгаа, түүнчлэн үрчлэлтэй холбоотой зуучлалыг Монгол Улсын хууль тогтоомжуудад хориглосон эрх зүйн зохицуулалт байхгүйгээс хуулиар хориглоогүй бүхнийг зөвшөөрөх зарчмын дагуу энэ асуудал хяналтгүй хийгдэж байгаатай холбоотой. Иймд хүүхэд үрчлэх хүсэлтэй гэр бүлд хүүхэд олоход нь туслах, туслан зуучлах асуудлыг нэвтрүүлэх,

¹³ Child adoption trends and policies. UN. 2009

хүүхэд үрчлэх асуудлыг шаардлага хангасан мэргэжлийн байгууллагын оролцоотой зохион байгуулах, эрх зүйн зохицуулалттай болгох, үрчлэгдэж буй хүүхэд бүрийн нөхцөл байдал харилцан адилгүй учир тэднийг үрчлүүлэхдээ бүтэн өнчин, асрамжийн газраас, төрөх газраас, ах дүү төрөл садандаа гэх мэт ямар нөхцөлөөс хэнд үрчлүүлж байгаатай холбоотойгоор үрчлэлтийн үйл явцыг ялгавартай тогтоох төдийгүй үрчлэлтийн дараах хяналтыг хууль тогтоомжид тодорхой тусгах нь зүйтэй.

Гадаад үрчлэлтийн хувьд, Үрчлэгдсэний дараах хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор “Хүүхдийн эрхийн тухай” НҮБ-ын конвенцид заасны дагуу хоёр буюу гурван талт гэрээг үрчлэгч эцэг, эх, зуучлагч байгууллагатай байгуулдаг. Гэрээгээр үрчлэгч эцэг, эх хүүхдийг хэвийн өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, эрхээ хамгаалуулах бүх нөхцөлөөр хангах, хувцас, хоол хүнс, орон байр, ахуйн хэрэгслээр гачигдуулахгүй, хүүхэдтэй хэрцгий харьцахгүй байх, уугуул эх орон, ёс заншил, түүх соёлын уламжлалыг танин мэдэх боломжоор хангах талаар гэрээнд тусгаж өгдөг.

Үрчлэгч эцэг, эх үрчлэгдсэн хүүхдийн талаарх мэдээллийг өөрийн улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт жил бүр мэдээлж байх, хүүхдийн өсч бойжиж буй фото зураг, видео бичлэг зэргийг хүүхдийг 1 сартайгаас 3 нас хүртэл хагас жил тутам, 4-8 нас хүртэл жил тутам, 8-16 нас хүртэл хоёр жил тутам гаргаж, гадаадын

иргэн харьяатын асуудал эрхэлсэн байгууллагад ирүүлсэн байх талаар тусгасан байдаг хэдий ч үрчлэгч талын ирүүлсэн зураг, видео бичлэг бүхий тайлангаар хязгаарлаж, үрчлэгдсэн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөөгүй байна гэж дүгнэх нь учир дутагдалтай юм.

Дэлхийн 195 орны 173 нь үрчлэлтийг албан ёсоор хүлээн зөвшөөрдөг бөгөөд эдгээрийн 8 нь үрчлэлтийг зохицуулсан бие даасан хуультай, 26 улс гэр бүлийн тухай хуулиар (Монгол Улс энэ ангилалд хамаарна), 42 улс Иргэний хуулиар, 5 улс Хүүхдийн тухай хуулиар тус тус зохицуулдаг байна¹⁴.

НҮБ-ын “Adoption trends and policies”¹⁵ нийтлэлд дурдсанаар улс орнуудад үрчлэлтийн үйл явцын дараалал нь,

1. Үрчлэгч хүсэлт гаргах
 2. Үрчлэгч хүүхэд үрчилж авах бололцоотой гэдгээ мэдүүлэх, нотлох
 3. Эрх бүхий байгууллага мэдүүлгийн дагуу үнэлгээ, хяналт хийх, зөвшөөрөл олгох
 4. Үрчлэгч болон үрчлүүлэгч талын хооронд гэрээ, хэлэлцээр байгуулах
 5. Туршилтын хугацаа
 6. Үрчлэлт хүчин төгөлдөр болох
 7. Үрчлэлтийн дараах хяналт
 8. Үрчлэлт цуцлах, хүчингүй болгох
- Гадаадын зарим улс орнууд**

¹⁴ Adoption trends and policies, UN., 2009

¹⁵ Хүүхэд үрчлэлтийн талаарх хуулийн түүхэн хөгжил, шашны хууль болон уламжлалт нийгэм дэх үрчлэлт, орчин үеийн үрчлэлтийн хуулийн гол онцлог, улс хоорондын үрчлэлтийн олон улсын болон бүс нутгийн хоёр талт гэрээ, үрчлэлтийн чиг хандлага, үрчлэгч, үрчлүүлэгч эцэг эх, үрчлэгдэж буй хүүхдийн онцлог, хэрэгцээ шаардлага, үрчлэлтийн талаарх судалгааг цаашид хөгжүүлэх асуудал зэрэг агуулга бүхий нийтлэл

үрчлэлтийн үйл явцыг өмнөх, үрчлэлтийн үе дэх, үрчлэлтийн дараа гэсэн цогц байдлаар авч үздэг бөгөөд дээр дурдсан 1-6 дахь үйл ажиллагааг үрчлэлтийн өмнөх үе шатанд, 5-6 дугаарт дурдсан үйл ажиллагааг үрчлэлтийн үед, 7-8 дугаар үйл ажиллагааг үрчлэлтийн дараах үе шатанд тооцох хандлага түгээмэл байна.

Ихэнх улс орнуудад "post adoption services" гэсэн Засгийн газрын харьяа байгууллагууд байх бөгөөд эдгээр байгууллагууд үрчлэгч болон үрчлэгдэгчид үрчлэлтийн дараа тулгарч буй бэрхшээл, сэтгэл зүйн хямралыг даван туулахад зөвлөгөө өгч, тусламж дэмжлэг үзүүлэх үйлчилгээг эрхэлдэг байна. Улс орнууд үрчлэлттэй холбоотой мэдээ мэдээлэл, зөвлөгөө, тоо баримтыг холбогдох байгууллагуудын цахим хуудсанд нээлттэй байршуулж иргэдэд ашиглуулдаг.

Зарим улс орнуудын үрчлэлтийн дараа хяналт тавих механизмыг бий болгосон жишгээс авч үзвэл,

Румын улсад хүүхдийг үрчлэгдсэнээс хойш 2 жилийн хугацаанд эрх бүхий байгууллага хүүхдийн эрүүл мэнд, аз жаргалтай байдал, орчин нөхцөлд хяналт тавих үүрэгтэй байдаг. Украйнд Сайд нарын зөвлөл дотооддоо үрчлэгдсэн хүүхдийн амьдралын нөхцөл, хүүхдийн хүмүүжлийн асуудалд хяналт тавих үүрэгтэй. Харин гадаад улс оронд үрчлэгдсэн хүүхдийн амьдрах нөхцөл, эрхийн асуудалд тэднийг 18 нас хүртэл нь Гадаад хэргийн яам Консулын газраараа дамжуулан зохих журмын дагуу хяналт тавьдаг. ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор

ОХУ-ын харьяалалтай хүүхдийг үрчлэн авсан гадаадын иргэн болон дотоод үрчлэлт хийсэн тус улсын харьяат иргэн гадаад оронд байнга оршин суух тохиолдолд хянах тогтолцоог бий болгосон байна. Үрчлэгдсэн хүүхдийн оршин сууж буй улсад ОХУ-аас сууж буй эрх бүхий байгууллага үрчилж авсан эцэг эхээс тухайн хүүхэд гэр бүлтэйгээ хэрхэн амьдарч буй болон амьдрах нөхцөл байдал ямар байгаа талаар үрчлэгдсэнээс хойш эхний жилд хагас жил тутам, хоёр, гурав дахь жилээс жилд 1 удаа бичмэл тайлан ирүүлэхийг шаарддаг байна.

Япон улсын Хүүхдийн төв 47 мужид 219 салбартайгаар хүүхэд хамгааллын үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд үрчлэлтийн өмнө ба дараа гэсэн чиглэлээр үрчилсэн эцэг эх болон үрчлэгдсэн хүүхдэд сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг ба шаардлагатай тохиолдолд гэрээр нь очиж хяналт тавьдаг байна.

Зарим улс орон хүүхэд үрчлэлтийг шүүхийн шийдвэрээр хүлээн зөвшөөрдөг бөгөөд энэ нь хүүхдийн язгуур эрх ашигт эрсдэлтэй үрчлэлт буурах, үрчлэлтэд оролцогч талуудын зорилго, баримт бичиг бодитой эсэхийг хянадаг, үрчлэгч талуудын эрх зүйн мэдлэгийн дутмаг байдлаас гарах үр дагавар багасах зэрэг давуу талтай байдаг зэргийг цаашид харгалзан үзэх боломжтой.

ДҮГНЭЛТ, САНАЛ

“Монгол улс дахь хүүхэд үрчлэлтийн хяналтын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” сэдвийг Монгол Улсад үрчлэлтийг зохицуулж буй хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг болон үрчлэлт хүчингүйд тооцуулах нэхэмжлэлийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, гадаадын зарим орнуудын эрх зүйн зохицуулалт зэргийг судалж, дараах дүгнэлт, саналтай байна.

“Хүүхэд үрчлүүлсэн, үрчилж авснаар дэлхий ертөнц өөрчлөгдөхгүй ч тэр хүүхдийн хувьд бүхий л ертөнц нь өөрчлөгдөх болно”. Хүүхэд үрчлэлттэй холбоотой эрх зүйн зохицуулалт бүхий л цаг хугацааны туршид эртний хуулиуд¹⁶-аас эхлэн улс орнуудын хууль тогтоомжид тусгагдан хэрэгжсээр ирсэн бөгөөд өнөөгийн байдлаар дэлхийн 195 орны 173 нь үрчлэлтийг хүлээн зөвшөөрч энэхүү асуудлыг дагнасан хууль болон бусад хууль, хуульчилсан актандаа тусгаж зохицуулдаг байна.¹⁷

¹⁶ Эртний хуулиуд Ойрх Дорнод, Орчуулсан М.Хатанзориг, Д.Одон, Л.Нарангэрэл, Ц.Байгаль., УБ, 2022 он болон бусад эртний хууль цаазын бичгүүдэд

¹⁷ Child adoption trends and policies. UN, 2009 / Үрчлэлтийг хориглосон: Афганистан, Алжир, Жибути, Бахрайн, Египет, Иран, Ирак, Иордан, Кувейт, Ливи, Мальдивын арлууд, Мавритини, Морокко, Оман, Пакистан, Катар, Саудын Араб, Арабын БН, Сири, АНЭУ, Йемен зэрэг Гадаад үрчлэлтийг хориглосон: Антик болон Барбуда, Аргентин, Бангладеш, Микронез, Намиб, Нигериа, Сейшел арлууд, Соломоны арлууд, Танзан зэрэг Гэр бүлийн тухай хуулиар зохицуулдаг улс орон: Коста рико, Хойд Солонгос, БНАКонго, Элсальвадор, Филиппин, Киргизстан БН, Лаос, Либери, Монгол, Польш, Молдав, Румын, ОХУ Сенигал, Тажигистан, Туркместан, Украин, Узбекистан зэрэг Үрчлэлтийн хуультай улс орон: Андорра, Зааны ясан эрэг улс, Кипр, Гүрж, Грек, Израйл, Лесото, Перу зэрэг Хуульчилсан актаар зохицуулдаг улс орон: Ангол, Антик

Хүүхдийг асрамжийн газар өсгөхөөс илүүтэй эцэг, эхийн хайр халамжид, гэр бүлд өсгөх нь зүйтэй гэсэн чиг хандлага дэлхий нийтэд давамгайлж байгаа бөгөөд үүнийг зарим улс орнууд бодлогоор дэмжиж хүүхэд үрчилж авсан гэр бүлд тодорхой хэмжээний мөнгөн дэмжлэг үзүүлэх, татвараас хөнгөлөх гэх мэт аргуудыг хэрэгжүүлж эхэлжээ.

Монгол Улс дахь Хүний эрхийн үндэсний комиссын сүүлийн 10 жилийн тайланд үрчлэгдсэн хүүхдийн эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх талаарх асуудал огт дурдагдаагүй, НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол

болон Барбуда, Бахамас, Барбадос, Белис, Бутан, Бостаани, Чиле, Хятад, Хорват, Чех, Дани, Доминика, БН Доминикан улс, Фижи, Финланд, Гамби, Гана, Гранада, Гуана, Гайти, Палау, Шинэ Гвиней, Унгар, Исланд, Энэтхэг, Ирланд, Итали, Ямайка, Казакстан, Кеня, Мадгаскар, Малави, Малайз, Мали, Маршалын арлууд, Мянмар, Намиб, Шинэ Зеланд, Никарагуа, Норвеги, Эстон, Сайнт Киттс болон Невс, Сайнт, Лусиа, Сайнт, Винсент, болон Гранадин, Самау, Сан-томе ба Принсипи, Сейшелийн арлууд, Сьерра-Леон, Сингапур, Словак, Словен, Соломоны арлууд, Өмнөд Африк, Шриланк, Судан, Суринам, Свазиланд, Швед, Македон, Тринидад, Тобаго, Тунис, Англи, Танзан, Замба, Улсбаб зэрэг Иргэний хуулиар зохицуулдаг улс орон: Аргентин, Австри, Белги, Бенин, Буркини, Фасо, Бурунди, Камерун, Кабо, Верда, Төв Африкийн БНУ, Чад, Коморос, Эквадорын, Гвиней, Эритрей, Португал, Габон, Герман, Гватемал, Гвиней, Гвиней-Бисау, Индонез, Япон, Латви, Лихтенштейн, Литуаниа, Лекснбург, Мальта, Мавритус, Мексик, Микронези, Монако, Мозамбек, Непал, Нидерланд, Өмнөд, Солонгос, Руанда, Испани, Швейцарь, Тайланд, Турк, Венесуэл, Вьетнам, Нигер зэрэг Иргэний хууль, Гэр бүлийн тухай хуулиар: Армина, Этоп, Франц, Панам, Того зэрэг Муж бүртээ өөр өөр зохицуулалттай: Австрали, Канада, Нигериа, Америк зэрэг Шашин шүтлэгээс хамаардаг: Бангладеш, Бруней, Даруссалам, Лебан зэрэг Хүүхдийн тухай хуулиар: Аргентин Австри, Белги, Бенин, Буркини, Фасо, Бурунди, Камерун, Кабо Верда зэрэг Үндсэн хууль болон бусад хуулиар: Гондариус, Микронез, Пала, Параг зэрэг/ тусгагдсаныг түүвэрлэв.

Улсын үндэсний тайлан илтгэлд болон хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллагын тайланд зөвхөн жилд хэдэн хүүхэд үрчлэгддэг талаарх тоон мэдээллийг л оруулдаг нь **үрчлэгдсэн хүүхдийн эрх ашиг зөрчигдөхгүй байна уу эсвэл зөрчигдөж буйг хянах механизм байхгүй** сул байна уу гэдэгт цаашид анхаарал хандуулах чухал байна.

Хэдийгээр гэр бүлийн асуудал нь хувийн шинжтэй боловч нийгмийн үндсэн нэгж болсон гэр бүлийг төрөөс дэмжих, хамгаалах, иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг нарийвчлан тодорхойлох, хариуцлагажуулах, гэр бүл дэх хүүхдийн эрхийг хангах, хүүхэд үрчлэлт, асран хамгаалах үйл ажиллагааг боловсронгуй болгох, гадаадын харьяат гэр бүлд монгол хүүхдийг үрчлүүлэх асуудлыг хуульд тусгайлан, нарийвчлан зохицуулах шаардлагатай. Түүнчлэн,

1. Хүүхэд үрчлүүлэхээс өмнө үрчлэгч гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийх
2. Үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн үрчлэгчид хууль зүйн хариуцлага хүлээлгэх асуудлыг хуульчлах
3. Үрчлэлтийн үйл явцад холбогдох байгууллагуудыг тодорхой болгох Тухайлбал, Үрчлэлттэй холбоотой зуучлалын байгууллага¹⁸
4. Хувь хүний нууцтай холбоотойгоос бусад үрчлэлттэй холбоотой мэдээллийг нээлттэй байршуулах, холбогдох мэдээ,

мэдээлэл, тоо баримтыг судалгааны эргэлтэд оруулах

5. Дотоод, гадаад үрчлэлтийг бие даасан хуулиар зохицуулах, эсвэл зохицуулж буй хуульд нэмэлт өөрчлөлт оруулах / Тухайлбал, хяналтын асуудал/
6. Хүүхэд үрчлэлтийн нэгдсэн бүртгэлийн системийг эрх зүйн зохицуулалтад оруулж, нэвтрүүлэх¹⁹ нь зүйтэй.

¹⁹ Тухайлбал, Герман, Япон, Америк зэрэг улсад нэгдсэн бүртгэлийг хөтлөн явуулж, мэдээллийн сан үүсгэдэг төдийгүй хүүхэд үрчлэлтийн талаар "ROOT" бүртгэлийн системийг ашигладаг байна.

¹⁸ Япон улсын хувьд, Хувийн зуучлалын байгууллагуудын хүүхэд үрчлүүлэхэд зуучлахтай холбоотой хүүхдийг хамгаалах тухай хууль

УЛС ТӨР СУДЛАЛ БА ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН



Шихихутуг их сургуулийн
дэд профессор. Доктор (Ph.D)
Д.Отгончимэг

Түлхүүр үг: Улс төр, шинжлэх ухаан, боловсрол, хөгжил, хууль, хэм хэмжээ, субъектив, объектив эрх зүй

Товч утга: хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлээр илрэн хэрэгжиж байгаа эрх зүйн дэг журам байх ёстой хэм хэмжээнд хэрхэн нийцэж байгаагаар тухайн төр улсын мөн чанарыг танин мэднэ гэсэн хэрэг. Үндсэн хуульт төр ёсны үндсэн онолоор эрх зүйн хэм хэмжээний байх ёстой суурь зарчим, хэм хэмжээ Үндсэн хуульд тусгалаа олсон байх тул төрийн бүтэц, чиг үүргийг Үндсэн хуулийн тулгуур үзэл санаа, зарчмыг удирдлага болгодог үүднээс нь товч тайлбарлахыг зорив.

Субъектив, объектив эрх зүйг төр холбоно. Эрх эрх чөлөөний боломж байдлаар оршиж буй субъектив эрх зүйг хамгаалж, хууль зүйн хүчин чадалтай эрх зүйн хэм хэмжээ, нийгэмд үйлчлэх хүч болгодог үндсэн субъект нь төр мөн. Эрх зүйн харилцаа, хэм хэмжээ үүсэх, орших, өөрчлөгдөх, хөгжих,

дуусгавар болох үйл явц төртэй шууд холбоотой. Тийм ч учраас бүх салбар эрх зүйн хэлбэрийн эх сурвалж төрөөс тогтоосон буюу зөвшөөрсөн хэм хэмжээний нийлбэр цогц байдаг.

1. Төрийн онолыг судлах шаардлага

Эрх зүй объектив, субъектив агуулгатай. Үүнийг зөвхөн хийсвэр сэтгэлгээний төвшинд ялгана. Төр хууль бүтээхдээ эх сурвалж болгодгийг субъектив эрх зүй, төрөөс эрх зүйн хэм хэмжээ болгон баталсныг объектив эрх зүй гэдэг.

2. Төрийг судлах ач холбогдол

Эрх зүйг төрөөс хамгаалж, хэм хэмжээний хэлбэрт оруулан хууль баталж байдаг хэдий ч ямар эх сурвалжид тулгуурлаж буйгаас хамаарч зохицуулалтын арга, механизм нь харилцан адилгүй. Зарим төр иргэдээ хувийн өмчтэй байхыг зөвшөөрч, тэр эрхийг хуулиар хамгаалж байхад, зарим нь хориглож байх жишээтэй. Тэгвэл ямар нь хамгаалж, ямар нь хориглож байдгийг ойлгох, түүний учир шалтгааныг тогтоох шаардлагатай. Үүнийг "объектив, субъектив эрх зүйгээс бус, харин тэдгээрийг холбогч төрөөс эрх хайх шаардлага зүй ёсоор гарна. Төрийг анатомичлан судалсны үр дүнд эрх зүйн эх сурвалжийн сонголт, зохицуулалтын арга механизм янз бүр байдгийн учир шалтгааныг тодруулна. Энэ зүй тогтлыг ойлгох нь хууль зүйн шинжлэх ухаанд хөл тавих эхлэл юм"¹. Тэгэхээр төрийн

¹ Лүндэндорж Н. "Төрийн онол". УБ., 2008. 3 дахь

онолыг судалснаар хууль зүйн шинжлэх ухааны тулгийн гурван чулуу болсон эрх зүй, төр, шинжлэх ухаан гурвыг чухалчилж үзэх хэрэгтэй болно.

Эрх зүй. Эрх зүйн хэм хэмжээ нь "Төр гэсэн нэр томъёогоор тэмдэглэсэн үзэгдлийн шалтгаант холбооны зүй тогтлыг ойлгох улмаар хууль зүйн практикт түүний илрэх арга, хэлбэрийг танин мэдэх, тайлбарлах, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тандах онол арга зүй эзэмшдэг"² гэж тайлбарласнаас үзвэл төрийн зохицуулалт, хууль эрх зүйтэй нягт холбоотой.

3. Төрийг судлах арга зүй

Төр бол нэг талаас нийгмийн бодит үзэгдэл, бэлэн оршиж буй факт, нөгөө талаас байх ёстой хэм хэмжээ бүхий эрх зүйн үзэгдэл мөн. Тиймээс төрийг байгаа болон байх ёстой зүйлийн үүднээс судална. Төрийг байгаа зүйлийн хувьд судална гэдэг нь бодитой байгаа факт, түүний үүсэл, хөгжлийн зүй ёсны шалтгаант холбоог эрж хайна гэсэн үг. Үүний тулд "нийгэм, хүмүүнлэгийн ухаан, байгалийн шинжлэлийн ололт, хууль, зүй тогтолд тулгуурлан, хүн байгалийн салшгүй холбооноос эх үндсээ авсан соёл иргэншлийн онол, арга зүйг ашиглана"³ гэх мэтээр тодорхой тусгалыг зааж өгсөн байна. Мөн "Байгаа төрийн бодит фактад тулгуурлан бах ёстой төрийг улс төр, эрх зүйн үнэт зүйлийн хэм хэмжээнд /Basic Norm/ тулгуурлан бас судалдаг"⁴.

Байх ёстой зүйл гэдгийг юмс үзэгдэл, байгалийн хууль зүй тогтлыг задлан шинжлэх замаар тогтоосон зүйл гэж үзэх хандлага нь хууль, эрх зүйн судлалд түгээмэл байсан. Харин энэ хандлага оновчтой биш гэдгийг 1740 онд Хюм /Hume/ тэмдэглэж, байх ёстой зүйл буюу хэм хэмжээ, байгаа зүйл буюу бодит фактыг ямагт бүрэн тусгахгүй гэсэн үзэл баримтлалыг дэвшүүлжээ. Үүний үндэслэлийг тайлбарлахдаа ёс суртахууны хэм хэмжээ хүмүүсийн сэтгэл ханамж ямар байгааг шалгаж тогтоох гэвэл асар их зөрчил бэрхшээлтэй тулгарч, Мүүн /G.E.Moore/-ийн хэлснээр натуралист алдаанд хүрнэ.

Өөрөөр хэлбэл байгаа зүйл, байх ёстой зүйл хоёрын хооронд зай завсар буюу хэм хэмжээ байх ёстой. Тийм учраас байх ёстой зүйлийг бодит фактаар тодорхойлохоос гадна оршин буй үйлдлийн горимыг урьдчилан тогтоож, үнэлгээний стандарт, шалгуурын дагуу үнэлж болно гэжээ.

Байх ёстой зүйл гэдэг бол ямар нэг субъектын хүсэл зориг, дур зоргын хэм хэмжээ биш. Энэ бол тухайн үеийн хүний танин мэдэхүйн хүрсэн төвшингөөр хязгаарлагдан тогтсон дээд эрмэлзэл юм. Байх ёстой зүйл буюу дээд эрмэлзэл оршин буй фактын итгэлцүүрийг тогтоох замаар эрх зүйн үнэт зүйл, суурь хэм хэмжээг хүлээн зөвшөөрч, баримтлал болгодог. Түүнийг байх ёстой хэм хэмжээ гэнэ.

Тэгэхээр хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлээр илрэн хэрэгжиж байгаа эрх зүйн дэг журам байх ёстой хэм хэмжээнд хэрхэн нийцэж

хэвлэл

² Отгончимэг, Д. Улс төр судлал. УБ., 2007

³ Лүндандорж, Н. "Төрийн онол". УБ., 2008. 3 дахь хэвлэл

⁴ Отгончимэг, Д. Улс төр судлал. УБ., 2007

байгаагаар тухайн төр улсын мөн чанарыг танин мэднэ гэсэн хэрэг. Үндсэн хуульт төр ёсны үндсэн онолоор эрх зүйн хэм хэмжээний байх ёстой суурь зарчим, хэм хэмжээ Үндсэн хуульд тусгалаа олсон байх тул төрийн бүтэц, чиг үүргийг Үндсэн хуулийн тулгуур үзэл санаа, зарчмыг удирдлага болгон судлах хандлага өдгөө давамгайлж байна.

Хууль зүйн шинжлэх ухаан нь эрх зүйн үзэгдлийн мөн чанар, зүй тогтол, хэтийн төлөв, чиг хандлагыг судалдаг нийгмийн шинжлэх ухааны нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм." Жишээлбэл: Монголын их, дээд, тусгай мэргэжлийн дунд сургууль нь нийгмийн оюун санааны хэрэгцээг хангаж ирсэн олон мянган сэхээтнийг бэлтгэж өөрийн орны улс ардын аж ахуй, соёлын бүх салбарыг бүрэлдүүлж хөгжүүлэхэд чухал үүрэгтэй оролцож байсан. Орчин үеийн төр улс, эдийн засгийг бүтээн байгуулахад үлэм их нөлөө бүхий тун хэрэгтэй хамгийн хомс нөөц хүч болох сэхээтний давхарга ийнхүү бүрэлдэн бэхжиж ирсэн байна. Тэдгээр сэхээтнүүдийн бүтээлч хөдөлмөрийн үр дүнд монголын нийгэм хөгжил дэвшлийн зохих түвшинд хүрчээ. Монголын сэхээтний нэг гол бүрэлдэхүүн хэсэг бол бүх шатны сургуулийн багш нар байсан агаад боловсролын салбарт ажиллагсдын тоо байнга өсөн нэмэгдэж байсан. Тухайлбал: "1969 онд 21,7 мянга, 1979 онд 43,1 мянга, 1989 онд 69,4 мянган хүн боловсролын салбарт ажиллаж байсан агаад тэдгээрийн дийлэнх нь багш нар байв"⁵.

⁵ Дашдаваа. Ч.БНМАУ дахь соёлын хувьсгал: түүхэн туршлага, орчин үеийн асуудал. УБ.,1989.

Боловсролын бодлого хүчтэй байсны үр дүнд бий болсон мэргэжилтнүүд нийгэм, эдийн засгийн бүх салбарын үр ашгийг нэмэгдүүлж, улс орныг хөгжлийн тодорхой тавцанд гаргаж ирсэн байна. "1960-1985 онд улс ардын аж ахуйн үндсэн фонд 10,5 дахин, үндэсний орлогын үйлдвэрлэл 3,2 дахин, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 9,3 дахин, нийгмийн хөдөлмөрийн бүтээмж 2,8 дахин өсжээ"⁶. Монгол улсын боловсролын салбарын өсөн дэвшилт судалгаа шинжилгээг ч хөгжүүлж ирсэн билээ. Монголын тэргүүний эрдэмтдийн олон улсын чанартай нээлт болон эдийн засаг, нийгмийн хөгжилд дорвитой нөлөө үзүүлсэн практик үр дүн багагүй гарсан билээ.

1960-1990 онд Ардын боловсролын салбарт 3-6 тэрбум төгрөг зарцуулжээ. Боловсролын салбарын нийт хөрөнгө оруулалт 1980 онд 10,5 хувьд хүрсэн бөгөөд 1990 оноос өмнө улсын төсвийн 25 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 64 хувийг эзэлсэн хамгийн их хөрөнгө оруулалттай, төрийн онцгой халамжид байсан байна. Мөн дээрх он жилүүдэд "Гэгээрлийн яам", "Ардын боловсролын яам" хэмээн нэрлэгдэж, Магалжавын Жамсран, Дэнзэнгийн Ишцэрэн, Раднаасэдийн Санжаасүрэн, Чимэдийн Сэрээтэр, Бямбын Даваасүрэн нарын сайдууд удирдан ажиллаж байв"⁷.

х-46

⁶ Монгол Улс Шинжлэх Ухааны Академи Түүх, угсаатны зүйн хүрээлэн. XX зууны МОНГОЛ. Боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжлийн түүх, УБ.,2020. х-236

⁷ Монгол улсын боловсрол, шинжлэх ухааны яамны цахим хуудас <http://www.meds.gov.mn>.

Ард түмнээ ядуурал, эрдэм мэдлэгийн хоосролоос гаргаж, улс орноо хөгжүүлэе хэмээн зорьсон Монгол төрийн нүд тайлж, оюунжсан удирдагчдын тогтоол шийдвэр, түүний дагуу хийсэн хүчтэй, далайцтай ажлын үр дүнд асар богино хугацаанд нийтээрээ бичиг, далайцтай ажлын үр дүнд асар богино хугацаанд нийтээрээ бичиг үсгийн мэдлэг эзэмшиж, ерөнхий боловсролтой сурагчид, мэргэжсэн ажилчин анги, дээд боловсролтой сэхээтний давхаргыг бий болгож, оюун санааны хийгээд аж үйлдвэржилт, хөдөөд аж ахуйн салбаруудыг босгон хөгжүүлсний үрээр дундад зууны үеийн байдалтай хоцрогдсон Монгол орчин үеийн шинэ Монгол улс болон цэцэглэн хөгжсөн бөгөөд энэхүү үйл явц тус улсыг хөгжиж буй орнуудын жагсаалтад албан ёсоор оруулсан байна.

"Хууль зүйн шинжлэх ухаан нь нийгмийн шинжлэх ухааны нэг төрөл бөгөөд эрх зүйн хэлбэржих, хэрэгжих хөгжих зүй тогтлыг нээн харуулж, тэдгээрийн ойлголт ухагдахуунаар илэрхийлж буй эрх зүйн тухай мэдлэгийн тогтолцоо мөн" юм. Иймээс **Хууль зүйн шинжлэх ухааны онолын арга зүйн асуудал нь:** Шинжлэх ухааны танин мэдэхүйн арга зүй. Арга зүй /methodologi/ гэж юуг хэлэх вэ? Методологи буюу арга зүй гэсэн үг, нэр томъёог этимологи буюу түүхэн гарал үүсэл талаас нь тодорхойлбол "Methodos" нь эртний грекчүүдийн хувьд "арга зам, судалгаа, дагаж мөрдөх" гэсэн агуулгатай. Харин "Logos" гэдэг ойлголт нь оюун ухаан, сэтгэлгээ гэсэн агуулгатай.

"Монголчууд эртнээс дээд тэнгэрийг тахин шүтэж, эзэн хаанаа тэнгэрийн хүү хэмээн өргөмжилж, энэ талаар улстөрийн бүхэл бүтэн сургаалыг бий болгосон бөгөөд үүнийг судлаачид Тэнгэрийн үзэл буюу тэнгэризм"⁸ гэж нэрлэх боллоо. Энэ нь "Их Монгол улсын төрийн үзэл суртлын үндэс болж байв. Чингис, Өгэдэй, Гүюг хааны үеэс тэнгэрт шүтсэн бөөгийн үзэл ноёрхож байсан бол Мөнх хааны үеэс тэнгэрийн доорх бүхнийг захирна хэмээх тэнгэрчлэх үзэл болон хөгжсөн байна"⁹

"Арга зүйн ойлголт"-ын тухайд гэвэл:

1. "Үйл ажиллагааны /шинжлэх ухаан, улс төр, урлаг гэх зэрэг/ аль нэгэн салбарт хэрэглэж байгаа тодорхой арга, арга зам, ажилбарын тогтолцоо.
2. Аргын тухай онол, аргын тухай сургаал гэсэн хоёр ач холбогдлыг илэрхийлж байна"¹⁰.

Иймд шинжлэх ухааны арга зүй нь шинжлэх ухааны танин мэдэхүйн бүтэц, хөгжил, шинжлэх ухааны шинжилгээ судалгааны арга хэрэгсэл, түүний үр дүнг нэгтгэн дүгнэх аргачлал, эрх зүйн тухай мэдлэг практикт нэвтрэх механизм, хэлбэр зэргийг судалдаг.

Хууль зүйн шинжлэх ухааны судалгааны үндсэн арга зүй

Хууль зүйн шинжлэх ухаан нь эрх зүйн шийдэх ёстой асуудал бүрийг амжилттайгаар шийдвэрлэхэд гарц болж чадах онолын байгууламж

⁸ Бира. Ш. Их Монгол Улсын түүх, үзэл суртлын зарим онцлог асуудлууд. УБ., 2006

⁹ Болдбаатар. Ж. Лүндээжанцан. Д. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 2021, х-52

¹⁰ Отгончимэг Д. Нийгмийн ухааны хичээлүүдийн товч ойлголтууд. УБ., 2016, х-41

төдийгүй эрх зүйн тогтолцоог хөгжүүлж байдаг онол, арга зүйн тогтолцоо юм.

Тус шинжлэх ухаанд дараах 3 арга зүйг түгээмэл хэрэглэдэг. Үүнд:

- “Норматив буюу прескриптив
- Экспликатив буюу дескриптив
- Харьцуулалт

Норматив арга зүй нь байх ёстой зүйл, хэм хэмжээг чухалчилдаг бөгөөд дараах зарчмуудыг баримталдаг.

- Метафизик зарчим;
- Түүхчлэх зарчим;
- Логикийн зарчим.

Метафизик зарчим нь хүний эрх, эрх чөлөөний ойлголт дан ганц философийн категори, хийсвэр санаа төдий биш энэ нь хэм хэмжээнд суурилах ёстой гэсэн үндэслэлийг чухалчилдаг.

Логикийн зарчим нь хуулийн зүйл, заалт, үзэл баримтлалыг тайлбарлахдаа өөрийн хувийн үзэл бодлоос ангид байдлаар гагцхүү үндсэн хэм хэмжээний агуулгаар тайлбарлахыг гол зорилгоо болгодог. Дескриптив арга зүй нь: дараах зарчмуудыг баримталдаг.

- Нөхцөл байдлыг шинжлэх зарчим;
- Онтологийн зарчим;
- Арга зүйн зарчим”¹¹.

Нөхцөл байдлыг шинжлэх зарчим нь тухайн цаг үеийн бодит байдлыг судалсны үндсэн дээр үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино. Жишээ нь:

- Иргэдийн шүүхэд итгэх итгэл ямар үзүүлэлттэй байна вэ?
- Монгол улсын засгийн газар

¹¹ Жалбажав. Н, Чойжамц. Я, Доржняв. Ц, Отгончимэг Д. Энхбаатар М. Улс төрийн судлалын бүдүүвчийн цомог. УБ., 2020.

ямар бүтэц, бүрэлдэхүүнтэй вэ?

Одоогоор Монгол улсад нийт хэдэн хууль, хуульчилсан акт хүчин төгөлдөр үйлчилж байна вэ? гэх мэт..

Харьцуулалтын арга зүй нь: танин мэдэхүй болон дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэсэн ололт дээр тулгуурлаж байдаг. Харьцуулалтын арга зүйн дараах зарчмуудтай.

Чиг үүргийн зарчим нь: Харьцуулсан судалгааны асуултыг цэвэр чиг үүргийн нэр томъёогоор тавих ёстой, харин асуудал нь судлаачийн өөрийнх нь эрх зүйн тогтолцооны үзэл баримтлалтай ямар нэг холбоогүйгээр илэрхийлэгдсэн байх шаардлагатай.

Чиг үүргийн зарчмын онцлог нь: Эрх зүйн харьцуулалтад абстракт түшингээс хандах нь үр дүнгүй. Харин тодорхой нөхцөл байдлыг авч үзээд түүн дээрээ тулгуурлан төрөлжүүлсэн судалгаа хийх нь илүү үр дүнтэй байдаг.

Жишээ нь: Эдгэрэхгүй өвчтэй хүнд сайн дураар нас нөгчихөд туслах, спортын тэмцээний үеэр бусдад санаатай гэмтэл учруулах асуудлыг хэрхэн шийдвэрлэж байна вэ? гэх мэт

Хязгаарлалтаас зайлсхийх зарчим нь: Ихэнхдээ эрх зүйн эх сурвалжтай холбож ойлгох нь үр дүнтэй байдаг. Тухайн эрх зүйн тогтолцоонд юуг эрх зүйн эх сурвалжид тооцно түүнийг нь судлаач хүлээн зөвшөөрөх ёстой.

Таамаглалын арга нь: Өмнөх хоёр зарчимд тулгуурладаг. Энэхүү аргын тусламжтайгаар судлаач өөрийн оронд эрх зүйн хэм хэмжээнүүдийн гүйцэтгэдэг үүргийг эрх зүйн нэмэлт

арга хэрэгслүүдээр хангадаг болохыг мэдэх бололцоотой. Жишээ нь:

Civil Law тогтолцоонд насанд хүрээгүй хүмүүсийг эрх зүйн бүхий л үйл ажиллагаанд төлөөлдөг "хууль ёсны төлөөлөгч" гэсэн ойлголтыг Common Law тогтолцоонд үүнтэй адил институт байхгүй ч энэхүү асуудлыг шийдвэрлэдэг. Тухайлбал, хэрэв бага насны хүүхэд шүүхэд нэхэмжлэл гаргах шаардлагатай бол "next friend", хүүхдийн өмчтэй холбоотой үүргийг "trustee" гэх мэтээр олон институт гүйцэтгэдэг байх жишээтэй.

Дүгнэлт:

Хууль зүйн шинжлэх ухаан өөрөө иргэншсэн нийгмийг хөгжүүлэгч нэг гол хүч, хөгжлийн гарц юм бол тэрээр янз бүрийн үндэстний хэл соёл, ёс заншил, сэтгэлгээний онцлогоос үл хамааран хамгийн рационал онол, арга зүйд тулгуурлах ёстой. Ингэж чадвал тэрээр өөрийн үндсэн үүргийг амжилттай биелүүлээд зогсохгүй шинжлэх ухааны ертөнцөд өөрийн орон зайг хурдацтайгаар тэлж чадна. Судлаач миний бодлоор "Төрийн онол", "Төрийн онолуудыг судлах арга зүйн ач холбогдол", "Эрх зүйн хэм хэмжээ", "Хууль зүйн шинжлэх ухааны онолын арга зүйн асуудал"-ууд зэрэгт логикийн үндсэн зарчмуудаас товч бөгөөд тодорхой тусган иргэдийн боловсролоор дамжуулан, нийгэм-төрийн тогтолцоог хууль эрх зүйн аспектэд үндэслэн тайлбарлахыг хичээв.

Ашигласан ном зүй

1. Болдбаатар. Ж, Лүндээжанцан, Д. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 2021
2. Лүндэндорж. Н. "Төрийн онол". УБ., 2008. 3 дахь хэвлэл
3. Жалбажав, Н.Чойжамц, Я.Доржняма, Ц.Отгончимэг, Д.Энхбаатар М "Улс төрийн судлалын бүдүүвчийн цомог". УБ., 2020.
4. Отгончимэг. Д. Улс төр судлал. УБ., 2007
5. Отгончимэг. Д. Нийгмийн ухааны хичээлүүдийн товч ойлголтууд. УБ., 2016,
6. Дашдаваа. Ч.БНМАУ дахь соёлын хувьсгал: түүхэн туршлага, орчин үеийн асуудал. УБ., 1989
7. Монгол Улс Шинжлэх Ухааны Академи Түүх, угсаатны зүйн хүрээлэн. ХХ зууны МОНГОЛ. Боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжлийн түүх. УБ., 2020
8. Монгол улсын боловсрол, шинжлэх ухааны яамны цахим хуудас <http://www.meds.gov.mn>.
9. Бира. Ш. Их Монгол Улсын түүх, үзэл суртлын зарим онцлог асуудлууд. УБ., 2006

Эрүүгийн хууль дахь хөөн хэлэлцэх хугацааны тулгамдаж буй асуудал
Statute of limitations in Criminal Law



*Шихихутуг их сургуулийн Нийтийн
эрх зүйн тэнхимийн эрхлэгч.
Докторант Б.Мөнх-Эрдэнэ*

Гарчиг

Удиртгал

1. Эрүүгийн хууль дахь хөөн хэлэлцэх хугацааны ойлголт, тулгамдаж буй асуудал
2. Эрүүгийн хууль дахь хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалтын онцлог
3. Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой үүсэж буй асуудлыг даван гарах үндэслэл

Дүгнэлт/Санал/

Удиртгал

Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдөр тогтоол гаргахдаа Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт өөрчлөлт оруулж 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа, шүүхэд хянан шийдвэрлэгдэж буй эрүүгийн хэрэгт гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолохдоо өмнө нь үйлчилж байсан процессын хэм хэмжээ болох “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолох” зохицуулалтыг хэрэглэхгүй гэж тайлбарласан.

Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох” зохицуулалт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “журам тогтоосон” шинжтэй буюу процессын эрх зүйн хэм хэмжээ бөгөөд уг хэм хэмжээг өөрчлөн тогтоосон хууль хүчин төгөлдөр болсон тохиолдолд өмнө үйлчилж байсан хэм хэмжээг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэхгүй, хүчин төгөлдөр үйлчилж байгаа процессын хэм хэмжээг өмнө үйлчилж байсан хэм хэмжээтэй ямар нэг байдлаар өрсөлдүүлэхгүй, зэрэгцүүлж эсхүл давхцуулж хэрэглэхгүй гэж үзсэн байгаа нь Эрүүгийн болон

Эрүүгийн процессын эрх зүйн онол, хэм хэмжээний үзэл баримтлалын хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, хөндөх тохиолдолд эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх харилцааг төрөлжсөн хуулиар тусгайлан зохицуулдаг бөгөөд уг ажиллагаанд хамаарах хэм хэмжээг тус хуулиар тогтоох, эсхүл заавал эш татан хуульчилдаг онолын болон хууль зүйн үндсэн ойлголтыг зөрчиж алдаатай агуулга бүхий тогтоол гаргасан байна.

Учир нь 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд шалгагдаж байгаа гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлд заасан хууль буцаан хэрэглэх зохицуулалт үйлчлэхгүй” гэсэн заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж Цэцийн дунд болох их суудлаар шийдвэр гаргаж дээрх агуулга бүхий заалтыг бүхэлд нь хүчингүй болгосон билээ. Гэтэл дээрх Монгол Улсын дээд шүүхийн тогтоол гарснаар практикт хөөн хэлэлцэх хугацааг шүүгч бүр өөрийнхөөрөө шийдвэрлэх тайлбарлах асуудал үүссэн. Зарим шүүгч хуулийг буцаан хэрэглэж хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож байхад зарим шүүгч яллагдагчаар татагдаад хөөн хэлэлцэх хугацаа зогссон тул хуулийг буцаан хэрэглэхгүй гэж ял өгсөн. Энэхүү ойлголтыг зөрүүтэй

байдлыг засах нэрийдлээр Монгол Улсын дээд шүүх нь хуулиас давсан тайлбар гаргах нь онолын хувьд алдаатай юм. Монгол Улсын Дээд шүүх нь тогтоолдоо Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс хүчингүй болгосон хуулийг агуулгыг тайлбарынхаа нэг хэсэг болгон оруулан сэргээсэн нь дахин төвөгтэй нөхцөл байдлыг бий болгож хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой үүсээд буй өмнөх асуудлуудыг ч шийдвэрлэх боломжгүй болгохоор байна.

Эрүүгийн хууль нь бусад хуультай харьцуулахад онолын хувьд хэзээ ч хүчингүйд тооцогддоггүй хууль гэдгээрээ онцлог байдаг. Гэмт хэрэг үйлдэгдэх үед үйлчилж байсан хуулийг буцаан хэрэглэх боломж нь Эрүүгийн хуульд л бий. Учир нь Эрүүгийн хуулийг хүчингүй болгочихвол хөөн хэлэлцэх хугацаа тооцох, хуулийг буцаан хэрэглэх нөхцөл бүрдэхгүй. Эрүүгийн хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэгдэж аливаа нэгэн өөрчлөлтийг онол арга зүйн дагуу хийгдсэн судалгаан дээр тулгуурлан иргэдийн эрх зүйн байдлыг ижил тэгш авч үзэх ёстой. Эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны асуудал нь нэг мөр ойлгогдохгүй байр суурь зөрөх, практикт хэрхэн нэг ойлголттой хэрэглэх талаар төвөгтэй нөхцөл байдал үүсгэсэн нь энэхүү судалгааг хийхэд хүргэсэн болно.

1. Эрүүгийн хууль дахь хөөн хэлэлцэх хугацааны ойлголт, тулгамдаж буй асуудал

Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг хуульчилж өгсөн¹ байдаг. Хөөн хэлэлцэх

¹ 1.10 дугаар зүйл. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа

1. Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй;

1.1. энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн;

1.2. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;

1.3. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг арван таван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван хоёр жил өнгөрсөн;

1.4. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг арван хоёр жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн.

1.5. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн.

2. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно.

3. Гэмт хэрэг үйлдсэн этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай дахин үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн гэмт хэргийг үйлдсэн үеэс гэмт хэрэг тус бүрд шинээр тоолно.

4. Энэ хуульд бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй.

5. Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш таван жил байна.

6. Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг

хугацаа нь БНМАУ-ын 1926, 1929 оны Шүүх цаазын бичигт “Ялыг үл хэлэлцэх”, 1934 оны Шүүх цаазын бичигт “Шүүх цаазын ёсоор хөөн байцааж үл болох шалтгаан”, 1942 оны Эрүүгийн хуульд “Хуулийн ёсоор хөөн шийтгэж үл болох шалтгаан” гэж тус тус хуульчлан томъёолж байсан. “Хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн томъёоллыг 1961 оны Эрүүгийн хуульд тусгаснаас хойш Эрүүгийн эрх зүйд ийнхүү нэрлэж хэвшсэн. Эдгээр хуульд гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш “Эрүүгийн хууль”-д заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй, эрүүгийн хариуцлагад татаж болохгүй, шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхгүй байх² гэсэн утгаар хуульчлагдан иржээ.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох зохицуулалтыг өөр өөрөөр тайлбарлан хэргийг шийдвэрлэсний улмаас шүүхийн практикт хууль хэрэглээний зөрүү үүссэн нь анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрүүдээр тогтоогдож байна. 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хууль хүчин төгөлдөр болсноор зохицуулалтын давхцалыг заагласан гэж үзэж байгаа бөгөөд

үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно.

6. Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно.

² Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тогтоол.

2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр. Дугаар 01.

өөрөөр хэлбэл энэ цаг хугацаанаас хойш хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт болон шүүхийн шатанд хянагдаж буй хэргийг шийдвэрлэхдээ уг заалтын өмнөх агуулга “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолох” зохицуулалтыг баримтлахгүй, харин түүний зөвхөн шинэ агуулга “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолох” зохицуулалтыг хэрэглэнэ³ гэж ойлгогдохоор зохицуулалт хийгдсэн. Гэтэл Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн нэг болон хоёрдугаар зүйлд зааснаар бол 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны нэгдүгээр сарын 10-ны өдрийн хооронд хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр прокурорын тогтоол, шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон зарим гэмт хэргүүдийг сэргээн шалгах нөхцөл бүрдүүлсэн нь онолын болон практик маргааныг дагуулсан нь өнөөдрийг хүртэл үргэлжилж байна.

Монгол Улс 1984 оны Эрүүгийн хууль мөн 2002 оны Эрүүгийн хууль гэмт хэргийн төрөл болоод оногдуулах ялын хэмжээнээс хамаарч хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай тогтоож иржээ. 2017 оны тавдугаар сарын 08-ны өдрийн

³ Монгол Улсын Дээд Шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоол. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар. 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр. Дугаар 11.

УИХ-ын чуулганы хуралдаанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа хөөн хэлэлцэх хугацааг шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно гэж өөрчилсөн. Уг заалт хэрэгжиж эхэлсэн өнгөрсөн хугацаанд анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхээр нийтдээ 400 гаруй хүнд холбогдох хэргийг хөөн хэлэлцэх хугацаагаар хэрэгсэхгүй болгож эрүүгийн хариуцлагаас чөлөөлжээ. Гэтэл Улсын Их хурлын 2020 оны нэгдүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд шалгагдаж байгаа гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй гэсэн агуулга оруулсан. Энэхүү заалт нь Үндсэн хууль зөрчсөн гэж Цэцийн дунд болох их суудлаар шийдвэр гаргаж дээрх агуулга бүхий заалтыг бүхэлд нь хүчингүй болгосон билээ.

Улсын Дээд шүүх нь хууль тогтоогч биш тул хуулиас давсан тайлбар гаргахгүй байх ёстой. Гэтэл Үндсэн Хуулийн Цэцээс хүчингүй болгосон хуулийг Улсын Дээд Шүүх тайлбараараа дахин хүчинтэй байдлаар хэрэглэх ёстой мэт тайлбарласан нь онолын алдаатай асуудал үүсгэж байна. Дээд шүүх хөөн хэлэлцэх хугацаа нь процессын эрх зүйн журамласан заалт учраас өмнөх хуулийн заалтыг хэрэглэхгүй гэсэн тогтоол баталсан нь практикт хэд хэдэн ойлголт төрүүлсэн

асуудлыг шийдвэрлэх нэг арга зам мөн хэдий ч онолын талаасаа энэ нь зөв гэж дэмжигдэх боломжгүй юм. Учир нь хуулийг буцаан хэрэглэх үед эрх зүйн байдлыг дээрдүүлэх гэсэн хууль ёсны зарчмын гол агуулгатай Улсын дээд шүүхийн тайлбар зөрчилдөж байгаагаас гадна хөөн хэлэлцэх хугацаа хэрвээ эрүүгийн процессын заалт гэж үзэж байгаа бол процессын хуульдаа энэхүү агуулгыг оруулж өгөх эсэх дээр анхаарах нь чухал юм. Нөгөө талдаа Улсын Дээд шүүхийн тогтоол гарахаас өмнө хэрэгсэхгүй болсон шүүгдэгчид ял завшсан гэж үзэх нь өөрөө өрөөсгөл ойлголтыг дагуулж байна.

Эрүүгийн эрх зүйн түүхэн хөгжил болон улс орнуудын Эрүүгийн хууль, эрүүгийн процессын хуулийг судалж үзэхэд хөөн хэлэлцэх хугацаагаар хэрэгсэхгүй болгосон хэргийг буцаан сэргээх, Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглосон заалт нэг ч байхгүй байна. Улс орнууд Эрүүгийн хуульдаа хөөн хэлэлцэх хугацаа хэзээ эхэлж, хэзээ зогсох болон түдгэлзэх, хэзээ дуусах, ямар гэмт хэрэгт хэрэглэхгүй байхыг нарийвчлан зохицуулж байна. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Япон Улс, Оросын Холбооны Улс зэрэг гадаадын улс орнуудын Эрүүгийн хуульд гэмт этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахгүйн үүднээс эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэх, эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхийг хориглосон заалтыг тусгасан байна. Мөн аль ч улс оронд хууль тогтоох байгууллагаас баталсан хүчин төгөлдөр Эрүүгийн

хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалтад үндэслэн шүүх нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хэрэгсэхгүй болгосон шүүхийн хүчин төгөлдөр тогтоолыг хүчингүй болгодог туршлага, эрх зүйн шинжлэх ухааны ойлголт, практик байхгүй⁴ байгаагаас харахад Дээд Шүүхийн тогтоолын агуулгаар зарим гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцох хуулийн үндэслэл эргэлзээтэй болчхож байна. Эргэлзээтэй тохиолдолд шүүгдэгчид ашигтайгаар шийдэх зарчим үйлчлэх ёстой. Нөгөө талаасаа зөвхөн тодорхой цөөн хэргийг онилж сэргээн шалгаж байгаа нь улс төрийн шинжтэй болохыг ч үгүйсгэхгүй. Дээд Шүүхийн тогтоолын агуулгаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр шийдвэрлэчихсэн хэргийг сэргээн шалгана гэдэг нь нэг хэргийг хоёр удаа шүүхээр оруулна гэсэн утга илэрхийлж байна. Эрүүгийн хуульд шүүх хууль хэрэглэхдээ гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэхээс өөр бусад тохиолдолд хэрэглэхийг хориглосон заалттай бөгөөд онолын хувьд ч энэхүү агуулга нь үгүйсгэгдэх боломжгүй билээ.

Эрүүгийн процессын хувьд тухайн хэрэгтэн алга болоод олон жил өнгөрөхөд хэргийн ул мөр баларна, баримтын нотлох чанар алдагдана. Тийм учраас 10 жилийн дараа цагдаагийн байгууллага тухайн хүнийг олж ирсэн байсан ч нотлох баримт шаардлага хангахгүй болсон байх нь цөөнгүй. Нөгөө

⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тогтоол. 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр. Дугаар 01.

талаар, энэ явдалд цэг тавихгүй бол төрийн байгууллага дээр хаагдаагүй хэрэг овоордог сул талтай.

Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой өөр тулгамдаж буй асуудлуудаас дурдвал Эрүүгийн хуулийн 17.3 зүйлийн 1, 17.4 дүгээр зүйлийн 1-т заасан залилах, завших гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг нэг жил, эсвэл таван жилийн алинаар тогтоосон нь ойлгомжгүй байна. Авлигын гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 22-р бүлэгт хуульчилсан байдаг. Албан тушаалтан л үйлдэх боломжтой нийт 20 гэмт хэргийн нэгээс бусад бүх хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа таван жил байхаар заасан байна. 5-15 жилийн хорих ял оноохоор Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдвэл 12 жил өнгөрөхөд хөөн хэлэлцэх хугацаа дуусаж хэрэгсэхгүй болгоно. Тэгэхээр дээр хэлсэнчлэн зарим гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцох хуулийн үндэслэл эргэлзээтэй байна. Эргэлзээтэй тохиолдолд шүүгдэгчид ашигтайгаар шийдэх зарчим үйлчилнэ. Эрүүгийн хуулийн тусгай ангийн диспозицийн системчлэл алдагдсан, оногдуулах ялын интервал шинжлэх ухааны үндэслэлгүй хийгдсэнээс ердийн бүрэлдэхүүнтэй буюу хөнгөн гэмт хэрэг үйлдсэн ч хөөн хэлэлцэх хугацаа 5 жил, уг гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн ч таван жил байхаар хуульчилж өгсөн асуудал харагдаж байна.

Эрүүгийн хуульд 209 зүйл бие даасан гэмт хэргийг зохицуулсан. Эдгээрийг заалт бүрээр тоолбол 400 гаруй гэмт хэрэг байдаг. Үүний

84 зүйл, хэсэгт заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг нэг жилээр тооцох уу таван жилээр тооцох уу гэдэг нь тодорхойгүй болсон. Эрүүгийн хуульд хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялаас гадна торгох, нийтэд тустай ажил хийлгэх, эрх хасах ял бий. Эрүүгийн хуулийн 18, 20, 22, 24, 25-р бүлэгт заасан хуулийн этгээд субъект нь байх 31 гэмт хэрэг байдаг. Эдгээр хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцох асуудал нэг бүр шийдэгдсэн гэж үзэх боломжгүй. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын тухайд ялгамжтайгаар нарийвчлан зохицуулахгүй бол шударга ёсны зарчим алдагдах эрсдэл үүссэн байна.

2. Эрүүгийн хууль дахь хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалтын онцлог

Хөөн хэлэлцэх хугацаа тасрах, зогсох гэсэн онолын хоёр ойлголт байдаг. Гэмт хэрэг гарсны дараа тухайн хүн өөрийгөө илчлэн ирэх, эсвэл цагдаагийн байгууллага илрүүлж анхны мэдүүлэг авсан үеэс хөөн хэлэлцэх хугацаа зогсдог. Оргон зайлбал хөөн хэлэлцэх хугацаа мөн адил зогсоно. Түүнчлэн анхан болон давж заалдах шатны шүүхээс хэргийг буцаасан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа зогсож байх ёстой. Хөөн хэлэлцэх хугацаа зогсоно гэдэг нь хэргийг хэрэгсэхгүй болгоход шаардагдах хугацааг тоолохгүй болохыг хэлж байгаа юм. Тэгэхгүй бол шүүхээс дахин дахин буцаасаар

байгаад хөөн хэлэлцэх хугацааг дуусгаж, ял завшуулах боломж олгох эрсдэл гарна.

Эрүүгийн хуульд нэг хүртэлх жилийн хорих ялтай, эсхүл хорихоос өөр төрлийн ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрвөл, 1-5 жилийн хорих ялтай хэрэг дээрээ таван жил, 5-8 жилийн ялтай хэрэг дээр найман жил, 8-15 жилийн ялтай хэрэг дээрээ 15 жил өнгөрвөл гэх мэтээр хөөн хэлэлцэх хугацаагаа тавих нь чухал юм. Япон болон барууны орнуудад ч ийм л зарчим үйлчилдэг. Учир нь ялын дээд хэмжээнээсээ хөөн хэлэлцэх хугацаа нь бага байж болдоггүй.

Францад гэмт хэргийг манай хуучин хуульд байсан шиг хүнд хөнгөнөөр нь 3 ангилан хөөн хэлэлцэх хугацаа хамгийн хөнгөнд нь 1 жил байсныг 1 жил хэвээр нь үлдээж, дунд зэрэгт нь 3 жил байсныг 6 жил болгож, хамгийн хүндэд нь 10 жил байсныг 20 жил болгож нэг нугалан сунгасан байдаг. Насанд хүрээгүй хүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн бол 10 жилээс доошгүй, насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн гэмт хэрэгт 20 жилээс доошгүй, мансууруулах бодис болон алан хядах ажиллагаа, дайны гэмт хэрэгт 10 жил байсныг 30 жилээс доошгүй болгож, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хугацаа хөөн хэлэлцэхгүй байхаар тогтоосон⁵ байдаг.

ХБНГУ-д гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийн төрлөөс хамаарч өөр өөр байдаг

бөгөөд хамгийн дээд хөөн хэлэлцэх хугацаа нь хүний амь насыг хөнөөсөн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 30 жил байдаг. Хүн амины хүндрүүлэх хэрэг, геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, түрэмгийллийн гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацаа байхгүй. 1969 онд хүн амины хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 20 жилээс 30 жил болгон сунгасан. Нацист гэмт хэрэгтнүүдийг эрүүгийн хариуцлагаас зайлсхийхээс нь сэргийлж 1979 онд хөөн хэлэлцэх хугацаагүй байх зохицуулалтыг хуульчилсан. 10 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулах хэрэг дээр бүх насаар нь хорих ялаар шийтгүүлэхгүй гэмт хэрэг үйлдсэн бол 20 жил, 5 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 10 жил, 1 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 5 жил байх бөгөөд бусад бүх гэмт хэрэгт 3 жил⁶ гэсэн хугацаатайгаар хөөн хэлэлцэх хугацааг авч үздэг.

Канад улс эрүүгийн хэргийн хөөн хэлэлцэх хугацааны доод хязгаар 12 сар байдаг. Томоохон хулгай, аллага, хүн хулгайлах, бэлгийн хүчирхийлэл зэрэг ноцтой гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа яригддаггүй. Ялангуяа бэлгийн хүчирхийллийн хэргүүдэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хүчирхийлэл үйлдсэнээс хойш хэдэн жилийн ч дараа хэргийг нь шийдэх тохиолдол гардаг⁷.

⁵ Монгол Улсын Дээд Шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоол. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар. 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр. Дугаар 11.

⁶ "German criminal code". www.gesetze-im-internet.de. Retrieved 3 August 2018.

⁷ "Criminal Procedure". The Canadian Encyclopedia. Retrieved 1 September 2019.

АНУ-ын Мужуудын гэмт хэргийн дийлэнх нь нийт таван жилийн хөөн хэлэлцэх хугацаатайгаар хуулиар зохицуулагддаг ч Конгресс тодорхой төрлийн гэмт хэргийн хувьд илүү урт хугацааг сонгодог. Тухайлбал урлагийн бүтээл хулгайлсан гэмт хэрэгт 20 жил, галдан шатаасан бол 10 жил, санхүүгийн эсрэг зарим гэмт хэрэгт 20 жил зэрэг ялгамжтай хугацаа яригддаг бол хүчирхийллийн гэмт хэрэг, террорист гэмт хэрэгт 22 жилээс дээш хугацаагаар хөөн хэлэлцэх хугацааг авч үздэг байна.

Франц улсын хувьд Ромын хуулийн эртнээс хөөн хэлэлцэх хугацаатай байсан улс юм. Францын хувьсгалын дараа 1791 оны Францын Үндсэн хуулиар хөөн хэлэлцэх хугацаа тогтоосон⁸ Францад геноцид гэх мэт хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа байдаггүй. Хүнд гэмт хэрэгт 10 ба түүнээс дээш жил, хөнгөн хэрэгт 1 жил ба түүнээс дээш хугацаагаар хөөн хэлэлцэх асуудлыг авч үздэг⁹ байна.

Япон улсад Эрүүгийн хэрэг хянан шийтгэх тухай хуулийн 254 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хэргийн оролцогчийн аль нэгийг нь яллах дүгнэлт үйлдүүлэх замаар хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх үйл ажиллагаа нь бусад хамтран гүйцэтгэгч нараас хамаардаг. Өөрөөр хэлбэл хэн нэгэн хамтран оролцогч этгээдийн

асуудлыг ярихын тулд бусдынх нь хөөн хэлэлцэх хугацааг зогсоодог. Хэрэгт холбогдсон хамтран оролцогч нэг этгээд нь шүүхээр хэргээ эцэслэх хүртэл бусад хамсаатны хөөн хэлэлцэх хугацаа зогсоно¹⁰. Японы Эрүүгийн хэрэг хянан шийтгэх тухай хуулийн 255 дугаар зүйлд гэмт хэрэгтэн гадаадад гарсан, гадаад улсад нуугдаж байгаа бол яллах дүгнэлт үйлдэх болоод яллах дүгнэлт үйлдэх боломжгүй бол энэ хугацаанд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлнэ гэж заасан байдаг.

Өөрөөр хэлбэл дээрх заалт нь гадаадад гарч зугтаж байгаа л бол хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх явдал юм. Үүний нэг жишээ бол Япон улсын Йодо группын Такахиро Кониши, Кимихиро Уомото, Мориаки Вакабаяши, Широ Акаги нарын хэрэг юм. 2009 оны 10-р сарын 20-ны өдөр Японы Дээд шүүх үл хөдлөх хөрөнгийн зуучлагчаас нийт 33 сая орчим иен залилан мэхэлсэн хэргээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байх үед дээрх этгээдүүд гадаадад 56 удаа аялж, нийт 324 хоног гадаадад байсан нь тогтоогдсон бөгөөд дээрх хугацааг хөөн хэлэлцэх хугацаанд оруулж тооцоогүй байдаг.

Түүнчлэн яллах дүгнэлтийг хүргүүлээгүй тохиолдолд, яллах дүгнэлт үйлдэж ирүүлээгүй тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх эсэх асуудал яригддаг. Хуульд заасан хугацаанд прокурор яллах бодолтой байгаагаар илэрхийлсэн л бол ял хөнгөрүүлэх, нотлох баримтыг сарниулахаас урьдчилан сэргийлж, хөөн хэлэлцэх

¹⁰ 刑事訴訟法第254条2項。(Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 254 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг).

⁸ 松尾浩也監修 松本時夫・土本武司編、『条解 刑事訴訟法 第3版増補版』、弘文堂、2006年 ISBN 4-335-35369-3.

⁹ 安富潔『刑事訴訟法講義』初版 168頁「総合説は実体法説及び訴訟法説のそれぞれ疑問点がいずれも妥当する」『条解 刑事訴訟法』第3版増補版 弘文堂 452、453頁「総合説(実体法説と訴訟法説を併せた説であるがこれに対しては両説

хугацааг түдгэлзүүлснийг хүлээн зөвшөөрсөн тохиолдол бий¹¹. Тиймээс 1995 онд Гунма мужийн Такасаки хотын эрүүл мэндийн хүнсний борлуулалтын компанийн ерөнхийлөгчийн татвараас зайлсхийсэн хэрэгт түүнийг хаана байгааг нь тогтоохгүйгээр хэрэг үүсгэж байсан. 1999 оны 3-р сараас эхлэн яллах дүгнэлт үйлдээгүй, шүүхээс яллах бүрэлдэхүүнийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргахад өмнөх ерөнхийлөгчийг цагдан хорих хүртэл нийт 42 удаа яллах дүгнэлт үйлдэж прокурорын тогтоолыг 5 жил зогсоож 2007 оны 3-р сард шийдсэн тохиолдлууд байдаг¹². Мөн Кагава мужийн Такамацу хотод тусгай асрамжийн газар барихтай холбоотой авлигын хэргээр баривчлагдсан хотын зөвлөлийн дарга асан Казүто Миямотогоос 2005 онд Кагава мужийн цагдаагийн газраас нөхцөл байдлын талаар ярилцлага авсны дараа үргэлжлүүлэн зугтсан тул Такамацу дүүргийн прокурорын газар хөөн хэлэлцэх хугацааг дуусгахаас урьдчилан сэргийлэхийн тулд хоёр удаа хээл хахуулийн хэрэг үүсгэсэн байдаг.

3. Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой үүсэж буй асуудлыг даван гарах үндэслэл

Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх бодлого барьж буй л бол хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульд тусгайлан зааж өгөх боломжтой. Тухайлбал, Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөд татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг онцгойлон таван жил байна гэж заасан.

Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зүйл, заалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгаагүй бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх боломжгүй юм. Гэтэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах агуулгатай зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгахгүйгээр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай дээрх хуулиар тогтоосон нь хууль зүйн хувьд хэрэглэх боломжгүй байгааг илтгэнэ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн суурь зарчим болсон зүйл, хэсэг, заалттай Монгол Улсын Дээд Шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоол зөрчилдөж байна. Учир нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2 дахь заалтад “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад энэ зүйлийн 1.1-д заасан нөхцөл байдал илэрвэл шүүх эрүүгийн хэрэг хянан

¹¹ 最高裁決定昭和55年5月12日”. 裁判所. 2015年8月22日閲覧。

¹² 脱税で40回起訴 元社長に有罪判決 前橋地裁＝群馬 読売新聞 2007年7月12日

шийдвэрлэх ажиллагааг дуустал нь явуулж, цагаатгах тогтоол гаргана.” гэж заасан байдаг. Өөрөөр хөөн хэлэлцэх хугацааны асуудлыг авч үзэх боломжгүй гэсэн үг.

Хүний эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй байх эрх зүйн хэм хэмжээ юм. Гэвч гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа өөрчлөгдсөнтэй холбогдуулан хөөн хэлэлцэх хугацааны талаарх хүний эрх зүйн байдлыг дордуулсан заалт, тогтоол нь хүний эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийн хэм хэмжээнд хамаарахгүй байхаар заасан нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимд үл нийцнэ. Түүнчлэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээн шалгах тухай шууд заасан агуулга нь Монгол Улсын Дээд Шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоол болох Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар гарсан байгаа нь Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ, Улсын Их Хурлын гишүүн, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй гэсэн Үндсэн хуулийн заалтыг үгүйсгэж байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хэрэг үйлдэх үед нь дотоодын хууль буюу олон улсын эрх зүйгээр эрүүгийн гэмт хэрэгт эс тооцож байсан ямар нэг үйлдэл буюу эс үйлдлээр хэнийг ч

гэмт хэрэгтэн гэж буруутгаж болохгүй түүнчлэн эрүүгийн гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж байснаас илүү хүнд ял шийтгэл оногдуулж болохгүй. Гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш тийм хэргийн ялыг хуулиар хөнгөлсөн бол уг хэрэгтэнд тэрхүү хөнгөлсөн ялыг хэрэглэнэ.” гэж заажээ. Эрүүгийн хууль буюу материаллаг хуулийг дагаж зохицуулагдах учраас хоорондын уялдаа холбоог хангах тухай асуудал чухал бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ.” гэсэн заалт хуулийг буцаан хэрэглэхэд баримтлах үндсэн зарчмын зохицуулалтыг ямар ч үед баримтлан хэрэгжүүлэх ёстойгоос гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлд мөрдөн байцаалтын явцад хөөн хэлэлцэх хугацаа өнгөрвөл хэргийг хэрэгсэхгүй болгоно гэж прокурорын эрх хэмжээг хуульчилсан. Гэтэл шүүхийн шатанд хэрэг хянан шийдвэрлэх явцад хөөн хэлэлцэх хугацаа өнгөрвөл энэ үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох заалт процессын хуульд орхигдсон байна. Өөрөөр хэлбэл шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгох асуудлыг

зохицуулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19-д зөвхөн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан үндэслэлээр хэрэгсэхгүй болгох заалт байдаг. Тиймээс Эрүүгийн тухай хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 -т заасан хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тоолох журам нь харилцан зөрчилтэй мөн процессын тухай хуультай уялдаагүй байгаа тул хууль хоорондын зөрчлийг арилгах, Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг нэг зарчмаар хуульчлах, зарим төрлийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг оногдуулах хугацааг оногдуулах ял шийтгэлийн хэмжээтэй уялдуулж нэмэгдүүлэх хэрэгтэй.

Дүгнэлт

Шүүхээс гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэргүүдийг судалж үзэхэд нэг талаас гэмт хэргийн хугацаа дуусах дөхсөн үед зарим тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа хэргийг шүүхэд шилжүүлэх тохиолдлууд гарсан. Мөн хэргийн оролцогчид шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулдаг, үндэслэлтэй, үндэслэлгүйгээр завж заалдах гомдол гаргадаг ийм байдлаар хугацаа хожих явдал түгээмэл байна. Тухайлбал: нэг жил хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг нэг жилээр тогтоосон. Найман жил хүртэлх хорих ял оногдуулахаар заасан гэмт

хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг таван жилээр тогтоосон байгааг засаж залруулах хэрэгтэй байна. Олон улс орны жишгээс харахад ялын дээд хэмжээнээсээ хөөн хэлэлцэх хугацаа нь бага байж болдоггүй. Шаардлагатай үндэслэлүүдээр хөөн хэлэлцэх хугацааг зогсоох асуудлуудыг ч эргэн харах хэрэгтэй байна. Яллагдагчаар татсан өдрөөр хөөн хэлэлцэх хугацааг зогсооно гэдэг агуулга өөрөө ямар ч хугацаанд хэргийг хөөн хэлэлцэж болно гэсэн зохицуулалт болох эрсдэл байгааг анхаарах хэрэгтэй.

Санал

1. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш эхлэн эрүүгийн хууль үүсгэж яллагдагчаар татах хүртэл тоолох журмыг сэргээх нь үндэслэлгүй юм. Эрүүгийн тухай хуульд заасан гэмт хэргийн төрөлд хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай тогтоох, зарим төрлийн гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх, энэ талаар бусад улсын Эрүүгийн тухай хуульд заасан зохицуулалтуудыг харьцуулан судлах Монгол Улсын өнөөгийн нөхцөлд тохирсон хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг шинэчлэн хуульчлах нь зүйн хэрэг ч өнгөрсөн нөхцөл байдлыг сэргээх байдлаар эрүүгийн эрх зүйн зарчим болон онолыг үгүйсгэх боломжгүй. Тиймээс Монгол Улсын Дээд Шүүхээс гаргасан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар тайлбар нь

- хуульд үл нийцэх тул хэрэглэхгүй байх. Эрүүгийн хөөн хэлэлцэх хугацааны дагуу хэрэгсэхгүй хэргийг сэргээн шалгаж шийдвэрлэсэн түүхэн туршлага, зөвтгөсөн онол байдаггүй
2. Хүний эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй байх нь эрх зүйн хэм хэмжээний хамгийн чухал зарчим буюу хууль ёсны зарчим юм. Гэвч гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа өөрчлөгдсөнтэй холбогдуулан хөөн хэлэлцэх хугацааны талаарх хүний эрх зүйн байдлыг дордуулсан заалт, тогтоол нь хүний эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийн хэм хэмжээнд хамаарахгүй байхаар заасан нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимд үл нийцэхийг анхаарч хэрэгсэхгүй болсон хэргүүдийг дахин сэргээн шалгахгүй байх. Учир нь эрх зүйн байдлыг хүндрүүлэх байдлаар гэмт хэрэгт ял шийтгэдэг жишиг тогтох эрсдэл үүсэх боломжтой
 3. Авлигын гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 22-р бүлэгт хуульчилсан. Албан тушаалтан л үйлдэх боломжтой нийт 20 гэмт хэргийн нэгээс бусад бүх хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа таван жил байхаар заасан байна. 5-15 жилийн хорих ял онохоор Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдвэл 12 жил өнгөрөхөд хөөн хэлэлцэх хугацаа дуусаж хэрэгсэхгүй болгоно. Тэгэхээр дээр хэлсэнчлэн зарим гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцох хуулийн үндэслэл эргэлзээтэй байгааг өөрчилж засах
 4. Эрүүгийн хуульд хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялаас гадна торгох, нийтэд тустай ажил хийлгэх, эрх хасах ял бий. Эрүүгийн хуулийн 18, 20, 22, 24, 25-р бүлэгт заасан хуулийн этгээд субъект болдог гэмт хэргүүд бий. Эдгээр хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцох асуудлыг нэг бүр шийдэх хэрэгтэйгээс гадна хуулийн этгээд хариуцлага хүлээх гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх шинж дээр торгох ялын хэмжээ нь өөр хэдий ч хөөн хэлэлцэх хугацаа нь адил байгааг засах
 5. Эрүүгийн хуульд нэг хүртэлх жилийн хорих ялтай, эсхүл хорихоос өөр төрлийн ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрвөл, 1-5 жилийн хорих ялтай хэрэг дээрээ таван жил, 5-8 жилийн ялтай хэрэг дээр найман жил, 8-15 жилийн ялтай хэрэг дээрээ 15 жил өнгөрвөл гэх мэтээр хөөн хэлэлцэх хугацаагаа тавих нь чухал юм. Япон болон барууны орнуудад ч ийм л зарчим үйлчилдэг. Учир нь ялын дээд хэмжээнээсээ хөөн хэлэлцэх хугацаа нь бага байж болдоггүй.
 6. Японы Эрүүгийн хэрэг хянан шийтгэх тухай хуулийн 255 дугаар зүйлд гэмт хэрэгтэн гадаадад гарсан, гадаад улсад нуугдаж байхад яллах дүгнэлт үйлдэх боломжгүй бол энэ хугацаанд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлнэ гэж заасан байдаг. Энэхүү заалттай ижил төстэй байдлаар хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх үндэслэлүүдийг гаргаж хуульчлах

7. Зорчих эрхийг хязгаарлах болон хорих ялаар зөвхөн хөөн хэлэлцэх хугацааг тоолох биш гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан хөөн хэлэлцэх хугацааг торгох ялын хэмжээгээр ялгамжтай тоолохоор хуульчлах. Учир нь торгох ялын хэмжээ нь бага боловч хөөн хэлэлцэх хугацаа нь бусад хэрэгтэйгээ харьцуулахад өндөр байна
8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлд мөрдөн байцаалтын явцад хөөн хэлэлцэх хугацаа өнгөрвөл хэргийг хэрэгсэхгүй болгоно гэж прокурорын эрх хэмжээг хуульчилсан. Гэтэл шүүхийн шатанд хэрэг хянан шийдвэрлэх явцад хөөн хэлэлцэх хугацаа өнгөрвөл энэ үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох заалт процессын хуульд орхигдсон байгааг нэмж оруулах.

Ном зүй

- I. Хууль, тогтоол
 1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
 2. Эрүүгийн хууль. 2015 он.
 3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он.
 4. Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль. 2020 он.
 5. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тогтоол. 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр. Дугаар 01.
 6. Монгол Улсын Дээд Шүүхийн

нийт шүүгчийн хуралдааны тогтоол. 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр. Дугаар 11.

II. Ном, нэг сэдэвт бүтээл

1. С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган. Монгол Улсын эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж. УБ.2019 он.
2. German criminal code. www.gesetze-im-internet.de. Retrieved 3 August 2018.
3. "Criminal Procedure". The Canadian Encyclopedia. Retrieved 1 September 2019.
4. 松尾浩也監修 松本時夫・土本武司編、『条解 刑事訴訟法 第3版増補版』、弘文堂、2006年 ISBN 4-335-35369-3.
5. 安富潔 『刑事訴訟法講義』初版 168頁 「総合説は実体法説及び訴訟法説のそれぞれ疑問点がいずれも妥当する」『条解 刑事訴訟法』第3版増補版 弘文堂 452, 453頁 「競合説（実体法説と訴訟法説を併せた説であるがこれに対しては両説
6. 刑事訴訟法第254条2項。(Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 254 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг).
7. 最高裁決定昭和55年5月12日". 裁判所. 2015年8月22日閲覧。
8. 脱税で43回起訴 元社長に有罪判決 前橋地裁＝群馬 読売新聞 2007年7月12日

ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ ЗЭРЭГЛЭЛИЙН ТАЛААР ЭРТНИЙ ХУУЛЬ ЦААЗЫН СУРВАЛЖ БИЧГҮҮДЭД ТУСГАГДСАН БАЙДАЛ



Шихихутуг их сургуулийн докторант
Т.Сосорбарам

Түлхүүр үг:

албан тушаалын ангилал, түшмэд, зэрэг дэв, хэргэм, хаан, тайж, ван, гүн, хууль цааз.

Оршил

Төрийн албан тушаалын зөв, системтэй ангилал нь төрийн албан дахь хүний нөөцийн удирдлагад чухал ач холбогдолтой хэмээн үзэж энэ чиглэлд дэлхийн улс орны олон судлаач анхаарал хандуулж судалсаар ирсэн байна. Тухайлбал, В.Ф.Виллоуби¹ «Төрийн албан хаагчдын хөдөлмөр эрхлэлтийн ангилал, стандартчилал нь бүх салбарын хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааны тулгуур үндэс суурь болдог» гэж үзсэн бол Их Британийн улс төр судлаач, түүхч Самуэл Эдвард Файнер² “ангилал төгс байх нь ажилд авах үйл явцыг үр дүнтэй болгон, албан хаагчдыг шатлан дэвшүүлэх системийг бий болгож өөр байгууллагад ажиллаж буй албан хаагчдад ч эрх тэгш хандах үндэс суурийг бүрдүүлдэг”

гэж үзсэн байдаг.

Судлаач Милтон М Манделл³ гүйцэтгэх үүрэг, хариуцлагын төстэй байдал, мэргэшсэн байдалд тавигдах шаардлагын ижил шинжээр нь албан тушаалыг бүлэглэснийг ангилал хэмээн тодорхойлж, ангилал бол албан тушаалыг харьцуулах зорилгодоо хүрэхийн тулд бодит байдал практикт тулгуурлан хүлээх үүрэг, хариуцлагын ерөнхий түвшний талаар байгууллагуудын хийсэн хэлэлцээр тохиролцоо юм гэсэн дүгнэлтийг хийсэн байдаг.

“АНУ-ын төрийн албан хаагчдын цалин хөлсний тогтолцоо, түүний үр нөлөө” сэдэвт судалгаанд албан тушаалын ангиллыг эрх зүйн болон холбогдох бичиг баримтад үндэслэн харьцуулалт хийсэн байна.⁴ Судлаачдын хийсэн бүтээлээс үзэхэд төрийн албан тушаалын ангиллын асуудалд анхаарлаа хандуулан тусгайлан судалгаа хийх байдал эрчимжиж буй төлөв байдал ажиглагдаж байна. Тухайлбал, БНХАУ, Их Британи улсын төрийн албан хаагчдын албан тушаалын ангиллын харьцуулсан судалгаанд агуулгын шинжилгээний аргыг ашигласан байна.⁵

Доктор Б.Чимид “Төрийн алба, албан тушаалыг ангилах нь онол, практикийн чухал ач холбогдолтой. Түүний дотор төрийн албыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, албан

³ The Selection of Foremen-Milton M. Mandell, 1947

⁴ Li Yongkang, Sun Weiyang, Bai Yang 2012

⁵ Song Wang, 2016

¹ Willoughby, W.F., 1964, хууд. 220

² Samuel Edward Finer, 1970

хаагчдын харилцан ажиллагааг нарийн тодорхой тогтоох, төрийн байгууллагын бүтэц, орон тоо, албан тушаалын цалин, урамшууллын системийг боловсруулж тогтоох, албан хаагчдын тоог удирдлагын салбараар бүлэглэн төлөвлөх, тэдний хөдөлмөрийн харилцааг зохицуулах зэрэг практик зорилтыг шийдвэрлэхэд тусалдаг” гэжээ.⁶

Аливаа эх бичвэр нь ямагт нийгмийн бүтээгдэхүүн байдаг тул тухайн үеийнхээ нийгмийн хүчин зүйлийн нөлөөний ул мөрийг агуулдаг онцлогтой. Энэ талаар нэрт түүхч Г.Сүхбаатар “Эх түүхийн үнэнийг мэдсэнээр өнгөрсөн үеийн баатарлаг үйл, гайхамшигт бүтээл туурвилаар бахархахын зэрэгцээ ... түүхэн хөгжлийн нэн бартаатай, замнал, сургамжийг танин мэдэх ойлгох болно” гэсний эш болгон миний бие төрийн албаны ангилал, зэрэглэлийн асуудлыг онол, арга зүйн түвшинд харьцуулан судлах зорилгын хүрээнд Монгол Улсад төрийн албаны тогтолцоо, ангилал, зэрэглэлийг хэрхэн төлөвшүүлж, хөгжүүлж ирсэн логик хөгжил, практик туршлагыг танин мэдэх, тухайн цаг үеийн нийгэм, улс төр, нийгэм, соёл, эрх зүй, зан заншилтай уялдуулан системтэйгээр үнэлэх, эх сурвалжийг судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах, харьцуулан судлах зорилт дэвшүүлж, Монголын эртний хууль цаазын эх сурвалжууд болон энэ талаарх эрдэмтэн, судлаачдын судалгааны бүтээлд тулгуурлан судалж үзлээ.

Монголын эртний хууль цаазын эх сурвалжуудыг үндэсний болон

гадаадын эрдэмтэн судлаачид судалгааны эргэлтэд оруулж, судлах болсон нь судалгааны эх сурвалжийг нэмэгдүүлсэн, хялбаршуулсан давуу талтай байсныг энд онцолъё.

Монголын эртний улсуудын хууль цааз дахь төрийн албаны ангилал, зэрэглэл.

Хүннү гүрэн (НТӨ III-НТ I зуун)-ий үед төрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх түшмэлийн албан тушаал, зэрэг цол, эрхлэх ажил, үүрэг, эдлэх эрх ямба авах, хангамж, аж төрөх, амьдрах улс төр, эрх зүй, зохион байгуулалт, аж ахуйн тогтолцоо бүрэлдсэн талаар сурвалж бичгүүдэд тодорхойлж ирснийг эрдэмтэн Г.Сүхбаатар⁷, Н.Сэр-Оджав⁸, Ц.Доржсүрэн⁹ нар судлан тодорхойлсон байх бөгөөд түшмэл, тогтолцооны шатлал хэсгийн цөм нь **24 түмтийн даргын тогтолцоо** байжээ.

Хүннү судлаач М.Мооригийн судалгаагаар албан тушаалын өөрчлөлт нь албан тушаалын агуулга, зэрэг цолын хэмжээ, эрх мэдэл зэрэгтэй холбоогүй, харин **6 эвэртэн** нь Шаньюйн хүү юм уу дүү нар, **10 том эвэртэн** нь хаан угсааны овгийн хүмүүс байх ёстой бөгөөд эдгээр эвэртэн нь “их” гэсэн чимэгтэй бөгөөд бүгд түмэн морьтон цэрэг захирах өндөр албан тушаалд ажиллах эзэмшил газартай байх эрхтэй байжээ.¹⁰

Эдгээрийн дор аж ахуйн хэргийг зохицуулж харьяат иргэдээ захирч, олгосон газар нутгийг эзэмшиж

⁷ Монголчуудын эртний өвөг, УБ., 1980

⁸ Монголын эрхтний түүр. УБ., 1977

⁹ Умард Хүннү, УБ., 1961

¹⁰ И.Дашням, Монгол Улсын төр эрх зүйн түүх (МЭӨ 209-МЭ XIII зууны дунд үе), Тэргүүн боть, 2005, УБ., 51 дэх тал.

⁶ Б.Чимид, 1973, хууд. 253

түмтээ захирах 14 түмтийн дарга ажиллаж байсан бөгөөд энэхүү 14 түмтийн дарга болон түүнээс дооших албан тушаал нь хааны овгийн бус байжээ. Ши Цзигийн нэг дэх талд "24 түмтийн дарга тус бүр мянгат зуут аравтын даргыг томилно" хэмээн бичсэнээс үзвэл аравтын дарга нь зуутын даргадаа, зуутын дарга нь мянгатын даргадаа захирагдан, хариуцлага хүлээх тогтолцоо тогтсон байна.

Энэ нь бүхэлдээ түшмэдийн тогтолцоо буюу түшмэл ёсон бүрэлдэн тогтсон бөгөөд энэ нь угсаа залгамжлах ёсонд үндэслэж байжээ.

Сяньби (НТ 156-235) улсад баруун, зүүн, төв гурван хэсгийг хааны томилсон 12 зонхилогч, 50 гаруй толгойлогч, 200 гаруй овгийн ахлагч хэмээх албан тушаалтан удирдаж байжээ. Эдгээр нь эзэн, ноён, захирагч гэсэн утгатай болж овог аймгийн ёсноос нэгдмэл улсын удирдахуйн ёсонд шилжиж байсан байна. Зонхилогч нь хааны бодлого шийдвэрийг шууд биелүүлэх үүрэг бүхий төрийн дээд албан тушаалтан, захирагч, цэргийн жанжин байсан бөгөөд хаанд зөвлөх, нөлөөлөх өндөр эрх мэдэлтэй байжээ. Сяньби улсад зонхилогч-хэсгийн удирдагч, толгойлогч-аймгийн удирдагч, ахлагч-овгийн удирдагч, бидэчжэнь-бичиг хэргийн түшмэл, үйзэн-хэсгийн түшмэл, ямутан, хорчин-зэвсэг хариуцсан түшмэл буурч, борогчин-хувцас хэрэгсэл хариуцсан түшмэл, замчин-өртөөчин, хэлмэрч зэрэг албан тушаалыг хэрэглэж байсан талаар Г.Сүхбаатар "Сяньби" бүтээлдээ дурджээ."¹¹

¹¹ Г.Сүхбаатар, Сяньби, Уб.,1971

Жужан (Нирун) улс (НТ 330-555)-ын түшмэлийн тогтолцоо нь Их хаан, төрийн сайд, төрийн багш том түшмэд, цэргийн жанжин, дархан, ордны түшмэл, бичгийн түшмэл, хаалгач, түмт, мянгат, туг аравны дарга зэрэг тус тусын эрх, үүрэг бүхий албан тушаалтнуудаас бүрдэж байжээ. Хааны дараах албан тушаал нь төрийн сайд буюу Госян юм. Сылифа цолтой төрийн сайд нь улсын баруун Зүүн хэсгийг захиран хаан угсааны адил үе залгамжлан ажиллаж байжээ. Мөн Амгай хааны үед ордны түшмэл, хаалгач, бичгийн түшмэл, хэрэг, зарга эрхлүүлэх түшмэл, туслах түшмэл зэрэг албан тушаал бий болгож түшмэлийн тогтолцоог улам бэхжүүлж байжээ.

Энэ үед түшмэдэд "Баатар", "Цэцэн", "Мэргэн" зэрэг цол олгож, ард иргэд, адуу мал соёрхох зэргээр "зэрэг олгох", "цол өргөмжлөх", "өрх соёрхох" зэрэг ёсон үүсэж бэхэжсэн байна. Тухайлбал, Жужаны хаан Чуну төрийн багш Дарматрия ламд гурван зуун өрх буюу нэгэн түм таван мянга орчим иргэнийг соёрхож байжээ.

Хятан гүрэн (917-1125)-ий үед төрийн удирдлагын өөрийн өвөрмөц зохион байгуулалт, тэнд ажиллах түшмэдийн харьцангуй нарийн тогтолцоо, ёс горим бүрэлдэн бий болсон байна. Хааны шууд захиргаанд Илижин, Юйвэй, Тамажуй, Сали зэрэг захиргааны том түшмэлийн тушаалууд гарч ирсэн. Бүгд эрдмийн хэрэг эрхэлсэн "Линя" хэмээх эрдэмтэн түшмэл, улсын тэнгэрийн улирлыг үзэгч мэргэшсэн түшмэлтэй байжээ. Ялангуяа соёл,

урлагийн чиглэлээр яам, хүрээлэн, газар зэргийг байгуулан ажиллуулж эхлэхийн зэрэгцээ аймгийн захиргааг их, бага, хараат аймгийн захиргаа гэсэн шаталсан тогтолцоо бий болгож, зайсан, тайш, сыту зэрэг албан тушаалыг бий болгож байжээ.¹²

XII-XIII зууны үе дэх Монголын хууль цааз дахь төрийн албаны ангилал, зэрэглэл.

Хамаг Монгол Улс (1130-1206)-ын төрийн зохион байгуулалт, түүний бүтэц, албан тушаал эрхлэгч түшмэдийн талаар доктор Гонгор XI-XVII зууны үеийн Монголын нийгмийн байгуулалт Монгол орны дотоод хөгжлийн үйл явцыг судлан туурвисан "Халх товчоон" зохиолдоо тодорхой өгүүлсэн байна. Мөн Монголын нууц товчоонд тэмдэглэснээр ордны дотоод ёс горим, эгэл хөдөөх байдалтай боловч улам бүр нарийсаж, черби, хорчи, засуулч, тамгач, бичээч, буурч, агач, хоньч, тэргэч зэрэг цэрэг захиргаа, аж ахуйн үүрэг бүхий албан тушаалтнуудыг ажиллуулж байжээ.

Монголын Нэгдсэн Улс (1162-1227)-ын үед Монгол угсааны нэгдсэн улс тогтож, төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт бүрэлдэн бий болохын зэрэгцээ түшмэдийн тогтолцоо бүрдэж, төрд алба хаших төрийн түшмэлийн албан тушаал, цол зэрэг, эрх үүрэг, ажиллах ёс горим нарийн дэгтэйгээр үүсэн төлөвшсөн байна. Монголын нэгдсэн улсын төрийн түшмэдийн тушаал, цол зэрэг эрх мэдэл, эрэмбэ дарааллын

¹² И.Дашням, Монгол Улсын төр эрх зүйн түүх (МЭӨ 209-МЭ XIII зууны дунд үе). Тэргүүн боть, 2005, ᠕6

тухай доктор Ш.Нацагдорж бусад эрдэмтдээс илүү тодорхой судалсан бөгөөд тэрээр төрийн дээд эрхийг Чингис хаан барьж, түүний дараа Ерөнхий сайд буюу Улсын ван, төрийн заргач, шадар сайдууд, төрийн зайран төрийг байгуулахад хүчин зүтгэж, гавьяа байгуулсан шадар есөн өрлөг дархадууд ордог байв хэмээн тэмдэглэжээ.¹³

Нэгдсэн улсын түшмэдийн тогтолцооны хамгийн дээд хэсэгт улсын ван түмнийг захирагчид, төрийн сайдууд багтаж байжээ. Чингис хаан төрийн байгууллагын тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээнийхээ эхэнд Мухулайд улс гүрний "Го ван" цол өгч, зүүн түмний захирагч, мянганы ноён, цэргийн жанжнаар томилжээ. Тэрээр бас "Сэцэн" хэмээх цолтой байсан бөгөөд Мухулай бол Чингис хааны хамтран зүтгэгч, төрийн түшээ, билгүүн их зөвлөгч, эр зориг, туршлага төгс цэргийн жанжин төрийн бодлогын баримтлал, тактик, боловсруулагч ухаан саруул холч бодлоготон бөгөөд үүнийхээ хувьд Чингисийн төрийн амьдралд хамгийн их нэр нөлөө бүхий, улсын хэмжээний хоёр дахь өндөр албан тушаалтан байжээ.

Мөн төрийн зүтгэлтэн, албан тушаалтнуудын дунд Наху Баяны хүү Боорчи хүндтэй байрыг эзэлж байсан байна. Чингис хаан төрийн их сайд, улсын заргач Шихихутаг гэж "Хэлсэн үгийг минь гадагш үл өгүүлэгч битүү лонх, мэсийг минь хурцатгагч чулуун билүү, бууц нутгийг минь засагч" хэмээн тодорхойлсон нь төрийн

¹³ И.Дашням, Монгол Улсын төр эрх зүйн түүх (МЭӨ 209-МЭ XIII зууны дунд үе). Тэргүүн боть, 2005, ᠕6., 289 дэх тал.

түшмэлийн албан тушаалд тохирох шинж бүрдмэл байсныг харуулж байна.

Мөн “Төрийн Бэхи” хэмээх тушаалд Үсүн өвгөнийг томилж байжээ. Төрийн Бэхи нь одод Тэнгэрийг шинжиж он жил, сар, өдрийг тодорхойлон цаг улирлын тооны бичиг зохиож, наран, саран хиртэхийг урьдан мэдэж, хаанд айлтгах үүрэгтэй байжээ. Бэхи өргөмжлөх заншил нь ахмад үеийн хүнээ хүндэтгэх ёсноос үүсэлтэй бөгөөд бэхи өргөмжлөгдөөд цагаан дээл өмсөж, цагаан морь унаж дээд сууринд сууж, он, сарыг олж сонгож байсугай хэмээн зарлиг буулгаж байсан талаар тэмдэглэгдсэн байна.

Есөн өрлөг нь хаант төрийн түшмэдийн дотор өндөр дээд зиндаа үүсгэж, төрийн хамгийн гол тушаалын албыг хашин, түүнийгээ гүйцэтгэхэд шаардагдах эрх мэдэл эдэлж, өмч хөрөнгө эзэмшиж, иргэд харьяатыг захирч байсан ажээ. Монголын Нэгдсэн Улсыг байгуулмагцаа Чингис хаан төрийн зүтгэлтэн, төрийн түшмэдийн тогтолцооны ноён нуруу, үндсэн бүрэлдэхүүн болсон Наян найман гавьяатныг шалгаруулан тогтоож, зарлиг баталж байсан түүхтэй.

Энэ талаар Монголын нууц товчооны 234-т “Бас зарлиг болруун: “Шигихутугийн зарга шийтгэхэд хэвтүүлээс сонсолцох оролцтугай. Хэвтүүлээс нум, саадаг, хуяг, зэвийг хадгалах, түгээх ажлыг эрхлэлцтүгэй. Агт морьдыг авчирч ачаа юмыг ачиж явтугай” гэв. “Хэвтүүл, чэрби нарын хамт эд уурсыг түгээж байгтун. Хорчин, торгууд нар нутаг заагаад нүүхэд Есөнтэй, Бүхэдэй нарын

хорчин, Алчидай, Өэлэн Ахудай нарын торгуудууд, ордны баруун этгээдэд явтугай” гэв. “Буха, Дода чэрби, Чанай нарын торгууд, ордны зүүн этгээдэд явтугай” гэв. “Хэвтүүл, орд гэр, тэргийг хамгаалж ордын дэргэд, зүүн этгээдэд явтугай” гэв. “Бүх хишигтэн, торгууд ба ордын орчим явах, орд гэрийн хөвүүд адуучин, хоньчин, тэмээчин үхэрчнийг ордны дараа ард явах Додай чэрби захиртугай” гэж тушаав.” гэснээс харахад Монголын нэгдсэн улсыг байгуулсны дараа ч “Черби”-г уламжлуулан үлдээжээ.

Түүнчлэн хаант улсын төрийн түшмэлийн ёсонд дархлал олгон хүндэтгэж, төрд хүчийг нь авах ёсон өвөрмөц байрыг эзэлж байжээ. Нууц товчоонд тэмдэглэсэн баримтаас үзэхэд Чингис хаан Сорхон шар, Хорчи нарын түшмэлүүдэд дархан эрх олгож, уугуул овог аймгаа хураан цуглуулж захирах, газар нутгаа ургийн урагт хүртэл эзэмшиж, дайн ба ангийн олзоо хувьдаа ашиглах дархан эрхийг олгож байжээ. Төрийн түшмэдийн хүрээнд түмт, мянгат, зуут аравтын ноёд чухал байр эзэлж байж. Тэд тооны хувьд төрийн Түшмэдийн дийлэнх хувийг бүрдүүлж байжээ. Хамгийн бага хэмжээнд авч үзвэл 15300 гаруй хүн Түмт, мянгат, зуут аравтын ноёноор ажиллаж байжээ.

Түшмэдийн тогтолцоонд Засаг захиргааны нэгжийг удирдах, ноёдыг томилох, захирах, захирагдах, дэвшүүлэх, огцруулах ёс горим тогтон үйлчилж байжээ.¹⁴ Мөн Чингис хаан “Илдэч” хэмээх цэргийн

¹⁴ И.Дашням, Монгол Улсын төр эрх зүйн түүх (МЭӨ 209-МЭ XIII зууны дунд үе). Тэргүүн боть, 2005.Уб., 300 дахь тал.

хэргийн бодлогын газрыг байгуулж, хэвтүүл, хорчин, торгууд зэрэг хишигтэн цэргүүдийг бий болгон, тэдгээрийг шилж сонгогдсон, сайн бэлтгэгдсэн, хатуу сахилга бүхий онцгой маягийн шадар цэрэг байхаар ажиллуулж байсан талаар Доктор Гонгор судалгаандаа дурджээ. Энд дурдсан хааны хишигтэн цэрэг нь ёс журмыг чанд сахидаг, төрийн нууцыг хамгаалж чаддаг, сайн бэлтгэл сургуультай хүмүүс байжээ. Тэд тусгай халамжид байж, зөвхөн хаанд захирагдана өөр хэн ч зэмлэл шийтгэл хүлээлгэх эрхгүй байв. Энэ нь орчин цагийн төрийн тусгай албаны үндэс гэж үзэх талтай.

13-19 дугаар зуун хүртэлх үеийн Монгол улсын хууль цааз дахь төрийн албаны ангилал, зэрэглэл.

Монголын хууль цаазын эх сурвалжууд түүх, хэл, утга зохиолын эх сурвалжаар уламжлан ирсний дээр заримынх нь зөвхөн нэр л түүхэнд үлджээ. Тэдгээрийг гадаад, дотоодын судлаачид судалж бүтээл туурвиж, мөн заримыг нь огт судлагдаагүй байна. Энэ үеийн Монгол хууль цаазын үнэт эх сурвалжид Арван буянт номын цагаан түүх¹⁵, Юан улсын цаазын бичиг (1320), Алтан хааны цааз (1507-1582), Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн арван найман хууль, Ойрад Монголын цааз (1640-1761), Халх журам (1709-1790), Монгол цаазын бичиг (1789) зэрэг эх сурвалжуудыг голлон судалсан байна. Тухайлбал,

Хутагтай Сэцэн Хун Тайжийн зохиосон Арван буянт номын цагаан

¹⁵ С.Жалан-Аажав 1998 онд "Арван буянт номын Цагаан түүх (Төр засах хөтөлбөр

түүх хэмээх цаад шар болон харын талын эрх ямбатан, хэргэм зэрэгтний цол зэрэг нь хоорондоо хэрхэн дүйцэх талаар тогтоосон байна. Тухайлбал Цорж нарын ямба нь хунтайж лугаа адил хэмээн тогтоож ирсэн байна.

Усан туулай жилийн өчүүхэн цааз буюу 1613 оны цаазад "Ямутан гүүш, хонжин, сэнжин, ширээт өрлөг, хөхөлтэн, хиа нар, хатдын эцэг, дүү, ах, тугч, бүрээч дарга дархад тэдний эмс эрийн ямутай адил болов оо."¹⁶ Хэмээн заасан нь дээр дурдсан албан тушаалууд төдийгүй тэдний эхнэр тусгайлсан ямба эдлэхээр тогтоож байсныг харуулж байна.

Дээрх цаазад "долоон хошууны засаг барьсан түшмэдэд занги, гүүш жанжин, хүр зайсан, өрлөг, тайжийн чанмай товчиту, тайш, унагай заягачи тугухи, эшэн сартай, Хонжмэ хүлчингүй, байгажуни саарал, заяга чи бошинтаг заягачи, шигэчир, шинуга, шүлэнги, цөгүжэгэр мүндүю, исэл зэрэг хүнийг ямутан хүн занчваас засгийн тулд бол ялгүй. Шоглож занчиваас нэг ес ав," хэмээн зааснаас харахад түшмэдүүдийн эрхэлж буй ажлын онцлогоос хамаарч өөр өөрөөр нэрлэхийн зэрэгцээ чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө гарсан алдаа эндэгдлээс чөлөөлөхөөр заасан нь бүрэн эрхийн баталгааны үндэс ажээ.

1700-гаад оны сүүлчээс 1800-гаад оны үеийн эрх зүйн эх сурвалж болсон "Ардын зарга"-аас сурвалжлан үзвэл тухайн үед эзний буюу төрийн алба нь засаг, чуулганы дарга, хэвэй, хошууны түшмэл,

¹⁶ Т.Алтангэрэл, 16-17 дугаар зууны Монгол цаазын бичгүүд, Уб.,1999, 67 дахь тал

занги, эмч, хиа хөтөл, түшмэд туслах түшмэл, хошууны хөөгч, тайж, лам, ард гэсэн давхраажилттай байсан бөгөөд ардууд нь хамжлага ба хамжлага бус гэсэн төрөлтэй байжээ.

Хууль цаазын нэр томъёо тодорхой ухагдахуунуудын талаар сурвалжлан судлах явцад "жинс хадаж, хамжаа авах" хэмээх ухагдахууныг хэрэглэж байсан талаар тэмдэглэсэн нь Сэцэн ханд илгээсэн засаг Дашдэндэвийн хошууны Дансүрэн нарын өргөдөлд эрхтэн дархтан "цол зэрэг" авахын хэмжээгээр "хамжаа авах" эрх ямба эдлэх нөхцөл бүрдэж байсныг харуулж байна.¹⁷

Профессор Н.Лүндэндорж "Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага" бүтээлдээ "XVIII-XVIII зууны үеийн монголчуудын хууль цаазын сэтгэлгээний бодит илрэлийг 1709 оны "Гурван хошууны их цааз" буюу "Халх журам"-ын үзэл санаа, зохицуулалтын арга хэлбэрээс олж харж болох юм. 1640 оны "Монгол-Ойрадын цаазын" гол зорилго агуулга-овог аймгуудын хоорондын зөрчлийг шийдвэрлэхэд гол зохицуулалт нь хандсан байдаг бол "Халх журам" (1691-1728) монголын дотоод амьдралын харилцааг түгээмлээр зохицуулахад чиглэж, өмнө хуулиар бүрэн зохицуулагдаагүй олон харилцаанууд зохицуулалтад оржээ"[4] гэж дүгнэснийг эш болгон дээрх эх сурвалжуудыг судлан үзвэл энэ үед засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг хуулиараа

баталгаажуулан, зохицуулах болсон, төрийн захиргааны орон нутгийн суурин байгууллагын үндсийг тавьсан, төрийн алба, түшмэлийн зэрэг дэвийг хуулиар тогтоосон нь тодорхой харагдана.Тухайлбал,

Алтан ханы цаазад "... Дээд тэнгэр бурхны заяагаар төрсөн, тэнгэрлэг төрөлт, төгс эрдэм билгийн залгамж болсон алтан ураг хаан ахай, засаг барьсан Хатан баатар ноён, засаг барьсан дархан Түшээт ноён, Дайчин баатар ноён, Хөндлөн цүүхэр ноён, ... Хоёр чуулганы далайн дунд Хоосон чанарын номын биеэс Хотол агсан бэлэг үлгэрээр цогтойёо чимсэн ... баатар төмөр луу хэмээх жилийн намрын дундад сарын таван шинэд сайн өдөрт, Эрдэнэ засагт хаан, эхлэн Түшээт хаан, Убаши далай ноён, ...", "Тэнгэрийн тэтгэсний арван нэгдүгээр он зуны сүүл сарын хорин есөнд жасааны газраас илгээсэн нь, Тэнгэрийн тэтгэсний арван нэгдүгээр он (1746) зуны дунд сарын арванд: Засагт хан, Сэцэн хан, Дайчин ван Дэчинжав, Чин ван Ринчэндож, Туслагч жанжин Шигээ, туслагч жанжин жүн ван, туслагч жанжин бэйл, туслагч жанжин гүнтэн эхлэн хүрээний газраа чуулган нийлэхүйд тогтоосон нь.." гэх мэтээр тэр үеийн цааз баталсан, чуулганд оролцсон түшмэдүүдийн нэр, хэргэм зэргийг нэг бүрчлэн бичиж үлдээсэн байна. Энэ нь төрийн байгуулалд ноёдын чуулганд цааз тогтоох эрх мэдэл шилжсэн нь хэмжээгүй эрхт хаант төрийн удирдлагад түүний нөлөө хүчтэй байсныг харуулж байна.

Судлаач А.В.Рязановский "Монголчуудын хууль цаазын

¹⁷ Ц. Насанбалжир, Ш.Нацагдорж /эмхэтгэн боловсруулсан/, Ардын заргын бичиг: XVIII-XX зууны эхэн 1966

дурсгал бичгүүдийн түүхэн тойм” бүтээлдээ¹⁸ Монгол цаазыг бичигт нэр төр, хэргэм зэрэг, эрх ямбын тухай 24 зүйл байгаа хэмээн тэмдэглэсний дагуу сурвалжлан үзвэл:

Хэргэм зэрэг олгох, түүнийг залгамжлуулах эрхийг бүр монголчуудын уламжлалт төрийн хэргэм зэргийг эвдэх үүднээс зохион байгуулалттайгаар хуулиараа зохицуулж өгчээ. 1627 оны үеийн Монгол цаазын бичигт “Халхын тайж нар дөрвөн зуун өрхөөс дээш авч орж ирвэл тэргүүлсэн нэг тайжийг тэргүүн зэргийн тайж, гурван зуун өрхөөс дээш бол тэргүүлсэн нэгэн тайжийг дэд зэргийн тайж хоёр зуун өрхөөс доош зуун өрхөөс дээш бол тэргүүлсэн нэгэн тайжийг гутгаар зэргийн тайж зуун өрх эс хүрвэл дөтгөөр зэргийн тайж болгож, эрх ямба эдлүүлнэ гээд заасан байхад 1764 оны энэхүү сурвалж бичигт Манжийн их хааны хишиг хүртээж олгосон зэргийг залгамжлуулахтай холбогдсон харилцааг Тайзун тулгар төр нээсэн цагт, аливаа урьд өөр өөрийн харьяат албат нарыг авч чин үнэнээр орж ирээд, газар газрын цэргийн дайнд маш ихэд зүтгэсний тул тийнхүү гавьяа зүтгэлийг илэрхийлж, ялган салгаж ван, гүн, засаг өргөмжлөөд цөм үе улиран тасралтгүй залгамжлуулна гэжээ.

Төрийн ноён нуруу төрийн түшмэлийн үйл ажиллагаатай шууд холбоотой байсан бөгөөд тэдгээр нь эзэн хааны албан хаагч, журганы албан хаагч гэсэн тогтолцоотой

¹⁸ А.В.Рязановский “Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм, Уб.,200, 29 дэх тал.

байсан байна. Журганы албан хаагчид нь засаг захиргааны нэгжийн албан хаагч (аймгийн хан, чуулганы дарга, засаг ноён буюу засгийн тайж, хошууны туслагч, хошуу занги, мэйрэн, залан, сумын занги, орлон хөөгч, бага хөөгч, арван гэрийн дарга, түшмэл, бичээч, галч г.м.), шүүхийн буюу заргын газрын албан хаагч (заргач, хошуу ноён, чуулганы дарга г.м), зах хязгаар, харуул, сэргийлэн хамгаалах, цэргийн албан хаагч (залан, занги) гэсэн тогтолцоотой ажиллаж, цалин пүнлүү авч байжээ.¹⁹

Түүнчлэн Монгол цаазын тэргүүн дэвтрийн 1-24 дүгээр зүйлд Түшмэлийн зэргийг олгох, угсаа залгамжлуулах, жинс дэвсгэр олгох, хишиг хүртээх, цол, зэргийг үл дуудах, отго шагнах, хадуулах зэрэг журмыг тогтоосныг сурвалжлан үзвэл:

- Түшмэлийн зэргийг тэргүүн, дэд, гутгаар, дөтгөөр зэрэг гэсэн ялгамжтай байдлаар олгож байсан
- Түшмэлийг угсаа залгамжлуулахын зэрэгцээ тодорхой шаардлага хангасан хүнийг (алба хааж чадах, малтай, харц хүнийг) тохоон томилдог байсан
- Түшмэл худал мэдүүлбээс тушаал буулгаж, пүнлүүг хасаж байсан зэрэг нь орчин цагийн төрийн албаны харилцааны агуулгыг тодорхойлох үндэс бүрдэж байсныг харуулж байна.

Төр захиргааны эрх зүйн асуудал Халх Монголын хошууг захирагч занги болон бусад албан тушаалтан цалин пүнлүү, хувцас хэрэглэлийг

¹⁹ Б.Баярсайхан, Монгол цаазын бичиг, харьцуулсан судалгаа, 2001

дотоод Монголын хошууг захирагч занги болон бусад албан тушаалтнаас нэгэн зэрэг доогуур авч, эдэлж хэрэглэдэг байжээ.

Халхын Улиастайн жанжны Манжийн Найралт төв хааны үед байгуулж, Баруун Монголыг тохинуулан хамгаалах эрхтэйгээр анх тогтоожээ. Энэхүү байгууллагыг байгуулсны дагуу Манжаас Их жанжин, туслагч жанжны” албан тушаал бий болгосон юм. Мөн Манжийн Тэнгэр тэтгэгчийн хорин долоодугаар он (1762)-д Нийслэл хүрээнд амбан сайд томилж Хиагт зэрэг газар орны худалдаа арилжаа, Богд Жавзандамба хутагтын шавь нарыг харьяалан захирах болон бусад орон газарт хамаарах асуудлыг шийдвэрлэж байх болсонтой холбоотойгоор Амбан сайд” зэрэг албан тушаал гарч иржээ.

Монгол ноёдын зэрэг дэвийн тогтолцоог Монгол Улс (1911-1919) өөрийн онцлогтойгоор уламжлан хэрэглэхдээ төрийн тусгаар тогтнол, ёслол хүндэтгэлийн бэлгэдэл, төрийн ноёны нэр төр, эрх мэдэл, үүрэг хариуцлагын хэмжүүр болгож байжээ.²⁰

Монголчууд 1911 оны 12 сарын 29-д тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, VIII Богд Жавзандамба хутагтыг “Монгол Улсын эзэн шашин төрийг хослон баригч наран гэрэлт түмэн наст хаан”-аар өргөмжлөх үеэр Богд хаан төр улсаа сэргээсэн ноёд, түшмэдийн гавьяаг үнэлж, “*Хишиг тархаах зарлиг*” буулгаж цол, хэргэм, зэрэг шагнажээ.²¹ Ингэж

төрд гавьяа байгуулагсдыг цол зэргээр шагнадаг монгол төр ёсны уламжлал Монголын төрийн мэдэлд шилжсэн байна.

Тус зарлигаар тусгаар тогтносон Монгол Улсын хаанаас ноёдын зэрэг дэвийн талаар баримтлах анхны эрхзүйн шинжтэй баримт байсан гэж үзэхээр байна. Уг зарлигаар ноёдын зүтгэлийг “онц хүчин зүтгэсэн”, “үнэн санаагаар чармайн зүтгэсэн”, “хүчин хавсран зүтгэсэн” хэмээн дэсэлж, 90 ноёнд цол, 17 ноёнд хэргэм, 82 ноёнд хэргэмийн зэрэг шагнаж, давхардсан тоогоор 122 ноёнд “цол, хэргэм, хэргэмийн зэрэг” соёрхжээ.²²

Чухам энэ үеэс ноёдын зэрэг дэвийг илтгэх цол, хэргэм, зэрэг нь тус тусын үүрэг, ач холбогдол бүхий бие даасан төрийн шагнал болж, төр улсын хэрэгт чинхүү зүтгэж, дэмжсэн хүмүүс дангаар нь болон давхар хүртэж болдог болжээ.

Монгол Улсын төр ноёдод цол өргөмжилдөг ёсыг уламжлан “Хишиг тархаах зарлиг”-аар 33 нэр бүхий цолоор 90 хүнийг шагнаснаас 58 ноёнд үе улиран тасралгүй залгамжлуулахаар, 32 ноёнд нэгэн биеэр эдлэхээр зарлигджээ. Энэ нь цолыг үе улиран залгамжлуулах анхны зарлиг юм. Монголын төр ёсны түүхэнд “цол”-ыг үе улирч хэрэглэж байсан боловч зарлигаар үе улиран залгамжилж байсан нь ховор шиг байна.

Харин зарим цолонд шинэ чимэг нэмж, зарим цолыг чимэг хэлбэрээр, заримыг цол хэлбэрээр хэрэглэж байсан бөгөөд цолны нэршил нь

²⁰ Д.Цогзолсүрэн, Монгол төрийн ноёдын цол, хэргэм, зэргийн талаарх бодлого (1911-1919)

²¹ Н.Дугарсүрэн, Г.Жамсранжав. Богдын лүндэн. 2010. Улаанбаатар.

²² Дотоод Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч яамнаас Сангийн Гадаадын Цэргийн Шүүх Таслах яамнаа өргөн Дөрвөн аймгийн жанжин Хүрээний хамба шанзудба нарт тушаан явуулсан бичиг. Монгол Улс. Үндэсний Төв Архив. ХА-3,Д-1,т.83-115

гол төлөв хүмүүний саруул ухаан, цог хийморь, эр зориг, эрдэм чадал, хичээл зүтгэлийг сайн сайхнаар бэлгэдсэн утга бүхий байгаа нь монгол төр ёсонд тухайн хүний гавьяа, авьяас чадвар, сайн сайхан шинж төрхийн илэрхийлэл болгон хэрэглэж байсныг харуулж байна.²³

1912 онд Монгол Улсын бүрэлдэхүүнд Дөрвөдийн хоёр аймаг нэгдэв. Дөрвөдийн Сайн заяат Зүүн гарын Бат Ерөөлт Төгс Хүлэг Далай хан аймагт 1756 оноос “Төгс хүлэг далай хан” хэмээх цолтон бий болж, уг цолыг хамгийн сүүлд Галсаннамжилын ахмад хөвгүүн Түмэндэлгэржав залгамжилжээ. Дөрвөдийн Сайн заяат баруун гарын засаг, хошой чин ван Содномжамцой 1912 онд Монгол Улсад дагаар орсон тул Богд хаанаас түүнийг хан болгож, үе улиран “Үнэн зориг” цол шагнажээ. Ийнхүү Монгол Улс зургаан хан цолтой ноёнттой байжээ.

Тухайн үеийн нэг онцлог бол “ханы ямба” шагнасан явдал юм. Гадаадын Хэргийг Бүгд Захиран Шийтгэх яамны тэргүүн сайд, засаг хошой чин ван Ханддоржид ханы ямбыг 1911, 1914 онуудад шагнасан байдаг. Энэ нь түүнд “ханы ямба” эдлүүлэхээс илүүтэй бусад хануудын адил улс төрийн эрхтэй байхыг баталгаажуулсан хэрэг бололтой байна. “Хан” цол нь “хэргэмийн зэргэмжтэй цол” хэвээр байсан

²³ Богд хаан "... Түшээт хан Дашнямд үе улиран Очирбат сайн цол, Сэцэн хан Навааннэрэнд үе улиран Махасамади далай сэцэн цол, Засагт хан Содномравданд үе улиран Эрдэнэ бишрэлт цол, Сайн ноён хан Намнансүрэнд үе улиран Итгэмжит зөтэй эрх дайчин цол ..." шагнасан нь Халхын дөрвөн аймгийн хануудын аймаг захирах улс төрийн эрхийг сэргээн батламжилсан хэрэг ажээ. Тиймээс тэдний өвөг дээдсийн уламжлан хэрэглэж байсан цолыг зарлигдан шагнасан байна.

юм. Хануудад төрийн хэргэмтний адилаар пүнлүү өгч, зарим ноёдод “ханы ямба”, “ханы зэрэг” шагнаж байснаас ийнхүү үзлээ.

Цолыг нэгэн үед болон үе улиран залгамжлуулахаар зарлигдсан нь цолны нэр хүндийг өсгөх төрийн бодлого байжээ. Мөн Их шавийн 12 том ламд цол шагнасан нь лам нарт төрөөс зарлигаар цол соёрхсон анхны үзэгдэл байх талтай бөгөөд төрд зүтгэгчдийн гавьяаг үнэлэхийн зэрэгцээ зарим ноёдод төрийн хэргийг идэвхийлэн дэмжих итгэл хүлээлгэсэн хэрэг байв. Засаг ноёд бүгд үе улиран залгамжлах цолтой болсон тул хошуудыг засаг ноёных нь “цол, хэргэмийн хавсарсан нэр”-ээр нэрийдэж байв.²⁴ Эндээс үзвэл ерөөс алдаршуулах зорилго бүхий цол нь тухайн ноёноо төдийгүй нутаг хошууг алдаршуулах үүрэг бүхий болжээ.

Монгол Улсын төрөөс “хэргэм”-ийг нэр хүндтэй, эдийн засгийн баталгаа бүхий цол хэвээр нь хэрэглэв. Богд хаан анхны зарлигаараа 17 ноёны хэргэмийг нэмэн соёрхсоноос 1 үе улиран чин ван, 5 жүн ван, 6 хошууны бэйс

²⁴ Тоо дурдвал, Богд хааны анхны зарлигаар шагнагдсан ноёдын 33 цолын 31 нь хошууны цол болж нэрлэгдсэн байна. Хошууны засаг ноёны ихэнх нь хэргэмтэй байсан бөгөөд хэрвээ тэргүүн зэрэг тайж засаг ноён болсон бол “цол, хэргэмийн зэргийн хавсарсан нэр”-ээр нэрлэж байжээ. Монголчууд Манжийн эрхшээлд байхдаа ч засаг ноёныхоо цол хэргэмээр хошуугаа нэрлэж байжээ. 1909 онд Монголоор аялсан Финляндын судлаач Рамстед "... Агсан Ма гүнийх гэж нэг багахан нутаг байна. Ма гүн нь тэр нутгийн ноён байгаад олон жилийн өмнө нас баржээ. Нутгийн ардууд Вээжин рүү удаа дараа захидал, хүсэлт гаргасан ч үе залгамжлах ноёныг тодруулж өгөөгүй аж. Тийм ч учраас Агсан гэж үг нутгийнх нь нэрэнд нэмэгджээ. Энэ нэр, ер нь байгаа байдалдаа нутгийн ард ихэд шаналж, эмзэглэдэг ажээ. Монголд зээн ноёнгүй нутаг, албат байна гэдэг доромжлол гэсэн үг” хэмээн тэмдэглэсэн нь бий.

хэргэм шагнасны 5 ноёнд үе улиран залгамжлуулахаар, 4 ноёнд улсад туслагч гүнгийн хэргэм шагнасны 3 ноёнд үе улиран залгамжлуулжээ. Түшээт хан аймгийн засаг хошууны бэйс Пунцагцэрэнг II Жибзундамба хутагтын, Дархан чин вангийн угсааны ноён хэмээн “чин ван”-гийн хэргэмээр үе улиран шагнасан нь Монголын шашин, төрд удам дамжсан зүтгэлийг илүүтэй эрхэмлэсэн хэрэг. “Төрийн жүн ван” хэргэмээр шагнагдсан 5 ноён бол Халхын Хүрээний Бүх Хэргийг Түр Ерөнхийлөн Шийтгэх газрыг үүсгэн байгуулж, Монгол улсаа сэргээсэн гавьяатай зүтгэлтнүүд байв.

Насан өндөр боловч төрийн үйл хэрэгт зүтгэж буй хэмээн “Түшээт хан аймгийн улсад туслагч гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж Батсуурь, Сэцэн хан аймгийн улсад туслагч гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж Дорж-Юлжилдог нарыг “үе улиран хошууны бэйс”, Сайн ноён аймгийн засаг, тэргүүн зэрэг тайж Чимэдбалжинд “үе улиран улсад туслагч гүн” өргөмжилжээ.

Мөн төрийн түшмэл тухайн хэргэмийг хүртээгүй боловч, хэргэмийн ямбыг эдлүүлэх “Хэргэмийн зэрэг”-ийг олгож байжээ. Хэргэмийн зэрэг нь тухайн хүний гавьяа зүтгэл, эрх ямбаны илэрхийлэл болж, тэдний төрийн үйл хэрэгт жагсаж, суух дэс, хэргэм шагнуулах үндэс болж байсан бөгөөд хэргэмийн зэрэг нь хэргэм бүхий ноёдын хэргэмийн дэс ахих боломж, язгуургүй хүнд бол хэргэм зэрэг бүхий болохын эхлэл болж байжээ. “Монгол улсын шастир”-

аас үзвэл хэргэмгүй дан “хэргэмийн зэрэг” бүхий 16 ноён байв. Язгуур хэргэмгүй ноёдод “хэргэмийн зэрэг” эхэлж шагнаад хойшид гавьяа байгуулах бүрийд ахиулан шагнасаар “хэргэм” бүхий ноёдын адил болж байжээ. Дээрхээс харвал Монгол улсын “Хэргэмийн зэрэг хэмээх шагнал бол тодорхой дүрмээр байгуулсан гавьяаны тулд олгодог, хэргэмгүй ноёдын дэвших үндэс болдог онцлог бүхий шагнал байсан нь тодорхой байна.

Мөн Монгол улсын ноёд түшмэд төрдөө туслан барьж, “нэмсэн, тэмдэглэсэн зэрэг” шагнагдсан баримт олон байна. “Нэмсэн, тэмдэглэсэн зэрэг”-ийг дээр дурдсан “сайшаан хөхиүлэх дүрэм”-ээр олгож байжээ. Туслан барих дүрмийн эхэнд Монгол Улс байгуулаад урьд олгож байсан “нэмсэн, тэмдэглэсэн” зэргийг хасаж хэрэгсэхгүй болгосныг эргэн сэргээн олгох тухай дурджээ. Эндээс нэмсэн, тэмдэглэсэн зэргийг туслан барьсан болон төрийн хэрэгт онц зүтгэсэн зүтгэлийг үнэлэн шагнах болсон нь тодорхой байна. Уг сайшаан хөхиүлэх дүрмийн сайшаан хөхиүлэх заалт хэд хэдэн удаа өөрчлөгдсөн боловч “нэмсэн, тэмдэглэсэн зэрэг” шагнах тухай заалтуудад төдийлөн өөрчлөлт ороогүй юм. 1913 оны дүрэмд аливаа засаг ба засаг бус бэйл, бэйс, гүн, улсад туслагч гүн нарыг нэгэн зүйл заалтаар хөхиүлэхээр журамласныг 1916 оны шинэчилсэн дүрэмд аливаа засаг ба засаг бус улсын түшээ гүн, улсад туслагч гүнг тэргүүн зэрэг тайж, бүгдийн дарга нарын зиндаанд оруулан заасан ба туслан барих мөнгөний тоо нь

өөрчлөгдөөгүй юм. Дүрмээс үзвэл нэг тэмдэглэсэн зэрэг нь 50 лан мөнгөтэй, нэг нэмсэн зэрэг нь 200 лан мөнгөтэй тэнцэж байжээ.

Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг (1913-1918)-ийн Дөрөвдүгээр дэвтэрт “Зэрэг залгамжлах” талаар тодорхойлсон байх бөгөөд “Засаг ба жич сул хан, Чин вангийн хөвгүүнийг тэргүүн зэрэг тайж болго. Жун ван, бэйлийн хөвгүүнийг дэд зэрэг тайж болго. Бэйс гүнгийн хөвгүүнийг гуравдугаар зэрэг тайж болго. Тэргүүн зэрэг, дэд гуравдугаар зэрэг, дөрөвдүгээр зэрэг тайжийн хөвгүүнийг цөм дөрөвдүгээр зэрэг тайж болго. Нийтээр арван найман насанд хүрсний хойно ялган салгаж зэрэг олгуулагтун.” хэмээн зааж, зэргийг үе улиран тасралгүй залгамжлуулах, ялган салгаж залгамжлуулах, гавьяа зүтгэлийг бодож залгамжлуулах, авч тэжээсэн хүнд дуртайг үзэж зэрэг залгамжлуулах, түүнийг гэрчлэх үе улиран тасралгүй залгамжлуулах жуух бичиг тархаан өгөх зэрэг харилцааг журамласан байна.²⁵

Төрийн албан тушаалын ангилал, зэрэглэлийн талаар Монгол Улсын эртний хууль цаазын сурвалж бичгүүд болон судлаачдын бүтээлүүдэд Монгол төрийн түшмэдийн ангилал, цол, хэргэм, зэрэг хэрхэн тусгагдаж ирснийг дүгнэн үзвэл дараах шинжийг агуулж байна:

Нэгдүгээрт: Түшмэлүүдийн ангилал, зэрэг дэв нь төрийн хэргийг тогтсон горим, ёс зүй, дэгтэй

байлгах, ноёдын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, төрийн ёс жаягийг мөрдөх хэм хэмжээ болж, төрийн эрх мэдлийн хэм хэмжээг тогтоох арга болж байжээ.

Хоёрдугаарт: Цол, хэргэм, зэргээр төрд зүтгэсэн хүмүүсийн гавьяаг үнэлж, урамшуулан хөхиулж, алдаршуулж, үр хойчид нь Монгол төрийн төлөө зүтгэх урам зориг, үлгэр дуурайл болгож байсны зэрэгцээ тухайн ноёд, түшмэдийн нэр төр, эрх мэдэл, эдийн засгийн баталгаа болж байжээ.

Гуравдугаарт: Цол, хэргэм, зэрэг залгамжлах ёсыг уламжлан мөрдсөн хэдий ч хэргэм залгамжлах батлан тэмдэглэсэн хөвгүүний төр засах, ардыг ачлах эрдэм ухаан, олныг удирдан чиглүүлэх авьяас, чадварыг онцлох болсон юм. Энэ бүхнийг нэгтгэн дүгнэвэл, ноёд, түшмэдийн зэрэг дэвийн тогтолцоог Монгол Улс өөрийн онцлогтойгоор уламжлан хэрэглэхдээ төрийн тусгаар тогтнол, ёслол хүндэтгэлийн бэлгэдэл, төрийн ноён, түшмэлийн нэр төр, эрх мэдэл, үүрэг хариуцлагын хэмжүүр болгож байжээ.

²⁵ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг, уб..2010

Ашигласан эх сурвалж:

1. Willoughby, W.F., *Principles of Public Administration*, 1964
2. Samuel Edward Finer, *Comparative government*, 1970
3. *The Selection of Foremen-Milton M. Mandell*, 1947
4. Li Yongkang, Sun Weiyan, Bai Yang, *Proceedings of the 2012 International Conference on Public Management (ICPM 2012)*
5. Б.Чимид, БНМАУ-ын Захиргааны эрх зүй, 1973
6. Н.Лүндэндорж, Монголын төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага, 2004
7. Монголчуудын эртний өвөг, УБ., 1980
8. Монголын эрхтний түүр, УБ., 1977
9. Умард Хүннү, УБ., 1961
10. И.Дашням, Монгол Улсын төр эрх зүйн түүх (МЭӨ 209-МЭ XIII зууны дунд үе), Тэргүүн боть, 2005
11. Г.Сүхбаатар, Сяньби, УБ., 1971
12. С.Жалан-Аажав 1998 онд "Арван буянт номын Цагаан түүх (Төр засах хөтөлбөр
13. Т.Алтангэрэл, 16-17 дугаар зууны Монгол цаазын бичгүүд, УБ., 1999
14. Ц.Насанбалжир, Ш.Нацагдорж /эмхэтгэн боловсруулсан/, Ардын заргын бичиг: XVIII-XX зууны эхэн 1966
15. А.В.Рязановский "Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм, УБ., 200,
16. Б.Баярсайхан, Монгол цаазын бичиг, харьцуулсан судалгаа, 2001
17. Д.Цогзолсүрэн, Монгол төрийн ноёдын цол, хэргэм, зэргийн талаарх бодлого (1911-1919)
18. Н.Дугарсүрэн, Г.Жамсранжав. Богдын лүндэн. 2010. Улаанбаатар.
19. Дотоод Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч яамнаас Сангийн Гадаадын Цэргийн Шүүх Таслах яамнаа өргөн Дөрвөн аймгийн жанжин Хүрээний хамба шанзудба нарт тушаан явуулсан бичиг. Монгол Улс. Үндэсний Төв Архив. ХА-3,Д-1,т,83-115
20. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг, УБ., 2010

ХҮНИЙ ҮНДСЭН ЭРХ БА ХҮНИЙ ГЕНЕТИК МЭДЭЭЛЛИЙН ХУУЛЬ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ



Шихихутуг их сургуулийн докторант
Ц.Амарсанаа

ГАРЧИГ ОРШИЛ

1. ҮНДСЭН ЭРХ БА ХҮНИЙ
ГЕНЕТИКИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ
2. ОЛОН УЛС ДАХЬ ХҮНИЙ
УДМЫН САН БУЮУ
ГЕНЕТИКИЙН ХУУЛЬ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ
3. МОНГОЛ УЛС ДАХЬ
ХҮНИЙ УДМЫН САН БУЮУ
ГЕНЕТИКТЭЙ ХОЛБООТОЙ
ХУУЛЬ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

ДҮГНЭЛТ НОМ ЗҮЙ ХАВСРАЛТ

*Олж харж буй маань биш, хэрхэн
харж байна вэ гэдэг маань л хавьгүй чухал.
Монтэнь*

ОРШИЛ

Хүний генетик мэдээлэлтэй холбоотойгоор бусад улс орон бие даасан хуулийг батлан дагаж мөрдөж байна. Үүний дагуу хүний генетик мэдээлэл хамгаалах, тухайн хүний эрүүл мэнд, нийтийг хамарсан гоц халдвараас сэргийлэх, эмчилгээ, судалгааны явуулах зэрэг үйл ажиллагааг журамлаж өгсөн байна. Харин манай улсын хувьд энэ талаар өөрийн бие даасан хууль, тогтоомж байхгүй байгаа нь хүний үндсэн эрхийг зөрчигдөж бодит нөхцөл байдлыг үүсгэж байна.

Монгол Улсын хувьд хүн амын удмын сан буюу генетикийн талаар зохицуулсан төрийн цогц бодлогын баримт бичиг байхгүй байгаа нь хүний үндсэн эрхийг зөрчих, зөвшөөрөлгүйгээр мэдээлэл алдах, ашиглуулах, дотоодод цус ойртолтыг бий болгох аюулыг дагуулж байгаа бөгөөд энэ талаар төрөөс зайлшгүй бодлого боловсруулах, эрх зүйн орчин бий болгох хэрэгцээ шаардлага тулгарсан.

Үүний дагуу дээрх судалгааг хийх болсон бөгөөд судалгааны хүрээнд дараах асуудлуудыг хамрах хүрээнд хөндөж тусгасан болно. үүнд:

1. Үндсэн эрх ба хүний генетикийн тухай ойлголт
2. Олон улс дахь хүний удмын сан буюу генетикийн хууль зүйн зохицуулалт.

3. Монгол улс дахь хүний удмын сан буюу генетиктэй холбоотой хууль зүйн зохицуулалт зэрэг юм. Энэхүү судалгааг баримт бичигт дүн шинжилгээ хийх болон харьцуулалтын арга ашигласан болно.

Хүний генетиктэй холбоотой Монгол Улсад Доктор Ж.Батсуурь, Э.Энхмаа, С.Ганболд, Ж.Оюумаа, Ш.Дүрэвдулам, Ө.Мөнхтунгалаг, Д.Живгаагүнсэл зэрэг судлаачид судалгаа хийсэн байна. Мөн удмын сангийн цус ойртолтоос үүсэх сөрөг үр дагавар болох сэтгэцийн эмгэг, хам шинжийн тархалтын талаарх судалгааг Ш.Дорждамба, С.Бямбасүрэн нар 1984-1992 онуудад хийсэн. Харин 1990 онд Доктор, профессор Л.Наранцэнгэл ерөнхий боловсролын сурагч нарын дунд цус ойртолтоос үүсэх өвчлөлийн тархалтын талаарх судалгааг хийсэн байна. Энэхүү судалгааны талаар хууль зүйн үүднээс Гэр бүлийн эрх зүйн хүрээнд хийсэн судалгаа байгааг эс тооцвол өөр нарийвчлан хийгдсэн хууль зүйн судалгаа одоогоор байхгүй байна.

Судалгааны хамрах хүрээний хувьд хүний генетик мэдээлэл, хүний үндсэн эрхийн хүрээнд хийгдсэн болно. Цаашид шүүх шинжилгээ болон уг мэдээллийг цуглуулах, ашиглах, хадгалахтай холбоотой гарах үр дагаврын талаар судалгаа хийх шаардлагатай болно.

Энэхүү судалгааны илтгэлийн үр дүнд Монгол Улсад хэрэгжиж буй хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх, хүний үндсэн эрх болох хүний генетик мэдээлэлтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт нь

практикт хэрхэн хэрэгжиж буйг тогтоох болон олон улсын авч хэрэгжүүлж буй хууль зүйн арга хэмжээ, туршлагыг өөрийн улсад хэрэгжүүлэх боломжийн талаар тусгах зорилготой юм.

1. ҮНДСЭН ЭРХ БА ХҮНИЙ ГЕНЕТИКИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ.

Хүний эрхийн тухай ойлголт нь хүний төртэй харьцах, түүний эдийн засгийн нийгэмшлийн, улс төрийн соёлын хүрээн дэх боломж ба шаардлагын эрх зүйн байдлыг тодорхойлсон ухагдахуун¹. Мөн түүхэн эх сурвалжуудын хувьд хүний эрхийг хамгаалахад Английн 1266 оны Хүний эрхийн билль, Америкийн нэгдсэн улсын 1776 оны Тусгаар тогтнолын тунхаглал, Францын 1789 оны Хүний ба иргэний эрх чөлөөний тунхаглал, Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 он, Иргэний болон улс төрийн эрх мэдлийн тухай олон улсын пакт 1966 он, Европын холбооны Үндсэн эрхийн тунхаг бичиг, Европын хүний эрхийн конвенц, Европын нийгмийн харт гэх зэрэг олон баримт бичгүүдэд хүний эрхийн суурь зарчмуудыг хамгаалсан билээ.

Хүний эрхийн талаар ойлголтод, хүнийг хамгаалах арга хэрэгсэл болохын нь хувьд түүхэн нөхцөл байдал, уламжлал хүчтэй нөлөө үзүүлдэг учир түүний утга агуулгыг илэрхийлсэн олон янзын нэр томьёо байж ирсэн нь ойлгомжтой юм. Үүнд, иргэдийн эрх, үндсэн хуулийн эрх, үндсэн эрх чөлөө, үндсэн эрх ба эрх

¹ Нарангэрэл.С. "Эрх зүйн эх толь бичиг". УБ., 2009. 11 дэх тал.

чөлөө, үндсэн эрх буюу бусад эрх зэрэг категориуд байдгийг дурдаж болох юм. Америкийн түүхэн эх сурвалж-тунхаглалуудад "эрх", "салшгүй" эсвэл "заяамал эрх" гэсэн нэр томъёонуудыг хэрэглэж ирсэн бол Францын Хүний болон иргэний эрхийн тухай тунхаглалд "хүний эрх" болон "иргэдийн эрх" гэсэн ойлголтуудыг хооронд нь ялган, тусад нь авч үзсэн байдаг. 1867 оны Австрийн Төрийн тулгуур хуульд "төрлөх иргэдийн түгээмэл эрхүүд"-ийг бэхжүүлсэн байдаг. XIX зууны дунд үеэс эхлэн дэлхий нийтийн хууль зүйн утга зохиолд, үндсэн хуульд заасан эрхүүдийг иргэн бүрт олгож буй Үндсэн эрхүүд гэсэн утгаар нэг мөр ойлгож эхэлсэн юм². Позитив эрхийн шинж чанартай ийнхүү өөрчлөлтийг тухайлбал, Германд анх Ваймерийн Үндсэн хуулиар хийсэн гэж үздэг.

Харин дараагаар гарсан ХБНГУ-ын 1949 оны Үндсэн хууль нь өмнөх Үндсэн хуулийнхаа ойлголтыг уламжлан авсан байна. Дээр дурдсан нэр томъёонуудын алиныг нь ч сонголоо гэхэд, үүнд хүний болон иргэн хүний эрх зүйн байдлыг хангахад суурь ач холбогдолтой болох тэрхүү эрхүүдийг л ойлгож байсан гэдэг нь ойлгомжтой юм. Хүний эрхэмсэг оршихуй /человеческое достоинство/³ бол бүх

үндсэн эрхийн үндэс суурь юм гэж орчин үеийн либераль ардчилсан төрүүдийн үндсэн хуулийн онолоор үзэх болсон байна. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн арван долдугаар зүйлийн нэг дэх хэсгийн хоёрт, энэхүү үндсэн эрхийг Монгол Улсын иргэний ёсчлон биелүүлэх үндсэн үүрэгт хамааруулан үзэж "Хүний нэр төр, алдар хүнд..."-ийг "хүндэтгэх" үүрэгтэйг бэхжүүлсэн байдаг. "Достоинство" гэдэг үгийн орчуулга "алдар хүнд" гэсэн нэр томъёогоор орчуулдаг нь хэдийгээр тогтсон зүйл боловч, уг үндсэн эрхийн агуулгыг яг тэнцүү илэрхийлж чадаагүй гэсэн саналтай зохиогч нэг байдаг тул "эрхэмсэг оршихуй" гэсэн хэллэгээр орчуулсан болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зүйлд эрхэмсэг оршихуйг үндсэн эрхийн тоонд оруулаагүйгээр үл барам, төрөөс, төрийн эрх мэдлүүдээс үйл ажиллагаагаа явуулахдаа түүнийг хүндэтгэх үүрэгтэй болохыг заагаагүйгээрээ өрөөсгөл зохицуулалттай болсон гэж үзүүштэй.

Дээрх дурдсан хүний эрхэмсэг оршихуй болон бие хүн болох шинж чанар нь түүнд эрх зүйн этгээд болох шинж чанарыг олгож буй ба хүн зөвхөн оршин байгаа гэдгээрээ л тодорхой эрхүүдийг эдэлдэг. Үүнийг хүний эрх гэдэг. Ийм эрхүүд нь хүний натур /природа/-тай холбоотой буюу тэдгээр нь заяамал, төрөлхийн /естественные и врожденные/

² Й.Изенүе, П.Кирххоф.Государственное право Германии.Т2М., 1994.С.167,дам эшлэв.

³ Энэхүү эрхийг үндсэн эрхүүдийн суурь хэмээн үзэж дэлхийн улс орнуудын олон Үндсэн хуулиудад бэхжүүлсэн байдаг. Тухайлбал, ХБНГУ-ын Үндсэн хууль /1949/ чухамхүү энэ эрхээр эхэлдэг ба түүний 1 зүйлд: "Die Wuerde des Menschen ist unantastbar. Sie zu achten und zu schuetzen ist Verpflichtung aller staatlichen Gewalt" гэж заасан байдаг бөгөөд түүнийг хамгаалахыг төрдөө үүрэг болгосон байдаг. Түүнчлэн Баварын

Үндсэн хуулийн /1946/ 100 дугаар зүйлээр ч мөн хүний эрхэмсэг оршихуйг үндсэн эрх болохынх хувьд хамгаалсан байдаг. ОХУ-ын Үндсэн хуулийн /1993/ 21 дүгээр зүйлд: "Достоинство личности охраняется государством. Ничто не может быть основанием для его умаления" гэж бэхжүүлсэн байна. дам эшлэв.

эрхүүд байдаг. Ийм ч учраас дээрх эрхүүдийн үндэс суурь нь позитив буюу төрөөс олгосон /тогтоосон/ шинж чанартай бус, өөрөөр хэлбэл, хуулиас үүдэн гарсан бус шинжтэй байдаг. Тэрээр позитив эрх зүйгээс ангид буюу "дээгүүр" байдаг. Үүний мөн чанар нь, зүй тогтлыг танин мэдэхийн тулд танин мэдэхийн тулд антрополог, гүн ухаан болон төрөлхийн эрхийн байр сууринаас тайлбарлан дүн шинжилгээ хийх шаардлагатай болдог. Ийм төрөөс "өмнөх" шинж чанартай эрхүүдийг /хүний эрхийг/ Америкийн Эрхүүдийн тухай Биллийн оршил хэсэг, Францын тунхаглал, 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал зэргээс олж үзэж болох юм. Эдгээр эрхүүд нь хүний өөрийнх нь оршин байгаатай нь хамааралтай учир тэдгээрийг орон зай, цаг хугацаагаар тогтоох буюу хязгаарлах боломжгүй юм. Хүний эрх нь төрийн эрх зүйн бүрэлдэхүүн хэсэг биш, тэдгээрийг шууд хэрэгжүүлэх боломжгүй, учир нь ийнхүү боломжийг олгоход тэдгээрт "тодорхой байх" шинж чанар дутдаг⁴. Энэ дутагдлаас ангижруулахын тулд "тодорхой байх" шинж чанарыг олгож амьдралд хэрэгжүүлэхийн тулд тэдгээрийг төрийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулахыг эрмэлзэж улс орнуудын үндсэн хуулиудаар бэхжүүлдэг байна.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн холбогдох бүлгийг "Хүний эрх, эрх чөлөө" гэж нэрлэхдээ тус бүлэгт заасан эрхүүдийг дан ганц Монгол Улсын иргэн эдлэхгүй, харин Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн нэг дэх хэсэгт

⁴ Й.Изензеев П.Кирххоф. Государственное право Германии. Т2, М., 1994. С.197. дам ишлэв.

заасан, Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр эдэлнэ гэсэн санааг агуулсан юм. Ингэж нэрлэсэн нь ийнхүү өөрийн гэсэн учир шалтгаантай боловч Хүний эрх гэсэн нэр томъёоны дээр дурдсан анхдагч утга агуулгаас тодорхой хэмжээгээр зөрөхөд хүргэж буй юм. Хэрвээ "Иргэдийн эрх, эрх чөлөө" гэж нэрлэсэн бол Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн заалтууд, нэгдүгээрт, зөвхөн Монгол Улсын иргэнд хамаатай болж явцуурах байсан хоёрдугаарт эдгээр нь заавал үндсэн эрх биш ямар ч ердийн эрх, эрх чөлөө байж болохоор ойлгогдох байсан гэж үзүүштэй.⁵ Ийм ч учраас суурь ач холбогдолтой гэж тооцон Үндсэн хуульд зааж буй бүх эрх, эрх чөлөөг олон улс оронд тогтсон ёсоор "Үндсэн эрх, эрх чөлөө" гэж нэрлэх нь утгандаа нийцэхдээ илүү ч байж болох юм.

Тодорхой нэг үндсэн хуулиас ангид, олон улсын хэмжээнд эрх, эрх чөлөөг фундаменталь ухагдахуун болохынх нь хувьд авч үзэхдээ "Үндсэн эрх" бус "Хүний эрх" гэсэн нэр томъёогоор хэрэглэгддэг. Хүний эрхийг бүдүүлгээр зөрчих явдал дэлхийн хоёрдугаар дайны үед туйлдаа хүрсэн гэж үзэж олон улсын түгээмэл эрх зүйгээр түүнийг хамгаалах ажлыг хүчтэйгээр өрнүүлж эхэлсэн. Бие хүний эрхийг олон улсын түгээмэл эрх зүйгээр хамгаалах оролдлогыг хийж байсан тохиолдлууд эрт дээр үеийн түүхэнд ч бас байсан ба ийнхүү эрхүүдийг "хүний олон улсын эрх" гэж нэрлэн иржээ.

Эдгээр нь үндэсний эрх зүйгээр хамгаалж буй эрхүүдээс цар

⁵ <https://legaldata.mn/buteel/pdf?id=721>

хүрээгээр өргөнд тооцогддог. Хүний эрхийн каталогийг улс орнууд өөрсдийнхөө хууль тогтоомжид тусгахаас гадна ийм эрхүүд нь нийт төрүүдийн хамтын нийгэмлэгийн эрх зүйн хувьд нийтлэг байдлаар хамгаалагдах объект нь болдог. Хүний эрхийн олон улсын стандарт болон тухайн улсын үндсэн хуулиар бэхжүүлсэн үндсэн эрхүүд өөр хоорондоо диалектикийн тэнцэлд орж үндэсний стандарт нь олон улсынхад хүрэхгүй байгаа улс орнуудын хувьд хөгжих түлхэц болж өгдөг. Монгол Улс Нэгдсэн Үндэсний Байгууллагад 1961 онд элссэнээс хойш НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагаас баталсан 20⁶ гаруй гэрээ /пакт, конвенцид/-нд нэгдэн орсон ба 1992 оны Үндсэн хуулиа боловсруулахдаа дээрх баримт бичгүүдийг аль болох иш үндэс болгохыг зорьсон юм.

Антропологи аспект. Эрх зүйн үндэс суурь нь хүн өөрөө бөгөөд төрсөн цагаас эхлэн нийгмийн харилцаа, дэмжлэг дунд оршин байдаг. Ертөнцөд хүн мэндлэхэд түүнд тодорхой халамж шаардагддаг бөгөөд энэ нь түүнийг насан туршид нь дагалддаг. Хүрээлэн байгаа орчноос түүнийг хамгаалах дэмжүүлэх шаардлага байнга тулгардаг.

Ийнхүү социал шинж чанартай суурь харилцаануудыг тойрон үндсэн эрхүүд бий болдог. Төрийн үндсэн суурь болсон хүн, түүний хэрэгцээг зөв үнэлж, зохистой гүйцэлдүүлэх байдлаар төр болон эрх зүйн аль нь ч хүлээн зөвшөөрөх ёстой байдаг. Ингэхдээ хүн бүрийг:

⁶ Хүний эрх. Олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхтгэл. УБ., 1992. 1 дэх тал.

Амьд явах /амьдрах/⁷ эрхтэй субъект эрх зүйн этгээд болохынх нь хувьд хүлээн зөвшөөрөх ёстой буюу түүний эрхэмсэн оршихуйг /достинство/ нь хамгаалах үүрэгтэй болдог.

Тодорхой зарим үндсэн эрх нь түүхийн болон антропологиин аспектаас улбаалан үзэхэд социал хүрээнд хэрэгжихдээ нэлээд эмзэг байдаг. Тэдгээрийг зөрчихөд хялбар боловч бүхэлдээ буюу өргөн утгаараа тэд хүний оршин байх зорилго, утга агуулгыг тодорхойлж байдаг.

Үндсэн эрх хүний бодит эрэлт, шаардлагад нийцэж байдгаараа нийгмийг болон улс төрийн тогтолцоог цогцлон бүрдүүлэхэд баримтлах зарчим болдог. Ийм ч утгаар Виржинийн Хүний эрхийн Биллийг бүтээхдээ үндсэн эрхийг "the founfadtion of government"⁸ гэдэг утгаар авч үзсэн байдаг. Нөгөө талаас үндсэн эрх нь хүн бүрийн субъектив эрхийг баталгаажуулдаг. Жишээ нь: Үндсэн хуульд заасан болзлыг хангасан хууль ёсны шүүгчээр өөрийгөө хамгаалуулах эрх⁹ гэсэн нэг эрх Герман, Швейцарийн болон барууны бусад улс орнуудын үндсэн хуулиудад байдаг ба энэ нь нэг талаас "эрх зүйн төрийн объектив зарчим, нөгөө талаас хүн бүрт тодорхой нөхцөл байдалд өөрийнхөө эрхийг хамгаалах боломжийг олгож

⁷ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйл. 1996, Монгол Улсын нэгдэн орсон он: 1974. Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. УБ., 1992. 11 дэх тал.

⁸ Виржинийн Хүний эрхийн Биллийн/1776.07.12/ оршил хэсэг.

⁹ Цвейцарийн Холбооны Үндсэн хуулийн 58 дугаар зүйл. Jorg Paul Mueller. Elemente einer schweizerischen Grundrechtstheorie. Bern, 1982. S6. дам эшлэв.

буй заалт /субъетив эрх/ юм”.

Үндсэн эрхийн тухай дефенсив ойлголт. Үндсэн эрхийг нэг талаас хувь хүний эрх чөлөө, нөгөө талаас түүний эсрэг байгаа төрийн засаг хоёрын зааг ялгаа гэж ойлгодог. Үүнийг дефенсив ойлголт гэж үзэх ба энэ нь иргэн хүний эрх чөлөөг дөвийлгөх, төрийн эрх мэдлийг хязгаарлахад чиглэсэн байдаг. Төрийн хязгаарлалтаас ангид байдаг хувийн эрх, эрх чөлөөг тусгайлан авч үздэгээрээ онцлогтой юм /халдашгүй чөлөөтэй байх эрх, шашин шүтэх эс шүтэх эрх, ажил мэргэжлээ сонгох эрх/.¹⁰

Улс үндэстнүүдийн өөрийн ондоошил, соёл, сэтгэлгээ, уламжлал, шашин, амьдралын хэв маягаас хамаарч хүний эрхийн талаарх ойлголт харилцан адилгүй байдлаар хөгжсөн байх бөгөөд түүний нэгтгэсэн байдлаар хүний зайлшгүй эдлэх ёстой эрхийн талаар олон улсын хэм хэмжээнд тусгасан байх бөгөөд түүнд нийцүүлэн жишиг болгож улс, үндэстнүүд дотоодын хууль тогтоомжид тусгах болжээ.

Энэхүү хүний аль ч улс оронд төрсөн, өссөн байхаас үл хамааран хүн болохын хувьд эдлэх ёстой эрхийг үндсэн эрх хэмээн дурдаж болох юм. Уг агуулга нь хүний эрхийг дэс дараалалд оруулах бус харин улс орнуудад түүний дотоодын хууль тогтоомжид зайлшгүй тусган хэрэгжүүлэх талаар өгүүлсэн болно.

Дараах хүний генетикийн асуудал бол хүний үндсэн эрхэд хамаарагдах ухагдахуун болох юм. Хүний удмын сан генетикийн мэдээллийг цуглуулах, ашиглах,

судлах, хэрэглэх, хадгалахтай холбоотой харилцааг хууль зүйн зохицуулалтаар хамгаалах шаардлага бий болсон. Үүний өмнө хүний генетикийн талаар товч авч үзье.

Генетик бол амьд организмуудын хэлбэр болон удамшлыг судалдаг шинжлэх ухаан юм.¹¹ Орчин үеийн генетикийн шинжлэх ухаан нь 1800-аад оны дунд үед амьдарч байсан Грегор Менделийн хийсэн ажлаас улбаатай.¹² Менделийн судалгаа ажлыг дэмжигч Виллиам Бэйтсон “Генетик” гэдэг энэ үгийг анх 1905 онд Адам Сэдживикт бичсэн захидалдаа дурдсан юм. “Генетик”¹³ гэдэг нэр үг болон хэрэглэгдэхээс өмнө 1830-аад оны үед анх хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд 1859 онд Чарльз Дарвин өөрийн Зүйлийн үүсэл номдоо анх удаа биологийн нэр томъёо болгон ашиглаж байжээ.¹⁴ Бэйтсон 1906 онд Английн Лондон хотод болсон Ургамалын эрлийзжүүлэлтийн олон улсын гуравдугаар чуулган дээр өөрийн шинэ ажлын анхны илтгэлдээ удамшлын судалгааг “генетик” гэдэг үгээр тодорхойлж, энэхүү үгийн хэрэглээг түгээмэл болгосон.¹⁵

¹¹ Griffiths AJF, Miller JH, Suzuki DT, Lewontin RC, and Gelbart WM (2000). An introduction to Genetic Analysis. New York: W.H. Freeman and Company.

¹² Weiling F (1991). “Historical study: Johann Gregor Mendel 1822-1884”. American Journal of Medical Genetics 40 (1): 1-25; discussion 26.

¹³ Грек хэлний γέννω “генно” буюу төрүүлэх гэсэн утгатай үгнээс гаралтай үгнээс гаралтай

¹⁴ Genetic, a. and n. pl., Oxford English Dictionary, 2nd ed. (1989)

¹⁵ Bateson, W (1907). “The Progress of Genetic Research”. Wilks, W (editor) Report of the Third 1906 International Conference on Genetics: Hybridization (the cross-breeding of genera or species), the cross-breeding of varieties, and general plant breeding, London: Royal Horticultural Society.

Although the conference was titled “International Conference on Hybridisation and Plant Breeding”,

¹⁰ <https://legaldata.mn/buteel/pdf?id=721>

Харин ген гэх ойлголт уг ухагдахуунд хэрэглэгдэх бөгөөд Грекийн genesis буюу төрөлт эсвэл genos буюу эх гэдэг үгнээс гаргаж авсан ойлголт юм. Генийг орчин цагт "тохируулах хэсэг, транскрибчилах хэсэг, өөр үйлдлийн хэсгүүдтэй холбогдолтой удамшлын нэгжтэй зохицох геномын дарааллын хувьсах байрлал" гэж тодорхойлдог.¹⁶

Өөрөөр хэлбэл Ген гэдэг нь хүний удмын мэдээллийг хэдэн үе дамжуулан авч явдаг "ертөнц" юм. Өөрөө хэлбэл, ген амьд организмын удамшлын мэдээллийг агуулсан молекул нэгж буюу материаллаг хэсэг болдог. Хүний бие махбодыг бүтээгч эсийн дотор хромосом хэмээх биенцэр байдаг. Энэ биенцэрийн дотор ген орших бөгөөд ген үеэс үед үр хүүхдэд дамжин хадгалагдана. Эцэг эх хоёроос 50, 50 хувийн ген буюу адилхан хос 23 хромосомыг хүүхэд энэ тэнцүүгээр хадгалан төрөх бөгөөд хүний амьдралын үйл ажиллагаа нь түүний генийн мэдээллийн сангийн шинж чанарт тулгуурлан явагддаг. Тухайлбал, хүний нүдний өнгө, царай зүс, зан төрх, явдал суудал, оюун ухаан зэргийг хадгалан дамжуулах ген хэдэн зуун жилийн өмнөх өндөр өвөг¹⁷, эмгээс эхлэн бөлөнцөр¹⁸ хүртэл өөрчлөгдөхгүй хадгалагдаж байдаг.¹⁹

Wilks changed the title for publication as a result of Bateson's speech.

¹⁶ Pearson H (2006). "Genetics: what is a gene?". Nature 441 (7092): 398–401.

¹⁷ Монгол хэлний их тайлбар толь 2016 он. "Тав дахь дээд үе, хуланц өвгийн эцэг"

¹⁸ Монгол хэлний их тайлбар толь 2016 он. "Эгч дүүгийн хүүхэд"

¹⁹ Ц.Амарсанаа. "Хүний удмын сан буюу генетикийн хууль зүйн асуудал" илтгэлээс. УБ., 2021 он.

Иймд хүний дахин давтагдахгүй эмзэг мэдээлэл болох генетик мэдээлэлтэй холбоотой асуудал нь хүний үндсэн эрх зайлшгүй мөн бөгөөд түүний хуулиар хамгаалах шаардлагатай байна.

2. ОЛОН УЛС ДАХЬ ХҮНИЙ УДМЫН САН БУЮУ ГЕНЕТИКИЙН ХУУЛЬ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Олон улсын түвшинд хүний удмын сантай холбоотой дараах олон улсын гэрээ, тунхаглалууд байна. Тухайлбал: Нэгдсэн Үндэстний байгууллагын 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал²⁰, Генетик нөөц болон тэдгээрийг ашигласнаас үүдэх үр ашгийг шударга, эрх тэгш хуваарилах тухай Нагоягийн протокол, Нэгдсэн Үндэстний байгууллагын 1997 оны Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглал²¹, Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглал²², Хүний генетикийн мэдээллийн олон улсын тунхаглал²³ Био ёс зүй ба хүний эрхийн түгээмэл тунхаглал²⁴

²⁰ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/1271>

²¹ 1997 оны ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлаар био ёс зүйн салбар дахь цорын ганц олон улсын баримт бичиг болох "Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглал"-ыг баталсан бөгөөд уг баримт бичгийг 1998 онд НҮБ-ын Ерөнхий ассамблей дахин баталсан. Эх сурвалж: <https://unesco.mn/mn/social-human-sciences/programmes/ethics/>

²² Universal Declaration on the Human Genome-1998. <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/universal-declaration-human-genome-and-human-rights>

²³ International Declaration on Human Genetic Data-2003. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000136112>

²⁴ Universal Declaration on Bioethics and Human Rights- 2005. <https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC2226192/>

Олон улсын томуугийн хяналт ба авах арга хэмжээний тогтолцоо гэх зэрэг олон улсын гэрээ, тунхаг бичгүүд байна.

Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд генетикийн мэдээллийн санг хөгжүүлэх ажлыг 20 гаруй жил явуулж ихээхэн туршлага хуримтлуулжээ. Олон улсын Интерполын гишүүн орнуудын дунд явуулсан судалгаанаас үзэхэд нийт 127 гишүүн орнуудын 71% нь судалгаанд хамрагдаж, тэдгээрээс Европ тивийн 28 орон, Америк тивийн 10, Ази, Номхон далайн 3 оронд албан ёсны итгэмжлэгдсэн генетикийн лаборатори бүхий санг байгуулсан байна. Харин Африк, Хойд Африк ба Ойрхи Дорнодод итгэмжлэгдсэн албан ёсны лаборатори бүхий санг одоогоор байгуулж амжаагүй, зөвхөн эхлэлийн үе шатандаа явж байгааг тэмдэглэжээ²⁵.

ОХУ-д шүүх ДНХ-ийн адилтгах шинжилгээг анх 1980-аад оны дунд үеэс хийж эхэлсэн ба ДНХ-ийн мэдээллийн сангийн бүртгэлийн системийг боловсруулах ажил 1990-ээд оны дундуур хийгдсэн боловч санхүүгийн бэрхшээлийн улмаас хэрэгжилт нь хойшлогдсоор Төрийн ДУМ нь "Холбооны улсын геномын бүртгэлийн тухай" хуулийг 2008 оны 12 сарын 9-нд баталсан бөгөөд 2009 оны 1 дүгээр сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлжээ⁵. ОХУ нь анх 2009 онд "ДНХ-ийн мэдээллийн сан"-ийн хуулиа баталж санд одоогийн байдлаар нийт 300000

орчим дээжний ДНХ-ийн мэдээлэл бүртгэсэн байгаа нь нийт хүн амын /147 сая хүн амтай/0,2% орчим хувийг хамруулсан байх жишээтэй.²⁶

АНУ нь анх 1994 оны ДНХ тогтоох тухай хууль²⁷ баталж 1996 онд "Генетик мэдээллийн сан" бүрдүүлж эхэлсэн ба одоогийн байдлаар нийт 13,7 сая орчим хүний дээжийг бүртгэсэн байгаа нь нийт хүн амын /326 сая хүн амтай/4.2 % орчим хувийг хамруулж чадсан байна.

АНУ-ын 50 муж улс ба Холбооны мөрдөн байцаах алба нь тус тусдаа ДНХ-ийн мэдээллийн сантай. Тэдгээрийг 44 муж улс нь гэмт хэрэг үйлдсэн хүн бүрийн, 39 муж улс нь зарим тодорхой гэм буруутай хэрэг үйлдэгчдийн, 28 муж улсад насанд хүрээгүйчүүдийн ДНХ-ийн мэдээллийг цуглуулахыг зөвшөөрсөн бол 6 муж улсад нь баривчлагдсан хүн бүрээс ДНХ-ийн шинжилгээ авч эхэлсэн байна²⁸.

БНХАУ-ын Хүний Генетикийн нөөцийн менежментийн тухай хууль нь 2019 онд батлагдсан. БНХАУ нь 2017 оны байдлаар үндэсний генетикийн мэдээллийн санд 68 сая орчим дээжний мэдээллийг бүртгэн ашиглаж байгаа бөгөөд энэ нь нийт хүн амын /1 млрд 384,350 сая хүн амтай/ 4,912 % орчим хувийг эзэлж байна. "Генетик мэдээллийн үндэсний сан" Хятад дахь хүний наймааг таслан зогсооход маш

²⁵ "Хууль дээдлэх ёс сэтгүүл", УБ., 2018. Цуврал 69, Дугаар №4, 175 дахь тал.

²⁷ DNA Identification Act 1994. <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/d-3.8/>

²⁸ Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг. "Шүүхийн шинжилгээний практикт "Генийн мэдээллийн санг" ашиглаж гэмт хэргийг илрүүлж буй гадаадын зарим улс орны туршлага, эрх зүйн орчин" харьцуулсан судалгаа., код: СТ-13/241., 2013 он, УБ хот.

²⁶ Чудинов О.С., Пименов, Абрамова А.Б., "Технико-экономическое обоснование внедрения ДНК-исследований в экспертно-криминалистическую деятельность и ее автоматизация", "Эксперт криминалист", 2006., №3. Дам ишлэв.

чухал үүрэг гүйцэтгэснийг дурджээ. 2009 оны 4-р сараас хойш 39000 гаруй хүн худалдсан хэргийн тохиолдлыг ДНХ-ийн шинжилгээгээр шийдвэрлэсэн байна. Үүнээс гадна ДНХ-ийн шинжилгээний үр дүнд сураггүй алга болоод олдсон, орон гэргүй тэнэмэл, асрах хүнгүй 1400 хүүхдийн эцэг, эхээс харьцуулах дээж авч ДНХ-ийн шинжилгээ хийж хүүхдийг эцэг, эхэд нь буцааж олж өгсөн байна. Генийн мэдээллийн үндэсний сан бүрдсэнээр Хятадад хүүхэд худалдаалах гэмт хэрэг ихээхэн буурсныг Хятадын нийгмийн аюулгүйн албаны яамны Хүн худалдаалахын эсрэг тэмцэх албаны захирал ЧенШику мэдэгдсэн байна.²⁹

Чили улс 2009 онд өмнөд америк тивдээ анх удаа "Генийн мэдээллийн сан"-гийн эрх зүйн орчныг хуулиар зохицуулсан улс орон болсон байдаг. Урагвай улс 2011 онд Генийн бүртгэлийн тухай хууль баталсан бөгөөд хууль зөрчиж саатуулагдсан хувь хүнд хуулиа тайлбарласны үндсэн дээр Батлан хамгаалах, Дотоод явдлын яамны ажилтны зөвшөөрөл, шүүхийн захирамжаар дээж авч шинжилгээ хийж, Генийн мэдээллийн санд бүртгэдэг байна. Мөн хэргийн газраас олдсон биологийн дээжнээс сорьц авч ДНХ-ийн шинжилгээ хийж үр дүнг мэдээллийн санд оруулж хадгалдаг байна.³⁰

Эстони болон Герман улсын хувьд генетик мэдээллийн цуглуулах, ашиглах, хадгалахтай холбоотой бие даасан хуультай. Эстони Хүний

генетик судлагааны тухай хууль³¹ 2000 онд баталсан бол Герман Хүний генетик оношилгоо, шинжилгээний тухай хууль³² баталсан байна.

Бусад улс орны хувьд Удмын сангийн аюулгүй байдлын талаарх харилцааг Эрүүгийн хуулиар зохицуулсан 23³³ улс, Иргэний хуулиар зохицуулсан 7³⁴, Гэр бүлийн хуулиар зохицуулсан 9³⁵, Бие даасан хуулиар зохицуулсан 4³⁶ улс байна³⁷. Эдгээр орнуудад цус ойртолттой холбоотой харилцааг бие даасан хуулиар эсхүл салбарын хоёр, гурван хуулиар зохицуулсан буюу хосолмол зохицуулалттай байна³⁸. Зарим улс оронд хүний генетикийн талаар бие даасан судалгаа шинжилгээ, хамгаалахтай холбоотой хуулиадтай байна.³⁹ Дээр дурдсан улс орнуудын туршлагаас үзэхэд⁴⁰ манай улс "Хүний генетик мэдээллийг цуглуулах, ашиглах, хамгаалах" тухай хууль нэн шаардлагатайг харуулж байна.

³¹ Human Genes Research Act. https://www-riiqiteataja-ee.translate.google/en/531102013003/consolidate?x_tr_sl=en&x_tr_tl=mn&x_tr_hl=mn&x_tr_olo=sc

³² Genetic Diagnostics Act. <https://www.drze.de/en-focus/predictive-genetic-testing/legal-aspects>

³³ Хавсралт №1. Бусад улс орны Эрүүгийн хуулийн харьцуулалтыг үзнэ үү.

³⁴ Хавсралт №2. Бусад улс орны Иргэний хуулийн харьцуулалтыг үзнэ үү.

³⁵ Хавсралт №3. Гэр бүлийн тухай хуулийн харьцуулалтыг үзнэ үү.

³⁶ Хавсралт №4. Бусад улс орны Бие даасан хууль, Зөрчлийн хуулиар зохицуулсан байдлын талаар үзнэ үү.

³⁷ Хавсралт №5. Хүн амын удмын сангийн аюулгүй байдлын талаар бусад орны хуульчилсан байдал. Хүснэгтийг үзнэ үү.

³⁸ Хавсралт №6. Гадаадын зарим оронд цус ойртолтыг хуулиар зохицуулсан байдлын судалгааг үзнэ үү.

³⁹ Хавсралт №7. Зарим улс орны хууль, тогтоомжийн зохицуулалтын товчийг хүснэгтээс үзнэ үү.

⁴⁰ Хавсралт №8. Зарим улс орны Генетикийн хуулийн бүтцийн талаар судалгааг үзнэ үү.

²⁹ "Хууль дээдлэх ёс сэтгүүл", УБ., 2018, Цуврал 69, Дугаар №4, 178 дахь тал.

³⁰ "Хууль дээдлэх ёс сэтгүүл", УБ., 2018, Цуврал 69, Дугаар №4, 179 дахь тал.

3. МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ УДМЫН САН БУЮУ ГЕНЕТИКТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ.

Монгол Улсын хууль тогтоомжид тусгасан байдлыг авч үзвэл. Монгол Улсын Их Хурлаас 1996 оны 22 дугаар тогтоолын хавсралтаар "Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлого"-ыг хэрэгжүүлж ирсэн ба 2004 оны 21 тогтоолын хавсралтаар "Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого"⁴¹ батлагдсанаар тус тогтоол хүчингүй болсонд тооцсон. Мөн Улсын Их Хурлын 2003 оны 16 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого"⁴² баталсан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"⁴³-д энэ талаар 3.1.Оршин тогтнохуйн аюулгүй байдал "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн", "3.1.3.4. Цус ойртолтыг

багасгах, архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна" гэж бодлого тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг⁴⁴ баталсан байна. Тус тогтоолын хавсралт 1-ийн "2.7.1.хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг сэргээнэ", "2.7.2.цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн согогтой хүүхдийн эрт оношилгооны чадавхыг дээшлүүлнэ", "2.7.4.хүн амын удмын сан, нөхөн үржихүйг хамгаалах төрийн бодлого, эрх зүйн орчныг бий болгоно" гэж тус тус тусгасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр тогтоол "Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын есөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай" тогтоол баталсан. Уг тогтоолын "1.3.хүний генетикийн оношилгоо, эмчилгээ, генийн сангийн аюулгүй байдлыг зохицуулах чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд 2023 онд багтаан өргөн мэдүүлэх," гэж заасан.

Харин Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6 дахь хэсэг "Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй...", Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэг "...Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр

⁴¹ Монгол Улсын төрөөс Хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг батлах тухай. 2004 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/6278?lawid=6278>

⁴² Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого батлах тухай. 2003 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/6281?lawid=6281>

⁴³ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/6163?lawid=6163>

⁴⁴ Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл. 2020 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/15584?lawid=15584>

хамгаална”, гэх зэрэг үндсэн эрхүүдийг хуульчилж өгсөн.

2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх Кибер аюулгүй байдлын тухай хуулийн⁴⁵ 19 дүгээр зүйлийн 19.1.3-т “хоёр, гуравдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллага”, 19.1.4 “хүн, малын гоц халдварт өвчин судлах лаборатори” зэрэг нь онц чухал мэдээллийн дэд бүтцийн байгууллага гэж заасан байна. Уг байгууллага нь генетик мэдээллийг цуглуулдаг байгууллага юм. Гэвч генетик мэдээллийг цуглуулах, ашиглах, хадгалах, судлах талаарх зохицуулалтыг тусгаагүй байна.

Мөн 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн⁴⁶ 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “«генетик мэдээлэл» гэж биологийн сорьцын шинжилгээгээр тогтоосон хүний бие махбод, эрүүл мэнд, өвлөн авсан удамшлын шинж чанарыг илэрхийлсэн дахин давтагдашгүй мэдээллийг;”, 4.1.12-т “«хүний эмзэг мэдээлэл» гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг;” гэж заасан байна.

Уг хуулиар генетик мэдээллийг дараах байдлаар цуглуулах,

⁴⁵ Кибер аюулгүй байдлын тухай хууль. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390365491081>

⁴⁶ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390288615991>

ашиглах, хадгалах талаар тусгасан байна.

- 10.1.3 “... эрх бүхий байгууллага гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, шалган шийдвэрлэх зорилгоор генетик болон биометрик мэдээллийг;”,

-10.1.4. “шүүхийн шинжилгээний байгууллага хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн шинжилгээ хийхэд генетик болон биометрик мэдээллийг;

- 13.2.”... мэдээллийн эзэн нас барснаас хойш 70 жил өнгөрсөн тохиолдолд хүний эмзэг мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад зөвшөөрөл шаардахгүй гэж тусгасан байна.

Дээрх зохицуулалтад шаардлагагүй нөхцөлд хүний генетик мэдээлэл авах талаар тусгасан байна. Тухайлбал гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор генетик мэдээлэл авах талаар тусгасан байна. Гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх гэх агуулгын хүрээнд хүний генетик мэдээлэл авах нь буруу зүйл бөгөөд хүнийг урьдчилан гэмт хэрэгт яллах, зөрчилд шийтгэл ногдуулахтай адилтган үзэж болохгүй юм.

Мөн хуульд хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагааны явцад гэж нээлттэй зааж өгсөн. Гэтэл хүний генетик мэдээллээс хамааралтай нотлох баримт цуглуулах шаардлагатай цөөн төрлийн хэрэг маргаанд байдаг. Тийм учир хуульд өөрчлөлт оруулан нарийвчлан зааж өгөх шаардлагатай.

Хуулийн 13.2-т заасан насан барснаас хойш 70 жил өнгөрсөн тохиолдолд хүний эмзэг мэдээлэл

цуглуулах, боловсруулах, ашиглахад зөвшөөрөл шаардахгүй гэж тусгасан байгаа нь хүний үндсэн эрхэд халдаж буй хэрэг юм. Тухайн хүний дахин давтагдахгүй байгаа генетик мэдээлэл заавал зөвшөөрөл олгогдсоны дагуу авах ёстой. Хэдий нас барсан ч түүний үр хүүхэд, гэр бүлийн гишүүдээс зөвшөөрөл авах нь зүйн хэрэг юм.

ДҮГНЭЛТ

Монгол улсын хөгжилд эрх зүйн шинэчлэлийн үр нөлөө бий болгох хүрээнд Хүний удмын сан буюу генетикийн асуудлыг төрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах зайлшгүй шаардлагатай байна.

Хүн амын эрүүл мэнд, удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах хууль, эрх зүйн орчинг бий болгох шаардлага бол улс орны тусгаар тогтнолтой шууд холбоотой асуудал юм. Мөн хүний генетикийн мэдээлэл хамгаалуулах эрх бол үндсэн эрх бөгөөд хуулиар хамгаалуулах ёстой.

Хэдийгээр Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний мэдээлэл хамгаалах тухай хуулиудыг батлан гаргасан ч уг харилцааг нийтлэг зохицуулалтыг тусгаж өгсөн байна. Мөн генетиктэй холбоотой дагалдан гарах сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх талаар Гэр бүлийн тухай хууль, Соёлын тухай хууль зэрэгт хэсэгчлэн тусгасан байна.

Бусад улс орны хувьд хүний генетик мэдээллийг цуглуулах, ашиглах, хамгаалах, хадгалах

талаар бие даасан хуулиар зохицуулж эхэлсэн. Мөн тухайн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлагуудыг ч холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан байна. Үүнтэй холбогдуулан дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Хүний генетик мэдээлэл бол тухайн хүнийг илэрхийлэх шинжлэх ухаанаар нотлогдсон мэдээлэл бөгөөд хүний үндсэн эрх учир зайлшгүй хуулиар хамгаалагдах шаардлагатай. Иймд тухайн харилцаатай холбоотойгоор бие даасан хууль батлах шаардлагатай.

2. Эрүүгийн хуульд Цус ойртох гэмт хэрэг гэж нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай⁴⁷ гэж үзэж байна. Эрүүгийн хуулийн зорилго нь хэдийгээр гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх боловч мөн урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байдаг. Тухайлбал, эрүүгийн хуульд тухайн үйлдлийг зааснаар гэмт хэрэгт тооцдог. Иймд нийгэмд тухайн зүйлийг үйлдэх нь буруу гэх ойлголтыг өгөх боломж бүрдэнэ.

2. Гэр бүлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан харшлах шалтгаанд заасан үндэслэл байгаа талаарх төрийн эрх байгууллага хяналттавих шаардлаганэмэгдүүлэх. Гэр бүлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т заасан улсын бүртгэлийн байгууллага, Дипломат төлөөлөгчийн газарт гэрлэлтийг бүртгэхэд хяналт хийх чиг үүрэг бий болгох. Тухайн чиг үүргийн дагуу мэргэжилтэн орон тоонд оруулах нь уг асуудлыг хянах боломжийг бүрдүүлэх юм.

⁴⁷ Хавсралт № 9. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг үзнэ үү.

3. Зөрчлийн хуульд өөрчлөлт оруулах⁴⁸. Зөрчлийн хуулийн 5.4 дүгээр зүйлд заасан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих гэсэн агуулгад үйлдэл буюу хүчирхийллийн хэлбэрийг нэмэх шаардлагатай. Нийгэмд гарч буй ёс зүйгүй үйлдлүүд нь эрүүгийн хариуцлага хүлээхгүй орхигдох үзэгдэл гарч байна. Мөн Зөрчлийн хуулийн үйлдлийн тооциж хуульчилсан агуулга дутмаг байгаа учир өөрчлөлт оруулж гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрийг нэмж оруулах шаардлагатай.

4. Хүний удмын сан буюу генетикийн талаарх улсын хэмжээнд сургалт, судалгаа, хяналт, шинжилгээ хийх төрийн бүтэцтэй болох. Монгол улсад Монгол хүн судлалын төв гэх байгууллага энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан туршлага бий. Одоогийн нөхцөлд энэ чиг үүрэг бүхий төрийн институцийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэд байгуулах боломжтой. Учир нь хүний удмын сангийн мэдээлэл, түүнтэй холбоотой шинжлэх ухааны судалгаа шинжилгээг мэдээлэл нь үндэсний аюулгүй байдалтай шууд хамааралтай бөгөөд нууцлалыг чанд хадгалах шаардлагатай байдаг.

7. Төрийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргах. **Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт** “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх,

хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх
⁴⁸ Хавсралт № 10. Зөрчлийн тухай хуульд оруулах өөрчлөлтийг үзнэ үү.

үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасны дагуу Улсын Их Хурал⁴⁹, Засгийн газар, Яам, агентлаг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хэм хэмжээг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай шийдвэр гаргах ёстой.

⁴⁹ Хүн амын удмын сан хамгаалахтай холбоотой УИХ-ын тогтоолын төслийг дараах холбооноос үзнэ үү. <https://lawforum.parliament.mn/draft/53/>

НОМ ЗҮЙ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ТОГТООМЖ:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Эрүүгийн хууль
3. Иргэний хууль
4. Гэр бүлийн тухай хууль
5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
6. Зөрчлийн тухай хууль
7. Соёлын тухай хууль
8. Төрийн болон албаны нууцын тухай хууль
9. Хувь хүний нууцын тухай хууль
10. Кибер аюулгүй байдлан тухай хууль
11. Хүний мэдээлэл хамгаалах тухай хууль
12. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1991 оны зарилгаг."БНМАУ-ын хүн ам зүйн талаар баримтлах чиглэл"
13. Монгол Улсын Их Хурлын 1996 оны тогтоол. "Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлого"
14. Монгол Улсын Их Хурлын 2003 оны тогтоол. "Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого"
15. Монгол Улсын Их Хурлын 2004 оны тогтоол. "Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого"
16. Монгол Улсын Их Хурлын 2010 оны тогтоол. "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"
17. Монгол Улсын Их Хурлын 2020 оны тогтоол. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"
18. Монгол Улсын Их Хурлын 2020

- оны тогтоол. "Алсын хараа-2050"
19. Монгол Улсын Их Хурлын 2022 оны тогтоол."Монгол хүний удмын сангийн аюулгүй байдал, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай"
20. Монгол Улсын Засгийн газрын 1997 оны тогтоол. "Угийн бичиг хөтлөх журам"
21. Монгол Улсын Засгийн газрын 2007 оны тогтоол. "Угийн бичиг хөтлөх журам" шинэчлэн батлах тухай

ГАДААД ОРНЫ ХУУЛЬ, ТОГТООМЖ:

1. Universal Declaration on the Human Genome-1998
2. International Declaration on Human Genetic Data-2003.
3. DNA Identification Act 1994. USA
4. Genetic Diagnostics Act.German
5. Human Genes Research Act. Estonia
6. Civil Act of the Republic of Korea (Law No.471)
7. Civil Code of the Philippines. Republic Act No. 386
8. Constitution of the Republic of Korea
9. Criminal Act of New Zeland
10. Criminal Code of Canada
11. Criminal Code of Albama USA
12. Criminal Law of North Carolina USA
13. Law on marriage and family of Vietnam (No 52/2014QH13)
14. Marriage and Divorce Act of Malaysia – 1976.
15. Penal Code of Malaysia (Act 574)
16. Penal Code of Vietnam (No 15/1999/QH10)
17. Punishment of Incest Act of Ireland
18. Swiss Criminal Code

19. The Family Code of the Philippines тайлан.УБ.,2020
20. Семейный кодекс Российской Федерации. 11. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн тайлан. УБ.,2019

НОМ, СУРАХ БИЧИГ:

1. Ж.Батсуурь, Э.Энхмаа."Монгол улсын иргэн угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар".УБ., 2010
2. С.Бямбасүрэн."Сэтгэцийн эмгэг судлал".УБ.,2007
3. Ш.Биндэръяа."Угийн бичиг багшийн ном".УБ.,2013
4. А.Гидденс."Социологи".УБ.,2006
5. Ш.Доржжадамба, С.Бямбасүрэн, Н.Орёл, Л.Эрдэнэбаяр."Хорьдугаар зууны үеийн Монгол улс дахь сэтгэцийн эмгэгийн тархалтын байдал".УБ.,1996
6. С.Нарангэрэл."Эрх зүйн эх толь бичиг".УБ.,2007
7. И.Пүрэвдорж."Удамшил". УБ.,1991
8. "Удмын сангийн бодлого, түүнийг хамгаалах, зохицуулахтай холбогдсон эрх зүйн баримт бичгийн харьцуулсан судалгаа" Парламентын судалгааны хүрээлэн /захиалгат судалгаа/. УБ.,2021
9. "Цус ойртолт ба оюуны хомсдол Монгол улсын хэмжээнд". Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны захиалгат судалгааны ажлын тайлан.УБ.,2020
10. "Төрөл ойртолт, түүний хүн амд эзлэх зохистой харьцааны алдагдал, сэтгэл мэдрэлийн өвчтэй, оюуны хомсдолтой хүмүүсийн динамик мэдээ" Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны захиалгат судалгааны ажлын
12. ШУА, ЕБСБХүрээлэн."Попцляцийн генетикийн үндэс".УБ., 1977
13. ФСЭХ, НХХЯ, НҮБ-ийн Хүн амын сан."Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал". УБ.,2010
14. "Хууль дээдлэх ёс сэтгүүл". УБ.,2018
15. "Шихихутуг сэтгүүл".УБ.,2021

ЦАХИМ ХУУДАС:

www.moleg.go.kr

www.drze.de

<https://www.unesco.org/en>

<https://www.ncbi.nlm.nih.gov/>

<https://laws-lois.justice.gc.ca/>

www.ohchr.org

www.legislation.govt.nz

www.ncga.state.nc.us

www.agc.gov.my

www.boluathinhsu.com

www.irishstatutebook.ie

www.chanrobles.com

www.consultant.ru

www.law2byu.edu

www.justia.com

www/mn.wikipedia.org/

www.legalinfo.mn

www.lawforum.parliament.mn

www.1212.mn

Эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах эрх зүйн зохицуулалтын зарим асуудал



Шихихутуг их сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, докторант Э.Анхбаяр

Монгол улсын өнөөгийн болон ирээдүйн хөгжилд гол нөлөөлөх хүчин зүйлийн нэг бол монгол хүний эрүүл мэнд юм. Эрүүл биед саруул ухаан оршино. Эрүүл биетэй, саруул ухаантай монгол хүн л энэ улсаа хөгжүүлэн цэцэглүүлж, эмхлэн цэгцэлнэ. Өөрөөр хэлбэл "хөгжил нь хүний сайн сайхан амьдралын үндэс, хөгжлийн эх үүсвэр нь хүн өөрөө байдаг билээ"¹. Манай улсын хувьд "хүрээлэн буй орчны бохирдол, хүнсний баталгаагүй байдал, хүн амын хорт хавдар, зүрх судасны болон зарим төрлийн халдварт өвчин буурахгүй байна. Энэ бодит байдал нь хүний эрүүл аж төрөх эрхийн хэрэгжилт хангагдаж"² байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж байна.

Иймээс эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт, мөн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн өнөөгийн байдал нь хүн амын эрэлт хэрэгцээнд бүрэн нийцэж байна уу? гэсэн асуулт урган гарч байна.

Уг асуултад хариулахын тулд монгол хүний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах ойлголтын хүрээнд нэр томьёо болон эрх зүйн зохицуулалтуудыг судалж үзэхэд:

"Хүний эрх", «эрүүл мэнд»³, «эрүүл мэндийг хамгаалах»⁴, «эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ»⁵, "эрүүл мэндийн байгууллага" гэсэн нэр томьёо, ойлголтуудыг дурдаж болохоор байна.

"Хүний эрх /human rights/ нь хүний төртэй харьцах, түүний эдийн засгийн, нийгэмшлийн, улс төрийн, соёлын хүрээн дэх боломж ба шаардлагын эрх зүйн байдлыг тодорхойлсон ухагдахуун"⁶. "Хүний эрхийг хамгаалах үүрэг бол төрийн өөрийнх нь үүрэг"⁷ байдаг. Мөн

³ гэж хүн өвчин, эмгэггүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг хэлнэ.

⁴ гэж хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн анагаах ухаан, нийгэм, эдийн засгийн цогц арга хэмжээг хэлнэ.

⁵ <https://legalinfo.mn/mn/detail/49>

⁶ Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 2021 он., 575 дахь тал

⁷ Амарсанаа.Ж., Үндсэн хуулийн эхийг баригч., 1 дэвтэр., УБ., 2019 он., 215 дахь тал

¹ Хүн ам зүйн цонхны үе ба хөгжлийн бодлогын зарим асуудлууд., УБ., 2010 он., 8 дахь тал

² Монгол улсын төрийн бодлогын баримт бичгүүд: "Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр", УБ., 439 дэх тал

“хүний эрх гэдэг нь хэн боловч тухайн нийгмийнхээ бүхий л харилцаанд оролцож амьдрах боломж, нөхцөл юм. Энэхүү боломж, нөхцөлийг төрөөс бүрдүүлэх боловч хүн өөрөө эрүүл мэндээ хамгаалах үүрэгтэй”⁸ байна.

Эрүүл мэндийг хамгаалах / Health protection/ гэдэг нь хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн анагаах ухаан, нийгэм эдийн засгийн цогц арга хэмжээ юм. Харин “эрүүл мэндийн байгууллага /health organization/ гэж хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэг бүхий хуулийн этгээд”⁹ гэж тайлбарлажээ.

Эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах эрх зүйн зохицуулалтуудыг судалж үзвэл:

1992 оны Монгол улсын үндсэн хууль¹⁰, 2011 оны Эрүүл мэндийн тухай хууль¹¹, 2016 оны Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль¹²

⁸ Хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгаа: онол, практикийн асуудал, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал, УБ., 2018 он., 9 дэх тал

⁹ Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 2021 он., 619 дэх тал

¹⁰ “...эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно гэжээ.

¹¹ Энэ хуулийн зорилт нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

¹² Энэ хуулийн зорилт нь хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах, удирдах, санхүүжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

зэрэг байна. Өөрөөр хэлбэл “Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 6 дахь заалтын дагуу хүний эрүүл мэндийн тусламж авах эрхийг хангах үүргийг төрөөс хүлээсний хувьд Эрүүл мэндийн тухай болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, эрүүл мэндийн холбоотой хууль, хууль тогтоомжийн бусад актуудаар зохицуулан хэрэгжүүлж байна”¹³.

Иргэдийн үндсэн эрхийг хамгаалах асуудал тухайн эрхийг хүлээн зөвшөөрч, Үндсэн хуулиар баталгаажуулахаас эхэлнэ¹⁴. Үндсэн хуулиар тогтоосон эрхийг бодитой эдлүүлэх үндэслэл нь УИХ-аас хууль батлах, Засгийн газар батлагдсан хуулийг хэрэгжүүлснээр биеллээ олдог. Хүний үндсэн эрхийг дээдэлж, хамгаалах нь Үндсэн хуульд төрийн нэг гол үүрэг мөн¹⁵ билээ.

Хүний эрүүл мэндийг хамгаалах, гэмт халдлагаас хүнийг хамгаалах, гэнэтийн осол, аюулд орох нөхцөлийг арилгах зэрэг нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд тодорхой үүрэг хүлээж байгаа хэрэг юм¹⁶.

Эрүүл мэндийн хуулиар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхийг хангахад ААН, байгууллага, албан тушаалтан иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага,

¹³ Товуусүрэн.Ц., “Үндсэн хуулиа ойлгохуй”, Үндсэн хуулийн хялбаршуулсан тайлбар., УБ., 2017 он., 57 дахь тал

¹⁴ Эрх зүй /NUM LAW REVIEW/ сэтгүүл., цуврал 37., 2017 он., 47 дахь тал

¹⁵ Хууль дээдлэх ёс сэтгүүл., цуврал 69., дугаар 4., 2018 он., 24 дэх тал

¹⁶ Товуусүрэн.Ц., “Үндсэн хуулиа ойлгохуй”, Үндсэн хуулийн хялбаршуулсан тайлбар., УБ., 2017 он., 54 дэх тал

ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан¹⁷ байна.

“Эмнэлгийн төлбөргүй тусламж авах эрхийг эрүүл мэндийн холбогдолтой хууль, хууль тогтоомжийн актуудаар зохицуулан хэрэгжүүлдэг байна. Тухайлбал эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээ, сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн болон удаан хугацаанд нөхөн сэргээх эмчилгээ шаардах зарим эмнэлгийн эмчилгээ, халдвар судлалын үйлчилгээ, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх тарилга, халдварт өвчний голомтын ариутгал, жирэмсэн, төрөх, төрсний дараах үед эмнэлгийн заалтаар хийсэн үзлэг, шинжилгээ, эмчилгээ, байгалийн гамшиг, гэнэтийн осол, нийтийг хамарсан аюул бүхий халдварт өвчний дэгдэлтийн үед гэмтсэн, өвчилсөн хүний эмчилгээ, аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хүний амь нас аврахаар, эсхүл их хэмжээний хохирлоос сэргийлж яваад гэмтсэн өвчилсөн хүний эмчилгээг төрөөс хариуцан санхүүжүүлэхээр зохицуулжээ”¹⁸.

Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй холбон тайлбарлах шаардлага зайлшгүй урган гарна. Тухайлбал монгол улсын байгаль орчны хамгийн ноцтой асуудал нь агаарын бохирдол.

Их хэмжээний агаарын бохирдол

нь эрт нас баралтад хүргэдэг амьсгалын замын болон зүрх судасны өвчин үүсгэх аюултай тул хүний амьд явах, **эрүүл байх** эрхэд сөргөөр нөлөөлж байна¹⁹.

1992 онд батлагдсан “Монгол улсын үндсэн хууль-д: Монгол улсын иргэн ... эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, ... эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно, ... эрүүл мэндээ хамгаалах нь ... иргэн бүрийн журамт үүрэг мөн”²⁰ хэмээн тусгажээ. Монгол хүний **эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин**, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, **амьдрах орчин**, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн²¹ юм. Төрөөс иргэдийн эрх чөлөөг хангах чиг үүргийн гол зүйлийн нэг хүний **эрүүл мэндийг хамгаалах** явдал.

Хүн бүр хаана ч, хэзээ ч эрхээ мэдэж, шаардаж чаддаг, баталгаатай эдлэх нөхцөл бүрдсэн тэрхүү нийгмийг бий болгох нь төрийн эрхэм зорилго байх ёстой²². Хүний эрхийн заалтуудыг хэрэгжүүлэх асуудал дэлхийн улсуудын хувьд өнөөдрийг хүртэл маргаантай хэвээр байна. Монгол

¹⁹ Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол улс, 2 дугаар боть, УБ., 2021 он., 891 дэх тал

²⁰ <https://moh.gov.mn/p/5>

²¹ Болдбаатар Ж., Лүндэжжанцан Д., Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал., УБ., 2021 он., 378 дахь тал

²² Хүний эрхийн цуврал нийтлэл., 2014 он., 5 дахь тал

¹⁷ Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 2021 он., 619 дэх тал

¹⁸ Товуусүрэн.Ц., “Үндсэн хуулиа ойлгохуй”, Үндсэн хуулийн хялбаршуулсан тайлбар., УБ., 2017 он., 57 дахь тал

улсын хувьд ч эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх бодитоор хамгаалах хэрэгжүүлэх асуудал тунхаглалын шинжтэй байна²³.

Орчны эрүүл мэнд нь дэлхий дахинаа нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болсоор байна²⁴. Жил бүр дэлхий дахинд бүртгэгдсэн нийт нас баралтын 4 тохиолдол бүрийн 1 нь хүрээлэн байгаа орчны бохирдол болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой өвчний улмаас нас барсан байна. Орчны бохирдол жилээс жилд нэмэгдэж өнөөгийн байдлаар Улаанбаатар хотын хүн амын 59.1 хувь нь гэр хороололд суурьшиж, нийслэлийн нийт ерхийн дийлэнх хувь нь төвлөрсөн ус, дулааны хангамжид холбогдоогүй, автомашины тоо жил тутам өсөж байгаа зэрэг нь агаарын бохирдлыг нэмэгдүүлж байна. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотын гэр хорооллын хүн амын хэт нягтрал, суурьшлаас хамааран хөрс, газрын гүний усны бохирдол өндөр, ундны усыг зориулалтын бус саванд хадгалж байгаа зэрэг нь усны чанар, аюулгүй байдлыг алдагдуулж улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

“Улаанбаатар хотын агаар дахь тоосонцрын (PM 2.5) агууламжийн жилийн дундаж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Агаарын чанарын зөвлөмжид заасан хэмжээнээс 20 дахин их байгаа нь 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын өвчний шалтгаант

нас баралтыг 33 хувиар, насанд хүрэгчдийн уушгины архаг бөглөрлийн шалтгаант нас баралтыг 19 хувиар, зүрхний шигдээсний шалтгаант нас баралтыг 27 хувиар, уушгины хавдрын шалтгаант нас баралтыг 24 хувиар тус тус нэмэгдүүлж байгааг судалгаагаар тогтоосон байна”²⁵. Хотжилттой холбоотойгоор хүн ам хэт шигүү суурьшсанаар хүн амын өвчлөл нэмэгдэж байгаа бөгөөд өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болох амьсгалын тогтолцооны өвчин хотод 10000 хүн амд 1730.3, хөдөөд 1450.6, зүрх судасны тогтолцооны өвчин хотод 980.4, хөдөөд 932.0, гэмтэл, хордлого болон гадны шалтгаант бусад тодорхой эмгэг хотод 916.2, хөдөөд 268.0 ногдож байна²⁶ гэсэн судалгаа гарсан байна.

Түүнчлэн мэргэжлийн хяналтын ерөнхий газрын судалгаанаас үзэхэд Улаанбаатар хот хамгийн их бохирдолтой байгаа бөгөөд үүний дийлэнх хэсгийг байнгын ажиллагаатай гурван цахилгаан станц, гэр хороололд хэрэглэгдэж буй 160000 орчим ердийн галлагаатай зуух, 120000 орчим тээврийн хэрэгсэл, 1500 орчим дунд болон бага оврын нам даралтын халаалтын зуух, нарийн шороо, ил хог хаягдлаас үүссэн их хэмжээний тоосонцор зэргээс агаарт 260000 гаруй тонн хорт бодис цацагдаж иргэдийг хордуулж байна²⁷ гэсэн дүгнэлт хийсэн байна.

²³ Эрх зүй /NUM LAW REVIEW/ сэтгүүл., цуврал 37., 2017 он., 33 дахь тал

²⁴ Засгийн газрын 2017 оны 225 дугаар тогтоолын хавсралт “Орчны эрүүл мэнд” Үндэсний хөтөлбөр

²⁵ Засгийн газрын 2017 оны 225 дугаар тогтоолын хавсралт “Орчны эрүүл мэнд” Үндэсний хөтөлбөр

²⁶ Засгийн газрын 2015 оны 4 дүгээр тогтоолын хавсралт “Хотжилт ба эрүүл мэнд” Үндэсний хөтөлбөр

²⁷ Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол улс., 2 дугаар боть., УБ., 2021 он., 582 дахь тал

Агаарын бохирдлыг багасгах зорилгоор 2006 оноос жилд улсын болон орон нутгийн төсвөөс 2-3 тэрбум төгрөг зарцуулж утаагүй зуух, шахмал түлшний үйлдвэрийг дэмжих, орон сууцны барилгын асуудлыг нэмэгдүүлэх. “Ногоон хэрэм” хөтөлбөр хэрэгжүүлэх гэх мэт олон арга хэмжээ авсан ч үр дүн нь хангалтгүй байна. Сүүлийн жилүүдэд манай оронд хотжилт, бүтээн байгуулалт, үйлдвэржилт, техник, технологийн дэвшилтэд суурилсан нийгэм, эдийн засгийн байдал сайжирч байгаа хэдий ч нөгөө талаас түүнийг дагасан шилжилт хөдөлгөөн, орчны бохирдол ихсэж, улмаар хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдсээр байна.

“Хүний эрх нь бүх хүнд байх бөгөөд тухайн хүний хаана амьдарч байгаа эсэхээс үл хамааран тухайн аль нэг улсын иргэн мөн эсэхийг үл хамааран төрөхөөс нь нэгэн адил заяагдмал байдаг”²⁸ бөгөөд “...хуулиуд нь бүх тогтолцоогоороо хүний эрх, эрх чөлөөг хангах зорилгод л эцсийн дүндээ үйлчилж байдаг”²⁹. Иймээс монгол хүн хаана амьдарч байгаа эсэхээс үл хамааран эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээр хангагдах ёстой.

Улаанбаатар хотод амьдарч байгаа иргэдийн хувьд эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах эрх зүйн зохицуулалтууд

²⁸ Хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгаа: онол, практикийн асуудал., Олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал., УБ., 2018 он., 9 дэх тал

²⁹ Болдбаатар.Ж., Лүндээжанцан.Д., Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал., УБ., 2021 он., 377 дахь тал

байгаа боловч хэрэгжилт нь хангалтгүй байна гэсэн дүгнэлт хийлээ.

Эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн талаарх эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд хүн өөрөө эрүүл мэндээ анхаарч, өвчнөөс урьдчилан сэргийлэх, гаж зуршлаас ангид байх, татгалзах боловсрол дадалтай болох нь тодорхой хэмжээнд нөлөөлнө гэдгийг дурдах нь зөв болов уу.

Эрүүл урт насалъя, төрийн эрүүл мэндийн бодлогыг дэмжье, эрүүл мэндийг хамгаалахад гарах зардлыг хэмнээ, хамгийн гол нь өөрөө үр хүүхдэдээ дараа болохгүй, нэмэр болохоор чанартай урт насалъя гэсэн чин хүсэлтэй бол эрүүл мэндийн иж бүрэн шинжилгээнд жилд 1-2 удаа хамрагдаж, сайн чанарын эрүүл хүнс хоол, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн хэрэглэж, нас биеийнхээ онцлогт тохирсон хөдөлгөөнтэй байж, сэтгэл санааны амар амгалан байдлаа хадгалахыг эрхэмлэж, ***эрүүл мэндээ өөрөө хамгаалах*** нь чухал³⁰ байна. Иймээс хүн амд, ялангуяа цэцэрлэг, ерөнхий боловсролын болон их дээд, сургууль, коллежид суралцагчдад эрүүл мэндийн мэдлэг олгох, ухуулга нөлөөлөл, мэдээлэл сурталчилгаа хийх, иргэдийн эрүүл мэндийн талаарх хүчин чармайлтыг дэмжих, урамшуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, хүн амын ёс заншилд тохирсон уламжлалт анагаах ухааны аргыг ашиглан өвчнөөс урьдчилан сэргийлэх,

³⁰ Товуусүрэн.Ц., “Үндсэн хуулиа ойлгохуй”, Үндсэн хуулийн хялбаршуулсан тайлбар., УБ., 2017 он., 57 дахь тал

эрүүл зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэх механизмыг бүрдүүлмээр байна.

Аливаа төрийн туйлын зорилго нь бүх нийтийн ашиг сонирхлыг хамгаалах явдал³¹ байдаг. Энэ зорилгын хүрээнд нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааг зөвхөн өвчин эмгэгийг эрт илрүүлэх, төгс эмчлэх төдийгүй, эрүүл хүнд хандуулах, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, гэр бүл, хамт олны идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх зорилготой байгааг анхаарах хэрэгтэй байна. Түүнчлэн нийгмийн эрүүл мэндийн асуудлаар салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн, гэр бүл, хамт олны оролцоонд тулгуурлан сайн түншлэлийг хөгжүүлэх, "мэдээлэл солилцох үйл ажиллагааны уялдаа холбоо, шуурхай байдлыг сайжруулан эмнэлгийн тусламж, үйлчилгээний чирэгдлийг бууруулах"³² бодлогын хэрэгжилтийг хангах механизм, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна. Ингэхдээ нийгмийн эрүүл мэндийг төлөвшүүлэхэд нийгмийн нөөц, бололцоог зүй зохистой ашиглах, түүнчлэн нийгмийн эрүүл мэндийн сургалтын төв, сургууль байгуулж, үндэсний боловсон

хүчин бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах тогтолцоог бий болгож, сургалтыг боловсролын талаарх төрийн бодлоготой уялдуулж зохион байгуулах³³, хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх албан болон албан бус сургалтыг зохион байгуулах, түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох гэсэн төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлоготой уялдуулах хэрэгтэй байна.

Өмнөх тогтолцооны үед хүн амын эрүүлийг хамгаалах асуудлыг төр дангаар хариуцан санхүүжүүлж байсан бол шинэ Үндсэн хуулийн дагуу хүний эрүүл мэндийн асуудлыг төр, ажил олгогч, ажиллаж байгаа хүн аль аль нь хувь оролцож санхүүгийн эх үүсвэрийг нь бүрдүүлдэг эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд шилжснийг³⁴ дурдах нь зүйтэй.

Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцаа³⁵, хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах, удирдах, санхүүжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хуулиар зохицуулдаг³⁶ байна.

³¹ Лүндээжанцан Д., Жалбажав Н., Сэлэнгэ Х., Отгонтуяа Д., Эрх зүйн философи., УБ., 2014 он., 150 дахь тал

³² Монгол Улсын засгийн газрын 24 дүгээр тогтоол., "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого"

³³ Монгол улсын төрийн бодлогын баримт бичгүүд: "Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого", УБ., 132 дэх тал

³⁴ Товуусүрэн Ц., "Үндсэн хуулиа ойлгохуй", Үндсэн хуулийн хялбаршуулсан тайлбар., УБ., 2017 он., 57 дахь тал

³⁵ <https://legalinfo.mn/mn/detail/49>

³⁶ <https://legalinfo.mn/mn/detail/11929>

Дэлхий дахины эрүүл мэндийн тогтолцооны өөрчлөлт, шинэчлэл нь орон бүрт өөрийн гэсэн зорилт, чиглэлтэй, ялгарах онцлогтой байдаг боловч хоёр зүйл дээр бүгд санаа нэгдэж байна. Энэ нь улсын төсөв дангаараа юм уу, хувь хүн дангаараа орчин үеийн эрүүл мэндийн зардлыг дийлэхгүй болсон, Төсвөөс эрүүл мэндэд зориулах зардал нь аль болох бага зардлаар хамгийн олон хүний эрүүл мэндийг хамгаалах, өөрөөр хэлбэл өвчлүүлэхгүй байхад зориулагдах ёстой гэсэн дүгнэлт хийсэн байна³⁷. Эдгээр бэрхшээлийг арилгах зөв бодлогыг тодорхойлж, хөрөнгө хүчийг төвлөрүүлэн ажиллах дэс дараатай арга хэмжээг хэрэгжүүлэх, агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд болон эрүүл мэндийн салбарт учруулж байгаа санхүүгийн дарамт, эдийн засгийн хохирлын тооцоог үндэсний түвшинд хийх хэрэгтэй байна. Хүн амын суурьшил, нягтрал, хот төлөвлөлтөд хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тооцох, эрүүл ахуйн хэм хэмжээ, стандартад нийцүүлэн эрх зүйн орчинг боловсронгуй болгох³⁸ бодлогыг хэрэгжүүлэх, түүний чиглэлүүдийг нэг бүрчлэн зааж өгөх нь зүйтэй байна.

Эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах талаарх олон улсын гэрээний зохицуулалтуудыг судалж үзвэл:

Хүний эрхийн олон улсын хэд хэдэн баримт бичиг /1948 оны

³⁷ <https://moh.gov.mn/p/5>

³⁸ Монгол улсын төрийн бодлогын баримт бичгүүд.. 2011 он., УБ., 131 дэх тал

хүний эрхийн түгээмэл тунхаглал³⁹, 1966 оны хүний эрхийн тухай олон улсын пакт⁴⁰/ байна. Манай улсын хувьд Үндсэн хууль ба бусад хуульд бататган бэхжүүлжээ. Мөн өнөө үед олон улсын эрх зүйд хүний эрхэд зориулсан олон улсын хүмүүнлэгийн эрх зүй хэмээх салбар буй болж⁴¹ байгааг дурдаж болно.

Монгол улсын хувьд **эрүүл мэндээ хамгаалуулах эрх** /право на охрану здоровья/ нь үндсэн хуулиар тогтоосон, иргэний нийгэмшлийн үндсэн эрхийн нэг бөгөөд Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйлд:

"1 Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн бие бялдрын болон сэтгэцийн эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрхийг хүлээн зөвшөөрнө. 2 Энэхүү Пактад оролцогч улсууд энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах дараах арга хэмжээг авна:

(а) нялхсын эндэгдлийг багасгах, хүүхдийн эрүүл чийрэг өсөлтийг хангах;

(б) гадаад орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйг бүх талаар сайжруулах;

(с) халдварт өвчин, тухайн нутгийн өвчин, мэргэжлийн болон бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, тийм өвчинтэй тэмцэх;

(d) өвчилсөн тохиолдолд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, сувилах нөхцөлийг бүгдэд бий болгох" гэж заасан эрх. Уг эрхийг

³⁹ <https://legalinfo.mn/mn/detail/1271>

⁴⁰ Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"

⁴¹ Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 2021 он., 575 дахь тал

Монгол улсын үндсэн хуулийн 16/6/ дугаар зүйлд "эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй, иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно" хэмээн бэхжүүлсэн. Энэ эрх зүйн зохицуулалт нь хүн амын эрүүл мэндийн даатгалыг хөгжүүлэх талаар нийтлэг арга хэмжээ авах, бие тамир спортыг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх, хүн амыг экологийн ба ариун цэвэр, эрүүл ахуйн таатай нөхцөлөөр хангах талаар төрөөс хүлээх үүргийг буй болгожээ⁴².

Хүний эрхийг олон улсын жишигт нийцүүлэн томъёолж, түүний хэрэгжилтийг хангах нь төрийн нэн тэргүүний үүрэг гэдгийг тодорхойлсон билээ⁴³. Үүний хүрээнд "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"-ыг дурдаж болно. Энэхүү Пактад оролцогч улс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэмд тунхагласан⁴⁴ зарчмын дагуу хүн төрөлхтний ам бүлийн гишүүн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөн болохыг анхааралдаа авч, эдгээр эрх нь хүнд угаас заяасан нэр төрөөс үүдэн гарч байгааг хүлээн зөвшөөрч, Хүний эрхийн түгээмэл Тунхаглалд⁴⁵ зааснаар хүн бүр эдийн

засаг, нийгэм, соёлын эрхээ улс төр, иргэнийхээ эрхийн адил эдлэх нөхцөлөөр гагцхүү хангагдаж байж л улс төр, иргэний эрх чөлөөгөө эдэлж, айх аюулгүй, гачигдах зовлонгүй байх чөлөөт бие хүний эрхэм зорилго биелэгдэхийг хүлээн зөвшөөрч, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм ёсоор улс гүрэн хүний эрх, эрх чөлөөг бүх нийтээр хүндэтгэн сахих явдлыг хөхүүлэн дэмжих үүрэгтэйг анхааралдаа авч, хувь хүн бүр бусад хүн болон хамт олныхоо өмнө үүрэг хүлээхийн сацуу энэхүү Пактад хүлээн зөвшөөрсөн эрхийг хөхүүлэн дэмжих, сахиулах талаар чармайх ёстойг анхааралдаа авч, дор дурдсан зүйлийг тохиролцов⁴⁶: гээд

"...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах"⁴⁷ хэмээн тунхагласан байна. Ийнхүү тунхагласан боловч "...хүний эрхийг хуульчлах, олон улсын гэрээнд нэгдэж орох нь хүний эрхийн хууль зүйн баталгаа бүрэн хангагдсан гэсэн үг биш"⁴⁸ гэдгийг дурдах нь зөв болов уу

Монгол улсын хувьд хүний эрхэмсэг оршихуй, үнэт зүйлсийг хүндэтгэн үздэг. Ийм ч учраас хүн

217/А/III
тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ.

⁴⁶ Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"

⁴⁷ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 19 дүгээр зүйл

⁴⁸ Хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгаа: онол, практикийн асуудал., Олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал., УБ., 2018 он., 9 дэх тал

⁴² Нарангэрэл.С., Эрх зүйн эх толь бичиг, УБ., 2011 он., 583 дахь тал

⁴³ Хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгаа: онол, практикийн асуудал., Олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал., УБ., 2018 он., 9 дэх тал

⁴⁴ Хүний эрхийн тунхаглалыг ёс зүйн шаардлагуудын ойлгомжтой тодорхойлолт гэж үзэх нь зөв.

⁴⁵ Хүний эрхийн түгээмэл тунхаглал., Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн

бүр ямар нэг алагчлалгүйгээр өөрийн салшгүй эрх, эрх чөлөөгөө эдлэх тэр боломжийг нь бүрдүүлж өгөх үндсэн үүргийг гүнээ ухамсарлаж, хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг⁴⁹ билээ. Ромын эзэн хаан /482-565/ Юстиниан: "Шударга ёс гэдэг бол хүн бүрд зохих ёсоор хандах байнгын, мөнхийн хүсэл юм"⁵⁰ гэжээ. Иймээс эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хүн бүрт ямар нэг алагчлалгүйгээр эдлэх тэр боломжийг эрүүл мэндийн талаар баримталж байгаа бодлогодоо тусгаж өгөх нь зүйтэй байна.

Аливаа хөгжлийн бодлогыг хүний эрхийн үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн тодорхойлох, хэрэгжүүлэх ба үнэлэх хандлага НҮБ болоод түүний системийн байгууллагууд, олон улсын төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, хөгжлийн хөтөлбөрүүдийн нэгэн зайлшгүй элемент болсон⁵¹ байдгийг анхаарах хэрэгтэй.

Хүний эрхийг хүлээн зөвшөөрөх, хуульчлах, олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орон нь асуудлын зөвхөн нэг тал бөгөөд хамгийн чухал, хамгийн төвөгтэй нь хамгийн хүнд ажил нь тэдгээр эрхийг хүн бүр баталгаатай эдлэх эдийн засаг, нийгэм, улс төр, хууль зүйн баталгааг бүрдүүлэх, зөрчигдсөн тохиолдолд эрхийг

сэргээж, хохирлыг бүрэн барагдуулах явдал юм⁵².

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн талаар хэрхэн тусгасныг судалж үзэхэд:

2010 онд батлагдсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд: "Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ"⁵³ гээд

Монгол Улсын

- оршин тогтнохуйн аюулгүй байдал
- эдийн засгийн аюулгүй байдал
- дотоод аюулгүй байдал
- **хүний аюулгүй байдал**
- хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал
- мэдээллийн аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна⁵⁴ гэжээ.

Мөн **хүний эрх**, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн⁵⁵ хэмээн тусгасан боловч хурдтай хувиран өөрчлөгдөж байгаа аюулгүй байдлын орчинд

⁴⁹ Хүний эрхийн олон улсын гэрээ буюу Монгол улс., 2 дугаар боть., УБ., 2021 он., 561 дэх тал

⁵⁰ "Хууль", Монсудар хэвлэлийн газар., УБ., 2021 он., 61 дэх тал

⁵¹ "Хүний эрх" Улирал тутмын сэтгүүл., 2005/3., 24 дэх тал

⁵² Хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгаа: онол, практикийн асуудал., Олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал., УБ., 2018 он., 9 дэх тал

⁵³ <https://mfa.gov.mn/documentation/55630>

⁵⁴ Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим

⁵⁵ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

үндэсний ашиг сонирхлоо тууштай хамгаалах, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа бататгахын тулд үндэсний аюулгүй байдлыг хангах, **эрүүл мэндээ хамгаалуулах эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах** тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлэх шаардлага байна.

Дээрхээс дүгнэхэд Монгол улсын Үндсэн хуульдаа хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй болохыг тодорхойлсон. Үндсэн хуулийн энэ эрхийг хангах зорилгоор монгол улс иргэдийнхээ эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг улам бүр баталгаажуулах үүднээс олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд нэгдэн орох түүнчлэн дотоодын хууль, тогтоомж, төрийн бодлогодоо тусган хэрэгжүүлэх арга хэмжээг авч байгаа боловч хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн зохицуулалт дутуу, хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Үүнд маш олон хүчин зүйл нөлөөлж байна. Дээр дурдсан хүчин зүйлээс гадна уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, усны нөөцийн хомстол, химийн бодисын зохисгүй хэрэглээ, аюултай хог хаягдал, агаар, хөрс болон усны бохирдол зэрэг тулгамдсан асуудлууд байна.

Тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд эрүүл мэндийн талаарх асуудлыг бусад салбарын бодлогод тусган уялдуулж, нэгдсэн зохицуулалттайгаар хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх нь зүйтэй

байна. Ингэснээр хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах боломж бүрдэнэ.

Эрх зүйд нийцэж, эрх зүйг тодорхойлж, эрх зүйг дагадаг зүйл л шударга байна. Үйл ажиллагааг шударгаар явуулна гэдэг бол түүнийг эрх зүйн дагуу, эрх зүйн түгээмэл, тэгш шаардлагуудад нийцүүлнэ гэсэн үг юм⁵⁶ өөрөөр хэлбэл: *хууль тогтвортой үйлчилдэг, төрийн байгууллага, албан тушаалтан хэлбэрэлтгүй хэрэгжүүлдэг, иргэд нь дагаж мөрддөг нийгмийн харилцаа төлөвшсөн нөхцөлд хүний эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн баталгааг бүрэн хангалаа гэж үзэж болно*⁵⁷.

Мөн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн өнөөгийн байдлыг хүн амын эрэлт хэрэгцээнд бүрэн нийцүүлэхийн тулд эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах эрх зүйн зохицуулалтуудыг боловсронгуй болгоод зогсохгүй, эрүүл мэндийн байгууллага, түүний үйл ажиллагааны талаар судалж, үнэлэлт дүгнэлт хийх зайлшгүй шаардлага урган гарна.

Уг асуултад хариулахын тулд эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах төрийн зорилгыг хэрэгжүүлэх эрүүл мэндийн байгууллага, түүний түүхэн замнал, үйл ажиллагааны

⁵⁶ Лүндээжанцан Д., Жалбажав Н., Сэлэнгэ Х., Отгонтуяа Д., Эрх зүйн философи., УБ., 2014 он., 49 дэх тал

⁵⁷ Хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгаа: онол, практикийн асуудал., Олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал., УБ., 2018 он., 10 дахь тал

онцлог, чиг үүрэг, зорилт, бүтэц зохион байгуулалт зэргийг маш товчхон судалж үзвэл:

Эрүүл мэндийн байгууллага гэж /health organization/ гэж хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэг бүхий хуулийн этгээд⁵⁸ юм.

Монгол улсад шинжлэх ухааны эмнэлэгт тулгуурласан эрүүл мэндийн албаны үүсэл, хөгжил, түүхэн замналыг:

- 1921-1940 оны үе буюу БНМАУ-д орчин цагийн анагаах ухаанд суурилсан эрүүл мэндийн албыг бүрдүүлж эхэлсэн үе,
- 1941-1990 оны үе буюу Социалист эрүүлийг хамгаалах номлолоор замнасан үе
- 1991 оноос одоог хүртэлх үе буюу Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үеийн эрүүл мэндийн албаны хөгжил гэсэн гурван томхон үе болгон авч үзэж болохоор байна.

Одоо улсын хэмжээгээр эрүүл мэндийн 1500 шахам байгууллага ажиллаж байгаагаас төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг болон төв 15, нэгдсэн эмнэлэг 32, сум дундын эмнэлэг 13, хөдөөгийн буюу сумын эмнэлэг 334, ерхийн эмнэлэг 178, эрүүл мэндийн төв 12, БГХӨЭСТ-13, хувийн эмнэлэг 466, түргэн тусламжийн станц 35, цусны төв ба станц 26, эмийн сан 319 тус тус ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарт 6162 их эмч, эмнэлгийн тусгай дунд боловсролтой 13185 мэргэжилтэн, нийтдээ 30000 шахам хүн ажиллаж, эмнэлгийн 17877 ор

бүхий хүчин чадалтай боллоо⁵⁹ гэсэн судалгаа гарсан байна. Үүнээс харахад эрүүл мэндийн байгууллага нь 100 жилийн түүхтэй, төрөлжсөн болон нарийн мэргэжлийн, нэгдсэн, ерхийн гэх мэт эмнэлгүүдтэй байхын зэрэгцээ мянга, мянгаар тоологдох эмч, ажилтантай гэсэн судалгаа байгаа боловч хүн амын эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чаддахгүй байна. Иймээс эмч, эмнэлгийн мэргэжилтэн нэмж бэлтгэх, тэдгээрийн мэргэжил мэргэшлийг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог сайжруулах, мөн байгууллага, хамт олон, хувь хүний зүгээс нийгмийн болон хувийн **эрүүл мэндээ** ухамсартайгаар хамгаалах хөшүүрэг болж чадахгүйц эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй байна.

Монгол хүний эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, Нэгдсэн Үндэстний Байгууллагын тогтвортой хөгжлийн зорилт, "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн салбарын удирдлагын чадавхыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйлжиллагааг боловсронгуй болгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нийт хүн амд хүргэх, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажилладаг байгууллага бол эрүүл мэндийн яам юм. Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн яам нь эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийг **хэрэгжүүлэх** үүрэг хүлээдэг⁶⁰.

⁵⁸ Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 2021 он., 619 дэх тал

⁵⁹ <https://moh.gov.mn/p/5>

⁶⁰ Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол улс.,

Түүнчлэн эрүүл мэндийн яам нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэн бүрт чанартай, аюулгүй хүртээмжтэй хүргэж, амьдралын чанарыг сайжруулснаар хүн амын дундаж наслалтыг уртасгах зорилттой ажилладаг байна. Тухайлбал энэ зорилтынхоо хүрээнд “монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг хангаж, дундаж наслалтыг 78-д хүргэнэ”⁶¹ гэсэн зорилт дэвшүүлснийг дурдаж болно.

Дээрхээс харахад эрүүл мэндийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн захиргааны байгууллагын эрх мэдэл, үүрэг, хариуцлагыг өргөжүүлж, удирдлагын төвлөрлийг сааруулах, эрүүл мэндийн талаар төрөөс баримталж байгаа бодлогод нийцүүлэн нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна. Ингэхдээ төрөөс бодлогын хүрээнд эрүүл мэндийн байгууллагыг шинээр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэхдээ хүн амын тоо, газар зүйн байршил, нутаг дэвсгэрийн онцлог, эрүүл мэндийн эрэлт хэрэгцээний үнэлгээ, судалгаанд тулгуурлан зохион байгуулах нь зүйтэй байна.

2 дугаар боть., УБ., 2021 он., 563 дахь тал

⁶¹ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хэвсралт “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”

ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



Өмгөөллийн "Монгол Элч
консалтинг" ХХН-ийн гишүүн,
өмгөөлөгч /LL.M/
Ч.Жадамба



СЭЗИС-ийн багш, өмгөөлөгч /LL.M/
Э.Гэрэл

Удиртгал

Мэдээллийн эрин зууны гайхамшиг, мэдлэгт тулгуурласан нийгмийн үсрэнгүй хөгжил эдүгээ хүний оюун ухаан, мэдлэгийн оргил нь болж байна. Энэ цаг үе дор хүн бүр чөлөөтэй сэтгэж, чөлөөтэй туурвих эрх нь нээлттэй болсон манай орны хувьд оюуны хөдөлмөрийн үнэлэмжийг эрс дээшлүүлж, оюуны бүтээлд хандах нийгмийн хандлагыг үндсээр нь өөрчилж, оюуны өмчийн эрхийн баталгаажуулалтыг улам дархлаатай болгох нь нэн чухал. Иргэн бүр өөрийн энэ дуусашгүй, дундаршгүй бүтээлч хөдөлмөрийнхөө үр шимийг зохих ёсоор хүртэж, үнэ цэнийг жинхэнэ утгаар нь мэдэрч, тууштай хамгаалж чаддаг, төр засаг нь иргэдийнхээ энэ бололцоог, энэ эрхийг нь бүх талаар хангаж өгөх явдал нэн чухал юм.

Ингэж байж оюуны өмч нь улс орны болоод бүтээл туурвигчийн өөрийнх нь хөгжлийн үндэс болж чадна.

Харин манай улсад оюуны өмч бүр улс орондоо болоод зохиогч, эрх эзэмшигчдээ үр шим, өгөөжөө бүрэн дүүрэн өгч чадаж байна уу? гэвэл хангалттай хэмжээнд байж чадахгүй байна. Зохиогч нь зохиогчийн эрхийн гэрчилгээгээ, эрх эзэмшигч нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварынхаа патент, барааны тэмдгийнхээ гэрчилгээг хавтаслаад шүүгээндээ хадгалдаг эсхүл жаазлаад хананд өлгөдөг нь явдал түгээмэл байна. Ийн хананд өлгөх бус харин эдийн засгийн эргэлтэд оруулж, үр шимийг хүртэх нь хамгаас чухал юм. Уул нь патент, гэрчилгээгээр хамгаалагдсан бүтээлээрээ хөрөнгийн баталгаа гаргах, хөрөнгө оруулах, түүнийгээ барьцаалах, худалдах, тодорхой хугацаагаар бусдад ашиглуулах, дуудлага худалдаан оруулах, компанийн дүрмийн сангаа

нэмэгдүүлэх зэрэг олон хэлбэрээр эдийн засгийн эргэлтэд оруулж, үр шимийг нь хүртэх боломж байдаг.

Иймд бидэнд оюуны өмчийн эрхээ эдийн засгийн эргэлтэд оруулж, үнэ цэнийг хэрхэн бий болгох вэ? Үр шимийг хэрхэн хүртэх вэ? гэсэн асуулт тулгарч ирсэн. Энэ нь манай улсын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд оюуны өмчийн тухай ойлголт, энэ талаарх мэдээлэл дутмаг, оюуны өмчийн ниймгийн үнэлэмж сул байгаагийн илрэл гэж дүгнэж болно. Оюуны өмчийн эрхээ эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд нэн тэргүүнд түүний үнэ цэнэ, зах зээлийн үнэлгээг бодитой тогтоох явдал хамгаас чухал тул энэхүү судалгааны ажлаараа оюуны өмчийн үнэлгээний хууль, эрх зүйн орчныг судлахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Оюуны өмч, зохиогчийн эрх, аж үйлдвэрийн өмч, оюуны өмчийн эрх, биет бус хөрөнгө, үнэлгээний хандлага, арга

Нэг. Оюуны өмчийн тухай ойлголт, оюуны өмчийн эрх

Оюуны өмч гэсэн ойлголтыг анхлан 1845 оны 10 дугаар сард АНУ-ын Массачусетсын тойргын шүүх Дэволл боло Брауны хооронд үүссэн патентын хэргийг хэлэлцэх үеэр албан ёсоор хэрэглэсэн байдаг.¹ Чарльз Л.Вудбюри шүүгч шүүхийн шийдвэрийн үндэслэлдээ "хэн нэгэн улаан буудай тарьж түүнийг ургуулдаг шиг хүний ашиг сонирхол, оюуны хөдөлмөр гэх мэт оюуны өмчийг бид мөн адил энэ арга замаар хамгаалж чадах байна. ..."

¹ Жадамба Ч. "Интернет дэх зохиогчийн эрхийн асуудал". Эрх зүй сэтгүүл. 2013 он. №1(23) 47 дахь тал

хэмээн үзжээ. Мөн энэхүү ойлголтыг Европт анхлан түгээн дэлгэрүүлсэн хүн бол Францын зохиолч А.Нион, тэрээр 1845 онд хэвлэгдсэн "Droits Civils Des Auteurs, Artistes Et Inventeurs" буюу "Зохиолч, зураач, зохион бүтээгч зэрэг иргэдийн хууль ёсны эрх" хэмээх бүтээлдээ оюуны өмч гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна.

Манай улсад 1990-ээд оноос ардчилал, зах зээлийн нийгэмд шилжсэн үеэс эхлэн оюуны өмчийн хамгаалалт жинхэнэ утгаар хөгжих болсон. Энэ цаг үеэс өмнө оюуны өмч нь төрийн өмч байж, зохиогч нь бүтээлийнхээ хувьд зөвхөн эд хөрөнгийн бус эрхийг эдэлж, бүтээл туурвисныхаа төлөө шагнал, урамшуулал авдаг байв. Хэдий шинэ бүтээл, оновчтой санал, зохиогчийн эрх, барааны тэмдэг, гарлын заалт гэсэн нэр томъёо, ойлголт байсан ч энэ нь оюуны өмчийн жинхэнэ утгыг агуулдаггүй, зөвхөн шинэ санаачлагыг дэмжин урамшуулах зорилгоор шинэ зүйл санаачлагч, бүтээгчдэд шагнал олгох төдийхнөөр хязгаарлагдаж байсан.

Харин 1992 оны шинэ Үндсэн хуулийн Долдугаар зүйлийн 1-д "Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.", мөн зүйлийн 2-т "Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн.", Арван зургадугаар зүйлийн 8-д Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөг хуульчлахдаа "соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих,

үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална” гэж тус тус заасан нь манай улсын нэгдэн орон олон улсын гэрээ, конвенцод бүрнээ нийцсэн.

Манай улс 1979 онд гишүүнээр элссэн Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын тухай конвенцод “оюуны өмч” гэх ойлголтод багтах объектын талаар авч үзсэн нь олон улсын түвшинд анх удаа оюуны өмчийн агуулгыг тодорхойлсон чухал заалт болсон юм. Уг конвенцийн 2 (VIII) зүйлд “Оюуны өмч” нь:

1. Шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээл,
2. Уран бүтээлчдийн тоглолт, дуу авианы бичлэг, шугамаар нэвтрүүлэх,
3. Хүний хэрэгцээний салбар дахь шинэ бүтээл,
4. Шинжлэх ухааны нээлт,
5. Бүтээгдэхүүний загвар,
6. Барааны тэмдэг, үйлчилгээний тэмдэг, худалдааны нэр, илэрхийлэл,
7. Шударга бус өрсөлдөөнийг хамгаалах болон үйлдвэрлэл шинжлэх ухаан, уран зохиол, уран сайхны салбарт оюуны хөдөлмөрийн үр дүнд бий бусад зүйлд хамаарах эрхийн агуулга гэж заажээ.

Манай улсад оюуны өмчийн харилцааг Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль (2006.01.19), Патентийн тухай хууль (2006.01.19), Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай (2010.06.10), Инновацийн тухай (2012.05.22) болон Технологи дамжуулах тухай хууль (1998.05.07)-аар тус тус

зохицуулж ирсэн. Оюуны өмчийн салбарт мөрдөгдөж байгаа дээрх хуулиуд нь оюуны өмчийг төрөөс хамгаалах харилцааг голчлон зохицуулдаг ч хамгаалагдсан оюуны өмчийг хэрхэн эдийн засгийн эргэлтэд оруулж, үр шимийг нь хүртэх харилцааг хангалттай зохицуулж чадаагүй гэхэд болно.

Иймд оюуны өмч бүтээхийг урамшуулах, хамгаалах, түүний үнэлэмжийг өсгөж, эдийн засгийн эргэлтэд оруулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн Байнгийн хорооны анхны хэлэлцүүлгээр хуулийн төслийн нэрийг “Оюуны өмчийн тухай” гэж өөрчлөн, 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Оюуны өмчийн тухай хуулийг баталсан байдаг. Уг хууль 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхлээд байна.

Тус хуульд тодорхойлсноор “оюуны өмч” гэх ойлголтод оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон зохиогчийн эрхийн бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объект болон аж үйлдвэрийг өмчийг хамруулж авч үзсэн. Үүнээс үзвэл, оюуны өмч нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх, аж үйлдвэрийн өмчийн эрх гэсэн хоёр салбарт хуваагдах ба, салбар бүрээр авч үзвэл:

Хүснэгт-1

ОЮУНЫ ӨМЧ

ЗОХИОГЧИЙН ЭРХ	АЖ ҮЙЛДВЭРИЙН ӨМЧ
<ul style="list-style-type: none"> • Шинжлэх ухаан, утга зохиолын бичмэл буюу аман бүх төрлийн бүтээл, компьютерийн программ, • Хөгжмийн болон бүжгийн урлагийн бүтээл, • Чимэглэх болон хавсарга урлаг, тайз чимэглэл, дүрслэх урлагийн бүтээл • Архитектурын бүтээл, уран баримал, уран барилга, • Жүжиг, хөгжимт жүжиг, тайзны урлагийн бүтээл, • Гэрэл зураг, дуу авиа бүхий дүрст бүтээл, • Үүсмэл бүтээл гэх мэт 	<ul style="list-style-type: none"> • Шинэ бүтээл¹ • Бүтээгдэхүүний загвар² • Ашигтай загвар³ • Барааны тэмдэг⁴ • Газар зүйн заалт⁵


Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх нь тухайн бүтээлийг бодитойгоор туурвиж, бодит хэлбэрт орсон үеэс (бүртгэл шаардахгүй) үүсдэг бол аж үйлдвэрийн өмчийн эрх нь оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (Оюуны өмчийн газар)-д эрхийн хамгаалалт хийлгэж, улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсдэг. Үүнээс дүгнэвэл, оюуны өмч гэдэг нь хүний сэтгэхүйн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон, бодитой, үнэлэгдэх боломжтой зүйл бөгөөд өмчлөлийн зүйлийн шинжгүй (*гэрчилгээ, патент аваагүй тохиолдолд*) бол үнэлэгдэх байдлаа алддаг. Монгол Улсын Оюуны өмчийн газар бүртгэгдсэн зохиогчийн эрхийн бүтээл, мөн эрхийн хамгаалалт хийлгэж, улсын бүртгэлд бүртгүүлсэн патент (шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварт олгоно), гэрчилгээ (барааны тэмдэг, газар зүйн заалтад олгоно) авсан бүтээлүүдийн сүүлийн гурван жилийн статистик мэдээллийг хүснэгтээр болон баганаан графикаар авч үзвэл,²

Хүснэгт-2

	Зохиогчийн эрх ⁶	Шинэ бүтээл	Ашигтай загвар	Бүтээгдэхүүний загвар	Барааны тэмдэг
2018 он	1072	159	152	300	3927
2019 он	1007	170	166	293	4028
2020 он	1060	148	197	269	3505
Нийт	3139	477	515	889	11460

² <https://www.1212.mn/> Статистикийн нэгдсэн мэдээллийн сангийн цахим хуудсанд хандан оюуны өмчийн объект тус бүрээр гаргав.

График-1



Дээрх статистик, тоон үзүүлэлтээс үзэхэд оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийгдсэн бүтээлийн тоо сүүлийн жилүүдэд харьцангуй өсөх хандлагатай байна.

Хоёр. Оюуны өмчийн эрхийг эдийн засгийн эргэлтэд оруулах хэлбэр, оюуны өмчийн үнэлгээ

2.1. Оюуны өмчийн эрхийг эдийн засгийн эргэлтэд оруулах хэлбэр

Оюуны өмч бүтээхийг урамшуулах, хамгаалах, үнэлэмжийг өсгөхийн зорилго нь түүнийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд орших бөгөөд оюуны өмчийн эрх (гэрчилгээ, патент)-ийг лиценз, франчайз, мерчандайзийн болон бусад гэрээ, хэлцлээр бусдад бүрэн болон хэсэгчлэн ашиглуулах, өмчлөх эрх шилжүүлэх, оюуны өмчөөр хуулийн этгээдэд хөрөнгө оруулах, барьцаалах болон бусад хэлбэрээр эдийн засгийн эргэлтэд оруулах боломжтой юм.

Мөн 2017 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөж буй Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд зааснаар зохиогч болон эрх эзэмшигч өөрийн оюуны өмчийн эрхийг барьцаалан банк, санхүүгийн байгууллагаас зээл авах боломж бүрдсэн ба, өнгөрсөн хугацаанд хэд хэдэн арилжааны банк нийт дүнгээр тэрбум гаруй төгрөгийн зээлийг ийм хэлбэрээр олгосон байна.³ Үүнээс үзвэл, оюуны өмчийн эрх эзэмшигч иргэн, хуулийн этгээд өөрийн шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент, барааны тэмдгийн гэрчилгээгээ үнэлүүлэн өөрийн болон гуравдагч этгээдийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор банк, санхүүгийн байгууллагад барьцаалах боломжтой нь харагдаж байна.

³ Оюуны өмчийн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга С.Ганзоригийн ярилцлага, нийтлэгдсэн 2020.12.25, <https://www.ipom.gov.mn/index.php?pid=40&nid=661>

Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд нэн тэргүүнд бүтээлийн зах зээлийн үнэлгээг тодорхойлох шаардлага гардаг бөгөөд уг үнэлгээг талууд харилцан тохиролцож тогтоох боломжтой, хэрэв тохиролцоогүй тохиолдолд оюуны өмчийн үнэлгээ хийх сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан хөрөнгийн үнэлгээчин⁴ тогтооно.

Оюуны өмчийн үнэлгээ нь тухайн объектын онцлогоос ихээхэн хамаардаг. Тухайлбал, аж үйлдвэрийн өмчийн үнэлгээний асуудал нь салбарын онцлогоос шалтгаалан тухайн шинэ бүтээлийг гаргахад гаргасан судалгаа, шинжилгээний ажлын зардал, лицензийн төлбөр, зах зээлийн үнэ, олох бодит орлого, технологийн түвшин зэрэгтэй шууд хамааралтай байдаг бол зохиогчийн эрхийн бүтээлийн үнэлгээ нь үзэгчдийн тоо, борлуултын орлого, киноны хувьд хандалтын тоо, киноноос олох ашиг, орлого, кино бүтээл хийхэд гарсан зардал гэх мэт олон үзүүлэлтийг шалгуур болгон үнэлэх боломжтой байдаг.⁵

Патентийн тухай (шинэчилсэн найруулга) хууль болон Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд зааснаар оюуны бүтээлийн өртгийг тооцсон үнэлгээг хөрөнгийн баталгаа гаргах, барьцаа, хөрөнгө оруулалт, хувьцаа гаргах, хувьчлал болон дуудлага худалдаанд оруулах, компанийн дүрмийн сан бүрдүүлэх, даатгалд хамруулах, худалдан борлуулах хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлох, татварын тооцоолол, хохирол гаргуулах зэрэг үйл ажиллагаанд хэрэглэж ирсэн. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын үнэлгээг зохиогчийн хүсэлтээр, барааны тэмдэг, газар зүйн заалтын үнэлгээг эзэмшигч, хэрэглэгчийн хүсэлтээр тус тус Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (Оюуны Өмчийн Газар) баталгаажуулдаг бөгөөд 2020 оны I улирал хүртэлх хугацаанд нийт 309 объект (аж үйлдвэрийн өмчийн эрх 283 буюу 91.5 хувь)-д баталгаажуулалт хийгдсэн байна. Харин оюуны бүтээлийн үнэлгээгээ баталгаажуулж батламж авахаар гаргасан хүсэлтийн 5-10 хувийнх нь үнэлгээний аргачлал тодорхойгүй, үнэ цэнэ нь бодит бус гэсэн үндэслэлээр буцаасан байна. Хүснэгтээр үзүүлбэл,⁶

Хүснэгт-3

№	Төрөл	Тоо	Хувь	Үнэлгээ	Хувь
1	Шинэ бүтээл	22	7.1	5,453.81	13
2	Бүтээгдэхүүний загвар	47	15.2	5,624.77	13
3	Ашигтай загвар	2	0.6	192.35	0
4	Барааны тэмдэг	212	68.6	24,676.29	59

⁴ Оюуны өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт

⁵ Монгол Улсын Засгийн газрын Хэрэгжүүлэгч Агентлаг-Оюуны өмчийн газар, Шихихутуг Хууль зүйн дээд сургууль. "Оюуны өмч-хөгжлийн ундарга, хүний зувчигдах эрх" (Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл), УБ, 2013 он, 70 дахь тал

⁶ Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институт (MICA)-ын гишүүн, Хөрөнгийн үнэлгээний "АТЕН" ХХК-ийн Дэд захирал, мэргэшсэн үнэлгээчин П.Болормаагийн бэлтгэсэн статистик мэдээллийг ашиглав.

5	Зохиогчийн эрх	13	4.2	891.58	2
6	Тусгай зөвшөөрөл	11	3.55	505.07	1
7	Нөү Хуа	2	0.6	4,356.03	10
8	Дүн /сая.төг/	309	100%	41,699.91	100%

Баталгаажуулалт хийгдсэн үнэлгээг салбараар ангилж үзвэл, хүнс, үйлдвэрлэлийн салбарт 146 буюу 47 хувь, хэвлэл мэдээлэл, зар сурталчилгаа салбарт 38 буюу 12 хувь, боловсрол, сургалтын чиглэлд 14 буюу 5 хувь, гоёл чимэглэл, бэлэг дурсгалын салбарт 26 буюу 8 хувь, эм, био бэлдмэл салбарт 32 буюу 10 хувь, гоо сайхан салбарт 47 буюу 15 хувь бол зам, барилга, санхүү, ложистикийн салбарт нийт 6 буюу 3 хувийг эзэлж байна.

Харин үнэлгээ хийсэн зорилгыг авч үзвэл санхүүгийн тайлагналын зорилгоор 97 хувь нь, шүүхийн журмаар (хохирол гаргуулахад чиглэсэн) 2 хувь нь, бусад зорилгоор 1 хувь байна.

2.2. Оюуны өмчийн үнэлгээний хандлага, аргууд

Оюуны өмчийн эрхийг үнэлэх нь бодит эд зүйл (*биет хөрөнгө*) үнэлэхээс илүү нарийн төвөгтэй байдаг тул үнэлгээний зорилго, бүтээлийн онцлог, шинж байдал зэргийг харгалзан түүнд тохирсон хандлага, аргыг сонгох нь хамгийн чухал юм. Оюуны өмчийн тухай хуульд зааснаар оюуны өмчийг үнэлэхдээ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, үнэлгээний олон улсын стандарт (*цаашид "ҮОУС" гэх*), оюуны өмч, биет бус хөрөнгийн үнэлгээний үндэсний стандарт, аргачлалыг удирдлага болгох бол, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль (2010 он)-д тухайн үнэлгээний зүйлийн шинж байдал, онцлог, зориулалтыг харгалзан хөрөнгийн үнэлгээний өртгийн, жишиг үнийн, орлогын аргуудыг хослуулан, олон улсын болон хөрөнгийн үнэлгээний үндэсний стандарт, аргачлалд нийцүүлэн үнэлнэ гэж заасан.

Дээрх хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн ч холбогдох стандарт, аргачлалууд нь батлагдаагүй өдийг хүрчээ. Дэлгэрүүлбэл, хөрөнгийн үнэлгээний үндэсний стандартыг олон улсын үнэлгээний стандартын зарчим, хууль тогтоомжид нийцүүлэн Стандартчиллын төв байгууллага (Стандарт, хэмжил зүйн газар), хөрөнгийн үнэлгээ хийх арга, аргачлалыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Сангийн яам) нь дангаараа, эсхүл төрийн холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран тухайн хөрөнгийн үнэлгээний зүйлийн шинж байдал, зориулалтад нийцүүлэн тус тус баталж,⁷ мөрдүүлэх ёстой.

Мөн 2020 оны 12 дугаар сараас Оюуны өмчийн тухай хууль хүчин төгөлдөр дагаж мөрдөгдсөн ч Оюуны өмч, биет бус хөрөнгийн үнэлгээний үндэсний стандарт, аргачлал батлагдаагүй, уг аргачлалыг хэн батлах нь ч тодорхойгүй байна.

⁷ Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг

Үүнээс харвал, манай улс нь өөрийн орны онцлог, үнэлгээний зүйлийн шинж байдал, онцлогт тулгуурласан хөрөнгийн үнэлгээний үндэсний стандарт, аргачлалгүй явсаар иржээ.

Оюуны өмчийг үнэлэхдээ ҮОУС-ыг дагаж мөрдөхөөр заасан. Оюуны өмч, биет бус хөрөнгийн үнэлгээнд Үнэлгээний Олон Улсын Стандарт (International Valuation Standards IVS/ҮОУС) 105 Үнэлгээний хандлагууд ба аргуудад дурдсан үнэлгээний зах зээлийн, орлогын болон өртгийн хандлагыг бүгдийг нь хэрэглэж болох ба, хандлага, аргыг сонгох үедээ үнэлгээчин нь ҮОУС 210 Биет бус хөрөнгийн үнэлгээ (Intangible Assets, IVS 210) шаардлагуудаас гадна ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд (Valuation Approaches and Methods, IVS 105)-ын шаардлагуудыг даган мөрдөхөөр байна.

1. Зах зээлийн хандлага (Market approach): Уг хандлагын дагуу биет бус хөрөнгийн үнэ цэнийг тухайнзахзээлийнүйлажиллагаа (тухайлбал, ижил буюу төсөөтэй хөрөнгөтэй холбооой ажил гүйлгээг)-г харгалзах ба, тухайн хөрөнгийг үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа ижил буюу жишиж болох төсөөтэй хөрөнгөтэй харьцуулснаар үнэ цэнийн үзүүлэлтээр хангадаг.
2. Орлогын хандлага (Income approach): Уг хандлагын дагуу тухайн биет бус хөрөнгийн эдийн засгийн ашиглалтын хугацааны туршид түүнд хамаарах орлого, мөнгөн гүйлгээ буюу өртөг зардлын хэмнэлтийн өнөөгийн

үнэ цэнийг лавлагаа болгосноор биет хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлдог,

3. Өртгийн хандлага (Cost approach): Ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг таамаглах боломжгүй, технологийн боловсруулалтын эхэн үед, оюуны өмчийг ашиглаад шууд орлого орж ирэхгүй бол, хамгийн доод үнийг тогтоох зорилгоор, бусад аргаад үнэлэх боломжгүй үед ихэвчлэн хэрэглэдэг. Орлуулалтын зарчимд үндэслэх ба хөрөнгө нь бүхлээрээ бүх бүрэлдэхүүн хэсгийнхээ өртгөөс илүүгүй үнэ цэнэтэй байна. оюуны өмчийн шинэлэг, онцгой шинж чанарыг авч үздэггүй, түүнээс бий болох орлогыг тооцдоггүй, ирээдүйн чиг хандлагыг авч үзддэггүйгээрээ сул талтай.

Үнэлгээний эдгээр хандлага нь хэрэглээний өөр өөр, нарийвчилсан аргуудтай байдаг. Хөрөнгийн хувьд үнэлгээний хандлагууд болон аргуудыг сонгох зорилго нь тухайн нөхцөлд байдалд хамгийн тохиромжтой аргыг олох явдал байдаг. Боломжит нөхцөл байдал бүрд тохирох нэг арга гэж байдаггүй. Сонголтын процессод наад зах нь дараах хүчин зүйлсийг харгалзан үздэг. Үүнд:⁸

- а) Үнэлгээний гэрээт ажлын нөхцөлүүд болон зорилгоор тодорхойлогдох үнэ цэнийн тохиромжтой суурь ба үнэ цэнийн урьдчилсан нөхцөл,
- б) Үнэлгээний боломжит хандлагууд

⁸ Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институт. Үнэлгээний Олон Улсын Стандарт (ҮОУС), УБ хот. 2019 он, 37 дахь тал

ба аргуудын тус тусын давуу болон сул талууд.

с) Хөрөнгийн шинж чанарыг харгалзан үзсэнээр тогтоосон арга тус бүрийн тохиромжтой байдал ба хамаарах зах зээлд оролцогчдын ашиглах хандлагууд буюу аргууд

д) Тухайн арга (аргууд)-ыг хэрэглэхэд шаардлагатай найдвартай мэдээллийн бэлэн, олдоцтой байдал болно.

Хөрөнгийн үнэлгээний хувьд, ялангуяа үнэлгээчин нь тухайн үнэлгээний нөхцөл байдлуудыг харгалзан үзсэнээр нэг аргыг үнэн зөв бөгөөд найдвартай гэдэгт бат итгэлтэй тохиолдолд олон арга ашиглахыг шаарддаггүй. Гэвч ялангуяа нэг аргын хувьд бодит баримтын буюу ажиглалтын хангалттай баримт, мэдээлэл, нотолгоо, шинжилгээ байхгүй тохиолдолд үнэлгээчин үндэслэл бүхий дүгнэлт гаргахын тулд олон хандлагууд ба аргуудыг хэрэглэх явдал гардаг. Нэгээс олон хандлага ба аргыг эсвэл нэг хандлагын хүрээнд дэх олон аргуудыг ашиглаж буй үед үндэслэл бүхий дүгнэлт, тайлан гаргах боломжтой.

Жиших ажил гүйлгээний арга нь биет бус хөрөнгийн хувьд хэрэглэж болох зах зээлийн хандлагын ерөнхийдөө цорын ганц арга ба, уг аргаар өргөн нэвтрүүлгийн сүлжээ, интернетийн домейн нэр зэргийг үнэлэхэд тохиромжтой байна.

Орлогын хандлага нь Биет бус хөрөнгийн үнэлгээнд хэрэглэдэг хамгийн түгээмэл арга юм. Орлогын хандлагын олон аргууд байдаг. Үүнд, илүүдэл ашгийн

арга, эрхийн шимтгэлээс чөлөөлөх арга, урамшуулалт ашгийн арга, грийнфиелдийн болон дистрибьюторын арга багтах уг аргаар технологи, барааны тэмдэг, худалдааны нэр, үйл ажиллагааны лиценз зэргийн үнэлэхэд илүү тохиромжтой юм. Дээрх хандлага, аргуудыг хэрэглэх боломжгүй тохиолдолд орлуулалтын өртгийн аргыг хэрэглэдэг байна.

Түүнчлэн оюуны өмчийн үнэлгээнд үнэлгээний анхдагч нөхцөл, үнэлгээний стандарт, үнэлгээний шалтгаан (зорилго), патент, гэрчилгээний хүчинтэй байх хугацаа, эдийн засгийн үзүүлэлт, хэмнэлт, үр ашиг, орлого, зардал, үнэлгээний огноо, мэдээ, холбогдох баримтын шинж чанар, тэдгээрт нэвтрэх боломж, үнэлгээний хандлага (арга), холбогдох оюуны өмчийн мөн чанар, цар хүрээ, давуу тал (бодит байдал) зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг байна.

Дүгнэлт

Оюуны өмчийн бүтээл нь өвөрмөц, дахин давтагдашгүй, үргэлж хөдөлгөөнтэй байж, шинэчлэгдэн өмнөхөөсөө улам боловсронгуй болж байдаг, амархан хоцрогдож ашигт болон харьцангуй давуу тал нь дараагийн шинэ бүтээл гарахад эрс буурдаг (энэ нь үнэ цэнэгүй зүйл болж байгаа байгаа хэрэг биш) зэрэг онцлогтой. Энэхүү онцлогоос хамаарч оюуны өмчийг үнэлэх, түүний эдийн засгийн үр ашгийг тооцох, түүнийг бусад оюуны өмчийн бүтээлтэй харьцуулан үнэлгээ тогтоох нь хүндрэлтэй байдаг. Тухайлбал, патентийн үнэлгээ эхэндээ өндөр байдаг ч түүний ашиглалтын хугацаанд үнэ цэнэ нь буурдаг бол эсрэгээрээ барааны тэмдэг (бренд)-ийн үнэлгээ эхэндээ бага ч олон танигдан, цаг хугацаа өнгөрөх тусам түүний үнэлгээ нэмэгддэг онцлогтой. Мөн оюуны өмчийн бүтээлийг дуудлага худалдаанд оролцуулахад оролцогчдын тоо хязгаарлагдмал (цөөн) зэргээс шалтгаалан өрсөлдөхүйц үнийн санал ирэхгүй байх зэргээр өмчлөгч, эрх эзэмшигчийн хувьд хүссэн (боломжийн) үр дүнг тэр болгон авчирч чаддаггүй. Ийм хязгаарлагдмал зах зээлд оюуны өмчийн үнэлгээг шударгаар, бодитой тогтоох боломжгүй байдаг.

Дээр дурдсанаар оюуны өмчийн эрхийг үнэлэх нь бодит эд зүйл (*биет хөрөнгө*) үнэлэхээс илүү нарийн төвөгтэй байдаг тул үнэлгээний зорилго, бүтээлийн онцлог, шинж байдал зэргийг харгалзан түүнд тохирсон хандлага, аргыг сонгодог.

Оюуны өмчийн тухай хуульд зааснаар оюуны өмчийг үнэлэхдээ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, үнэлгээний олон улсын стандарт (*цаашид "ҮОУС" гэх*), оюуны өмч, биет бус хөрөнгийн үнэлгээний үндэсний стандарт, аргачлалыг удирдлага болгох бол, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль (2010 он)-д тухайн үнэлгээний зүйлийн шинж байдал, онцлог, зориулалтыг харгалзан хөрөнгийн үнэлгээний өртгийн, жишиг үнийн, орлогын аргуудыг хослуулан, олон улсын болон хөрөнгийн үнэлгээний үндэсний стандарт, аргачлалд нийцүүлэн үнэлнэ хэмээн хуульчилсан байдаг ч холбогдох стандарт, аргачлалууд нь батлагдаагүй байна.

Иймд хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, өөрийн орны онцлог, үндэсний хэв шинжид тулгуурлан хөрөнгийн үнэлгээний үндэсний стандарт, аргачлалыг баталж, мөрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

ЭРХ ЗҮЙН ЭТГЭЭД БАЙХ ОЙЛГОЛТ БУЮУ ЭРХ ЗҮЙН ЧАДВАРЫН ТУХАЙ



Шихихутуг их сургуулийн Хувийн
эрх зүйн тэнхимийн багш.
Докторант М.Хатанзориг

Түлхүүр үгс: Эрх зүйн этгээд, эрх зүйн чадвар, хувь хүн

Хүний эрхийн, эрх зүйн сэтгэлгээний түүхийн явцад бий болгосон олон үнэт зүйлсийн нэлээдгүй чухал хэсэг нь "хувь хүн"-ий талаарх эрх зүйн үнэлэмж, эрх зүйн чадварын тухай үзэл баримтлалтай салшгүй холбоотой. Хувь хүн бүрийн үнэ цэнийг хүлээн зөвшөөрөөгүй нөхцөлд бусад эрхийн тухай ярих боломжгүй. Хүний эрхийн төлөөх тэмцэл, хөгжлийн явцад олон улсын болон үндэсний эрх зүйн тогтолцоонд хүний эрх зүйн чадварыг түгээмэл хүлээн зөвшөөрч, хувьсаж буй нийгмийн материаллаг орчинд тухайн чадварт агуулагдаж буй үнэт зүйлсийг хэрхэн хамгаалах талаар эрчимтэй судалж байна.

Түүхийн хувьд, хувь хүн, эрх зүйн чадварын номлол өнөөдрийн түвшинд хүрэхийн тулд олон эмпирик шалтгаануудаар нөхцөлдсөн байна. Ерөнхийдөө, зөвхөн хүний гэлтгүй, амьтны эсвэл бусад аливаа ухамсарт организмын эрхийг субъектийн

эсвэл объектын гэж ангилж болдог. Объектын эрх нь тухайн оршихуйг өөрийн ухамсартай, эрхэм чанартай эзэн бие гэхээсээ илүүтэй өмч, эзэмшлийн зүйл, бараа мэтээр тодорхойлон ойлгосны үндсэн дээр олгогддог. Тухайлбал, олон улсад боолчлолыг халахаас өмнө "боол хүн"-д амьгүй биеттэй харьцуулахад эд хөрөнгийн зохицуулалтаас гадна тодорхой субъектив шинжтэй эрх байсан¹ боловч, тэр нь хүний бус объектын эрх байв.² Харин субъектийн эрх нь тухайн этгээдийг эрх зүйн чадвартай, тусгаар оршихуй хэмээн хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой. Сүүлийн үед, цөөнгүй улсуудад зарим амьтныг ч "эрх зүйн этгээд" мөн эсэх тал дээр ёс зүйн, хууль зүйн маргааныг өрнүүлж байна.

Төрөлх эрхийн онолчид ихэвчлэн англи хэлний "human dignity" буюу хүний эрхэм чанарт тулгуурлан хүн бүр эрх зүйн этгээд байх, хүн байхынхаа хувьд адил тэгш байх талаар номлож байжээ. Эрх зүйн

¹ Ихэнх газарт боолуудын гэрлэх, өмчлөх, худалдаа хийх, зорчих, сурч боловсрох, эвлэлдэн нэгдэх зэрэг эрхүүдийг бүрэн хязгаарладаг байсан боловч зарим асуудлаар шүүхэд хандах эрхийг; тодорхой газруудад гэм буруутай үйлдэл хийж шийтгүүлээгүй л бол амьд явах эрхийн хэлбэрийн хувьд хүлээн зөвшөөрдөг байжээ. (Lawrence M. Friedman (2005). A History of American Law: Third Edition. Simon and Schuster. p.163; Hadden, Sally E. (2001). Slave Patrols: Law and Violence in Virginia and the Carolinas. Harvard Historical Studies. Cambridge, MA: Harvard University Press. p. 340; Berlin, Ira (1991). The slaves' economy: independent production by slaves in the Americas. Morgan, Phillip D. London: Cass. p. 7)

² Ingersoll, Thomas N. (1995). "Slave Codes and Judicial Practice in New Orleans, 1718-1807". Law and History Review. 13 (1): pp. 23-62

этгээд буюу эрх зүйн чадвартай хүний гарцаагүй эдлэх, хязгаарлаж үл болох төрөлх эрхүүдийн босго хүн төрөлхтний нийтлэг боловсрол, нийгмийн харилцааны өөрчлөлтийг дагаад улам өндөрсөж байгаа бөгөөд эдгээр эрхүүд нь өөр хоорондоо нягт холбоотой, харилцан бие биенээ нөхцөлдүүлж байна. Мөн салгаж, хязгаарлаж болох боловч орчин үеийн нийгэмд аж төрөхийн тулд Үндсэн хуулийн хэмжээнд хамгаалах ёстой шинэ төрлийн эрхүүд бий болж буй. Дангаарших (хувийн халдашгүй байдал) эрхийг төрөлх эрхэд хамаарах эсэх талаар, мөн Үндсэн хуулиар хамгаалагдсан эсэх талаар онолын маргаанууд зарим улсын шүүхийн практикт хэрэглэгдсэн, нэвтэрсэн байна.³ Ямар ч субъектив эрхийн хувьд тухайн эрхийг эдлэх этгээд нь эрх зүйн чадвартай байхыг шаарддаг.

Эрх зүйн этгээд байх – Эрх зүйн ерөнхий чадвар тухай

“Этгээд [ж.н]” гэдэг нь нийгмийн харилцаанд оролцогч эзэн биеийг хэлдэг бөгөөд “хүн”-ээс илүү өргөн утгатай. “Хүн” гэдэг нь биологийн ойлголт бөгөөд хүний ген агуулсан амьт биетийг хэлнэ. Харин “этгээд” гэдэг нь нийгмийн, тэр дундаа философи, улс төр, эрх зүйн ойлголт болдог аж.

Эрх зүй өөрөө оюун ухаантай, ухамсарт нийгмээс улбаалан гарсан ухагдахуун учраас “эрх зүйн этгээд” гэдэгт эрх зүйн хамгаалалтад хамаарч болох мөн тийм ухамсартай

амьтныг ойлгодог аж. Ерөнхий утгаараа “этгээд (person)” буюу нийгмийн харилцааны эзэн бие байх чадвартай оролцогчийг: “Аливаад үндэслэлтэй ханддаг, юмсын учир шалтгааныг ухамсарлаж ойлгодог, ёс суртахуунлаг, өөрийгөө бусдаас тусгаар хувь оршихуй гэдгээ сэрж мэдэрдэг, өмчлөл, хариуцлага зэргийг ухамсарладаг, нийгэм соёлын төлөвшил бүхий оршихуй юм” хэмээн тодорхойлдог.⁴ Логик утгаараа эрх зүйн этгээд гэдгээр эрх зүйгээр тухайн этгээдийг ёс суртахууны сэрэл мэдрэмжтэй, үйлдэл, үйл явдлын учир холбогдлыг ухамсарлан ойлгодог, нийгэмд эрх эдлэх, хариуцлага хүлээх анхан шатны чадвартай хэмээн үзэж эрх зүйн зохицуулалтад эзэн бие хэмээн хүлээн зөвшөөрөхийг ойлгоно.⁵

Хэн нэгнийг эрх зүйн этгээд мөн хэмээн үзэхийн цаана түүнийг бусадтай адил тэгш, эрхэм чанартай (dignity - нэр төр, эрхэм чанар, хүнлэг шинж), төрөхөөсөө эрх чөлөөтэй байхаас гадна оюун ухаантай, өрлөг сэтгэлтэй хэмээн хүлээн зөвшөөрөх санаа боловсорч, позитив эрх зүйн хүрээнд Хүний эрхийн түгээмэл тунхаглалын §1-д “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй,

³ АНУ-ын Үндсэн хуулин дахь дангаарших эрхтэй холбоотой шүүхийн шийдвэрүүдийг үзнэ үү (Katz v. United States, 389 U.S. 347 (1967); Engblom v. Carey, 677 F.2d 957 (2d Cir. 1982); Schmerber v. California, 384 U.S. 757 (1966) гэх мэт).

⁴ De Craemer, Willy. “A Cross-Cultural Perspective on Personhood.” The Milbank Memorial Fund Quarterly. Health and Society, vol. 61, no. 1, 1983, pp. 19–34. <https://www.jstor.org/stable/3349814>; Christian Smith. 2003. Moral, Believing Animals: Human Personhood and Culture. Oxford University Press; Carrithers, Michael, Steven Collins, and Steven Lukes, eds. 1985. The category of the person: Anthropology, philosophy, history. Cambridge, UK: Cambridge Univ. Press.

⁵ Денгөж төрсөн хүүхэд болон сэтгэцийн хүнд өвчтэй, тархины хүнд саажилттай зэрэг эрх үүргээ ухамсарлах чадваргүй ч Үндсэн хуулиар тогтоосон эрх зүйн этгээд хэмээн хүлээн зөвшөөрөгдөх үндэслэлийн талаар хүний эрх зүйн чадвар хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан..." хэмээн тусгалаа олжээ.

Түүхийн хувьд, биологи талаасаа зарим хүн хэрцгий хүйтэн сэтгэлтэй учраас эрхэм чанаргүй, зарим амьтад хүнээс илүү эрхэм чанартай хэмээх маргаанууд цөөнгүй байсан тул хэнийг буюу юуг эрх зүйн хувьд "этгээд" мөн болохыг тодорхойлох нь ярвигтай байжээ. Ёс зүйн философичид хуулиар хамгаалагдах тэрхүү эрхэм чанар нь ямар нэг арьсны өнгө, эсвэл генетикийн мэдээлэл зэргээр тодорхойлогдохгүй бөгөөд гадаад шинжээрээ хүн боловч дотоод шинж нь араатнаас ялгаагүй байж болох талаар цөөнгүй тайлбарлаж байв.

Эрх зүйн этгээд гэдэгт язгуур утгаараа дээр дурдсан хүнлэг энэрэнгүй сэтгэл, оюун ухаан, ёс суртахуун зэрэгт тулгуурласан амьд организмын эрхэм чанарыг хүндэтгэж буюу хүлээн зөвшөөрөхийг ойлгох хэдий ч хууль зүйн харилцааны ялгаатай шинж байдлаас шалтгаалан зохион байгуулалтын нэгдлийг хийсвэр утгаар нь эзэн биед тооцож хуулийн этгээдийн⁶ зохицуулалтыг ч бүтээсэн байна. Энэ нь нийгэм, эдийн засгийн нарийн төвөгтэй харилцааг зохицуулахын тулд хууль зүйн зохицуулалтын хийсвэрлэх арга зүйгээр эрх зүйн тодорхой материаллаг хэрэгцээ шаардлагыг хангаж буй хэлбэр юм. Иргэний эрх зүйд эрх зүйн харилцаанд оролцогчийг хүн, хуулийн этгээд хэмээн тухайлан үздэг боловч эрх

зүйн этгээдийн талаарх ерөнхий номлолын хүрээнд эрх зүйн этгээд нь субъектийн эрхийг тодорхой хэмжээнд эдлэх боломжтой амьд организм, тэр дундаа хүн юм.

Норматив эрх зүйд эрх зүйн этгээд байна гэдэгт "эрх зүйн чадвар"-тай байхыг ойлгоно. Уг чадвар нь эрх зүйн харилцааны хувьд субъект байх суурь нөхцөлийг хууль тогтоомжид тодорхойлж өгдөг байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна." гэж заажээ. Хүн бүрийн эрх зүйн этгээд мөн гэж үзэх, хуульд тодорхойлохын тулд хүн төрөлхтөн философийн олон маргаан өрнүүлжээ.⁷

Хүний эрхийн талаарх орчин үеийн үзэл санаа түгээмэл хүлээн зөвшөөрөгдөхөөс өмнө хүмүүсийг хүйс, гарал усгаа, арьс өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлаж эрх зүйн тодорхой харилцаанд орох эрхийг нь хязгаарлах, эсхүл бүр эрх зүйн чадварыг нь үл хүлээн зөвшөөрөх явдал цөөнгүй байв. Эмэгтэйчүүдийн сонгуульд оролцох, өмчлөх эрх, еврейчүүдийн тээврийн хэрэгсэл ашиглах, хөдөлмөрлөх, зорчих гэх мэт төрөл бүрийн эрхийг хязгаарлах, өнгөт арьстнуудыг боолчлох, дайны үед хүн дээр шинжлэх ухааны туршилт хийх зэрэг нь хүний эрхэм чанарыг үл хүндэтгэх, хүнийг хүн байхынх нь хувьд үл зөвшөөрөх үзэл

⁷ Хүний эрх зүйн чадвар хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

⁶ Legal entity, legal person, juridical person

санааны нийтлэг шинжтэй.

Түүхийн хувьд, боолчлох, хүн дээр туршилт хийх зэрэг хүний эрх зүйн чадварыг бүхэлд нь үгүйсгэсэн хэрцгий явдлуудаас гадна тодорхой харилцаанд эрх зүйн чадварыг хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх үзэл ч түгээмэл байв. Эдгээр тэгш бус байдлын эсрэг тэмцэл нь эрх чөлөөний үзэл санааг бүрэлдүүлж “хүн бүр эрх зүйн чадвартай байх” хууль зүйн номлолыг үүсгэжээ. Агуулгын хувьд эрх зүйн чадварт юуг хамааруулах талаар судлаач нарын байр суурь зөрүүтэй байдаг ч жам ёсны эрхүүдийг эдлэх боломж олгох орон зайг бүхэлд нь хамруулж тайлбарлах хандлага түгээмэл. Суурь утгаараа эрх зүйн чадварт эрх эдлэх, үүрэг, хариуцлага хүлээх боломжийг ойлгодог бол тодорхой утгаараа ялгаварлагдахгүй байх, тэгш эрхтэй байх, эрх чөлөөтэй байх, эд хөрөнгө өмчлөх, хөдөлмөрлөх зэрэг хоорондоо салшгүй холбоотой язгуур эрхүүдийг эдлэх, бусдын ийм эрхийг зөрчихгүй байх, хуульд заасан тохиолдолд хариуцлага хүлээх зэргийг ойлгоно.

Олон улсад эрх зүйн чадварыг үүрэг хариуцлага хүлээхээс илүүтэй эрх зүйн этгээд байж тодорхой хэмжээнд хүндлэгдэх, хүнлэг бус хэрцгий хандалтаас ангид байх талаас нь тайлбарлах хандлага жин дарж буй. Боолчлолыг халах үед эрх зүйн чадварын үзэл санаа бүх хүнийг ижил тэгш хүлээн зөвшөөрөх, хүний эрхэм чанарыг хүндэтгэх буюу хүн гэх объектэд төвлөрсөн байсан бол түүнээс хойш хүний эрхэм чанар, хүнлэг ёсны үзэл санаа нь хүнээс гадагшаа чиглэсэн бие даасан

хандлага болон төлөвшиж байна. Тухайлбал, амьтны эрх, ургийн эрхийн сэдвийн хүрээнд тэдгээрийг эрх зүйн чадвартай хэмээн тайлбарлах, шүүхээр уг чадварыг нь хүлээн зөвшөөрөх тохиолдлууд бий.

Эрх зүйн этгээд (person) гэдэгт эхэндээ хууль зүйн хувьд хүн байх тухай ойлголтыг хамруулдаг байсан бол орчин үед эрх эдлэх боломж бүхий этгээд хэмээн өргөтгөн тайлбарлах болжээ. Энэ утгаараа бич зэрэг хүнтэй төстэй сэтгэл зүй, ухамсар бүхий амьтдын эрх зүйн чадварыг хүлээн зөвшөөрч хамгаалах үзэл дэлгэрч байна. Өөрөөр хэлбэл, эрх зүйн чадварын тухай санаа нь хүний эрхийг хүлээн зөвшөөрөх, хүнийг хамгаалах зорилгоор хөгжсөн бол эдүгээ улам өргөжиж хүнээс бусад оршихуйд ч эрх зүйн чадвар байх ёстой хэмээн тэдний эрхийг хамгаалах, хүчирхийлэл, харгислалаас ангид байлгахыг эрмэлзэх болжээ. Энэ утгаараа эрх зүйн чадвар нь зарим амьтдыг хүний жам ёсны тэр дундаа гарцаагүй хэрэгцээнд үл хамаарах тансаг хэрэглээ, хүнлэг бус ашиг сонирхлоос доогуур үзэх эрх зүйн хэвшмэл сэтгэлгээг даван туулах үндэслэл байж болох юм. Энэ нь хүн төрөлхтний нийтлэг ёс зүйн хувьд ахиц дэвшил мөн.

Австралийн ёс зүйн философич Петер Зингер: “Орчин үеийн амьтны эрх хамгаалах хөдөлгөөнүүдээс ч өмнө амьтанд хэрцгий хандахын эсрэг нийгэмлэгүүд ажилладаг байсан боловч тэдгээрийн амьтан хамгаалах ажиллагаа нь гагцхүү хүний ашиг сонирхол хөндөгдөөгүй үед л хэрэгждэг, явцуу хүрээтэй

байв. Хүмүүс өөрсдийгөө бусад бүх амьтдаас дээгүүр тавьж хэрэв сонирхлын зөрчил үүсвэл хүний сонирхлыг нэн түрүүнд тавьдаг. ...Тэгш эрхийн суурь санаа нь хэн нэгний ашиг сонирхлыг бусдаас нь илүүд үзэхгүй байх бөгөөд энэ нь зөвхөн хүн төрөлхтөнд хамааралтай бус. Амьтны мэдэрч байгаа өвдөлт нь хүний өвдөлттэй адил хэмжээнд анхаарал хандуулах ёстой асуудал. Өвчин зовлонгийн хэр хэмжээ нь хэн түүнийг мэдэрч байгаагаас шалтгаалах ёсгүй” гэжээ.⁸

Зингерийн дурдсан өмнөх амьтан хамгааллыннийгэмлэгүүд нь амьтдыг тусдаа мэдрэхүй, ухамсартай оршихуй хэмээн тэдний эрх зүйн чадварыг хүлээн зөвшөөрөх бус, хүний өөрийнх нь ёс зүйгүй, хүнлэг бус үйл ажиллагааг эсэргүүцэх, хязгаарлах хандлагатай байжээ. Өөрөөр хэлбэл амьтныг хамгаалах үзэл санааны тулгуур нь хүн өөрөө бөгөөд “ёс суртахуунлаг амьтан болохынхоо хувьд хүн ийм үйлдэл хийж болохгүй” хэмээн объектэд уягдсан үзэлтэй байсан бөгөөд энэ нь мөн чанартаа амьтныг хамгаалах санаа бус хүнийг ёс зүйн алдаа завхралаас хамгаалсан үзэл юм. Үзэл санааг объектээс салгаж цэвэр байдлаар баримтлаагүй тохиолдолд сонирхлын зөрчил байнга үүсдэг. Эрх зүйн чадварыг хүлээн зөвшөөрөх нь тухайн этгээдийн ашиг сонирхлыг бусад чадвар бүхий этгээдтэй ижил тэнцүү хэмжээнд авч үзэх эрх зүйн суурь үндэс болно.

⁸ Peter Singer. *Animal Liberation: A New Ethics for our Treatment of Animals*. 2015 (40th year anniversary edition). New York; Peter Singer, Richard Posner нарын амьтны эрхийн талаарх мэтгэлцээний протокол. 2001 он.

Эрх зүйн чадварыг зорилгоор нь тайлбарлавал ухамсарт амьд биет аливаа халдлага, хүчирхийлэл, санаатайгаар учруулах зовлонгоос хууль ёсоор хамгаалагдах, жам ёсоороо өөрийн сайн сайхныг эрэлхийлэх эрх зүйн анхдагч баталгаа юм. Тийм учраас орчин үед зарим амьтдад ч хамаатай эрх зүйн ерөнхий чадвараас хүнд хамааралтай тухайлсан чадварыг нарийвчлан тодорхойлох шаардлага үүсэж буй. Хүний нийгэмд зохих ёсоор аж төрөхөд хөдөлмөрлөх, өмчлөх, улс төрийн эрх чөлөөтэй байх, бусад хүний халдлагаас ангид байх зэрэг амьтны байгалийн орчинтой харьцуулахад нэгэнт бий болгосон нийгмийн зохион байгуулалттай салшгүй холбоотой, нарийн төвөгтэй эрхүүд, мөн үүргүүд нь хамгийн суурь шинжтэй болдог тул тэдгээрийг илүү тодорхой тусгах шаардлагатай байдаг аж.

Хүний эрх зүйн чадварын тухай

Хүний хувьд, эрх зүйн чадвар гэдэг нь тухайн хүн хувь болон бие хүнийхээ хувьд эрх зүйн этгээд байх, Үндсэн хууль болон хүний эрхийн суурь баримт бичгээр баталгаажсан, жам ёсны эрхүүдийг хэн нэгнээс ялгаваргүй ижил тэгш эдлэх төрмөл шинж, боломж юм.

Хэдийгээр эрх зүйн чадвар нь хүний хувьд төрснөөр эхэлж нас барснаар дуусгавар болохоор норматив эрх зүйн зохицуулалтад тусгагдах нь түгээмэл ч төрөхөөс өмнө, нас барсны дараа ч хэрэгжих боломжийг мөн хуульчилсан байдаг. Тухайлбал, иргэний хуулийн §40.3-т “Хэлцэл хийснээс хойш нас барсан,

эсхүл эрх зүйн бүрэн чадамжгүй болсон этгээдийн урьд нь хийсэн хэлцэл, илэрхийлсэн хүсэл зоригийн илэрхийлэл хүчин төгөлдөр хэвээр байна” гэсэн байна. Хүсэл зориг нь тухайн этгээдийн чадварыг бүхэлд нь тодорхойлохгүй ч, түүний салшгүй хэсэг мөн.

Хүний эрх зүйн чадварын агуулга нь энгийн мэт боловч тодорхой харилцаанд илүү төвөгтэй асуудалд хөтөлдөг. Тухайлбал, үр хөндөлтийг хориглосон улсуудад жам ёсны эрхийн үзэл санаанд үндэслэсэн ургийн эрх зүйн чадварт тулгуурлаж амьд явах эрхийг нь хамгаалж буй хэмээн тайлбарладаг бол нөгөө талаас хүүхэд төрүүлэхийг хүсэхгүй байгаа эмэгтэйчүүдийн бие махбодь, цаашлаад хувийн амьдралаа удирдан зохион байгуулах эрхийг ургаас илүүд үзэж хамгаалах позитив эрх зүйн зохицуулалтыг⁹ баримтлан маргадаг. Энд эх, ураг хоёрын эрх зүйн чадварын асуудал, цаашлаад эрх зүйн этгээд байх шалгуурын асуудлыг авч үзэх шаардлагатай болно.

Тодорхой шинж, хэрэгцээг нь харгалзвал, биологийн хувьд “хүн” биш оршихуй нь эрх зүйн хувьд “этгээд-эзэн бие” байж болох олон улсын эрх зүйн хүрээнд нэгэнт санал нэгдсэн байна.¹⁰ Харин биологийн хувьд “хүн” боловч эрх зүйн хувьд “этгээд-эзэн бие” биш байж болох тухай маргаан онолын хувьд одоо ч

⁹ Хүний эрх зүйн чадварыг төрсөн цагаас эхэлж тооцох, эсхүл хүний эрхийн зохицуулалт нь “хүн”-д чиглэсэн ба ураг нь хүн биш гэх мэт эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах хандлагыг хэлж байна. Энэ бүлэгт “хүн” буюу “эзэн бие, этгээд” байх шаардлагын талаар дэлгэрүүлж авч үзнэ.

¹⁰ Тухайлбал, өмнө дурдсан хуулийн этгээд (legal entity), зарим амьтан.

үргэлжилсэн хэвээр. Зарим хүмүүс хүнийг санаатайгаар алах, хүчиндэх, тарчлаах зэрэг хүнлэг биш хэрцгий араншингийнхаа улмаас “эрх зүйн этгээд” байх буюу эрх зүйн этгээд байхад тавигдах тулгуур шаардлага-хүнлэг шинжээ алдаж болно гэх үзэл ч бий. Түүхийн хувьд ийм үзэлд тулгуурлан олон нийтийн өмнө цаазаар авах, шатаах зэрэг хэрцгий хэргүүд үйлдэгдэж байв.

Дээр дурдсан үр хөндөлтийн асуудалд, хэвлийд бүрэлдсэн “ураг” нь генетикийн хувьд “хүн” мөн боловч эрх зүйн хувьд “этгээд”-ийн шинжийг агуулах эсэх? Эсвэл, сэтгэцийн, тархины болон мэдрэлийн эдгэрэшгүй хүнд өвтэй хүмүүсийн хувьд ч эрх зүйн этгээд байх шинжийг агуулж буй эсэх дээр философичид санал зөрөлдсөөр байна.

Судлаачид “этгээд” буюу объект бус эзэн бие байх шалгуурыг тодорхойлох оролдлогууд хийж, өөрсдийн санааг дэвшүүлж байжээ. Тухайлбал:

Генетикийн шалгуур-Хүний генетикийн мэдээллийг агуулсан байх нь субъектийг тодорхойлох гол шалгуур хэмээн үздэг, John T. Noonan-ы боловсруулсан санаа. Тэрээр уг онолоо үр хөндөлтийн асуудалд тулгуурлан дэвшүүлжээ. Хүний тухай үзэл баримтлал тухайн оршихуйд бүрэлдсэн цагаас эхлээд дуусах хүртэл хугацаанд тэрхүү оршихуй нь хүн буюу эзэн бие мөн гэж үздэг.¹¹ Энэ талаар тэрээр “Үр хөндөлтийн талаарх урт түүхийн явц дахь хамгийн тулгуур асуудалт нь: Хүнийг “хүн” гэдгийг

¹¹ John T. Noonan (ed.), *The Morality of Abortion* (Cambridge, Mass.: Harvard University Press, 1970)

хэрхэн тодорхойлох вэ? ¹²... Хүний потенциалтай учраас эхийн хэвлийд бүрэлдсэн цагаас нь ургийг хүн гэж үзнэ. Хүнийг тодорхойлох уг шалгуур нь тун энгийн – эр, эм хүний дундаас бүрэлдсэн л бол хүн мөн” гэжээ.¹³ Үр хөндөлтийн эсрэг агуулгын хүрээнд дэвшүүлсэн уг санаа нь зөвхөн хүн бус “этгээд” байх ерөнхий тодорхойлолтын хувьд ихээхэн шүүмжлэлтэй тулгардаг. Судлаачид эл онолд ихэвчлэн “эзэн бие байх чадамж”-ийн хувьд шүүмжлэлтэй ханддаг байна.

• *Когнитив шалгуур* – Америкийн философич Mary Anne Warren аливаа оршихуй нь нийгмийн харилцаанд хүлээн зөвшөөрөгдөх, хамгаалагдах буюу эзэн бие байхын тулд таван шалгуурыг хангасан байх ёстой хэмээн үзжээ:

- Өөрийн ухамсарт байдал – Өөрийн дотор болон гадаад ертөнцөд болж буй үйл явдал, объектыг ухамсарладаг, өвчин мэдрэх чадамжтай байх;
- Эргэцүүлэл – шинээр бий

12 Тэрээр энэ хэсэгт үр хөндөлтийн талаарх шашны зарим тайлбаруудад ургийн “сүнсгүй байдал” нь хүн биш байх статусыг голчлон илэрхийлж байсан бөгөөд сүнсгүй байдал, үр хөндөлтийн талаар шашны тухайлсан номлол байдаггүйг дурджээ. Гэвч өөрийн бүтээлдээ энэхүү сүнсгүй байдлын тухай тайлбарлах арга зүйг генетикийн сэдвийн хүрээнд авч ашиглажээ.

¹² The Morality of Abortion: Legal and Historical Perspectives, ed. John T. Noonan, Jr. (Cambridge: Harvard University Press 1970) pp. 51-59.

- болох, харьцангуй комплекс асуудлуудыг шийдвэрлэх сэтгэлгээний чадамжтай байдал;
- Өөрийн сэдэлт үйл ажиллагаа – генетикийн эсвэл гадны нөлөөлөл, удирдлагаас ангид, өөрийн сэдэл, сонирхлоор тодорхой үйл ажиллагаа явуулах;
- Харилцааны чадамж – олон төрлийн сэдвийн хүрээнд бусадтай ямарваа хэлбэрээр харилцан ойлголцох, харилцах чадамж;
- Өөрийн тусгаар оршихуй, “би”-гээ мэдэрдэг байх.

Тэрээр уг үндэслэлээ мөн үр хөндөх асуудлын хүрээнд дэвшүүлсэн бөгөөд “Хүн гэж хүлээн зөвшөөрөгдөхийн тулд эдгээр шинжүүдээс ядаж заримыг нь агуулсан байх ёстой ба эдгээр нь ёс суртахуунлаг хандлагын чухал бүрэлдэхүүн болох юм. Урагт эдгээр шинжүүд байдаггүй учраас үр хөндөлтийг хүлээн зөвшөөрч болно” гэж үзсэн байна.¹⁴ Мөн л дөнгөж төрсөн буюу нярай хүүхдэд дээрх шинжүүд байдаггүй учраас ерөнхий чадварын хувьд явцуу шалгуур хэмээх шүүмжлэлд өртдөг.

Нийгмийн шалгуур – Нийгмийн хандлага нь тухайн этгээдийн эзэн бие буюу субъект мөн эсэхийг шийдвэрлэнэ гэх үзэл. Хэн нэгэн тухайн этгээдэд санаа тавьдаг байх, түүнийг хүн гэж хүлээн зөвшөөрдөг байх нь хүнд тавигдах гол шалгуур гэж үздэг. Уг шалгуур нь хэт ерөнхий агуулгатай учраас түгээмэл хүлээн зөвшөөрөгддөггүй аж.

¹⁴ Warren, Mary Anne. On the Moral and Legal Status of Abortion - Biomedical Ethics (4th ed.). pp. 434-440. 1996

Зингерийн шалгуур – Амьтны эрхийг хамгаалах агуулгаар дэвшүүлсэн, Австралийн философич Петер Зингерийн эл шалгуур нь “Өвдөлт мэдрэх чадамжтай аливаа амьтдыг зовоох нь ёс суртахууны зөрчил” гэсэн санаанд тулгуурладаг бөгөөд эрх зүйн этгээдийн тухай номлолыг зөвхөн хүнээр үл хязгаарлан, өвдөлт мэдрдэг амьтан болгоны хууль зүйн хувьд хамгаалах ёстой (объектын хувьд биш, эзэн бие гэсэн утгаар) гэж үздэг.¹⁵

Америкийн философич Даниел Калахан эдгээр онолуудыг (1) гененикийн номлол; (2) хөгжлийн номлол; (3) нийгмийн үнэлэмжийн номлол хэмээн ангилсан байна.¹⁶ Эрх зүйн этгээд байх шалгуурын талаар эдгээр онолуудын алинд нь ч үл хамаарах, шалгуурыг тодорхойлох бус тохируулах агуулгатай өөр онол байдаг нь “харьцангуй онол”.¹⁷ Өөрөөр хэлбэл ямар шалгуураар хэнийг эрх зүйн этгээд гэж үзэх гэхээс илүүтэй хэнд илүү “эзэн биелэг шинж” байна вэ гэдгийг харьцуулж тодорхойлохыг оролддог. Тухайлбал, дөнгөж бүрэлдсэн үр хөврөл (эмбрион) боловсорсон урагтай харьцуулахад эзэн биелэг шинж багатай байдаг бол төрөөд удаагүй нярай хүүхэд ургаас илүү, насанд хүрэгч нь хүүхдээс илүү тэрхүү шинжийг агуулдаг хэмээн харьцуулж үнэлдэг.

¹⁵ Peter Singer. *Animal Liberation: A New Ethics for our Treatment of Animals*. 2015 (40th year anniversary edition). New York.

¹⁶ Gabriel Pastrana. *Personhood and the Beginning of Human Life*. *The Thomist: A Speculative Quarterly Review*, vol. 41 no. 2, 1977

¹⁷ The Gradient Theory. Монгол хэлнээ утгачилж орчуулав.

Бусад эрх зүйн этгээд байх боломжтой оролцогчдоос (хуулийн этгээд, зарим амьтан) хүний эрх зүйн чадвар нь Үндсэн хууль болон хүний эрхийн бусад баримт бичгээр баталгаажсан, жам ёсны эрхүүдийг хэн нэгнээс ялгаваргүй ижил тэгш эдлэх төрмөл шинж, боломж болдгоороо ялгагдана. Хүний эрхийн зохицуулалт нь амьтанд чиглэсэн, хүний бус эрхүүдээс¹⁸ амьдрах буюу хүрээлэн буй орчин, оюун ухааны нийтлэг түвшний ялгаа, шаардлагаар зааглагдаж, эрх зүйн чадварын хувьд ч илүү өргөн агуулгыг (өмчлөх, сурч боловсрох гэх мэт) багтаадаг аж.

Эрх зүйн чадвар ба иргэний эрх зүйн чадвар

Иргэний эрх зүйн чадвар нь иргэний эрх зүйд хамаарах тухайлсан субъектив эрхийг эдлэх боломж байдаг бол эрх зүйн (ерөнхий) чадвар нь илүү суурь шинжтэй. Өөрөөр хэлбэл, иргэний эрх зүйгээр үл хязгаарлагдах, тулгуур шаардлага, суурь боломж юм. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд ял оногдуулах явдал ч *буруутныг эрх зүйн чадвартай хэмээн хүлээн зөвшөөрснөөс үүдэлтэй*. Эрх зүйн чадвартай учраас эрх эдлэх, үүрэг хүлээх боломжтой ба түүнийгээ ухамсарладаг учраас гэм буруутай үйлдэл хийснийх нь төлөө эрүүгийн эрх зүйн хүрээнд ял хүлээлгэж буй. Тухайлбал, ихэнх улсад амьтныг ял хүлээх эрх зүйн чадваргүй гэж үздэг. Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн этгээд байх буюу эрх зүйн чадвартай байх ойлголт нь иргэний эрх зүйгээр

¹⁸ Nonhuman rights

олгогдсон, эдийн болон эдийн бус баялагтай холбоотой тодорхой төрлийн эрхүүдээс илүү суурь шинжтэй байдаг. Тухайлбал, амьд явах, халдашгүй байх гэх мэт. Энэ утгаараа эрх зүйн (ерөнхий) чадварыг хууль тогтоомж, гэрээ хэлцлээр хязгаарлаж үл болно. Хүний эрх зүйн чадварт тулгуурлан хязгаарлаж үл болох үндсэн эрхүүд тодорхойлогдоно. Тухайлбал Үндсэн хуулийн §19.2-т "Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө" гэжээ. Эрхээс гадна ерөнхий үүргүүд ч байна. Тухайлбал Үндсэн хуулийн §19.3-т "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй" гэж заажээ. Иргэний эрх зүйн чадвар нь баялагтай холбоотой тухайлсан эрхүүдийн боломжийг илэрхийлдэг утгаараа хязгаарлагдаж болдог. Монгол Улсын хууль тогтоомжиос үзэхэд иргэний эрх зүйн чадварыг хязгаарлах үндэслэлийг эрхийн шинжээр биш, субъектийн шинжээр нь тодорхойлж өгсөн байна. Тухайлбал, иргэний хуулинд иргэний эрх зүйн чадварын агуулгыг тодорхойлоогүй ч (§14), хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадварын

талаар тухайн зохицуулсан байна (§§26.3-26.8). Мөн иргэний эрх зүйн чадварыг хязгаарлахыг хориглодог боловч (§14.2), хуулийн этгээдийн болон гадаадын иргэний эрх зүйн чадварыг хязгаарлах боломжтойгоор зохицуулжээ.¹⁹

Эрх зүйн этгээдээс хасагдах, эрх зүйн чадваргүйд тооцогдох

Түүхэнд үргэлж хүн бүрийг эрх зүйн чадвартай хэмээн тооцож байгаагүй ч бүлэг дотроо нэгнийгээ тодорхой гэм буруугүй бол ядаж амьд явах эрхтэй гэж үздэг байв. Шашны, уламжлалын гэх мэт нийгмийн хэм хэмжээгээр нийгэм бүлгийг давхраажуулах, шаталж үзэх, угсаа гарвалаар ангилан ялгаварлах явдал цөөнгүй байсан ч харц ардыг ч хүн хэмээн үзэж нийгэмд аж төрөхөд шаардлагатай анхдагч эрхүүдийг нь хүлээн зөвшөөрдөг байжээ. Олон мянган жилийн боолчлолын түүхийг эс тооцвол хүмүүс өөр хоорондоо ижил гэх үзэл өчүүхэн ч атугай оршсоор байж. Тиймдээ ч язгууртан, хаад өөрсдийгөө хүн биш, бурхан эсвэл бурхнаас шууд заяасан, бурханлиг шинжтэй гэх мэтээр хүнээс илүүд үзэгдэх бэлгэдэлт сэтгэлгээний аргыг түгээмэл ашигладаг байв. Тэр утгаараа хэн нэгэн хүн бусад хүнд гэм хор учруулсан бол түүнийхээ төлөө хариуцлага хүлээх ёстой, эсвэл бусдаас зээл авсан бол эргүүлэн төлөх үүрэгтэй гэсэн шударга ёсны зарчим ч хүмүүсийн мэдрэмжид олон зуун жилийн өмнөөс төлөвшиж тогтжээ.

¹⁹ Иргэний хуулийн §§26.9; 543.1.

Тэгш байдал, шударга ёс, зүй ёсны зарчмууд, хүний эрхэм чанарын мэдрэхүй ийм эртнээс уламжилж ирсэнтэй холбогдуулан гэм буруутай, эсвэл үүрэгтэй этгээдэд хариуцлага тооцохдоо хүнийх нь хувьд үнэлж үздэг байсан ч мөн хүний тооноос хасах, хүн биш гэж тооцох явдал ч бас байдаг байжээ. Эрх зүйн үзэл санааны үүднээс ийм заншлууд нь хүнийг эрх зүйн этгээд биш гэж үзэх, эрх зүйн чадварыг нь хүчингүй болгох шинжтэй байв.

Homo sacer

Ромын эрх зүйд "Homo sacer"²⁰ (лат. хараагдсан хүн) гэдгээр эрх зүй, шашны хувьд орхигдсон бөгөөд нийгмийн ойлголтоор хүнд үл тооцогдох, бүхий л эрхээ хасуулсан хүнийг хэлдэг байв. Гэм буруутайд тооцогдон орхигдсон "homo sacer"-ийг хэн ч гэмтээх, алах бүрэн эрхтэй боловч золиос болгох зэрэг шашны зан үйлд оролцуулахыг хориглодог байжээ.²¹ Ийнхүү хөсөр хаяхын шалтгаан нь шашны сэдэлтэй байсан байх магадлал өндөр бөгөөд шашиндаа буруудсан хүнийг "бурхан өөрөө шүүг" хэмээн хүний хуулийн хамгаалалтаас гаргадаг байсан байж магадгүй талаар зарим эх сурвалжид²² дурдсан байна. Ромын 12 таблетийн хуулийн 8 дахь таблетийн 21 дэх заалтад: "Патрон

нь клиентээ хуурсан бол хараагдана" гэж заасан нь homo sacer болгох шууд зохицуулалт юм.

"Homo sacer" болгож зарлах нь гэм буруутай этгээдийн албан ёсны шийтгэл учраас бусад хүн, нийгэм түүнийг албан ёсоор нэмж шийтгэхгүй (гэмтээх, цаазаар авах гэх мэт). Нэгэнт эрх зүйн этгээд биш, хүн биш хэмээн тооцогдсон тул түүнийг хүний хуулиар, албан ёсоор шүүх ажиллагаа явуулж шийтгэх үндэслэлгүй ч болох юм. Харин албан бусаар тийнхүү шийтгэсэн тохиолдолд (хэн ч хамаагүй) хариуцлага хүлээдэггүй байсан нь²³ орчин үеийн эрх зүйн хувьд түүний эрх зүйн чадварыг хүчингүй болгосонтой дүйх аж.

Эртний Европын эрх зүй дэх Хүн чоно

Судлаачид эртний Германы эрх зүйн тогтолцоо нь энх тайван ба гэм буруутай этгээдийг тухайн энх тайван бүхий нийгмээс зайлуулах гэсэн хоёр дэнсэн дээр тулгуурласан гэж үздэг. Буруу зүйл хийсэн гэм буруутай этгээд нь "энх тайвангүй нэгэн (гер: friedlos)" болж хувирах бөгөөд түүнийг хэн ч хөнөөх эрхтэй байв.²⁴ Энэ нь Ромын "Homo sacer"-тай агуулгын хувьд ихээхэн төстэй, бараг ижил гэж болох боловч философийн үндэслэл нь өөр аж. Ромын католик шашны homo sacer нь католик шашны философид тулгуурласан бөгөөд "шашинд орхигдсон, бурхандаа буруудсан" байдаг бол эртний Герман, Англи-Саксоны эрх зүй дэх дээрх ойлголт

²⁰ Уг нэршил нь "хүний нийгмээс ангид, огоорогдсон" гэсэн шашны утгатай бөгөөд англи хэлнээ "sacred" хэмээн хөрвөжээ. Латинаар "гэгээрсэн, эсвэл хараагдсан" гэсэн утгыг илэрхийлнэ. Дээрх хам утгад гэм буруутай этгээдийн талаарх өгүүлж буй тул хараагдсан гэдгээр орчуулав.

²¹ Agamben, Giorgio. Heller-Roazen, trans. *Homo Sacer: Sovereign Power and Bare Life* Stanford, California: Stanford University Press, 1 April 1998. 72.

²² Stefan Jonsson. *A Brief History of the Masses: (three Revolutions)*. 2008 pp 167.

²³ Мөн тэнд.

²⁴ Vikki Bell. *The Shooting of Jean Charles de Menezes: On Agamben*. Goldsmiths Research Online. 2007

нь “нийгэм, хамт олондоо хаягдсан” шинжтэй байдаг.

Дундад зууны Герман, Скандинав, Англи-Саксоны улсуудын энэ талаарх санаанд нийтлэг зүйл ажиглагддаг нь тийнхүү хаягдсан этгээдийг “хүн-чоно” хэмээн нэрийдэх, зүйрлэх явдал юм. Энэ талаар Италийн философич Giorgio Agamben: “Нийтлэг үл ухамсарлахуйд буусан дүр нь хүн, амьтан хоёрын аймшигт холимог, хүний хот харанхуй ой хоёрт хуваагдсан хүн-чоно: хотоос цөлөгдсөн, хүн ч биш, чоно ч биш, бүдэг бадгийн тод зураас, амьтан-хүний нэгдэх сав” хэмээн дүрсэлжээ.²⁵ Үндсэн санаа нь хүний соёлт зан суртахууныг зөрчиж буруутай үйлдэл хийсэн зэрлэг араатан мэт этгээдийг хүний нийгмээс зайлуулан ойд чоно мэт амьдар хэмээн цөллөө гэж үзсэн хэрэг. Тийнхүү тэр хүнд эрх зүйн хүн ёсны хамгаалалт үйлчлэхгүй болдог ажээ.

²⁵ Giorgio Agamben. *Homo Sacer: Sovereign Power and Bare Life*. 1998. Pp105

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙД



*Шихихутуг их сургуулийн Нийтийн
эрх зүйн тэнхимийн багш.
Докторант Г.Батнасан*

Агуулга:

Түлхүүр үгс, хураангуй

Оршил

Нэг. Онолын асуудал

Хоёр. Олон улсын туршлага

Гурав. Дотоодын эрх зүйн зохицуулалт ба түүнд тулгамдсан асуудал

Дүгнэлт

Түлхүүр үгс: Төр хувийн хэвшлийн түншлэл, захиргааны гэрээ, концесс,

Хураангуй: Төр, хувийн хэвшлийн түншлэл гэдгийг олон улсын худалдааны байгууллагаас тодорхойлохдоо Засгийн газар, ажил олгогчид, ажилчдын төлөөлөгчдийн хооронд эдийн засаг, нийгмийн бодлоготой холбоотой нийтлэг ашиг сонирхлын асуудлаар хэлэлцэн тохиролцох, зөвлөлдөх, мэдээлэл солилцох бүх хэлбэрийг хамруулсан ойлголт юм.

Оршил

Олон улсын хэмжээнд Төр хувийн хэвшлийн түншлэл /цаашид ТХХТ гэх/ хэмээх нэр томъёог төрийн болон хувийн секторын аж ахуйн нэгжүүдийн хооронд байгуулдаг олон төрлийн гэрээний талаар ярихдаа ашигладаг бөгөөд ТХХТ-ийн хөтөлбөр нь өргөжин хөгжихийн хэрээр улс орнууд ТХХТ-ийн өөр өөр тодорхойлолтуудыг бий болгон ашиглаж ирсэн байдаг. Гэсэн хэдий ч ТХХТ-ийн гэрээ гэдэг нь төрийн хийх ёстой нийтийн зориулалтай ажил үйлчилгээг төрийн ба хувийн аж нэгж хамтарч хийхээр тэдгээрийн хооронд байгуулдаг удаан хугацааны гэрээ хэмээн ойлгодог нийтлэг ойлголт дээр тэдгээр тодорхойлолтууд төвлөрч байдаг.¹ Өөрөөр хэлбэл нийтийн зориулалттай ажил, үйлчилгээг төр хувийн хэвшилтэй хамтарч гүйцэтгэх юм. Улс орон бүр төсөл арга хэмжээг гүйцэтгэхдээ дараах хөрөнгөөр санхүүжүүлдэг:

1. Тухайн улсын төсвийн хөрөнгөөр
2. Гадаад улс орны хөнгөлттэй болон буцалтгүй тусламжаар
3. Засгийн газар Зээллэг/Бонд/ -оор
4. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар
5. Төр хувийн хэвшлийн түншлэлээр **/Концесс/** санхүүжүүлдэг байна. Эдгээр санхүүжилтээс тухайн төсөл хөтөлбөрт тохирсон эдийн засгийн үндэслэлтэй санхүүжилтийг хэрэглэдэг.

Орчин үеийн захиргааны үйл ажиллагааны өөрчлөлтийн гол

¹ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гарын авлага, УБ хот, 2013 он, 10 дах тал

агуулга нь иргэдэд төрийн үйлчилгээг аль болох бага зардлаар, хамгийн үр дүнтэй хүргэх, аливаа хүнд суртал чирэгдлийг багасгахад чиглэгдэж буй юм. Иргэдэд хүргэх **/төрийн хийх ёстой/** нийтийн үйлчилгээг хувийн хэвшилтэй хамтарч гүйцэтгэх нь эдийн засгийн хувьд хамгийн зөв сонголт юм.

Нэг. Онолын асуудал

Улс орны эдийн засгийн болон төрийн хэлбэр, тогтолцоо, хэв маягийн тухай асуудал нь тус тусдаа шинжлэх ухааны өөр өөр судлагдахуун боловч эдгээр нь бие биенээ харилцан нөхцөлдүүлж байдаг нийгэм, эдийн засаг, улс төр, хууль зүйн ойлголт билээ. Төр, эдийн засгийн харилцан холбоо нь аль ч улс оронд төр анх үүссэн цагаас эхлэн бий болсон бөгөөд аж ахуй, зохион байгуулалтын үүргийг тодорхой арга, хэлбэрүүдээр хэрэгжүүлсээр ирсэн байна.² Эдийн засаг дах төрийн оролцоо, зохицуулалтын хэмжээ, хязгаарын тухай асуудал нь түүхийн хөгжлийн явцад янз бүрээр тодорхойлогдсоор ирсэн. Дундад зууны үеийн жижиг хэмжээний натурал эдийн засгийн үед төрийн оролцооны тухай ойлголт тодорхой хэмжээнд байсан хэдий ч төдийлөн хүчтэй хөгжөөгүй, хөгжих бодит шалтгаан, шаардлага ч байсангүй. Харин шинэ цагийн үед³ /сэргэн мандалтын үе/ улс төр, эдийн засгийн тогтолцоон дах төр болон эдийн засгийн хоорондын

харилцааны асуудал нь илүү нухацтайгаар өргөн хүрээнд яригдах болжээ. Өөрөөр хэлбэл төрөөс эдийн засгийн бүтэц, тогтолцоог бий болгох, өөрчилж болох тухай үзэл баримтлал нь шинэ цаг үеийн бүтээл юм.⁴ XVI зууны нийгэм, эдийн улс төрийн хүчтэй тэсрэлт нь энэхүү салбарт ч мөн өөрчлөлтийг авчирсан байна. Энэ үеийн эдийн засгийн сэтгэлгээний хөгжлийг үндсэн хоёр урсгал тодорхойлдог. Үүнд нэг нь төрөөс эдийн засгийн процесст хүчтэй оролцож түүний зохицуулах, удирдах ёстой гэж үздэг бол нөгөө нь үүнийг эрс эсэргүүцдэг байна.⁵

Public Private Partnership /PPP/ буюу төр, хувийн хэвшлийн түншлэл гэдгийг олон улсын худалдааны байгууллагаас тодорхойлохдоо Засгийн газар, ажил олгогчид, ажилчдын төлөөлөгчдийн хооронд эдийн засаг, нийгмийн бодлоготой холбоотой нийтлэг ашиг сонирхлын асуудлаар хэлэлцэн тохиролцох, зөвлөлдөх, мэдээлэл солилцох бүх хэлбэрийг хамруулсан ойлголт юм. Өөрөөр хэлбэл төрөл бүрийн салбаруудын эрх тэгш этгээдүүдэд сайн дурын үндсэн дээр нэгдсэн эрсдэлтэй асуудлаа хамтран шийдвэрлэх, үүрэг хариуцлага, чадамж болон нөөц бололцоогоо хуваалцах замаар адил зорилгууддаа хүрэхийг хэлнэ гэжээ.⁶

Төрийн удирдлага, захиргааны

⁴ Г.Банзрагч – Эдийн засгийн захиргааны эрх зүй УБ хот 2013 он 13 дах тал

⁵ Werner Frotcher, Wirtschaftsverfassungs- und Wirtschafts-verwaltungsrecht, х.8. м.13; Jarass, Wirtschaftsverwaltungsrecht – und Wirtschafts-verfassungsrecht, х.43, м.2 дам ишлэв

⁶ Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтуудыг ажил олгогч эзэд, бизнес эрхлэгчдийн оролцоо, гарын авлага, УБ хот, 2009 он, 36 дэх тал дам ишлэв

² Т.Мөнхжаргал Эдийн засгийн харилцааны эрх зүйн зохицуулалт 1 дэх тал дам ишлэв.

³ Европын түүхийн антик буюу эртний, дундад зууны, шинэ цагийн гэсэн гурван үед хуваах бөгөөд шинэ цагийн үед ойролцоогоор XVI зуунаас хойших хугацааг хамруулдаг байна дам ишлэв.

шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлэх үйл явц нь ихэвчлэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд явагддаг ба төрийн эрх, үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэх хэд хэдэн хэлбэрийг ангилж болохоор байна. Үүнд:

- a. **Концессын гэрээ** /Төрийн зүгээс хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах хэлбэр/
- b. **Тендерийн гэрээ** /Төрийн хөрөнгөөр хувийн хэвшлээр ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх хэлбэр/
- c. **Өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага, мэргэжлийн холбоодоор төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх** /Зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, төрийн байгууллагын зарим чиг үүргээс зах зээлийн хяналт, зохицуулалтын зарим эрх, үүргийг мэргэжлийн холбоод, нийгэмлэгүүдэд шилжүүлснээр зах зээлийн өөрөө өөрийгөө зохицуулах механизмыг төлөвшүүлэх, шаталсан хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх хэлбэр/
- d. **Аутсорсинг** /Тухайн хэрэгцээт ажил үйлчилгээг нарийн мэргэшсэн мэргэжлийн байгууллага, хувь хүмүүсээр гүйцэтгүүлэх хэлбэр/ гэх зэрэг.

Концесс нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэг хэлбэр бөгөөд төр, концесс эзэмшигчид

байгалийн баялаг, газар, дэд бүтцийн объектууд, үйлдвэрийн газар бусад аж ахуйн объектууд, тоног төхөөрөмжийг гэрээний үндсэн дээр харилцан ашигтай нөхцөлөөр ашиглуулахаар шилжүүлэх хэлбэр юм. Концессын гэрээний зүйл буюу объект нь гол төлөв нийтийн шинж чанартай объектууд байдаг, тухайлбал, нисэх буудал, төмөр зам, барилга байгууламж, дэд бүтцийн байгууламжууд мөн нийтийн тээврийн тогтолцоо, эрүүл мэнд, боловсрол, соёл, спортын объектууд зэрэг болно.

Төр, хувийн хэвшлийн олон хэлбэрүүд байдаг. Тухайлбал:⁷

- a. **Хамтын нийгэмлэгийн буюу хоршооллын загвар:** Нийтийн болон хувийн эрх зүйн этгээдүүд буюу төр, хувийн хэвшил хамтран холимог хэлбэрийн эдийн засгийн нийгэмлэг буюу хоршоо байгуулах, ингэхдээ ихэнхдээ нийтийн эзэмшлийн хувь хэмжээ нь давамгай байдалтай, жишээ нь төрийн оролцоо 51 хувь байна. /Cesellschafts-bzw. Kooperationsmodell/
- b. **Ашиглах загвар:** 30 хүртэлх жил үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд хувийн хэвшлийн этгээдээс нийтийн эрх зүйн хамтрагчийн /төрийн/байнгын нөхөнтөлбөрийн хариуд нийтийн ашиглалтын байгууламжийг төлөвлөх, барих санхүүжүүлэх, ашиглах, төслийн хугацаа дуусахад түүнийг төрд шилжүүлэхийг хэлнэ. /Erwerbermodell/

⁷ Jan Ziekow, Oeffentliches Wirtschaftsrecht, x.143-144 дам ишлэв

- с. Лизингийн загвар:** 30 хүртэлх жилийн хугацаанд мөн хувийн хэвшлийн этгээд нь байгууламжийг төлөвлөх, барих, санхүүжүүлж, барьж, ашигласан байгууламжаа төрд түрээслэх замаар нийтийн эзэмшилд ашиглуулна. Гэрээгээр тохиролцсон тохиолдолд байгууламжийг төр худалдан авна. /*Vermietungsmodell*/
- d. Эзэмшигчийн загвар:** 15-20 хүртэлх жил үргэлжлэх бөгөөд хувийн хэвшлийн этгээд нь нийтийн эрх зүйн хамтрагчийн /төрийн/ байгууламжийг сайжруулах, засварлах, ашиглах эрхийг эдэлнэ. /*Inhabermodell*/
- e. Гэрээний загвар:** 15 хүртэлх жил үргэлжилнэ; захиалгын буюу гэрээний зүйл нь хувийн хэвшлийн этгээдээр бариулж, сайжруулж, эцэст нь ашиглагдах тодорхой нэг байгууламжийн тусгайлсан хэсэг нь байдгаараа онцлог. /*Contractingmodell*/
- f. Концессын загвар:** дээр дурдсан эхний дөрвөн загварын холимон хэлбэр бүхий онцгой загвар бөгөөд хувийн хэвшлийн этгээд нь үйл ажиллагаагаа нийтийн эрх зүйн түншлэгчээс тогтмол төлөх нөхөн төлбөрөөр биш өөрт олгогдсон эрхийн үндсэн дээр ашиглалтын төлбөрийг нэмэгдүүлэх байдлаар дахин санхүүжүүлдгээрээ өмнөх загваруудаас ялгаатай. /*Konzessionsmodell*/
- А. Хамтын харилцаа болох ажиллагаа нь төрийн болон хувийн хэвшлийн хоёр бас түүнээс дээш оролцогчтой байх. Хувийн хэвшил нь аж ахуйн нэгж байгууллага байхаас гадна зарим тохиолдолд ашгийн бус байгууллага буюу төрийн бус байгууллага байж болно.**
- В. Оролцогч тал бүр эзэн байх, өөрөөр хэлбэл оролцогчид нь ямар нэгэн эрх мэдэл бүхий байгууллагаас үл хамааран өөрийн нэрийн өмнөөс гэрээ хэлэлцээр хийх чадвартай байх.**
- С. Түншлэл нь оролцогчдын хооронд урт хугацаанд тогтвортой үргэлжлэх харилцааг бий болгоно. Жишээ нь засгийн газрын агентлаг нь жил бүр өөр өөр нийлүүлэгчээс бараа, ажил үйлчилгээ авдаг бол түүнийг түншлэл гэж үзэхгүй, харин засгийн газрын худалдан авах ажиллагаа байж болно.**
- D. Түншлэлд оролцогч талууд тодорхой зүйлийг хамтран эзэмшиж ашиглана. Тиймээс түншлэл жинхэнэ харилцаа болохын тулд оролцогч талууд материаллаг болон материаллаг бус нөөцийг хамтын өмчлөл, ашиглалтад шилжүүлэх шаардлагатай.**
- Е. Түншлэл нь үр дүн эсвэл үйл ажиллагааны төлөө хариуцлага хуваалцахыг илэрхийлнэ. Харин төр хувийн хэвшлийн байгууллагаас аливаа туслалцаа, үйлчилгээ авсан ч бодлогын шийдвэрийн биелэлтийг хянах эрхээ өөрт үлдээдэг бусад харилцаанаас ялгаатай.⁹**

Дээр дурдсанчлан төр, хувийн хэвшлийн олон хэлбэрүүд байх хэдий ч тэдгээрт нийтлэг хэд хэдэн шинж байдаг. **Үүнд:**⁸

⁸ Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгэх боломж, "Удирдахуйн онол, практикийн асуудлууд" эрдэм шинжилгээний бичиг №9, х-2 дам ишлэв

⁹ Г.Банзрагч – Эдийн засгийн захиргааны эрх зүй УБ хот 2013 он 21 дэх тал

Төр хувийн хэвшлийн түншлэл нь ихэвчлэн төсвийн хөрөнгийн оролцоотой хийгдэх боловч түүнийг эргэн төлөх болон үйл ажиллагааны зардлаа хэсэгчлэн болон бүхлээр нь хэрэглэгчийн хураамж шимтгэлээр нөхдөг байна.

Хоёр. Олон улсын туршлага

- АВСТРАЛИ УЛС

Австрали улс нь төрийн бүтцийн хувьд парламентын засаглалтай Холбооны Засгийн газар бүхий тогтолцоотой бөгөөд ТХХТ /Төр Хувийн Хэвшлийн Түншлэл/ төсөл, хөтөлбөрүүд нь голчлон нэгдсэн Засгийн газар гэхээсээ илүү Холбооны муж улсаар дамжин, бие даан хэрэгжиж эхэлсэн. Мужуудын засаг захиргаа нь эдийн засгийн болон нийгмийн дэд бүтцийн асуудлыг хариуцан, хүн амын хэрэгцээнд нийлүүлэх ажлын тэргүүлэх үүргийг гүйцэтгэдэг.

Бодлого, хууль эрх зүйн орчин ТХХТ-ийг хэрэгжүүлэхдээ дараах бодлого, хууль эрх зүйн актын дагуу хэрэгжүүлдэг.

- **Хууль эрх зүй:** Австралийн Үндсэн хууль (Constitution), Төрийн үйлчилгээний тухай хууль (Public Service Act) 1999, Эрүүгийн хууль (Crimes Act) 1914, Хяналт шалгалтын ерөнхий хууль (Auditor-General Act) 1997, Санхүүжилтийн тухай хууль (Appropriation Acts), Иргэний түншлэлийн тухай хууль (Civil Partnership Act) 2004.

- **Бодлогын баримт бичиг:** Викториа хамтын ажиллагааны тухай (Partnerships Victoria) 2000, Нээлттэй өрсөлдөөний бодлого (Open Competition), Албан тайлангийн баримтлах бодлого (Mandatory Reporting), Төрийн

үйл ажиллагааны үндсэн чиглэл (Public Works).

- **Санхүүгийн менежментийн хууль зүйн орчин:** Санхүүгийн удирдлага ба хариуцлагын тухай хууль (Financial Management and Accountability Act) 1997 болон хуультай холбогдож гарсан дүрэм, журам, тогтоолууд (Orders,), Хамтын нөхөрлөлийн орнуудын компани болон тэдгээрийн зохицуулалтын тухай хууль (Commonwealth Authorities and Companies Act) 1997, хуультай холбогдолтой гарсан тогтоолууд (Commonwealth Authorities and Companies Regulations). Викториа мужид хувийн хэвшил дэд бүтцийн салбарт гар бие оролцож, бүтээн байгуулах болсон үеийг цаг хугацааны хувьд 2000 оноос өмнөх болон 2000 оны дараах үе гэж ерөнхийд нь хоёр хуваан авч үздэг байна.

2000 онд гарсан “Partnerships Victoria” бодлогын баримт бичиг нь хамтын хэлэлцээр хийхийн өмнөх шийдвэр гаргалт, хамтын ажиллагааны гэрээ байгуулах, төслийн менежмент, мониторинг ба хяналтын хийх асуудлыг багтаасан цогц заавар журмуудыг анхлан тодорхойлжээ. Түүнээс хойш уг удирдамжийг байнга сайжруулан шинэчилж, хэрэгцээт жишээ хэв загваруудыг багтааснаараа цаг үетэйгээ нийцэж Австралийн бусад мужуудын хувьд төдийгүй олон улсын түвшинд стандарт, үлгэр дуурайлал болон хэрэглэгддэг байна. Викториа мужийн Хамтын Ажиллагааны арга барилын салшгүй гол санаа нь Засгийн газар актив хөрөнгө худалдан авч байгаа бус,

харин зөвшөөрөгдсөн чанартай, тоо хэмжээтэй, тогтоосон зардалтай болон заасан цаг хугацаатай ажил үйлчилгээг хувийн хэвшлээс худалдан авч байгаа явдал юм.

ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ВАНТ УЛС

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсад XVIII зуунаас анх эхлэн орон нутгийн баян хүмүүс зээлийн сан бий болгон хувийн хөрөнгө оруулагчдаас хөрөнгө мөнгө зээлж, эвдэрч муудсан зам засаж түүнийгээ ашиглуулахдаа хэрэглэгчийн хураамжийн шимтгэл авч зээлсэн өрөө буцаан төлдөг байжээ. Анх Лейборист намын засгийн газар 1997 онд иргэдэд өндөр чанартай төрийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хамтран ажиллах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх стратеги зорилт дэвшүүлэхдээ ТХХТ-ийг санаачилж, улмаар 2000 онд Их Британи улсын ТХХТ-ийн төв болсон Их Британи Түншлэл¹⁰ байгууллага бий болж үйл ажиллагаагаа эхэлжээ.

Хууль эрх зүйн орчин: Их Британийн Төрийн үйлчилгээний тухай хууль 2009 онд шинэчлэгдсэн, Захиргааны байгууллагын шинэчлэлийн тухай хууль 2001 он, Төрийн зохицуулалтыг шинэчлэх болон харилцан тохиролцох гэрээ хийх тухай хууль 1994 он, Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль 2000 он, Төрийн үйлчилгээний гомдол шийдвэрлэх тухай хууль 2005 он¹¹, Иргэний түншлэлийн тухай хууль¹² 2004 онд тус тус батлагдан гарсан байдаг.

¹⁰ Partnerships UK-PUK..., Орчуулга

¹¹ Public Services Ombudsman /Wales/ Act..., Орчуулга

¹² Civil Partnership Act..., Орчуулга

Бодлогын баримт бичиг: Их Британи Түншлэл байгууллага нь 2000 он, Засгийн газар болон иргэний секторын хоорондын хамтын ажиллагааны гэрээ Их Британийн дотоод хэргийн яам ¹³2004 он, Иргэний Харти ¹⁴ 1991 онд батлагдсан баримт бичиг байдаг.

ИХ БРИТАНЫ ТҮНШЛЭЛ Partnerships UK-PUK/байгууллага: ИХ БРИТАНИЙН ТҮНШЛЭЛ байгууллага нь ашгийн бус статустай бөгөөд анх тус улсын Сангийн яамны бүтцийн¹⁵ нэг хэсэг байсан бөгөөд өнөөдөр 51 хувь нь хувийн салбарын пүүс кампаниуд, үлдсэн 49 хувийн хувьцааг Сангийн Яам¹⁶ болон *Scottish Executive* эзэмшдэг байна. Түүнийг Сангийн Яам болон төрийн салбарын бусад байгууллагууд бодлогын хүрээнд дэмжих үүрэгтэй ажилладаг байна. PUK хөрөнгөө хувь эзэмшигчдээс зээлийн хувьцаа хэлбэрээр босгож, зөвхөн шинээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжих болон төрөөс баримтлах ТХХТ-ийн зорилтын хүрээнд шинэ бизнес хэрэгжүүлэхэд зориулж ашигладаг, илүүдэл ашгийг буцаан хөрөнгө оруулдаг ба хувь эзэмшигч нарт олгодоггүй байна.¹⁷

PUK улсын салбарт гагцхүү доорх 5 үндсэн салбарт ажлаа явуулахаар тогтжээ. **Үүнд:**

1. Цогц худалдан авалтын төслүүдийг дэмжих
2. Хөрөнгө оруулалтын болон худалдан авалтын бодлогыг хөгжүүлэх
3. Бие даасан дэд бүтцийн төслүүдийг боловсруулах

¹³ Memorandum the civil partnership..., Орчуулга

¹⁴ Citizens charter..., Орчуулга

¹⁵ Treasury Taskforce..., Орчуулга

¹⁶ HM Treasury..., Орчуулга

¹⁷ United Kingdom Treasury - Public Private Partnership policy and guidance..., орчуулга

4. Төрийн үйлчилгээ ханган нийлүүлэгчийн загварыг боловсруулах
5. Төсөл болон компаниудад хөрөнгө оруулах

PUK-ын ажлын албаны баг 80 орчим хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд хувийн болон төрийн байгууллагын ажилтнууд багтдаг. Хувийн салбарын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор 2003 онд анхны хөрөнгө оруулалтын сан байгуулагдсан. Мөн Төслийн мэдээллийн сан, Үйл ажиллагааны туслалцааны нэгж, (Operationa Maskforce) болон хэрэгжиж буй төслүүдийн хэрэглэгчдийг дэмжих үүрэгтэй "Мэдээллийн технологийн харилцааны туслах төв" нээгджээ.

- КАНАД УЛС

Канад нь арван муж, гурван нутаг дэвсгэрээс тогтсон холбооны улс бөгөөд парламентын засаглалтай ардчилсан, үндсэн хуульт хаант улс юм. Канад нь технологийн хувьд хөгжсөн, аж үйлдвэржсэн орон юм. Канад улс нь Төр хувийн хэвшлийн түншлэлийг 1988 оноос эхлэн өнөөг хүртэл амжилттай хэрэгжүүлж байгаа орны нэг юм. 2000 оноос эхлэн ТХХТ-ийн үйл ажиллагаа өргөн далайцтай эрчимтэйгээр хөгжиж, орон нутгийн шинж чанартай хөтөлбөрүүд нь ихэнх тохиолдолд Барих-санхүүжүүлэх болон Төсөл санаачлах-барих-санхүүжүүлэх-ажиллуулах загвараар хэрэгжиж байна.

Канадын ТХХТ-ийн Үндэсний зөвлөл (1998) ТХХТ-ийг төрийн болон хувийн хэвшлийн хооронд бие биенийхээ экспертиз дээр суурилсан, нөөцийн, эрсдэлийн ба ашгийн зохистой хуваарилалтаар дамжуулан олон нийтийн хэрэгцээг хамгийн сайнаар хангах хамтарсан

нэгдэл гэж тодорхойлдог байна. Үндэсний зөвлөл нь гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг жинхэнэ ТХХТ гэж үздэггүй. Канад улсад ТХХТ нь амжилттайгаар хэрэгжиж буй үндсэн хүчин зүйл нь:

- Олон улсын сонирхогч талыг татан оролцуулсан
- Хувийн салбарын хөрөнгө босгох бололцоо өндөр (тэтгэврийн сан, даатгалын сан, хувийн хөрөнгө)
- Засгийн газрын (нам бус) болон олон нийтийн дэмжлэг нэн өсч буй
- Төрийн салбар дахь холбоодын эерэг хандлага, эсэргүүцэл багассан байдал
- Дээд түвшний улс төрийн хатуу манлайлал зэрэг байна.

Хууль эрх зүйн орчин: Хууль эрх зүйн хувьд Канадын холбооны хууль болон мужийн хуулиудаар зохицуулагддаг. **Голлох хуулиудад:**

1. Канадын стратегийн дэд бүтцийн санхүүгийн тухай хууль¹⁸

Хуульд стратегийн дэд бүтцийг тодорхойлж өгсөн. Үүнд:

1. Авто зам болон төмөр зам
2. Орон нутгийн тээврийн харилцаа
3. Аялал жуулчлал болон хотын хөгжил
4. Бохир ус цэвэршүүлэх
5. Цэвэр ус салбарыг хуульчилсан байна.

- АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-д дэд бүтцийг ханган нийлүүлэхэд хувийн салбарын оролцоо бусад орнуудтай харьцуулахад харьцангуй голлох байр суурь эзэлж байна. Холбооны мужийн болон орон нутгийн засаг

¹⁸ Canada Strategic Infrastructure Fund Act., Орчуулга

захиргааны нэгжийн хэмжээнд дараах ажил үүргүүдийг гэрээгээр гүйцэтгүүлдэг байна. **Тухайлбал:**

1. Цэвэр болон бохир ус
2. Хог хаягдлын үйлчилгээ
3. Нийтийн аж ахуйн үйлчилгээ
4. Барилгын засвар үйлчилгээ
5. Архитектур ба инженерийн үйлчилгээ
6. Түргэн тусламжийн үйлчилгээ
7. Барилга, байгууламжийн менежментийн удирдлага ба ашиглалт гэх мэт.¹⁹

Мөн хувийн хэвшил дангаараа эсхүл улсын салбартай хамтарсан хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төлбөрт авто замын барилгын ажлууд орно. Хувийн салбарын пүүс компаниуд бас нийгмийн салбар болох сургууль, халамжийн үйлчилгээний хөтөлбөр, хотын дотоод хөгжлийн дахин сайжруулалт болон төрийн барилга байшин барих зэрэг ажил үүргийг Төр хувийн хэвшлийн түншлэлийн зохицуулалтаар хийдэг.

Хууль, эрх зүйн орчин: АНУ-ын хувьд Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн үйлчилгээний тухай хууль болон бусад салбарын хуулиудаар зохицуулагддаг байна. Харин өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагуудын хувьд Канадаас нэлээд туршлага солилцож эрчимтэй хөгжүүлж байгаа улсуудын нэг юм. Тухайлбал: АНУ-ын хувьд мэргэжлийн томоохон холбоо, нэгдлүүдээр болон өөрөө өөрийгөө зохицуулагч холбоодоор энэхүү үүргийг гүйцэтгүүлдэг жишиг байдаг байна.²⁰

¹⁹ Public-Private Partnerships in Transportation - a Toolkit for Legislators developed by the National Conference of State Legislators (2010 with updates from 2014) - includes links to PPP enabling legislation in the transport sector in different states of the United States... Орчуулга

²⁰ Public-Private Partnerships for Public Facilities

- БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

1994 оны 8 дугаар сард батлагдсан "Хувийн Хөрөнгө Оруулалтыг Урамшуулах Хууль"-аар²¹ концессоор дамжуулан, Өмнөд Солонгос улс нийтийн салбарын дэд бүтцийн дутмаг орон зайг нөхөх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах ажлын анхны оролдлого хийгдэж байжээ. Гэвч тухайн үеийн батлагдсан хуулийн сул талаас үүдэн хэт их эрсдэлийг хувийн хэвшилд шилжүүлснээр онцын дэвшил гараагүйн зэрэгцээ, 1997 оны Азийн санхүүгийн хямрал болон Олон Улсын Балютын Сангийн хараа хяналт, зохицуулалтын нөлөөнд давхар өртөж амжилтгүй болсон байна.

Улмаар 1998 онд концессын гэрээ дахин сэргэж, өмнөх хуулийг²² Дэд Бүтэц дахь Хувийн хэвшлийн оролцооны: хууль²³ /ДБХХОХ/ гэсэн нэртэйгээр шинэчлэн найруулж, 2005 онд дахин нэмэлт өөрчлөлт оруулснаар уг хууль нь өнөөг хүртэл БНСУ-ын ТХХТ, Концессын эрх зүйн харилцааны үндэс болж байна.

ТХХТ хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдон Хувийн Хэвшлийн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Төв²⁴ байгуулагдсан. Түүний үйл

- Legislative Resource Guide, American Institute of Architects (AIA), November 2014. The Legislative Resource Guide was developed for jurisdictions in the United States. It provides important elements in a successful PPP law... Орчуулга

²¹ The Private Capital Inducement Promotion Act... Орчуулга

²² 1994 оны 8 сард батлагдсан БНСУ-ын "Хувийн Хөрөнгө Оруулалтыг Урамшуулах Хуулийг концессын хэрэглэний процесс дахин сэргээсэнтэй холбогдуулан

²³ PPIA - The Private Participation in Infrastructure Act... Орчуулга

²⁴ Private Infrastructure Investment Center of Korea P.I.C.K.O... Орчуулга

ажиллагааны хүрээнд бодлогын туслалцаа, экспертиз, шинэ төслийн үнэлгээ, төслийг сайжруулан боловсруулах, үнийн санал ба Концессын гэрээ хэлэлцээрийн арга зүйн туслалцаа, боловсрол ба сургалт явуулах үүргийг өөртөө хүлээжээ. Хожим тус байгууллага Төрийн болон Хувийн Хэвшлийн Дэд Бүтцийн Менежментийн Төв²⁵ болон өөрчлөгдөж, Солонгос Улсын Ерөнхийлөгчид ажлаа тайлагнадаг Солонгос Улсын Хөгжлийн Институтэд²⁶ харьяалагдах болжээ.

Гурав. Дотоодын эрх зүйн зохицуулалт ба түүнд тулгамдсан асуудал

Монгол Улсад анх УИХ-аас "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай" 64 дугаар тогтоолыг 2009-н онд, "Концессын тухай" хуулийг 2010-н онд баталснаар концессын эрх зүйн зохицуулалт бий болсон. Монгол улсын засгийн газар 2013 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн дугаар 317-р "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай" тогтоолоор 51-н концессын төсөл хөтөлбөрийг баталсан байна.

Монгол Улсад бүрэлдэн бий болсон төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны талаарх эрх зүйн баримт бичгүүдийг жагсаавал:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Концессын тухай хууль
- Иргэний хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

Хөрөнгө оруулалтын тухай хууль

²⁵ Public & Private Infrastructure Management Center P.I.M.A.C

²⁶ Korea Development Institute

- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- 2009 онд УИХ-аас баталсан "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого"
- Засгийн газрын тогтоол /2011 оны 36 дугаар тогтоол/ "Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги"
- Засгийн газрын тогтоол: /2010 оны 102, 177, 198, 343-р тогтоол, 2011 оны 40, 105, 127, 185, 262-р тогтоол/
- Төрийн өмчийн хорооны тогтоол: /2010 оны 153, 342-р тогтоол/ зэрэг болно.

Судлаж буй сэдвийн хүрээнд манай улсад хамгийн түгээмэл хэрэглэгдэж байгаа төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа бол төр, хувийн хэвшлийн түншлэл үүний дотор концессын гэрээгээр хийгдэж байгаа зам, гүүр, төмөр зам, цахилгаан станц, цэвэрлэх байгууламжийг бий болгох, бүтээн босгох, барьж байгуулах зэрэг ажлуудад чиглэгддэг.

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байна. Уг хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улс төр, хувийн хэвшлийн асуудлыг бүрэн зохицуулсан эрх зүйн зохицуулалттай болох юм. Уг хуулийн төслийн 16 дугаар зүйлд Төрийн болон хувийн хэвшлийн түншлэгч талууд тодорхойлж өгсөн нь давуу тал болсон байна.²⁷

²⁷ 16 дугаар зүйл.Төрийн болон хувийн хэвшлийн түншлэгч талууд

16.1 Дараах этгээд нь төрийн түншлэгч байна:

16.1.1.Монгол Улсын яам;

16.1.2.аймаг, нийслэлийн Засаг дарга;

16.1.3.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн

Мөн хуулийн төслөөр дэд бүтцийн салбараас бусад салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хамруулахгүйгээр тусгасан байна.²⁸ Уг хуулийн төслөөр Засгийн газар нь ТХХТ-ийн төвийг ТХХТ-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын удирдлагад байгуулж ажиллуулахаар тусгасан байна. Энэ өмнө байсан дутагдалтай асуудлыг шийдвэрлэх нэгээхэн том алхам юм. Өмнө төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудлыг Төрийн өмчийн хороо, Аж үйлдвэрийн яам, Үндэсний хөгжлийн газар зэрэг байгууллагууд хариуцан ажилладаг байсан юм. ТХХТ-ийн төв байгуулагдсанаар уг гадаадын хөрөнгө оруулагч нарт ихээхэн тус дэмтэй юм. ТХХТ-ийг хэрэгжүүлэгч түншлэгчийн гэрэл нэмэгдсэн байна.²⁹

146

этгээд.

16.2.Хувийн хэвшлийн түншлэгч нь Компанийн тухай болон Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байна.

²⁸ 3.2.Дараах үйл ажиллагаа нь энэ хуульд заасан түншлэлд хамаарахгүй. Үүнд:

3.2.1.үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа;

3.2.2.олон нийтэд үйлчилгээ үзүүлэх зорилготой дэд бүтцээс бусад богино хугацаанд өөрчлөгдөх, хөгжих магадлалтай мэдээллийн технологийн үйл ажиллагаа, санхүүгийн зах зээлийн бүх төрлийн үйлчилгээ болон уул уурхайн салбарын дэд бүтцээр дамжуулан олон нийтэд үйлчилгээ үзүүлэхээс бусад ашиг олох зорилготой ашигт малтмал эрэх, хайх, олборлох, ашиглах үйл ажиллагаа;

3.2.3.хуулиар хориглосон бусад үйл ажиллагаа.

²⁹ 16 дугаар зүйл.Төрийн болон хувийн хэвшлийн түншлэгч талууд

16.1.Дараах этгээд нь төрийн түншлэгч байна:

16.1.1.Монгол Улсын яам;

16.1.2.аймаг, нийслэлийн Засаг дарга;

16.1.3.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд.

16.2.Хувийн хэвшлийн түншлэгч нь Компанийн тухай болон Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан гадаад, дотоодын

Уг хуулийн төслөөр түншлэлийн гэрээг хувийн эрх зүйн гэрээ гэж тодорхойлон оруулсан байна. Ингэснээр түншлэлийн гэрээ Захиргааны ерөнхий хуулийн үйлчлэл үйлчлэхгүй юм.³⁰ Мөн уг хуулийн төслийн 37 дугаар зүйлд Шууд гэрээлэх нөхцөлийг тусгасан бөгөөд 37.1.2 онц байдал тогтоосон эсхүл гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шүүд холбоотой бараа, ажил, үйлчилгээг худалдан авах нэн яаралтай хэрэгцээ бий болсон бөгөөд ТХХТ-ийн шалгаруулалтын бусад аргыг хэрэглэх нь цаг хугацааны хувьд боломжгүй бол шууд гэрээлж болохоор тусгасан байна. Уг хуулийн төсөлд нэн яаралтай хэрэгцээгээ тодорхойлоогүй байгаа юм. Энэ төр хяналтгүй худалдан авалт хийх боломж үүсч байгаа юм.

Төр, хувийн хэвшлийн түншлэл / Концессь:ч гэрээгээр/ хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад орсон 51 төсөл хөтөлбөрүүдээс 6 төсөл, хөтөлбөрт хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байна.

³⁰ 33 дугаар зүйл.Түншлэлийн гэрээ

33.1.ТХХТ-ийн гэрээ болон түүнийг дагалдан байгуулах гэрээнүүд нь тэгш эрхийн зарчимд суурилсан, хувийн эрх зүйн салбарын гэрээнд хамаарах, Иргэний хуулийн дагуу байгуулсан гэрээ байх бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалтад үл хамаарна.

³³ 2.ТХХТ-ийн гэрээний талууд нь төрийн түншлэгч талаас тухайн төсөлд хамаарах салбарын төрийн захиргааны төв байгууллага, ТХХТ-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төсөл хэрэгжих орон нутгийн байгууллагын төлөөлөл, нөгөө талаас хувийн хэвшлийн түншлэгч буюу төсөл хэрэгжүүлэгч компани, төслийн санхүүжүүлэгч хуулийн этгээд нар байна.

концессын гэрээ байгуулагдсан байна.

- Концессын зүйлийн жагсаалтын дагуу батлагдсан төсөл, хөтөлбөрүүдэд уралдаант шалгаруулалт зарласан боловч санал ирээгүй, ирсэн санал нь шаардлага хангахгүй, тэнцэхгүй байгаагаас болж төсөл хөтөлбөрүүд уралдаант шалгаруулалтын зарчмаар биш шууд гэрээ байгуулах замаар төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Энэ нь концессын талаарх ойлголт, хууль эрх зүйн мэдээлэл, мэдлэг хувийн хэвшлийн салбарт байхгүй байгааг харуулж байна. Хувийн хэвшлийн байгууллага эдгээр ажилд хэрхэн оролцох, өөрт байгаа санал санаачилгаа хэрхэн хэрэгжүүлэх талаар эрх зүйн анхан шатны ойлголт байхгүй байгаа нь төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны талаар ойлголтыг бий болгох энэ талаар үйл ажиллагаанд оролцох сонирхол бүхий этгээдэд мэргэшүүлэх сургалт өгөх ажлыг хийх мэргэшсэн хуульчдыг бэлтгэн ажиллуулах зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Дүгнэлт

Концессын гэрээ нь ТХХТ-ийн нэг үндсэн төрөл болохынхоо хувьд ямагт нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх бөгөөд төрийн гүйцэтгэх ёстой үндсэн чиг үүрэг буюу иргэдэд хүргэх ёстой үйлчилгээ нь концессын гэрээний зүйл болж, Концесс эзэмшигчонцгой эрхэдэлсний үндсэн дээр урт хугацаагаар тус үйлчилгээг иргэдэд үр ашигтайгаар хүргэж, үзүүлдэг. Иймд гэрээний талуудын урт хугацааны харилцааг тогтвортой уяхын тулд, иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ нь чанартай, шударга байхын тулд, гэрээний хугацаанд аливаа эрсдэлээс нийтийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд концессын гэрээг маш сайн хийж, эрсдэлээ хуваарилах шаардлагатай байдаг байна.

Төр хувийн хэвшлийн түншлэл, Концессын ажиллагааг бүхэлд нь буюу эхнээс нь дуустал тодорхой эрх хэмжээтэйгээр зохицуулах эрх бүхий тусгай статустай мэргэшсэн, тогтвортой ажиллах нэгжийг бий болгох хэрэгтэй. Угнэгжнь Төр хувийн хэвшлийн хамтын байгууллага байж болох ба Концессын тухай хуулийг шинэчлэн найруулах эсвэл нэмэлт өөрчлөлт оруулах замаар уг нэгжийн эрх зүйн зохицуулалтыг зохицуулж болох юм. Тухайлбал, "Хөрөнгө оруулалтыг дэмжих төв" гэсэн нэртэй бие даасан, төрийн болон хувийн хэвшлийн хамтарсан нэгж байгуулж болно.

ДААТГУУЛАГЧИЙН ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР АВАХ ЭРХ ТҮҮНИЙГ ХАМГААЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ



Шихихутуг их сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш
Г.Хонгор

1. Даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт

Даатгуулагчийн эрх, тэр дундаа өндөр насны тэтгэвэр авах эрх, түүнийг хамгаалах, эдийн засаг, нийгмийн баталгааг бүрдүүлэх, холбогдох эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх хэрэгцээ шаардлага хэрхэн үүсэж бий болж байгаа талаарх асуудлыг хөндөн энэхүү судалгааны ажлыг хийж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хууль эрх зүйн арга замыг тодорхойлохыг зорьсон билээ.

Нийгмийн хамгааллын талаарх үзэл санаа нь нийгмийн сонгодог онол, сургаал, үзэлбаримтлалуудаас эх аван хөгжиж ирсэн бөгөөд Грекийн сэтгэгч Платон (МЭӨ 427-347) хувь хүн үлгэр жишээ төр улсад аз жаргалтай амьдрах боломжийн тухай номлож байв. Платоны шавь Аристотель (МЭӨ 384-322) хүмүүс зөвхөн нийгмийн дотор л амьдарч чадах бөгөөд чухам ард олны эрх ашгийг удирдлага болгодог засаг, эрх

баригчидтай төр л зөв гэж үзэж байв. Тэрээр хэрвээ иргэдээ цогцолбороор нь бус аль нэгэн хэсгийг нь салган авч анхаарал тавьж байгаа төр улс байвал сайн сайханд тооцогдохгүй" гэж хэлэхдээ насны эрхээр ажлаас чөлөөлөгдсөн хүмүүст амрах, эрсдэлд орчон иргэнийг харж үзэх шаардлага гардгийг авч үзсэн байна.

Нийгмийн хамгааллын стратегид "нийгмийн хамгаалал" гэдэг нь үр өгөөжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эмзэг аюултай байдал болон орлогогүй болохоос сэргийлэх чадварыг бий болгосноор ядуурал, эмзэг байдлыг бууруулахад чиглэгдсэн багц бодлого, хөтөлбөр¹ хэмээн тусгасан байна.

Нийгмийн даатгалын тухай хуульд «тэтгэвэр» гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, тахир дутуу болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгө² гэж тодорхойлсон байна.

Мөн зарим судлаач нар Өндөр насны тэтгэврийг сар бүр авч байсан цалин хөлстэй нь дүйцүүлэн шимтгэл төлсөн хугацааг нь харгалзан нийгмийн даатгалын тэтгэврийн

¹ Энхцэцэг Б., Нийгмийн хамгааллын үзэл баримтлал, нийгмийн хамгааллын индексийн тооцоолол. Монголын хүн амын сэтгүүл, УБ., 2014 он. Дугаар 418.39 дэх тал

² Нийгмийн даатгалын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1994 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

сангаас насан туршид нь олгогдож байгаа мөнгөн хөрөнгө³ гэж хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу тодорхойлсон байна.

Монгол улс нь 1940 оны Үндсэн хуулиас эхлээд 1992 он хүртэлх үндсэн хуулиуддаа иргэний тэтгэвэр авах эрхийг хуульчилж, зохицуулсан байдаг. Тухайлбал:

1940 оны Үндсэн хуулийн Аравдугаар бүлэг Ард иргэний үндсэн эрх ба үүргүүд Далан наймдугаар зүйлд:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын биеийн хүчнийг үнэлэх ард иргэн нь нас хөгшрөх цагт мөн түүнчлэн өвчин хүрэх буюу хөдөлмөр хийх чадвараа гээгдүүлэх ахул эдийн тусламж олох эрх эдэлнэ. Энэхүү эрх нь нийгмийг аюулаас хамгаалах журмаар улсын бүх хөлслөн авагчдын зардлаар хангагдах ба хөдөлмөрчин ард түмэнд эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүйгээр үзүүлэх хийгээд рашаан усыг дэлгэрүүлэх зэргээр хангагдах болно.

1960 оны Үндсэн хуулийн Долоодугаар бүлэг Иргэдийн үндсэн эрх ба түүнийг хангах баталгаа Далан есдүгээр зүйлд:

БНМАУ-ын иргэд нас хөгшрөх, мөн өвдөх, хөдөлмөрийн чадвараа алдах, тэжээгчээ алдахад эдийн тусламж авах эрхтэй. Үүнд: нийгмийн даатгал, улсын тэтгэвэр хоршооллын байгууллагын тусгай фондын системээр дамжуулан хөдөлмөрчдөд тусламж олгож, амралт, сувиллын газрыг олшруулан, эмнэлгийн тусламжийг

үнэ төлбөргүй үзүүлж, хөдөлмөр хамгааллыг хөгжүүлж энэхүү эрхийг хангана.

1992 оны Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэг Хүний эрх, эрх чөлөө Арванзургадугаар зүйл:

5/ өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй. Ийнхүү Монгол улс нь хуульд заасан нөхцөлд иргэнийхээ эд, мөнгөний тусламж авах эрхийг иргэний Үндсэн эрх мөн болохыг баталгаажуулж ирсэн байна.

1992 оны Үндсэн хуулийн нэг онцлог, ач холбогдол нь төр иргэнийхээ өмнө үүрэг, хариуцлага хүлээх асуудлыг тусгаж хуульчилсан. Мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”⁴ гэж заасны дагуу Монгол улсын төр нь тус улсын иргэний өндөр наслах үед олгох эд мөнгөний тусламж, түүний дотор тэтгэвэр авах эрхийг нь хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг хангах үүргийг иргэнийхээ өмнө хүлээж, Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, үр дагаврыг нь хариуцах ёстой гэдгийг хуульчилж өгсөн байна.

Монгол улсын хувьд 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс үйлчилж эхэлсэн нийгмийн даатгалын багц

³ Давхарбаяр Ц., Жаргал Б., Нийгмийн хамгааллын эрх зүй. УБ., 2016 он. 90 дэх тал

⁴ Монгол улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн

хуулиас өмнө энэ хүрээний гол акт нь 1990 онд батлагдсан Тэтгэврийн хууль байв.⁵ Монгол Улсын Их Хурлаас 1994 онд Нийгмийн даатгалын багц хуулиудыг буюу Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийг тус тус баталсан.

Тэтгэврийг улсын төсвөөс олгож байсан тогтолцоог 1995 оноос өөрчилж, нийгмийн даатгалын хуваарилалтын зарчимд үндэслэн нийгмийн даатгалын багц хуулиудыг батлан мөрдүүлж, ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлээс тэтгэвэр олгодог тогтолцоо хэрэгжиж байна.⁶ Нийгмийн даатгалын тухай хуулийн даатгуулагчийн шимтгэл төлөх эрхийг заасан 19 дүгээр зүйл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн Өндөр насны тэтгэвэр авах эрх 4 дүгээр зүйл гэх зэргээр нийгмийн даатгалын ердийн хуулиудад даатгуулагчийн эрхийг тусган хуульчилсан байдаг.

Монгол улсын нэгдэн орсон болон соёрхон баталсан гэрээ, конвенц нь нийгмийн хамгааллын үүний дотор нийгмийн даатгалын эх сурвалж болно. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах олон улсын

эрх зүйн зохицуулалтаар хүн бүр нийгмийн хангамж эдлэх эрхтэй бөгөөд энэ эрхээ өөрийн орны бүтэц, нөөц бололцоотой уялдуулан олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй болохыг Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 22 дугаар зүйлд заасан байдаг.

Мөн Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого, 2015 оны 53 дугаар тогтоол Төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого /2015-2030/ зэрэг бодлогын баримт бичгүүдэд тэтгэврийн шинэчлэлийн талаар төрөөс баримтлах бодлогыг тусгаж хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна. Мөн "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын 3.1-д "Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ⁷ гэж заасан байна

2.Тэтгэврийн даатгалтай холбогдох тулгамдсан асуудал

Нийгмийн даатгалын багц хуулиуд үйлчилж эхэлснээс хойш Нийгмийн даатгалын тухай хуульд 23 удаа, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд 14 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын гол үзэл баримтлал нь нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх эрх зүйн орчиныг

⁵ Лүндзэжанцан.Д.,Болдбаатар.Ж. Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал.УБ.,2021он.343 дах тал

⁶ Монгол улсын их хурал. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл.Бодлогын баримт бичиг.УБ.,1999 он

⁷ Монгол улсын их хурал.Алсын хараа 2050. Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого. УБ.,2020 он

бүрдүүлэх, тэтгэвэр бодох жишиг цалингогтоох, тэтгэвэрт огтоолоход баримталсан хөдөлмөрийн хөлсийг нэг удаа өөрчлөх боломжийг тэтгэвэр авагчид олгох зэргээр ажил олгогч, тэтгэвэр авагч, даатгуулагчийн эрх ашигт нийцсэн асуудлуудыг хуулиудын зохицуулалтад оруулж тусгахад чиглэгдэж энэ хүрээнд олон асуудлыг тусгаж хэрэгжүүлсэн боловч тогтолцооны хувьд дорвитой шинэчлэл хийгдээгүй гэсэн асуудал олон жил яригдаж байна.

Тэтгэвэрийн даатгалын тогтолцоо: Манай улсын хувьд өнөөдрийн байдлаар тэтгэврийн хуваарилалтын тогтолцоотой буюу цалингийн системд суурилсан тэтгэврийн тогтолцоотой улсад хамаарч байна. Хуваарилалтын тогтолцоо гэдэг нь ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлогоос тэтгэвэр авагчдын тэтгэврийг санхүүжүүлж орлогоороо зарлагаа нөхөх зарчмын дагуу ажиллах явдал мөн. Хуваарилалтын тогтолцооны үеийн гол зарчим нь эв нэгдлийн зарчим юм. Даатгалын шимтгэл төлж байгаа иргэд нийгмийн даатгалын сан буюу нийгмийн даатгалын мөнгөн хөрөнгийг бүрдүүлдэг учраас дээрх зарчим үйлчилдэг гэж үздэг байна. Энэ тогтолцооны үед даатгуулагчид тэтгэвэр тогтоох гол үндэслэл нь түүний шимтгэл төлсөн цалин байдаг. Энэ тэтгэврийн тогтолцооны тэтгэвэр бодох арга нь төлсөн шимтгэлтэйгээ шууд хамааралгүй буюу ажилласан жил ба цалин хөлсний дунджаар тогтоогдож байгаа учир хуваарилалт шударга бус, хувь хүний тэтгэврийн даатгалын сангийн

хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалах болон өсөж арвижуулах механизм бүрдээгүй, эдийн засгийн шинэчлэл хөрөнгийн зах зээлийн хөгжилтэй шууд уялдаагүй байгаа зэрэг сөрөг үр дагавраас зайлсхийхийн тулд хагас хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх шаардлагатай⁸ гэж үзэн 1999 онд Улсын Их Хурлаас баталсан Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл баримт бичигт тусгасан байдаг.

1999 онд Улсын их хурлаас Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийг баталж даатгуулагчийн төлсөн шимтгэл, хүүг тооцох, нэрийн данснаас тэтгэвэр тогтоон олгохтой холбогдсон харилцааг зохицуулахаар хүчин төгөлдөр үйлчилж байна.

Гэхдээ өнгөрсөн хугацаанд тэтгэврийн шимтгэлээс цугласан орлого нь төлөх ёстой тэтгэврийн зардлыг давж байгаагүй учраас хөрөнгийг ийм байдлаар удирдах нөхцөл бүрдээгүй юм⁹.

2015 онд Улсын Их хурлаас Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, 1960-1979 онд төрсөн, нэрийн данснаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэж буй даатгуулагчид цалингийн системд төвлөрсөн тогтолцоо, нэрийн дансны тогтолцоо хоёрын аль өндрийг сонгох боломж олгосон байна. 1960

⁸ Монгол улсын их хурал, Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл, Бодлогын баримт бичиг, УБ., 1999 он

⁹ Нээлттэй нийгэм форум, Нийгмийн даатгалын сангийн 2012-2022 оны төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтын дүн шинжилгээ, Судалгааны тойм, 2021 он

оноос хойш төрсөн даатгуулагчдын эхний хүмүүсийн хувьд 2015 оноос тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн бөгөөд бүгд цалингийн системд суурилсан тэтгэврийн тогтолцоо сонгожээ. Тиймээс манай улсын тэтгэврийн тогтолцоо хуваарилалтын тогтолцоо буюу цалингийн системд суурилсан тэтгэврийн тогтолцоо хэвээр байгаа гэсэн үг юм.

Дэлхийн улс оронд даатгуулагчийн өндөр насны тэтгэврийг олгох хэд хэдэн тогтолцоо мөрдөгдөж байгааг харуулбал:

- Хуваарилалтын тогтолцоо / цалингийн системд суурилсан/
- Хагас хуримтлалын тогтолцоо
- Бүрэн хуримтлалын тогтолцоо гэсэн гурван тогтолцоо ажиллаж байна.

Хуваарилалтын тогтолцоо: Хуваарилалтын тогтолцоо гэдэг нь ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлогоос тэтгэвэр авагчдын тэтгэврийг санхүүжүүлж орлогоороо зарлагаа нөхөх зарчмын дагуу ажиллах явдал мөн. Өнөөдрийн тэтгэвэр авагчдын тэтгэврийг өнөөдөр хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн төлсөн шимтгэлээс санхүүжүүлдэг. Энэ нь ажил эрхэлж буй хүмүүсийн тэтгэврийн даатгалын шимтгэлд төлсөн мөнгө нь хуримтлагдаж хуримтлал үүсгээд тэр мөнгөнөөс нь хожим тэтгэвэрт гарахад нь тэтгэврийг нь төлдөггүй харин тэтгэврийн даатгалын шимтгэлийг төлснөөр хожим нь тэтгэвэр авах эрхээ баталгаажуулж байна гэсэн үг. Уг тогтолцоо нь хүн амын дийлэнх нь залуучууд байгаа өнөөгийн нөхцөлд

тохирч байгаа ч хүн амын наслалт уртсан тэтгэвэр авагчдын тоо нэмэгдэх үед тэтгэврийн даатгалын санг санхүүжүүлэх боломжгүй болох магадлалтай байдгаараа сул талтай.¹⁰

Хуримтлалын тогтолцоо: Хуримтлалын тогтолцоо нь дараах байдлаар ангилалдаж байна.

- Хагас хуримтлалын тогтолцоо
 - Бүрэн хуримтлалын тогтолцоо
- Хагас хуримтлалын тогтолцоо бол хуваарилалтын болон хуримтлалын аргыг хослуулан хэрэглэж хуваарилалтын зарчмаас бүрэн хуримтлалын тогтолцоонд үе шаттайгаар шилжихийг хэлнэ.

Бүрэн хуримтлалын тогтолцоо гэдэг нь даатгуулагчид өөрсдийн тэтгэвэрт зориулж хуримтлал бий болгох нөхцөлийг бүрдүүлдэг тогтолцоо юм. Энэ тогтолцооны гол агуулга нь даатгуулагчийн төлсөн шимтгэл нь хуримтлал үүсгэн төвлөрснөөр ирээдүйд тэтгэвэрт гарахдаа авах мөнгийг санхүүжүүлэх гол хэлбэр байдаг байна.

Манай улсын хувьд хуваарилалтын тогтолцоогоор 30 орчим жил явж байна. Тэтгэврийн санд үүсээд байгаа хүндрэлийн үндэс нь эв найрамдлын зарчимаар хэрэгждэг уг тогтолцоотой холбоотой байх магадлал өндөр юм. Тиймээс энэ тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоо улмаар бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжих, тэтгэврийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх асуудал олон жил яригдсан боловч өнөө хэр шийдвэрлэгдээгүй байна.

¹⁰ https://nii.gov.mn/nii/gmii/namqaalal_erh.pdf

Хүн амын дундаж наслалт өсч байна:

2010 оны байдлаар 60 насандаа тэтгэвэрт гарснаас хойших эрэгтэйчүүдийн амьдрах хугацаа 16 жил, 55 наснаас хойших эмэгтэйчүүдийн амьдрах хугацаа 22.1 жил байсан бол 2016 оны байдлаар эрэгтэйчүүдийнх 1.2 жилээр нэмэгдэж 17.1 жил, эмэгтэйчүүдийнх 3.3 жилээр нэмэгдэж 25.4 жил болж өссөн байна. Энэ үзүүлэлт 2050 онд эрэгтэйчүүдийн хувьд 19.2 жил, эмэгтэйчүүдийн хувьд 27.1 жил болох судалгаа тооцоо гарч байгаа юм.

Мөн 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт өндөр насны тэтгэвэр авагчдын тоо 434.2 мянгад хүрсэн бөгөөд 2025 оноос эхлэн хүн ам зүйн цонх үе хаагдаж, дундаж наслалт нэмэгдсэнээр нийт хүн амд эзлэх тэтгэвэр авагчдын тоо өсч, 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2017 онд 3, 2030 он гэхэд 7, цаашид 9 тэтгэвэр авагч болохоор байна. 2019 оны байдлаар 60-аас дээш насны хүний тоо нийт хүн амын 7.0 хувь байгаа бол 2050 онд 28.6 хувь болж өсөхөөр байна¹¹.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх насыг тогтоосон 4дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт 1999, 2017, 2018 онд тус тус өөрчлөлт оруулсан байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 2021 оны 11 дүгээр сарын байдлаар тэтгэвэр авч байгаа хүний тоогоор аль төрлийн тэтгэвэрт зарлага илүү гарч байгааг үзвэл: /График 1/

/График 1/

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа нийт хүний дотор хамгийн их буюу 77.7% нь өндөр насны тэтгэвэр авагч байна. Тоо баримтаас дүгнэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарцуулалтын ихэнх хувийг өндөр насны тэтгэвэр олгоход зарцуулж байгаа нь харагдаж байна.

НИЙТ ТЭТГЭВЭР АВАГЧ 454.204

- | | |
|---|---|
| ■ Өндөр насны тэтгэвэр авагч 351.67677.7% | ■ Тахир дутуугийн тэтгэвэр 53367 13.9% |
| ■ Тэжээгээ алдсаны тэтгэвэр 19513 4.2% | ■ Цэргийн алба хаагчийн тэтгэвэр 19548 4.3% |



Хүн амын насжилттай холбоотойгоор сүүлийн жилүүдэд өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг нэмэх нь зүйтэй гэсэн бодлогыг баримталж байгаа бөгөөд 2017 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар тэтгэвэр

¹¹ Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хийсэн судалгааны тайлан.УБ.,2020 он

тогтоолгох насыг харьцангуй олон жил баримталж ирсэн 60 наснаас 65 нас болгож нэмэх асуудлыг аажмаар буюу 2027 оны хүртэл жил бүр 3 сараар нэмэгдүүлж зорилтот насанд хүргэх өөрчлөлтийг оруулсан. Үүний дараа 2018 онд мөн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хуулийн 4дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг “Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 65 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно.” гэж өөрчилснөөр 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн даатгуулагч өөрөө хүсэхгүй бол 65 насанд хүрч өндөр насны тэтгэвэр тогтоолгох энэ насыг хүртэл Ажил олгогчийн санаачилгаар тэтгэвэрт гаргах боломжгүй байхаар зохицуулсан.

2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон “Хөдөлмөрийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгад 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3-д заасан “ажилтан 60 насанд хүрч тэтгэвэр авах эрх үүссэн бол” ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалж ажлаас нь чөлөөлдөг зохицуулалтыг хассан байна. Иймд тэтгэвэр тогтоолгох насны дээд хязгаарыг 65 нас болгосон, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дах хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол

төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийн төрийн алба хаах насны дээд хязгаар нь 65 нас байна”¹² гэж заасан нь мөн л өндөр насны тэтгэвэр авах эрх үүсэх ерөнхий насыг нэмж тогтоосон зохицуулалт юм. Насыг нэмэх зохицуулалттай зэрэгцүүлж эмэгтэй даатгуулагчийн ажилласан хугацааг төрүүлсэн хүүхэд тус бүрд 1.6 сараар тооцон нэмэх, тэтгэвэр авагчдын 59.1 хувь буюу 270,900 мянган иргэн тэтгэврийн доод хэмжээгээр буюу 350,000 /мянган/ төгрөгийн тэтгэвэр авч байсныг 2022 оны 01 сараас тэтгэврийн доод хэмжээг 500,000 /мянга/ болгож нэмэх зэргээр тэтгэвэр авагчдын эрх ашгийг хамгаалсан тодорхой нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан нь даатгуулагчийн эрхийг хамгаалж буй нэгэн хэлбэр юм.

Бусад улсын хууль тогтоомжоор өндөр насны тэтгэвэрт гарах насыг тогтоосон байдлыг судлан үзэхэд Эквадор улс 70 нас байхаар тогтоосон нь хамгийн өндөр, ихэнх орнууд 67- 65 нас байх, хамгийн бага нь Тайланд эрэгтэй, эмэгтэй 55 нас, Шри-ланка улс эрэгтэй 55, эмэгтэй 50 нас байна. Монгол улсын хувьд тэтгэвэр тогтоох нас нь 2017 он хүртэл эрэгтэй 60, эмэгтэй 55 нас байсан бөгөөд 2017 онд тэтгэврийн насыг нэмснээр одоо тэтгэвэр тогтоох нас 65 байгаа нь тэтгэвэр тогтоох насны хэмжээ нь “дундаж” гэсэн ангилалтай оронд хамаарч байна.

Манай улсын хувьд ердийн журмаар тэтгэвэр тогтоох насаа нэмж 65 нас болгосон боловч

¹² Төрийн мэдээлэл сэтгүүлийн тусгай дугаар. УБ., 2019. 28 дах тал

хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр авах насны хувьд өөрчлөлт оруулаагүй хэвээр байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 ба 4.3-д зааснаар 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эх 50 насанд хүрсэн бол, мөн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд хуульд заасан хугацаагаар ажилласан бол эрэгтэй 60, эмэгтэй 55 хүрээгүй байхдаа тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Өнөөгийн байдлаар тэтгэвэр тогтоолгож байгаа иргэдийн 50 орчим хувь нь хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгон авч байна.


Насжилтаас хамааран үүсэх эрсдэлээс хамгаалах, ахмад настныг ядууралд өртөхөөс сэргийлэхийн тулд өөрийн орны онцлог, нөхцөл байдалд тохирсон тэтгэврийн шинэчлэлийн бодлого, тэтгэврийн параметрийн өөрчлөлтүүдийг 20- 25 жилийн өмнөөс авч эхэлдэг гадаад орнуудын туршлага байна. Европын орнуудаас Унгар, Польш, Латви, Эстони, Болгар, Литва, Словак, Румын зэрэг улсууд 1990-ээд оны сүүлч, 2000 оны эхээр уламжлалт хуваарилалтын зарчимд тулгуурласан тэтгэврийн тогтолцоог халж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлсэн. Түүнчлэн хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Казахстан улс 1998 онд, ОХУ 2002 онд, Украин улс 2004 оноос, Киргиз улс 2010 оноос олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжсэн байна.¹³

Улсын төсөвт: Улсын төсвөөс тэтгэврийн даатгалын санд 2010 онд 170.7 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн бол энэ хэмжээ 2020 онд 2.3 дахин нэмэгдэж 399.4 тэрбум төгрөгт хүрсэн.

Тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нь 2019 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 1.8 хувь байгаа бол энэ үзүүлэлт 2030 онд 6.0 хувь, 2050 он гэхэд 11.0 хувь болж өсөх магадлал хэтийн тооцоо, судалгааны үр дүнгээс харагдаж байна.¹⁴ Тэтгэврийн даатгалын санд шаардагдах төсвийн дэмжлэг жилээс жилд нэмэгдэж байгаа голлох нэг шалтгаан нь тэтгэвэр авагчдын тоо өсч байгаатай холбоотой байна.

/График 2/

ТЭТГЭВРИЙН САНД УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ /ДНБ/




¹³ <http://forum.parliament.mn/projects/11188>

¹⁴ Дэлхийн банк. Тэтгэврийн шинэчлэлийн бодлогын хувилбарууд. 2017 он

Нийгмийн даатгалын тэтгэврийн сангийн орлого, зарлага сүүлийн 3 жилийн байдлыг /тэрбум төгрөгөөр / харьцуулан харахад доорх байдалтай байна.¹⁵ Манай улсын хувьд тэтгэврийн даатгалын сангийн гол орлого нь даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх шимтгэл юм. Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн 1995 оноос хойш тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээг нэмэх, бууруулах зэргээр нийт 5 удаагийн өөрчлөлт оруулсан байна. 2008 онд шимтгэлийн хэмжээг 5%, 2021 онд 2% бууруулсан байна. Өнөөдрийн байдлаар тэтгэврийн даатгалын санд ажил олгогч хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос 8.5%, ажилтан цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос 8.5% -ийн шимтгэлийг сар бүр төлж байна.

Нийгмийн даатгалын тэтгэврийн сангийн орлого 2014-2020 онд байнга өссөөр ирсэн нь даатгалын шимтгэлийн хувь өсөж байсантай шууд хамааралтай байна. /График 3/

/График 3/ ¹⁶



Монгол улсын тэтгэврийн тогтолцоо нь эв найрамдлын буюу хуваарилалтын тогтолцоотой холбоотойгоор тэтгэврийн нөөц сан бүрдүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, даатгуулагч өөрийн нэрийн дансанд мөнгөн хуримтлал үүсгэх, хуримтлагдсан хөрөнгөө эргэлтэд оруулах, тэтгэврээ өв залгамжлагчдаа өвлүүлдэг болох зэрэг даатгуулагчийн олон эрх зөрчигдөж хэрэгжих боломжгүй байгаа бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу иргэний эрхийн нийгэм, эдийн засгийн баталгааг хангах үүргийн биелэлт хангалтгүй байгааг харуулж байна.

Нийгмийн даатгалын тэтгэврийн сангийн орлого, зарлага сүүлийн 3 жилийн байдлыг /тэрбум төгрөгөөр / харьцуулан харахад доорх байдалтай байна ¹⁷ /График 4/

¹⁵ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хийсэн судалгааны тайлан.УБ..2021 он

¹⁶ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.1212.mn.

¹⁷ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хийсэн судалгааны тайлан.УБ..2021 он

Нийгмийн даатгалын тэтгэврийн сангийн орлого, зарлагын төсөв /тэрбум төгрөгөөр /



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Нийгмийн даатгалын тухай багц хуулиудыг шинэчлэхтэй холбогдуулан хийсэн дээрх тоо мэдээнээс харахад нийгмийн даатгалын тэтгэврийн сангийн зарлага нь орлогоосоо байнга өссөн дүнтэй харагдаж байна.

4. Тэтгэвэртэй холбогдсон тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд анхаарах асуудлын талаарх дүгнэлт, санал:

Дүгнэлт

Өндөр насны тэтгэвэртэй холбогдсон тулгамдсан асуудлыг судалсан судалгаа, шинжилгээний үр дүнг үндэслэн доорх дүгнэлтэд хүрлээ.

Нийгмийн даатгалын сангийн удирдлагын олон улсын туршлагаас харахад, дийлэнх улсад олон давхаргат тэтгэврийн тогтолцоо хөгжсөн байна. Жишээ болгон олон давхаргат тэтгэврийн дараах тогтолцоог авч үзвэл: I давхарга буюу суурь давхарга нь бүх ахмад настанд наад захын орлогын баталгаа бий болгох бөгөөд үүнийг ихэвчлэн тухайн улсын төрөөс хариуцдаг бол II давхарга буюу шимтгэлд суурилсан давхарга нь нийгмийн даатгалын өндөр

насны тэтгэвэр авах механизмыг бүрдүүлэх зорилгоор төрөөс эсхүл ажил олгогчийн зүгээс эрхлэн хэрэгжүүлдэг даатгалын тогтолцоог агуулна. III давхарга буюу нэмэлт давхарга нь өндөр насны орлогыг нэмэгдүүлэх, нэмэлт орлого бий болгох зорилгоор сайн дурын үндсэн дээр хамрагдан хадгаламж бий болгох схемийг багтаадаг байна. Мөн манай улсад тулгамдаад байгаа тогтолцооны хямрал болон насжилттай холбоотой асуудал нь бусад улс орнуудад ч тулгамдаж байсан ба үүнийг амжилттай шийдсэн туршлагаас судлан өөрийн орны онцлогт тохирсон өндөр насны тэтгэврийн олон давхаргат тогтолцоонд шилжих зайлшгүй шаардлага тулгараад байна.

1. Монгол улсын нийгмийн даатгалын тэтгэврийн тогтолцоо, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал ихээхэн учир дутагдалтай бөгөөд цаашид энэ байдлаар удахгүй тэтгэврийн даатгалын сан хөрөнгийн дутагдалд орох, дампуурах эрсдэлд ойрхон очсон байна.

2. Тэтгэврийн сангийн мөнгөн хөрөнгө нь даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн зарлагыг дангаар олгож чадахгүй байгаа нь улсын

төсөвт сөргөөр нөлөөлж иргэдийн татварын ачааллыг ихэсгэх нэг хүчин зүйл болж байна.

3. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн бодлогын талаарх цөөнгүй баримт бичгийг гаргасан боловч хэрэгжилт, үр дүн төдийлөн гараагүй байна.

4. Нийгмийн даатгалын ялангуяа тэтгэврийн даатгалын эрх зүйн зохицуулалт нийгмийн харилцааг зохицуулах хэрэгцээ, шаардлагыг хангахгүй байна.

Санал

1. Тэтгэврийн даатгалын эрх зүйн орчныг боловсронгуй болгох: гол зорилго нь даатгуулагчид эрх тэгш, шударга, амьжиргаанд нь хүрэлцэхүйц хэмжээний тэтгэвэр олгох, тэтгэврийн сангийн санхүүгийн орлогын тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлэх, улсын төсвийн санхүүжилтийн хэмжээг бууруулах, даатгалд хамрагдах сонирхол, хөшүүргийг бий болгох, тэтгэврийн хэмжээг төлсөн шимтгэлтэй уялдуулах, тэтгэвэр тооцох аргачлалыг боловсронгуй болгох зэрэг асуудлыг дахин авч үзэх юм.
2. Малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх хувь нь нийгмийн даатгалд хамрагдахгүй байгаа нь ирээдүйд эдгээр иргэдийн нийгмийн баталгаа алдагдаж, улмаар халамжийн зардал өсөж, улсын төсвийн ачааллыг нэмэгдүүлэх тул тэдгээр иргэдэд тохирсон тэтгэврийн олон давхаргат тогтолцоо бүхий улс орнуудын туршлага, холбогдох

хууль тогтоомжийг судалж, олон давхаргат тэтгэврийн тогтолцооны эрх зүйн орчныг бүрдүүлэх

3. Нийгмийн даатгалын сангийн хуримтлагдсан мөнгөн хөрөнгөнөөс тодорхой хувь хэмжээгээр жил бүр тооцон хуримтлалын сан байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоонд хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлдэг чиг үүрэг бүхий байгууллага, бүтцийг байгуулж судалгааны үндсэн дээр уг мөнгөн хөрөнгийг өсгөн арвижуулах механизм бүрдүүлэх
4. Тэтгэврийн даатгалын санг хямралд оруулах, алдагдал хүлээлгэх, улсын төсөвт сөргөөр нөлөөлөх, тохиолдлыг зохицуулах үүднээс цаг үеийн шинжтэй шийдвэрүүдийг гаргахгүй байх. Зайлшгүй тохиолдолд судалгаа шинжилгээний дүнд үндэслэн ажиллах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай гэж үзэж байна.

Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь Issues on improving legal environment on investment



Шихихутуг их сургуулийн докторант
Г.Төгөлдөр

УДИРТГАЛ

*Харьцуулан судлах нь мэдлэгийг
баталгаажуулаад зогсохгүй маш сайн
үр дүнг гаргана. J.H.KINNER*

Монгол улсын Засгийн газар эрдэс баялгийн салбарт гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан компани байгуулан хувь эзэмшиж байсан туршлага хэд хэд бий. Тухайн цаг үед нийгмийн тогтолцоо, эрх зүйн орчин одоогийнхоос эрс өөр байсан хэдий ч өнөөгийн өндөрлөгөөс харахад, харилцан ашигтай хамтын ажиллагааны гэрээнүүд байгуулагдаж, шаардлагатай үед хэлэлцээрийн журмаар дахин тодотгож ирсэн билээ.

Ардчилал, зах зээлийн харилцаанд шилжээд 30 гаруй жил болж буй энэ хугацаанд Монгол улс гадаадын хөрөнгө оруулалтыг татах, түүний хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар том алхам хийгээд байна. Хэдийгээр энд алдсан, оносон зүйл байгаа ч гэсэн ерөнхийдөө энэ хүрээнд хууль эрх зүйн анхны суурь орчин бүрджээ гэж үзэх үндэстэй. Харин одоо түүнийг улам

төгөлдөржүүлэх, илүү боловсронгуй болгох шаардлага өнөөгийн Монгол орны уул уурхайн хөгжлийн бодит байдлаас шууд урган гарч байна.

Энд гадаадын хөрөнгө оруулах талаар Монгол улсын байгуулж буй гэрээ асар чухал үүрэгтэй. Ер нь уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээ нь нэг талаас тухайн улсын нийтлэг эрх ашгийг төлөөлсөн Засгийн газар, нөгөө талаас уул уурхайг ашиглан аль болох их ашиг олох зорилго бүхий хуулийн этгээд байдаг. Энэ утгаараа гэрээ нь хоёр талын хүсэл зоригийн илрэл болдог бичиг баримт юм. Монгол улсын хувьд энэхүү хүсэл зоригийн илрэл нь Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдал, цаашлаад үндэсний аюулгүй байдлыг хангах улс орны амин эрх ашгийн жинхэнэ тусгал болж байх ёстой. Тийм ч учраас нэг талаас энэ төрлийн гэрээнд тавигдах хууль эрх зүйн хязгаарлалт, хориг, нөгөө талаас гадаадын хөрөнгө оруулалтыг татах эрх зүй, эдийн засгийн орчны хөнгөлөлт эл хоёр асуудлыг тэнцвэртэйгээр зохицуулах шаардлага онц чухал юм.

Энэ үүднээс аваад үзвэл манай улсын байгуулсан зарим гэрээ, юуны өмнө Оюу толгойн гэрээ Монгол улсын ерөнхий сайд асан, нэрт эдийн засагч Д.Бямбасүрэнгийн хэлснээр "Монголын эдийн засгийн нэгдмэл орон зайг"¹ задалсан шинжтэй байна. "Улс орны эдийн засаг гэдэг бол нэг цогц бүхэл зүйл" билээ. Гэтэл манай орны "эдийн засаг одоогийн байдлаар хууль эрх

¹ Өдрийн сонин 2013.04.03 №81.

зүйн орчноороо” “гурван бүтцэд хуваагджээ” “Энэ бол Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрх нь хуваагдах үндэс тавигдаж байна гэсэн үг. Энэ бол том аюул”². Энэ аюулаас сэрэмжлэх, Голланд өвчинд нэрвэгдэхгүй байх, уул уурхайн хөгжлийн эрх зүйн орчныг улам төгөлдөржүүлэх арга замыг нарийн судалж тогтоох, энд гадаадын орнуудын туршлага сургамжийг өөрийн орны нөхцөлд бүтээлчээр хэрэгжүүлэх нь өнөөгийн бачим чухал зорилт болоод байна.

Энэхүү судалгааны ажил нь Уул уурхайн хөрөнгө оруулалтын эрх зүйн ойлголтыг судалсны үндсэн дээр түүний гол төрлийн хуулийн зохицуулалтыг гаднын орнуудынхтай харьцуулан жишиж, өнөөгийн Монголын энэ салбарын эрх зүйн орчны тулгамдсан асуудлыг тодорхойлж, түүнийгээ эдийн засгийн томъёолоор баталж, цаашид шаардлагатай зохицуулалтыг нээн илрүүлсэн судалгааны ажил юм.

Нэгдүгээр бүлэг. Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, Гадаад орнууд тэдгээрийн эрх зүйн орчны харьцуулсан судалгаа

1.1 Монгол улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин

Манай улс гадаад орчноос шууд хамааралтай, эмзэг эдийн засагтай жижиг улс. Хоёр их гүрний дунд, далайгаас алслагдсан, газар зүй, байгаль, цаг уурын тааламжтай бус нөхцөлд, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспортод түшиглэсэн бага эдийн засагтай, хүн ам цөөнтэй орон тул гадаад хүчин зүйлс, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн нөхцөлд шийдвэрлэх үүрэгтэй.

Манай орны хувьд гадаадын хөрөнгө оруулалт нь бүхэлдээ хийгээд бүсчилсэн нутаг дэвсгэр, тодорхой аймаг нийслэл, сум баг, компанийн хөгжил дэвшил, үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлдэг улс төр, эдийн засаг, эрх зүйн чухал хүчин зүйл юм. Монгол улсын эдийн засгийн хөгжилд гадаадын хөрөнгө оруулалт голлох байр суурийг эзэлж байна.

Гадаадын хөрөнгө оруулалтыг татахад дараахь давуу талууд байна.

Давуу талууд:	Дутагдалтай талууд нь :
<ul style="list-style-type: none"> • Гадаадын Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин бүрдсэн. • Гадаадын Хөрөнгө оруулалттай холбоотой Олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орж, соёрхон баталсан. • Дэлхийн Худалдааны байгууллага, НҮБ болон холбогдох бусад олон улсын байгууллагад гишүүнээр элссэн. 	<ul style="list-style-type: none"> • Хууль эрх зүй, эдийн засгийн тогтворгүй байдал /эмзэг эдийн засагтай жижиг улс/ • Улс төрийн тогтворгүй байдал • Инфляци • Дэд бүтцийн хөгжил сул • Авлига, хүнд суртал • Далайгаас алслагдсан, газар зүй, байгаль, цаг уурын тааламжгүй нөхцөл
<ul style="list-style-type: none"> • Нээлттэй эдийн засгийн бодлоготой. • Татварын тогтолцоо, хөнгөлөлт, чөлөөлөлтийн систем • Хоёр их гүрний дунд оршдог • Байгалийн томоохон нөөц ордуудтай 	

² Мөн тэнд үз.

* *Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин*

Манай улс бусад орнуудтай харьцуулахад дэлхийн гадаадын хөрөнгө оруулалтын урсгалаас өчүүхэн хэсгийг хүртэж байгаа нь олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа хэдий ч хөрөнгө оруулалтыг дэмжих оновчтой бодлого, зөв зохион байгуулалт, эрх зүйн таатай орчин зэргийг оновчтой бүрдүүлэн хөгжүүлж чадвал зохих үр шимийг хүртэх бүрэн боломжтой юм. Монгол улс нь Дэлхийн Банкны Хөрөнгө оруулалтын даатгалын олон талт агентлагийн гишүүн бөгөөд 1965 оны Вашингтоны конвенцид Олон улсын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх асуудлаар 1996 онд, 1985 оны Сөүлийн конвенцид хөрөнгө оруулалтын даатгалын асуудлаар 1999 онд тус тус элсэн орсон.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийг 2013 оны 10 дугаар сарын 03-нд шинээр баталсан бөгөөд энэ хуульд 2013-2021 он хүртэл нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Энэ хуульд "Хөрөнгө оруулалт гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг;"³ гэж хөрөнгө оруулалтын үндсэн ойлголтыг тодорхойлсон.

Монгол Улсад оруулах гадаадын хөрөнгө оруулалт нь эрх зүйн хувьд: а/ чөлөөтэй хөрвөх валют, хөрөнгө оруулалтын үр дүнг төгрөгөөр олсон орлого; б/ хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, тэдгээртэй холбогдсон эд хөрөнгийн эрх; в/ оюуны өмчийн эрх гэсэн гурван үндсэн төрөлтэй байхаас гадна гадаадын хөрөнгө оруулагч нь Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхээс бусад хүрээнд гадаадын хөрөнгө оруулалт хийж болохыг хуулиар тодорхойлсон бөгөөд татварын нөхцөл, хөрөнгө оруулалтын эрх зүйн баталгаа, хөрөнгө оруулагчид олгох нөхцөл зэргийг зохицуулсан юм.

Хэдийгээр манай улсын холбогдох хууль тогтоомжоор хөрөнгө оруулалтын эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн гэж үзэж болох бөгөөд цаашид тэдгээрийг цаг үеийн шаардлага, өнөөгийн эрчимтэй хөгжиж байгаа нийгэм, эдийн засгийн хөгжилд нийцүүлэн сайжруулах, мэдээлэл, технологи, татвар, үйлдвэрлэлийн чиглэлээр эрх зүйн орчинг шинэчлэн зохицуулах шаардлагатай юм.

Цаашид гадаадын хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийг боловсронгуй болгохдоо зах зээлд чиглэсэн (market-seeking), ашигт малтмалд чиглэсэн (resource - seeking), үйлдвэрлэлийн бүтээмжид чиглэсэн (efficiency - seeking), стратегийн нөөц баялаг болон чадварт чиглэсэн (strategic asset or capability-seeking) хөрөнгө оруулалтын алинд нь түлхүү анхаарал тавих, алийг нь илүү дэмжих, ямар хөнгөлөлт үзүүлэх бодлогыг сайтар тодорхойлох хэрэгтэй юм.

Учир нь гадаадын хөрөнгө оруулалтын шийдвэрлэгч хүчин зүйлст эдийн засгийн хүчин зүйлсээс гадна манай орны гадаадын хөрөнгө оруулалтын

³ Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 он.

бодлогын тогтолцоо (policy framework) болон бизнесийн тав тухтай орчин (business facilitation), эрх зүйн таатай орчин (favorable legal environment) хамаарах бөгөөд үүнд төрийн тодорхой үйл ажиллагаа бодлого үгүйлэгдэж байна.

1.2 Оросын холбооны улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин

ОХУ-нь дэлхийн нийтэд найдвартай хөрөнгө оруулалт хийх боломжыг нээж өгсөн орнуудын нэг зүй ёсоор мөн ба энэ нь тухайн улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлого зэрэгтэй шууд хамаатай. Мөн үүнээс гадна хөрш орны бодлого, эрх зүйн зохицуулалтыг судалж өөрийн орны зохицуулалтуудыг сайжруулах нь найдвартай, зөв, эрсдэлгүй бодлого явуулахад чухал ач холбогдолтой юм.

* *Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин:*

1	Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин	<p>ОХУ дахь гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль¹ /1999 он/ - ОХУ дахь гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэн баталсан нь гадаадын хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг хамгаалах, тэдний үйл ажиллагааг дэмжихэд илүү анхаарсан байна.</p> <p>Улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуй нэгжүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай хууль² /2008 он/ - 2008 онд батлагдсан Улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуй нэгжүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай хуулиар гадаадын хөрөнгө оруулагчид стратегийн ач холбогдол бүхий ААН-үүдийн хувьцааг эзэмших тухай, эсхүл энэ төрлийн ААН-үүдэд хяналт тогтоох тухай хэлцлийг хязгаарлах, тэдгээрийнүйл ажиллагааг тодорхой болгох, ААН-үүдийн хөрөнгө оруулах өргөдлийг хянаж үзэх процедур, хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлага зэрэг асуудлыг зохицуулсан байна.³</p>
		<p>ОХУ-д капитал хэлбэрээр хөрөнгө оруулж буй үйл ажиллагааны тухай хууль⁴ /1998 он/ - ОХУ-д капитал хэлбэрээр хөрөнгө оруулж буй үйл ажиллагааны тухай хуулиар ОХУ-ын нутаг дэвсгэр дээр капитал хэлбэрээр хөрөнгө оруулж буй хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны эрх зүйн болон эдийн засгийн үндэсийг тогтоосон, мөн түүнчлэн хуулийн этгээлийн хэлбэрийг үл хамааран капитал хэлбэрээр хөрөнгө оруулж буй субъектын эрх, сонирхлыг тэгш хамгаалах баталгааг тогтоосон байна.</p>

2 Хөрөнгө оруулагчид үзүүлэх баталгаа буюу тогтворжуулалт

Гадаадын хөрөнгө оруулагч нарт үзүүлэх нийт 13 төрлийн үндсэн баталгаануудыг хуулийн 5-17-р зүйлүүдэд оруулсан байна. Тухайлбал,

- үйл ажиллагааны эрх зүйн хамгаалалт /5-р зүйл/
- хөрөнгө оруулалтын олон хэлбэрийг хэрэгжүүлэх /6-р зүйл/
- эрх, үүргийг нь өөр этгээдэд шилжүүлэх баталгаа /7-р зүйл/
- гадаадын хөрөнгө оруулагч, эсхүл гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийн эд хөрөнгийн улсад хураах, улсын болгоход нөхөн олговор олгох /8-р зүйл/
- гадаадын хөрөнгө оруулагч, эсхүл гадаадын хөрөнгө оруулалттай ААН-н хувьд ОХУ-ын хууль тогтоомжинд таагүй өөрлөлт орохоос сэргийлэх /9-р зүйл/
- хөрөнгө оруулалт оруулах, аж ахуйн үйл ажиллагаагаа явуулахтай холбоотойгоор үүсэх маргааныг зохих ёсоор шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх /10-р зүйл/
- ОХУ-ын нутаг дэвсгэрт олсон орлого, бусад хууль ёсоор олсон мөнгөн хөрөнгөө захиран зарцуулах, өөр улс руу шилжүүлэх /11-р зүйл/
- ОХУ-ын нутаг дэвсгэрт анхлан гадаадын хөрөнгө оруулалтын хэлбэрээр зөөвөрлөн оруулсан эд хөрөнгө, баримт бичиг, эсхүл цахим зөөврийн хэрэгсэлд агуулах мэдээлэлийг ОХУ-аас саадгүй зөөвөрлөн гаргах эрх /12-р зүйл/
- үнэт цаас олж авах эрх /13-р зүйл/
- хувьчлалд оролцох эрх /14-р зүйл/
- гадаадын хөрөнгө оруулагчид газар, бусад байгалийн баялаг, барилга байгууламж болон бусад үл хөдлөх эд хөрөнгө олж авах эрх /15-р зүйл/
- гаалийн албан татвараас хөнгөлөх /16-р зүйл/
- ОХУ-ын субъектууд болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын үзүүлэх хөнгөлөлт /17-р зүйл/

Гадаадын хөрөнгө оруулагчид болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид гаалийн албан татварын хөнгөлөлт үзүүлэх нь Холбооны улсын татварын тухай хуулиар нарийвчлан зохицуулагдана.

ОХУ-ын субъектууд болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын өөрсдийн эрх мэдлийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчид болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжидэл татварын хөнгөлөлт үзүүлэх, баталгаа гаргах, санхүүжилт хийх болон гадаадын хөрөнгө оруулагчийн хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөлд бусад хэлбэрийн дэмжлэгийг үзүүлж болно.

1.3 Чили улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин

1970-аад оны эцэс 1980-аад оны эхээр Чилийн Засгийн газар хувийн хөрөнгө оруулалтыг татахын тулд гадаадын хөрөнгө оруулалтыг либералчилсан. Үүний үр дүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт нь Чилийн зэсийн үйлдвэрлэл болон тус улсад шинээр томоохон хэд хэдэн уурхайг байгуулж ашиглах хувийн компаниудын хөгжилд их үүрэг гүйцэтгэсэн.

Зэсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хурдан өссөн бөгөөд Чили улсын эдийн засгийн өсөлт эрс хурдассан нь чухамхүү зэсийн үйлдвэрлэл эрс өргөжсөнтэй голчлон холбоотой. Хорь гаруй жилийн туршид Чили улс уул уурхайн хувийн хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын маш таатай орчин бүрдүүлж өгсөн. Фрэйзерийн Хүрээлэнгийн судалгаагаар хөрөнгө оруулалт татах чадавхын үнэлгээгээр Чили улс ямагт эхний хэдэн байрт орж байсан ба 2017-2018 оны байдлаар 12 дугаарт бичигджээ. Ийнхүү таатай орчин бүрдүүлсэн явдал нь Чилийн ашигт малтмалын татварын тогтолцоо, ялангуяа аж ахуйн нэгжийн татварын ерөнхий зохицуулалтаас үүдэлтэй.

Ийм өргөн хүрээний туршлага болон олон улсын тавцангаас өндөр итгэлийг уул уурхай, хөрөнгө оруулалтын салбарт хүлээсэн мөн цаашлаад эдийн засгийн хувьд Монгол улстай адил хэмжээнд байсан уул уурхайг хөгжлийн гол гарц болгон ашигласан зэргээс хамаарч Чилийн эрх зүйн зохицуулалт туршлагыг судалж ашиглах нь зүйтэй.

164

* Хөрөнгө оруулалтын орчин:

<p>1</p> <p>Хөрөнгө оруулалтыг зохицуулж буй хууль эрх зүйн актууд</p>	<p>Чилид гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих эрх зүйн гол хоёр баримт бичиг байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Гадаадын хөрөнгө оруулалтын хууль-Decree Law 600, 1974 оноос өнөөг хүртэл мөрдөж байгаа. 2. Төв банкнаас гаргасан валютын журмын 14 дүгээр бүлэг.
<p>2</p> <p>Гадаадын хөрөнгө оруулалтын зарчим</p>	<p>Гадаадаас Чили руу хөрөнгө шилжүүлж байгаа болон гадаадын хөрөнгө оруулалтын гэрээ хэлэлцээр хийсэн гадаадын иргэн, хуулийн этгээд, гадаадын албан ёсны хаягтай Чилийн байнгын оршин суугч нь тус улсын гадаадын хөрөнгө оруулалтын хуулийн зарчимд нийцүүлнэ.</p>
<p>3</p> <p>Гадаадын хөрөнгө оруулалтын бүртгэлийн үйл ажиллагаа</p>	<p>Гадаадын хөрөнгө оруулалт нь зөвшөөрөл, бүртгэл гэсэн 2 үе шатыг дамжина.</p> <ol style="list-style-type: none"> 1. Хөрөнгө оруулалтын зөвшөөрлийг тус улсын Гадаадын Хөрөнгө Оруулалтын Хорооноос олгоно. Дараахь 4 нөхцөлд хөрөнгө оруулалтын зөвшөөрөл шаардана.

	<p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 5 сая ам.доллараос дээш болон түүнтэй тэнцэх хэмжээний бусад валютаар хөрөнгө оруулалт хийгдэж байгаа бол, - Төрийн өмчийн оролцоотой компаниудад хөрөнгө оруулж байгаа бол, - Хэвлэл мэдээллийн компаниудад хөрөнгө оруулж байгаа бол, - Гадаадын улсын болон төрийн оролцоотой байгууллагаас хөрөнгө оруулалт хийгдэж бол тус тус зөвшөөрөл авах ёстой. <p>2. Харин хөрөнгө оруулалтын бүртгэлийг Төв банк капитал хөрөнгө орж ирсэн үед нь бүртгэх ба ингэхдээ олон улсын гадаад валютын журмын заалтыг баримтлан 10 мянгаас дээш ам.долларын хөрөнгө оруулвал түүнийгээ төв банкинд бүртгүүлэх ёстой. Мөн тус журмын дагуу бүртгүүлсэн хөрөнгө оруулагч нь татвар төлөлтөө Төв банкинд мэдээлж байх ёстой.</p>
4 Хөрөнгө оруулалтын гэрээ хийх нөхцөл	<p>Хөрөнгө оруулалтын гэрээг тус улсын Гадаадын Хөрөнгө Оруулалтын Хороо, хөрөнгө оруулагч нарын хооронд хийнэ.</p> <p>Гэрээгээр гадаадын хөрөнгө оруулагч нь тус улсад капитал хөрөнгө оруулах ёстой ба үүний хугацаа нь уул уурхайн хөрөнгө оруулалтанд 8-аас доошгүй жил, бусад салбарт 3 жил байна.</p> <p>Гадаадын хөрөнгө оруулалтын хороо нь уул уурхайн хөрөнгө оруулалтын дээрх хугацааг 12 жил болгон сунгаж болох ба энэ нь хайгуулын ажил хийх шаардлагатай, хайгуулын хугацааг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд сунгана. Үйлдвэрлэлийн салбар болон уул уурхайн олборлолтоос бусад салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалтын хэмжээ 50.0 сая ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют байвал дээрх хугацааг 8 жил хүртэл сунгаж болно.</p>
5 Гадаадын болон үндэсний хөрөнгө оруулагчидад хандах хандлага	<p>Чилийн хөрөнгө оруулалтын зохицуулалт нь гадаадын хөрөнгө оруулагчдыг дотоодын хөрөнгө оруулагчидтай ижил нөхцлөөр авч үздэг нь гадаадын хөрөнгө оруулагчдад таатай байдаг. Ингэснээр, гадаадын хөрөнгийг эдийн засгийн салбар бүрээр, бүс бүрт жигд байршуулж чаддаг.</p>
6 Гадаадын хөрөнгө оруулалтын хориглолт, хязгаарлалт	<p>Хөрөнгө оруулалтыг хориглосон салбар: Загас агнуур, банк, даатгал, харилцаа холбоо</p> <p>Хөрөнгө оруулалтыг хязгаарласан салбар: цөмийн эрчим хүч, далайн тээвэр, уул уурхай, батлан хамгаалах салбар, үл хөдлөх хөрөнгө</p>

7 Татварын орчин	<p>Чили улс нь татварын сайн системтэй орнуудын тоонд ордог. Чилийн эдийн засгийн бодлого нь гадаадын хөрөнгө оруулалтанд тусгайлсан урамшуулал тооцоод байдаггүй харин татвараар дамжуулан дэмжлэг үзүүлдэг. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - Гадаадын хөрөнгө оруулагч 10 жилийн туршид 42 хувийн татварыг тогтвортой төлөх ёстой. Энэ татварын хэмжээг Засгийн газар 10 жилийн туршид тогтвортой байлгах үүрэг хүлээх ба 50 саяас дээш ам.долларын хөрөнгө оруулсан бол энэ хугацааг 20 хүртэл жил болгож сунгах эрхтэй. - Уул уурхайн салбарт 50-иас дээш сая ам.долларын хөрөнгө оруулалт хийвэл 15 жилийн хугацаанд татварыг өсгөхгүй байх үүргийг Засгийн газар хүлээнэ. - Албан ёсоор зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын төсөлтэй холбоотой гадаадаас оруулж буй капитал, бараа бүтээгдэхүүнийг НӨАТ /VAT=19%/-аас хөнгөлөлт эдлүүлдэг.
8 Хөрөнгө оруулал-тын олон улсын гэрээний талаар	<p>Тус улс нь хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах зорилгоор Франц, Герман, Испани, Хятад, Бразиль, Аргентин зэрэг 45 оронтой олон улсын гэрээг байгуулсан байна.</p>

Дүгнэлт

Дэлхийд байгалийн, тэр дундаа эрдэс баялгийн нөөц шавхагдах тусам хаана газрын баталгаатай баялаг байна тэнд хөрөнгө оруулагч нар татвар, зарим улс төрийн эрсдэлийн магадлалыг төдийлөн харгалзахгүй хүрэлцэн очих болжээ. Учир нь соёлт ертөнцөд хөрөнгө оруулагч, орчуулуулагч нар олон улсын ба үндэсний хэмжээнд тодорхой гэрээ эрхийн дагуу ажиллах, эрсдлийн даатгал хийлгэх зарчмаар ажиллах тул хохирох магадлал үндсэндээ бараг үгүй юм.

1. Канадын "Fraser" институт уул уурхайн хөрөнгө оруулалтыг дэлхийн улс орнуудаар судалж, зэрэглэл тогтоодог судалгаандаа Бодлогын Чадавхийн Индекс (PPI) гэсэн үзүүлэлтийг чухалчилж авч үздэг бөгөөд PPI гэсэн энэхүү үзүүлэлт нь тухайн орны Засгийн газрын цогц бодлого уул уурхайн салбарт нь хөрөнгө оруулах гадаадын компаниудын сонирхолд хэрхэн нөлөөлж байгааг илэрхийлэх ба тухайн улсын уул уурхайн салбарын бодлого, татварын хууль, байгаль орчны хууль, зохицуулалтууд, захиргааны зүгээс үзүүлэх хүнд суртал, дарамт шахалт, дэд бүтцийн орчин, хөдөлмөрийн хууль, улс төрийн тогтвортой байдал, нийгэм-эдийн засгийн байдал, аюулгүй байдал зэрэг чухал хвчин зүйлүүдийг харгалзан тооцдог нийлмэл индекс юм.⁴ Мөн уул уурхайн салбарт судалгаа шинжилгээ, консалтингийн үйл ажиллагааг олон улсын түвшинд эрхэлдэг Behre Dolbear компани 1999 оноос эхлэн уул уурхайн хөрөнгө оруулалтын зэрэглэл (MIR)-ийг дэлхийн улс орнуудын

⁴ Annual Survey of Mining Companies 2005/2006, Fraser Institute

хувьд тооцож ирлээ. Тус байгууллага уул уурхайн хөрөнгө оруулалтын зэрэглэлийг дараах долоон шалгуураар үнэлдэг. Үүнд: тухайн орны, Эдийн засгийн систем, Улс төрийн систем, Нийгмийн асуудлуудын уул уурхайн салбар дахь нөлөөллийн зэрэг, Захиргаа үйлчилгээний шат дамжлага, хүнд суртал, Авлигал хээл хахуулийн зэрэг, Үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн хэлбэлзэл, тогтвортой байдал, Татварын бодлого, татварын хууль зэрэг болно.⁵ Fraser институтын жил бүр гаргадаг судалгаанаас үзвэл Монгол улс нь Бодлогын Чадавхын Индекс (PPI) үзүүлэлтээр ерөнхийдөө 15-20(онооны дээд хэмжээ нь 100) онооны хэмжээнд өмнө нь хэлбэлздэг байсан.⁶ Оюу толгойн гэрээ байгуулагдаж, хэрэгжиж эхэлсэн үеэс эхлэн /2008 он/ жилд дунджаар тогтмол 5 оноогоор ихэссээр 2022 оны байдлаар 43 оноонд хүрсэн харагдаж байна.⁷ Энэ нь Монгол улсын олон улсын тавцанд уул уурхайн салбар дээр тулгуурлан хөрөнгө оруулалтыг улам ихээр татаж хөгжих боломжийг нээж өгч буй үзэгдэл юм. Бид энэхүү зэрэглэлээ цаашид хадгалж олон улсын тавцан дахь байр сууриа алдахгүйн тулд өөрийн орны эрх зүй, эдийн засгийн орчноо төгөлдөржүүлэх асуудал

⁵ Where Not To Invest", Annual Report, Behre Dolbear & Co, Inc., 2006

⁶ Annual Survey of Mining Companies 2012/2013, Fraser Institute

⁷ <https://www.ceicdata.com/en/indicator/mongolia/producer-price-index-growth>

нэн чухал болоод байгаа юм.

- Манай улс бусад орнуудтай харьцуулахад гадаадын хөрөнгө оруулалтын урсгалаас өчүүхэн хэсгийг хүртэж байгаа нь олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа хэдий ч хөрөнгө оруулалтыг дэмжих оновчтой бодлого, зөв зохион байгуулалт, хууль эрх зүйн таатай орчин зэргийг оновчтой бүрдүүлэн хөгжүүлж чадвал зохих үр шимийг хүртэх бүрэн боломжтой юм. Иймд бид юуны түрүүнд хууль эрх зүйн хувьд нэгдмэл ойлголттой, өөр хоорондоо зөрчилгүй, эрх үүрэг, хариуцлага тодорхой байх шаардлагатай.

Жишээлбэл: Хөрөнгө оруулалтын тухай хуулинд Хөрөнгө оруулалтыг "...Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг;..."⁸ гэж тодорхойлжээ. Энэ нь хангалттай тодорхой бус ойлгомжгүй тодорхойлолт юм. Иймээс энэхүү тодорхойлолтыг Казахстаны харьцуулсан судалгаан дээр үндэслэн **"Хөрөнгө оруулалт гэдэг нь хүүлийн этгээдийн дүрмийн санд, эсхүл үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах тогтсон активыг нэмэгдүүлэх зорилгоор оруулж буй бүх төрлийн /хувийн хэрэгцээний бараа, бүтээгдэхүүнээс бусад нь/ хөрөнгийг, үүнд лизингийн гэрээ байгуулсан үеэс эхлэн санхүүгийн лизингийн зүйл болон эдгээр бүх хөрөнгөд хамаарах**

⁸ Хөрөнгө оруулалтын тухай хууль. 2013 он.

эрхийг хэлнэ⁹ гэж тодорхойлох нь илүү оновчтой, хөрөнгө оруулагчдад харьцангуй ойлгомжтой эрх зүйн зохицуулалт болно гэж үзэж байна.

3. Монгол улсын ашигт малтмалын тухай хуулийн хувьд Тусгай зөвшөөрлөөр эзэмшүүлж байгаа талбай, ордоо тодорхой хугацааны өмнө урьдчилан зарлаад, түүнийг эзэрсөлдөөнөөр шалгаруулж олгодог, олгохдоо аж ахуйн нэгж хувь хүнд талбайн хэмжээ, тусгай зөвшөөрлийн тоо түүнийг эзэмших хугацаагаар нь хязгаарладаг байх хэрэгтэй. Нэгэнт тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд зохих дүрэм зааврын дагуу иж бүрэн ажил явуулангуут хэсэгчлэн буцааж хүлээлгэж өгдөг байхыг тодорхой зааж хуульчилбал зохино.
4. Монгол улсын хувьд “Хөрөнгө оруулалтын тухай хууль”, “Концессийн тухай хууль”, “Ашигт малтмалын тухай хууль” болон Татварын багц хуулиуд зэрэг хууль эрх зүйн актуудаар хөрөнгө оруулалтын орчныг зохицуулж байгаа боловч нэгдмэл эрх зүйн тогтолцоог бүрдүүлж, хууль хоорондын зөрчлийг арилгаж системчлэх шаардлагатай байна.
5. Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хууль эрх зүйн орчны хүрээнд ихэвчлэн Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, хөнгөлөлт болон давуу эрх олгох асуудлыг түлхүү зохицуулсан байна.

Дотоодын хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгө оруулалтад хөрөнгө оруулах боломж олгох, хөнгөлөлт эдлүүлэх, тогтвортой байдлын гэрээ хийх зэрэг асуудлыг тодорхой хуульчилсан, нарийвчлан зохицуулсан байдал байхгүй байна.

Ашиглагдсан материал

Хууль тогтоомж, эрх зүйн актууд

1. Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2019 он.
2. Татварын ерөнхий хууль, 2019 он.
3. Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 он

Гадаад хууль тогтоомж эрх зүйн актууд

1. Закон Республики Казахстан “Об инвестициях” от 8 января 2003 года.
2. Федеральный закон от 25 февраля 1999 N 39-ФЗ “Об инвестиционной деятельности в Российской Федерации, осуществляемой в форме капитальных вложений”
3. Федеральный закон от 29 апреля 2008 года N 57-ФЗ “О порядке осуществления иностранных инвестиций в хозяйственные общества, имеющие стратегическое значение для обеспечения обороны страны и безопасности государства”
4. Федеральный закон от 9 июля 1999 года N 160-ФЗ “Об иностранных инвестициях в Российской Федерации”

⁹ Закон Республики Казахстан “Об инвестициях” от 8 января 2003 года.

Монгол ном зохиол

1. “Бизнесийн эрх зүй- хуульчдад зориулсан гарын авлага”. УБ., 2003 он
2. “Дотоод хөрөнгө оруулалтын чуулган-санал асуулгын дүн”. УБ., 2005 он
3. З.Бороо. “Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шийдвэрлэгч хүчин зүйлс”. УБ., 2005 он
4. Д.Баянбилэг. “Гадаадын хөрөнгө оруулалт, чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт”. УБ., 2009 он

Гадаад ном зохиол

1. Тихомиров Ю.А. Публичное право. М.: НОРМА, 2002.
2. Бахрах Д.Н. Административное право. М.: Юрайт-Издат, 2002.
3. Налетов К.И. Еще раз о правовой природе концессионного договора в сфере недропользования // Законодательство и экономика. 2005. № 10.
4. Салиева Р.Н. Правовое обеспечение развития предпринимательства в нефтегазовом секторе экономики. Новосибирск: Наука, 2001.

Сонин сэтгүүл

1. Зууны мэдээ сонин 2008 оны 11,12, 2009 оны 1-3 сарын дугаарууд
2. Өдрийн сонин 2008 оны 11,12, 2009 оны 1-3 сарын дугаарууд

Илтгэл мэдээллүүд

1. Журнал «Главный Бухгалтер» № 28, 2007 г. Максим Щербина, экономист
2. Кандинская Ольга Александровна Журнал «Финансовый бизнес», № 2, 2000.
3. Монгол улс: ОУВС-ийн Дүрмийн IV заалтын дагуу 2008 оны зөвлөлдөх хэлэлцүүлгийн ажлын хэсгийн тайлан, Ажлын хэсгийн нэмэлт хавсралтууд болон Гүйцэтгэх Захирлуудын Зөвлөлийн хурлаас Олон нийтэд түгээх мэдээлэл
4. С.Болд-Эрдэс. “Ашигт малтмалын татварын зарим асуудалд”. www.tsahimurtuu.mn
5. Д.Мөнхтуяа. “Австрали-Монголын уул уурхайн эрх зүйн зохицуулалтын талаарх зарим

Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийн Үндсэн хуулийн үзэл баримтлал



Дотоод хэргийн их сургуулийн докторант З.Жаргалмаа

Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх нь эмэгтэйчүүдийн эрх, хүний эрхтэй салшгүй холбоотой. Хүний эрхийн талаар Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид “Үндсэн хуулийн үзэл баримтлал” бүтээлдээ “Хүний эрх гэж юуны өмнө хүнд өөрт нь байдаг төрөлх шинж, мөн чанар гэсэн утгаар буюу субъектив (эзэнлэг) эрхийг хэлдэг. Үүнийг хүнд өөрт нь байна уу, үгүй юу гэж үзэж мэдэрч болно. Бас тухайн төр нийгмийн мөн чанар, улс төрийн дэглэмээс хамааран хууль, журмаар хүнд олгосон боломж буюу эдэлж, дагаж болох хэм хэмжээний цогц “эрх зүй” гэсэн утга бий. Үүнийг “объектив эрх, эрх чөлөө” гэж болох бөгөөд энэ тухай олон хууль, гэрээний эмхэтгэлүүд зөндөө байдаг”¹ хэмээн дурджээ.

Мөн Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор С.Нарангэрэл “Хүний эрх- Хүний төртэй харьцах, түүний эдийн засгийн, нийгэмшлийн, улс төрийн,

соёлын хүрэн дэх боломж ба шаардлагын эрх зүйн байдлыг тодорхойлсон ухагдахуун юм”² гэж тодорхойлжээ.

Үндсэн хууль нь эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн асуудлыг бүрэн шийдэж чадахгүй байж болох ч шийдвэр гаргагчдыг удирдан чиглүүлэх удирдамжийн зарчмуудыг өөртөө агуулах боломжтой³ юм.

Монгол Улс түүхэн хөгжлийнхөө явцад хүний эрх, эмэгтэйчүүдийн эрх, тэгш эрх, хөдөлмөрлөх эрхийн талаар Үндсэн хуульдаа хэрхэн тусгаж ирснийг тоймлон авч үзье.

1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан Үндсэн хуульд иргэдийн эрх ашиг, эрх чөлөөг анх удаа хуульчлан тунхагласан нь Монголын түүхэнд байгаагүй ололт, цоо шинэ зүйл байсан гэж болно. 1924 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 3.11-д “Тус улсын харьяат ард түмэнд угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй гэдэг ялгаваргүй нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино”⁴ хэмээн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг анх удаа тунхаглан зарлажээ.

1940 оны Үндсэн хуулийн 71 дүгээр зүйлд “БНМАУ-ын харьяат 18 насанд хүрсэн бүх иргэд нь эрэгтэй, эмэгтэй, шашин шүтлэг, яс үндэс, эрдэм чадвар, нүүдлийн буюу суурьшлын байдал, эд хөрөнгийн байдлыг ялгаварлахгүй, гагцхүү

² Нарангэрэл, С. Эрх зүйн толь бичиг. (2007), 563 дахь тал

³ Хүний эрхийн соёлыг бий болгох нь. (2011). УБ., 73 дахь тал

⁴ Батаа, С. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд /1924-1992/. (1998). УБ., 5 дахь тал

¹ Чимид, Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал. (2017). УБ., 191 дэх тал

ашиг олз хураах зорилгоор хөлсний хүчийг ашиглагчид ба мөнгө хүүлэгчид, урьдын хутагт хувилгаад, дээд лам нар, жинхэнэ засаг ба засаг бус хан, ван, бэйл, бэйс, гүн түүнчлэн албан хамжлагатай байсан бөгөөд тэрхүү хамжлагаа хатуу чангаар дарлан захирч явсан тайж нар, хошуу шавь захирч байсан түшмэд, нөлөө бүхий бөө удган, цагаан цэрэгт ба хувьсгалын эсэргүү бослогод идэвхтэйгээр оролцогсод, ухаан мэдрэл эвдрэгсэд хийгээд шүүх таслах газрын тогтоолоор сонгуулийн эрхээ хасагдаж шийтгүүлсэн хүмүүсээс бусад нь сонгуульд оролцох ба сонгогдох эрхтэй”⁵ болохыг хуульчилсан. Үндсэн хуулийн 73 дугаар зүйлд эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдийн нэгэн адил сонгох, сонгогдох бүрэн эрхтэй хэмээн баталгаажуулсан байна.

Мөн иргэдийн хөдөлмөрлөх эрхийг баталгааг хангах зорилгоор ажлын найман цагийн үргэлжлэлийг тогтоож, ээлжийн амралт эдлэх, амарч сувилуулах, нийгмийн тусламж дэмжлэг авах эрхийг 1940 оны Үндсэн хуульд анх удаа тусгасан. Энэхүү Үндсэн хуулийн 89 дүгээр зүйлд “БНМАУ-ын иргэд амрах эрхтэй. Үүнд ажилчин албан хаагчдын амрах өдрийг 8 цаг болтол хорогдуулж, ажилчин албан хаагчдад цалинг хэвээр олгон, жил бүр амралтаа эдлүүлэх, бас театр, клуб, санатори, амралтын газрыг хөдөлмөрчдөд зориулж хэрэгжүүлснээр энэхүү эрхийг

хангана”⁶ хэмээн хуульчилжээ. Түүнчлэн 91 дүгээр зүйлд “БНМАУ-ын хөлсний ажил хийгч ард иргэн нь нас хөгшрөх цагт мөн түүнчлэн өвдөх ба хөдөлмөрийн чадвараа алдвал эдийн тусламж авах эрхтэй. Үүнд: Улсын буюу хөлслөгч этгээдийн зардлаар ажилчин, албан хаагчдыг нийгмийн зардлаар хангах ба хөдөлмөрчдөд эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүйгээр үзүүлэх, эмнэлгийн рашаан усыг дэлгэрүүлэх зэргээр энэхүү эрхийг хангана” гэж дурдсан байна.

1924 оны Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 3.11 дэх заалтад тусгагдсан эрэгтэй, эмэгтэй ялгаваргүй тэгш эрх эдлэх тухай товчхон заалт 1940 оны Үндсэн хуульд дараах байдлаар илүү дэлгэрэнгүй болж уламжлагдсан байна. Үндсэн хуулийн 93 дугаар зүйлд “БНМАУ-ын эмэгтэйчүүд нь засаг төр, аж ахуй, нийгэмлэг, улс төр, ахуй соёл, боловсролын бүхийлэн салбарт эрэгтэйчүүдийн нэгэн адил тэгш эрхийг эдэлнэ. Эдгээр эрхийг биелүүлэх бололцоо нь эмэгтэйчүүдэд эрэгтэй хүний нэгэн адил ажил хөдөлмөрийн бололцоог олгох, амрах буюу аюулаас хамгаалуулах эрдэм сурах бөгөөд эх нялхсын эрх ашгийг улсаас батлан хамгаалах ба бие жирэмсэн эмэгтэйчүүдэд зохих чөлөөг олгох, мөн энэ завсар хөлс хэрэглэлийг бүрэн дүүрэн хэвээр олгох явдлаар хангагдана” гэжээ. Уг хуулийн 102 дугаар зүйлд хөдөлмөрийн сахилга, хандлагын талаар “БНМАУ-ын иргэн хэн бүхэн БНМАУ-ын Үндсэн хуулийг

⁵ Батаа, С. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд /1924-1992/. (1998). Уб., 38 дахь тал

⁶ Батаа, С. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд /1924-1992/. (1998). Уб., 41 дэх тал

журамлан дагаж, хууль цаазуудыг биелүүлэн гүйцэтгэх бөгөөд ажлын сахилгыг сахиж тус орны аж ахуй ба соёл боловсрол, улс төрийг хөгжүүлэх явдалд бүхийлэн аргаар тусалж нийгмийн үйлсэд үнэнчээр зүтгэвэл зохино”⁷ гэж дурджээ.

1924, 1940 онуудын Үндсэн хуульд тусгалаа олсон тэгш эрхийн зарчим 1960 оны Үндсэн хуульд мөн уламжлагдсан бөгөөд 76 дугаар зүйлд “БНМАУ-ын иргэд эрэгтэй, эмэгтэй, арьс, үндэс, шашин шүтлэг, нийгмийн гарал байдлаар ялгаваргүй тэгш эрхтэй”⁸ хэмээн тунхаглав. 1960 оны Үндсэн хуулийн 77 дугаар зүйлд “БНМАУ-ын иргэд хөдөлмөрлөх, хөдөлмөрийн хэмжээ, чанарт тохирсон цалин хөлс авах эрхтэй. БНМАУ-ын иргэн бүр аж ахуй, соёлын байгуулалтын аль ч салбарт хүч чадал, мэдлэгээ саадгүй ашиглан хөдөлмөрлөж, хийснийхээ хирээр тогтоогдсон цалин хөлс авч энэхүү эрхээ эдлэх бололцоог тус улсын социалист ахуйн системийн бүх давуу тал хангаж өгөх” тухай тусгасан ба цалин хөлс нь хөдөлмөрийн хэмжээ, чанар хийсэнд тохирох ёстой гэсэн зарчмыг шинээр оруулж өгсөн байна. Уг Үндсэн хуулийн 78 дугаар зүйлд “БНМАУ-ын иргэд амрах эрхтэй. Үүнд ажлын өдрийн дээд хэмжээг найман цагаар тогтоож, зарим онцгой мэргэжлийн ажлын цагийг хорогдуулж, ажилчин албан хаагчдыг долоо хоног тутам ба жил бүр амруулж, жилийн амралтын

цалинг нь хэвээр олгон, амралт, сувиллын газар, театр, клуб, зэрэг үйлчилгээний газрыг хөдөлмөрчдөд зориулан ажиллуулж, энэхүү эрхийг хангана. Тус орны үйлдвэрлэх хүчин хөгжих тутам ажлын цагийг хорогдуулж, төрөл бүрийн үйлчилгээг сайжруулан хөдөлмөрчдөд ойр дөт болгох замаар хөдөлмөрчдийн чөлөө цагийг нэмэгдүүлж, тэрхүү чөлөө цагаа гагцхүү амрахдаа биш харин мэдлэг боловсролоо дээшлүүлэн, бие бялдар, оюун ухаанаа хөгжүүлэхэд улам улмаар ашиглах боломж олгоход БНМАУ-ын бодлого чиглэгдсэн байна” гэж зааснаас дүгнэхэд өмнөх 1940 оны Үндсэн хуульд зааснаас зарим онцгой мэргэжлийн ажлын цагийг хорогдуулах, цаашид ажлын цагийг багасгаж, иргэдийн сурч боловсрох чөлөөт цагийг нэмэгдүүлэх бодлого баримтлах тухай тусгаснаараа илүү дэвшилттэй болжээ. Мөн 1960 оны Үндсэн хуулийн 79 дүгээр зүйлд “БНМАУ-ын иргэд нас хөгшрөх, мөн өвдөх, хөдөлмөрийн чадвараа алдах, тэжээгчээ алдахад эдийн тусламж авах эрхтэй. Үүнд: Нийгмийн даатгал, улсын тэтгэвэр, тусгай фондын системээр дамжуулан хөдөлмөрчдөд тусламж олгож, амралт сувиллын газрыг олшруулан эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүй үзүүлэн хөдөлмөр хамгааллыг хөгжүүлэн энэ эрхийг хангана”⁹ гэж хуульчилжээ. Энд нийгмийн даатгалын, тэтгэврийн зэрэг фондын систем, үнэ төлбөргүй эмнэлгийн тусламжийн талаар шинээр тусгаж, хөдөлмөр хамгааллыг хөгжүүлэх тухай

⁷ Батаа, С. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд /1924-1992/. (1998). Уб., 43 дахь тал

⁸ Батаа, С. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд /1924-1992/. (1998). Уб., 66 дахь тал

⁹ Мөн тэнд, 67 дахь тал

дурдсан байна. Түүнчлэн эвлэлдэн нэгдэх эрхийн талаар Үндсэн хуулийн 82 дугаар зүйлд "БНМАУ-ын иргэд үйлдвэрчний эвлэл, хоршоолол, залуучууд, биеийн тамирын эвлэл зэрэг байгууллага, соёл, шинжлэх ухаан, техникийн нийгэмлэг, тэрчлэн улс түмний найрамдал, энх тайвныг бэхжүүлэх нийгэмлэг зэрэг олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдэх эрхтэй. Улсын ба хөдөлмөрчдийн олон түмний бусад бүх байгууллагын манлайлагч бөгөөд жолоодогч Монгол Ардын Хувьсгалт намд ажилчид, хоршоолсон хөдөлмөрчид, хөдөлмөрч сэхээтний эгнээнээс шалгарсан хамгийн идэвхтэй, ухамсартай иргэд эвлэлдэн нэгдэнэ" хэмээн дурджээ.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийн талаар 1960 оны Үндсэн хуулийн 84 дүгээр зүйлд тусгахдаа "БНМАУ-ын эмэгтэйчүүд нь төр, аж ахуй, нийгэм, улс төр, соёлын бүх салбарт эрэгтэйчүүдийн нэгэн адил эрх эдэлнэ. Үүнд: эмэгтэйчүүдэд хөдөлмөрлөх, амрах, нийгмийн даатгалаар хангагдах, боловсрох нөхцөлийг эрэгтэйчүүдийн адил тэгшээр олгож, эх нялхсын эрх ашгийг улсаас хамгаалж, олон хүүхэдтэй эхчүүдэд тусламж үзүүлэх, жирэмсэн эмэгтэйчүүдэд амаржихын өмнө ба хойно зохих чөлөө олгож, цалинг нь хэвээр өгөх, амаржих газар ба хүүхдийн ясли, цэцэрлэгийг өргөтгөж энэхүү эрхийг хангана. Эмэгтэйчүүдийг эрхээ эдлэхэд ямар нэг саад тотгор учруулахыг хуулиар хориглоно"¹⁰ гэж

¹⁰ Багаа, С. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд /1924-1992/. (1998). Уб., 69 дэх тал

заажээ. Олон хүүхэдтэй эхчүүдэд тусламж олгох, амаржих газар, ясли, цэцэрлэгийн хүрэлцээнд анхаарч тоог нэмэгдүүлэх, жирэмсний болон амаржсаны тэтгэмжтэй чөлөөний асуудлыг шийдвэрлэх асуудлыг Үндсэн хуульд тусгаснаар эмэгтэйчүүдэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой ач холбогдолтой болжээ. Мөн хуулийн 87 дугаар зүйлд "БНМАУ-ын төрийн байгууллыг хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоор хөдөлмөрчдийн эрх ашигт нийцүүлэн БНМАУ-ын иргэдэд үг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх эрх чөлөөг хуулиар батлан олгосон болно. Эдгээр эрх чөлөөг эдлэхэд шаардагдах эд материалын нөхцөлийг хөдөлмөрчид ба тэдгээрийн байгууллагад хангаж өгнө"¹¹ гэж дурдсан байна.

1940, 1960 оны Үндсэн хуулиудын талаар Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид "1940 оны Үндсэн хуульд малчин ард, иргэдэд мал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн буюу "багаж хэрэгсэл" бүтээгдэхүүн орлогоо өмчлөх хувийн өмчийг зөвшөөрсөн онцлогтой ч улсын эдийн засгийн зонхилох өндөрлөгүүдийг төрийн өмчид байхаар тогтоосон тэр гол чанараараа болон 1950-иад онд нийгэмчилсэн үр дүнгээрээ 1960 оны хуультай адилсах мэт. Үндсэн хуулийн мөн чанарыг илэрхийлдэг нэгэн гол шалгуур болох хүний эрх, эрх чөлөөний тухайд энэ хоёр хууль үзэл баримтлал нэгтэй гэж

¹¹ Мөн тэнд

үзэж болно"¹² гэж тодорхойлж хэлсэн байдаг. Өмнөх Үндсэн хуулиудын агуулга, үзэл санаанаас тухайн үеийн нийгмийн хөгжлийн чиг баримжааг тодорхойлж болох бөгөөд эдгээр Үндсэн хуулиудыг Академич Б.Чимид “хувьсгалын ардчилсан шатны” Үндсэн хууль (1924 он), “Социализмын үндсийг байгуулах үеийн” Үндсэн хууль (1940 он), “Социализмын бүрэн ялалтыг хангах үеийн” Үндсэн хууль (1960 он)¹³ хэмээн тодорхойлжээ.

1992 оны Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”, 16 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж тус тус хуульчилсан. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулж, 16 дугаар зүйлийн дөрөв дэх хэсэгт хөдөлмөрлөх эрхийн талаар “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэж заасан бөгөөд өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд

төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхийг хуульчилсан. Түүнчлэн Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд хөдөлмөрлөх нь иргэн бүрийн журамт үүрэг хэмээн тодотгосон. Мөн 16 дугаар зүйлийн 14-т Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах эрхийг тусгасан.

“Монголчуудын өвөг дээдсийн үнэлэмжийн ёсоор “Түмэн бодисын охь, мянган амьтны манлай болсон хүнийг дээдэлж, түүний эрх чөлөөт байдлыг бүрэн зөвшөөрч эрхэмлэсэн нь Үндсэн хуулийн язгуур үзэл баримтлалын нэг юм. Шинэ Үндсэн хууль нь 1924 оных шиг хүн амынхаа төдийгүй, нэгэн ангийн зөвхөн нэг хэсэг байсан жинхэнэ ардын эрх чөлөөг бус, 1960 оны Үндсэн хууль шиг “ажилчин анги тэргүүтэй, хөдөлмөрчдийн ч биш, ерөөс дархыг бус хүний ба иргэний эрх, эрх чөлөөт ардчилсан нийгэм, эрх зүйт төрийн мөн чанарт нийцүүлэн тодорхойлж, өргөн дэлгэр баталгаа тогтоосноороо чанарын ялгаатай гэж үзэх бүрэн үндэстэй.”¹⁴ “Шинэ Үндсэн хууль (1992 он) бол Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол хийгээд нийгэм, төрийн байгууллын ардчилсан үндэс тулгуурыг төрийн эрх мэдлийн хуваарилалт, түүний байгууллагын болон орон нутгийн удирдлагын тогтолцоог бэхжүүлж, Үндсэн хуулийг сахин хамгаалах хяналтыг тогтоосон гол хууль мөн”¹⁵.

Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах үндсэн хуулийн

¹² Чимид, Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал. (2017). УБ., 126 дахь тал

¹³ Чимид, Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал. (2017). УБ., 129 дэх тал

¹⁴ Мөн тэнд, 127 дахь тал

¹⁵ Чимид, Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал. (2017). УБ., 129 дэх тал

хамгаалалт нь ямар үр дүнд хүрэх ёстой вэ? Юуны өмнө үндсэн хууль бүтээхэд эмэгтэйчүүдийн оролцоо машчухал. Хэрэв эмэгтэйчүүд үндсэн хуулийн асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцвол эмэгтэйчүүдийн эрх зүйн болон нийгмийн байдалтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд үндсэн хууль ерөнхийдөө баталгаа болж чаддаг¹⁶ байна.

1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалын талаар Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид "Сүүлийн жилүүдэд "үзэл баримтлал" гэдгийг юм болгонд, бараг л хоолны нэртөрөлдөөр шахам ярьж хэлдэг нэгэн сонсголонтой үг болгожээ. Уг нь мэргэдийн тайлсан ёсоор бол аливаа үзэгдэл үйл явцыг тодорхойлж ойлгох үзэл бодлын тогтолцоо буюу шинжлэх ухааны бүтээл туурвилд бол түүнийг бүтээхэд зорьж баримталсан нэгдмэл тодорхойлогч гол үзэл санаа, сэтгэмжийг хэлдэг билээ. Энэ горимд захирагдвал Монгол Улсын Үндсэн хуулийг боловсруулахдаа зорьж баталсан гол үзэл санааг:

1. Монголын нийгэм- төрийн байгууллын хөгжлийн чиг баримжаа, үндэс тулгуурыг бэхжүүлэхэд зорьсон
2. Хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөхөд зорьсон.
3. Төрийн байгуулал, байгууллагуудын тогтолцоог тодорхойлоход зорьсон
4. төрийн байгууламж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь, түүний удирдлагыг тодорхойлж, бэхжүүлэхэд зорьсон

үзэл баримтлалд тус тус хуваан
¹⁶ Хүний эрхийн соёлыг бий болгох нь. (2011). Уб., 60 дахь тал

тодорхойлох боломжтой гэж үзэж байна¹⁷ гэж бичжээ. Түүний "Хүний эрх ба Үндсэн хуулийн үзэл баримтлал" илтгэлд "Үндсэн хууль бол "цэвэр" эрх зүйнхээс гадна улс төрийн хэм хэмжээг агуулж байдаг хийгээд нийгмийн улс төрийн өрсөлдөгч, тэмцэлдэгч хүчнүүдийн бодит харьцаа, сөргөлдөөн дэх тэнцлийг илэрхийлдэг учраас "шүүмжлэлд" ертөх нь бий, байх ч болно. Нэг талаар Үндсэн хууль халдашгүй ариун дархан зүйл биш нь ямар нэг хэмжээгээр ойлгомжтой боловч "өдөр бүр" ноолж өөрчилж байдаг тогтоол, заавар биш. Нөгөө талаар бүх үндсэн хууль нь бүх улс оронд адил шийдэл өгдөг цорын ганц жор ч бус. Харин байж болох хувилбаруудын дотроос тухайн орны түүхэн үе дэх улс төрийн хүчнүүдийн "эвлэрэн" шилж авсан нэг л сонголт нь байдаг"¹⁸ хэмээн үндсэн хуулийн тогтвортой байдлын талаар дурдсан байдаг. Мөн тэрээр "Үндсэн хууль бол ёслол хүндэтгэл үзүүлж байвал зохих төр-хууль зүйн хамгийн гол баримт бичиг мөн"¹⁹ гэж тодорхойлсон.

1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиудад баталгаажсан хөдөлмөрийн харилцааны зарчмууд нь тухайн үеийн хөдөлмөрийн хууль тогтоомжуудад тусгалаа олж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн адил хөдөлмөрлөх эрхээ эдлэх, нийгэм, ахуйн хөнгөлөлт, тусламж дэмжлэг авах, эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо

¹⁷ Чимид, Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал. (2017). Уб., 53 дахь тал

¹⁸ Батаа, С. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд /1924-1992/. (1998). Уб., 136 дахь тал

¹⁹ Чимид, Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал. (2017). Уб., 87 дахь тал

илэрхийлэх боломжтой болсон. Монгол Улс хөдөлмөрийн харилцааг зохицуулсан нэгдмэл актуудыг 1925 онд Аливаа хүчин үнэлэгчдийн дүрэм, 1930 онд БНМАУ-ын хэчнээн үнэлэгчдийн хууль, 1933 онд Хүчин үнэлэхүйн тухай хууль, 1934 онд Хүчин үнэлэхүйн тухай хууль, 1941 онд БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль, 1973 онд БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль, 1991 онд Хөдөлмөрийн хууль, 1999 онд Хөдөлмөрийн тухай хууль нэртэйгээр баталж, хэрэгжүүлж ирсэн бөгөөд 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-ын чуулганаар баталсан. Эдгээр хуулиудын тухайд тухайн үеийн Үндсэн хуулийн үзэл баримтлал, нийгэм, эдийн засгийн хөгжил, шаардлагатай уялдуулан хөдөлмөрийн харилцааг зохицуулж иржээ гэж болно.

Харин Монгол Улсад 1921 оны 03 дугаар сараас 1925 оны 02 дугаар сарын 14 хүртэлх зурвас хугацаанд хөдөлмөрийн харилцааг зохицуулсан нэгдмэл акт байсангүй. Энэ үед шинээр байгуулагдсан төрийн яамд, улсын болон бусад албан газар, байгууллагад ажиллагсдын хөдөлмөрийн үйл ажиллагааг Ардын Засгийн газраас батлан гаргасан тогтоол, жич дүрмүүдээр зохицуулж байв. Жишээ нь: Ажилчин, албан хаагчдын цалин хэрэглэлийн тухай дүрэм (Түр Засгийн газрын 1921 оны 04 дүгээр сарын 23, 1921 оны 05 дугаар сарын 13-ны тогтоол), ажлын цагийг тогтоох тухай (Ардын түр Засгийн газрын 1921 оны 05 дугаар сарын 20-ны тогтоол) болон бусад асуудлаар Монгол Улсын

Засгийн газраас тусгайлан тогтоол гаргаж байжээ. 1921-1925 оны үед хөдөлмөрийн харилцааны асуудлыг "Засгийн газрын төлөөлөгчийн дүрэм", "Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм", "Ардын засгийн уул уурхайн дүрэм" (1922 он), "Хоршоо байгуулах тухай бичиг" (1921 он) гэх мэтийн тусгайлан гарсан дүрмүүдээр зохицуулж байв.

1925 оны 02 дугаар сарын 14-нд Ардын Засгийн тогтоолоор баталсан "Аливаа хүчин үнэлэгчдийн дүрэм" буюу Монгол Улсад хөдөлмөрийн үйл ажиллагааг нэгдмэлээр зохицуулагч анхны актаар энэ шаардлагыг хангажээ. Ардын Засгийн газрын тогтоолоор 1925 онд батлагдсан "Аливаа хүчин үнэлэгчдийн дүрэм"-д "Аливаа хүчин үнэлэгчдэд өвчний зэрэг зовлон тохиолдоход арчлан хамгаалахын учир тусламжийн тухай" асуудлыг тусгаж хэрэгжүүлж байсан ба ажилчин албан хаагч өвдөх, хөдөлмөрийн чадвараа түр алдвал нэг сар хүртэл, жирэмсэн болох, хүүхэд төрүүлэхэд гурван сарын хугацаанд цалинг олгож байхаар тусгажээ. Энэ бол Монгол Улсад эмэгтэйчүүдэд жирэмсний болон амаржсаны тэтгэмж, чөлөөг олгохоор төрөөс тогтоосон анхны хэм хэмжээ байсан юм. Улмаар 1930 онд БНМАУ-ын хүчнээн үнэлэгчдийн хууль, 1933, 1934 онуудад Хүчин үнэлэхүйн тухай хууль, 1941, 1973, 1991 оны Хөдөлмөрийн хууль, 1999 оны Хөдөлмөрийн тухай хууль батлагдаж, тухайн цаг үеийнхээ хөдөлмөрийн харилцааг зохицуулах түүхэн үүргийг гүйцэтгэсэн.

2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр УИХ-аар батлагдаж, 2022

оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөдөлмөрийн тухай хуульд өнөөгийн нийгэмд шинээр бий болсон харилцаануудыг зохицуулах, ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт, албадан хөдөлмөрлүүлэхийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах, нийгмийн түншлэлийг хангах суурь зарчмуудыг тусгаснаараа шинэлэг болсон. Мөн энэхүү хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т ажил олгогч нь ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах гэх мэт ажилтны хүүхдэд ээлтэй хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх тухай заалт нь хөдөлмөр эрхлэлтийн харилцаа эх, хүүхэд, гэр бүлд ээлтэй байх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байна.

Бизнесийн эрх зүйн орчныг сайжруулахад комплаенсын
мэргэжилтнүүдийн үзүүлэх үр нөлөө



Монголын Криминологичдын
холбооны эрх зүйн судалгааны
ажилтан, олон улсын эрх зүйч,
бизнесийн удирдлагын магистр
О.Анударь

Хураангуй: Шударга, ёс зүйтэй, авлигаас ангид эрх зүйн орчныг бий болгохын тулд юуны өмнө тус эрх зүйн орчин бизнес эрхлэгчдэд ойлгомжтой, тодорхой, тогтвортой байх шаардлагатай хэмээх санаан дээр үндэслэн юуны өмнө байгууллагынхаа үйл ажиллагааг эрх зүйн зохицуулалтуудад нийцүүлэхээр хяналт тавин ажиллах ажилтнуудыг бэлдэж, улмаар уг чиглэлийн мэргэжилтнүүд нийцэл буюу комплаенсыг хэрэгжүүлэхэд тулгарсан асуудлууд дээрээ дуу хоолойгоо нэгтгэн, уг асуудлуудыг шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлж, шийдлийг шаардах тогтсон механизм бүрдүүлэхийг санал болгож байна.

Түлхүүр үгс: комплаенс, дагаж мөрдөх, нийцэл, комплаенсын стандарт, комплаенсын ажилтан, комплаенсын форум, комплаенсын сургалт, комплаенсын үйл явцыг үнэлэх

Abstract: Based on the idea that

the legal environment needs to be stable, clear and understandable to businesses in order to create a fair, ethical and corruption-free legal environment, the first step is to train compliance officers to oversee the organization's activities and bring them into compliance. We propose to unite our voices on the issue, bring them to the attention of the officials authorized to resolve them, and establish a well-established mechanism to demand a solution.

Key words: compliance, compliance standards, compliance officer, compliance forum, compliance training, compliance process assessment

Оршил

Бизнес эрхлэгчид бизнесийн үйл ажиллагаа эрхлэхдээ эрх зүйн зохицуулалтуудыг чанд дагаж мөрдөөд явахад хүндрэлтэй, чирэгдэлтэй байдаг, тусгай зөвшөөрөл авах, үйл ажиллагаагаа тайлагнах гэх мэтээр цаг хугацаа болон зардал ихээхэн үр дүнгүй зарцуулдаг, төрийн албаны уялдаагүй ажиллагаа, баталгаатай байдлын эргэлзээ гэх мэт тулгардаг бэрхшээлүүдийг ихээр илэрхийлдэг.^{1,2,3,4} Улмаар үр ашиггүй зардал гаргалгүйгээр ажлаа бүтээхийн тулд авлига өгч, таньдаг хүнтэйгээ холбогдон амар хялбар аргаар шийдүүлэхийг оролдох гэх мэт хууль бус, ёс зүйгүй үйлдлүүд гарч байна.⁵ Тэгвэл эдгээр асуудлыг нэг хоёр хууль, дүрэм журамд өөрчлөлт оруулаад л шийдчихэж болох уу гэвэл үгүй юм. Тиймээс нарийн уялдаа холбоотой, тасралтгүй, хүндрэл чирэгдэлгүй ажилладаг механизм бүрдүүлэх хэрэгтэй байна.

¹ Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, International Labour Organization. *Аж ахуй эрхлэлт дэх албан бус хэвшлийг албан хэвшилд шилжүүлэх нь: өнөөгийн байдал, дүгнэлт, сорилт, шинэчлэлийн бодлогын зөвлөмж (чиглэл)* УБ., (2015)

² Монголбанк. *Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал*. Төвхимол-6. (2011) <https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group6/6-01.pdf>

³ Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монгол Улсын Их Сургууль. *Монголын бизнесийн орчны судалгаа 2020*. УБ., (2020) 25 дахь тал http://tram-mn.eu/media/tram/content/newsletters/mon/Business_Climate_Survey_Report_2020_MN-min.pdf

⁴ Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага. *Монгол Улсын бизнесийн орчны суурь судалгаа эцсийн тайлан*. (2018) <https://openjicareport.jica.go.jp/pdf/12321667.pdf>

⁵ Азийн сан. *Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгаа*. (2018) 28-30 дахь тал

Үндсэн хэсэг

Монгол Улсад өнөөгийн байдлаар эрх зүйн хэм хэмжээний актуудыг дагаж мөрдүүлэх зохицуулалтуудыг судлан үзвэл МУЗГ-ын 2011 оны 11-р сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолоор «Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам»-ыг баталсан байдаг.⁶ Тус журмын 1.3-т «Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон «Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам»-тай байна» хэмээн зохицуулсан. Мөн 5.1-д «Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын дагуу буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг ногдуулна», 5.2-т «Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ» хэмээн дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалд ногдуулах хариуцлагын зохицуулалтыг оруулж өгсөн байдаг. Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйлийн 1.2-т дотоод хяналт шалгалтын журам тогтоож мөрдүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан.⁷ Цагдаагийн Ерөнхий

⁶ Засгийн газрын 2011.11.09-ний тогтоол. Дугаар 311. *Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам*. (2011)

⁷ Зөрчлийн тухай хууль (2017) <https://legalinfo.mn/mn/detail/12695>

Газрын Хуулийн этгээдийн зөрчлийн бүртгэлийн сүүлийн 5 жилийн бүртгэлийг авч үзвэл 2018 оноос бусад жилд 800-аас дээш тооны аж ахуйн нэгжид зөрчлийн хэрэг үүсгэн торгууль ногдуулсан үзүүлэлттэй байгаагаас үзвэл хуулийн этгээдүүдийн хууль дүрэм журам дагаж мөрдөлт хангалтгүй байна.⁸ Бас нэгэн жишээ дурдвал Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2 дугаар сарын 10-ны дотор МХБ-д ирүүлэх үүрэгтэй байдаг бол 192 хувьцаат компанийн 95 нь олон нийтэд нээлттэй, ил тод байх компанийн засаглалын сайн жишгийг хангаж санхүүгийн тайлангаа ирүүлсэн байхад үлдсэн 97 нь үүргээ биелүүлээгүй байна.⁹ Эдгээр зөрчил ямар шалтгаантай вэ, дагаж мөрдөлтийг хэрхэн нэмэгдүүлэх боломжтой вэ? Дээр дурдсанаар журам байна, уг журмын дагуу дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамтай байх ёстой юм байна, байхгүй бол Зөрчлийн тухай хуулиар торгоно, байгаад журмынхаа дагуу зөрчлүүдийг илрүүлж арилгаагүй бол мөн торгох хариуцлагатай гэсэн ийм ерөнхий зураглал гарч ирж байна.

Тэгвэл энэ дагаж мөрдөлтийг хэрэгжүүлдэг тогтолцооны хувьд олон улсад байгууллагууд комплаенс буюу нийцлийн ажил эрхэлдэг алба юм уу мэргэжилтэнтэй, олон улсын форум нь жил бүр явагддаг,

⁸ Цагдаагийн Ерөнхий Газар. *Статистикийн мэдээ*. <https://police.gov.mn/as/article/3>

⁹ Монцамэ мэдээллийн агентлаг. *Хувьцаат компаниудын тал хувь нь үүргээ биелүүлжээ*. (2021.03.02) <https://www.montsame.mn/mn/read/255424>

өөрийн гэсэн стандарттай, энэ чиглэлээр сургалтууд өргөн зохион байгуулагддаг, нарийн хөгжсөн ухагдахуун юм. Комплаенс гэдэг нь байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомж, дүрэм, журам, олон улсын стандартыг дагаж мөрдөн, ажил үйлчилгээг стандартын дагуу хэрэгжүүлэх тухай ойлголт юм. Италиар "complire", испаниар "cumplir", латинаар "complere", англиар "compliment, complete" буюу гүйцэтгэх, гүйцээх, биелүүлэх гэсэн үгнүүдээс гаралтай.¹⁰¹¹¹² "Хууль тогтоомж, дүрэм, журам хаана, хэрхэн зөрчигдөж байгааг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, зөрчсөний улмаас байгууллагад учирч болзошгүй алдагдал, хохирлыг багасгаж бизнесийг саадгүй, амжилттай явуулахад дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй.¹³ Байгууллагууд холбогдох хууль, бодлого, дүрэм журмыг мэдэж, дагаж мөрдөх арга хэмжээ авахад чиглэсэн хүчин чармайлтаар хүрэхийг зорьж буй зорилтыг тодорхойлдог.¹⁴ Олон тооны зохицуулалт нэмэгдэж, үйл ажиллагааны ил тод байдал шаардагдаж байгаатай холбогдуулан байгууллагууд

¹⁰ Санхүүгийн зохицуулах хороо. *Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын комплаенсын ажилтнуудад зориулсан гарын авлага*. (Суурь ойлголт) (2019) 6 дахь тал

¹¹ International Compliance Association. *What is Compliance?* <https://www.int-comp.org/careers/your-career-in-compliance/career-in-compliance/>

¹² Hirokiyo Furuta. *Origins and History of Compliance*. (2016.09.30) <http://global.chuo-u.ac.jp/english/features/2016/09/8536/>

¹³ Richard M. Steinberg. *Governance, Risk Management, and Compliance: It Can't Happen to Us-Avoiding Corporate Disaster, While Driving Success*. (2011)

¹⁴ Tom C.W.Lin. *Compliance, Technology, and Modern Finance* (2017.04.21) https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=2904664

нэгтгэсэн, уялдуулсан багц комплаенсын хяналтын хэрэглээг улам бүр нэвтрүүлж байна.¹⁵ Энэхүү хандлагыг нөөц баялгаас шаардагдах хүчин чармайлт, үйл ажиллагааг давхардуулахгүйгээр шаардлагатай бүх засаглалын шаардлагыг хангахад ашигладаг.

Үр дүнтэй комплаенсын хөтөлбөр боловсруулахад 7 гол түлхүүр хүчин зүйлс шаардлагатай.¹⁶ Үүнд:

- 1) Байгууллага ажилтнууддаа комплаенсын стандарт, үе шатууд боловсруулах;
- 2) Хөтөлбөрийг байгууллага доторх "дээд шатны" ажиллах хүчнүүдээр удирдуулан хянуулах;
- 3) Байгууллага гэмт зан үйлд чиглэмтгий ажилтанд томоохон эрх мэдэл олгохгүй байхад анхаарах;
- 4) Боловсруулсан комплаенсын стандарт болон үе шатуудынхаа талаар ажилтнууддаа сургалт явуулж, үр дүнтэй харилцаа холбоо бүрдүүлэх;
- 5) Хяналт, аудитын тогтолцоог хэрэгжүүлж, ажилтнууд буруу үйлдлийг айдасгүйгээр мэдээлэх боломжтой тогтолцоо бүрдүүлэх (жишээ нь: шүгэл үлээх хөтөлбөр);
- 6) Ажилтнууддаа буруу үйлдлийг мэдээлэхийг уриалж, буруутай этгээдэд хариуцлага тооцох сахилгын бодлого боловсруулах;

¹⁵ Silveira, P., Rodriguez, C., Birukou, A., Casati, F., Daniel, F., D'Andrea, V., Worledge, C., Zouhair, T. *Aiding Compliance Governance in Service-Based Business Processes*, IGI Global, (2012) pp. 524–548

¹⁶ Michael G. Silverman. *Compliance Management for Public, Private, or Nonprofit Organizations*. (2008) p.57

7) Зөрчил мэдээлсэн тохиолдолд дүйх арга хэмжээ авч, ирээдүйд дахин тохиолдохоос урьдчилан сэргийлэх.

Үүн дээр бизнес эрхлэгчдэд хууль дүрэм журмаа дагахад нь дэмжлэг үзүүлдэг ямар аргачлал, чиглэл өгөх зөвлөмж байдгийг судлан үзвэл Монгол Улс 2019 оны 12 сарын 30-ны өдөр Нийцлийн (комплаенс) менежментийн тогтолцооны MNS ISO 19600:2019 стандартыг баталсан.¹⁷ Гэвч энэ стандартыг мэддэг, авч хэрэглэдэг байгууллага хэд байдаг бол? Тэдэнд ийм стандарт байдаг, ийм ач холбогдолтой гэдгийг ямар арга замаар мэдэгдэх боломжтой вэ? Юуны өмнө уг стандартыг авч үзье. Энэ нь олон улсын стандарт бөгөөд олон улсад «ISO 19600:2014 Compliance management systems» хэмээх нэршлээр 2014 оны 12-р сард батлагдсан байна. Уг стандарт сайн засаглал, тэнцүү чанар, ил тод байдал, дэмжих чадварын зарчмуудад тулгуурласан, үр дүнтэй комплаенсын менежментийн тогтолцоог байгууллага дотор бүрдүүлж, хөгжүүлж, хэрэгжүүлж, үнэлж, тогтвортой хадгалж, сайжруулах зөвлөмжийн шинжтэй. Бүх төрлийн байгууллага дотоод үйл ажиллагаандаа нийцүүлэн, чиглэл болгон ашиглах боломжтой. Хэрэгжүүлэх хүрээ нь байгууллагын хэмжээ, бүтэц, мөн чанар, нарийвчлалаас хамаараад ялгаатай байдаг. Стандартын бүтцэд дараах зүйлс хамрагдсан:

• Комплаенсын менежментийн

¹⁷ Стандарт, хэмжил зүйн газар. *Нийцлийн (комплаенс) менежментийн тогтолцоо*. <https://estandard.gov.mn/standard/vi/6131>

- тогтолцооны хамрах хүрээ, нөхцөлийг ойлгох
- Байгууллагын манлайлал чухал үүрэгтэй болохыг судлан тогтоох
- Комплаенсын хариуцлагын үүслийг ойлгох
- Комплаенсыг эрсдэл шилжүүлэх хэрэгсэл болгон ашиглах
- Комплаенсын зорилтууд тавих
- Сургалтаар дамжуулан комплаенсын мэдлэгийг дээшлүүлж, соёлыг бэхжүүлэх
- Үр дүнтэй харилцаа холбоо, баримтжуулалт хөгжүүлэх
- Менежментээр удирдуулсан хяналтуудыг бий болгосноор комплаенсын менежментийн тогтолцооны байгууллагын өмчлөлийг бий болгох
- Комплаенсын ерөнхий бүтцийн үр дүнг хянах шилдэг арга
- Комплаенсын хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах арга

2021 оны 04-р сарын 13-ны өдрөөс ISO 37301:2021 стандартаар шинэчлэгдсэн байна. Стандартын бүтцийг авч үзвэл:

Удиртгал

1. Хамрах хүрээ
2. Норматив эшлэл
3. Нэр томъёо, тодорхойлолт
4. Байгууллагын агуулга
 - 4.1 Байгууллага, түүний нөхцөл байдлыг ойлгох
 - 4.2 Сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг ойлгох
 - 4.3 Комплаенс менежментийн системийн хамрах хүрээг тодорхойлох
 - 4.4 Комплаенс менежментийн систем
 - 4.5 Комплаенсын үүрэг
 - 4.6. Комплаенсын эрсдлийн үнэлгээ

5 Манлайлал

5.1 Манлайлал ба хэтийн төлөв

5.2 Комплаенсын бодлого

5.3 Үүрэг, хариуцлага, эрх мэдэл

6. Төлөвлөлт

6.1 Эрсдэл, боломжийг

шийдвэрлэх арга хэмжээ

6.2 Комплаенсын зорилт ба

түүнд хүрэх төлөвлөгөө

6.3. Өөрчлөлтийн төлөвлөгөө

7. Дэмжлэг

8. Үйл ажиллагаа

9. Гүйцэтгэлийн үнэлгээ

10. Сайжруулалт

ISO 37301 нь дээд удирдлагыг оролцуулахыг зөвлөж, комплаенсын сайн засаглалын зарчим болгон сурталчилж байна. Түүнчлэн санхүүгийн, эрсдэл, чанар, байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын менежментийн үйл явц, үйл ажиллагааны шаардлага, журамд тусгахын тулд байгууллагын хэмжээнд комплаенсын менежментийг нэгтгэхийг зөвлөдөг. ISO 37301-ийг хэрэгжүүлсний ач тус нь зөрчлийн торгуулийн эрсдлийг бууруулаад зогсохгүй нэр хүнд, итгэл үнэмшлийг дээшлүүлж, үйлчлүүлэгчид болон бусад оролцогч талуудад илүү их итгэл төрүүлж, бизнес эрхлэх боломжийг нэмэгдүүлэх явдал юм. Стандарт нь байгууллагын бусад удирдлагын тогтолцоонд, жишээлбэл удирдамжийг дагаж мөрдөх эсвэл хээл хахуулийн эсрэг ISO 37001, чанарын хувьд ISO 9001 стандартыг дагаж мөрддөг тул үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлдэг.¹⁸

¹⁸ Clare Naden. *New ISO Standard for Compliance Management Makes Everyone a Winner.* (2021.05.03) <https://www.qualitydigest.com/inside/standards-news/new-iso-standard-compliance->

ISO 37301 сертификат нь байгууллага ил тод, найдвартай, холбогдох хууль тогтоомжийн дагуу ажилладаг болохыг баталгаажуулсан баримт юм. Олон улсын зах зээлийг зорьж буй байгууллагуудын хувьд энэ нь өрсөлдөх давуу тал болно. ISO 37301: 2021 стандартын гэрчилгээтэй байгууллагуудад дараах чиглэлээр давуу талтай:

- Комплаенсын соёлыг хөгжүүлэх
- Комплаенсын асуудлыг шийдвэрлэх, даван туулах
- Байгууллагын нэр хүндийг хамгаалах
- Ёс зүйгүй байдлаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх
- Байгууллагын тогтвортой байдлыг сайжруулах
- Үйлчлүүлэгчдийн итгэл, үнэнч байдлыг бий болгох

Дээрх стандарт байгууллагуудад хууль дүрэм дагаж мөрдөхөд чиглэл өгөхөд, цаашлаад байгууллагын зорилгод үр дүнтэй хүрэхэд дэмжлэг үзүүлдэг ач холбогдолтой баримт бичиг байна. Тэгвэл байгууллага уг стандартыг ямар арга барилаар авч хэрэглэх вэ? Байгууллагын хэмжээ томрох тусам зохицуулах үйл ажиллагаа төдий чинээгээр ихсэх тул удирдлага өөрөө хянах, эсвэл хуульчдаа даатгах нь төдийлөн үр дүнтэй байхгүй, гүйцэтгэл формаль л шинжтэй явагдаж өнгөрөх эрсдэлтэй. Учир нь энэ чиглэлээр мэргэшээгүй, ач холбогдлыг нь ухамсарлаагүй, хангалттай цаг зарцуулж чадахгүй байх боломжтой. Тиймээс нийцлийн буюу комплаенсын мэргэжилтэн, цаашлаад хэлтэстэй байх хэрэгтэй юм.

management-makes-everyone-winner-050321.html

Цааш нь комплаенсын ажилтны гүйцэтгэх ажил үүргүүдийг дэлгэрүүлэн авч үзье. Комплаенсын ажилтан нь олон улсад тогтсон ажлын байр бөгөөд дараах чиг үүргээр ажилладаг:

- Байгууллагын гаднах зохицуулалт, хуулиар тавигдсан шаардлагууд, дотоод бодлого, дүрэмд байгууллагын үйл ажиллагааг нийцүүлэн дагаж мөрдүүлэх;
- Зохицуулалтын эрсдлийг олж тогтоох, удирдлага болон ажилтнуудтай хамтран ажиллах;
- Байгууллагад тулгарч буй, тулгарч болзошгүй эрсдлийг зохих ёсоор хэмжиж, удирдан зохицуулах дотоод хяналттай байх;
- Имэйлээр татгалзах шаардлага тавих, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг шалгах гэх мэт гадаад харилцаа холбооны стандарт тогтоон хянах;
- Хууль тогтоомж зөрчих эрсдлийг бууруулах дотоод журмыг боловсруулж, шинэчилж, журмын дотоод аудитыг удирдан зохион байгуулах;
- Компанийн талаар бүрэн мэдлэгтэй байх ёстой бөгөөд хуулийн зөрчил хаана гарч болзошгүйг мэддэг байх;
- Компанийн ёс зүйн үндсэн зарчим, дагаж мөрдөх журмыг үр дүнтэй хүргэх нь чухал;
- Хууль тогтоомжийн гол өөрчлөлт, шинэчлэлийг мэдээлэх зорилгоор ажилтнуудад зориулсан тогтмол сургалт явуулбал тогтмол өөрчлөлт ордог зохицуулалтын орчинд онцгой ач холбогдолтой;

- Зохицуулалт зөрчсөн тохиолдолд зохих сахилгын арга хэмжээг авч ирээдүйд давтагдахаас сэргийлнэ;
- Сайжруулалт хийх боломжтой хэсгийг тодорхойлоход туслах зорилгоор дагаж мөрдөх журмыг байнга хянаж шалгаж байх;
- Компанийн бодлогын талаар бодитой дүгнэлт өгөх;
- Бусад ажилтнууд, удирдлага, гүйцэтгэх ажилтнууд зөрчлийг үл тоомсорлох нь их хэмжээний торгууль, шийтгэлд унагах, санхүүгийн алдагдал хүлээлгэх, бизнес зогсоход хүргэх эрсдэлтэй.¹⁹

Олон Улсын Комплаенсын холбоо комплаенсын албан тушаалтны үүргийг хоёр түвшинд хувааадаг:

- Байгууллагад бүхэлд нь хамаарах гадаад зохицуулалтуудыг дагаж мөрдөх;
- Гаднах зохицуулалтуудыг дагаж мөрдөхийн тулд бий болгосон хяналтын дотоод тогтолцоог дагаж мөрдөх²⁰

Комплаенсын ажилтнууд өдөр тутмын үйл ажиллагаандаа стандарт ашиглахаас гадна комплаенсын нөхцөл байдлын үнэлгээ хийх аргачлалуудын тусламжтайгаар байгууллагынхаа комплаенсын түвшнийг хянах боломжтой. Комплаенсыг үнэлэх хоёр төрлийн аргачлал байдаг. Нэгд, тусгай програм хангамжууд олон байдгаас байгууллагадаа хамгийн тохирохыг

¹⁹ Adam Hayes. *Compliance officer*. (2021.10.28) <https://www.investopedia.com/terms/c/compliance-officer.asp>

²⁰ Robert Walters. *The role of a compliance officer*. <https://www.robertwalters.us/blog/the-role-of-a-compliance-officer.html>

нь сонгон хэрэглэх боломжтой. Харьцуулсан үзүүлэлтүүд бүхий судалгааны эх үүсвэр олдоц сайтай байдаг.²¹ Ихэнх нь төлбөртэй, туршилтын хугацаатайгаараа нийтлэг бөгөөд гагцхүү доторх бүтэц, ажиллагааных нь байгууллагын үйл ажиллагаан дахь нийцэл, авчарх анхаарах юм. Мөн байгууллагын програм дээрээ оруулж болохоор комплаенсын загварууд ч байдаг.²² Хоёрт, програм ашиглалгүйгээр, тодорхой шкалаар байгууллагынхаа комплаенсын нэвтрэлтийг үнэлэх боломжтой. Энд АНУ-ын Hyperproof компанийн хамгийн сүүлийн үеийн бөгөөд өргөн тархаж буй бүтээлийг авч үзье. 2019, 2018 оны туршид анхан шатны судалгаа хийж, сүүлийн 12 сарын хугацаанд АНУ—д суурьтай байгууллагуудын 180 гаруй ажилтнуудтай ярилцан комплаенсын хөтөлбөр, түүнийг тойрсон асуудлуудыг судалсны үр дүнд бүтсэн. Ярилцлагын үр дүнд комплаенсын шаардлагуудыг удирдан зохион байгуулахад хамгийн их тулгардаг асуудал бол нэг ажлаа дахин дахин хийх явдал байжээ.²³ Уг санал асуулгын үр дүнд хамгийн үр дүнтэй үнэлгээний загварыг боловсруулсан нь «Комплаенсын төлөв байдлын түвшин» (Compliance maturity spectrum) байна.²⁴ Уг загвар дагуу байгууллага 1-9 оноогоор

²¹ *Best Compliance Software 2021*. <https://www.captterra.com/compliance-software/>

²² Hyperproof. *Compliance Operations Platform Built to Scale*. <https://hyperproof.io/>

²³ Jingcong Zhao. *Hyperproof Releases CrossWalks to Eliminate Duplicative Work in Meeting Multiple Compliance Framework*. (2020.03.18) <https://hyperproof.io/resource/crosswalks-between-compliance-frameworks/>

²⁴ Hyperproof. *The Compliance Maturity Spectrum*. <https://hyperproof.io/compliance-maturity-spectrum>

үнэлэгдэж, комплаенсын төлөв байдлын 5 түвшний (1. Хамгийн бага, 2. Реактив, 3. Хөгжиж буй, 4. Тасралтгүй дагаж мөрдөж буй, 5. Стратегийн) аль түвшинд нь явааг тодорхойлсноор цаашид ямар чиглэлийн арга хэмжээнүүд авбал илүү үр дүнтэй байх талаар зөвлөмжтэй.

Комплаенсын төлөв байдлын судалгаа

Монгол Улсад комплаенсын төлөв байдал хэр байгааг судалж, цаашдын чиг хандлагыг тодорхойлох нь практик ач холбогдолтой. Комплаенсын төлөв байдлын судалгааг санамсаргүй тохиолдлоор 101 хүнээс боловсруулсан асуулгын хуудсаар авч хариуг SPSS программд шивж боловсруулалт хийлээ. Судалгааны дэлгэрэнгүйг хавсралтаар оруулсан болно.

Судалгаанд хамрагдсан хүнийг насны бүлгээр ангилвал: 10.9 хувь 30 хүртэлх насны, 33.7 хувь 31-40 насны, 35.6 хувь 41-50 насны, 19.8 хувь 51-ээс дээш насны хүмүүс байна. Хүйсийн хувьд авч үзвэл 56 хувь нь эмэгтэй, 45 хувь нь эрэгтэй байна.

Аль салбарт үйл ажиллагаа явуулж байгааг авч үзвэл: хөдөө аж ахуйн салбарт 3 хувь, уул уурхайн салбарт 5.9 хувь, боловсруулах үйлдвэрт 3 хувь, барилгын салбарт 8.9 хувь, бөөний болон жижиглэнгийн худалдаагаар 15.8, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээнд 5.9 хувь, мэдээлэл холбоонд 7.9 хувь, санхүүгийн үйл ажиллагаанд 6.9 хувь, урлаг, үзвэр, тоглоомд 2 хувь, тээвэр, агуулахад 9.9 хувь, бусад салбарт 30.7 хувь гэсэн дүн гарсан байна.

Комплаенсын талаарх ойлголтыг тандан судалснаар мэдлэгийн түвшин хангалтгүй, хариуцсан ажилтан, нэгж бүрэлдэхүүнгүй, шаардлага гарсан үед буюу хяналт шалгалт хийх үед хуульчаас зөвлөгөө авах, төрийн байгууллагын заавраар тухай бүрт нь зохицуулдаг байна.

Мөн бизнес эрхлэхдээ хууль, стандарт барихгүй байх, эрх баригчдын хууль бус үйл ажиллагаа, бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулахдаа бусдын бүтээсэн мэдлэг, оюуны өмчийг өөрийн мэт ашиглах, сонгуульт ажилд ялахын тулд бусдад бэлэг өгөх, төрийн хяналт тавьдаг байгууллагын албан тушаалтанд бэлэг өгөх, баян байх болон шударга байхын аль нь илүү чухал болох, төрийн албан хаагч үйлчилгээ үзүүлснийхээ төлөө хариу шан харамж хүсэх, бизнес эрхлэх явцдаа хууль зөрчсөн хүнийг хэн байхаас үл хамааран хуулийн байгууллагад мэдэгдэх эсэх, урт дараалалд хүлээж байснаас урдуур нь дайрч үйлчилгээ хурдан авах, цагдаа байхгүй тохиолдолд хууль, дүрэм сахихыг хичээхгүй байх, байгууллагын ямар ч ажилтан хууль журам зөрчсөн холбогдох мэдэгдэх эсэх, гэр бүлийн гишүүд төрийн албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баяжих нь зөв эсэх, компанийн ашиг болон хууль журамд нийцүүлэн ажиллахын аль нь чухал болох дээр санал асууж тухайн бизнес эрхлэгчдийн ёс зүй, шүгэл үлээгчид хандах хандлага, ашиг сонирхлын зөрчлийн ойлголтыг тандсан байх бөгөөд үүн дээр ёс зүйгүй үйлдлийг дэмжихгүй

байх хариу их байх боловч ашиг сонирхлын зөрчилтэй асуулт дээр эргэлзсэн хариу нь давамгайлсан гарч ирж байгаа нь илэрхий байна.

Дүгнэлт

МУ-д дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамтай, уг журмын дагуу байгууллага бүр дотоод хяналт шалгалтын журамтай байх шаардлагатай, байхгүй байгууллагыг торгоно, дотоод хяналт шалгалтаараа зөрчлүүдээ илрүүлж арилгаагүй бол мөн торгоно. Үүнээс сэргийлж комплаенсын ажилтантай болж, уг ажилтан нь хууль, бизнесийн удирдлагын мэдлэгтэй байж, эрх зүйн зохицуулалтуудад орсон өөрчлөлтүүдийг даруй мэдэж авч, байгууллагадаа түгээж, зорилгод нь хэрхэн нөлөөлж байгааг эргэцүүлж, удирдлага, бусад ажилтнуудын хамтаар цаашдын замналаа тодорхойлдог байх шаардлагатай. Комплаенсын ажилтны үйл ажиллагаанд нийцлийн стандарт дэмжлэг үзүүлэх тул үйл ажиллагаандаа авч хэрэглэх хэрэгтэй. Үүнээс гадна нийцлээ тогтмол бүртгэж, хянахад төлөв байдлын үнэлгээний шкал, загвар, програмууд ашигласнаар илүү үр дүнтэй байна. Бизнес эрхлэгчдийн дунд комплаенсын төлөв байдлын судалгаа хийхэд комплаенсын талаарх ойлголтыг тандан судалснаар мэдлэгийн түвшин хангалтгүй, хариуцсан ажилтан, нэгж бүрэлдэхүүнгүй, шаардлага гарсан үед буюу хяналт шалгалт хийх үед хуульчаас зөвлөгөө авах, төрийн байгууллагын заавраар тухай бүрт нь зохицуулдаг байх

учраас ёс зүйн сургалт хөтөлбөрүүд явуулж, комплаенс ба ёс зүйн хоорондын харилцаа хамаарал, компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлдгийг тайлбарлан таниулах ажил шаардлагатай байгааг харуулж байхаас гадна эрх зүйн хэм хэмжээнүүдийн үнэлэмж сайн биш байж, тэдгээрийг дагаж мөрдөхгүй байгаа бизнес эрхлэгчийг өмөөрөх хандлага илэрч байгаа нь бизнес эрхлэх эрх зүйн орчинд дүгнэлт хийж, сайжруулах шаардлагатай байгааг илтгэж байна.

Санал

- Комплаенсын ажилтны албан тушаалыг гагцхүү банк санхүүгийн гэлтгүй бүх байгууллагуудад түгээмэл болгох хэрэгтэй.
- Комплаенсын ажилтны ач холбогдлыг түгээж, цаашид энэ чиглэлээр мэргэшсэн ажиллах хүчин бэлтгэх хэрэгтэй. Дээрх судалгаанаас хууль, бизнесийн удирдлагын мэдлэгтэй хүмүүс уг албан тушаалд илүү тохирох нь харагдаж байна.
- Цаашлаад комплаенсын ажилтнууд эрх зүйн хэм хэмжээний актуудыг дагаж мөрдөхөд ямар хүндрэл бэрхшээлүүд тулгарч байгаа дээр дуу хоолойгоо нэгтгэн тогтмол төрийн удирдлагуудад нэгдсэн байдлаар хүргүүлж, зохицуулалтуудыг байгууллагуудад ээлтэй болгоход чиглүүлэх боломжтой байна.

Ашигласан эх сурвалж:**Монгол хэл дээрх эх сурвалжууд:**

- Зөрчлийн тухай хууль (2017) <https://legalinfo.mn/mn/detail/12695>
- Засгийн газрын 2011.11.09-ний тогтоол. Дугаар 311. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам. (2011)
- Санхүүгийн зохицуулах хороо. Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын комплаенсын ажилтнуудад зориулсан гарын авлага. (Суурь ойлголт) (2019) <http://www.frc.mn/resource/frc/> Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим. Монгол Улсын Их Сургууль. Монголын бизнесийн орчны судалгаа 2020. УБ., (2020) http://tram-mn.eu/media/tram/content/newsletters/mon/Business_Climate_Survey_Report_2020_MN-min.pdf
- Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, International Labour Organization. Аж ахуй эрхлэлт дэх албан бус хэвшлийг албан хэвшилд шилжүүлэх нь: өнөөгийн байдал, дүгнэлт, сорилт, шинэчлэлийн бодлогын зөвлөмж (чиглэл) УБ., (2015)
- Цагдаагийн Ерөнхий Газар. Статистикийн мэдээ. <https://police.gov.mn/as/article/3>
- Монцамэ мэдээллийн агентлаг. Хувьцаат компаниудын тал хувь нь үүргээ биелүүлжээ. (2021.03.02) <https://www.montsame.mn/mn/read/255424>

- Стандарт, хэмжил зүйн газар. Нийцлийн (комплаенс) менежментийн тогтолцоо. <https://estandard.gov.mn/standard/v/6131>
- Монголбанк. Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал. Товхимол-6. (2011) <https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group6/6-01.pdf>
- Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага. Монгол Улсын бизнесийн орчны суурь судалгаа эцсийн тайлан. (2018) <https://openjicareport.ica.go.jp/pdf/12321667.pdf>
- Азийн сан. Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгаа. (2018) <http://khamtdaa.mn/media/khamtdaa/content/>

Гадаад хэл дээрх эх сурвалжууд:

- Clare Naden. New ISO Standard for Compliance Management Makes Everyone a Winner. (2021.05.03)
- Adam Hayes. Compliance officer. (2021.10.28)
- Robert Walters. The role of a compliance officer. <https://www.robertwalters.us/blog/the-role-of-a-compliance-officer.html>
- International Compliance Association. What is Compliance? <https://www.int-comp.org/careers/your-career-in-compliance/career-in-compliance/>
- Hirokiyo Furuta. Origins and History of Compliance. (2016.09.30) <http://global.chuo-u.ac.jp/english/features/2016/09/8536/>
- Richard M. Steinberg. Governance, Risk Management, and

Compliance: It Can't Happen to Us-Avoiding Corporate Disaster, While Driving Success. (2011)

- Michael G. Silverman. Compliance Management for Public, Private, or Nonprofit Organizations. (2008) p.57
- Tom C. W. Lin. Compliance, Technology, and Modern Finance (2017.04.21) https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=2904664
- Silveira, P., Rodriguez, C., Birukou, A., Casati, F., Daniel, F., D'Andrea, V., Worledge, C., Zouhair, T. Aiding Compliance Governance in Service-Based Business Processes, IGI Global, (2012) pp. 524–548
- Hyperproof. The Compliance Maturity Spectrum. <https://hyperproof.io/compliance-maturity-spectrum>
- Best Compliance Software 2021. <https://www.capterra.com/compliance-software/>
- Hyperproof. Compliance Operations Platform Built to Scale. <https://hyperproof.io/>
- Jingcong Zhao. Hyperproof Releases CrossWalks to Eliminate Duplicative Work in Meeting Multiple Compliance Framework. (2020.03.18)

ЭРХ, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛД
IDEAS TO REFINE DISPOSITIVE RIGHTS AND ITS REGULATIONS



Хууль зүйн магистр (LL.M)
 С.Номынбаясгалан

I. Оршил

II. Үндсэн асуудал

А. Диспозитив эрхийг хязгаарлах тусгай үндэслэл

Б. Диспозитив эрхийн гажуудал

В. "Reformatio in peius" буюу гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх асуудал

III. Дүгнэлт

Товч агуулга: Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 11 дүгээр зүйлд "Цэцийн шийдвэр нь Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль болон энэ хуулийн холбогдох заалтын үг үсэг, утга санаанд бүрэн нийцсэн нөхцөлд хууль ёсны болно. Цэц болон Цэцийн гишүүн Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн заалттай харшлаагүй бусад хуулийн заалтыг удирдлага болгож болно" гэж хуульчилсан байна. Энэхүү нийтлэлийн сэдвийг "Диспозитив эрх, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй бологох асуудал" гэж томъёолон, агуулгыг **онцгой эрхийн асуудлаар хязгаарлав.**

Түлхүүр үгс: Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, Үндсэн хуулийн маргаан, үндсэн хууль, нийтийн ашиг сонирхол.

Abstract: The article is named as the "ideas to refine Dispositive rights and its regulation" and its content is conducted within legal issues on the exclusive rights. The Law on Constitutional court procedure says that "A decision of the Tsets shall be accepted as lawful when it is fully compliant with the letter and spirit of the relevant provision of the Constitution, the Law on Constitutional Tsets, and this Law. The Tsets, and a member of the Tsets, may use as guidance provisions of other laws compliant with the provisions of the Constitution, and the Law on the Constitutional Tsets".

Key words: Constitutional procedure, constitutional case, constitution, public interests.

I. Оршил

Аливаа шүүхэд хандахаас гадна хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийн шаардлагын үндэслэл, зүйлийг өөрчлөх, хэмжээг ихэсгэх, багасгах болон шаардлагаас бүхэлд нь буюу зарим хэсгээс нь татгалзах, эвлэрэх эрх диспозитив зарчмын агуулгад багтдаг суурь асуудал юм. Энэхүү нийтлэлийн хүрээнд диспозитив зарчмыг чухамхүү "диспозитив эрх"¹ буюу

¹ Монгол Улсын Их Хурлаас 1997 оны 05 дугаар

онцгой эрхийн утгаар нь илүүтэй хөндөхийг оролдоо. Тиймээс энэхүү нийтлэлд **диспозицийн зарчим**,² **диспозитив байдлын зарчим**,³ **диспозитив зарчим**⁴ гэж нэрлэхийн оронд ***диспозитив эрх** гэсэн нэр томъёог ашиглав. Учир нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад **"дагнасан"**⁵ болон **"төрөлжсөн"**⁶ шүүх онцгой үүрэгтэй.⁷ Тиймээс дагнасан шүүх байна уу эсвэл төрөлжсөн шүүх байна уу гэдгээс үл хамааран эдгээр шүүхийн шийдвэрийн гол учир холбогдол **"ultra petita"**⁸ буюу

сарын 01-ний өдөр баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйл (Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг) –ийн 4 дэх хэсэгт "Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан тал хянаж байгаа асуудлын хүрээнд Цэцийн хуралдаан зөвлөлдөхөөр зөвшөөрөхөөс өмнө аль ч шатанд өөрийн шаардлагын үндэслэл, зүйлийг өөрчлөх, хэмжээг ихэсгэх, багасгах болон шаардлагаас бүхэлд нь буюу зарим хэсгээс нь татгалзах эрхтэй" гэж заасан байдаг. <https://legalinfo.mn/mn/detail/19> (Сүүлд үзсэн огноо: 2021.11.14)

² Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (Өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл) Уб., 2007, 374 дэх тал, Сарантуяа Ц. "Монгол Улс дахь Үндсэн хуулийн процессын эрх зүйн үүсэл, төлөвшил, тулгамдсан асуудал" (Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл) Уб., 2008, 129 дэх тал

³ "Процессын эрх зүй онол, туршлага" (Хамтын бүтээл) Уб., 2014, 181 дэх тал, "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар" (Хамтын бүтээл) Уб., 2008, 37–38 дахь тал

⁴ "Үндсэн хууль ба эрх зүйт ёс" (Илтгэлийн эмхэтгэл) VIII, Уб., 2017, 26–47 дахь тал

⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлд "Шүүхийг . . . захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно" гэж заасан.

⁶ Амарсанаа Ж., "Үндсэн хуулийн цэц ба захиргааны хэргийн шүүх", Хууль дээдлэх ёс сэтгүүл, Уб., 2005, №03(38)

⁷ Стратегийн өмгөөлөл: Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нь (Гарын авлага) Уб., 2006, 38–39 дэх тал

⁸ Мөнхсайхан О., "Монгол Улсын Үндсэн хуулиар

өргөдлөөс цааш яв гэсэн зарчим, түүнчлэн **"reformatio in peius"** буюу гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх гэсэн зарчимд тус тус оршдог учраас энэ нийтлэлийн цөм ч гэсэн дээрх байдлаас хөндийрөхгүй учиргүй юм. Тиймээс диспозитив зарчмыг: **нэг талаас, шүүх аливаа хэрэг маргааныг нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд шийдвэрлэх бөгөөд нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзах, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, талууд эвлэрэх эрхтэй төдийгүй эдгээрийн алиныг нь ч сонгож баримтлах боломжтой байхыг**,⁹ **нөгөө талаас, Үндсэн**

сонгуулийн холимог тогтолцоог хориглоогүй" Эрх зүй сэтгүүл Уб., 2016, №02(34), 15 дахь тал

⁹ Бусад (иргэн, захиргаа) процессын бүтээлүүдэд: Шүүх тухайн хэрэг маргааныг шийдвэрлэхдээ талуудын тавьсан нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд шийдвэрээ гаргана. Талууд нь нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх эрхтэй. Эдгээрийн алиныг ч сонгож баримтлах боломжтой байхыг **диспозитив зарчим** гэнэ. Энэ нь шүүхээс хэрэг маргааныг зөвхөн (1) талуудын гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр үүсгэж; (2) нэхэмжлэлийн хүрээнд шийдвэрлэх; (3) нэхэмжлэгч процессын аль ч үе шатанд нэхэмжлэлээсээ татгалзах эрхтэй гэсэн утга агуулгыг илэрхийлдэг. Зарим бүтээлд нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх, дуусгавар болгох бүрэн эрхийн зарчим гэсэн агуулгаар тайлбарлажээ. Тэгвэл диспозитив зарчим нь нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлээсээ татгалзах, эвлэрэх зэрэг хэргийн оролцогчийн эрхийн тухай юм. Энэ үндсэн дээр захиргааны процессын хуулийн дагуу энэ зарчим хэрэгждэг. Учир нь энэ ажиллагааны зарчим шүүхээс хэргийг хянан шийдвэрлэх явцад дагаж мөрдөх, удирдлага болговол зохих үзэл баримтлал болон хуулиар тогтоосон хэм хэмжээг хэлдэг. Харин Иргэний хэрэг үүсгэх, дуусгавар болгохтой холбогдсон бүх үйл ажиллагаа нь сонирхогч этгээдийн хүсэл зоригоос хамаарч байдаг явдал нь диспозитив зарчмын гол агуулга юм. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч хэзээ, хэнээс, юу шаардахыг өөрөө шийдвэрлэхийг хэлнэ. Иргэний хэрэг

хуулийн цэцэд шийдвэрлэж буй маргаан нь тодорхой нэг хүний биш, харин нийтийн ашиг сонирхлыг хөндөж байдаг учраас хандагч этгээд өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг буцаан авсан тохиолдолд

шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчид хуулиар олгогдсон материаллаг болон процессын эрхээ эдлэх боломжийг энэ зарчим олгодог. Тиймээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны гол хөдөлгөгч хүч нь уг ажиллагаанд оролцож байгаа этгээдийн санаачлага бөгөөд иргэний хэрэг үүсгэх нэг үндэслэл нь нэхэмжлэл юм. Учир нь нэхэмжлэлд нэхэмжлэгчийн эрх ашгаа шүүхээр сэргээлэх, хамгаалуулах хүсэл сонирхол тусгагддаг. Тиймээс нэхэмжлэл бүр нэхэмжлэгчийн эрх ашиг, зорилгыг агуулдаг. Тэрхүү зорилго нь нэхэмжлэлийн зүйл болон үндэслэл, нэхэмжлэлийн шаардлагаас хамааран Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны агуулга, хэлбэрт нөлөөлдөг. Энэ нь уг ажиллагааны явцад нэхэмжлэлийн зүйл, шаардлагыг өөрчлөх, багасгах, ихэсгэх, буцаан авах эрхээр илэрдэг. Тиймээс нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөх явдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа дахь диспозитив зарчмын илрэл гэж үздэг. Чимид Б., "Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн" (Гарын авлага) УБ., 2004, 91 дэх тал, "Захиргааны хэрэг, маргаан хянан шийдвэрлэх зарчим" (Гарын авлага) цуврал №4, УБ., 2005, 33 дахь тал, Эрдэнэцогт А., "Захиргааны процессын эрх зүй" (Гарын авлага) УБ., 2013, 18 дахь тал, "Процессын эрх зүй: онол, туршлага" (Хамтын бүтээл) УБ., 2014, 97 дахь тал, "Гадаад орнуудын захиргааны хэргийн шүүх" (Гарын авлага) цуврал №6, УБ., 2005, 13 дахь тал, "Захиргааны хэрэг, маргаан хянан шийдвэрлэх зарчим" (Гарын авлага) цуврал №4, УБ., 2005, 36 дахь тал, "Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль" (Хялбаршуулсан зурагт тайлбар) УБ., 2004, 162 дахь тал, "Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар" (Хамтын бүтээл) УБ., 2012, 60 дахь тал, "Эрх зүй сэтгүүл" УБ., 2002, №8–9, 111 дэх тал, "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар" (Хамтын бүтээл) УБ., 2007, 92 дахь тал, "Монгол Улсын төр, эрх зүйн үндэс" (Хамтын бүтээл) УБ., 2000, 343 дахь тал, Мөнхжаргал Т., "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй" Ерөнхий анги, УБ., 1999, 2004, 2008, 2011, 32, 38, 34, 43 дахь тал, Мөнхжаргал З., "Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй" (Ерөнхий анги) УБ., 2009, 105 дахь тал, "Процессын эрх зүйн толь" (Анхны хэвлэл) УБ., 2014, 97 болон 102 дахь талуудаас үзнэ үү.

ч маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулж шийдвэр гаргах боломж бөгөөд энэ ажиллагаа хандагч этгээдийн хүсэл зоригоос үл хамаарна. Тиймээс Үндсэн хуулийн шүүхэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа өргөдлийн шаардлагаас шууд хамааралтай биш¹⁰ гэсэн байдлаар агуулгын хүрээнд тодорхойлсон байдаг.¹¹

Түүнчлэн уг зарчмын агуулга, мөн чанар нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангахаас гадна "нийтийн ашиг сонирхол"¹²-ыг хамгаалахад чиглэгддэг онцлогтой. Үүнийг маргааны зүйлээрээ төрөлжсөн Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (цаашид "Үндсэн хуулийн цэц" гэнэ)—ээс үнэн зөв шийдвэр гаргахыг нийтийн эрх ашиг шаарддагтай холбон тайлбарлаж болно.¹³ Ингэснээр шүүх тодорхой

¹⁰ Сарантуяа Ц., Монгол Улс дахь Үндсэн хуулийн процессын эрх зүйн үүсэл, төлөвшил, тулгамдсан асуудал, (Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл) УБ., 2008

¹¹ Номынбаясгалан С., "Диспозитив зарчмын мөн чанар" Хууль дээдлэх ёс сэтгүүл, УБ., 2017, №01 (61), 75–81 дэх тал

¹² "Нийтийн ашиг сонирхол", "Нийтийн эрх ашиг" гэсэн нэр томъёоны утга санаа, агуулгыг тодорхойлоогүй хэдий ч Монгол Улсын Их Хурлын баталсан зарим (Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Нотариатын тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль) хуулиас эдгээр нэр томъёоны агуулгыг үндэслэл бүхий тодорхойлж болохуйц зохицуулсан байдлыг харж болно. Түүнчлэн зарим (Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль) хуульд эрх ашиг гэсэн ойлголтыг эрх, хууль ёсны ашиг сонирхол гэсэн ойлголтоор дүйцүүлж үзжээ. Тиймээс нийтийн эрх ашиг тодорхой чиглэл, үйл ажиллагаа, мэргэжил төдийгүй бусад байдлаар ялгарахуйц онцлог субъектийг өөртөө багтаасан ойлголт боловч нийтийн ашиг сонирхолтой давхцах тохиолдол цөөнгүй.

¹³ Номынбаясгалан С. Үндсэн хуулийн зарим маргааны түүхэн товч (Эмхэтгэл) УБ., 2015

тохиолдолд өргөдөл гаргагчаас бусад хандагч этгээдийн эрхийг хангах, нөгөө талаас энэхүү нийтийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд маргааны нөхцөл байдлыг бодитой, бүрэн дүүрэн бодит үнэний зарчимд нийцүүлэн тодорхойлох онцгой үүргийг хүлээдэг.¹⁴ Энэ нийтлэлээр диспозитив зарчмын агуулгыг мөн чанар, уг сурвалжтай нь холбон тайлбарлах хууль зүйн болон нийгмийн хэрэгцээ шаардлага байгааг тодорхой зарим жишээнд¹⁵ үндэслэн харуулахыг гол зорилгоо болгов.

Эндээс маргааныг дагнасан шүүхийн нэгэн адил маргагч талын гаргасан шаардлагын хүрээнд л Үндсэн

¹⁴ Үндсэн хууль ба эрх зүйт ёс (*Илтгэлийн эмхэтгэл*) VII Үб., 2016, 24 дэх тал

¹⁵ Маргааны гол агуулга нь: Ерөнхийлөгч Х.Б Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга Үндсэн хууль зөрчсөн тухай хүсэлтийг Үндсэн хуулийн цэцэд гаргасан. Шүүхийн тухай хуульд Шүүхийн ерөнхий зөвлөл болон Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгч бус гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал дангаар томилохоор заасан нь эрх мэдэл хуваарилах зарчмыг алдагдуулах нөхцлийг бүрдүүлж байгаа учраас Үндсэн хууль зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргасан. Энэ дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн. Их суудлын хуралдаанд бэлтгэл ажиллагааг хийгдэж байгаа. Энэ асуудлаар хүсэлт гаргасан Ерөнхийлөгч У.Х хүсэлтийнхээ шаардлагаас бүхэлд нь татгалзсан. Уг маргааныг Үндсэн хууль зөрчсөн гээд дүгнэлт гарчихсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн "Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцсэн тухай" 03 дугаар дүгнэлт <https://old.legalinfo.mn/law/details/16311> (Сүүлд үзсэн огноо: 2021.11.14)

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн "Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн Е/04 дүгээр албан бичгээр ирүүлсэн "хүсэлтээс бүхэлд нь татгалзах тухай" хүсэлтийг хүлээн авах тухай" 02 дугаар тогтоол <https://legalinfo.mn/mn/detail/16231026429231> (Сүүлд үзсэн огноо: 2021.11.14)

хуулийн цэц шийдвэрлэх үү гэсэн асуудал үүсдэг. Үүнээс шалтгаалан маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл учирдаг болох нь маргааны зүйлээрээ төрөлжсөн шүүхийн зарим шийдвэрээс ажиглагддаг.¹⁶ Ийнхүү нийтлэлээр тавьсан зорилгод хариулт өгөхийн тулд Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 02 дугаар тогтоолын зарим үндэслэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр маргагч талын диспозитив эрхийг хангах эрх зүйн зарим асуудлыг цухас авч үзэв.

II. Үндсэн асуудал

Үндсэн хуулийн цэцийн практикт маргагч тал болох өргөдөл, мэдээлэл гаргагч нар өөрийн шаардлагын үндэслэл, зүйлийг өөрчлөх, хэмжээг ихэсгэх, багасгах болон шаардлагаас бүхэлд нь буюу зарим хэсгээс татгалзсан, эсвэл маргагч талууд харилцан тохиролцон ойлголцож өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан тал нь шаардлагаасаа сайн дураараа татгалзсан цөөнгүй шийдвэрүүд бий.¹⁷ Энэ талаар Үндсэн хуулийн

¹⁶ МУҮХЦ, Дүгнэлт №03/1998.03.27., ТМ 1998 он №05; МУҮХЦ, Дүгнэлт №02/2005.03.31., ТМ 2005 он №14 дугаарт тус тус нийтлэгдсэн.

¹⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс гаргасан дурдсан эдгээр шийдвэрт маргагч тал диспозитив эрх буюу онцгой эрхээ хэрхэн эдэлсэн тухай тэмдэглэж, шийдвэрлэсэн байна. Үүнд: МУҮХЦ, Дүгнэлт №01/1994.01.07., ТМ 1994 он №02; МУҮХЦ, Дүгнэлт №08/1994.08.29., ТМ 1994 он №10; МУҮХЦ, Дүгнэлт №05/1995.08.02., ТМ 1995 он №10-11; МУҮХЦ, Дүгнэлт №01/2000.02.16., ТМ 2000 он №09; МУҮХЦ, Дүгнэлт №10/1996.12.12., ТМ 1997 он №04; МУҮХЦ, Дүгнэлт №05/1998.05.06., ТМ 1998 он №06; МУҮХЦ, Дүгнэлт №08/1998.10.16., ТМ 1998 он №11; МУҮХЦ, Дүгнэлт №03/2002.06.26., ТМ-д нийтлэгдээгүй; МУҮХЦ, Дүгнэлт №2/06/2005.09.29., ТМ 2005 он №37; МУҮХЦ, Дүгнэлт №04/2014.05.14., ТМ 2014 он №20; МУҮХЦ, Дүгнэлт №07/2016.05.25., ТМ 2016 он

маргаан (2012) хэмээх бүтээлд “Үндсэн хуулийн цэцийн практикт иргэд өргөдөл, мэдээллийн шаардлагаасаа татгалзсанаас шалтгаалан тухайн асуудлаар шийдвэр гаргахгүй байх жишиг тогтжээ” гэсэн ерөнхий дүгнэлтийг хийсэн байдаг.¹⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах бичиг (2018) хэмээх бүтээлд мөн энэ талаар тэмдэглэсэн байна.¹⁹

Гэвч Үндсэн хуулийн цэц “үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих” энэ чиг үүргээ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаагаар хэрэгжүүлэх²⁰ бөгөөд энэ ажиллагаа нь өөрөө Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны цөм, түүний оршин байх зориулалтыг илэрхийлэл болдог.²¹

№22; МУУХЦ, Дүгнэлт №03/1995.03.09., ТМ 1995 он №5-6; МУУХЦ, Тогтоол №01/1994.02.04., ТМ 1994 он №04; МУУХЦ, Дүгнэлт №03/1998.03.27., ТМ 1998 он №05; МУУХЦ, Дүгнэлт №02/02/2005.03.31., ТМ 2005 он №14; МУУХЦ, Дүгнэлт №02/2008.02.20., ТМ 2008 он №11; МУУХЦ, Тогтоол №02/1993.03.13., ТМ 1993 он №02; МУУХЦ, Дүгнэлт №03/1993.05.31., ТМ-д нийтлэгдээгүй; МУУХЦ, Тогтоол №02/1994.11.09., ТМ 1994 он №11; МУУХЦ, Дүгнэлт №01/2003.04.30., ТМ 2003 он №20; МУУХЦ, Дүгнэлт №02/2006.02.22., ТМ 2006 он №11; МУУХЦ, Дүгнэлт №07/2006.06.21., ТМ 2006 он №26; МУУХЦ, Дүгнэлт №04/2007.04.18., ТМ 2007 он №15; МУУХЦ, Дүгнэлт №06/2007.05.23., ТМ 2007 он №21; МУУХЦ, Дүгнэлт №07/2009.11.25., ТМ 2010 он №01; МУУХЦ, Дүгнэлт №02/2010.04.02., ТМ 2010 он №17; МУУХЦ, Дүгнэлт №07/2010.11.17., ТМ 2010 он №45; МУУХЦ, Дүгнэлт №07/2014.12.10., ТМ 2014 он №47; МУУХЦ, Дүгнэлт №01/2016.01.29., ТМ 2016 он №06; МУУХЦ, Дүгнэлт №10/1996.12.12., ТМ 1997 он №04; МУУХЦ, Дүгнэлт №06/2014.10.22., ТМ 2014 он №41 дугаарт тус тус нийтлэгдсэн.

¹⁸ Амарсанаа Ж., Үндсэн хуулийн маргаан (Анхны хэвлэл) УБ., 247 дахь тал

¹⁹ Номынбаясгалан., Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах бичиг, (Эмхэтгэл), УБ., 2018

²⁰ Лүндээжанцан Д., Энхбаатар Ч. “Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй” УБ хот, 2000, 248 дахь тал

²¹ Сарантуяа Ц. “Монгол Улс дахь Үндсэн хуулийн

Энэхүү ажиллагааны зорилт нь үндсэн хуулийг чандлан сахиулахад орших²² учраас энэ ажиллагааны гол амин сүнс хөдөлгөгч хүч нь хувь ашгаас гадна **нийтийн эрх ашиг** гэж тодорхойлж болно. Өөр үгээр хэлбэл, **диспозитив зарчмын онцлог шинж нийтийн эрх ашигт оршино** гэсэн агуулгыг илтгэдэг²³ боловч энэ зарчмыг хязгаарлах зайлшгүй шаардлага нийтийн эрх ашигт орших санааг давхар агуулахыг үгүйсгэх аргагүй юм.

Жишээлбэл, маргагч тал (өргөдөл, мэдээлэл гаргагч, хүсэлт гаргагч нар) **өөрийн шаардлагын үндэслэл, зүйлийг өөрчлөх, хэмжээг ихэсгэх, багасгах, эсхүл шаардлагаас бүхэлд нь буюу зарим хэсгээс нь татгалзах** онцгой эрхтэй²⁴ боловч алийг нь хуралдааны бэлтгэл шатанд эсвэл хуралдаан завсарлах өмнө хүртэл эдлэхийг Үндсэн

процессын эрх зүйн үүсэл, төлөвшил, тулгамдсан асуудал” (Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл) УБ хот, 2008, 62 дахь тал

²² Нарангэрэл С. “Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо” УБ хот, 2001, 139 дэх тал, Сэнгэдорж.Т “Монгол Улсын төр, эрх зүйн үндэс” УБ хот, 2000, 324 дэх тал

²³ Номынбаясгалан С. “Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд диспозитив зарчмыг хязгаарлах нь” Үндсэн хууль ба эрх зүйт ёс VIII, УБ хот, 2017, 27 дахь тал

²⁴ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан тал хянаж байгаа асуудлын хүрээнд Цэцийн хуралдаан зөвлөлдөхөөр завсарлахаас өмнө аль ч шатанд өөрийн шаардлагын үндэслэл, зүйлийг өөрчлөх, хэмжээг ихэсгэх, багасгах болон шаардлагаас бүхэлд нь буюу зарим хэсгээс нь татгалзах эрхтэй” гэж, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтад “маргагч талууд харилцан ойлголцож өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан тал нь шаардлагаасаа сайн дураараа татгалзвал маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг татгалзах тогтоол гаргах” гэж тус тус зохицуулсан байна. <https://legalinfo.mn/mn/detail/19> (Сүүлд үзсэн огноо: 2021.11.14)

хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нарийвчлан зааглаагүй. Харин Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь хэрэг үүсгэснээс хойш нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзахыг хориглох тухай онцлог зохицуулалт үйлчилж байна.²⁵ Энэхүү зохицуулалтад үндэслэн диспозитив эрхийг хязгаарлах үндэслэлийг Үндсэн хуулийн цэцийн практикт тодорхой маргааныг хянан шийдвэрлэх явцад гаргасан байна. Хэдий тийм боловч зарим тохиолдолд диспозитив эрхийн гажуудлаас үүдэлтэй маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгодог цөөнгүй жишээнүүд байна. Эдгээрийн шийдвэрийн заримыг танилцуулъя.

А. Диспозитив эрхийг хязгаарлах тусгай үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 04 дүгээр дүгнэлтийн үндэслэлд "1.Иргэн Б.С 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Хөвсгөл аймгийн Засаг даргаар Л.Г-ыг хуулийн шаардлага хангаагүй байхад томилсон гэсэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлсөн агуулгатай мэдээллийг Үндсэн хуулийн цэцэд хандан гаргасан болно. Үндсэн хуулийн цэцэд уг мэдээллийн дагуу маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа

үүсгэн шалгаад 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Дунд суудлын хуралдааныг зарлан хуралдуулахад Б.С нь уг хуралдаанд заавал биечлэн оролцох хүсэлт гарган хойшлуулсан болно. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг дахин 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр зарлан хуралдуулахад иргэн Б.С Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээллээсээ бүхэлд нь татгалзах хүсэлт гаргаад, татгалзсан шалтгаанаа Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирж тайлбарлах байсан боловч уг хуралдаанд хүрэлцэн ирээгүй болно. Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Цэц Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн заалттай харшлаагүй бусад хуулийн заалтыг удирдлага болгож болно." гэж заасныг үндэслэн 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас баталсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт "Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь хэрэг үүсгэснээс хойш нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзахыг хориглоно." гэсэн заалтыг Цэцийн дунд суудлын хуралдаан хэрэглэж болно гэж үзэн хуралдааныг үргэлжлүүлэн явуулахаар шийдвэрлэсэн болно. 2.Иргэн Л.Г нь 2009–2013 оны хооронд Аймгийн Засаг даргын орон нутгийн бодлого хариуцсан зөвлөхөөр ажилласан гэх хугацааг төрийн албанд ажилласан

²⁵ Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр баталсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт <https://legalinfo.mn/mn/detail/11703> (Сүүлд үзсэн огноо: 2021.11.14)

хугацаанд оруулаагүй буюу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.2 дахь заалтад заасан "төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан" байх гэсэн шаардлагыг хангаагүй болох нь Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 506 дугаар шийдвэрээр тогтоогдсон байна. 3. Монгол Улсын Их Хурлаас 1995 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлд "Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө" гэж заасан байх ба дээрх зүйлд заасан 1994 оны Төрийн албаны тухай хууль нь 2002 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн Төрийн албаны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиар хүчингүй болсон байна. Л.Г-ын 2013–2016 онуудад Хөвсгөл аймгийн Монгол Ардын Намын хорооны даргаар ажиллаж байсан хугацааг 1995 оны Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийг баримтлан төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцох хууль зүйн үндэслэлгүй болно. 4. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.2 дахь заалтад заасан Засаг даргад нэр дэвшигч нь төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх гэсэн хуулийн шаардлага хангаагүй

хүнийг Засаг даргаар томилсон Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ардчилсан ёс, шударга ёс . . . хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж заасныг зөрчсөн гэх үндэслэлтэй байна. Харин Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна." гэснийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна" гээд "Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Э-ын 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн "Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай" 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ардчилсан ёс, шударга ёс . . . хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэж заасныг зөрчсөн байна" гэж дүгнэн түдгэлзүүлсэн байна.²⁶

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 02 дугаар тогтоолын үндэслэлд "1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэдэг бөгөөд

²⁶ <https://legalinfo.mn/detail/13289> (Сүүлд үзсэн огноо: 2021.11.14)

холбогдох хуулийн зохицуулалтыг удирдлага болгон Дунд суудлын хуралдаанаар энэхүү маргааныг хянан шийдвэрлэсэн нь үндэслэлтэй байна. 2.Ерөнхий сайд аймгийн Засаг даргыг томилох харилцааг Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлээр зохицуулж, эрх зүйн үндсийг тогтоожээ. Үндсэн хуульд заасан уг бүрэн эрхээ хэрэгжүүлэхээр гаргасан Ерөнхий сайдын шийдвэрт холбогдох маргааныг Үндсэн хуулийн цэц хэлэлцэн шийдвэрлэж дүгнэлт гаргах бүрэн эрхтэй. 3.Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 1995 оны хуулийг батлан гаргасан зорилго, тухайн хуулиар зохицуулах харилцааны мөн чанараас үзэхэд 1994 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөхөөс өмнөх буюу шилжилтийн үеийн цаг хугацаанд хамаарах харилцааг зохицуулахад хэрэглэхээр байна. Түүнчлэн, 1994 оны Төрийн албаны тухай хууль батлагдахаас өмнө холбогдох албан тушаал эрхэлж байсан иргэдийн эрх зүйн байдлыг тодорхойлох, түүнийг дордуулахгүй байх зорилгоор Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 1995 оны хууль нь эдүгээ хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэж үзэхээр байна. Иймд Л.Г-ын 2013–2016 онд Хөвсгөл аймгийн Монгол Ардын Намын хорооны даргаар ажилласан хугацаа нь дээрх хуулийн үйлчлэлд хамаарахааргүй байх тул энэ хуулийг баримтлан төрийн албанд ажилласан хугацаанд тооцох хууль

зүйн үндэслэлгүй байна. 4.Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар захирамжийн 1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 04 дүгээр дүгнэлт үндэслэлтэй байна. 5.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "... Улсын Их Хурал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэл зөв болох нь нотлогдвол өмнөх дүгнэлтээ хүчингүй болгох, хэрэв үндэслэл нь батлагдахгүй бол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгож тогтоол гаргана." гэж заажээ. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 25 дугаар тогтоолд Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа үндэслэлээ заагаагүй байна" гээд "Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн "Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай" 12 дугаар захирамжийн 1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс . . . хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтад нийцээгүй байх тул хүчингүй болгосугай" гэж эцэслэн шийдвэрлэсэн байна.²⁷

Монгол Улсын иргэн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын үүднээс Үндсэн хуулийн цэцэд хандахын сацуугаар нийтийн ашиг

²⁷ <https://legalinfo.mn/mn/detail/13461> (Сүүлд үзсэн огноо: 2021.11.14)

сонирхол хөндөгдсөн асуудлаар ханддаг. Мөн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн ч тухайн зөрчилтэй гэх хууль болон бусад шийдвэр нь гол төлөв нийтэд хамааралтай үйлчилдэг буюу нийтийн ашиг сонирхлыг хөнддөг. Ийм ч учраас Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагц хүчин төгөлдөр болж бүх нийтэд үйлчилдэг. Үндсэн хуулийн цэц үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүргээ маргаан хянан шийдвэрлэх ажиллагаагаар хэрэгжүүлэх бөгөөд уг ажиллагааны зорилт нь үндсэн хуулийг чандлан сахиулахад орших учраас өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн шаардлагыг багасгасан, түүнээс татгалзсан ч уг зорилго биелэгдэж, Үндсэн хуулийн зөрчил арилж, нийтийн ашиг сонирхол хамгаалагдаж байх учиртай. Энэ байдлыг харгалзан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт *"Цэц Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн заалттай харшлаагүй бусад хуулийн заалтыг удирдлага болгож болно"* гэж заасныг үндэслэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт *"Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь хэрэг үүсгэснээс хойш нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзахыг хориглоно"* гэсэн заалтыг Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд хэрэглэн хуралдааныг иргэн гаргасан мэдээллийн шаардлагаасаа бүхэлд нь татгалзсан ч маргааныг

цааш үргэлжлүүлэн явуулахаар шийдвэрлэсэн онцлог шийдвэр болсон байна.

Ийнхүү Үндсэн хуулийн цэц үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүргээ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаагаар хэрэгжүүлдэг.²⁸ Энэ нь *үндсэн хуулийг маргаан шийдвэрлэх хэмжүүр болгон түүний шууд үйлчлэлийг хангадаг* гэсэн үг юм.²⁹ Тиймээс маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа нь өөрөө Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны цөм, түүний оршин байх зориулалтыг илэрхийлэл болдог.³⁰ Энэхүү ажиллагааны зорилт нь үндсэн хуулийг чандлан сахиулахад орших³¹ учраас энэ ажиллагааны гол амин сүнс хөдөлгөгч хүч нь *нийтийн ашиг сонирхол* юм. Энэ утгаараа *диспозитив зарчмын үйлчлэх онцлог* нийтийн эрх ашигт оршино гэсэн агуулгыг илтгэдэг. Ингэхлээр Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргаж буй этгээд нь хувийн ашиг сонирхлоос илүү нийтийн ашиг сонирхлыг чухалчлан тухайн маргааныг эцэслэн шийдвэрлүүлэх хандлага, сонирхолтой байдаг нь үүнтэй холбоотой. Энэ нь нийгмийн хэрэгцээ шаардлагад үндэслэгддэг.

²⁸ Лүндээжанцан Д. Энхбаатар Ч. "Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй" УБ хот, 2000, 248 дахь тал

²⁹ Сарантуяа Ц. "Монгол Улс дахь Үндсэн хуулийн процессын эрх зүйн үүсэл, төлөвшил, тулгамдсан асуудал" (Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл) УБ хот, 2008, 43 дахь тал

³⁰ Сарантуяа Ц. "Монгол Улс дахь Үндсэн хуулийн процессын эрх зүйн үүсэл, төлөвшил, тулгамдсан асуудал" (Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл) УБ хот, 2008, 62 дахь тал

³¹ Нарангэрэл С. "Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо" УБ хот, 2001, 139 дэх тал. Сэнгэдорж Т. "Монгол Улсын төр, эрх зүйн үндэс" УБ хот, 2000, 324 дэх тал

Б. Диспозитив эрхийн гажуудал

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 03 дугаар дүгнэлтийн үндэслэлд "1. Монгол Улсын Их Хурал 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийг "Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно." гэж, Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийг "Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно." гэж өөрчлөн найруулж, мөн зүйлийн 6 дахь хэсэгт "Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх,

огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно." гэсэн зохицуулалтыг нэмсэн байна. 2. Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийг мөн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталж, 1 дүгээр зүйлд ". . . Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана." гэж заасан байна. Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоол гарган Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийг баталсан бөгөөд тус хуваарийн 3.1-д "Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:" гээд 3.1.1-д "Шүүхийн ерөнхий зөвлөлийн бие даасан, хараат бус, тогтвортой байдлыг хангах зорилгоор түүний бүрэлдэхүүний тавыг шүүгчид дотроосоо хувь тэнцүүлэн сонгож, бусад таван гишүүнийг бусад институцээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон

шалгаруулж томилох, . . .”, мөн 3.2-т “Шүүгчийн хариуцлагыг сайжруулах талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:” гээд 3.2.3-т “Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг . . . холбогдох институцээс тэнцвэртэйгээр бүрдүүлэх зарчмыг хуульчлах.” гэж тус тус заажээ. Үүнээс үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталж, уг нэмэлт, өөрчлөлтийн гол үзэл баримтлалыг тодорхойлон дээрх хуваарийг гаргахдаа хууль тогтоомжийг боловсруулан батлахад баримтлах чиглэлийг тусгайлан заасан нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн холбогдох зохицуулалтад заавал тусган хуульчлах агуулгыг илэрхийлсэн гэж ойлгогдож байна. 3. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тогтоох зэрэг харилцааг зохицуулах зорилго бүхий Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан байна. Дээрх хуулийн 76 дугаар зүйлийн 76.2 болон 95 дугаар зүйлийн 95.4 дэх хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилохоор зааж,

77 дугаар зүйлийн 77.1–77.11 дэх хэсэг, 95 дугаар зүйлийн 95.5, 95.7 дахь хэсэгт гишүүдийг нэр дэвшүүлж, томилох журмыг тогтоож, тэдгээрийг сонгон шалгаруулж, томилох ажиллагаанд хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах журмыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо энэ хуульд нийцүүлэн батлахаар хуульчилжээ. Үүнээс үзэхэд шүүгчийн хараат бус байх, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилго бүхий Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүгчийн сахилга хариуцлагын асуудлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг тус тус Улсын Их Хурал дангаар томилохоор Монгол Улсын шүүхийн тухай хуульд тусгасан байна. Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтоох нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэгт зааснаар хууль тогтоогчийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах хэдий ч ийнхүү хуульчлахдаа Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын хүрээнд тодорхойлогдсон Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус бусад таван гишүүнийг бусад институцээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох талаарх чиглэлийг баримтлаагүй гэж үзэхээр байна.

Ингэснээр шүүх эрх мэдлийн байгууллагын хараат бус байдал болон Үндсэн хуулиар баталгаажсан төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлж, Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3, 5, 6 дахь хэсгийг зөрчсөн байна. Түүнчлэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн тайлан, мэдээллээс харахад Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн ёс зүйн хорооны гишүүдийн тодорхой хувь нь орон тооны бусаар ажиллаж байжээ. Харин Монгол Улсын Үндсэн хуулиар тодорхойлсон чиг үүргийн хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөл сүүлийн 10 жилийн дунджаар нэг жилд 26 шүүгчийг /зарим жилд 2 шүүгчийг/ санал болгож байсан бол, Шүүхийн ёс зүйн хороо нь сүүлийн 8 жилийн дунджаар нэг жилд 307 гомдлыг хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс үзэхэд хууль тогтоогч Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүний эрх зүйн байдлыг тогтоохдоо дээр дурдсан туршлагыг харгалзан үзэх шаардлагатай байгааг тэмдэглэх нь зүйтэй. 4. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч

томилно.” гэж зааж бүх шатны шүүхийн шүүгчийг томилох бүрэн эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгчид Үндсэн хуулиар олгосон байх бөгөөд мөн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нийцүүлэн зарлиг гаргахаар тогтоосон байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.7 дахь хэсэгт анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд танилцуулснаар, мөн Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүх санал болгосноос хойш Ерөнхийлөгч тус тус 14 хоногийн дотор томилохоор заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байх ба тодорхой хугацаа тогтоосон асуудал нь Үндсэн хуулийн маргааны шинжийг агуулаагүй байна. Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 36 дугаар зүйлийн 36.8, 36.9 дэх хэсэгт анхан, давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нууц санал хураалтаар гурван жилийн хугацаагаар сонгохоор, Ерөнхий шүүгчийг сонгоогүй бол шүүгчээр хамгийн олон жил ажилласан шүүгчийг тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс томилохоор, түүнчлэн мөн зүйлийн 36.10 дахь хэсэгт танхимын тэргүүнийг тухайн шүүхийн зөвлөгөөн

догтроосоо нууц санал хураалтаар, гурван жилийн хугацаагаар сонгохоор зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчөөгүй, Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд халдсан гэж үзэх үндэслэлгүй байна. Түүнчлэн Ерөнхий зөвлөлийн санал болгосон нэр дэвшигчийг шүүгчид тавигдах шаардлага хангаагүй гэх үндэслэлээр Ерөнхийлөгчөөс буцаах, уг буцаасан саналыг Ерөнхий зөвлөл дахин нягталж санал болгох, эсхүл өөр нэр дэвшигчийг санал болгохоор заасан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4, 36.5 дахь хэсэг нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

5. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд тавигдах шаардлагыг хуулиар тогтооно гэж заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь хэсэгт "Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүн нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна." гэж хуульчилсан байна. Дээрх шаардлага нь Монгол

Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцсэн байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 4, 5, Жаран есдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

6. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэгт Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд тавигдах шаардлагыг хуулиар тогтооно гэж заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3 дахь хэсэгт "Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүн нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна." гэж хуульчилжээ. Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг шүүгч болон шүүгч бус /эрх зүйч/ гишүүдээс бүрдүүлэхээр ийнхүү зохицуулсан нь шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагын асуудалд тавих хяналт бодитой бөгөөд харилцан тэнцвэртэй байх нөхцөлийг бүрдүүлсэн байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 6, Жаран есдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

7. Монгол

Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.2 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.3, 30.4 дэх хэсэгт анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүх тус бүр шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан танхимтай байж болох бөгөөд энэхүү асуудлыг тухайн шатны шүүгчдийн зөвлөгөөний саналыг үндэслэн Улсын дээд шүүх шийдвэрлэхээр нийтлэг байдлаар зохицуулжээ. Мөн уг хуулийн 56 дугаар зүйлийн 56.9 дэх хэсгийн зохицуулалтын талаарх хүсэлтийн үндэслэл нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудалд хамаарч байна. Иймд дээр дурдсан асуудлын хүрээнд Үндсэн хуулийн цэцээс дүгнэлт гаргах боломжгүй байна. Харин хууль тогтоогч холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох, Шүүх байгуулах тухай хуулийг шинэчлэн батлахдаа анхаарах нь зүйтэй байна. 8. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.5, 105 дугаар зүйлийн 105.8, 110 дугаар зүйлийн 110.6, 110.7, 112 дугаар зүйлийн 112.8 дахь хэсэгт шүүгчид холбогдох сахилгын хэрэг хянан шийдвэрлэх журам болон оролцогчдын эрх зүйн байдлын талаарх зохицуулалтыг тусгасан байх ба Үндсэн хуулийн холбогдох заалтаар баталгаажсан иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхийг хязгаарлаагүй байна” гээд “**Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсэгт “. . . бусад таван гишүүнийг**

нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно”, 95 дугаар зүйлийн 95.4 дэх хэсэгт “. . . Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно . . .”, 95.5 дахь хэсэгт “. . . Улсын Их Хурал энэ хуулийн 77.1, 77.2, 77.3, 77.4, 77.5, 77.6, 77.7, 77.8, 77.9, 77.10–т заасан журмыг баримтлан Сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулж, томилно” гэж заасан нь; мөн хуулийн 77 дугаар зүйлийн 77.1–77.11 дэх хэсэг, 95 дугаар зүйлийн 95.7 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3, 5, 6 дахь хэсгийг тус тус зөрчсөн байна. . .” гэж дүгнэн түдгэлзүүлсэн байна.³²

Харин Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 02 дугаар тогтоолын үндэслэлд “Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Х.Б–гаас 2021 оны 02 дугаар сарын 09–ний өдрийн Е/11 дүгээр албан бичгээр Үндсэн хуулийн цэцэд хандан Монгол Улсын Шүүхийн тухай хууль бүхэлдээ Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх асуудлаар хүсэлт ирүүлсэн бөгөөд мөн оны 03 дугаар сарын 11–ний өдөр хүсэлтийн шаардлагаа өөрчилсөн. Уг өөрчлөн ирүүлсэн хүсэлтийн дагуу үүсгэсэн маргааныг Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 04 дүгээр сарын 28–ны өдрийн Дунд суудлын

³² <https://old.legalinfo.mn/law/details/16311> (Сүүлд үзсэн огноо: 2021.11.14)

хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2 ахь хэсэгт ". . . бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно", 95 дугаар зүйлийн 95.4 дэх хэсэгт ". . . Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно . . .", 95.5 дахь хэсэгт ". . . Улсын Их Хурал энэ хуулийн 77.1, 77.2, 77.3, 77.4, 77.5, 77.6, 77.8, 77.9, 77.10-т заасан журмыг баримтлан Сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулж, томилно" гэж заасан нь; мөн хуулийн 77 дугаар зүйлийн 77.1–77.11 дэх хэсэг, 95 дугаар зүйлийн 95.7 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3, 5, 6 дахь хэсгийг тус тус зөрчсөн үзэн 2021 оны 03 дугаар дүгнэлтийг гаргаж, хуулийн тухайн заалтуудыг түдгэлзүүлсэн. Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн уг дүгнэлтийг хэлэлцээд хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 41 дүгээр тогтоол гаргасан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт тус тус заасны дагуу уг маргааныг Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар эцэслэн шийдвэрлэхээр тогтоосон бөгөөд хуралдаанд бэлтгэх явцад Монгол Улсын Ерөнхийлөгч У.Х-ээс Монгол

Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн Е/11 дүгээр албан бичгээр гаргасан Монгол Улсын Шүүхийн тухай хууль бүхэлдээ Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн талаарх хүсэлтээс бүхэлд нь татгалзаж байгаа талаар албан бичиг ирүүлсэн" гээд Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5, 15 дугаар зүйлийн 3, 18 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 31, 32 дугаар зүйлд тус тус зааснаар Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналыг удирдлага болгон "1.Монгол Улсын Ерөнхийлөгч У.Х-ээс ирүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн Е/11 дүгээр албан бичгээр гаргасан Монгол Улсын Шүүхийн тухай хууль бүхэлдээ Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн талаарх хүсэлтээс бүхэлд нь татгалзсан хүсэлтийг хүлээн авсугай. 2.Монгол Улсын Ерөнхийлөгч У.Х-ийн Үндсэн хуулийн цэцэд гаргасан хүсэлтээс бүхэлд нь татгалзсан хүсэлтийг хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийг хүчингүй болсонд тооцож, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн "Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 03 дугаар дүгнэлтийн

тухай” 41 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай. 3.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус заасны дагуу Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн дээрх зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд иргэд өргөдөл, мэдээлэл, эрх бүхий албан тушаалтан хүсэлт гаргах нь нээлттэй болохыг дурдсугай” гэж шийдвэрлэсэн байна.³³

Ийнхүү маргалдагч тал буюу хүсэлт гаргасан Монгол Улсын Ерөнхийлөгч хүсэлтээсээ бүхэлд нь татгалзаж болох ч энэхүү татгалзал нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэл болж байгаа нь үндсэн хуульд ёс болон хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэхэд харшилсан төдийгүй цаашлаад Үндсэн хуулийн цэцээс үндсэн хууль зөрчсөн дүгнэлт гаргасан маргааныг дуусгавар болгон өөрт олгогдоогүй эрхийг эдэлж үндсэн хууль зөрчиж байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

В. “Reformatio in perius” буюу гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх асуудал

Аль ч дагнасан шүүхийн давж заалдах, дээд шатны шүүх

³³ <https://legalinfo.mn/mn/detail/16231026429231>

(Сүүлд үзсэн огноо: 2021.11.14)

нь гомдлын хүрээнд хэргийг хянах, гомдол гаргагчийн анхан шатны шүүхээр баталгаажсан эрх зүйн байдлыг дордуулахгүй байх нь чухал асуудал юм. Энэ нь диспозитив эрхийн агуулгад хамаарах үндсэн ойлголт болно. Захиргааны төдийгүй эрүүгийн хэргийн шүүхүүд ч тийм болсон байна. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн практикт “Анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч дээд шатны шүүхэд хандсанаар шүүгдэгчид илүү хүнд ял оноох, эрх зүйн байдлыг дордуулж болохоор зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилгын агуулгад нийцэхгүй байхаас гадна хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхийн шийдвэрийг давж заалдах иргэний үндсэн эрхийг хөндөж, Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна . . . анхан шатны шүүхийн шийдвэрээс шалтгаалж давж заалдах шатны болон хяналтын шатны шүүхийн ажиллагаа эхэлдэг. Өөрөөр хэлбэл, анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч дээд шатны шүүхэд ханддаг бөгөөд гомдол, эсэргүүцлийн үндсэн дээр анхан шатны шүүх болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүснэ. Иймд давж заалдах болон хяналтын шатны шүүхийн үйл ажиллагаа нь анхан шатны шүүхийн шийдвэрийн хүрээнд асуудлыг шүүгдэгчид

ашигтайгаар буюу хэргийн бодит байдлыг тогтоон хүний эрхийг хангаж, анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч дээд шатны шүүхэд гаргасан үндэслэл бүхий гомдлыг шийдвэрлэх ёстой. Гэтэл давж заалдах болон хяналтын шатны шүүх шүүгдэгчид холбогдох эрүүгийн хэргийг гомдлоор хянан хэлэлцэхэд гомдолд дурдаагүй асуудал, тухайлбал ялын асуудлыг хөндөж анхан шатны шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг хүндрүүлэх боломжийг бий болгох зэргээр шүүгдэгч (бусад шүүгдэгч)-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дордуулах хууль зүйн үндэслэлийг бүрдүүлсэн байна” гэж тайлбарласан байна.³⁴

III. Дүгнэлт

1/ Үндсэн хуулийн цэцэд өргөдөл, мэдээлэл гаргасан иргэн өргөдөл, мэдээллийн, хүсэлт гаргасан эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүсэлтийн шаардлагаа багасгасан, түүнээс татгалзсан тохиолдолд, хэрэв маргаж буй асуудал нь нийтийн ашиг сонирхлыг хөндөж байна гэж Цэцийн гишүүн үзвэл, ажиллагааг цааш үргэлжлүүлэх тухай магадлал гаргах боломжтой байхаар цаашид Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд зохицуулах нь зүйтэй байна. Энэ нь мөн Цэцийн хуралдааны үе шатанд нэгэн адил хамаарна.

³⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 01 дугаар дүгнэлтийн үндэслэлээс авах. <https://old.legallinfo.mn/law/details/14145>

Энэ тохиолдолд ч Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаас магадлал гарч ажиллагааг үргэлжлүүлэх боломжтой байхаар хуульд зохицуулах зайлшгүй шаардлагатай байна.

2/ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа маргааны зүйл үгүй болсон эвсэл иргэний гаргасан өргөдөл, мэдээлэл, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан хүсэлтийн шаардлагаас шууд хамааралтай байж болохгүй. Дээр дурдсан үндсэн хуулийн маргаан нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага бий болсныг харуулж байна. Эс тэгвээс өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн шаардлагаас татгалзах нь үндсэн хуулийн зүйл, заалт зөрчигдсөн хэвээр үлдэх хор уршиг дагуулах эрсдэлтэй.

3/ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд “reformatio in peius” буюу гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх зарчим хэрэгжих боломжтой эсэхийг тодруулах хэрэгцээ шаардлага үүсээд байна. Хэрэв хэрэгжих боломжтой гэж үзвэл нийтийн ашиг сонирхлын үүднээс буюу иргэний гаргасан мэдээлэл // эрх бүхий албан тушаалтны гаргасан хүсэлтийн дагуу, мөн түүнчлэн хувийн ашиг сонирхлын үүднээс буюу иргэний гаргасан өргөдлийн дагуу үүссэн маргаан уу гэдгээс үл хамааран нийтлэг байдлаар үйлчлэх боломжтой байна. Цаашлаад нийтийн ашиг сонирхлын үүднээс үүссэн үндсэн хуулийн маргааны

хувьд гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх зарчмыг хязгаарлах эрх зүйн зохицуулалтын хөшүүрэг үгүйлэгдэж байна. Энэ нь Үндсэн хуулийн цэцийн практик (МУУХЦ, Дүгнэлт №03/2021.04.28., МУУХЦ, Тогтоол №02/2021.09.24.)-аас харагдаж байна.

Эцэст нь тэмдэглэхэд, Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 03 дугаар дүгнэлтээр **"маргааны зүйл болох шүүхийн тухай хуулийн холбогдох зарим зүйл, заалтыг үндсэн хууль зөрчсөн"** гэж дүгнэсэн хэрнээ Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 02 дугаар тогтоолоор **"хүсэлт гаргагч хүсэлтээс бүхэлд нь татгалзсан буюу хүсэлтийг хүлээн авсантай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 03 дугаар дүгнэлт, түүнд холбогдох Улсын Их Хурлын 2021 оны 41 дүгээр тогтоолыг хүчингүй болгон маргааны зүйл үгүй болсон гэх үндэслэлээр уг маргааныг эцэслэн шийдвэрлээгүй"** байдлаас улбаалан хууль дээдлэх зарчим зөрчигдөж, цаашлаад үндсэн хуульд нийцээгүй, нийтийн ашиг сонирхолд харшилсан хуулийн зохицуулалт хүчингүй болох бус харин хүчин төгөлдөр хэвээр үлдэж байгааг харуулсан үндэслэл муутай шийдвэр болсон байна.

НОМ ЗҮЙ

I. Эрх зүйн эх сурвалж:

- Монгол Улсын Үндсэн хууль (1992.01.13), Төрийн мэдээлэл (цаашид "ТМ" гэх), №1
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хууль (1992.05.08), ТМ, №3
- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль (1992.05.01), ТМ, 1997, №6
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016.02.04), ТМ, 2016, №9
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэг (Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн 2006 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн зөвлөгөөнөөр хэлэлцэн тогтсоныг үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2006 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 6/06 дугаар тушаалаар батлагдсан, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2012 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 16 дугаар тушаалаар, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 26 дугаар тушаалаар, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2015 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 27 дугаар тушаалаар, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 23 дугаар тушаалаар, Монгол Улсын

Үндсэн хуулийн цэцийн даргын
2020 оны 05 дугаар сарын 05–
ны өдрийн 17 дугаар тушаалаар
нэмэлт, өөрчлөлт оруулсан)

II. Монгол эх сурвалж:

- Амарсанаа Ж., Үндсэн хуулийн маргаан, (Анхны хэвлэл), УБ., 2012
- Сарантуяа Ц., Монгол Улс дахь Үндсэн хуулийн процессын эрх зүйн үүсэл, төлөвшил, тулгамдсан асуудал, (Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл) УБ., 2008
- Номынбаясгалан С., Үндсэн хуулийн маргаан: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах бичиг, (Эмхэтгэл), УБ., 2018

III. Үндсэн хуулийн маргаан

(Кейс):³⁵

- МУУХЦ, Дүгнэлт №03/2021.04.28.
- МУУХЦ, Тогтоол №02/2021.09.24.
- МУУХЦ, Дүгнэлт №01/2019.03.13.

IV. Цахим эх сурвалж:

- <https://legaldata.mn/b/379>

³⁵ Дээрхи товчлолын "МУУХЦ" гэснийг "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц" гэж ойлгоно. Н.С.

УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДЛУУД



Шихихутуг их сургуулийн магистрант М.Бүжинлхам

Хураангуй: Монгол Улсын Их Хурал (УИХ)-аас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (ЖЭТБХТХ)-ийг 2011 онд батлан гаргасан. Манай улсын хувьд олон салбарт жендэрийн тэгш эрхийн харьцаа дутмаг байгаа ч шийдвэр гаргалт буюу улс төрийн хүрээнд энэ тоо баримт хэтэрхий доогуур үзүүлэлттэй байгаа юм. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд сонгох сонгогдох, эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх хүний эрх, эрх чөлөө, тэдгээрт хүйсээр ялгаварлан гадуурхахгүй бах зарчмыг үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулж өгсөн байна. Гэсэн хэдий ч хууль тогтоомжийг хэрэгжүүлэх түвшинд буюу улс төрийн намын удирдах болон хууль тогтоох түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй түвшинд байна. Хэдийгээр манай улсын хувьд улс төрийн намууд хуульд заасны дагуу тодорхой квотын доод хязгаарыг тогтоосон хэдий ч төдийлөн үр дүнгээ өгөхгүй байна. Иймд энэхүү өгүүллээрээ улс төрийн хүрээнд жендэрийн тэгш

байдлыг хангахад манай улсын хэрэгжүүлж буй арга хэмжээ болон бусад улсын хэрэгжүүлж буй арга хэмжээг судлан санал дэвшүүлэхийг зорьсон болно.

Түлхүүр үг: жендэр, улс төрийн хүрээ, тэгш оролцоо, шийдвэр гаргалт, сонгуулийн хувь

Abstract: The Parliament of Mongolia passed the Law on Gender Equality in 2011. In our country, there is a lack of gender equality in many areas, but in the decision-making or political spheres, this figure is too low. The Law on Gender Equality guarantees human rights and freedoms of choice, association, and expression, and the principle of non-discrimination on the basis of gender. However, the level of women's participation in the leadership of the political party and in the legislature is insufficient. In our country, political parties have set minimum quotas in accordance with the law, but they have not been effective. Therefore, this article aims to study and propose measures taken by our country and other countries to ensure gender equality in the political sphere.

Keywords: gender, political framework, equal participation, decision-making, electoral percentage

Өгүүллийн агуулга:

- I. Удиртгал хэсэг
- II. Үндсэн хэсэг
 - II.1. Жендэр, жендэрийн эрх тэгш байдлын талаар онолын ойлголт

- II.2. Улс төрийн харилцаан дахь
жендэрийн тэгш эрхийн
талаар ойлголт:
- II.3. Улс төрийн харилцаан дахь
жендэрийн эрх тэгш байдлын
талаар эрх зүйн зохицуулалт:
- III. Харьцуулсан судалгаа
- III.1. АНУ-ын хувьд улс төрийн
харилцаан дахь жендэрийн
нөхцөл байдал
- III.2. ХБНГУ-ын хувьд улс төрийн
харилцаан дахь жендэрийн
нөхцөл байдал:
- IV. Практик судалгаа
- IV.1. Улс төрийн салбар дахь
жендэрийн тэгш байдлын
талаар нөхцөл байдал (УИХ-
ын сонгууль)
- IV.2. Улс төрийн салбар дахь
жендэрийн тэгш байдлын
талаар нөхцөл байдал (орон
нутгийн сонгууль)
- IV.3. Сонгуулийн төсвийн жендэрийн
тэгш хуваарилалтын нөхцөл
байдал
- V. Дүгнэлт
- VI. Санал дэвшүүлэх нь
- VII. Ашигласан эх сурвалж

I. Удиртгал хэсэг

Олон улсад нийгмийн хөгжлийн чиг хандлага улам бүр хүн төвтэй болж байна. Энэхүү хандлагын салшгүй нэг хэсэг нь нийгмийн амьдралд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш боломжийн асуудал байдаг. Иймээс нийгмийн харилцаан дахь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн ялгаатай байр суурь, үнэлэмж, оролцоо, түүх зэрэг олон асуудлыг судлан шинжлэх, танин мэдэх явдал чухалчлагдаж, улмаар нийгмийн бодлогод жендерийн мэдрэмжит

хандлагыг баримтлахыг чармайх болжээ.

Олон улсад төдийгүй манай оронд ч гэсэн “Жендэр” гэдэг нэр томъёо аль хэдийн танил болсон. Гэвч энгийн иргэд, ард түмний энэ талаарх мэдлэг, тэдэнд очиж байгаа мэдээлэл дутмаг байдгаас жендэрийг зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал гэсэн буруу ташаа ойлголт байсаар ирсэн билээ. Гэхдээ энэ талаар үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон төрийн, төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаач нарын ачаар хүний эрх, жендэрийн тухай ойлголт нь өнөөг хүртэл улам баяжиж хөгжсөөр иржээ.¹

Монгол улс олон улсын олон талт 240 гаруй гэрээнд нэгдэн орсноос хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйтэй холбоотой 50 гаруй, НҮБ-ын Хүний эрхийн суурь найман гэрээний долоог нь соёрхон баталсан байдаг байна. Гэвч нэгдэн орсон конвенц, бодлогын баримт бичгүүдийг сурталчлах, мэдээлэх, авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээ тайлагнах ажиллагаа дутагдалтай байдаг нь ажиглагдлаа.

Манай улсын хувьд шийдвэр гаргалтын түвшинд буюу удирдах албан тушаал, улс төрийн албан тушаалд эмэгтэйчүүдийн оролцоо муу байгааг судалгаанууд болон сонгуулийн дүнгээс бэлхнээ харж болох юм. Үүнээс үзвэл жендэрийн тэгш байдал төдийлөн хангагдахгүй байгаа бөгөөд улс төрийн хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоо дутмаг байгаа бол хөдөлмөрийн эрх зүйн зарим салбарт эрэгтэйчүүдийн

¹ Хүний эрхийн үндэсний комисс. Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 13 дахь илтгэл, 2014, 54 дэх тал

оролцоо ч дутмаг байна. Харин эдгээрээс улс төрийн хүрээнд жендэрийн тэгш байдлын түвшин бусад салбараас нэлээдгүй ялгаатай харагдаж буй бөгөөд улс төрийн хүрээнд эмэгтэйчүүдийн сонгогдож мөн томилогдож буй байдал, эрэгтэйчүүдээс маш бага үзүүлэлттэй байна. Манай улсын хувьд зарим намуудын жендэрийн тэгш байдлыг хангахын тулд квот тогтоож буй нь дэлхийн ихэнх улсын авч буй арга хэмжээтэй тохирч байгаа хэдий ч төлийлөн үр дүнгээ өгөхгүй байна. Иймд энэхүү өгүүллээрээ жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, улс төрийн салбарт жендэрийн тэгш байдлын түвшинг судлахын сацуу манай улстай ижил ром германы эрх зүйн тогтолцоотой улс болон англи саксоны эрх зүйн тогтолцоотой улсад энэ талаар зохицуулалтыг хэрхэн явагддаг талаар судлахыг зорьсон болно.

II. Үндсэн хэсэг

II.1. Жендэрийн тухай ерөнхий ойлголт:

Жендэр гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эдийн засаг, нийгэм, улс төр ба соёлын амьдралын онцлог шинж чанар, боломж бололцоог тодорхойлдог нэр томъёо бөгөөд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн биологийн ялгаа, нийгмийн үүргийг салгаж ойлгох арга зам юм². Жендэрийн тэгш байдал нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хүйсээр үл ялгаварлан, тэгш шударга хандах жендэрийн тэгш эрхийн тухай бус тэдний эрх эдлэх бололцоо, амьдралд хүртэх боломж нь тэгш

² Ж.Занаа. Жендэрийн тэгш эрх ба эрх зүйн байдал, УБ, 2004, 75 дахь тал

байх тухай асуудал юм. Хүн өөрөө байгаль-нийгмийн бүтээгдэхүүн юм. Иймээс судлаачид sex – биологийн хүйс, "Gender" нийгмийн хүйс гэж үздэг байна. "Gender ideology" буюу жендэрийн тухай үзэл баримтлал нь анх эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой гарч ирсэн. 20-р зууны эхэн үеэс эмэгтэйчүүдийн талыг баримталсан үзэл онол болон хөгжиж эхэлсэн бөгөөд энэ талыг баримтлагчдыг феминистүүд гэдэг болжээ. Энэ нь аажимдаа нийгэм соёлын бүхий л талыг хүйсээр задлан үзэх хандлагатай жендэр судлал /gender studies/-т шилжин хөгжсөн байна.³

Мөн жендэрийг хүмүүс дан ганц эмэгтэйчүүдийн тэгш эрхийн асуудал гэж ташаа ойлголт олон нийтийн дунд түгээмэл байдаг. Энэ ойлголтонд эрэгтэйчүүдийн тэгш эрх, тэгш боломж бас давхар яригдах бөгөөд энэ нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс аливаа нийгмийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, нийгмийн баялаг, хөгжлийн үр шимээс тэгш хүртэх, ингэснээр хөгжилд адил тэгш хувь нэмрээ оруулах тухай ойлголт юм.⁴

Монгол улсад Жендэрийн тэгш байдлыг хангах үйл явц Бээжингийн хурлын дараагаас буюу 1996 оноос эхтэй юм. МУ-ын Засгийн газраас "Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах" үндэсний хөтөлбөрийг 11 бүрэлдэхүүн хэсэгтэйгээр боловсруулан баталсан.

Хэдийгээр энэ баримт бичиг нь нийгмийн бүх хүрээг хамарч чадсан ч тодорхой үр дүнд хүрч

³ http://www.setael.org/2010/09/blog-post_7670.html

⁴ Боловсрол соёл шинжлэх ухааны яам, Дээд боловсролд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь, Сургалтын гарын авлага, УБ, 2019, 21 дэх тал

чадаагүй байна. Үүний үндсэн шалтгааныг тухайн үедээ жендэрийн шинжээчид дүгнэхдээ үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүтэц, төсөв санхүүжилтийн эх үүсвэрийг хамтатган батлаагүйгээс болсон гэж тайлбарладаг. Япон улсад жендэрийн тэгш байдлыг хангах төрийн механизмыг боловсронгуй болгож, цар хүрээг нь өргөтгөх зорилгоор 2001 оны 1 дүгээр сард засгийн газрын дэргэд Жендэрийн тэгш байдлын асуудлаарх зөвлөл түүний дор өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах ажлын алба буюу товчоог байгуулсан байна.

Манай улсын хувьд жендэрийн тэгш байдлын хэрэгжилтийг хянах засгийн газрын бие даасан агентлаг гэж байхгүй хэдий ч Ерөнхий сайдын ажлын албаны дэргэдэх Жендэрийн тэгш эрхийн хороо нь яамд, ТББ-уудын хоорондын бодлогыг зохицуулж, тодорхой үйл ажиллагааг явуулдаг. Улсын Их Хуралд Нийгмийн бодлого, боловсрол, шинжлэх ухааны байнгын хороо жендэрийн асуудлыг хариуцдаг.

Мөн жендэрийн тэгш эрх, хүний эрхийн талаар үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд сүүлийн хэдэн жил эрчимтэй өсч байгаа ба энэ чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулах болсон. Жендэрийн үзэл баримтлалыг бодлогод тусгахад юуны өмнө тухайн улс орны үндэсний засгийн газрын оролцоо, дэмжлэг хамгаас чухал хэмээн Бээжингийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тэмдэглэсэн байдаг.

Жендэрийн тэгш байдал нь

эрэгтэй эмэгтэй хүмүүст тэгш боломж олгох ба эрэгтэй эмэгтэй хүмүүс ижил алба хашиж ижил эрх мэдэлтэй байгаа нөхцөлд ижил эрх эдэлж, үүрэг хүлээж, ижил боломжоор хангагдана гэсэн үг юм. Тэгшитгэсэн нийгэмд эрэгтэй эмэгтэй хүмүүс:

- Эдийн засгийн хараат бус байдал болон хөгжих боломжийг олгох
- Ажил хөдөлмөр эрхлэх
- Өрх гэр, гэр бүл, хүүхдийнхээ өмнө хариуцлага хүлээх
- Нэгдэл холбоо, улс төр болон нийгмийн ажилд оролцох

Бэлгийн дарангуйлал, бэлгийн хүчирхийллээс ангид амьдрах зэрэг асуудлаар ижил эрх, үүрэг, боломжоор хангагдана гэсэн үг юм.⁵

II.2. Улс төрийн харилцаан дахь жендэрийн тэгш эрхийн талаар ойлголт:

Эмэгтэйчүүдийн Дэлхий нийтийн 4 дэх бага хурлаас гаргасан тунхагт¹⁴, эмэгтэйчүүдийн эрх мэдэл, нийгмийн бүхий л салбарын харилцаанд эрх тэгш оролцох боломж, тэр дундаа шийдвэр гаргах үйл явц дахь оролцоо, эрх мэдэлд хүрэх боломж зэрэг нь нийгмийн тэгш байдал, хөгжил, энх тайванд хүрэх үндсэн тулгуур байх болно хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг.⁶

⁵ Нэгдсэн Үндэстний байгууллагын дэргэдэх Жендэрийн асуудлаарх ажлын хэсэг, Жендэрийн нэр томъёо, тодорхойлолт, үндсэн ойлголтууд, УБ, 2003, 45 дахь тал

⁶ https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/mn/2015-Gender-Overview-%20Desk-Study-Mongolia_MN.pdf Швейцарийн

Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжсэн "Монгол улс дахь жендэрийн тэгш байдлын талаарх үзэл хандлага: Олон нийтийн тандалтын судалгаа"-ны төсөл, МОНГОЛ УЛС ДАХЬ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ: (Нөхцөл байдлын товч үнэлгээ, Баримт бичгийн судалгаа)

Улс төрийн хүрээн дэх жендэрийн тэгш байдлын баталгаа хангагдахгүй байх нь төрийн албан дахь жендэрийн тэгш байдал алдагдахад хүргэж байна. Төрийн байгууллагын удирдлагын томилгоо улс төрөөс шууд хамааралтай өнөөгийн нөхцөлд төрийн албаны удирдах түвшин дэх жендэрийн квот хангагдах боломжгүйд хүрч байна. Эрэгтэй, эмэгтэй хүний төрийн албанд орох тэгш эрх хууль эрх зүйн хувьд нээлттэй хэдий ч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн төрийн албанд албан тушаал ахих, удирдах албан тушаалд томилогдон ажиллах улс төр, эмэгтэйчүүдийн ажил эрхлэх бололцоо, нийгэмд тогтсон хэвшмэл буруу ойлголт зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж харилцан адилгүй байна.

II.3. Улс төрийн харилцаанд дахь жендэрийн эрх тэгш байдлын талаар эрх зүйн зохицуулалт:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр дүгээр зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна; Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” Хэмээн жендэрийн суурь зарчим болох ялгаварлан гадуурхалтын эсрэг зарчмыг тунхагласан байдаг.

Түүнчлэн тус хуулийн Арванзургадугаар зүйлийн 11 дэх хэсэгт “...улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш

эрхтэй” хэмээн заажээ. Харин уг тэгш эрхийг хангах зарчмыг Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн зааж өгснөөрөө “Жендэрийн эрх тэгш байдлын хангах тухай” (2011) хуулийн эрх зүйн зохицуулалтын үндэс, бусад хөтөлбөрийн суурийг тавьсан гэж ойлгож болох юм.

Дээрх суурь зохицуулалтуудын хүрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг баталсан бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн цогц арга хэмжээгээр хуулийн хэрэгжилтийг хангах, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэгддэг.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулагдсан улс төрийн хүрээний жендэрийн тэгш эрхийн зохицуулалтуудыг авч үзвэл:

- **6 дугаар зүйл. Жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглох**

- 6.1. Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглоно.

- **8 дугаар зүйл. Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын баталгаа**
 - 8.1. Улс төрийн нам, үйлдвэрчний эвлэлийн болон олон нийтийн бусад байгууллагад гишүүнээр эвлэлдэн нэгдэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломжийг хязгаарлах, ялгаварлан гадуурхахыг хориглоно.
 - 8.2. Бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна.
 - 8.3. Улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байна.

Улс төрийн харилцаан дахь жендэрийн тэгш байдлын талаар бусад хууль тогтоомжид:

- **Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль⁷**
 - 30.2. Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.
- **Улс төрийн намын тухай хууль⁸**
 - 5.1.3. гишүүддээ намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, сонгуульд нэр дэвших, сонгогдоход үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгох зарчмыг баримтална.
 - 11.2. Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана.
 - 11.2.8. сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгох, хүйсийн тэгш байдлыг хангах зарчим
- **УИХ-ын болон Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль**
 - 5.1. Сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр сонгох эрхтэй.

Намуудын дотоод дүрэмд жендэрийн тэгш байдлыг хангах талаар тусгасан заалт:

Нам	Жендэрийн квот тусгасан заалт
МАН	1.5.8. намын бүх шатны сонгуульд байгууллагад 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна. Санал хураалтыг энэ шаардлагад нийцүүлэн зохион байгуулна.
АН	6.4.1. Үндэсний бодлогын хорооны гишүүний суудлын тоо 410 байна. Үүнээс 90-ээс доошгүй суудал нь эмэгтэй гишүүдэд ногдоно. (21.9%) ¹

⁷ 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр шинэчилсэн найруулга батлагдсан.

⁸ 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан.

ХҮН	4-р бүлэг: Намын их хурлын төлөөлөгчдийг сонгохдоо 30-аас доошгүй хувь нь эмэгтэй гишүүн байх зарчмыг баримтална.
ИЗНН	20.4 Үндэсний хорооны нийт гишүүдийн 30-аас доошгүй хувийг эмэгтэйчүүдийн төлөөлөл /суудал хадгалах квот/ бүрдүүлнэ. Энэ заалт Улс төрийн зөвлөлийг сонгож бүрдүүлэхэд нэг адил хамаарна.
МҮАН	9.2.10 Сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгохдоо хүйсийн тэгш байдлыг хангах зарчмыг баримтална.
Монголын Ардчилсан Хөдөлгөөний нам	9.2.9 Сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгохдоо хүйсийн тэгш байдлыг хангах зарчмын баримтална.

III. Харьцуулсан судалгаа

Дэлхийн 30 гаруй орон жендэрийн эрх тэгш байдлыг хангах, шийдвэр гаргах төвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор нам нь эмэгтэйчүүдийн квотоо баримталж чадсан бол төсвөөс 10-20 хувийн санхүүжилт олгохоор хуульчилж өгсөн жишээ байгаа бол зарим орны улс төрийн нам нь санхүүжилтийнхээ 25-аас доошгүй хувийг сонгуульд нэр дэвшиж байгаа эмэгтэй нэр дэвшигчдэдээ зарцуулах хууль хэрэгжиж байгаа юм. Мөн Хорватад парламентад сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоогоор тухайн намд төрөөс олгох санхүүжилтийг 10 хувиар нэмдэг бол Гүржид эмэгтэйчүүдийг олноор нэр дэвшүүлсэн намд төсвийн 30 хүртэл хувийн урамшуулал олгодог гэх мэт тодорхой жишээнүүд байна.

Жендэрийн тэгш оролцоо, цөөнхийн төлөөллийг улс төрд хангах зорилгын үүднээс эмэгтэйчүүд, залуучууд, нутгийн уугуул иргэдийг дэмжиж тодорхой хувийг төсвөөс санхүүжүүлдэг туршлага олон улсад бий. Тухайлбал Намуудад очих төсвийн дэмжлэгээс Чили, Өмнөд Солонгост 10%⁹, Финландад 12%-ийг¹⁰ эмэгтэй улс төрчдийг дэмжихэд зарцуулдаг бол Колумбид Парламентад суудалтай намууд нийт төсвийн дэмжлэгийнхээ 5%-ийг эмэгтэйчүүдийн бүлгийг дэмжихэд зориулдаг¹¹. Португал, Ирланд, Франц, Италид эмэгтэйчүүдийн нэр дэвшүүлэх квотоо баримтлахгүй эсвэл тэдний улс төрийн оролцоог хязгаарлах аливаа бодлого хэрэгжүүлбэл төсвийн дэмжлэгийг бууруулах үндэслэл болдог байна.

III.1. АНУ-ын хувьд улс төрийн харилцаан дахь жендэрийн нөхцөл байдал:

АНУ-ын 116-р Конгресст эмэгтэйчүүд танхимын суудлын 23.2%, Сенатын суудлын 26%-ийг эзэлдэг. 2020 онд улсын хэмжээнд сонгогдох албан тушаалын 28.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.¹²

⁹ Political finance. International IDEA. <https://www.idea.int/node/294691>

¹⁰ Political finance. International IDEA. <https://www.idea.int/node/261413>

¹¹ Political finance. International IDEA. <https://www.idea.int/node/272641>

¹² <http://www.inquiriesjournal.com/articles/1811/the-gender-gap-in-american-politics-how-money-in-politics->

Улс төрд эмэгтэйчүүд дутагдаж байгаа нь сэтгэл түгшмээр үр дагавартай бөгөөд манай үндэстний чадавхийг хязгаарлаж байна. Эмэгтэй улс төрчид илүү ардчилсан байдлаар засаглаж, сонгогчдынхоо эрүүл мэндийг сайжруулахад илүү үр дүнтэй, жөндөрт суурилсан саад бэрхшээлийг үл харгалзан асуудлыг мэргэшүүлэх, зөвшилцөхөд илүү амжилттай, дасан зохицох чадвартай болох нь батлагдсан.¹³

Америкийн ерөнхийлөгчдийн 100% нь эрэгтэй хүмүүс байсан бөгөөд 2016 онд томоохон намаас ерөнхийлөгчид эмэгтэй нэр дэвшигчийг анх удаа дэвшүүлсэн. Одоогийн Конгресст эмэгтэйчүүд Танхимын 23.2%, Сенатын 26% байна.¹⁴ 2020 онд мужаас сонгогдсон албан тушаалын 28.9% нь эмэгтэйчүүд байна. Ерөнхий прокурор, Улсынаудиторзэрэгтөрийн томоохон албан тушаал хашиж буй 9 эмэгтэй Засаг дарга, 15 эмэгтэй дэд дарга, 66 эмэгтэй байна. Мужийн хууль тогтоох байгууллагуудын 29.1% нь эмэгтэйчүүд байдаг ба Америкийн томоохон хотуудын 20.8% нь эмэгтэй хотын даргатай. Эдгээр нь Америкийн түүхэн дэх эмэгтэйчүүдийн төлөөллийн хамгийн өндөр түвшний зарим нь боловч эмэгтэйчүүд эрчүүдтэй

affects-female-representation The Gender Gap in American Politics: How Money in Politics Affects Female Representation

¹³ Hansen, C. (2018). 116th Congress by Party, Race, Gender, and Religion. US News and World Report. <https://www.usnews.com/news/politics/slideshows/116th-congress-by-party-race-gender-and-religion>

¹⁴ Overby, Peter. (2018). There's A \$500,000 Gender Gap When It Comes To Campaign Fundraising: NPR. <https://www.npr.org/2018/09/26/651185105/theres-a-500-000-gender-gap-when-it-comes-to-campaign-fundraising>, paragraph 8

эн тэнцүү төлөөлөлтэй болох гэж тэмцсээр байна. Энэ хүрээний ахиц дэвшлийн хурд нь оновчтой биш юм. Конгресс дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 2001-2020 оны хооронд 13.6% -иас 23.7% болж өссөн бол муж даяар сонгогдсон албан тушаалын төлөөлөл мөн хугацаанд ердөө 1.3% өссөн байна.

Дээр дурдсанчлан, Америкт орлого, баялгийн аль алинд нь хүйсийн ялгаа байдаг. Эдгээр ялгаанаас гадна кампанит ажилд хандив өргөсөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тоо, тэдний хандивласан хэмжээ хоёрын хооронд ялгаа бий. Энэ цоорхойг шалгахын тулд хэн, ямар хэрэгслээр хандив өгч байгааг харах нь чухал. 2020 оны Ардчилсан намын үндсэн талбар арван таван нэр дэвшигчээр дүүрэхэд тэдний дөрөв нь л (Марианна Уильямсон, Камала Харрис, Жулиан Кастро, Элизабет Уоррен) хандивын 50 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хандивлагчдаас авсан байна. Энэ тоо баримт нь 2020 оны Ардчилсан намын ихэнх кампанит ажлыг голчлон эрэгтэй хандивлагчдаас санхүүжүүлдэг болохыг харуулж байгаа ч өмнөх ерөнхийлөгчийн сонгуулийн жилүүдийнхээс сайжирсан үзүүлэлт юм.

Судалгаанаас харахад ихэнх уралдаанд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд ижил төстэй кампанит ажлын санхүүжилт цуглуулдаг. Гэсэн хэдий ч зарим төрлийн уралдаанд эмэгтэйчүүд кампанит ажилд бага хэмжээний хандив авдаг. Уламжлал ёсоор, өрсөлдөөнт өрсөлдөөнд

оролцож буй ноцтой нэр дэвшигчид өрсөлдөх чадвар багатай өрсөлдөж буй нэр дэвшигчдээс илүү их мөнгө авчирдаг. 2018 онд Холбооны Сонгуулийн Хорооны (FEC) хандивлагчдын тоо баримтаас харахад танхимд суудлын төлөө өрсөлдөж буй ардчилсан намаас эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийн хоорондох өрсөлдөөнт тойргийн уралдаанд 500,000 долларын санхүүжилтийн зөрүү байгааг харуулж байна. Цаашлаад эмэгтэйчүүд өрсөлдөөнт уралдаанд оролцож, хандив өргөдөг. Тэдний кампанит ажил нь уралдаанд ихээхэн нөлөө үзүүлдэг тул уралдаанд түрүүлэх магадлал тун багатай эрчүүдээс ч бага байдаг. Жишээлбэл, Эндрю Янз Калифорни мужийн 22-р конгрессын тойрогт одоогийн Бүгд найрамдах намын Девин Нунесийн эсрэг Ардчилсан намаас нэр дэвшсэн нь нэлээд хойгуур орсон.¹⁵ Калифорнийн өөр нэг дүүрэгт өргөн дэмжигдсэн нэр дэвшигч Залуу Ким өөрийн үндсэн өрсөлдөгч эрэгтэй 5 удаа хандив цуглуулсан байна. Төлөөлөгчдийн танхимын төлөөх праймеризд ялалт байгуулсан эмэгтэй нэр дэвшигчид нийлээд эрэгтэй өрсөлдөгчдөөсөө 185 мянган ам.доллараар бага мөнгө цуглуулжээ. Энэ нь эмэгтэй нэр дэвшигчид хүчтэй өрсөлдөгчтэй тулгарах үед тэдний хүлээн авах санхүүгийн дэмжлэгийн хэмжээнд тэдний хүйс чухал үүрэг гүйцэтгэдэг тул энэ нь чухал юм.

¹⁵ Equitable Growth. (2018). Factsheet: Gender wage inequality in the United States and what to do about it.

III.2. ХБНГУ-ын хувьд улс төрийн харилцаан дахь жендэрийн нөхцөл байдал:

Холбооны түвшинд жендэрийн үзэл баримтлалыг бодитойгоор хэрэгжүүлсэн боловч 2005 оноос хойш үр дүнтэй хэрэгжихээ больсон. Холбооны засгийн газарт жендэрийн тэгш байдлыг хангах яам хоорондын бүтэц эсвэл бүх яамд холбоо барих хүмүүсийн сүлжээ байхгүй болсон. Европын холбооны гишүүн орнууд дахь Бээжингийн үйл ажиллагааны платформын хэрэгжилтийн талаарх хурлын тоймоос харахад Герман улс энэ чиглэлээс ухарсан Европын холбооны 8 оронд багтдаг ч холбооны яамд жендэрийн тэгш байдлыг хууль ёсны дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй хэвээр байна. Гэвч жендэрийн үзэл баримтлалыг үр дүнтэй хэрэгжүүлэх улс төрийн хүсэл зориг, бүтэц байхгүй үед энэ хуулийн үүрэг үр дүнгүй хэвээр байна. 2012 онд Герман улс жендэрийн тэгш байдлыг хангах ямар ч бүтэц зохион байгуулалтгүй Европын гурван орны нэг байв.¹⁶

Жендэрийн тайлагналын тухайд, Холбооны Засгийн газар 2011 онд жендэрийн тэгш байдлын талаарх анхны тайлангаа өргөн барьсан бөгөөд Германы Бундестагийн шийдвэрээр ийм тайлангийн төслийг сонгуулийн үеэр нэг удаа гаргах үүрэг хүлээсэн. Жендэрийн чиг хандлага ба жендэрийн төсөв Мужуудын түвшинд тэгш байдлын ахиц дэвшил нь 16 муж улсын засгийн газар тус бүрийн улс төрийн

¹⁶ Холбооны засгийн газар жендэрийн төсөвлөлтийг холбооны түвшинд хэрэгжүүлэх ТЭЗҮ-ийг захиалсан боловч ийм төслүүдийг дэмжихээс татгалзаж байна. BMFSFJ (2006) : Machbarkeitsstudie Gender Budgeting auf Bundesebene, Berlin pp 235.

хүсэл зоригоос хамаардаг бөгөөд энэ нь улс төрийн олонхийн дагуу ялгаатай байдаг. Зарим мужуудад жендэрийн тэгш байдлыг хангах нь үр дүнтэй стратеги болсон. Тухайлбал, Германы хотуудын дунд Мюнхен, Фрайбург, Кёльн хотуудад жендэрийн тэгш байдлыг хангах, төсөв боловсруулах дэвшилтэт үйл явц бий болсон.

Германы Бундестаг болон холбооны муж улсын түвшинд сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь арав гаруй жилийн хугацаанд гуравнынэгорчим хэвээр байна (2010 онд 32%). 30%-ийн оноо нь шийдвэр гаргахад үр дүнтэй нөлөөлөх "чухал масс" гэж тооцогддог. Энэ нь сүүлийн жилүүдэд улс төрийн шийдвэр гаргах гол асуудал биш байдгийг тайлбарлаж болох юм. Бусад бүх шийдвэр гаргах салбарт эмэгтэйчүүдийн эзлэх хувь бага байгаа нь асуудал дагуулж байна.

Сүүлийн үед 2013 оны есдүгээр сарын 22-нд болсон сонгуулийн үр дүнд Германы Бундестагт эмэгтэйчүүдийн суудал 32.9 хувиас 36.5 хувь болж өссөн байна

Эдгээр амжилттай үр дүн нь жендэрийн тэгш байдлыг хангах үүднээс улс төрийн намуудаас нэр дэвшүүлэх журамтай холбоотой юм. Улс төрийн намуудын дийлэнх нь улс төрийн сонгуульд нэр дэвшигчийн хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэнцвэртэй оролцоог дэмждэг. Улс төрийн бүх чухал намууд зохих арга хэмжээгээ танилцуулсан. Ногоон нам эмэгтэйчүүдийн тухай хууль тогтоомжийн талаар өргөн хүрээтэй заалтыг нийтлэлдээ тусгаж, эмэгтэйчүүдийн 50 хувийн

дотоод квотыг тогтоожээ.¹⁷ «Социал демократнам(СДН)бүхбайгууллагын түвшинд эмэгтэйчүүдийн 40 хувийн квот тогтоосон.¹⁸ Гэвч 16 сонгуулийн жагсаалтаас ердөө 9 нь (нэг) Холбооны муж бүрт жагсаалт) саяхан болсон Бундестагийн сонгуульд нэр дэвшигчдийн 40 хувь нь эмэгтэй нэр дэвшигчидтэй байна. Холбооны засгийн газарт нийт удирдах албан тушаалын бараг гуравны нэгийг эмэгтэйчүүд (2014 оны 9-р сард 32.1 хувь, 2012 онд 29 хувь) эзэлж байна. 2014 онд бараг бүх яамд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлсэн байна. Шатлалын түвшинд ихээхэн ялгаа бий: холбооны яамдын түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 40 хувь байна. УИХ дахь Төрийн нарийн бичгийн дарга нарын бүлэгт эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн өндөр (41.2 хувь) байна

Хотын түвшинд сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь сул байна. Эмэгтэйчүүдийн сонгуульд оролцох оролцоог тус тус бүрдүүлсэн нь хотын зөвлөлд эмэгтэйчүүдийн тоог хэрхэн нэмэгдүүлэх талаар нийгэмд маргаан үүсгээд байна. Үүний үр дүнд Холбооны Засгийн газар, мужуудын засгийн газрууд болон эмэгтэйчүүдийн байгууллагууд сонгуулийн жагсаалтад нэр дэвшигчдийн эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх олон хөтөлбөр хэрэгжүүлсэн. 2018 онтой харьцуулахад хэд хэдэн хотод эмэгтэйчүүдийн эзлэх хувь

¹⁷ [https://www.europarl.europa.eu/RegData/etudes/IDAN/2015/510025/IPOL_IDA\(2015\)510025_EN.pdf](https://www.europarl.europa.eu/RegData/etudes/IDAN/2015/510025/IPOL_IDA(2015)510025_EN.pdf)

¹⁸ <https://www.pewresearch.org/social-trends/2017/10/18/wide-partisan-gaps-in-u-s-over-how-far-the-country-has-come-on-gender-equality/>

нэмэгдсэн байна. 2021 онд хотын зөвлөлд эмэгтэйчүүдийн төлөөлөл улсын хэмжээнд дунджаар 26.1 хувьд хүрч, 18.7 хувиас 41.9 хувьд хүрчээ¹⁹

IV. Практик судалгаа

IV.1. Улс төрийн салбар дахь жендэрийн тэгш байдлын талаар нөхцөл байдал (УИХ-ын сонгууль)

Улс төрийн намын гишүүдийн 50 гаруй хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг хэр нь шийдвэр гаргах түвшин буюу Улсын Их Хурал (УИХ), Засгийн газар (ЗГ), Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ), улс төрийн намын удирдлагад тэдний төлөөлөл хангалтгүй байна.²⁰ Улс төрийн намын гишүүдийн хүйсийн харьцааг харуулсан бодитой тоо, статистик байхгүй байна. Монгол Ардын нам (МАН)-ын Бага хурал болон Ардчилсан нам (АН)-ын Үндэсний бодлогын хороо (ҮБХ)-ны гишүүдийн 22.0 хувь нь эмэгтэй байгаа бол аймаг, нийслэл, дүүргийн намын даргад нэг ч эмэгтэй байхгүй байна. Бусад намын дунд болон анхан шатны байгууллагуудын хүйсийн харьцааг харуулсан энэ талаарх мэдээлэл мөн байхгүй байна.


Улс төрийн намын удирдах түвшин дэх хүйсийн харьцаа

Намууд	Бага хурлын гишүүд /288:81/ Үндэсний бодлогын хороо /320:90/	Аймаг, нийслэл, дүүргийн намын дарга /31:0/	Аймаг, нийслэл, дүүргийн намын дэд дарга /25:6/
МАН	78.0:22.0	100.0:0.0	80.7:19.3
АН	78.0:22.0	-	-

218

2016 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн 26 хувь нь эмэгтэйчүүд байсан бол 2020 оны сонгуульд нэр дэвшигчдийн 25 хувь нь эмэгтэйчүүд байсан байна. Энэ нь 2016 оны сонгуультай харьцуулахад 1 хувиар буурсан үр дүн юм. 2012 онд 174, 2016 онд 129 эмэгтэй нэр дэвшсэн бол 2020 онд 151 болж, 18 хувиар өссөн байна.

Сүүлийн 4 удаагийн УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн хүйсийн харьцаа



¹⁹ <https://blogs.loc.gov/law/2021/03/addressing-the-gender-gap-in-politics-the-case-of-germany/> Addressing the Gender Gap in Politics: The Case of Germany March 8, 2021 by Jenny Gesley

²⁰ <http://ubsonin.mn/index.php?newsid=166>

2020 оны УИХ-ын сонгуульд хамгийн олон эмэгтэйг Зон олны нам, Хөгжлийн хөтөлбөр нам, Гэр хороолол хөгжлийн нам дэвшүүлсэн байна. Зон олны намын нэр дэвшигчдийн 77 хувь нь, Хөгжлийн хөтөлбөр намын нэр дэвшигчдийн 57 хувь нь, Гэр хороолол хөгжлийн намын нэр дэвшигчдийн 50 хувь нь эмэгтэйчүүд байжээ. Харин эрх баригч МАН-ын нэр дэвшигчдийн 21 хувь нь, сөрөг хүчин АН-ын нэр дэвшигчдийн 22 хувь нь, "Та бүхний эвсэл"-ийн нэр дэвшигчдийн 23 хувь, "Зөв хүн электорат" эвслийн нэр дэвшигчдийн 24.5 хувь нь эмэгтэйчүүд байсан байна.

1992 оноос хойш УИХ-ын 7 удаагийн сонгуулийн дүнд нийт 532 гишүүн сонгогдсоноос давхардсан тоогоор 50 нь эмэгтэй гишүүн байжээ.

2020 онд УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь 17.1 хувь болж өмнөх сонгуулийн үр дүнгээ бататгасан хэдий ч энэ нь дэлхийн дунджаас (2017 онд 23.7 хувь) болон Зүүн Ази, Номхон далайн бүсийн дунджаас (2017 онд 19.7 хувь) доогуур хэвээр байна. 2017 оны Жендэрийн зөрүүтэй байдлын тайланд улс төрийн эрх мэдлийн үзүүлэлтээр Монгол Улс 144 орноос 107-д эрэмбэлэгдсэн байна.²¹

Улс төрийн намуудад өгч буй төрийн санхүүжилтийн (улсын төсвөөс олгодог) тогтолцоог жендэрийн мэдрэмжтэй нам төлөвшүүлэхэд чиглүүлэх

шаардлагатай байна. Тухайлбал²², төрийн санхүүжилтийн хэмжээг сонгуульд нэр дэвшигч эмэгтэйчүүдийн тоотой нийцүүлэн өсгөх, намуудад олгох төрийн санхүүжилтийн тодорхой хувийг эмэгтэй улстөрчдийг дэмжихэд зарцуулах бодлого байж болох юм.

2017 онд хийсэн судалгаагаар "Эмэгтэйчүүдийг улс төрийн удирдлагын түвшинд гаргах тулд намууд илүү ихийг хийх ёстой" гэдэгтэй судалгаанд оролцогчдын 66 хувь нь, "Эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх, томилох талаар намууд илүү ихийг хийх ёстой" гэдэгтэй 65 хувь нь санал нийлснээс үзэхэд улс төрийн намууд эмэгтэйчүүдийг УИХ болон орон нутгийн сонгуульд нэр дэвших, сонгогдоход дэмжлэг үзүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

IV.2. Улс төрийн салбар дахь жендэрийн тэгш байдлын талаар нөхцөл байдал (орон нутгийн сонгууль)

Орон нутгийн 2016 оны сонгуулийн үр дүнд байгуулагдсан бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ)-д сонгогдсон нийт төлөөлөгчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 27.3 (нийт 40-өөс дээш хувийн эмэгтэйчүүд нэр дэвшдэг) байна. Харин засаг захиргааны түвшин ахих тусам эмэгтэйчүүдийн төлөөлөл багасдаг статистик байна. Тухайлбал, аймгийн ИТХ-д эмэгтэйчүүд 17.6 хувь эзэлж байгаа²³ бол Нийслэлийн ИТХ-ын

²¹ ХНХЯ, ЖҮХ, АХБ "Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт бас сорилт, сургамж". УБ хот., 2019 он, 52-р хуудас

²² ЖЭТБХТХ-ийн 8.2-р зүйл "Бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна"

²³ <http://www.khural.mn/n/7tkvn>

45 төлөөлөгчийн 6 нь буюу 13.3% нь эмэгтэйчүүд байжээ.

Орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэхэд УИХ-д нэр дэвшихтэй адил квот хэрэглэхгүй байгаа ч 2016 оны орон нутгийн сонгуулийн үр дүнд аймаг, сум, нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн 26.7 хувь, тэргүүлэгчдийн 27.8 хувь, хурлын даргын 13.8 хувьд эмэгтэйчүүд сонгогджээ (ЖҮХ, 2019). Харин аймаг, нийслэлийн болон ИТХ-ын даргаар эмэгтэй хүйсийн хүн ажилласан тохиолдол нэг байсан бол 2020 онд Сэлэнгэ, Хэнтий аймгийн ИТХ-ын даргаар эмэгтэй хүн сонгогдсон байна.

IV.3. Сонгуулийн төсвийн жендэрийн тэгш хуваарилалтын нөхцөл байдал

2016 оны УИХ-ын ээлжит сонгуулийн жилд нам эвсэл 3.4 тэрбумаар тогтоож байсан бол 2020 оны ээлжит сонгуулийн зардлын дээд хэмжээг 5.9 тэрбумаар тогтоосон. Тус газрын мэдээлснээр 2016 оны ээлжит сонгуулийн дүнгээр нэг нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээ 322 сая төгрөг байсан бол 2020 онд 410 сая төгрөг болж нэмэгдсэн байна.

ҮАГ-ын мэдээллээр энэхүү нэг нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээг тогтоохдоо жендэрийг харгалздаггүй байна.

Эмэгтэй нэр дэвшигчдэд сонгуулийн сурталчилгаа явуулахад шаардагдах хөрөнгө босгоход ихээхэн хүндрэлтэй байдаг. Одоо хэрэгжиж буй хуулиудад сонгуулийн кампанит ажлын санхүүжилт

босгох арга замын тухай тодорхой заалт байхгүй, харин зардлыг хэрхэн зарцуулах тухайд заалтууд бий. Зардлыг хязгаарлах заалт сул байгаа нь хөрөнгөтэй нэр дэвшигч, улс төрийн намуудад илүү боломж олгож байна. Хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, мөн хүлээлгэх хариуцлага сул байгаагаас намууд, нэр дэвшигчид сонгогдсоныхоо дараа бизнесийн ашиг сонирхолд автах эрсдэлтэй байна.

“Манай улсад одоог хүртэл эрэгтэйчүүд давамгайлсан парламентын гишүүдийн дунд бизнес эрхэлдэг гишүүд олон байдаг. Тиймээс улс төрд бизнесийн ашиг сонирхлын нөлөө их, томоохон компаниуд сонгуулийг санхүүжүүлж байгаа нь улс төрд орж буй эмэгтэйчүүд болон бага орлоготой эрэгтэй нэр дэвшигч сонгогдоход саад бэрхшээл болсоор байна”²⁴. Энэ нь улс төрийн гараа тэгш бус байгааг, мөн нэгэнт парламентад эрэгтэйчүүд давамгайл байгаа тул дахин сонгогдох боломж мөн эрэгтэйчүүдэд илүү байгааг харуулж байна. Түүнчлэн нам дотроо нэр дэвших эрх авах “нэр дэвшигчийн татвар” гэсэн өндөр босго тавьдаг. Энэ нь эмэгтэйчүүдийн сонгогдох эрхийг хэрэгжүүлэхэд ялгаварлал, бэрхшээл учруулж байна.

МАН-ын хувьд 30 хувийн суудал хадгалах квотын тогтолцоотой бол АН-ын хувьд Үндэсний бодлогын хорооны 410 гишүүний 90 нь эмэгтэй байх, бүх шатны сонгуульд нэр дэвшигчдэд аль нэг хүйсийн

²⁴ Р.Бурмаа. Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо: Туршлага ба сургаамж. Монгол Улс. Илтгэл. 3 дахь тал 2013 оны 9 сарын 7.

төлөөлөл хамгийн багадаа 25 хувь байна хэмээн дүрмээрээ тогтоосон аж. Ийнхүү өнөөдрийн хувьд улс төрийн намууд квотын аргыг хэрэглэдэг болсон нь сайшаалтай.²⁵

Улс төрийн хүрээний зохицуулалтын хууль тогтоомжийн хувьд жендэрийн шууд ялгаварлан гадуурхсан заалт байхгүй. ХҮЭК-т 2015-2019 онд ирсэн гомдлын тоо мэдээллээс харахад улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой гомдол нэг л иржээ. Харин сонгох, сонгогдох эрхтэй холбоотой 23 гомдол иржээ. Гэсэн хэдий ч жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай заалтын хэрэгжилт хангалтгүй, тунхаглалын шинж чанартай зорилт болсныг улс төрийн харилцааны хүрээнд тавьсан квотын хэрэгжилтээс харж болно.

V. Дүгнэлт

Эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төрийн харилцаанд эрх тэгш байх, улс төрд оролцох боломж, нөхцөлийг хангах зарчим хууль эрх зүйн хүрээнд тодорхой хэмжээнд хангагдаж байгаа хэдий ч хуулийн хэрэгжилтийн түвшинд хангалттай бус байна. Үүний гол шалтгаан нь хуулийн хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл улс төрийн намуудад бага байна.

Хууль тогтоомжийн хүрээнд ялгаварлан гадуурхалт, хүний эрх эрх чөлөөг хязгаарлах байдал байхгүй хэдий ч нийгмийн дундах жендэрийн хэвшмэл ойлголт өөрчлөгдөхгүй хэвээр оршсоор байна. Улс төрийн хүрээнд аль нэг хүйсийг илт ялгаварлан гадуурхсан зүйл байхгүй ч квотыг хэрэгжүүлэхгүй байх,

²⁵ С.Түмэндэлгэр, "Жендэр банийгэм: Социологигор төсөөлөхүй", УБ., 2019 он, 85 дугаар тал

дэмжлэг үзүүлэхгүй байх явдал байсаар байна. Улс төрийн хүрээнд төрөөс бодлого, хууль тогтоомжийг батлан гаргаж байгаа хэдий ч хуулийн хэрэгжилт, хариуцлага хүлээх байдал хангалтгүй байна.

Улс төрийн харилцааны хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөлд жендэрийн үзэл баримтлалыг тусгах чиглэлд сүүлийн жилүүдэд ахиц дэвшил гараагүй байна.

Улс төрийн намууд хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдал хангалтгүй байгаагаас гадна улс төрийн харилцааны хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд судалгаа, мэдээлэл хангалттай бус хэвээр байна.

VI. Санал дэвшүүлэх нь

- Бусад улсуудын туршлагаас үзэхэд сонгуулийн төрөөс олгох санхүүжилтийн тодорхой хувийг жендэрийн харьцааг тэнцвэржүүлэхэд ашигладаг бөгөөд манай улсын хувьд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр улс төрийн намын санхүүжилтийн суурийг тавьсан. Иймд манай улсын хувьд улс төрийн намын санхүүжилтийн тодорхой хувийг эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжихэд зориулж болох юм.
- Мөн тодорхой квотыг тогтоож өгснөөр тэгш байдлыг хангах нэг түлхэц болж болох юм. Манай улсын хувьд 20 хувиас дээш байх бөгөөд тухайн улс төрийн намууд хувиа тогтоодог. Гэтэл энэ нь төдийлөн үр дүнгээ

өгөхгүй байгаа бөгөөд ХБНГУ-ын жишээ шиг тодорхой хувь тогтоож албажуулж болох юм.

- Мөн дан ганц улс төрийн салбарт жендэрийн тэгш байдлыг хангахаас гадна бүх салбарт жендэрийн тэгш байдлыг хангах нь эмэгтэйчүүдийг сонгох сонголтыг нэмэгдүүлдэг байна.

VII. Ашигласан эх сурвалж Хууль, хуульчилсан акт:

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, 2019
- Улс төрийн намын тухай хууль, 2005
- УИХ-ын болон Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, 2020

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, гарын авлага

- Ж.Занаа, Жендэрийн тэгш эрх ба эрх зүйн байдал, УБ, 2004
- Хүний эрхийн үндэсний комисс, Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 13 дахь илтгэл, 2014
- Нэгдсэн Үндэстний байгууллагын дэргэдэх Жендэрийн асуудлаарх ажлын хэсэг, Жендэрийн нэр томьёо, тодорхойлолт, үндсэн ойлголтууд, УБ, 2003
- Боловсрол соёл шинжлэх ухааны яам, Дээд боловсролд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь, Сургалтын гарын авлага, УБ, 2019

- <https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/mn/2015-Gender-Overview-%20Desk-Study-Mongolia-MN.pdf> Швейцарийн Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжсэн «Монгол улс дахь жендэрийн тэгш байдлын талаарх үзэл хандлага: Олон нийтийн тандалтын судалгаа"-ны төсөл, МОНГОЛ УЛС ДАХЬ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ: (Нөхцөл байдлын товч үнэлгээ, Баримт бичгийн судалгаа)
- ХНХЯ, ЖҮХ, АХБ "Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт бас сорилт, сургамж", УБ хот., 2019 он
- <http://www.khural.mn/n/7tkyn>
- Р.Бурмаа. Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо: Туршлага ба сургамж. Монгол Улс. Илтгэл 2013 оны 9 сарын 7.
- С.Түмэндэлгэр, "Жендэр ба нийгэм: Социологиор төсөөлөхүй", УБ., 2019 он

Гадаад эх сурвалж

- Political finance. International IDEA. <https://www.idea.int/node/294691>
- Political finance. International IDEA. <https://www.idea.int/node/261413>
- Political finance. International IDEA. <https://www.idea.int/node/272641>
- The Gender Gap in American Politics: How Money in Politics Affects Female Representation

- Hansen, C. (2018). 116th Congress by Party, Race, Gender, and Religion. US News and World Report.
- Overby, Peter. (2018). There's A \$500,000 Gender Gap When It Comes To Campaign Fundraising: NPR.
- Equitable Growth. (2018). Factsheet: Gender wage inequality in the United States and what to do about it.
- Холбооны засгийн газар жендэрийн төсөвлөлтийг холбооны түвшинд хэрэгжүүлэх ТЭЗҮ-ийг захиалсан боловч ийм төслүүдийг дэмжихээс татгалзаж байна. BMFSFJ (2006) Machbarkeitsstudie Gender Budgeting auf Bundesebene, Berlin pp 235.

АРБИТРЫН ХЭЛЭЛЦЭЭР БА ХЭРГИЙН ХАРЬАЛЛЫН ЗАРИМ АСУУДАЛ



Шихихутуг их сургуулийн
магистрант М.Цэдэнпунцаг

1. Удиртгал

Ардчилсан үзэл баримтлалтай Үндсэн хуулиар Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна¹ гэж олон хэвшил бүхий чөлөөт эдийн засгийн үндсэн суурийг зохицуулсан.

Ашгийн төлөө хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагаанд бизнесийн эрх зүйн гэрээг байнга ашигладаг. Улмаар аж ахуйн нэгж байгууллага нь гэрээ, хэлцлээс үүдсэн маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий этгээдийг талууд харилцан тохиролцож тогтоодог. Энэ нь хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүх, арбитр бөгөөд аж ахуйн нэгж байгууллага нь бизнесийн аливаа эрсдэл, цаг хугацааг урьдаас тооцож гэрээ, хэлцэлдээ маргаан хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагаар арбитраар шийдвэрлүүлэхээр зохицуулалт оруулах, нөгөө талаас бэлэн гэрээний загварыг татаж

хэрэглэж байна. Үүнээс шалтгаалж практикт арбитрын хэлэлцээртэй гэрээнээс үүдсэн маргааныг шүүхэд нэхэмжлэл гаргаж шүүх түүнийг хүлээн авч иргэний хэрэг үүсгэн, хариуцагч хариу тайлбараа өгсөн тохиолдолд маргааныг өөрийн харьяалалд хамааруулан шийдвэрлэж байна.

Энэхүү сэдвийн хүрээнд Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг шүүх хэрхэн тайлбарлан хэрэглэж байгааг судлах, нөгөө талаас иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын ...гэрээний чөлөөт байдлын зарчим, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх ...зарчим²-ыг шүүх зөрчиж байгаад анхаарал хандуулахыг эрмэлзсэн болно.

2. Хэргийн харьяаллын эрх зүйн зохицуулалт

Хэргийн харьяалал гэдэг нь эрхийн болон бусад асуудлаарх маргааныг төрийн зохицуулалтаар шийдвэрлэх төрийн болон төрийн бус байгууллагын бүрэн эрхээр тодорхойлогдсон хамаарлыг хэлнэ³ гэж Монгол Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн хэргийн танхимын шүүгчдийн хамтарсан бүтээлд эрх зүйн шинжлэх ухааны тайлбар хийсэн байна. Харин Монгол Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбарт: Хэргийн харьяалал гэж

² Монгол Улсын Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт.

³ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ.2007 он.

¹ Монгол Улсын Үндсэн хууль. 1992.

тухайн маргаан ямар байгууллагаар шийдвэрлэгдэхийг тодорхойлдог, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бол шүүх уг асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй эсэхийг тогтоодог ойлголт юм⁴ гэжээ.

Эрх зүйн шинжлэх ухааны албан бус болон хууль зүйн албан ёсны тайлбарт үндэслэн тодорхойлбол хэргийн харьяалал гэдгийг аливаа эрх зүйн маргааныг ямар байгууллагаар шийдвэрлэгдэхийг тодорхойлдог ойлголт байж болохоор юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд хэргийн харьяаллын эрх зүйн зохицуулалтын талаар:

Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан үндэслэлээр гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдол /цаашид "нэхэмжлэл" гэх/-ыг шүүх харьяалан шийдвэрлэнэ гэж заасан нь хэргийн харьяаллын зохицуулсан ерөнхий зохицуулалт байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль⁵-ийн 13 дугаар зүйлийн 13.2. дэх хэсэгт Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан буюу зохигч хэлэлцэн тохиролцсон бол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитр шийдвэрлэнэ гэж хэргийн харьяаллын тусгай зохицуулалтыг хуульчилсан. Энэ заалтаас үзвэл: Нэгд, Хуульд

заасан, Хоёрт, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан, Гуравт, зохигч хэлэлцэн тохиролцсон бол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитр шийдвэрлэгдэхээр зохицуулжээ.

Хуульд заасан гэдэг нь хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд тухайн төрлийн маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээр тусгайлан заасан байхыг хэлнэ. Одоогийн даган мөрдөгдөж буй хуулиудад зөвхөн арбитраар шийдвэрлүүлэх маргааны төрлийг заасан зохицуулалт байхгүй болно⁶.

Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар хэргийн харьяаллыг ерөнхий болон тусгайлан зохицуулжээ. Тус хуулийн зохицуулалтаас үзвэл: Хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд тусгайлан заасан, иргэн хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээр тохиролцсоноос бусад маргааныг шүүх хянан шийдвэрлэхээр зохицуулсан нь харагдаж байна.

Арбитрын тухай хуулиар арбитрын ажиллагааны харьяаллын эрх зүйн зохицуулалтын талаар:

Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч этгээдүүдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргааныг шүүхийн болон шүүхийн бус аргаар шийдвэрлэж болох ба арбитраар маргаан шийдвэрлүүлэх ажиллагаа нь талууд сайн дураараа, хүсэл

⁶ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 2007.

⁴ Улсын дээд шүүхийн тайлбар /2007 оны 07 дугаар сарын 2-ны өдөр, тогтоолын дугаар 32.

⁵ "Төрийн мэдээлэл", 2002 он, №8.

зоригоо илэрхийлэн харилцан тохиролцож, өөрсдийн сонгосон хөндлөнгийн этгээдээр маргаанаа шийдвэрлүүлдэг шүүхийн бус арга юм⁷ Арбитрын шүүхэд маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний буюу шүүх нэхэмжлэлийг хүлээн аваад өөрийн эрх хэмжээний хүрээнд цаашид эрхлэн явуулж болох, эсэхийг тодорхойлох гол шалгуур бол хэргийн харьяалал байдаг. Арбитрын шүүх өөрийн харьяаллын бус хэргийг шийдвэрлэх эрхгүй⁸ гэж арбитрын хэргийн харьяаллыг оновчтой тодорхойлсон байна.

Монгол Улсын Арбитрын тухай хууль⁹-ийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт Арбитрын ажиллагааны харьяалал нь Монгол Улс бол энэ хууль үйлчилнэ гэж заасан бөгөөд Арбитрын ажиллагааны харьяаллын маргааныг тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт Шүүхэд тусгайлан харьяалуулснаас бусад, арбитрын хэлэлцээрт тусгасан аливаа маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ, мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалт Талууд арбитрын ажиллагааны журмыг тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн энэ хуулийн хүрээнд арбитрын ажиллагааг тохиромжтой гэж үзсэн журмаар явуулж болно. Арбитрын бүрэлдэхүүний бүрэн

эрхэд аливаа нотлох баримтыг нотлох чадвартай, хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв эргэлзээгүй болохыг тодорхойлох эрх хамаарна гэж арбитрын ажиллагааны харьяаллыг зохицуулжээ.

Арбитрын ажиллагааны харьяалан шийдвэрлэх маргаан нь арбитрын хэлэлцээртэй салшгүй холбоотой бөгөөд арбитрын хэлэлцээр, түүний хууль зүйн зохицуулалтын талаар дараагийн бүлэгт лавшруулан авч үзэх болно.

3. Арбитрын хэлэлцээр, хууль зүйн зохицуулалт

Өмнөх бүлэгт үзсэнчлэн Арбитрын ажиллагааны харьяалан шийдвэрлэх маргаан нь арбитрын хэлэлцээртэй салшгүй холбоотой тул түүний онолын болон хууль зүйн асуудлыг авч үзэхийг зорилоо.

Монгол Улсын 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан Арбитрын тухай хуулийн 1-р зүйлийн 1.1. дэх заалт Энэ хуулийн зорилт нь эрх зүйн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх ажиллагаатай холбоотой харилцааг олон улсын стандартад нийцүүлэн зохицуулахад оршино гэсэн нь НҮБ-ийн олон улсын худалдааны комиссоос гаргадаг 1985 оны ЮНСИТРАЛ-ын загвар хуульд нийцүүлэх том алхмыг тавьсан болов уу.

Улмаар ЮНСИТРАЛ-ын загвар хууль нь хамгийн сүүлд 2006 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн Комиссын 39 дэх хурлаар нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд арбитрын

⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны Арбитрын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт.

⁸ Мөнхжаргал.Т., Арбитрын процессын эрх зүй. УБ., 2008.т.45

⁹ Арбитрын тухай хууль. 2017.

хэлэлцээр хийхээс эхлээд арбитрын шийдвэр хүлээн зөвшөөрөгдөх, биелэгдэх хүртэл арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатыг хамарсан, янз бүрийн эрх зүйн болон эдийн засгийн тогтолцоотой бүх улс орон хүлээн зөвшөөрч баталж болохуйц эрх зүйн зохицуулалтыг хийж өгсөн байна¹⁰.

ЮНСИТРАЛ-ын загвар хуульд орсон өөрчлөлтөд уялдуулах, олон улсын жишигт нийцүүлэн 2017 онд Арбитрын тухай хуулийн шинэчлэн найруулж баталсан. Тухайлбал: Арбитрын хэлэлцээрийг ЮНСИТРАЛ-ын загвар хууль¹¹-ийн Хоёрдугаар бүлэг 7 дугаар зүйлийн 1 дэх заалтад “Арбитрын хэлэлцээр” нь талуудын хооронд ямар нэг эрхийн харилцаатай холбоотой үүссэн буюу үүсэж болох тодорхой маргааныг арбитрт шилжүүлэх тухай гэрээний шинжтэй эсэхээс хамаарахгүй тохиролцсон тохиролцоо мөн гэж тодорхойлсон бөгөөд манай улсын Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д Арбитрын хэлэлцээр гэж гэрээний үндсэн дээр үүссэн эсэхээс үл хамааран бий болсон эрх зүйн харилцаатай холбоотойгоор талуудын хооронд үүссэн, эсхүл үүсэж болох аливаа маргаан, эсхүл түүний тодорхой хэсгийг арбитрын журмаар шийдвэрлүүлэх тухай талуудын тохиролцоог хэлнэ гэж арбитрын хэлэлцээрийг хуулиар тодорхойлж өгсөн байна.

Дээрх загвар хууль болон

дотоодын хуулиар тодорхойлсноос үзвэл Арбитрын хэлэлцээр нь маргалдагч талуудын маргаанаа хянан шийдвэрлүүлэх хүсэл зориг илэрхийлсэн Иргэний хууль¹²-ийн 39-р зүйлийн 39.1 дэх заалт Иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл /эс үйлдэхүй/-г хэлцэл гэнэ гэж заасантай нийцэж байна гэж судлаачийн зүгээс үзлээ.

Арбитрын хэлэлцээр нь Иргэний хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт заасан хэлцлийн үндсэн шинжийг агуулж буй учир түүнд хэлбэрийн болон агуулга, субъектын шаардлага тавигдах, иргэний эрх зүйн зарчим хамаарах нь иргэний эрх зүйн онолын үндсэн асуудлын нэг болох нь мэдээж.

4. Гэрээний эрх чөлөөний зарчим

Судлаачийн хувьд иргэний эрх зүйн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргаанаа хянан шийдвэрлүүлэх шүүх, шүүхийн бус байгууллагыг сонгох буюу арбитрын хэлэлцээрт Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дэх заалт ...гэрээний эрх чөлөө... зарчмыг тодруулсан Иргэний хуулийн 189-р зүйлийн 189.1 дэх Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй гэсэн иргэний эрх зүйн үндсэн зарчим хамааралтай талаас нь судлахаар оролдсон болно.

¹⁰ Должин.С., Хувийн эрх зүй.УБ.,2017.т.48.

¹¹ Олон Улсын арилжааны арбитрын загвар хууль, 2006 оны нэмэлт өөрчлөлт, 7.1 дүгээр заалт

¹² Иргэний хууль.2002. 39.1 дүгээр заалт

Талууд маргаанаа арбитраар шийдвэрлүүлэх хүсэл зоригоо хангалттай тодорхой илэрхийлсэн байвал зохино¹³. Арбитрын хэлэлцээр хууль зүйн фактын шинжийг агуулна. Талуудын аль нэг нь арбитрын хэлэлцээр хийх санал болгосныг нөгөө тал зөвшөөрснөө илэрхийлсэн үйлдэл нь тэдний санал хүсэлтийг нэгтгэн илэрхийлж буй хэрэг болно. Талууд маргаан үүсвэл төрийн эсхүл арбитрын шүүхийн алинд нь нэхэмжлэл гарган шийдвэрлүүлэхийг хөндлөнгийн ямар нэг шахалт хавчилт, ятгалгаар биш зөвхөн өөрсдийн ойлголт, итгэл үнэмшлээр хэлэлцээр хийх ёстой¹⁴.

Гэрээ байгуулагч этгээд нь уг гэрээнээс үүсэж болох маргааныг хэнээр, ямар журмын дагуу шийдвэрлүүлэхээ нэлээд чөлөөтэй байдлаар тохиролцохыг Үндсэн хуулиар хориглоогүй гэж үзэх боломжтой. Өнөөдөр манай Улсад иргэний хэргийг хянан шийдвэрлэх журмыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай болон Арбитрын тухай хуулиар тус тус хэлэлцэн өөрчилж болохыг зөвшөөрсөн байгаа нь гэрээний эрх чөлөөг дээдэлсэн нэг жишээ юм¹⁵.

Гэрээний эрх чөлөө гэдэг хууль зүйн үүднээс өргөн утгаараа эрх зүйн этгээдүүд гэрээний харилцаанд хуулийн хүрээнд чөлөөтэй оролцох

/оролцох эсэхээ шийдэх/ боломж мөн. Өдгөө чөлөөт эдийн засаг бүхий улсуудад гэрээний эрх чөлөөг нийтлэг агуулгаар нь хүлээн зөвшөөрсөн байна. Уг агуулга нь аливаа этгээд хэнтэй, хэзээ, хаана, ямар агуулгаар, хэрхэн яаж гэрээ байгуулахаа, эсвэл байгуулахгүй байх буюу татгалзахаа өөрөө дур мэдэн шийдвэрлэх юм¹⁶.

XIX зууны либерализмтай холбоотойгоор хувийн бие даасан байдал ба гэрээний эрх чөлөөний зарчим гэрээний эрх зүйн суурь зарчим болсон. Хувийн эрхэд халдашгүй байдлын зарчим нь талуудын илэрхийлсэн хүсэл зориг нь гэрээний гол хөшүүрэг болох бөгөөд түүнийг хуулийн дагуу биелүүлэх үндэслэгээ болдог¹⁷.

Гэрээний чөлөөт байдлын зарчим нь зах зээлийн эдийн засгийн харилцаанаас үүссэн зарчим болно. Иргэн, хуулийн этгээд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх явцдаа гадаад дотоодын найдвартай түншээ өөрөө сонгон авах, түүнтэй хэний ч заавар шахалтгүйгээр гэрээ байгуулах эрхтэй¹⁸.

Гэрээний эрх чөлөөний зарчмыг эрдэмтэн, судлаачид дээрх байдлаар өөрсдийн бүтээлүүддээ тодорхойлжээ. Дээрх тодорхойлолтуудаас товч дүгнэхэд: Гэрээний эрх чөлөөний зарчим нь

¹³ Дүгэржав.Д., Арбитрын тухай хуулийн товч тайлбар, УБ., 2017. т.25

¹⁴ Мөнхжаргал.Т., Арбитрын процессын эрх зүй. УБ., 2008. Т.46-47

¹⁵ Мэндсайхан.Т. Арбитрын хэлэлцээр, түүний хууль зүйн зарим асуудал. "Арбитрын сэдэвт эрдэм шинжилгээний нийтлэлийн эмхтгэл". УБ.2020.т.202.

¹⁶ Хатанзориг.М., "Гэрээний эрх чөлөө ба гэрээнд тавигдах хэлбэрийн шаардлага".2018. www.legaldata.mn/b/574

¹⁷ Оюунтунгалаг.Ж. Харьцуулсан иргэний эрх зүй. УБ., 2013. т.114.

¹⁸ Мөнхжаргал.Т. "Монгол Улсын Иргэний Эрхзүй". УБ., 2000. т.21

тухайн үеийн нийгмийн үнэт зүйл болох үзэл санаа, эдийн засгийн харилцаанаас үүдэн бий болсон, гэрээний харилцаанд оролцогч талууд хуулийн хүрээнд чөлөөтэй оролцох, бусад иргэний эрх зүйн харилцаанд оролцогчидтой хэний ч заавар шахалтгүйгээр гэрээ байгуулах эрх юм.

Арбитрын хэлэлцээр нь гэрээний чөлөөт байдлын зарчмын үндсэн дээр маргаанаа шийдвэрлэх шүүхийн болон шүүхийн бус байгууллагыг сонгох талуудын хоорондын хооронд хүсэл зоригоо хангалттай илэрхийлж байгуулсан хэлцэл билээ.

5. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны харилцан хамаарал,

Арбитрын хэлэлцээртэй боловч шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд хуулиар хэрхэн зохицуулж байсан талаар товч авч үзвэл:

1. 1995 оны 10-р сарын 26-ны өдөр батлагдсан Гадаад худалдааны арбитрын тухай хуулийн 7 дугаар зүйл, Маргааны арбитрт шилжүүлэх, Энэ хуулийн 6 дугаар зүйл¹⁹-д заасан эрх зүйн маргааны аль нэг тал шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд түүний Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 64-р зүйл²⁰д заасны дагуу арбитрт шилжүүлнэ.

¹⁹ 6 дугаар зүйл. Арбитр нь арбитрын гэрээ, хэлэлцээр бүхий дараах маргааныг харьяалан шийдвэрлэнэ.

²⁰ 64 дүгээр зүйл. Нэхэмжлэлийг арбитрт шилжүүлэх.

2. 2003 оны 5 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан Арбитрын тухай хуулийн 12 дугаар зүйл. Нэхэмжлэлийг арбитрт шилжүүлэх. 12.1. Талууд тухайн маргаанаар шүүхэд эхэлж нэхэмжлэл гаргасан боловч нэхэмжлэлийн шаардлагын талаар тайлбар гаргахаасаа өмнө уг маргааныг арбитрт шилжүүлэх тухай хүсэлт гаргасан бөгөөд шүүх талуудын хооронд хийсэн арбитрын хэлэлцээр хүчинтэй бөгөөд хэрэгжих боломжтой гэж үзвэл уг маргааныг арбитрт шилжүүлнэ.

3. Монгол Улсын Дээд шүүхийн 45 дугаар тогтоол²¹-ын 2 дахь заалт: Хууль²²-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтын “талууд тухайн маргаанаар шүүхэд эхэлж нэхэмжлэл гаргасан боловч нэхэмжлэлийн шаардлагын талаар тайлбар гаргахаасаа өмнө уг маргааныг арбитрт шилжүүлэх тухай хүсэлт гаргасан...” гэдгийг иргэний хэрэг үүсгэсэн эсэхээс үл хамааран талууд хамтдаа болон тус тусдаа хүсэлт гаргасныг ойлгох бөгөөд шүүхэд нэхэмжлэлийн шаардлагын талаар хариу тайлбар гаргаснаас хойш маргааныг арбитраар шийдвэрлүүлэх хүсэлт гаргах эрхгүй гэж ойлговол зохино.

4. 2017 оны 01-р сарын 26-ны өдөр батлагдсан Арбитрын тухай хуулийн 10-р зүйлийн 10.1 дэх заалт “Арбитрын хэлэлцээртэй боловч шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд аль нэг тал тайлбар гаргахаасаа

²¹ Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол. Дугаар. 45.

²² Арбитрын тухай Монгол Улсын хууль. 2003.

өмнө уг маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан бол шүүх аль нэг талын хүсэлтээр арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бус, эсхүл биелүүлэх боломжгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгоно”.

Арбитрын хэлэлцээртэй боловч шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд хэрхэн хууль зүйн зохицуулалт хийсэн талаар товч авч үзэхэд: Гадаад худалдааны арбитрын тухай хуулийн 7 дугаар зүйлд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу Арбитрт шууд шилжүүлэх зохицуулалт нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын гэрээний эрх чөлөөний зарчмыг хүндэтгэсэн зохицуулалт байжээ. Харин Арбитрын тухай хуулийн 2003 оны хууль, Монгол Улсын Дээд шүүхийн 45 дугаар тогтоолоор Арбитрын хэлэлцээртэй боловч шүүхэд эхэлж нэхэмжлэл гаргасан боловч нэхэмжлэлийн шаардлагын талаар тайлбар гаргахаасаа өмнө уг маргааныг арбитрт шилжүүлэх хүсэлт гаргаагүй бол дахин энэ талаар хүсэлт гаргах эрхгүй, улмаар шүүх уг маргааныг хянан шийдвэрлэж шийдвэр гаргах боломжтой зохицуулалт болжээ.

2017 оны 01-р сарын 26-ны өдрийн Арбитрын тухай хуулийн 1

дүгээр зүйлийн 1.1. дэх заалт Энэ хуулийн зорилт нь эрх зүйн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх ажиллагаатай холбоотой харилцааг олон улсын стандартад нийцүүлэн зохицуулахад оршино гэж заагаад НҮБ-ийн олон улсын худалдааны комиссоос гаргадаг 1985 оны ЮНСИТРАЛ-ын загвар хуульд нийцүүлэх болов.

Тиймээс НҮБ-ийн олон улсын худалдааны комиссоос гаргадаг 1985 оны ЮНСИТРАЛ-ын загвар хуулийн 8 дугаар зүйл. **Арбитрын хэлэлцээр ба шүүхэд маргааны талаар нэхэмжлэл гаргах 1.** Хэрэв талууд маргааны талаарх анхны өргөдөлдөө маргааныг арбитрт шилжүүлэхийг хүссэн бөгөөд арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр бус эсвэл гүйцэтгэх боломжгүй болсноос бусад тохиолдолд бол шүүх нэхэмжлэлийг арбитрт шилжүүлнэ гэж заасантай нийцүүлэхээр 2017 оны 01-р сарын 26-ны өдөр батлагдсан Арбитрын тухай хуулийн 10-р зүйлийн 10.1 дэх заалт “Арбитрын хэлэлцээртэй боловч шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд аль нэг тал тайлбар гаргахаасаа өмнө уг маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан бол шүүх аль нэг талын хүсэлтээр арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бус, эсхүл биелүүлэх боломжгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд шүүхэд хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгоно” гэж хуульчилсан байна. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Арбитрын тухай хуулийн 10-р зүйлийн 10.1 дэх заалтыг шүүх хэрхэн хэрэглэж байгааг дараагийн бүлэгт авч үзэх болно.

6. Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1. дэх заалтыг хэрэглэж буй шүүхийн практик: Сонгосон анхан шатны шүүхийн шийдвэр, Улсын дээд шүүхийн тогтоол²³-д зөвхөн Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг хэрэглэсэн хэсгийг авсан.

Монгол Улсын дээд шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн дугаар 001/ХТ2018/01674 тогтоолоор:

“...Арбитрын хэлэлцээртэй хэдий ч нэгэнт шүүхэд иргэний хэрэг үүсгэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсэн тохиолдолд зохигчийн аль нэг нь маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргасныг хүлээн авч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох боломжтой урьдач нөхцөлийг “...тайлбар гаргахаас өмнө...” гэж хуульд тодорхойлсон байна...” гэжээ.

Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дугаар 181/ШШ2020/02692 шийдвэрээр:

“...Арбитрын хэлэлцээртэй талууд шүүхэд нэхэмжлэл гаргасан бол аль нэг тал тайлбар гаргахаасаа өмнө уг маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгохоор Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтаар хуульчилсан байдаг тул анхнаасаа нэхэмжлэлийг эс зөвшөөрч маргасан тайлбар гаргасан хариуцагчийг одоо харьяаллын талаар маргах эрхээ алдсан гэж үзнэ...” гэжээ.

Дээрх анхан шатны шүүхийн шийдвэрээр Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг иш татаж тайлбарлахдаа “...анхнаасаа нэхэмжлэлийг эс зөвшөөрч маргасан тайлбар гаргасан хариуцагчийг одоо харьяаллын талаар маргах эрхээ алдсан...” гэж үзсэн бол Улсын Дээд шүүхийн тогтоолоор: “...нэгэнт шүүхэд иргэний хэрэг үүсгэсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсэн тохиолдолд... хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох боломжтой урьдач нөхцөлийг “...тайлбар гаргахаас өмнө...” хуульд тодорхойлсон байна гэж үзэж арбитрын хэлэлцээртэй гэрээнээс үүдсэн маргааныг шүүх

²³ http://codelex.test.lc/?fbclid=IwAR2S8qTuy3A7hvrUP4WgS-qwgnyc_uPtCFjyeZfLbK5UBiTzI6bJkamw4o

өөрийн харьяаллын маргаан болгон шийдвэрлэж буй практик тогтсон байна.

Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65-р зүйлийн 65.1 дэх заалт "Шүүгч дараах тохиолдолд захирамж гарган нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана" гээд 65.1.1 дэх хэсэгт энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан хэргийн харьяалал зөрчсөн; гэж заасан. Хэрвээ шүүх нэгэнт хэргийг хүлээн авч иргэний хэрэг үүсгэсэн тохиолдолд арбитрын хэлэлцээртэй буюу хэргийн харьяалал зөрчсөн хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1 дэх заалт "Энэ хуулийн 65.1.9-д заасан үндэслэл хэрэг үүсгэснээс хойш, 65.1.1, 65.1.3-65.1.8, 65.1.10-д заасан үндэслэл шүүх хуралдаанаар хэлэлцэх үед тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгоно. Энэ тухай шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана" хуулиар хэргийн харьяалал зөрчсөн болох нь шүүх хуралдаанаар тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгох зохицуулалттай.

Гэвч Арбитрын тухай хуулийн 10-р зүйлийн 10.1 дэх заалтыг шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тусгайлсан хуулиас илүү нарийвчилсан хууль гэж үзэж хэрэглэж буй нь хууль хэрэглээний алдаа нөгөө талаас гэрээний эрх чөлөөний зарчмын үүднээс маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагыг сонгосон арбитрын хэлэлцээрийг үр нөлөөгүй болгосон үр дагаварт хүргэж байна.

7. ДҮГНЭЛТ

Арбитрын хэлэлцээр нь хэргийн харьяаллыг тодорхойлсон, гэрээний эрх чөлөөний зарчмын дагуу талуудын хүсэл зоригоо илэрхийлж маргаанаа шийдвэрлүүлэх эрх бүхий байгууллагыг сонгож буй хэлцэл байна. Энэхүү хэлцлийн дагуу маргаанаа шийдвэрлүүлэхээр харилцан тохиролцсон байхад шүүх түүнийг арбитраар шийдвэрлүүлэхээр хариу тайлбар гаргахаас өмнө хүсэлт гаргаагүй гэж үзэн гэрээний суурь зарчим болох гэрээний чөлөөт байдлын зарчмыг баримтлахгүй талуудын эрх зүйн байдлыг дордуулж буй нэг хэлбэр гэж үзэж болохоор байна.

Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг баримталж хэргийг шүүх шийдвэрлэж буй практик нэгэнт тогтсон байна. Гэтэл гадаадын хөрөнгө оруулагчид маргаан гарсан тохиолдолд дотоодын шүүхээр шийдвэрлүүлэх сонирхолгүй байхад дээрх практик үргэлжилсээр байх уу.

Санал

Арбитрын хэлэлцээртэй боловч шүүхэд аль нэг тал нэхэмжлэл гаргасан байхад хариу тайлбар гаргахаас өмнө хүсэлт гаргаагүй тохиолдолд Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1 дэх заалтыг зөв хэрэглэж хэргийг шийдвэрлэх талаар Улсын Дээд шүүхээр зөвлөмж гаргуулах саналтай байна.

Эх сурвалж**Нэг. Монгол Улсын Хууль,
Тогтоомж, Эрх зүйн акт**

- Монгол Улсын Үндсэн хууль
- Иргэний хууль
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /1994он
- Арбитрын тухай хууль /2017 он/
- Арбитрын тухай хууль /2003 он/
- Гадаад худалдааны арбитрын тухай хууль /1994/
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны Арбитрын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт.
- Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол.Дугаар.45.

Хоёр. Ном, Сурах бичиг, Өгүүлэл

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар.УБ., 2007.
- Мөнхжаргал.Т., Арбитрын процессын эрх зүй.УБ.,2008.
- Мөнхжаргал.Т., Монгол Улсын Иргэний Эрхзүй.УБ.,2000.
- Должин.С., Хувийн эрх зүй. УБ.,2017.
- Дүгэржав.Д., Арбитрын тухай хуулийн товч тайлбар,УБ.,2017.
- Оюунтунгалаг.Ж. Харьцуулсан иргэний эрх зүй.УБ.,2013.
- Мэндсайхан.Т. Арбитрын хэлэлцээр, түүний хууль зүйн

зарим асуудал. "Арбитрын сэдэвт эрдэм шинжилгээний нийтлэлийн эмхэтгэл".УБ.2020

- Хатанзориг.М., "Гэрээний эрх чөлөө ба гэрээнд тавигдах хэлбэрийн шаардлага".2018.

Гурав. Гадаад эх сурвалж

- Олон Улсын арилжааны арбитрын загвар хууль, 2006 оны нэмэлт өөрчлөлт,

Дөрөв. Цахим Хуудас

- <http://www.Legalinfo.mn>
- <http://www.Legaldata.mn>
- <http://www.shuukh.mn>
- <http://www.arbitr.mn>
- <http://www.consourt.gov.mn>
- <http://www.supremecourt.mn>
- <http://www.code.lex.test.lc>

ОРОН НУТАГ ДАХЬ ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА



Шихихутуг их сургуулийн магистрант Ч.Саранмандах

Хураангуй

Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хүрээнд уул уурхайн олборлолт тээвэрлэлтийн бүс дэх орон нутгийн иргэд малчдын хөндөгдөж буй асуудлыг гаргаж ирэхийг зорьсон. Уул уурхай, нүүрс тээвэрлэлтийн бүс нутгийн иргэд өдөр тутамдаа хамгийн наад захын үндсэн хуульд заасан эрхээ эдэлж чадахгүй, мөн хуулиа мэдэхгүйгээс болж тулгамдаад буй асуудлаа хэрхэн яаж шийдүүлэхээ мэдэхгүй байгаа нь тэдний эрхийг ноцтой зөрчих үйлдлийг өөгшүүлэх боломж олгосоор байна. Ирээдүй үе хойчдоо нүүдэлчин өв, соёлоо өвлүүлэх нөхцөл боломж улам хумигдаж, бахархал болсон зэрлэг онгон байгалийн бүтэц мөн чанар эвдрэн сүйдэж, устаж байгаад харамсаж байна. Иймд нүүдлийн аж ахуй эрхлэн аж төрж байгаа малчин иргэдийн эрх зүйн орчныг сайжруулах хуулийн зохицуулалт нэн шаардлагатай байна.

Товчилсон үгийн тайлбар

АМГТГ- ашигт малтмал газрын тосны газар

ХЭҮК – хүний эрхийн үндэсний комисс

ХЗҮХ – хууль зүйн үндэсний хүрээлэн

ИТХТ- иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч

ТББ – төрийн бус байгууллага

Оршил

Хүний хэрэгцээ бол хязгааргүй. Хязгааргүй хэрэгцээг хангахын тулд сэргээгдэх болон сэргээгдэхгүй баялгийг хүн төрөлхтөн хэт их ашиглаж байна. Мэдээж сэргээгдэх баялгаа боловсруулан ашиглах нь оновчтой боловч нөхөн сэргээгдэхгүй баялагтаа хайр найргүй хандах нь өөрөө экологийн асар хүнд нөхцөл байдлыг дэлхий дахинаа үүсгэх аюултай. Миний ажигласнаар ядуу буурай орны байгалийн баялаг руу хүчтэй улс гүрэн нь илүү их анхаарал хандуулж, байгалийн баялгийг нь авч ашиглах явдал түүхэн дэх колоничлол шиг байсаар байгаад санаа их зовниож байна.

Улс орны хөгжил дэвшлийг хүмүүсийн амьдралын наад захын хэрэглээгээр, харагдах байдлаар дүгнэж болохгүй. Улаанбаатар хотод Монгол Улсын нийт хүн амын 50 шахам хувь амьдардаг хэдий ч нийслэлээр зөвхөн улс орны хөгжлийг төсөөлж болохгүй. Энэ өргөн уудам газарт тарж суурьшсан

бүх хүмүүс мөн газар, хөрс, ус, ургамал, ой мод, ан амьтан, агаар байгалийн баялаг гээд энэ бүгд нэг цул байж, байж бид нэг улс гүрэн өнө мөнхөд оршиж чадна. Харин сэндийчүүлсэн хөрстэй, ухуулсан уултай, усгүй худагтай, малгүй нүүдэлчин гэх түүхтэй, хэдэн машин, хэдэн байртай, цөлжилт газар нутгийг бүрхсэн, хүчтэй, мөнгөтэй, идсэн, завшсанууд нь гадагшаа гараад, гаднаасаа монголоо хараасан, шүүсэн, өрөвдсөн, тэгсэн хэр нь өөрсдөө гадны орондоо үе удмаараа гадны хүн гэдэг тодотголтой болж амьдарч байгаагаа зөв алхам гэж бодон, өнөө маргаашийн хэрэгцээндээ дарагдсан өнөө үеийнхэн газар шороотойгоо, үүх түүхтэйгээ, улстайгаа уусан замхрах эрсдэлтэй байна.

2019 оны судалгаагаар монголын 10 хүн тутмын нэг нь өөр оронд амьдрахыг илүүд үзсэн. Хамгийн эмгэнэлтэй нь Монголдоо үлдсэн 21-48 насныхны дунд судалгаа явуулахад тэдний 79 хувь нь гадаадад гарч амьдрах хүсэлтэй хэмээн хариулжээ. Тэдний хувьд явах боломжгүйдээ л Монголд байгаа хэрэг. Хэрэв боломж нь олдоод виз нь гарчихвал залуусын дийлэнх нь нутгаа орхиод явахад бэлэн гэсэн үг. Харамсалтай хэдий ч өнөөгийн бидний бодит байдал ийм л байна¹. Энэ үзүүлэлт 2022 оны хувьд нэмэгдсэн байх магадлал өндөр юм.

Мэдээж хэрэг эх нутгаа гэсэн монгол хүн ийм ирээдүйг хүсэхгүй нь тодорхой. Өвөг дээдсийн халуун амь, цусаа урсган тэмцэж, тунхагласан тусгаар тогтнолын үнэ цэнийг үеийн үедээ монгол хүн бүр өвлүүлэн үлдээсэн газар нутгийг аль болох унаган төрхөөр нь хэвээр хадгалж авч үлдэх, байгалийн болон нийгмийн хувьд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ирээдүй хойч үедээ экологийн тэнцэл нь алдагдаагүй хүрээлэн буй орчныг үлдээхийн төлөө хүн бүр дор бүрнээ санаж явах учиртай.

Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх

Би цөөнгүй жил гадны 3 ч улсад сурч, ажиллаж яваад ирсэн. Дайны хөлд нэрвэгдээд дахин бүтээн байгуулалт хийсэн улс орнуудын ой модноос хэзээ ч миний эх орны ой модноос үнэртдэг шиг тийм гоё чийглэг, тансаг үнэр үнэртдэггүй. Энэ юу хэлж байна гэхээр хүний гараар бүтсэн ямар ч байгалийн тогтоц яг жинхэнэ байгаль шиг хэзээ ч байж чадахгүй.

Манай улс нь нүүдэлчдийн соёл иргэншлийнхээ ачаар байгалийн онгон төрхөө харьцангуй хадгалж авч үлдсэн цөөхөн хэдэн улсын нэг гэж саяхныг хүртэл бахархаж ирсэн билээ. Үүний цаад гол шалтгаан нь өнө эртнээс уламжлагдан ирсэн байгальтайгаа зөв зохистой харьцах, хайрлах, хамгаалах уламжлалт ёс заншлын үр нөлөө юм. Гэвч одоо онгон зэрлэг байгальтай улс

¹ <https://qogo.mn/riqd967>

гэж бахархдаг бахархал маань 1990 оноос хойш хэт их байгалийн баялагруугаа төвлөрсөн бодлого, үйл ажиллагаанаас үүдээд үгүй болох эрсдэл тулгарч байна.

Монгол Улсад өнөөдөр уул уурхай ашигт малтмалын сургалтанд 100 шахам хүн оролцож байхад байгаль орчноо хамгаалах, хүний эрхийн мэдлэг олгох сургалтанд 30 хүрэхгүй хүний ирцтэй оролцож байна. Энэ төрийн бодлого үйл ажиллагаа хаашаа илүү төвлөрч нийгэмд ямар салбар чухал байр суурь эзэлж байгааг илэрхийлнэ. Гэтэл энэ жил Сүхбаатарын талбай дээр зулсан хиймэл зүлгэн дээр хүмүүс хөөрөлдөн инээлдэж, найзуудаараа, гэр бүлээрээ цуглан сууж, хүүхдүүд зүлгэн дээр хөгжилдөн гүйлдэж байгааг хараад эцсийн эцэст хүн байгалийн хүйн холбоог ямар ч өндөр барилга, ямар ч үнэтэй байшин, машин нөхөж чадахгүйг мөн ард түмэн үнэндээ яг ямар орчинд амьдрахыг хүсэж байгааг тодорхой илэрхийлж байна.

Мэдээж байгалийн баялгаа ашиглаж улсдаа олох үр өгөөжөө нэмэгдүүлэх нь нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал байр суурь эзэлж байгаа нь ойлгомжтой. Уул уурхайн салбар нь Монгол Улсад 2019 оны гүйцэтгэлээр ДНБ-ний 25 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 72 хувь, экспортын 90 хувийг тус тус бүрдүүлжээ. Гэвч уул уурхайн олборлолт, үйлдвэрлэлээс нийгэм, хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг зохицуулах асуудал нь Монгол

Улсын хувьд томоохон сорилт болдог. Тиймээс уул уурхайн болон бизнесийн төслүүдэд хүний эрхийг хүндэтгэх, хангах чиглэлээр бусад улсын хуримтлуулсан туршлага, сургамжаас суралцах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлох шаардлага зүй ёсоор тавигдаж байна².

Уул уурхайн салбарт илүү анхаарсан улс орны ард түмний хамгийн түгээмэл зөрчигддөг эрх бол эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн асуудал эхний эгнээнд байдаг.

1972 оны 6 дугаар сард анх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүрээлэн буй орчны асуудлаарх чуулга уулзалтаар Стокгольмын тунхаглалыг баталж, “Хүн бүр эрхэмсэг, сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн дээд зэргийн орчинд эрх чөлөөтэй, эрх тэгш байх, амьдралын таатай нөхцөлөөр хангагдах үндсэн эрхтэй агаад одоо ба хойч үеийнхээ өмнө хүрээлэн буй орчноо хамгаалах, хөгжүүлэх журамт үүргийг хүлээнэ³” хэмээн хүн төрөлхтний оршихуйн үндсийг тодорхойлсон байдаг.

1981 онд баталсан Хүний болон ард түмний эрхийн тухай Африкийн Хартид зааснаар хүрээлэн буй орчин дахь хүний эрхийн талаар олон улсын түвшинд хүлээн зөвшөөрч эхэлсэн байна. Хүрээлэн буй

² ХЭҮК “Хүний эрхэд суурилсан хандлага”. УБ., 2020 он. 4 дэх тал

³ Хууль зүйн үндэсний хүрээлэн “Эрдэс баялгийн эрх зүйн тойм”. УБ., 2012 он. 193 дахь тал

орчинд хүний үзүүлэх нөлөө улам ихсэхийн хэрээр хүрээлэн буй орчин дахь хүний эрхэд улам их асуудал тулгарч байгааг илэрхийлж байна⁴. НҮБ-н дараа дараагийн хүрээлэн буй орчин ба хүний эрхийн талаарх олон улсын хурал хэлэлцүүлэг улам өргөн хүрээгээр зохион байгуулагдаж байгааг харахад энэ салбарын асуудал дэлхий нийтээр улам өргөн хүрээтэйгээр анхаарал хандуулж байгааг харуулж байгаа юм.

Монгол улсын Үндсэн хуулийн 6-р зүйлийн хоёрт зааснаар "... Монгол улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг ой усны нөөц анамьтан төрийн нийтийн өмч мөн. Түүнчлэн байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш шударгаар хүртээхэд чиглэнэ. Мөн иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар мэдэх эрхтэй..." гэж тус тус хуульчилж өгсөн байна.

Үүнээс үзвэл манай улсын хууль хүний эрхийн маш мэдрэмжтэй, зөв шударга, байгаль орчны тэнцвэрт байдалд их ач холбогдол өгсөн мэт харагдаж байгаа боловч бодит байдал дээрээ энэ нь үнэнд нийцэхгүй, хэрэгжихгүй байгаа юм.

⁴ Мөн тэнд: 192 дахь тал

Мөн "сөрөг нөлөөллийн талаар мэдэх эрхтэй" гэж заасан мэдэх гэдэг нь үндсэн хуулийн бас нэг бөөрөнхийлсөн байдал юм. Иргэд мэдээд цааш нь хэрхэх ёстойг үндсэн хуульдаа заавал оруулах хэрэгтэй. Тэгж байж энэ заалтын үйлчлэх хүрээ бодитойгоор илүү үр дүнтэй хэрэгжих болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.2-т баталгаажуулсан "...эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах..." эрхийн хүрээнд маш олон судалгаа эрдэм шинжилгээний ажил, судлаач, шинжээчдийн бүтээлүүд илүү их судлагддаг болсон байна.

Гэвч дийлэнх хүн амын олонх зонхилсон газар хүний эрх илүү их яригдаад эсрэгээрээ нүүдлийн соёл иргэншлээ хадгалан амьдарч байгаа малчин иргэдэд тулгарч байгаа асуудлаар хийсэн судалгаа шинжилгээ алга дарам байгаа нь харамсалтай. Нэг талаас Улаанбаатар хотын иргэн, нөгөө талаас орон нутгийн тэр дундаа уул уурхай, тээвэрлэлт, олборлолтын бүсэд байгаа иргэн хоёрын эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн улмаас тулгамдаж буй асуудал ялгаатай илэрч байна гэж харж байна. Хотын амьдралыг тог цахилгаан, халуун ус, дулаан байргүйгээр төсөөлөхөд бэрх. Үүнтэй адил малчин хүний амьдралыг малын бэлчээр, ус, хөрс, цэвэр агааргүйгээр оршин тогтнох аргагүй билээ.

Орон нутаг дахь эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт

Өнөөдөр улсын хэмжээнд 2022 оны 4 сарын 30-ны байдлаар ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл 2591 олгогдсон байгаагаас ашиглалтын тусгай зөвшөөрөл 1697, хайгуулалтын тусгай зөвшөөрөл 894 байна. Энэ нь нийт нутаг дэвсгэрийн 3,9% -ийг эзэлж байна⁵ гэжээ. Мөн эдгээр уул уурхайн лицензийн дийлэнх нь говийн аймгуудад байна. Тэр дундаа Өмнөговь аймаг бол том төлөөлөл юм. Харин Өмнөговь аймгийн Цогт-Цэций сум сүүлийн жилүүдэд маш хурдацтай хөгжиж байгаа үүнийгээ дагаад хүний эрхийн зөрчлүүд гарч байна. Үүнд тоосжилт, усны чанар хүртээмж, бэлчээрийн доройтол хомсдол, хүн малын эрүүл мэнд гээд асуудал илүү олныг хамарсан байдалтай байсаар л байна.

Цогтцэций сум нь Сийрэст, Билгэх, Цагаан-Овоо, Өгөөмөр гэсэн 4 багтай. Тус сумын Цагаан-Овоо, Сийрэст багуудын 2557.4 га нутаг дэвсгэр дээр Тавантолгойн уурхайн олборлолтын үйл ажиллагаа явагдаж байна. Түүнчлэн экспортын нүүрс тээвэрлэх 44.4 км засмал зам, 55.9 км төмөр замын трассын зориулалттай далан дайран гарч байна. Түүнчлэн нүүрс тээврийн олон тооны шороон замууд тус сумын нутаг дэвсгэрийг дайран гарсан байна⁶. Энэхүү

шороон тээвэрлэлтийн улмаас хэт их тоосжилт үүсч хүн, малын эрүүл мэндэд хамгийн их сөргөөр нөлөөлж байгаа юм.

Агаар бохирдуулах бодисын хүлцэх агууламж, агаарт үзүүлэх физикийн хортой нөлөөллийн төвшний хэм хэмжээ, түүнчлэн хөдөлгөөний эх үүсвэрийг төрөл бүрийн агаарт гаргах, бохирдуулах бодисын хүлцэх агууламж, физикийн хортой нөлөөллийн төвшний хэм хэмжээ, тэдгээрийг тодорхойлох аргыг стандартаар батална⁷.

Цогтцэций сумын Цаг уурын ажиглалтын харуул 2015 онд сумын төв орчим хийх тоосжилтын хэмжилт хийх Dust Trak багаж ашиглан сумын төв орчмын тоосжилтын түвшинг сард 4-5 удаа 24 цагийн дунджаар хэмжих болсон байна. Тус харуулаас 2017 онд хийгдсэн тоосжилтын хэмжилтээр Цогтцэций сумын төвийн орчмын тоосжилт хавар, зуны саруудад зөвшөөрөгдөх түвшнээс хоёр дахин, түүнээс илүү хэтэрсэн гэж тэмдэглэжээ⁸. Өнөөгийн байдлаар нутгийн иргэдийн хамгийн түгээмэл өвчлөл бол харшил, амьсгалын замын өвчин юм.

Агаарын тоосжилт их байхын хамгийн их аюул нь уушги тоосжих буюу пневмокониоз өвчин үүснэ. Уушги тоосжих өвчний хамгийн хүнд хэлбэр нь силикоз буюу уушги цахиуржих өвчин юм. Энэ нь

⁵ АМГТГ "Эрдэс баялгийн статистик мэдээ" УБ., 2022 он. 3 дахь тал

⁶ ХЭҮК "Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ". УБ., 2020 он. 88 дахь тал

⁷ ХЗҮХ "Эрдэс баялгийн эрх зүйн тойм" УБ., 2012 он. 181 дэхь тал

⁸ ХЭҮК "Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ" УБ., 2020 он. 92 дахь тал

цахиурын давхар исэл ихтэй тоосны нөлөөгөөр үүснэ. Хамгийн аюултай нь уул уурхай, нүүрсний уурхайн хөрсний давхаргын найрлагад цахиурын исэл их хэмжээтэй байдаг⁹.

Өмнө хэлсэнчлэн малчин хүнд ус, бэлчээр бол амин сүнс юм. Говийн бүсийн малчдын хувьд худгийн асуудал тулгамдсан асуудал байж ирсэн. Үндэсний статистикийн хорооны мэдээллээр Өмнөговь аймгийн зүүн бүсийн ихэнх сумдын хувьд худгийн тоо нэмэгдсэн бол Цогтцэций сумын хэмжээнд малчдын худгийн тоо сүүлийн жилүүдэд огцом буурсан байна. Жишээ нь Цагаан овоо багт малчны энгийн уурхайн худаг 60 орчим байснаас одоогийн байдлаар 10 хүрэхгүй шахам болсон байна¹⁰. Энэ нь тухайн бүс нутаг ямар их экологийн гажуудал үүсч байгааг харуулж байна.

Түүнчлэн малчид сэтгэл санаагаараа, эд хөрөнгөөрөө хохирч, эргээд хариуцлага тооцох гэхэд эзэн олдохгүй хохирлоо барагдуулж чаддаггүй асуудал их түгээмэл болсон. Жишээ нь Нүүрс тээвэрлэдэг машинууд хурд хэтрүүлж явснаас эсвэл шөнө тээвэр хийдгээс нь болж малаа дайруулсан тохиолдол нэлээдгүй байна. Үүнээс үүдээд хэнд, хаана хандахаа мэдэхгүйгээс хохирлоо барагдуулж чадахгүй арга мухардсан иргэд олон.

⁹ Монгол улсын хөдөлмөрийн яам "Бичил уурхайн хөдөлмөрийн нөхцлийг сөрөг хүчин зүйлс түүнээс урьдчилан сэргийлэх нь" УБ., 2015 он. 23дахь тал
¹⁰ ХЗҮК "Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ" УБ., 2020 он.167 дахь тал

Хамгийн гол нь орон нутгийн иргэд, малчдад тулгарч байгаа эдгээр асуудал нь гэнэт урган гарч ирээгүй юм. Анхнаасаа ашигт малтмалын лиценз олгохдоо тухайн бүсэд оршин байгаа хүний эрхийг давхар бодож, тооцоолох нь чухал юм. Ялангуяа өөрсдийн ондоошил бахархал болсон нүүдэлчин соёлоо хадгалан аж төрж яваа малчдынхаа эрх ашгийн төлөө, тэдний амьдралын онцлог хэв маягт таарсан хууль, журам гарган хүний эрхэд суурилсан хандлагыг шат шатандаа хангах хэрэгцээ ихэд дутагдаж байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүн түүний орчин эрүүл, аюулгүй байх нь зөвхөн малчин өрхөд үнэ цэнэтэй бус Монгол улсын хувьд экологийн ээлтэй хөдөө аж ахуйн эдийн засагт ч чухал ач холбогдолтой¹¹ юм.

¹¹ Хил хязгааргүй алхам ТББ "Хуулиа мэдье эрхээ хамгаалья". УБ., 2021 он. 14 дэхь тал

Дүгнэлт

Тухайн орон нутгийн иргэд хууль дүрмээ мэдэхгүй эрхээ хамгаалж чадахгүй байгаа нь үнэн боловч тэд төрж өссөн болон амьдарч байгаа нутгийнхаа онцлог үүссэн нөхцөл байдал нийтлэг ашиг сонирхол хэрэгцээ шаардлага тулгамдсан асуудлыг хамгийн сайн мэднэ. Гол нь хэчнээн мэддэг байлаа гээд төрд иргэдийн дуу хоолойг сонсох, хүлээн авах нь хэлбэр төдий зүйл болж үзэл бодлыг нь сонслоо гэхэд бодлогод тусгахгүй байгаад гол учир бий болов уу.

Хэрвээ төрийн бодлогыг “шулуун зураас” гэж үзвэл түүнтэй огтлолцох маш олон нэмэлт “зураас”-нууд бий. Төрөөрийн бодлогоо хэрэгжүүлэхдээ бусад “зураас”-тай огтлолцохгүй явбал энэ нь том гажуудал үүсгэх эрсдэлтэй. Огтлолцох “зураас” бүрт анхаарал хандуулж хоорондоо уялдаатай байх хэрэгтэй болвуу. Түүнчлэн Засгийн газар өөрсдөө орон нутгийн удирдлагууддаа эрх мэдлийнхээ хүрээнд хуульд заасны дагуу ажиллах, шийдвэр гаргах, гаргасан шийдвэр нь хэрэгжих боломжийг олгох хэрэгтэй. Орон нутгийн засаг дарга, иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нар бол хуулиар хамгаалагдсан эрх мэдэлтэй албан тушаалтан юм. Харин бодит байдал дээр аймаг, сумын удирдлагууд уул уурхайн ашиглалтын лицензээс нутаг усаа хамгаалахын тулд арга хэмжээ авах гэхээр хэрэгжих боломжийг нь хааж байгаа тохиолдлууд цөөнгүй ил далд байсаар байна.

Өнөөдөр Монгол улсын эдийн засаг, хөгжил дэвшилд эрдэс баялгийн салбар чухал байр суурь эзэлж байгаа гээд хэт туйлширч хэт говийн бүс рүү төвлөрүүлэн лиценз олгож байгаа нь говийн бүсийн байгалийн тэнцвэрт байдлын алдагдлыг бий болгож байна. Ямар ч үед ирээдүй хойч үеийнхээ хөгжлийн боломжийг өнөө үеийнхэн хулгайлж болохгүй. Өрх айл ч гэсэн ийм л зарчим баримталдаг монгол уламжлалтай билээ.

Санал

Уул уурхай нөхөн сэргээлтийг ном журмынх нь дагуу хийсэн тохиолдол алга дарам мөн нөхөн сэргээлтийн үйл явцыг цаг тухайд нь дүгнэн шалгаж хуулийн дагуу шаардаж, хариуцлагыг ноогдуулах тогтолцоог бодитой хэрэгжүүлэхгүй атлаа лицензийн тоо нь 2500 давсан байна. 30 гаран жил уул уурхайгаа эрчимтэй ашиглаж байгаа ч уурхайн хаалт хийсэн тохиолдол тийм туршлага огт байхгүй байна. Энэ нь төрөөс маш тодорхой эрх зүйн зохицуулалтыг шаардаж байгаагийн тод жишээ юм.

Иймд дэвшүүлж байгаа санаагаа нэгтгэхэд:

1. Хууль эрх зүйн орчин нь бодитой дорвитой хэрэгждэг байх
2. Хүний эрхэд суурилсан хандлагатай бизнесийн үйл ажиллагааг баталгаажуулах, зөвхөн төр үүрэг хүлээдэг биш бизнесийн байгууллагууд хүний эрх, байгаль орчны талаар

үүрэг, хариуцлага хүлээдэг зохицуулалттай байх

3. Байгаль орчны үнэлгээ хийдэг компаниудын явцыг хянадаг шинэ механизмтай болох эхнээс нь эцсийн нь хүртэл хууль ёсны дагуу үйл ажиллагааг хяналтыг биелүүлэх
4. Нөхөн сэргээлтийн болон Уурхайн хаалтын бие даасан шинэ хууль гаргах түүний хэрэгжилтийг хянадаг шинэ залуу эх оронч боловсон хүчинг бэлдэх
5. Иргэд мэдээллийг зорьж очиж авдаг биш тэдэнд мэдээлэл явал хурдан шуурхай хүргэх талаар илүү ажил хэрэгч хандах, ялангуяа иргэдэд тухайн бүс нутагтаа байгаль орчинтой холбоотой ямарваа шийдэл шийдвэрийн мэдээллийг түлхүү хүргэж энэ талаарх асуудалд олон нийтээрээ хамтдаа оролцож, эцсийн шийдвэрт орон нутгийн иргэдийн саналыг шийдвэртээ бодитоор тусгадаг байх
6. Иргэдийн оролцоо, олон нийтийн хяналт их чухал тусгагдах эдгээр саналуудыг дэвшүүлж байна.

БҮХ НАСААР ХОРИХ ЯЛЫН ЗАРИМ ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ НЬ



Шихихутуг их сургуулийн
магистрант Д.Цэрэнпагам

242

Товч утга: Бүх насаар хорих ялын эрх зүйн зохицуулалттай холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтуудад судлаачийн зүгээс дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлон, өөрийн санал дүгнэлтийг илэрхийлсэн болно.

Түлхүүр үгс: Үндсэн хууль, Олон улсын баримт бичиг, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх тухай хууль, Бүх насаар хорих ял;

НЭГ. УДИРТГАЛ

Эрүүгийн хариуцлага, “Ял” нь хоорондоо зарчмын ялгаатай ойлголтууд бөгөөд эрүүгийн хариуцлага нь ялыг өөртөө багтаадаг өргөн хүрээтэй институц юм¹. Бүх насаар хорих ял нь бусад ялын төрлөөс хамгийн хүнд ял бөгөөд уучлал, өршөөлөөр урьдчилан суллагдах ямар ч боломжгүй байдгаараа ач холбогдолтой бөгөөд

цаазын ялаас² ийнхүү ялгаатай. Цаазаар авах ялыг халаад бүх насаар хорих ялын төрөл орлуулж ирсэн практиктай улсуудын эрдэмтэн, судлаачид бүх насаар хорих ял цаазаар авах ялыг орлох боломжтой, илүү үр нөлөөтэй гэж үздэг³. Цаазаар авах ялыг халснаар бүх насаар хорих ялын төрөл нэмэгдсэн нь энэхүү судалгааг хийх үндэслэл болж байна.

Өгүүллийн гол зорилго нь бүх насаар хорих ялын эрх зүйн зохицуулалтын хийдлийн талаар тухайлан судалж, холбогдох эрх зүйн зохицуулалтын талаар өөрийн дүгнэлт болон саналыг илэрхийлэх явдал болно. Шинэчлэн найруулсан хуулийн үг хэллэг нь хоригдлуудын эрхийг хангах эсэх нь эргэлзээтэй байдлаар хуульчилсан байгаа бөгөөд энэхүү асуудлыг тус өгүүллийн дүгнэлт, саналд дэлгэрэнгүй өгүүлэх болно.

ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ

Хууль зүйн ухааны профессор, Гавьяат хуульч Б.Чимид “*Нүгэлтэнд ч ирээдүй бий. Гэгээнтэнд ч өнгөрсөн бий*” хэмээн оновчтой тодорхойлжээ.

² Эрүүгийн хууль. УБ., 2002 он. 53р зүйл. Цаазаар авах ял.

Монгол улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт амьд явах эрхийг заахдаа Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэгт шүүхээс цаазаар авах ял оногдуулах боломж байхыг үгүйсгээгүй учир зөвхөн “... онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь насыг бусниулахыг хориглоно хэмээн улсын дээд шүүхээс тайлбарласан байдаг.

³ <https://mojha.gov.mn/newmojha/?p=1197>

¹ Жанцан С. Эрүүгийн эрх зүйн онол /ялын тухай сургааль/. УБ., 2014. 104 дэх тал

Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн хүн бүрт бүх насаар хорих ялыг оногдуулах боломжгүй. Ямар ч нийгэмд гэмт хэрэг үйлдсэн хүнийг ял оногдуулах боломжтой боловч мөн засаж, хүмүүжүүлэх, гэмт хэргээс ангид байх боломжийг тэдэнд олгох учиртай. Бүх насаар хоригдож байгаа хүнд тухайн ял эдэлж байгаа газар нь амьдралын утга учир зорилгоо олохуйц өдөр тутмын хэвшил тогтооход туслах нь хүнлэг зүйл болно. Бүх насаар хорих ял эдэлж буй хүн тухайн ялын бэрх хэцүүг бүрэн дүүрэн ухаарч ойлгоход тодорхой цаг хугацаа орох нь бий.

Бүх насаар хорих ял цаазаар авах ялаас илүүтэй бусдад нөлөөлж, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж чаддаг. Монгол Улс цаазаар авах ялыг практикт халсан улс байсан бол бүрэн халсан дэлхийн 103 дахь улс болсон⁴.

2015 онд баталж 2017 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хэрэгжсэн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад бүх насаар хорих ялын эрх зүйн зохицуулалттай холбоотой зарим заалтын талаар судлаачийн зүгээс дүн шинжилгээ хийх болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд "Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш

байна", 16 дугаар зүйлийн 13 дэх хэсэгт "Хэнд боловч ... хүнлэг бус, хэрцгий хандаж ... болохгүй" гэж тунхагласан байна. Үүнийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.9 дүгээр зүйл, 1.12 дугаар зүйлд тодорхойлбол зарчим болгож хуульчилсан нь зөрчиж болзошгүй зүйл гэдгийг баталжээ.

Цаазаар авах ялыг халсантай холбоотой бүх насаар хорих ялд ч мөн тодорхой хэмжээний давуу тал бий ажээ.

- Нөхөшгүй алдаанаас урьдчилан сэргийлэх нь ял шийтгүүлэгчийн амь нас эндэхээс сэргийлнэ;
- Хохирогчийн нөхөн төлбөрийг барагдуулах;
- Шударга ёсыг тогтоох;
- Нийгмийн үнэт зүйлийг хамгаалах;
- Үр нөлөө сайтай, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;
- Тухайн ял шийтгүүлэгчид хүнд ял;
- Ял шийтгүүлэгч буруугүй нь нотлогдвол суллагдах боломжтой;
- Ганцаарчилсан өрөөнд ял эдлэх нь гэм буруугаа ухаарч, хүмүүжих учиртай
- Шаардлагатай гэж үзвэл хорих ангийн дарга прокурортой зөвшилцөн хоригдлыг хоёроор нь хорьж болно.
- Хоригдлыг урамшуулна. Хорих ял эдлэх хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй, хуваарилсан ажил, үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэсэн, сургалт-хүмүүжлийн

⁴ <https://mojha.gov.mn/newmojha/?p=1197>

ажил болон нийгэмшүүлэх хөтөлбөрт идэвхтэй хамрагдсан, хууль тогтоомж, хорих ангийн дотоод журмыг мөрдөж байгаа байдал, өөрийн зан үйл, хувийн байдлаараа хорих ангийн дарга, алба хаагчаас зэрэг үнэлгээ авсан тохиолдолд түүнд шагналын хоног олгоно⁵;

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 11 гэмт хэргийн хүндрүүлсэн нөхцөлд бүх насаар нь хорих ялыг тусгасан. Үүнд:

10.1 дүгээр зүйл. Хүнийг алах /10.1 дүгээр зүйлийн 10.1.2 дэх хэсэг/

12.1 дүгээр зүйл. Хүчиндэх /12.1 дүгээр зүйлийн 12.1.4 дэх хэсэг/

12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг /12.3 дугаар зүйлийн 12.3.4 дэх хэсэг/

13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах гэмт хэрэг /13.1 дүгээр зүйлийн 13.1.3 дах хэсэг/

19.3 дугаар зүйл. Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах /19.3 дугаар зүйлийн 19.3.2 дах хэсэг/

19.4 дүгээр зүйл. Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах /19.4 дүгээр зүйлийн 19.4.2 дах хэсэг/

19.5 дугаар зүйл. Зэвсэгт үймээн дэгдээх

19.6 дугаар зүйл. Хорлон сүйтгэх /19.6 дугаар зүйлийн 19.6.2 дах хэсэг/

29.4 дүгээр зүйл. Дайны үед хориглосон арга, хэрэгсэл хэрэглэх

⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017 он. 224 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

/29.4 дүгээр зүйлийн 29.4.2 дах хэсэг/

29.7 дугаар зүйл. Олон улсын хамгаалалтад байдаг хүнд халдах /29.7 дугаар зүйлийн 29.7.2 дах хэсэг/

29.8 дугаар зүйл. Төррор үйлдэх⁶. Эрүүгийн хуульд заасан бүх насаар хорих ялыг оногдуулах зүйл заалтаас ажиглахад дараах нийтлэг шинжийг агуулсан байна:

- Хоёр ба түүнээс олон хүний амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан үйлдэл
- Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн
- Байнгын тогтвортой үйлдсэн
- Төрийн албан хаагчийн санаатай үйлдэл
- Төрийн албан хаагч, олон улсын хамгаалалтад байдаг хүний амь насыг хохироох
- Зэвсэг хэрэглэсэн үйлдлүүд байна. Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн зүйчлэл бүр тухайн гэмт хэргийн объектив шинж чанарт тохирсон ялыг ялгамжтай хуульчлах нь зүйтэй. Дээр дурдсан гэмт хэргийг үйлдсэн нь шүүхээр тогтоогдож бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг шударгаар ял эдэлж байгаа талаар мөн хоригдлын эрх зөрчигдөж болохуйц эрх зүйн зохицуулалт байгаа талаар асуудал дэвшүүлье.

⁶ Эрүүгийн хууль. УБ., 2015 он.

Асуудал 1. Ял буюу зэрэглэл хөнгөрүүлэх тухай асуудал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 199 дугаар зүйлийн 199.3дах хэсэгт Хаалттай хорих ангийн тусгай нэгжид бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлнэ⁷ гэх заалт мөн хуулийн 206 дугаар зүйлийн 206.5 дах хэсэгт "Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил ял эдэлсэн тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлж болно" гэж заасан нь хоорондоо зөрчилдөж болохуйц байна.

Асуудал 2. Хуулийн зарим зүйл заалт хоорондоо зөрчилдөх.

Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 5.6.5д "Энэ хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хүнийг хаалттай хорих байгууллагад тусгаарлаж бүх насаар хорих ял эдлүүлнэ", 5.6 дугаар зүйлийн 7д "Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан журмаар ялтныг суллаагүй бол хоёр жил тутам энэ талаар дахин хэлэлцэнэ" гэх заалтууд хоорондоо зөрчилдөж байна.

Асуудал 3. Шинэчлэн найруулсан хуулийн зарим үгийн сонголт.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.14 дүгээр зүйлийн 34.14.2т "Шүүх нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэн өөрчилж болно" гэж заасан нь шүүх хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэхгүй байх боломжтой

⁷ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017 он. 199 дүгээр зүйлийн 3 дах хэсэг

гэсэн ухагдахууныг агуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 199 дүгээр зүйлийн 199.4.т "Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол нь 60 хоногт нэг удаа түр, 90 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 30 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно". 199 дүгээр зүйлийн 199.5. "Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 90 хоногт нэг удаа түр, 120 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 60 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно", 200 дугаар зүйлийн 200.3д "Хоригдлыг зөвхөн хорих ангийн байранд хөдөлмөрлүүлж болно" хэмээн хуульчилсан нь эрх бүхий албан тушаалтны эрх мэдэл, албан тушаалын байдал, өөрийн үзэмжээр тухайн хоригдлын уулзалтыг мэдэгдэхгүй, утсаар ярих, илгээмж авах, хөдөлмөрлүүлэхгүй байх, тухайн эрхийг нь хязгаарлах боломжтой байх юм. 1955 оны Нэгдсэн Үндэсний Байгууллагын "Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм"-ийн 37 дугаар зүйлд заасан "Хоригдлууд ... гэр бүлийнхэнтэйгээ болон найз нөхөдтэйгөө ... захидлаар харилцах боломж олгож болно" гэсэн нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ял эдлүүлэх албан тушаалтнуудад шууд хамааралтай бөгөөд уг дүрмийн талаар сургалт зохион байгуулах нь хоригдлын наад захын эрхийг хангахад чиглэгдэх юм. Бүх насаар хорих ял шийтгэгдсэн

хоригдлын уулзалт биечлэн уулзах боломжгүй тохиолдолд бусад улс орны ар гэр, найз нөхөдтэйгөө цахим уулзалт хийх жишгийг нэвтрүүлэн цахим системийг нэвтрүүлэн техник, технологи, интернэт сүлжээний боломж бололцоог нэмэгдүүлэх нь зүйтэй.

ГУРАВ. ГАДААД УЛС ОРНЫ ТОВЧ ХАРЬЦУУЛАЛТ

Ром, Германы эрх зүйн бүлтэй улс орны хувьд авч үзвэл:

Испани: эрүүгийн хуулийн дагуу хорих ялын төрөлд шоронд хорих, амралтын өдрүүдээр баривчлах, торгууль төлөөгүй бол цагдан хорих зэрэг хамаарна. Шоронд хорих ялын үргэлжлэх хугацаа 6 сараас 20 жил байдаг. Тухайн этгээд 2 ба түүнээс дээш гэмт хэрэг үйлдэж эдгээр хэргийн аль нэгэнд 20 жилийн хорих ял оногдуулдаг бол шүүх 25 жилийн ял оногдуулдаг бол шүүх 30 жилийн хорих ял оногдуулах эрхтэй. Бүх насаар нь хорих ял Испанийн эрүүгийн хуульд байдаггүй⁹.

Австрийн эрүүгийн хуулийн дагуу хорих ял нь насаар нь хорих ба тодорхой хугацаатай байж болно. Хугацаатай хорих нь 1 өдрөөс эхлэн 20 жил хүртэл, гэмт хэрэг үйлдэх үед 20 нас хүрээгүй этгээдэд насаар нь оногдуулахгүй харин 10-20 жилийн хугацаатай хорих ял оногдуулна. Австрийн эрүүгийн хуулийн 37д заасны дагуу 5 хүртэл жилээр хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорих ялын оронд

мөнгөн торгууль оногдуулж болно⁹.

Швейцарийн эрүүгийн хуульд цөллөгийн шорон, шоронд хорих, баривчилгаа гэсэн хорих ялын төрлүүд байдаг. Цөллөгийн шорон гэдэг нь хамгийн хатуу ял ба түүнийг 1-20 жилийн хугацаатай, эсхүл насаар нь гүйцэтгэж болно. Хуульд өөр заалт байхгүй нөхцөлд 3 өдрөөс 3 жил хүртэл хугацаагаар шоронд хорих ял оногдуулна. Швейцарийн эрүүгийн хуульд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хэд хэдэн хэм хэмжээ байдаг. Цөллөгийн шоронд байх ялын гуравны хоёрыг эдэлсний дараа, шоронд хорих ялын 3 сараас багагүй хугацааг эдэлсний дараа, шоронд хорих ялын 3 сараас багагүй хугацааг эдэлсний дараа тэнсэнгээр чөлөөлж болно¹⁰.

Испанийн эрүүгийн хуульд хорих ялыг хугацаатай байхаар заасан бөгөөд 6 сараас 20 жил, гэмт хэрэг үйлдсэн байдлаас шалтгаалан 30 жилийн хорих ялыг оногдуулж болох заалттай бөгөөд бүх насаар хорих ялын эрх зүйн зохицуулалт байхгүй талаар онцолсон байдаг. Австри болон ХБНГУ-ын эрүүгийн хуульд хорих ял нь хугацаатай ба хугацаагүй байж болно гэж заасан байдаг нь сонирхолтой. ХБНГУ-ын эрүүгийн хуульд хэд хэдэн гэмт хэргийг онцлон түүнд хугацаагүй хорих ялын санцгийг заасан байдаг. Харин Австрийн эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээ нь 20 жил хэмээн заажээ. Тэгэхээр Австрийн эрүүгийн хуульд насаар нь буюу хугацаагүй

⁹ Жанцан С. Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол /ялын тухай сургааль/. УБ., 2014 он. т-423

⁹ Мөн тэнд. т-423

¹⁰ Мөн тэнд. т-423

хорих ялын санкц байдаггүй байна. Швейцарийн эрүүгийн хуульд хорих ялыг 3 төрлөөс 1-20 жилийн хугацаатай хорих ял байдгаас гадна насаар нь хорих ял гүйцэтгэж болно хэмээн заажээ. Үүнээс үзэхэд дээрх судалгааны дагуу бүх насаар хорих ялын хугацааны хувьд хугацаагүй байхаас дийлэнхдээ 20 жилийн хугацаагаар тодорхойлсон байдаг. Дэлхийн улс орнуудын эрүүгийн хууль дах ялын тогтолцоог тогтоох үзэл баримтлал нь аливаа өөрчлөлтөд тэсвэртэй онолыг сэтгэгчид бий болгосон нь ийнхүү харагдаж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Бүх насаар хорих ялын цээрлүүлэх зорилго зонхилж хүмүүжүүлэх зорилго орхигддог тал бий. Олон жил хоригдсон хүн нийгмийн хөгжлийг гүйцэх боломжгүй, нийгэмшихэд чадвар боломж хомс. Дэлхийд хорих ялыг хугацаагүй, хугацаатай гэж ангилдаг бөгөөд 112 орчим улс хэрэглэдэг. Харин уг ялыг огт хэрэглэдэггүй буюу ялын ийм төрөл байхгүй орнуудад Андорра, Афганистан, Боливи, Босни, Бразил, Венессуэль, Дорнод Тимор, Ирдани, Норвеги, Парагвай, Перу, Португали, Сальвадор, Серб, Уругвай, Черногор, Эквадор зэрэг болно¹¹.

Хууль зүйн ухааны профессор, Гавьяат хуульч Б.Чимид *"Тогтвортой хуульгүй бол тогтворжсон нийгэм төлөвшихгүй"*

¹¹ Баярсайхан Д. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2011.

хэмээн тодорхойлсон байдаг. Манай улсын түүхэн уламжлалыг Хүннүгийн үед баримталдаг хууль, дундад зууны үеийн оршин тогтнож байсан Их Монгол Улсын үед мөрдөж байсан Их засаг хууль, Халх журам, 1926 оноос хойш хэрэглэж байсан Шүүх цаазын бичиг, 1942 оны эрүүгийн хууль, 1961 оны эрүүгийн хууль, 1986 оны эрүүгийн хууль, 2002 оны эрүүгийн хууль, 2015 оны эрүүгийн хууль зэргийг судлан үзэхэд нийгэм өөрчлөгдөх болгонд хууль даган өөрчлөгдсөөр байсан нь харагдаж байна. Хууль, эрх зүйн зохицуулалтын алдаа тодхон бичигдэн үлдсэн учир одоо бид тогтвортой хуулийг бүтээх болгох бүрэн боломж бий. Хуулийг бүтээхдээ бидний анхаарах нэн шаардлагатай зүйл бол хууль хоорондын уялдаа холбоог нягт болгох, хуулийн үгний сонголтыг энгийн иргэдэд ойлгомжтой байдлаар найруулах мөн тайлбар оруулах. Аливаа хуулийн хүчин чадал тогтвортой хуульд оршино.

ТАВ. САНАЛ

1. Эрүүгийн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай, тэдгээрийн уялдаа холбоог тодорхой тусгах;
2. Эрүүгийн хууль болон холбогдох хуулийн зарим заалт дахь үгийн сонголтыг оновчтой болгох. Бүх насаар хорих ял гэдэг нь үхэн үхтэл гэж ойлгох уу, 25 жилийн хугацаатай хорих ял шийтгэхийг ойлгох уу гэдгийг хуулийн 5.6

дугаар зүйлийн доор нэмэлт тайлбар оруулах нь зүйтэй, Хоригдлыг зөвхөн хорих ангийн байранд хөдөлмөрлүүлж болно гэж заасан нь хөдөлмөрлүүлэхгүй байх боломжтой гэсэн давхар утга агуулагдаж байна;

3. Хоригдлыг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх асуудлыг дээшлүүлэх буюу түүний чанар үр нөлөөг дээшлүүлэх;
4. Хоригдлын эдлэх эрх, эрх чөлөөг хангах талаарх асуудлыг оновчтой тодорхойлох;
5. Бүх насаар хорих ялын талаар иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах;
6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;
7. Цахим дэлгүүрээс үйлчилгээ авах эрхтэй, эрүүгийн хууль, тогтоомжид хуульчлах шаардлагатай бөгөөд цахим систем нэвтрүүлэх;
8. Хорих ял эдлүүлэх тогтолцоотой холбоотой дэглэм, зэрэглэлийн асуудлыг онолын болоод хууль тогтоомжийн хүрээнд тодорхой болгох. Тухайлбал: эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 5.6.6д "гэмт хэрэг үйлдсэн хүнийг хаалттай хорих байгууллагад тусгаарлаж бүх насаар хорих ял эдлүүлнэ", Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 199 дүгээр зүйлийн 199.3д "хаалттай хорих ангийн тусгай нэгжид бүх насаар хорих ял эдлүүлнэ" гэж тус тус заасан нь тусгай нэгж нь хаалттай хорих

ангийн төрөл, дэглэм, зэрэглэл эсэх нь тодорхой бус байна. ШШГТХ-ийн 206 дугаар зүйлийн 206.5д "Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хаалттай хорих ангийн зэрэглэлд 10 жил ял эдэлсэн тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлж болно" гэж заасан нь тусгай нэгжээс тусгай зэрэглэлд шилжих бололцоог олгож байгаа ба энэ тохиолдолд хэрхэн шилжүүлэхээ улмаар мөн хуулийн 195 дугаар зүйлийн 195.4т заасан "Хорих ангийг татан буулгах, өөрчлөн зохион байгуулах, хоригдлыг эзэмшсэн мэргэжлийн дагуу хөдөлмөрлүүлэх, хорих анги, хоригдлын аюулгүй байдлыг хангах, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд хоригдлыг анх хуваарилсан хорих ангиас өөр хорих ангид шилжүүлэхийг хориглоно" гэсэн заалттай зөрчилдсөн эсэхийг шалгах. Бүх насаар хорих ялыг эдлүүлэх ажиллагаа нь аюулгүй байдлыг хангах, нийгэмшүүлэх ажлын хувьд онцлогтой тул тусгайлан журам зааврын хүрээнд явуулах. Угтаа шүүхийн шийдвэрт заасан хаалттай хорих тусгай нэгжид ял эдэлж дуусах хүртэл хоригдох тухай ойлголтыг агуулах бөгөөд зэрэглэл хөнгөрүүлэхгүй байх нь зүйтэй.

ЗУРГАА. ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль.
УБ., 1992он
2. Эрүүгийн хууль. УБ., 2015он
3. Эрүүгийн хэрэг хянан
шийдвэрлэх тухай хууль. УБ.,
2015 он
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
тухай хууль. УБ., 2017 он
5. Хоригдолтой харьцах наад
захын жишиг дүрэм., 1955 он
6. Жанцан С. Монгол улсын
эрүүгийн эрх зүйн онол /ялын
тухай сургааль/. УБ., 2014 он
7. [https://mojha.gov.mn/
newmojha/?p=1197](https://mojha.gov.mn/newmojha/?p=1197)

Гэрээний зарчмын онолын хандлагуудын хэрэглээний зарим асуудал
Some issues in the application of theoretical approaches to contract



Шихихутуг их сургуулийн
магистрант Г.Ариунболор

Түлхүүр үгс: Гэрээний эрх зүй, Гэрээний зарчим, Гэрээний онолын хандлагын хэрэглээ
Contract law, The principle of the contract, Application of contract theory approach

Товч агуулга: Эдийн засгийн харилцаа өргөжсөн цаг үед гэрээг тодорхойлох, түүний агуулгыг зөв зохистой тодорхойлж практикт хэрэглэхэд хувийн эрх зүй дэх эдийн засгийн онол болон нийтийн эрх зүй дэх шударга ёсны онолыг хослуулан, тэдгээрийн тэнцвэрийг хангаж хэрэглэх шаардлага дэлхий дахины зах зээл, бизнесийн харилцаанд тулгарч байна. Гэрээ нь нэг талаас эдийн засгийн хэрэглэгдэхүүн боловч нөгөө талаас оролцогчдын эрх, үүргийг тодорхойлдог хамгаалалтын хэрэгсэл, ёс зүйн хэм хэмжээний баталгаа болох тул дээрх зарчмын онолын хандлагуудыг Монгол улсын хувийн эрх зүйн хүрээнд хослуулан хэрэглэх боломжтой эсэхийг тогтоохыг зорьсон болно.

Summary: Improve economic theory and fair theory based on social consensus in private law aimed at defining contracts, their proper use and practical application in times of intensification of economic relations, reforming the method of maintaining balance, and supporting enterprises and enterprises. Since the agreement is not only an economic instrument, but also a guarantee of the rights, protections and norms of the participants, on the one hand, it aims to establish the theoretical approaches of the above principles to Mongolia's private legal structure.

Өмнөтгөл

Аливаа орны хувийн эрх зүйн салбарын зайлшгүй судлах зүйлд гэрээний эрх зүй хамаарна. Эдийн засаг, соёл, бизнес, ёс зүй зэрэг бүхий л төрлийн нийгмийн харилцаанд "гэрээ"-тэй үл холбогдох хэсэг цөөн бөгөөд гэрээг судалж, гэрээний соёлыг нэмэгдүүлэх нь хууль эрх зүйн төдийгүй нийгэм, соёлын өндөр ач холбогдолтой юм. Хувийн эрх зүйн гэрээний хувьд нийтийн эрх зүйн болон бусад төрлийн гэрээнээс зарчим, зохицуулалт, хүсэл зориг, зохицуулалтын шинжээр ялгагдах бөгөөд сонгодог утгаараа "гэрээ" болгож буй үнэт зүйл нь түүний "зарчим буюу principle" юм. Иймд гэрээний эрх зүйн онолын хандлага, зарчмын практик хэрэглээний талаар гэрээний эрх зүй судлаачид болон

гэрээний чиглэлээр дагнан мэргэшиж буй эрх зүйч, хуульчид нарийвчлан судлах шаардлагатай байгаа ба манай улсад энэ төрлийн судалгаа гол төлөв Иргэний эрх зүйн үүргийн харилцааны зарчимд хамааруулсан байдлаар хийгдэж иржээ. Гэрээний зарчмын эдийн засгийн болон залруулах шударга ёсны онолын хандлагыг 2003 онд Стэнфордын их сургуулийн судлаачид Гэрээний эрх зүйн зарчмын хэрэглээний практикт хэрэглэхийг санал болгож байсан бөгөөд Монгол улсын хууль зүйн практикын хувьд эдийн засгийн хандлагыг түлхүү Иргэний эрх зүйд, харин Залруулах шударга ёсны хандлагыг Зөрчлийн эрх зүйд түлхүү хэрэглэж тогтжээ. Гэсэн ч энэхүү ялгамжтай байдал нь дээрх онолын хандлагуудыг судлаагүй гэсэн үг биш бөгөөд Х.Сэлэнгэ "Эдийн засгийн өмнө хүлээх эрх зүйн үүрэг, хариуцлага / онол, практикын зарим асуудал", УБ., 2012 эрдэм шинжилгээний өгүүлэл, Х.Сэлэнгэ, "Эрх зүй ба эдийн засаг", УБ., 2016 эрдэм шинжилгээний өгүүлэл, Л.Банзрагч, "Гэрээний эрх зүйн онол, арга зүйн асуудал", УБ., 2017, М.Хатанзориг, "Гэрээний эрх чөлөө ба гэрээнд тавигдах хэлбэрийн шаардлага", УБ., 2018, Т.Мэндсайхан "Гэрээний эрх зүй", УБ., 2021 бүтээлүүдэд тус тус судлагдсан байна. Дээр дурдсанчлан гэрээний зарчмын онолын хандлагуудыг Иргэний эрх зүйн ерөнхий ангийн судлах зүйлд хамааруулсан байх тул хувийн эрх

зүй тэр дундаа Гэрээний эрх зүйн тусгай онолын хандлага болохын хувьд практикт хэрэглэхэд тулгарч буй зарим асуудлыг хөндөхийг зорьсон болно.

Гэрээний эрх зүйн зарчим, онолын хандлагын хэрэглээний хувьд Иргэний эрх зүй дэх үүргийн нийтлэг үндэслэл, зарчмуудаас салган авч үзэх нь эдийн засаг, бизнесийн харилцаа өргөжин тэлж буй 21-р зуунд гэрээг бие даасан шинжээр нь ангилж, үнэлэхэд чухал ач холбогдолтой юм.

Гэрээ байгуулах суурь зарчим буюу санал хүлээн авах парадигм нь орчин үеийн гэрээний эрх зүйн хэрэглээг төвөгтэй болгож байна хэмээн гэрээний эрх зүй судлаачид үзэж буй. Санал, санал хүлээн авагч талын харилцан тохиролцоо, хүсэл зориг илэрхийлсэн байдлыг гэрээ хэмээн тодорхойлж, практикт дээрх зүй тогтлын дагуу хэрэглэсээр ирсэн ч гэрээ байгуулах үндэслэл болсон ёс зүйн хэм хэмжээ, эдийн засгийн тооцооллыг аливаа нөхцөлд авч үзэж, судлах зайлшгүй шаардлагатай. Санал болгох-санал хүлээн авах гэх дараалал бүхий зүй тогтол нь илүү функциональ шинжтэй бөгөөд дээрх албан ёсны хэлбэр тогтоосон загварыг цаашид онолын хандлагад суурилан шинжлэх нь гэрээний эрх зүйн практикт гэрээг нэг мөр зөв ойлгон хэрэглэх, гэрээний агуулгыг зөв тогтоох, талуудын үүргийн зөрчлөөс нөгөө талын зөрчигдсөн эрхийг сэргээх зэрэгт нэгэн хэрэгсэл болно.

Олон улсын түвшинд хэрэглэгддэг гэрээний эрх зүйн онолын хандлагын дагуу гэрээний залруулах шударга ёсны болон эдийн засгийн хандлагыг тайлбарлан түүнийг практикт хэрхэн хэрэглэх боломжийн талаар энэхүү судалгааг хийлээ. Гэрээний үндсэн хоёр зарчмын хүрээнд гэрээнд нөлөөлөх ач холбогдлын шинжийг харьцуулах аргаар тодорхойлсон болно.

1. Гэрээний зарчмын талаар

Гэрээ нь нийгэм, эдийн засгийн харилцааны хэрэгсэл болохын хувьд түүний бүрэлдэхүүн хэсэг нь гэрээ байгуулах эрх бүхий талууд, тэдний хүсэл зоригийг эрх зүйн үүднээс авч үзэж буй харилцан хамтын тохиролцоо юм¹. Гэрээний маргаанд эрх, үүргийг тодорхойлохдоо шүүхийн зүгээс талуудын хүсэл зоригийг харгалзан үзэх ёстой бөгөөд гэрээ байгуулахад үндэслэл болгон илэрхийлсэн хүсэл зоригийг бүрэн дүүрэн биелүүлэхийн тулд түүнийг талуудаар тайлбарлуулж байх нь зүйтэй. Бичгээр хийсэн гэрээ нь хоёрдмол утгагүй, түүнд бичигдсэн үгс тодорхой, шууд утгатай байх нь шүүх тэдний зорилгыг зөвөөр танин тайлах боломжийг олгож байдаг. Аливаа тохиолдолд шүүх гэрээний маргааныг хянан хэлэлцэхдээ нэмэлт номлох баримтаас урьтаж гэрээний угшил, санаа зорилгыг судлах нь чухал юм². Иймд зөвхөн шүүхийн шатанд бус гэрээ байгуулахаас өмнөх үеийн, гэрээ байгуулах үеийн, гэрээ байгуулсны

дараах үеийн зэрэг гэрээний хүсэл зориг илэрхийлэгдсэн байдлыг тогтооход гэрээний зарчмын онолын хандлагуудыг хэрэглэх боломжтой, онолын хандлагыг хослуулан хэрэглэснээр талуудын хүсэл зоригийг бүрэн таньж мэдэх, гэрээний эрх, үүргийг тал бүрээс авч үзсэнээр “талуудын тохиролцоо” болох гэрээг зөв үнэлэх, талуудын эрх ашгийг хөндөхгүй байх чухал ач холбогдолтой.

Гэрээний зарчмын ерөнхий ойлголтын хувьд эрх зүйн бүл хийгээд тухайн орны соёл, зан заншлын хэм хэмжээнээс хамааран харилцан адилгүй тайлбарлаж, хэрэглэгддэг. Тухайлбал Оксфордын их сургуулийн гэрээний эрх зүйн тэнхимийн гарын авлагад³ гэрээний зарчмыг тодорхойлохдоо нэг талын ба хоёр талын гэрээ гэж гэрээний талуудыг ангилаад түүнд тогтоох зарчмыг харилцан өөрөөр тодорхойлжээ. Харин Австралийн судлаач Надиа Маклод гэрээний эрх зүйн зарчмыг тодорхойлохдоо “гэрээ нь зайлшгүй хоёр талын хүсэл зоригийн илэрхийлэл байна” хэмээн үзээд гэрээний ангилал (хэлцэл, зөвшилцөл, хэлэлцээр, гэрээ, тохиролцоо, арилжаа гэх мэт)-аас хамааран зарчмыг өөрөөр тодорхойлох санал дэвшүүлсэн байдаг. Харин манай улсын хувьд Ром-Германы эрх зүйн бүлд хамаарах тул Иргэний эрх зүйд тусгалаа олохдоо үүргийн эрх зүй бүлэгт хамааруулан хэрэглэж

¹ Mallory v Detroit, 181 Mich App 121, 127 (1989)

² Petovello v Murray, 139 Mich App 639, 642 (1984)

³ <https://oxford.universitypressscholarship.com/>

байгааг манай улсын эдийн засгийн харилцаан дахь гэрээний хэрэглээ, соёл, түүнийг үнэлэх, дүгнэх, ач холбогдлыг зэрэглэх практик харьцангуй залуу байгаатай холбож үзэж болох юм.

Гэсэн ч сонгодог гэрээний эрх зүй (Classical contract law)-д гэрээний үндэслэлийг талуудын тооноос үл хамааран хүсэл зоригт тулгуурлан (гэрээ нь сайн дурын шинжтэй, ухамсарласан үйлдлийн илрэл хэмээн үзэх хандлага) хэрэгждэг гэх санааг судлаач миний хувьд түлхүү дэмжиж байх тул энэ чиглэлийг баримталсныг дурдах нь зүйтэй. Сонгодог агуулгаар гэрээний соёл ба зарчим нь бизнесийн харилцаанд илүү хэрэгждэг гэх ба гэрээ нь харилцан ашигтай байж, талуудын сонголтоо хэрэгжүүлэх нэгэн хэрэгсэл болдог. Ийнхүү хэрэгсэл болохын хувьд анхдагч хэрэгцээн дээр тулгуурлаж түүний зарчмыг хэрэгжүүлэх гол түлхүүр болон онолын хандлагуудыг ангилах арга зүйн урьдчилсан төсөөллийг нэн тэргүүнд бий болгох нь чухал байна. Хоёрдугаарт тухайн ангилах арга зүй нь өөрийн үзэл баримтлалтай байх шаардлагатай бөгөөд үүнийгээ зарчмын томъёоллоор илэрхийлнэ. Эл хандлага нь 20-р зууны эхэн үеэс гэрээний эрх зүйд хүчтэй нэвтэрсэн бөгөөд орчин үеийн гэрээний эрх зүй судлаачид өөрсдийн судалгаанд нийцүүлэн хэрэглэх нь тэдгээрийн үзэмж болон үнэт зүйлийг баримжааны асуудал болсон⁴. Дээрх тодорхойлолтод үндэслэн гэрээний доорх үндсэн хоёр зарчмын онолын хандлагыг задалж харья.

Онолын хандлага	Эдийн засгийн хандлага (Economic approach)	Залруулах шударга ёсны хандлага (Corrective justice)
Тайлбар	Олон улсын (only in private law) гэрээний эрх зүй судлаачдын үзэж буйгаар гэрээ нь эдийн засгийн эрх, ашиг сонирхлын илэрхийлэл болохын хувьд түүнийг эдийн засгийн онол, хандлагаар тайлбарлах нь зүйтэй хэмээн үздэг. Иймээс гэрээний эрх зүйд гэрээг тайлбарлах үндсэн аргачлал нь эдийн засгийн хандлага байх нь шударга бөгөөд гэрээний эдийн засгийн үнэ цэнийг хадгална гэж үздэг.	Дийлэнх судлаачид залруулах шударга ёсны хандлагыг гэрээний эрх зүйгээс илүүтэй гэм хорын эрх зүйд хэрэглэгдэх онолын хандлага хэмээн үздэг. Гэвч гэрээнээс үүдсэн гэм хорын асуудалд тухайн алдааг залруулах (corrective failure) буюу ёс зүйн чиг баримжаагаар зарчим болгон шийдвэрлэх нь эдийн засгийн онолын хандлагын зохицуулалт хүрээгүй орхигдсон нөгөө талд орхигдсон үл харагдах үндсэн эрхийг хамгаалах, хангахад чухал ач холбогдолтой хэмээн үзжээ.

⁴ Curtis Bridgeman, "Corrective justice in Contract law: Is there a case for a punitive damages?", 2003, Law review, 237

<p>Онолын гарал үүсэл ба хэрэглээ</p>	<p>Олон улсын түвшинд уг онолыг анх 1975 онд Ричард Поснер нэвтрүүлсэн бөгөөд хууль эрх зүй нь эдийн засгийн тооцооллын үндэслэлтэй байх ёстой гэх санааг дэвшүүлсэн. Уг хандлагаар гэрээний эдийн засгийн үнэлгээ болон талуудын хүлээх үүргийг зах зээлийн зан үйл, үнэлэмжид суурилан тогтоодог. Ийнхүү тогтоосноор талуудын хооронд хэзээ нэгэн цагт маргаан гарсан тохиолдолд хэн нэгний эдийн засгийн эрхийг хохироолгүй, үнэлсэн хэмжээгээр хангах боломжтой байна. Эл хандлага нь мөн эрх зүйчдийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой төдийгүй зах зээлд эдийн засгийн холбогдолтой хуулийг тайлбарлах, гэрээг үнэлэх, гэрээний маргааныг шийдвэрлэхэд зөвхөн мөнгөн дүн, албан ёсны тооцоолол, санхүүгийн баримтуудад түшиглэсэн байдлаараа эрх зүйн субъектив байдлаас ангид байдлаар асуудлыг шийдвэрлэх боломжтой болгодог гэж үздэг¹.</p>	<p>Сүүлийн хорин жилийн хугацаанд шударга ёсны онол судлаачид гэм хорын эрх зүй дэх залруулах шударга ёсны хандлагыг хөгжүүлж ирсэн. Хамгийн энгийнээр учруулсан хохирлыг бүхэлд нь нөхөн төлүүлэхэд энэхүү хандлагын зорилго оршдог. Нийтийн ба хувийн эрх зүй гэж ерөнхийд нь ангилж байгаа ч хувь хүмүүсийн хоорондох ёс зүйн хэм хэмжээг зохицуулах хэм хэмжээ зайлшгүй байх ёстой гэж үзжээ. Үүнд эрүүгийн хуульд гэмт хэргийн хохирлыг арилгах ёс зүйгээс гадна гэрээний эрх зүйд гэм хор арилгах асуудлыг ч авч үзэж болно. Залруулах шударга ёсны хохирлыг нөхөн төлөх үүрэг нь "зайлшгүй үүрэг" мэт харагдаж болох ч хохирогчийн буруутай үйлдлээсболсонтохиолдолд үүрэг хүлээдэггүй байх нь шударга ёсыг тогтоож буй явдал юм хэмээн Ж.Эрнэст, Вейнриб нар "Хувийн эрх зүйн үзэл санаа" 1997 бүтээлдээ тайлбарлажээ.</p>
--	--	--

2. Эдийн засгийн хандлагыг гэрээний эрх зүйнд хэрэглэх асуудал

Economic approach in law буюу эдийн засгийн хандлага нь эдийн засагчдын хувьд ч, академик хуульчдын хувьд ч эмпирик шинж чанартай, аль ч эрх зүйн тогтолцоонд ашиглаж болох арга зүй юм. Энэ онолын давуу талыг судлаачид эдийн засгийн эрх зүйд хэрэглэснээр уламжлалт гэрээний онол илүү мэргэжлийн буюу бизнесийн гэрээнд сайнаар нөлөөлөх, судлаачид өсөн хөгжих, гэрээний эрх зүйн харилцааг эмх цэгцэд оруулахад чухал ач холбогдолтой хэмээн дүгнэсэн байдаг. Эдийн засгийг эрх зүйтэй хослуулан хэрэглэх нь шинэ зүйл огт биш бөгөөд 1960-аад оны эхээр "хууль

ба эдийн засаг нь бүхэлдээ биш ч гэсэн бизнесийн салбарт тэр дундаа монополын эсрэг хамтдаа тэмцэж чадах хамгийн зөв шийдэл” хэмээн үзсэнээс уг онолын суурь тавигдсан байдаг.

Уг онолын суурь нь анх татварын эрх зүй болон нийтийн аж ахуйн зохицуулалтын баримт бичгүүдэд тусгалаа олж байсан бөгөөд улмаар 20-р зууны сүүл үеэс гэрээний эрх зүйд чухал нөлөөтэй зарчим болон бэхжсэн байна. Хөдөлмөрийн болон хөрөнгийн зах зээлд эдийн засаг болон эрх зүйн хоршил хамгийн их байдаг⁵. Гэсэн ч нийгмийн харилцаа, дэлхийн эдийн засаг, техникийн дэвшлээс хамаараад одоо цагт эдийн засагтай үл холбогдох салбар үгүй болж буйг судлаачдын зүгээс анхаарах нь зүйтэй. Монгол улсын хувьд банк, санхүүгийн салбарт энэ хандлага хамгийн их үйлчилж байгаа буюу зээлийн болон хадгаламжийн гэрээний хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд эдийн засгийн хандлагыг удирдлага болгосон жишээнүүд цөөн хэд байна. Тухайлбал фидуцын гэрээ⁶гээр банк бус санхүүгийн байгууллагаас зээл авсан иргэн гэрээгээр хүлээсэн зээл төлөх үүргээ хугацаанд нь биелүүлээгүйгээс өмчлөлд шилжүүлсэн эд хөрөнгөөр гэрээний үүргийг биелүүлсэн ба үндсэн гэрээний үүргийн ногдох хэсгийн төлбөрийг өмчлөлийн

зүйлээс гаргуулж, үлдсэн хэсгийг зээлдэгчид буцаан олгож буй жишиг практикт нэгэнт тогтсоныг жишээлж болно. Энэ нь гэрээний эрх зүй дэх эдийн засгийн онолын биежсэн нэгэн жишээ юм. Энэхүү онолын хандлагын нэгэн давуу тал нь талуудын хүлээх үүргийг эдийн засгийн агуулгаар нь тодорхойлж илүү ч үгүй дутуу ч үгүй тухайн хэм хэмжээн дотор хангуулдаг явдал юм. Иймд дээрх зарчмын хэрэгжилт өргөн биш ч тодорхой хэмжээнд материаллаг хуулинд тусгалаа олж, практикт цөөн боловч хэрэглэгдэж байгаа нь сайшаалтай. Энэхүү хандлагын нэгэн сул тал нь зөвхөн хөрөнгөөр үнэлж болох эдийн засгийн тооцоолол бүхий гэрээнд үйлчилдэг бол эдийн бус харилцаа болон оролцогч талуудын гэрээнд тусгалгүй орхигдсон боловч зайлшгүй хамгаалбал зохих эрхийг бүрэн хангаж чаддаггүй.

Гэрээний эрх зүйн зарчмын эдийн засгийн хандлага нь эдийн засгийн шинжилгээг эрх зүйтэй хэрхэн харьцуулах талаар хууль зүйн сэтгэлгээний нэг төрлийн арга юм. Эрх зүйн онолын үр дүнд судлаачид болон оюутнууд илүүтэй норматив байдлаар эрх зүйг тайлбарлах, байр сууриа илэрхийлж ирсэн ч эдийн засгийн шинжлэх ухаантай хослуулан хэрэглэх тал дээр мэргэшсэн хуульчид цөөн байдаг. Иймд эдийн засгийн хандлагыг эрх зүйд хэрэглэх нь хосолмол ур чадвар тогтоогоод зогсохгүй ирээдүйн эрх зүйчдийн арга барилыг сайжруулна

⁵ Richard A. Posner, "Economic analysis of law", NY., 1973

⁶ Монгол Улсын Иргэний хууль, 235-р зүйл. Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ

хэмээн Брүүклиний Их Сургуулийн Профессор Вилльям Арайза өөрийн нэг сэдэвт бүтээлдээ дурджээ. Брүүклиний Их Сургуулийн, Хуулийн Сургуулийн судлаачид Эрх зүйн эдийн засгийн онолын хандлагыг дараах байдлаар мөн нарийвчлан ангилсан байх нь бий. Үүнд:

1. Зан үйлийн эдийн засгийн хандлага
2. Үр ашиг, баялгийг нэмэгдүүлэх зорилго бүхий эдийн засгийн хандлага
3. Бодит болон норматив эдийн засгийн ялгаа бүхий хандлага
4. Бодит эдийн засгийн арга зүйд суурилсан хандлага

Брүүклиний Их сургуулийн хуулийн сургуулийн судлаачдын дээрх ангилал, эрх зүй дэх эдийн засгийн хандлагын нөлөөг өндөр ач холбогдолтойд үзсэнийг бусад судлаачид (тухайлбал Роналд Дворкин, Роберт Эликсон зэрэг) шүүмжлэхдээ түлхүү либерал, радикал, социологийн шинжлэх ухааны хосломол байдлаар шүүмжилдэг нь эдийн засгийн хандлагаар эрх зүйг тайлбарлах нь өрөөсгөл, өөрөөр хэлбэл эрх зүй нь нийгмийн шинжлэх ухаан болохын хувьд байгалийн шинжлэх ухааныг хавсарган хэрэглэснээр бие даасан байдлаа алдана гэж үздэгтэй холбоотой. Нөгөө талаас гэрээний талуудын хүсэл зоригийг эдийн засгийн ашиг сонирхол талаас давуу байдлаар авч үзвэл зөрчигдсөн эрхийг сэргээх гэдэг эрх зүйн нийтлэг шударга ёсны үйлчлэл

алдагдана гэж үздэг тул сонгодог байдлаар эдийн засгийн хандлагыг хэрэглэж, шийдвэрлэсэн шүүхийн кейс тэр бүр байдаггүй хэмээжээ⁷.

Иймд гэрээний зорилго, агуулга, зохицуулалтыг нарийвчлан тогтоох, түүнийг нэг мөр шийдвэрлэхэд аль нэг зарчмын хандлагыг дангаар хэрэглэх бус "залруулах шударга ёсны хандлага"-ыг зайлшгүй зэрэгцүүлж судлах шаардлага үүсч буй.

3. Залруулах шударга ёсны хандлагыг гэрээний эрх зүйд хэрэглэх асуудал

Corrective justice буюу залруулах шударга ёсны хандлагыг гэрээний эрх зүйд хэрхэн хэрэглэх талаар Куртис Бриджмэн тайлбарлахдаа "Гэрээний эрх зүйд залруулах шударга ёсны онолыг хэрэглэж эхэлсэн нь тун сайшаалтай. Гэрээний улмаас өөрт учирсан гэм хорыг нэхэмжилсэн этгээдийн хувьд энэ нь огтхон ч ичгэвтэр асуудал биш бөгөөд хууль зөрчсөн асуудлаас тусдаа бие даасан ойлголт юм. Зөрчлийн эрх зүйд хүмүүсийн санаатай болон болгоомжгүй байдлаас бусдад учирсан гэм хорыг хатуу хариуцлагын тогтолцоогоор стандартжуулсан байдаг бол гэрээний талууд ердөө хүлээсэн үүргээ биелүүлэх хүчин чармайлт гаргаагүйгээс нөгөө талдаа хохирол учруулж байдаг. Иймд гэрээний эрх зүйд шударга ёсны онолыг ашилахдаа гэрээ хийсэн шалтгаан, хүлээх үүрэг,

⁷ Ronald DWORKIN, *Taking Rights Seriously*, Ch 4 (1978); Ronald DWORKIN, *Response to Overseas Commentators* 1, *Intl. J. of Con. Law (I.CON)* 651.660-662 (2003).

үүргийг хариуцлагажуулсан байдал, ёс суртахууны үүргээс чөлөөлөх үндэслэл зэргийг судлан тогтоох нь нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх боломжтой зүйл юм⁸ хэмээжээ. Товчхондоо гэрээний эрх зүйд уг онолыг хэрэглэх нь зөрчигдсөн эрхийг сэргээх буюу гэрээний талуудын эрх ашгийг ижил хэмжээнд барихад чухал ач холбогдолтой нь харагдаж байна.

Монгол улсын хувьд залруулах ёс зүйг хувийн эрх зүй болон шүүхийн практикт хэрхэн хэрэглэж буй талаар судлахад ихэвчлэн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх харилцаанд хэрэглэгдэж байна. Ингэхдээ гэрээний үүргийн зарим зөрчлийг Гэм хорын эрх зүйд хамааруулж шийдвэрлэсэн хэд хэдэн жишээг дурдаж болно. Тухайлбал:

- Даатгалын компани даатгалын гэрээний дагуу төлсөн төлбөрөө гэм буруутай этгээдээс нэхэмжилснийг хэрэглэвэл зохих нарийвчилсан зохицуулалт болох ИХ-ийн 443 дугаар зүйлийн 443.7, Даатгалын тухай хуулийн 8 дугаар 8.7-д заасныг хэрэглээгүй, ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-д заасныг хэрэглэсэн;
- Хариуцагч нэхэмжлэгчид өөрийн буруутай үйлдлээс автомашинд учирсан хохирлыг ижил төрлийн автомашин худалдан авч өгч барагдуулсан байхад шүүх зөрүү

мөнгийг гаргуулж шийдвэрлэсэн нь ИХ-ийн 510 дугаар зүйлийн 510.1-д заасантай нийцээгүй⁹;

- Шүүх гэрээний үүргийн биелэлттэй холбоотой гэм хорын хохирлын шаардлага гаргасныг гэрээний бус үүргийн хохирлын талаар зохицуулсан ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх зохицуулалтуудыг хэрэглэсэн; ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасан гэм хор учруулснаас үүсэх үүргийн ерөнхий үндэслэл болон тусгай төрлийн гэм хорын зохицуулалтыг ялган авч үзээгүй эсхүл гэрээний үүргийн болон үүргийн ерөнхий зохицуулалтуудыг гэм хорын маргаанд хэрэглэсэнтэй холбоотойгоор хууль хэрэглээний алдаа түгээмэл гарсан байна¹⁰.

Монгол улсын Иргэний хуулийн 18-р бүлэг, 228-230 дугаар зүйлд хуульчилсан гэрээнээс үүдсэн гэм хорыг арилгуулах эрхийн зохицуулалт нь Залруулах шударга ёсны хандлагыг гэрээний эрх зүйд хэрэглэж болох үндэслэл болж болохоор байна. Хувийн эрх зүйн материаллаг хэм хэмжээгээр уг онолыг хэрэглэх боломж 2002 оны Иргэний хуулиар бүрдсэн байна. Иргэний хуулийн 229.1 дэх хэсэгт заасан "Үүрэг бүхий этгээд нь гэм хорыг арилгахдаа эд хөрөнгөд учруулсан бодит хохирол болон олох

⁸ Шүүхийн ерөнхий зөвлөл, "Давж заалдах болон хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн үндэслэл, төрөл" бодлогын судалгааны тайлан, УБ., 2014, т.45

¹⁰ Шүүхийн ерөнхий зөвлөл, "Давж заалдах болон хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн үндэслэл, төрөл" бодлогын судалгааны тайлан, УБ., 2014, т.46

⁸ Curtis Bridgeman, "Corrective justice in Contract law: Is there a case for a punitive damages?", 2003, Law review, 237

ёстой байсан орлогыг нөхөн төлөх үүрэгтэй” гэх зохицуулалт нь онолын хувьд шударга ёсны шинжтэй боловч практикт “олох ёстой байсан орлого”-ыг нөхөн төлүүлэх нь ховор буюу нэг зөрчилд нэг л хариуцлага хэрэглэнэ хэмээн андуурч ойлгон хэрэглэж буй нь бас нэгэн шүүмжлэлтэй хандах асуудал мөн гэж үзэж байгаа юм.

Ихэнх оронд Corrective justice хандлагыг Зөрчлийн эрх зүй /Tort Law/-д хамаатуулан хэрэглэж ирсэн уламжлал байна. 2019 онд Куртис Брижмэн өөрийн “Гэрээний эрх зүй дэх залруулах шударга ёс” бүтээлдээ гэрээний эрх зүйд уг хандлага яагаад чухал болохыг дараах байдлаар тайлбарласан байдаг. Гэрээ нь талуудын тохиролцоо мөн болохын хувьд гэрээг үнэлэхдээ эдийн засгийн онолд даатгаж шийдвэрлэж байна. Гэрээнээс үүдсэн маргааныг шийдвэрлэхэд шударга ёсны онол дангаараа ч хангалтгүй тул эдийн засгийн онол, хандлагатай уялдуулж, илүү уян хатан байдлаар шийдэж болох юм. Зөрчлийн хуулиас илүүтэй энэ онолыг гэрээний эрх зүйн нийтлэг зарчмуудтай харилцан хамааруулж хэрэглэж болох тул залруулах шударга ёсыг гэрээнд заавал хэрэглэх хэрэгтэй. Гэрээний суурь зарчмын хүрээнд авч үзвэл санал илэрхийлэгч талын саналыг хүлээн авагч тал хүлээн авснаа илэрхийлээгүй бол энэ нь хүчин төгөлдөр бус гэж үзнэ. Харилцан зөвшилцөх энэхүү шаардлага нь гэрээ байгуулах хоёр туйлт арга тул гэрээ байгуулагдсан эсэх маргааны хувьд залруулах шударга

ёсны хандлагаар үүнийг тогтоох боломжтой. Хоёрдугаарт талуудын гэрээнд хандах хувийн хандлагаар шударга ёсыг тогтоох-энэ нь гэрээний үүргийн сайн дурын байдлыг зөрчсөн буюу тохиролцоогоо эвдсэн талд давуу байдал олгохгүй байх зорилготой. Дээрх шалтгааны улмаас гэрээнд шударга ёсны онол, хандлагын дагуу тодорхой хязгаарлалтууд орсноор залруулах шударга ёс биеллээ олох юм¹¹. Тэрээр мөн “гэхдээ энэ хандлагыг хэрэглэхэд зайлшгүй анхаарах зүйл нь гэрээнээс үүдэх хохирлын асуудал юм. Залруулах шударга ёсны онолын хүрээнд гэрээнээс үүдсэн хохирлыг арилгахын өмнө эрх зөрчигдсөн талын хүчин чармайлтад учирсан хохирлыг мөн тодорхойлох хэрэгтэй” гэжээ.

Өөрөөр хэлбэл гэрээний өөр ямар ч онолд бичигдээгүй боловч ёс зүй зөрчсөнөөс үүдсэн бүх төрлийн хохирлыг энэхүү хандлагаар тодорхойлж болох юм гэсэн санааг дэвшүүлсэн байна.

Уг зарчмын хандлага нь манай улсын материаллаг хуулинд зарим хэсэг нь тусгагдан бэхэжсэн ч процессын хуулиар түүнийг нэг мөр хэрэглэх боломжийг бүрдүүлээгүй байгаа нь гэрээний эрх зүй судлаачдын хувьд анхаарах асуудал болж байна. Нөгөө талаас залруулах шударга ёсны онолыг хэт давуу байдлаар хэрэглэвэл тоон утгаар илэрхийлэгдэх эдийн засгийн ашиг сонирхол үгүйсгэгдэх сул талтай байж болох юм.

¹¹ Curtis Bridgeman, “Corrective justice in contract law”, 2019, p.257

Дүгнэлт

Гэрээний үндсэн агуулга, шинж чанар, зорилго, онцлог шинжийг үнэлэхэд онолын зарчмын үзүүлэх нөлөө өргөндэлгэр юм. Материаллаг хуулийн хэм хэмжээнд хуульчлагдсан зохицуулалт нь нийгмийн харилцаа хийгээд технологийн дэвшил, аж байдлын өөрчлөлтөөс хамааран хуучрах, хоцрогдох, эсхүл бүр огт хэрэглэгдэхгүй болох шинжтэй байх нь бий. Угтаа тэдгээр материаллаг хуулиар зохицуулсан болон зохицуулаагүй аливаа гэрээний эрх зүйн харилцаанд үнэт зүйлийн чиг баримжаа болон зайлшгүй хэрэглэгдэх жанжин шугам болдог зарчмын хэрэглээг өндөрт байлгах нь эрх зүй судлаачдын тэргүүний үүрэг юм. Материаллаг хууль нь байгаа хэм хэмжээг агуулж байдаг бол зарчим нь байх ёстой сонгодог агуулга руу дөхүүлэх жим болдог. Иймд гэрээний эрх зүйд эрх үүргийг тайлбарлах, тэдгээрийг шийдвэрлэх, хариуцлагажуулахад олон улсын түвшинд хамгийн өргөн хэрэглэгддэг, хүлээн зөвшөөрсөн хоёр хандлагыг өмгөөлөл болон гэрээний эрх зүйн практикт нэвтрүүлэх нь чухал ач холбогдолтой байгаа юм. Гэхдээ практикт зарчмыг сохроор нэвтрүүлэх бус зарчмын үндсэн үнэт зүйл, агуулга, үзэл баримтлалыг ойлгосон байх нь түүнийг нэг мөр хэрэглэхэд чухал ач холбогдолтойг мөн анхаарах нь зүйтэй.

Гэрээний эрх зүйн зарчмын эдийн засгийн хандлагыг практикт хэрэглэхийн хувьд зарим хуульчид эдийн засгийн мэдлэггүйгээс төөрөгдөл үүсэх эрсдэлтэй гэж үздэг

бол судалгааны объект болохын хувьд ахисан түвшний үр дүн үзүүлэх ач холбогдолтой юм. Гэсэн ч цар хүрээ болон ач холбогдлын хувьд эл онол олон зуун жилийн турш үр ашгаа өгч ирсэн. Эдийн засгийн үндэслэлтэй хууль, шүүхийн шийдвэр гэдэг нь хүний эрхийг ханган хамгаалахдаа эдийн буюу мөнгөн дүнгээр тодорхойлоход гол үүргээ гүйцэтгэж иржээ. Улмаар энэхүү онол дангаараа ноёлсноос шударга ёс, талуудын эрх ашиг сонирхол хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцын зарим хэсгүүдэд гээгдэж эдийн бус эрхийн асуудал хөндөгдөх болсоноор залруулах шударга ёсны хандлагыг зайлшгүй хавсран хэрэглэх шаардлага үүсч байна.

Залруулах шударга ёсны хандлагын хүрээнд түүнийг хэрхэн хэрэглэж болохыг авч үзвэл гэрээний бүтэц, талуудын үүргийн хуваарилалт, үүрэг зөрчсөн байдал, үүргээ биелүүлэх хүчин чармайлт гаргаагүй байдал зэргийг нэн тэргүүнд үнэлэн авч үзэх шаардлагатай. Цаашлаад залруулах шударга ёсны хандлага нь эрх зүйн шударга ёсны онолын нэгээхэн хэсэг тул түүнийг практикт хэрэглэхэд шүүгчдийн энэ талаар мэргэшсэн байдал, ур чадвар чухал нөлөөтэй. Зарим судлаачдын үзэж буйгаар энэхүү хандлагыг жишгийн эрх зүйн бүлд түлхүү ашиглах боломжтой гэж үздэг боловч эх газрын эрх зүйн бүлийн хувьд материаллаг хуулиар хэрэглээг бэхжүүлсэн тохиолдолд процессын хуулинд тусган хослуулан ашиглах боломж

бүрэн нээлттэй байгаа юм. Академик хуульч, судлаачид цаашлаад хэрэг маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий шүүхийн байгууллагууд гэрээний зарчмын агуулга, үнэ цэнийг үнэлж хууль зүйн асуудалд ханддаг байх нь байгаа зүйлийн түвшинд биш байх ёстой зүйлийн түвшинд эрх зүйн болон гэрээний соёлыг бэхжүүлэхэд ихээхэн түлхэц болох юм. Дээрх хоёр онолын хандлагыг судалснаар сонгодог гэрээний формализмыг эвдээд зогсохгүй ёс суртахуунд суурилсан эдийн засгийн тооцоолол бүхий гэрээний эрх зүйн шинэ тутам хандлагыг хэвшүүлэх ач холбогдолтой. Орчин цагийн гэрээний эрх зүйд гэрээ байгуулах дүрмийн талаар ойлголтыг онолын түвшинд хязгаарлах боломжгүй болсоор байгаа бөгөөд талууд хүсэл зоригоо илэрхийлж гэрээ байгуулсны дараах эрх үүргийн биелэлт, талуудын үйлдэлд ач холбогдол өгч, радикал сууринаас онолын дээрх хандлагуудыг хослуулан хэрэглэх нь гэрээг харьцангуй явцуу үнэлэхгүй байх үндэслэл болно.

Ашигласан материал:

1. Curtis Bridgeman, "Reconciling strict liability with corrective justice in Contract law", 2007
2. Curtis Bridgeman, "Corrective Justice in Contract law: is there a case for Punitive damages?", 2003
3. Curtis Bridgeman, "Corrective Justice in Contract law", 2019
4. Douglas G. Baird, "The Oxford handbook of Law and economics: Volume 2: Private and commercial law", 2017

5. John H. Barton, "The Economic Basis of Damages for Breach of Contract", 1972
6. Nadia Macleod, "Six principles of contract law", 2018
7. Richard A. Posner, "Economic analysis of law", NY., 1973
8. Richard A. Posner, "The economic approach to law", 1975
9. Ronald DWORKIN, "Taking Rights Seriously", Ch 4, 1978
10. Монгол Улсын Иргэний хууль, 2002
11. Монгол Улсын Шүүхийн Ерөнхий зөвлөл, "Давж заалдах болон хяналтын журмаар шийдвэрлэсэн шийдвэрийн үндэслэл, төрөл" бодлогын судалгааны тайлан, УБ., 2014
12. Монгол Улсын Дээд шүүхийн зөвлөмж, Дугаар 03, "Гэрээний зарим эрх зүйн маргааны хууль хэрэглээ болон гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахад анхаарах асуудлууд", 2016

ЯРИЦЛАГА



Монгол Улсын боловсролын шинэчлэлийн зарим асуудлаар Шихихутуг их сургуулийн захирал, Монгол Улсын гавьяат багш, профессор Д.Оюунцэцэгтэй хийсэн товч ярилцлага.

Асуулт 1. Боловсролыг нийгмийн хамгийн тогтвортой байх ёстой зүйл /институт, процесс/ гэдэг, гэтэл шинэчлэлийн нэрийн дор боловсролын үзэл баримтлал, хөгжлийн чиг хандлага ойр ойрхон өөрчлөгдөх боллоо. Энэ тухай таны санаа бодол?

Мэргэжлийн ном, толь бичиг зэргээс /тухайлбал: Я.Цэвэл.Монгол хэлний товч тайлбар толь.УБ 2013 он/, “БШУЯ. Монголын боловсрол. Нэвгэрхий толь.” г.м/ үзэхэд Боловсролыг хувь хүн эсхүл нийгэм бүхэлдээ сурах үйл явц, нийгмийн хуримталсан мэдлэг болон үнэт зүйлсийг дамжуулан эзэмших үйл явц өөрөөр хэлбэл мэдлэг, мэдээллийг зөвхөн түгээх төдий биш, шинжлэх ухаан, соёл, нийгмийн түүхэн өвийг үеэс үед дамжуулах, өвлүүлэх тасралтгүй үйл явц хэмээн тодорхойлжээ.

Нийгэм /хүн төрөлхтний хөгжлийн үе шат, нийгэмшин аж төрөх олонлог/ үндэс угсааны, нийгмийн хэсэг бүлэг, давхаргын г.м/, тэдгээрийн

аж төрөхүйн хэлбэр, чиг баримжаа, соёл, туршлагын цогц байнга хувьсан өөрчлөгдөх жамтай. Нийгмийн оршин тогтнохуйн энэхүү жам ёсыг дагаж боловсрол шинэ агуулга, арга хэлбэрээр тасралтгүй хөгжиж баяжиж байх учиртай үйл явц юм. Учир нь боловсрол нийгэмд хуримтлагдсан хүмүүнлэгийн аж төрөхүйн туршлага, соёл, үнэт зүйлсийн чиг баримжаа, танин мэдэхүйн ололт сургамжийн бодит тусгал нь гэх үндэстэй юм. Иймээс боловсролын хувьсал хөгжил нь хүрээд ханачих хязгаар гэх зүйлгүй процесс гэж ойлгогдож байна.

Даяаршин буй ертөнцөд, шинжлэх ухаан, мэдээллийн технологийн эринд нийгэм, нийгмийн доторх үйл явцыг соргог сэтгэж мэдэрч, ухаарахгүй бол өрнөл, өөрчлөлтийн хурд нь гүйцэгдэхээргүй болж байна. Үүний дээр боловсролыг тээгч, гол хэрэглэгч нь болсон хүний материаллаг болон оюуны эрэлт хэрэгцээний яаж хувьсаж байгааг бид бэлхнээ мэдэрч байгаа бус уу. Хүний амьдралын утга учир,хэв маяг, үнэт зүйлсийн чиг баримжаа өөрчлөгдөж буй нь түгээмэл шинж чанартай үзэгдэл болох нь тодорхой байна.Түүнчлэн газар газрын эрдэмтэн судлаачид эдүгээ нийгэм, эдийн засгийн хөгжил мэдлэгт суурилсан байх учиртайг илүүтэй ярьж бичих боллоо. Үүнийг бид шинжлэх ухаан мэдээллийн технологийн эрин үеийн дуудлага хэмээн ойлгож байна. Өнөөгийн ертөнцөд хүн төрөлхтний энх амгаланд заналхийлсэн гамшиг гал усны гамшиг, өвчин тахал, газар хетлөлт г.м/-н аюул, эрсдэл үлэмж нэмэгдэн, тэдгээрийн хүмүүнлэгийн аж төрөл, харилцаа, соёл боловсролын хэрэгт үзүүлэх нөлөө нэмэгдсээр

байна. Ийм цаг үед Дээд боловсролын байгууллагуудад ямар ч нөхцөлд үйл ажиллагаа нь тасралтгүй хэвийн байх чадвар эзэмших зайлшгүй шаардлага тавигдах боллоо.

Эдүгээ хүний боловсрол, мэдлэг ур чадвар нь нийгэмд эзлэх байр суурь, чанартай амьдралын баталгаа нь болж, чухамдаа боловсролтой, мэдлэгтэй, шинжлэх ухаан, мэдээллийн технологийн ололт амжилтыг амьдрал ахуй, ажил албандаа хэрэглэж чаддаг иргэн, мэргэжилтэн л улс орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн баталгаа нь байх тийм цаг үед бид аж төрж, сурцгааж байна.

Ийм учраас иргэдийнхээ боловсролыг дэлхий дахины боловсролын хөгжлийн нийтлэг чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэх нь төрийн бодлогын нэн чухал зорилт болж байна. Гэхдээ энэ ажил үйлсийг зөвхөн төрд даатгаад л орхих зүйл биш, энэ бол боловсролын үйл ажиллагаанд оролцогч бүх талууд, боловсролын асуудал хариуцдаг төрийн бүх шатны байгууллага, эрдэмтэн, багш судлаачид, суралцаж байгаа бүх хүний санаа бодол, хүчин чармайлт шаардсан ёстой бүх нийтийн үйлс гэж үзэж байна.

Асуулт 2. Орчин үеийн боловсролын шинэчлэлд нөлөөлж буй хүчин зүйлээс та юуг нь онцлох вэ ?

Би ярилцлагынхаа эхэнд боловсрол шинэчлэгдэх учир шалтгаан, орчин нөхцөлийн тухай товч санаагаа товч илэрхийллээ.

Бид даяаршлын буюу улс үндэстнүүдийн соёл, туршлага сургамж, үнэт зүйлс харилцан чөлөөтэй нэвтрэх, нэвчих

нөхцөл боломж бүрдсэн цаг үед боловсролын үйл хэрэгт зүтгэж байна. Өөрөөр хэлбэл хаана ямар улс оронд боловсролын шилдэг сайн арга, туршлага байна тэндээс суралцах, үйл ажиллагаандаа нэтрүүлэх боломж байна гэсэн үг. Энэ бол сургалт судалгааны агуулга, арга технологийг олон улсын шилдэг стандарт жишигт хүргэх үндсэн арга зам юм. Гагцхүү санаачилга, оновчтой сонголт чухал. Шихихутугчууд хөгжлийнхөө хэтийн зорилгыг "Олон улсын түвшний, үндэсний тэргүүлэх их сургууль байна" гэж тодорхойлсон нь сургуулийнхаа хөгжлийн алхам бүрийг дэлхий дахины боловсролтой хөл" нийлүүлэх санаа зорилгыг шингээсэн хэрэг юм.

Энэ цаг үеийг шинжлэх ухаан мэдээллийн технологийн эрчимтэй хөгжлийн эрин гэж нэрлэж буй. Эдийн засаг нийгмийн амьдралын бүх салбарын хөгжил дэвшлийг мэдээллийн IT болон нано, био зэрэг орчин үеийн арга технологийг хэрхэн нэвтрүүлж эзэмшиж байгаагаар хэмждэг жишиг тогтож байна. Энэхүү чиг хандлагыг дагаж нийгмийн үйлдвэрлэл үйлчилгээний цоо шинэ мэргэжил бий болж бас нийгэмд өнөө хэр хэрэгцээ нь тасраагүй хүний нөөц, банкны теллер, машин механизмын засварчин, харуул хамгаалалтын ажилтан зэрэг 20 гаруй мэргэжлийн хэтийн төлөв ээдрээтэй болж байна. Зарим судлаачийн /Ж.Ариунболд, Б.Басбаяр. Ирээдүйн хөдөлмөрийн зах зээл, боловсрол. УБ.2021 он/ үзэж буйгаар" Бид хүний оюун ухааны чадамж, урчадварын дутагдлыг хиймэл оюун ухаан нөхөх сорилттой тулгарч байгаа" ажээ. "Дэлхий дахинаа хиймэл оюун ухаан, их өгөгдөл

зэрэг орчин үеийн технологийн нөлөөгөөр аж үйлдвэрийн шинэ хувьсгал өрнөж, хөдөлмөрийн зах зээлийн уламжлалт ойлголт эрс өөрчлөгдөж байна. Дэлхийн эдийн засгийн 2018 оны форумас 2022 он гэхэд нэн шаардлагатай 10 ажлын байрыг тодорхойлж, шинээр 133 сая ажлын байны орон тоо бий болж 75 сая ажлын байрны орон тоо цомхотголд орно "гэжээ.

Асуулт 3. Боловсролын шинэчлэлийн үндсэн чиг хандлагын тухайд таны үзэл бодол?

Дээр дурдагдсан зүйл бол сургалтын байгууллагууд сургалтын мэргэжлийн чиглэл, элсэлтийн бодлогоо хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний одоогийн болон маргаашийн үндэстэй бодит судалгаанд түшиглэн хэрэгжүүл, шинэчил гэсэн дохио сануулга гэж ойлгогдож байна. Судлаачдын үзэж буйгаар суралцагсад амьдралын шинэ хэв маягт суралцах, ажил мэргэжлийн ур чадвартаа олон платформыг ашиглах боломж нээгдэж байгаа ажээ. Тухайлбал 2025 он гэхэд машин, технологи, алгоритмын гүйцэтгэлийн чадамж өмнөх жилүүдтэй харьцуулахад өсч хүний гүйцэтгэх хугацаатай тэнцэх юм байна. Мөн дэлхий дахинаа ур чадварын хэрэгцээ шаардлага өөрчлөгдөж "Асуудал шийдвэрлэх чадварын хэрэгцээ 36 хувь, зөөлөн ур чадварын хэрэгцээ 16 хувь, системийн сэтгэлгээний хэрэгцээ 17 хувь өсөж байхад биеийн хүчний ажлын ур чадварын хэрэгцээ 4 хувь өсөх хандлагатай байгаа ажээ/ мөн тэнд үзнэ үү/.

Үүнийг сургалтын агуулга, арга технологийг прагматчилах, ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр шинэчлэх нэг гол хүчин зүйл гэх үндэстэй байна. Энд нэг зүйлийг онцлоход сургалтыг прагматчилна гэдэг нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд мэргэжлийн боловсролын онол арга зүйн үндэс болсон хичээлүүдийн тоо, эзлэх хувийн жинг бууруул, цөөрүүл гэсэн үг гэж механикаар ойлгож боломгүй, харин ч эсрэгээрээ хичээлийн агуулгад тухайн мэдлэгийн салбарын шинэ ойлголт, ухагдахуун, зарчим, зүй тогтол зэрэг шинэ мэдлэг олгох, мэдлэг бүтээх арга зүйд сургах, ирээдүйн мэргэжилтний эзэмшсэн байх мэдлэг, ур чадварын харьцаанд гарч буй өөрчлөлтийг тусган баяжуул гэсэн үг юм. **Мэдлэг бүтээх арга зүйн гол гогцоо нь мэдлэгийг бүрдүүлэгч мэдээ, мэдээлэл зэргийг олон эх үүсвэр арга замаар олж авах, харьцуулж жиших, сонголт хийх, боловсруулах, бүтээлчээр хэрэглэхэд сургах** гэж ойлгогдож байна. Ийм мэдлэг, ур чадварыг мэдлэгийг нэг талаас/багшаас/ дамжуулах уламжлалт аргаар олгоно гэдэг бүтэхгүй зүйл гэдэг нь ойлгомжтой. Шинэ арга технологийг эрж хайх, түүнд суралцаж эзэмших, нэвтрүүлж хэрэглэх нь боловсролын шинэчлэлд хамгийн тулгамдсан асуудлын нэг болж байна. Сүүлийн жилүүдэд "боловсролын хөгжил нь тогтолцоо, залгамж холбоо, бүтэц" гэсэн үзэл баримтлалд, зарчимд суурилсан "блумын таксономи" тухай их ярьж бичих боллоо. Энэхүү аргын ерөнхий агуулгыг дараах байдлаар ойлгож болох байна:

- Аливаа ойлголт, ухагдахууныг ойлгохын тулд тогтоох,
- тухайн ойлголтоо хэрэглэхийн тулд ойлгож, ухаарах,
- Ойлгосноо шинжлэхээс урьдаар хэрэглэх/энд туршилт судалгаа, хэрэглээ гэсэн утга илүү зохимжтой мэт/,
- үнэлэлт, дүгнэлт өгөхөөс өмнө задлан шинжлэх,
- бүтээхийн тулд эргэн санадаг, ойлгодог хэрэглэдэг, задлан шинжилдэг, үнэлэлт дүгнэлт өгдөг байх ёстой ажээ.

/Ирээдүйн хөдөлмөрийн зах зээл, боловсрол. 183 дахь талд/.

Орчин цагийн ажлын байранд тавигдаж буй нэн чухал шаардлага бол “шударга байх зарчим, дэвшилтэд сэтгэлгээг хөгжүүлэх, ухаалаг арга барилд суралцах, өөрийгөө хөгжүүлэх чадвар, ажил, алба, хөдөлмөрийн хамт олон, түүний бүтээж бүрдүүлсэн үнэт зүйлсэд өөриймсөг хандах зэрэг хандлагын зүйлүүд болж буй ажээ. Товчоор илэрхийлэхэд мэргэжилтэнд олгож буй мэдлэг, ур чадвар хандлагын зүйлүүд болон ажлын байрны бодит хэрэгцээ, шаардлагын зөрүүг арилгах нь прагматчилахын утга учир нь юм.

Энэ цаг үеийг бас мэдээллийн технологийн эрчимтэй хөгжил, хүмүүнлэгийн харилцааны зах, хязгааргүй тэлэлтийн эрин гэж тодорхойлж болох байна. Өнөөдөр Монгол Улсын иргэн, хувь хүн бүрд шахуу малын бэлчээр, тээврийн замд, хилийн чанадад гээд хаана ч байсан хэрэгцээтэй мэдээллийг түргэн хугацаанд, нэг их хүч чармайлт гаргалгүйгээр олж авах, хэрэглэх

боломжтой боллоо. Өөрөөр хэлбэл ИТ технологи айл өрх бүр, хүн бүрийн бодит хэрэглээний зүйл болж байна.

Энэ бол сургалтад танхимын, зайн, цахим сургалтын бүх хэлбэрийг хослуулах өргөн боломж бүрдэж байна гэсэн үг. Үүний зэрэгцээ ковид 19 цар тахал хүн төрөлхтөнд чамгүй сургамж өглөө. Эмнэлэг, боловсрол, нийгмийн бүх үйлчилгээ эзэндээ ямар ч цаг үед хөрөнгө чинээ, гарал үүсэл үл хамааран тасралтгүй хүрч байх, нээлттэй байх, тэгш, хүртээмжтэй шударга байх, хүнд сурталгүй шуурхай байх, цаг үеийн мэдрэмжтэй, хөрөнгө хүч, анхаарлыг төвлөрүүлж чаддаг байх зэрэг нь гамшгийн хорио цээрийн болон, олноороо хамт байх боломж хязгаарлагдмал нөхцөлд төдийгүй энх амгалан цаг үед ч баримтлах зарчим, бүх цаг үед бий болгохыг хичээж эрмэлзэх учиртай чадавхын тухай асуудал юм. Шихихутуг их сургуулийн хамт олон хорио цээрийн дэглэмийн хүнд үед хөрөнгө хүч, анхаарлаа төвлөрүүлж цахим зайн сургалтын орчинг богино хугацаанд бүрдүүлж арга технологид суралцан сургалтаа тасралтгүй явуулж, ээлжит төгсөлтөө цаг хугацаанд нь чанартай хийж чадсан нь дээр хэлснийг нотлох баримт гэж үзэж байна.

Тасралтгүй боловсролын тогтолцооны тухайд зөвхөн үйл явцын тасалдал доголдолгүй гэсэн утга төдий бус, иргэн эзэмшсэн ажил, мэргэжлийн ур чадвараа насан туршдаа хадгалах, хөгжүүлэх, мэдлэг боловсролоо цаг алдалгүй шатлан ахиулах нөхцөл боломжийн тухай яриа гэж ойлгогдож байна. Өөрийн сургуулийн жишээн дээр гэхэд Шихихутуг их сургууль төгсөгч нартайгаа байнгын

амьд холбоотой байж тэднийхээ ахиц дэвшил хөгжлийг дэмжих тогтолцоотой, мөн бакалаврын, магистрын, докторын зэргийн сургалтын болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, судалгааны суурь болон хэрэглээний, өсөлт хөгжлийн туршилт судалгаа бүрдүүлснээр нээлттэй, тасралтгүй боловсролын үндэс суурийг баттай тавьсан болно. Манай төгсөгчдийн холбоо саяхан төгсөгчдийн ангийн дарга нарын уулзалтыг зохион байгуулав. Үе үеийн төгсөгчдийн хамгийн шилдэг манлайлагч, зохион байгуулагчид байсан эрхмүүд маань сургалтын хөлбөрийг хөгжүүлэхэд ямар үнэтэй санал, бодлоо дэвшүүлэв. Бид сургуулийнхаа хөгжлийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа багш судлаачид суралцагсад, төгсөгчид бусад оролцогсдын оролцоог хангах, идэвхжүүлэх, иргэний нийгэм, хөдөлмөрийн зах зээлийг мэдрэх арга хэлбэр зүгширч хэвшиж буй хамт олон, байгууллага гэж дүгнэж байна.

Асуулт 4. Боловсролын чанарын асуудлыг зарим мэргэжилтэн, судлаачид “мөнхийн асуудал” гэж ярьж бичдэг. Хорин нэгдүгээр зууны боловсролд чанарын асуудалд ямар шинэ хандлага байна гэж та үзэж байна вэ?

Дэлхий дахины боловсрол, түүнийг дагаад Монгол Улсын боловсролын хамгийн чухал зорилт бол Алсын хараа 2050-д зааснаар хүнд, иргэндээ чанартай, сэтгэл хангалуун аж төрөхийн баталгаа болж чадах боловсрол олгох гэж үзэж байна. Иргэдээ өмч хөрөнгөтэй болгож, өмчлөх эрх нь баталгаажсан, хүсэл

тэмүүлэл, сонирхолд нь нийцсэн ажлын байртай, ур чадвар, авьяас билгээ хөгжүүлж өөрийгөө илэрхийлэх нөхцөл боломжоор хангах нь төрийн эн тэргүүний зорилт, улс үндэстний тусгаар тогтнол, аюулгүй байдал, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийн үндэс юм. Үүнийг хангах гол арга бол чанартай боловсрол гэж үзэж байна.

“Алсын хараа 2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” баримт бичигт “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” гэж төрийн боловсролын бодлогын алсын харааг тодорхойлжээ.

Чанартай боловсрол гэж ямар боловсролыг хэлэх вэ? түүнд хүрэх ямар арга зам байна вэ? Энэ бол боловсролын хөгжлийн түлхүүр асуудал юм. “Монголын боловсрол нэвтэрхий толь “бичигт сургалтын чанар гэдгийг” Олон хэмжээст, олон түвшнийг хамарсан хувьсан өөрчлөгдөж байдаг ойлголт, Энэ нь тухайн боловсролын тогтолцоо, сургалтын байгууллага, хөтөлбөр эсхүл мэргэжлийн хүрээнд боловсролыг загварчлах орчин нөхцөл, дээд боловсролын байгууллагын эрхэм зорилго, зорилтууд болон тодорхой стандарт зэрэгт хамааралтай” гэжээ. Эндээс харахад сургалтын чанар, боловсролын чанар гэсэн ойлголтуудыг ерөнхийдөө идентичний буюу ижилсгэн /адилаар/ авч үзжээ гэх үндэстэй байна. Бидний үзэж буйгаар

боловсролын чанарт:1, боловсролын байгууллагын олгож буй мэдлэг, ур чадвар, хандлага нь ирээдүйн мэргэжилтний ажлын байрны бодит хэрэгцээ, шаардлагад нийцэж буй эсэх, энэ үзүүлэлт нь зөвхөн сурлагын чанараар тодорхойлогддог төдийгүй, төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах чадвар, энэ чадвар хэрхэн биеллээ олж буй болон төгсөгчдийн болон ажил олгогчдын зүгээс өгч буй үнэлгээ, хандлага өсөлт хөгжлийн үзүүлэлтүүдээр хэмжигдэнэ. Нэг үгээр хэлэхэд дээд боловсролын байгууллага суралцагсдадаа ийм мэдлэг ур чадвар хандлага, чадавхыг бүрдүүлсэн нөхцөлд л чанартай сургалт, боловсролын зорилго хэрэгжиж байна гэх үндэстэй юм..

Боловсролын мэргэжилтэн, судлаачдын олонхын үзэж буйгаар чанартай боловсролд хүрэх үндсэн арга замыг:

Нэг. Профессор, багш судлаачдын чадварлаг,цаг үеэ мэдэрч өсч хөгжих чадвартай багийг төлөвшүүлэх. Эдүгээ багшид өндөр ёс суртахуунтай, манлайлагч байх, мэргэжлийн нарийн мэдлэг, заах арга зүйн ур чадвар,харилцааны соёл, мэдээллийн орчин үеийн өндөр багтаамжит техник технологийг эзэмшсэн, өөрийн бүтээл туурвилыг мэдээлэх түгээх төдийгүй сургалт явуулах түвшний гадаад хэлний мэдлэг, эрдэм, шинжилгээ судалгааны дадлага туршлага зэрэг олон талынбэлтгэлтэйбайхшаардлага тавигдах боллоо. Учир нь орчин үеийн сургалт нь суралцагч бүрийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, чадамж буюу үйл явц, юмс үзэгдлийг задлан шинжлэх мэдлэг, чадвар, хандлагыг цогцоор олгох, түүнийгээ амьдралд

хэрэгжүүлэх чадвартай, нэгтгэн дүгнэх, шинэ мэдлэг бүтээх чадамжтай “дэлхийн иргэн”-ийг бэлтгэхэд чиглэж байгаа бөгөөд энэ нь Юнескогоос гаргасан дээд боловсролын сургалтын 4 тулгуур үзэлтэй нягт уялдаж байгаа ажээ./Үр дүнд суурилсан боловсрол. УБ,2016он 13 дах талд/ .

Учир иймд дээд боловсролын байгууллага бүрд багшаа хөгжүүлэх бодлого, хөтөлбөр төлөвлөгөөтэй, тэдгээрийг хэрэгжүүлэх тогтолцоо/багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаа нь төлөвшсөн, багшид тавигдах шаардлага хэрэгжүүлэх арга зам тодорхойлогдсон байдал, багшийн хөгжилд зарцуулах хөрөнгийн хүрэлцээ ба санхүүгийн эх үүсвэрийн найдвартай байдал, багшийн хөдөлмөрийг үнэлэх дүгнэх урамшуулах тогтолцооны төлөвшил, багш, ажилтанд үзүүлэх дэмжлэг, тусламжийн үр, өгөөж г.м/төлөвшсөн байх шаардлага тавигдаж байна. Монгол Улсын дээд боловсролын ууган байгууллага МУИС-ийн жишээн дээр гэхэд “багш нарын залгамж халааг тасралтгүй бэлтгэх, багш судлаачдыг хөгжүүлэх, эрдмийн зэрэг, цолтой багш нарын эгнээг өргөтгөх, чадавхжуулах, мэргэжил мэдлэгээ дээшлүүлэхэд нь анхаарч бүтээлийн чөлөө, сургалтын тэтгэлэг олгох, гадаадын их дээд сургуульд докторын тэтгэлэгт хөтөлбөрт суралцуулах, багшийн академик хөгжилд анхаарах, судалгааны санхүүжилт, грант олгох, олон улсын нэр хүнд бүхий WEB of Science IF-JCR импакт фактор индекс бүхий мөн энэ үнэлгээний системтэй дүйцэх мэргэжлийн өндөр түвшинд хянагддаг бусад сэтгүүлд багш нарыг өгүүлэл нийтлүүлэхэд нь санхүүгийн

дэмжлэг үзүүлэх” зэрэг арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

Шихихутуг их сургуулийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн тэргүүлэх зорилтын нэг нь багшийн хөгжил бөгөөд энэ үйл ажиллагааны үндсэн чиглэлийг:

-багш нарын ёс зүйн төлөвшил,

-багш нарын боловсрол, ур чадварын өсөлт, хөгжил,

-багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чанарыг дээшлүүлэх, үндэсний болон олон улсын оюуны зах зээлд эргэлтэд оруулах,

-багш нарын гадаад хэлний мэдлэг чадварыг сайжруулах,

-багш нарын эрдэм судлалын ажилд үзүүлэх дэмжлэг тусламж,

-багш нарын нийгмийн баталгааг бүрдүүлэхэд үзүүлэх дэмжлэг гэж тодорхойлсон юм.

Хоёр. Шинжлэх ухаан, мэдээллийн технологийн ололтыг шингээсэн, сургалтыг хосолмол аргаар зохион байгуулах, сургалтын арга зүйг хөгжүүлэх, мэдлэг бүтээх боломж бүрдсэн, суралцагсдад ээлтэй сургалт, судалгааны орчин бүрдүүлэх нь сургалтын чанарыг хангах нэг гол арга зам юм. Энэ бол сургалтын зайн, цахим болон танхимын хосолмол сургалтын арга технологийг эзэмших, сургалтыг ямар ч нөхцөлд тасралтгүй /хэвийн/ зохион байгуулах үндсэн нөхцөл гэж үзэж байна.

Гурав. Дээд боловсролын байгууллагууд элсэлтийн болон, сургалтын хөтөлбөрийн бодлогоо эргэж харах цаг нь болсон гэж үзэж байна.

Эдүгээ ЕБС-ууд нэгэн цаг үеийг бодоход нэг тогтолцооноос ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжих хүнд нарийн төвөгтэй хямралт цаг үеийг туулж сургалтын агуулга, арга зүйд нь нийгмийн шинэ эрэлт хэрэгцээнд нийцэн төлөвшин тогтворжих чиг хандлага гарч байгааг үгүйсгэх аргагүй. ЕБС төгсөгчдөд насан туршийн ажил мэргэжлээ зөв сонгох, сонгосон мэргэжлээрээ суралцах их, дээд сургууль, мэргэжлийн сургалтын байгууллагаа сонгох боломж бүрдэж байна. Гэхдээ л үнэхээр тухайн мэргэжилд дур сонирхолтой, суралцах чин хүсэл эрмэлзэлтэй, суралцах чадвартай элсэгчийг сонгон шалгаруулах нөхцөл хараахан бүрдээгүй л байна. ЕБС-иудын сургалтын чанар жигд сайжраагүй, төгсөгчдийн нэлээд хэсэгт нь нь их, дээд сургуульд суралцах/бие даан суралцах/ чадвар суугаагүй, товчоор хэлэхэд чанартай суралцагсдын төлөөх шударга өрсөлдөөний тогтолцоо төлөвшөөгүй байна. Их дээд сургуульд элсэгчдээс сургуулиа төгсөж чадаагүй иргэдийн 60-аас илүүтэй хувь нь мэргэжлийн сонголтоо зөв хийгээгүйгээс, эсхүл сурлагаар хасагдсан, мөн их, дээд сургууль төгсөгчдийн 40 гаруйхан хувь нь л эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байгаа гэсэн судалгаа ч байна.

Чанартай боловсрол эзэмших чадвартай элсэгчид, суралцагсадтай болохын тулд мэргэжлийн чиг хандлага, элсэлтийн бодлогоо хөдөлмөрийн зах зээлийн бодит хэрэгцээнд суурилан тодорхойлох, сургалтын хөтөлбөрөө хөгжүүлэх, мэдээлэл, сурталчилгааны ажлынхаа үр өгөөжийг нэмэгдүүлэх, ЕБС, иргэний

нийгэмтэй илүү үр бүтээлтэй хамтран ажиллах гээд их дээд сургуулиудад ч, ЕБС-иудад ч сургалтаа чанаржуулах, агуулга, стандартыг нь их дээд сургуулийн элсэгчдэд тавигдаж буй шинэ шаардлагад нийцүүлэх, уялдуулах гээд хийх зүйл их байна.

Энд Дээд боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрийн хөгжлийг онцолж байна.

Сургалтын хөтөлбөр нь тодорхой түвшний мэргэжлийн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, хичээлийн агуулга, суралцахуйн үр дүн, суралцах, сургах, үнэлгээний арга зүй, суралцах орчин зэргийн хоорондын уялдаа, холбоог тодорхойлсон нэгдмэл баримт бичиг юм.

“Дээд боловсролын шинэчлэлийн төсөл” баримт бичигт дурьдсанаар “Орчин үед дээд боловсролын хөтөлбөр нь суралцахуйн үр дүн болон хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангасан, онол, практик хосолмол байх, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн байх, хянан магадалж сайжруулдаг байх, сургалтын арга зүй, үр дүн, үнэлгээний хэлбэрүүдийг багтаасан байх ёстой” гэж үздэг байна.

Дөрөв. Сургалтын чанарт их дээд сургуулийн удирдлага бүтэц, зохион байгуулалт, хөгжлийн бодлого тодорхойлох хэрэгжүүлэх үйл явц нь сургалтад оролцогч талууд/ юуны өмнө суралцагсдын/ -ын оролцоо хэрхэн хангагдсан, үйл ажиллагааны нээлттэй ил тод байдал хангагдсан эсэх зэрэг олон хүчин зүйл их юм. Одоо Монгол Улсад өөрийн удирдлагын

байгууллага төлөвшөөгүй, оюутан суралцагсдын, төгсөгчдийн олон нийтийн байгууллагагүй сургууль олдохгүй биз ээ. Гагцхүү тэдгээрийн үйл ажиллагааны легитимчлэл, тогтворжиж төлөвшсөн байдал, үр өгөөжийг нэмэгдүүлэх нь чухал. Нэгэн зүйлийг онцлоход төгсөгчид нь ажил эрхлэлт, нийгэмд эзлэх байр суурь нь бэхжих, нийгмийн баялаг бүтээхэд оролцох хувь нэмэр нь өсөхийн хэрээр сургуулийн хөгжлийн, сургалтын чанарыг сайжруулахад чухал үүрэгтэй болдог байна. Үүнийг Шихихутугийн төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа харуулж байна. Төгсөгчдийн маань 90 гаруй хувь нь мэргэжлээрээ, мэргэжлийн байгууллагуудад ажиллаж сургуульдаа олж авсан мэдлэг ур чадварын давуутай ба сул талыг биеэрээ мэдэрсэн, холбоогоороо дамжуулж сургалтын хөтөлбөрийг сайжруулах, шинэчлэхэд идэвхитэй оролцдог нь Шихихутугт олгож буй мэдлэг боловсрол нь ажлын байрны / шүүгч, прокурор, өмгөөлөгч г.м/ бодит хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэхэд үнэ цэнэтэй байдаг юм.

Тав. Чанарын дотоод баталгаажуулалт /Дотоод Чанарын Баталгаажуулалт/-ын систем /quality assurance system/ буюу сургалтын стандарт, сургалтын чанарт тавих хөндлөнгийн ба дотоод хяналтын тогтолцоо нь олон улсын дээд боловсролын шинэчлэлийн нэг бөгөөд сургалтын чанарын үндсэн баталгааны нэг болж байна. Чанарын дотоод баталгаажуулалтын хамгийн чухал зорилтод эрдэм шинжилгээний ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэх /94 хувь/ дээд сургуулийн гүйцэтгэлийн дүгнэлт /92 /хөндлөнгийн жишгийн уялдааг хангах /90/, засаглал ба

нийгмийн хариуцлага /89/, суралцахуй /87/, удирдлагыг боловсронгуй болгох /88/, нөөцийг тэгш хуваарилах /75/ гэж тус тус заасан байдаг /Чанарын дотоод баталгаажуулалт. Дээд боловсролын шинэ загвар. УБ. 2019 он.21 дэх талд/.

Эдүгээ Монгол улсын их, дээд сургуулиудад чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх эрэл хайгуул, туршилт судалгаа ид өрнөж байна. Сургуулиудын олонх нь Дотоод Чанарын Баталгаажуулалтын гол зорилго нь сургалтын хөтөлбөрүүдийн тасралтгүй сайжруулалт, хэрэгжилтийн үнэлгээ гэж үзэж, энэ үйл ажиллагаа нь дотоодын болон хөндлөнгийн/магадлан итгэмжлэл, олон улсын магадлан итгэмжлэл, эрэмбэлэлт болон бусад/ хяналт шинжилгээ, үнэлгээний арга байх гэж ойлгож байна. Одоо Дээд боловсролын байгууллагуудын тал хүрэхгүй хувь нь л Дотоод Чанарын Баталгаажуулалтын гол зүйлүүд болох "Чанарын бодлого"- той, мөн 80 орчим хувь нь Дотоод Чанарын Баталгаажуулалт хариуцсан нэгжтэй/ алба, орон тооны ажилтан, орон тооны бус зөвлөл г. м/ байна. Шихихутуг их сургууль, "Чанарын бодлого"-оо тодорхойлж баталгаажуулсан, бодлогыг гардан хариуцаж хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий орон тооны чанарын албатай, эдүгээ түүний үйл ажиллагааны харьцангуй бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх чиг барьж байгаа болно.

Асуулт 5. Монгол Улсын их, дээд сургуулийн хөгжлийн нэг гол чиг баримжааг сургалтын чанар, үр дүн нь олон улсад

хүлээн зөвшөөрөгдөх, Дээд боловсролын байгууллагын хувьд эрэмбэлэгдэх гэж ойлгогдож байна. Д боловсролын байгууллагыг олон улсын шилдэг жишиг стандартыг хангаж буй эсэхийг хэмжих ямар шалгуур үзүүлэлтүүд байна гэж та үзэж байна вэ?

Би хувьдаа эрэмбэлэлтийг Дээд боловсролын байгууллагууд өөрсдийгөө үндэсний болон олон улсын түвшинд хаана яваагаа мэдрэх, өөрөөр хэлбэл хөгжлийн чиг хандлага нь зөв эсэх, нэр хүнд байр сууриа бэхжүүлэхийн тулд юу хийх зэргээ таньж мэдэхэд нэн чухал ач холбогдолтой арга хэмжээ гэж үзэж байна.

Дэлхийн хэмжээнд их дээд сургуулиудыг харьцуулан үзэхдээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрэмбэлэлт, шалгуур үзүүлэлтүүд, жагсаалтыг суурь болгодог байна. Эдүгээ их дээд сургуулиудыг эрэмбэлдэг THE /Times higher education/, RUR / World University Rankings/ зэрэг 6 систем байдаг ажээ. Тэд их дээд сургуулийг өөр өөрийн боловсруулж нийтэд ил тод зарласан аргачлалыг хэрэглэдэг байна. Тухайлбал QS /Quac quality symonds/ байгууллага нь:

-Академик нэр хүнд-40 хувь./бүх үзүүлэлтийг нийтдээ100 хувь гэж үзвэл/

-Ажил олгогчдын үнэлгээ 10 хувь.

-Багш оюутны харьцаа. 20 хувь.

-Нэг багшид ногдох ишлэл. 20 хувь /сүүлийн 5 жилийн хугацааны нийт = ишлэл/.

Олон улсын оюутны тооны эзлэх хувь.5хувь.

Олон улсын ажилтны тооны эзлэх хувь. 5хувь зэрэг үзүүлэлтийг ашигладаг байна.

Сүүлийн жилүүдэд манай их дээд сургуулиуд дэлхийд эрэмбэлэгдэх болсон нь дээд боловсролын тогтолцооны хөгжлийн чухал үзүүлэлт гэх үндэстэй юм. Тухайлбал Ranking world web of universities 2021-д МУИС-дэлхийд 3024-д, ШУТИС-4453-д, АШУИС -5888-д үнэлэгджээ. Их дээд сургуулиудыг эрэмбэлэхийн нэг гол санаа нь тэдгээрийн өрсөлдөх чадвар, үндэсний болон олон улсын боловсролын тогтолцоонд эзлэх байр суурь, нэр хүндийг тодорхойлоход оршино гэж үзэж байгаа бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдөх гол арга зам нь их, дээд сургуулиуд байгууллага болон сургалтын хөтөлбөрүүдээ олон улсын магадлан итгэмжлэл хийлгэх гэж үзэж байна.

Асуулт 6. Одоо боловсролын тухай багц хуулийн шинэчилсэн төслүүдийн хэлэлцүүлэг ид өрнөж байна, Хуулийн төслүүд батлагдсанаар боловсролын шинэчлэлийн шинэ үе эхлэх тухай ярьж, бичиж байна. Энэ тухайд таны бодлыг сонсмоор байна.

Хуулиудын төслийн хэлэлцүүлэг их, дээд сургуулиудын удирдлага, эрдэмтэн, судлаачид, боловсролд оролцогч бүх талуудыг оролцуулсан, урьд өмнөхөөс илүү нээлттэй болж буй нь төслүүд чамбай боловсрогдоно гэсэн итгэл төрүүлж байна.Шихихутуг их сургуулийн удирдлага,эрдэмтэн багш нар хуулийн төслийн хэлэлцүүлэгт идэвхтэй оролцон санал

бодлоо хууль санаачлагчдад дараах чиглэлээр хүргүүлсэн. Үүнд:

-Судалгааны их сургуультай болох бодлого, хандлагыг дэмжихийн зэрэгцээ их сургуулиудыг ангилах шалгуур үзүүлэлтүүдийг оновчтой тодорхойлох, Дээд боловсролын байгууллагуудын үйл ажиллагааны бие даасан байдлыг бэхжүүлэх,

-Их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны чадавхыг нэмэгдүүлэх, багш нараа чадваржуулах зэрэгт төрөөс үзүүлэх дэмжлэгийн тогтолцоо механизмыг хуульчлан тогтоох,

-Зарим нарийн мэргэжлийн анагаах ухаан, техник-технологи, хууль эрх зүй г.м/ чиглэлээр төрөлжсөн их сургууль их сургуультай байх хуулийн зохицуулалтыг бий болгох,

-Магадлан итгэмжлэх үндэсний байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх.

Шинэ хуулиуд батлагдсанаар боловсролын шинэчлэлийн нэгэн шинэ шатны бодит эхлэл нь болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Асуулт7. Орчин үеийн боловсролын тогтолцоонд баримтлах нэг гол чиг шугам бол үйл ажиллагаандаа шударга ёсны зарчим, ёс зүйг тууштай баримтлах гэж үзэж байна. Энэ шаардлага хэрхэн хэрэгжиж байна гэж та үзэж байна вэ?

Тиймээ. Сүүлийн жилүүдэд шударга ёсны тухай, ёс зүйтэй байх асуудал дэвшигдэж байна. Энэ бол зөвхөн боловсролын төдийгүй нийгэм, төрийн удирдлагын нөлөө, нэр хүндийн асуудал, цаашилбал нийгмийн тогтвортой байдал, хөгжлийн нэн чухал бөгөөд нэмэлт хөрөнгө

оруулалт шаардахгүй эх үүсвэрийн тухай асуудал юм. Боловсролын тухайд энэ бол:

-нийт иргэндээ үндэс угсаа, хүйс, хөрөнгө чинээ, нийгэмд эзлэх байр суурь зэргээс үл хамааран чанартай боловсрол, мэргэжил эзэмших тэгш нөхцөл, боломж бүрдүүлэх,

-боловсролын байгууллагуудад төрийн, хувийн гэхээс үл хамааран өрсөлдөөний, төрийн дэмжлэг, хандлагын тэгш, шударга орчин нөхцөл бүрдүүлэх,

-Дээд боловсролын байгууллага бүрд багшийн ёс зүйг чандлан сахих, сургах, суралцах хөдөлмөрийг шударга, үнэн зөв үнэлэх тогтолцоог хэвшүүлэх, өөрөөр хэлбэл ёс зүйтэй багшлах бүрэлдэхүүнтэй байх, суралцагсдадаа ёс суртахууны эрхэм чанар, мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэхийг чиг баримжаагаа болгох, үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод, шударга ёсыг тууштай баримталдаг удирдлагын тогтолцоотой байна гэсэн үг юм.

Эдүгээ Дээд боловсролын байгууллагууд багш, судлаачдын ёс зүйн дүрэм, ёс зүйн хороо, оюутны төлөвшлийн хөтөлбөр гээд ёс зүйн тогтолцоотой болжээ. Зарим сургуулийн сургалтын төлөвлөгөөнд мэргэжлийн ёс зүйн /жишээ нь хуульчийн, багшийн, эмчийн г. м/ хичээлүүд заагдаж байна.

Шихихутугчууд сургуулиа ёс жудагтай, ажил мэргэжлийн ёс зүйг эрхэмлэдэг хамт олон гэж бахархдаг. Шихихутугт бүтэж бүрэлдсэн сайн зүйлүүд, тухайлбал, эрдмийн хамт

олны үнэт зүйлс, сургалт судалгааны чанарыг эрхэмлэсэн дэг жаяг, боловсролын шинэчлэлд анхдагч байх хүсэл эрмэлзэл, төгсөгчдийн нэр хүнд, өсөлт хөгжил энэ бүхэн багш судлаачид, суралцагсдадаа ёс суртахууны эрхэм чанар, мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэхийг хичээж чармайж ирсний үр дүн гэж үзэж байна.

-Ярилцлагаа Шихихутуг их сургуулийн хөгжлийн бодлогын чиг хандлагын тухай асуудлаар өндөрлөө.

Монгол Улсын дээд боловсролын өнөр бүлийн нэр хүндтэй гишүүн Шихихутуг их сургууль үүсэн байгуулагдсаар 30 гаруй жил болж хөгжил, дэвшлийнхээ шинэ шатны зорилго зорилтоо хэрэгжүүлж эхлээд байна. Бид хөгжлийнхөө 30 жилийн бодлого үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийж, шинэ шатныхаа зорилгыг "Бодлого, үйл ажиллагаандаа шилдэг менежмент, арга технологийг шингээсэн сургалт, судалгааны тэргүүлэх их сургууль байж, нийгэмд сайн сайхныг түгээнэ" хэмээн тодорхойлж байгаа бөгөөд чанарыг эрхэмлэх философидоо үнэнч байж, "Олон улсын түвшний, үндэсний тэргүүлэх их сургууль байх" чиглэлийг баримтална.

Шихихутугчууд Монгол Улсын боловсролын шинэчлэлд манлайлагч, анхдагч нь байх хүсэл эрмэлзэлтэй. Энэ бол Шихихутугчуудын хөгжилд хөтөлгөч дотоод сэдэл нь, зүй ёсны бахархал маань юм. Шихихутуг их сургууль хувийн их, дээд сургуулийн алтан хараацай нь болсон анхдагч

нарын нэгэн нь бөгөөд үндэсний боловсролын тогтолцооны эрх зүйн шинэчлэлд болон дээд боловсролын тогтолцоонд чөлөөт өрсөлдөөнийг бий болгох, эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлэхэд идэвхтэй оролцож хувь нэмрээ оруулсан юм. Бид хууль зүйн их, дээд сургуулиудаас анх удаа " Эрх зүйн боловсролын бакалаврын хөтөлбөр"-өө, мөн Дээд боловсролын байгууллагын 3 дахь магадлан итгэмжлэлийг шинэ шалгуур үзүүлэлтээр магадлан итгэмжлүүлсэн анхдагч сургууль.

Цаашдаа Шихихутугчууд багш, судлаач, суралцагчдынхаа бүтээлийг үндэсний болон олон улсын оюуны зах зээлийн эргэлтэд оруулах, сургалт, судалгааны шилдэг менежмент, арга технологийг эзэмших, сургалтын хөтөлбөрүүдээ олон улсад магадлан итгэмжлүүлж, олон улсад хүлээн зөвшөөрүүлэх, нийгмийн хариуцлагаа өргөжүүлж, үрөгөөжийг нь сайжруулах, их сургуулийн манлайллыг хангах замаар олон улсад эрэмбэлэгдсэн их сургууль болгон хөгжүүлэх болно.

Хөгжил, дэвшилд хуримтлуулсан туршлага сургамж, бүтээж бүрдүүлсэн сургалтын тохилог, суралцагсдад ээлтэй соёлтой орчин, чадал чансаатай, өсөх ирээдүй бүхий профессор багш, судлаачдын баг, сургуулийн маань өрсөлдөх чадвар энэ бүхэн Шихихутугчуудын зорьсондоо хүрэх баттай үндэс юм. Бидний урагшлах алхам бүр нийгмийн хэрэгцээ шаардлагыг тунгаасан, хамтын санаа бодол, олон нийтийн оролцоог түшиглэсэн, эрдмийн хамт олны маань эрхэмлэх үнэт зүйлс

болох сайн сайхны шилдэг уламжлал, сургуулийнхаа нэр хүнд, сургалт, судалгааны Шихихутуг дэг жаягаа хөгжүүлж бэхжүүлэхэд чиглэсэн алхам байх болно.

Захирал багш Танд боловсролын хөгжлийн асуудлаар санаа бодлоо илэрхийлсэнд "Шихихутуг" сэтгүүлийн зөвлөл, нийт уншигчдын нэрийн өмнөөс талархлаа.



Шихихутуг их сургуулийн Клиник
сургалтын төвийн эрхлэгч
Т. Сүхбаатартай ярилцав.

ХАМТРАН АЖИЛЛАХ ЭТГЭЭДЭЭР ТОГТООХ АЖИЛЛАГАА

Асуулт: Монгол Улсын ЭХХШтХуульд /2017 оны/ Хамтран ажиллах этгээдээр тогтоох тухай шинэ заалт орсон. Хуулийн энэ заалтын ач холбогдлын талаар ярина уу?

Хариулт:

Монгол Улсын Их Хурлаас 2017 онд баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хүний эрх эрх чөлөөг хамгаалах, хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг өөрчлөн шинэчлэх, боловсронгуй болгоход чиглэгдсэн цөөнгүй заалт орсон. Тухайлбал: Зарим төрлийн мөрдөн шалгах ажиллагааг зөвхөн прокурорын зөвшөөрлөөр явуулах болсон, эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх зэрэг мөрдөн шалгах ажиллагааны шинэ төрлүүд, шүүх хэргийн талаар урьдчилсан хэлэлцүүлэг хийх, хэргийг шалгах явцад хамтран ажиллах этгээдээр тогтоох зэрэг заалтууд

чухал ач холбогдолтой болсон.

Зохион байгуулалттай бүлгийн гишүүн тухайн зохион байгуулалттай бүлгийн үйлдсэн хэргийн талаар хэргээ илчилж ирсэн, хэргийг илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн, хэргийн талаар мэдээлэл өгсөн, хэргийг шалгах эрх бүхий байгууллагатай хамтран ажиллахаа илэрхийлсэн бол тухайн хүнийг хамтран ажиллах этгээдээр тогтоож болохоор хуульд заасан.

Асуулт: Хуулийн энэ заалт их чухал ач холбогдолтой болох нь тодорхой байна. Тэгвэл хуулийн байгууллагатай хамтран ажиллах этгээдийг хэрхэн, ямар журмаар тогтоодог бэ?

Хариулт:

Хамтран ажиллах этгээд хамтран ажиллах тухай хүсэлтээ прокурорт гаргах ёстой. Прокурор зохион байгуулалттай бүлгийн үйлдсэн хэрэгт яллах дүгнэлт үйлдэхээс өмнө тухайн этгээд хүсэлтээ прокурорт гаргана гэж хуульд заасан.

Прокурор хамтран ажиллах тухай хүсэлт гаргасан хүний үйлдсэн гэмт хэрэг, хэрэг илрүүлэхэд туслалцаа үзүүлэх гэж байгаа гэмт хэргийн нөхцөл байдал, гаргаж өгөх нотлох баримтын нотолгооны ач холбогдлыг шалгаж тогтоосон байна.

Прокурор тухайн хүнийг хамтран ажиллах этгээдээр тогтоолгох саналыг битүүмжлэн шүүхэд хүргүүлнэ. Хуулийн заалтаас үзэхэд Нэгдүгээрт "Хамтран ажиллах этгээдээр тогтоолгох хүн хамтран ажиллах гэж байгаа хэрэгт гэрчийн мэдүүлэг өгөх" Хоёрдугаарт "Хамтран ажиллах гэж байгаа хэрэгт нотлох баримт гаргаж

өгөх" баталгааг тус тус гаргахаар заасан. Эдгээр баталгааг прокурор өмгөөлөгчид мэдэгдэлгүй нууцлах хүсэлтийг шүүхэд гаргаж болно " ЭХХштХуулийн 13.4 дүгээр зүйлийн 7-д " Шүүх хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл нууцлах тухай шийдвэр гаргаж болно. " гэж заасан.

Хамтран ажиллах этгээдээр тогтоолгох тухай прокурорын саналыг хүлээн авснаас хойш 72 цагийн дотор шүүгч шүүхийн хэлэлцүүлгийн товыг прокурор, хамтран ажиллах этгээдээр тогтоолгох хүн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэж хамтран ажиллах этгээдээр тогтоолгох тухай хэлэлцэх шүүхийн хэлэлцүүлгийг хаалттай явуулна.

Асуулт: Ямар төрлийн хэргүүдийг мөрдөн шалгахад хамтран ажиллах этгээдийг тогтоож болох талаар тайлбар өнгө үү?

Хариулт: Эрүүгийн Хуулийн 19.4 дүгээр зүйлд заасан /Гадаадын тагнуулын алба, байгууллага иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах /гэмт хэрэг, 19.7 дугаар зүйлд заасан / Хорлон сүйтгэх ажиллагаанд бэлтгэх/ гэмт хэрэг, 20.7 дугаар зүйлд заасан / Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах / гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүх хамтран ажиллах этгээдээр тогтоож болно.

Асуулт: Хөгжлийн банкны зээл олголттой холбоотой олон хэрэг шалгагдаж байгаа бололтой Энэ хэргүүд дээр хамтран ажиллах этгээдийг тогтоож, хэргийг шалгаж болох уу?

Хариулт:

Хөгжлийн банкны зээлтэй холбоотой хэргийг бүрэн илрүүлэх шаардлагын үүднээс одоо мөрдөн байцаалтаар шалгагдаж байгаа хэргүүд дээр хамтран ажиллах этгээдээр тогтоох нөхцөл байдал үүсч болно. Энэ тохиолдолд хуулийн заалтыг удирдлага болгон хэрхэн үр дүнтэй ажиллах нь мөрдөгч болон прокурорын мэргэжлийн ур чадвараас шалтгаална.

Ярилцлага өгсөн таньд баярлалаа. Ажлын өндөр амжилтыг Сэтгүүлийн зөвлөл, уншигчдынхаа нэрийн өмнөөс хүсье.



ХУУЛИЙН ТАЙЛБАР

КОМПАНИЙН ХУУЛИЙН ТАЙЛБАР



Шихихутуг их сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш
А.Доржготов

КОМПАНИЙН ХУУЛИЙН ТАЙЛБАР:
Үргэлжлэл. Түрүүч нь “Шихихутуг”
сэтгүүлийн 2015, 2018, 2019, 2021
оны дугааруудад нийтлэгдсэн болно.

29 дүгээр зүйл. Компанийг татан
буулгасан тухай мэдэгдэх

29.1 Татан буулгах комисс нь
компанийн бүх эд хөрөнгийг
хуваарилсны дараа компанийг
татан буулгах замаар үйл
ажиллагаа дуусгавар болсон
тухай бүртгэх байгууллагад
мэдэгдэж, татан буулгах
балансын нэг хувийг бүртгэх
байгууллагад хүргүүлнэ.

29.2 Бүртгэх байгууллага
компанийг улсын бүртгэлээс
хассанаар түүнийг татан
буугдсанд тооцох бөгөөд энэ
тухай бүртгэх байгууллага
нийтэд мэдээлнэ.

Тайлбар:

“Компанийг татан буулгасан
тухай мэдээлэх” талаарх хуулийн
зохицуулалт хоёр үндсэн ойлголтыг
тодорхойлсон байна.

1-рт: Компанийн үйл ажиллагаа
дуусгавар болсон тухай ;

2-рт: Татан буулгасанд тооцох.

Татан буулгах комисс компанийн
бүх эд хөрөнгийг хуваарилж дуусгана.
Ийнхүү эд хөрөнгө хуваарилж
дуусгасны дараа компанийг татан
буулгах үйл ажиллагаа дуусгавар
болсон тухай мэдэгдэх, мэдээлэх үйл
ажиллагаа явуулна. Үүнд:

- татан буулгах ажиллагаа дуусгавар
болсон тухай бүртгэх байгууллагад
албан ёсоор мэдэгдэнэ.
- татан буулгалтын балансын нэг
хувийг бүртгэх байгууллагад
хүргүүлнэ.

Татан буулгах комиссоос эдгээр
ажиллагаа явуулсны эрх зүйн үр
дагавар нь компанийг татан буугдсанд
тооцох үндэслэл болдог.

Бүртгэх байгууллага татан буулгах
комиссын мэдэгдэл, татан буулгалтын
балансад үндэслэн компанийг улсын
бүртгэлээс хасна. Энэ ажиллагаа
явагдсанаар компани татан буугдсанд
тооцогдоно.

Эдгээр ажиллагааны дүнд бүртгэх
байгууллага тухайн компанийг татан
буугдсан тухай мэдээлнэ. Мэдээлэл
компанийн бүх эрх үүрэг, хариуцлага
дуусгавар болсныг илэрхийлнэ.
Хуулийн этгээдийг татан буулгасныг
улсын бүртгэлд бүртгүүлэх журмыг
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн
тухай хуулиар зохицуулжээ.¹

¹ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай
хууль (шинэчилсэн найруулга) Монгол улсын
хуулийн 24-26 дугаар зүйл. 2018.06.21-ний өдөр
батлагдаж, 2018.11.01-ний өдрөөс дагаж мөрдсөн.

**ТАВДУГААР БҮЛЭГ
КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН
ХӨРӨНГӨ,
КОМПАНИЙН ХУВЬЦАА, БУСАД
ҮНЭТ ЦААС**

Компанийн нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө

30.1 Тухайн компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тухайн компанийн зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.

30.2 Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэнэ.

30.3 Энэ хэсгийг 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсон.

30.4 Хуульд өөрөөр заагаагүй бол компанийг үүсгэн байгуулахад хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хязгаар тавихгүй.

30.5 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг компанийн дүрэмд тусгасан байна.

Тайлбар:

"Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, компанийн хувьцаа, бусад үнэт цаас" тавдугаар бүлэгт компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх, хувьцаа

энгийн ба давуу эрхийн болон алтан хувьцаа, хувьцаа эзэмшигчдийн эрх, хувьцаанд хамаарах үнэт цаас, хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх, хувьцаанд хөрвөх үнэт цаас, опцион, өрийн бичиг, үнэт цаас гаргах, хувьцаа болон үнэт цаасны төлбөр болон түүнийг эзэмшигчийн бүртгэл зэрэг ойлголт, эдгээрийн компанийн эрх зүйн зохицуулалтыг тусгажээ. Эдгээр ойлголт, хуулийн зохицуулалтыг зүйл бүрээр авч үзэх болно.

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө, түүний эрх зүйн ойлголтыг дараах байдлаар тодорхойлж болох юм.

Компанийн хөрөнгө. Ойлголтыг тодорхойлохын тулд иргэний эрх зүйн "хөрөнгө" гэх ойлголтыг үзэх хэрэгтэй болно.

Хөрөнгө. Иргэний хуульд "Аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс, эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг эд хөрөнгө болно." гэж тодорхойлдог.²

Эрх зүйн толь бичигт "Хөрөнгө гэдэгт актив, ашиг (орлого) олоход ашигладаг бараа, эд хөрөнгө, активын цогц "хөрөнгө" гэсэн нэр томъёо нь байнга компанийн нийт хөрөнгө (total assets) гэсэн учир холбогдолтойгоор хэрэглэгддэг байна.³ Иргэний эрх зүйн ойлголтоор "аливаа этгээдийн эзэмшилд байгаа эд юмсыг хөрөнгө" гэж тодорхойлбол компанийн

² Иргэний хуулийн 83 дугаар зүйл. "Төрийн мэдээлэл" №2002 он №7.

³ С.Нарангэрэл. "Эрх зүйн эх толь бичиг". УБ хот, 2007 он. Хуудас 532.

"эзэмшилд байгаа эд юмсыг компанийн эд хөрөнгө" гэж үзэж болно.
Монгол Улсын хууль, иргэний эрх зүйд эд хөрөнгө нь:

Үл хөдлөх эд хөрөнгө
Газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс

Хөдлөх эд хөрөнгө
Үл хөдлөх хөрөнгөд хамаарахаас бусад эд юмс

Ийм байдлаар хоёр ангилалд хувааж үздэг.

Үл хамаарах хувьцаа. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд хамааралгүй хувьцаанд тухайн зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаардаг.

Иргэний хуульд зохицуулсан эдгээр ойлголт нь компанийн хөрөнгийг тодорхойлох эрх зүйн үндэслэл болно.

Хувь нийлүүлсэн хөрөнгө болон компанийн өөрийн хөрөнгө. Компанийн хөрөнгө, түүний шинжийг Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 30 дугаар зүйлийн 30.1-д тодорхойлон заажээ. Компанийн хөрөнгийг дараах байдлаар ангилан тодорхойлдог.

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө. Тухайн компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу тус компаниас гаргасан нийт давуу эрхийн хувьцаа, энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэдэг. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд үл хамаарах хувьцаа байж болно.

Эдийн бус хөрөнгө. Эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага, окуны үнэт зүйл хамаарна.

Компанийн өөрийн хөрөнгө. Компани бүр үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэхэд зориулагдах өөрийн хөрөнгөтэй байна. Энэхүү хөрөнгийг тодорхойлох гол шалгуур нь тус компанийн тайлан тэнцэлд тусгагдсан хөрөнгө байх учиртай.

Ийнхүү тайлан тэнцэлд тусгагдсан хөрөнгө нь хэлбэрийн хувьд биет болон биет бусаар оршин байдаг.

Тэгэхлээр хуульд компанийн тайлан тэнцэлд тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэж тодорхойлжээ. Хялбарчилсан байдлаар үзүүлбэл:

Компанийн тайлан тэнцэлд тусгагдсан биет болон биет бус хөрөнгө. Үнийн дүн 2.0 тэрбум төгрөг

Компанийн нийт өр төлбөр 500 сая төгрөг

Компанийн өөрийн хөрөнгө 1,5 тэрбум төгрөг

Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тодорхойлох үндэслэл болно. Түүнчлэн компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь тус компанитай гэрээ, хэлцэл байгуулах, ногдол ашиг авах зэрэг компанийн үйл ажиллагаатай холбоотой эдийн засаг, эрх зүйн харилцаанд нөлөөлнө.

Компанийг үүсгэн байгуулахдаа Компанийн хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу компани үүсгэн байгуулах тухай шийдвэр гаргана. Компани үүсгэн байгуулах талаар хамтран ажиллах гэрээ байгуулна. Эдгээр шийдвэр, гэрээнд "компанийг үүсгэн байгуулахад хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хязгаар"-ыг тавихгүй байх ёстой. Хуульд өөрөөр заан зохицуулж болно. Энэ нь компани үүсгэн байгуулах оролцогчдын эрх, эрх чөлөөг хязгаарлахгүй байхад чиглэгдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг компанийн дүрэмд заавал тусгасан байх шаардлагатай.

1 дүгээр зүйл. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх

- 31.1 Энэ хэсэгт 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.
- 31.2 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн дор дурдсан хэлбэрээр өөрчилж болно.
- 31.2.1 нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, эсхүл бууруулах ;
- 31.2.2 Хувьцаа нэмж гаргах замаар өсгөх ;
- 31.2.3 өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар бууруулах.
- 31.3 Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг тайлан гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэгтэй.
- 31.4 Гүйцэтгэх удирдлага нь энэ хуулийн 31.3-т заасан нөхцөл байдал үүссэн тухай болон түүнийг хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээллийг шийдвэр гаргаснаас хойш 30 хоногийн дотор тухайн компанийн зээлдүүлэгчид мэдээлэх үүрэгтэй.
- 31.5 Энэ хуулийн 31.3-т заасан асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлээгүй тохиолдолд тухайн компанийн хувьцаа эзэмшигч, зээлдүүлэгч, хувьцаат компанийн тухайд Санхүүгийн зохицуулах хороо тухайн компанийг шүүхийн журмаар татан буулгах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

Тайлбар:

Энэ зүйлд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх арга, хэлбэр хийгээд компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд авах арга хэмжээг тус тусад нь зохицуулжээ. Түүнчлэн хувьцаат компанийн тухай Санхүүгийн зохицуулах хороо шүүхэд нэхэмжлэл гаргах эрх зүйн үндэслэлийг тогтоосон байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг өөрчлөх асуудал тухайн компанийн үйл ажиллагаа, зайлшгүй шаардлагаас улбаалан бий болдог. Тэгэхлээр энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн, тус хурлын шийдвэрт үндэслэн өөрчилж болно.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх хэлбэрийг дараах байдлаар тодорхойлно.



Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс бага байж болохгүй. Компанийн тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан дүн гарсан тохиолдолд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулна.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол гүйцэтгэх удирдлага) зарлана.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг тайлан гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор зарлана.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол гүйцэтгэх удирдлага) дараах асуудлыг боловсруулан оруулж шийдвэрлүүлэх үүрэгтэй. Үүнд:

- а) Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах ;
- б) Компанийг дахин хөрөнгөжүүлэх ;
- с) Компанийг татан буулгах.

Эдгээр асуудлыг компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

Зээлдүүлэгчид мэдээлэх.

Компанийн зээлдүүлэгч (харилцагч)-д компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс бага болсон нөхцөл байдал, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээллийг тухай бүрт мэдээлэх үүрэгтэй. Энэ мэдээлэх үүргийг компанийн гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ. Хуульд зааснаар мэдээллийг шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор зээлдүүлэгчид (харилцагч)-д хүргэнэ.

Шүүхэд нэхэмжлэл гаргах.

Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан, энэ нь жилийн санхүүгийн тайлангаар илэрхий болсон боловч тухайн компани хуулийн 31.3-д заасан авбал зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй тохиолдолд тухайн компанийг татан буулгах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. Энэ компани нь хязгаарлагдмал хариуцлагатай компани бол түүний хувьцаа эзэмшигч, мөн зээлдүүлэгч шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

Хэрэв хувьцаат компани байх тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороо, түүнийг шүүхийн журмаар татан буулгах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Энэ нь зээлдүүлэгчид (харилцагчид)-

ийг эрсдлээс хамгаалах чухал ач холбогдолтой.

2 дугаар зүйл. Компанийн хувьцаа

32.1 Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд⁴ заасны дагуу компанийн хувьцаа нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг хувьцаа эзэмшигчийн эрхийг гэрчилнэ.

32.2 Хувьцаа нь энгийн ба давуу эрхийн гэсэн төрөлтэй байна.

32.3 Компани нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэг хүлээх ба компани нь давуу эрхийн хувьцааг гаргаж болно.

32.4 Хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон нэрлэсэн үнэтэй байх бөгөөд тухайн компанийн нэг төрлийн хувьцааны нэрлэсэн үнэ ижил байна.

32.5 Хувьцааг нэрлэсэн үнээс нь доогуур үнээр гаргахыг хориглоно.

32.6 Хуульд өөрөөр заагаагүй бол хувьцаа бүр саналын нэг эрхтэй байна.

32.7 Хувьцаа нь нэрийн үнэт цаас байх бөгөөд хувьцааны саналын эрх хуваагдахгүй.

Тайлбар:

Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлд компанийн хувьцаа, түүний үндсэн шинж, төрөл, энгийн ба давуу эрхийн хувьцаа гаргах эрх зүйн

⁴ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2002 оны №48.

үндэслэл, нэрлэсэн үнэ, хувьцаанд ногдох саналын эрх, хувьцаа нь нэрийн үнэт цаас байх бөгөөд хувьцааны саналын эрх хуваагдахгүй тухай тус тус заан зохицуулжээ.

1. Хувьцаа, түүний төрөл.

“Хувьцаа гэж компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үндсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг хэлнэ.” хэмээн толь бичигт тодорхойлжээ.

Компанийн тухай хуульд “Компанийн хувьцаа” гэдгийг тодорхойлон заахдаа “Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу компанийн хувьцаа нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үндсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг хувьцаа эзэмшигчийн эрхийг гэрчилнэ.” хэмээн заажээ.

Компанийн хувьцаа хэлбэрийн хувьд энгийн ба давуу эрхийн гэсэн хоёр төрөлд хуваагдана. Мөн компанийн дүрмээр тогтоосон хувьцааг зарласан хувьцаа гэдэг бол хувьцаа эзэмшигчийн худалдан авч эзэмшсэн хувьцааг гаргасан хувьцаа гэж ангилдаг.

Үнэт цаасны зах зээл дээр компанийн хувьцаа, бонд болон эдгээрт суурилсан гуравдагч буюу үүсмэл үнэт цааснууд арилжаалагддаг. Өөрөөр хэлбэл, үнэт цаасыг хувьцаа, бонд болон үүсмэл үнэт цаас гэж ерөнхийд нь ангилдаг байна.

2. Энгийн ба давуу эрхийн хувьцааны ялгаа онцлог шинжийг дараах байдлаар тайлбарлаж болно.

Шинээр үүсгэн байгуулагдаж байгаа компани нь хөрөнгийн эх үүсвэр олох зорилгоор гадаадын болон дотоодын зах зээлээс зээл тусламж авахгүйгээр хувьцаа гаргах замаар хөрөнгө татан төвлөрүүлж болох бөгөөд энгийн болон давуу эрхийн хувьцаа гаргадаг.

Энгийн хувьцаа гэдэг нь: Өөрийн эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь нийлүүлэгчдийн хуралд санал өгөх эрхтэй. Компани ашигтай ажилласан жилдээ хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр ногдол ашиг тараах шийдвэр гаргасан тохиолдолд ногдол ашиг авах, татан буугдах, дампуурсан тохиолдолд хөрөнгө оруулагчдад хөрөнгө хуваарилахад өөрийн хувьцааны тоонд хувь тэнцүүлэн өөрийн хөрөнгөө буцаан авдаг байна.

- **Давуу тал:** Санал өгөх, ногдол ашиг авах эрхтэй. Компанийн удирдлагад хяналт тавих эрхтэй.
- **Сул тал:** Тогтмол ногдол ашиг авдаггүй. Компани татан буугдсаны дараагаар зээлдэгч болон давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийн өр төлбөрийг барагдуулсны дараагаар өөрийн хувьцааны тоо ширхэгт хувь тэнцүүлэн өөрийн хөрөнгөө буцаан авдаг.

Давуу эрхийн хувьцаа гэдэг нь: Саналын эрхгүй, тогтмол ногдол ашиг авдаг, компани татан буугдах, дампуурахад хөрөнгө оруулагчдад хөрөнгө хуваарилахад тэргүүн ээлжинд авдаг.

- **Давуу тал:** Тогтмол ашиг авдаг. Компани татан буугдсаны дараагаар хөрөнгө хуваарилахад



зээлдэгч нарын өр төлбөрийг барагдуулсны дараа энгийн хувьцаа эзэмшигчдийн өмнө хөрөнгөө буцааж авдаг. Хөрвөх чадвартай. Энэ нь хөрвөх нөхцөлийг нь тодорхой зааж өгсөн тохиолдолд энгийн хувьцаа руу хөрвөх чадвартай байдаг.

- Сул тал: Санал өгөх эрхгүй.⁵
3. Компани нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэгтэй байдаг. Давуу эрхийн хувьцааг заавал гаргах хуулиар тогтоосон үүрэг хүлээхгүй. Хөрөнгө оруулалт татах зорилгоор давуу эрхийн хувьцаа гаргаж болно. Давуу эрхийн хувьцааг компанийн дүрмээр зарласан бол давуу эрхийн хувьцааны тоо, түүний эзэмшигчийн эрхийг компанийн дүрэмд заавал тусгана.

4. **Нэрлэсэн үнэ.** Энгийн болон давуу эрхийн хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон нэрлэсэн үнэтэй байдаг. Нэрлэсэн үнэ гэдгийг “хөрөнгө оруулагчид үнэт цаасыг хөнгөвчлөн гарах зорилгоор бондыг хэсэгчлэн төлөх стандарт хэмжээ, үнэт цаасны нэрлэсэн өртөг буюу худалдан авах үед төлөх мөнгө”⁶ гэж тодорхойлсон бол “нэрлэсэн үнэ гэж тогтоосон хугацаа дуусах өдөр төлөгдөх дүн”, “бодит үнэ цэнэ” гэдэг ойлголтод “ажил гүйлгээг бүртгэх өдөр зах зээлийн харилцаанд оролцогчдын хооронд байнга хийгдэх арилжаагаар хөрөнгө худалдах, худалдан авах үнэ” гэх мэтээр санхүүгийн агуулга талаас нь тодорхойлсон байна.

⁵ www.sanhuu.mn сайтаас авч ашиглав.

⁶ А.Ганзориг нар. “Бонд санхүүгийн нэр томъёоны тайлбар толь”. УБ хот, 2015 он.

Компанийн хувьцааны нэрлэсэн үнийг компанийн дүрэмд тогтоон заах бөгөөд компанийн нэг төрлийн хувьцааны нэрлэсэн үнэ ижил байдаг.

5. Компани хувьцааг нэрлэсэн үнээс доогуур үнээр гаргахыг хуулиар хориглодог. Хувьцаа бүр саналын нэг эрхтэй. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ зарчмыг компани бүр баримтлах ёстой.

6. Монгол улсын Иргэний хуульд үнэт цаасны эргэлтээс үүсэх үүргийн тухай зохицуулсны дотор үнэт цаас, түүний төрөл, хэлбэрийг заан тогтоосон байдаг. Иргэний хуулийн 467 дугаар зүйлд үнэт цаасыг нь биет болон биет бус төрөлтэй байхаар, "тусгайлан хэвлээгүй, бүрдүүлбэр нь тусгай бүртгэлд байгаа үнэт цаасыг биет бус үнэт цаас гэнэ" гэж заажээ. Мөн тэнд үнэт цаас нь нэрийн, мэдүүлгийн, зөвшөөрлийн гэсэн хэлбэртэй байхаар тусгажээ.

Үнэт цаасаар гэрчлэгдсэн эрх.

- a) Үнэт цаасаар мэдүүлгийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг үнэт цаасыг хууль ёсоор олж авсан этгээд ;
- b) Нэрийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг гагцхүү түүнд нэр заасан этгээд ;
- c) зөвшөөрлийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг уг үнэт цаасыг өмчлөгч буюу түүнээс уг эрхийг шилжүүлж авахаар өөрийн нэр дээр холбогдох бичилт хийсэн этгээд байхаар тус тус тодорхойлсон байдаг.

Үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг эдлэгч нь үнэт цаасны өмчлөгч байна.

Тэгвэл компанийн хувьцаа нь нэрийн үнэт цаас байх бөгөөд "хувьцааны саналын эрх хуваагдахгүй" хэмээн заажээ.

